J. K. ROWLING

ХАРРИ ПОТТЕР

ҮХЛИЙН ШҮТЭЭН

Харри Поттер ба Үхлийн шүтээн

Зохиолч: J. K. Rowling

http://www.jkrowling.com/

Орчуулагч: Asuult Forum-ийн гишүүн CROFT

http://forum.asuultserver.com

Эмхэтгэл, хөрвүүлэлт: Б.Болдхүү

Имэйл: bxbenny@gmail.com

Блог: http://www.boldkhuu.com

Facebook: http://facebook.com/bxbenny

Twitter: http://twitter.com/bxbenny

Эхийг Asuult Forum-аас авав.

ГАРЧИГ

БҮЛЭГ 1: ХАР ЛОРДЫН ӨСӨЛТ 4
БҮЛЭГ 2: ДУРСАМЖ 11
БҮЛЭГ 3: ДУРСЛИЙНХАН ЯВСАН НЬ 20
БҮЛЭГ 4: ДОЛООН ПОТТЕР 29
БҮЛЭГ 5: УНАСАН ДАЙЧИН 42
БҮЛЭГ 6: ХҮРЭМТЭЙ ОРООЛОН 57
БҮЛЭГ 7: АЛЬБУС ДАМБЛДОРЫН ГЭРЭЭСЛЭЛ 73
БҮЛЭГ 8: ХУРИМ 73 90
БҮЛЭГ 9: НУУГДСАН НЬ 106
БҮЛЭГ 10: КИКИМЕРИЙН ЯРИА 116
БҮЛЭГ 11: ХАХУУЛЬ 131
БҮЛЭГ 12: ШИДИЙН ХҮЧ 145
БҮЛЭГ 13: МАГЛ ГАРАЛТАЙ ХҮМҮҮСИЙГ БҮРТГЭХ КОМИСС 160
БҮЛЭГ 14: ХУЛГАЙЧ 174
БҮЛЭГ 15: АЛБИНГИЙН ӨС ХОНЗОН 184
БҮЛЭГ 16: ГОДРИКИЙН ХОНХОР 202
БҮЛЭГ 17: БАТИЛЬДАГИЙН НУУЦ 213
БҮЛЭГ 18: АЛЬБУС ДАМБЛДОРЫН ХУУРАМЧ АМЬДРАЛ 226
БҮЛЭГ 19: МӨНГӨН СОГОО 234
БҮЛЭГ 20: КСЕНОФИЛИУС ЛАВГУД 249
БҮЛЭГ 21: АХ ДҮҮ ГУРВЫН ТУХАЙ ҮЛГЭР 260
БҮЛЭГ 22: ҮХЛИЙН ШҮТЭЭН 272
БҮЛЭГ 23: МАЛФОЙН ЭДЛЭНД 286
БҮЛЭГ 24: ШИДЭТ САВААНЫ МАСТЕР 306
БҮЛЭГ 25: ХЯСААН БАЙШИН 322
БҮЛЭГ 26: ГРИНГОТТС 333
БҮЛЭГ 27: СҮҮЛЧИЙН НУУЦ ГАЗАР 347
БҮЛЭГ 28: АЛГА БОЛСОН ТОЛЬ 353
БҮЛЭГ 29: АЛДАГДСАН ТИТЭМ 363
БҮЛЭГ 30: СЕВЕРУС СНЕГГ ОГЦОРСОН НЬ 374
БҮЛЭГ 31: ХОГВАРТСЫН ТЭМЦЭЛ 387
БҮЛЭГ 32: ГАНДИГАРЫН САВАА 405
БҮЛЭГ 33: ПРИНЦИЙН ТҮҮХ 417
БҮЛЭГ 34: АХИН ОЙД 437
БҮЛЭГ 35: КИНГС КРОСС 445
БҮЛЭГ 36: ӨӨТЭЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 456
ТӨГСГӨЛ: АРВАН ЕСӨН ЖИЛИЙН ДАРАА 472

БҮЛЭГ 1: ХАР ЛОРДЫН ӨСӨЛТ

Харанхуйн хаа нэгтээгээс хоёр хүн гарч ирээд сарны гэрэл гийгүүлсэн давчуу зөрөг дээр бие бие лүүгээ ойртлоо. Хормын турш тэд нэг нэгнийхээ цээж рүү шидэт саваа чиглүүлэн хөдөлгөөнгүй зогссоноо дараа нь урдаа хэн байгааг мэдмэгц саваагаа жанчин дороо шургуулж яаран нэг зүгт явлаа.

- Сонин юу байна? гэж арай өндөр нь асуув.

- Хамгийн сайн гэж Северус Снегг хэлэв.

Хоёул зүүн талдаа намхан бөөрөлзгөний бут баруун талдаа өндөр амьд бургасан хашаагаар хүрээлэгдсэн зөргөөр явахад урт жанч нь шагайных нь дэргэд намирч байлаа.

- Би хоцорсон гэж айлаа хэмээн Яксли хэлэхэд сарны гэрэлд хэрцгий царай нь гийгүүлэгдсэнээ ахин мододын мөчрийн цаагуур далд оров. Энэ бодсоноос ч хэцүү байлаа. Ер нь бол түүнийг сэтгэл ханамжтай байна гэж найдаж байна. Чи үнэхээр түүнийг биднээс сайн зүйл хүлээж байгаа гэж бодож байна уу?

Снегг толгой дохисоноос ондоо дэмжсэн тэмдэг үзүүлсэнгүй. Хоёул баруун тийшээ эргээд өргөн замд орлоо. Өндөр амьд бургасан хашаа тэдний хамт эргээд урд нь төмөр хаалга сүндэрлэж харагдана. Тэд манан дундах хашаа руу орохдоо хэн нь ч алхаагаа удаашруулсангүй бөгөөд хоёул зүүн гараа мэндчилж буй аятай өргөлөө.

Одоо тэдний алхаа замын хоёр талын өтгөн бургасан хашаанд намсан дуулдаж байлаа. Баруун талд нь ямар нэг зүйл шар шурхийв. Яксли ахин жанчин дороос саваагаа авч хамтрагчынхаа толгой дээгүүр чимээ гарсан зүгт чиглүүлсэн ч ердөө цагаан өнгийн тогос хашааны орой дээгүүр жавхлантай алхаж байв.

- Люциус үргэлж ая тухад дуртай байх юм даа. Тогоснууд ... гэж Яксли тургилаад жанчин дороо саваагаа шургуулав.

Харанхуй замын эцэст том үзэсгэлэнтэй байшин урган гарч ирэхэд доод давхарын цонхноос нь гэрэл тусан гийгүүлнэ. Хашааны хаа нэгтээ усан оргилуур хоржигноно. Снегг, Яксли хоёр хайрга шажигнуулж явсаар яаран үүдний хаалгаар ороход хэн ч үзэгдсэнгүй.

Сайхан засаж янзалсан бүдэг гэрэлтэй уужим үүдний танхимд чулуун шалан дээр сахлаг зузаан хивс дэвсчээ. Снегг, Яксли хоёр өрөөн дундуур өнгөрөхдөө хананд өлгөсөн зэвхий царайтай хүмүүсийн хөрөгийг харав. Хоёр эрэгтэй агшин зуур дараагийн өрөөнд орох хүнд модон хаалганы өмнө зогссоноо дараа нь Снегг хүрэл бариулыг эргүүлэв.

Зочны өрөөнд сийлбэртэй урт ширээг тойрон дүүрэн чимээгүй хүмүүс суусан байлаа. Өрөөний тавилга хэрэгслийг хана руу холдуулан түлхжээ. Гантиг зууханд асан дүрэлзэж буй галын дөл сийлбэртэй гуу бүхий том толинд тусна. Снегг, Яксли хоёр яльгүй удаашран босгон дээр зогслоо. Тэдний харц бүдэг гэрэлд дасаад энэ

өрөөний хамгийн хачирхалтай хэсэг болох ширээн дээр толгойгоо уруу харуулан өлгөгдсөн хүний амьгүй бие дээр тусахад үл үзэгдэх олсоор өлгөгдсөн мэт удаанаар

эргэлдэх нь ширээний толин гадаргууд тусна. Дэргэд нь суусан цонхийн цайсан залуу хүүгээс ондоо ширээнд суугсдын хэн нь ч бие рүү харсангүй. Тэрбээр тэсгэлгүй ойролцоогоор хором тутамд түүн рүү хяламхийж байлаа.

- Яксли, Снегг гэх өндөр чанга хоолой ширээний голоос гараад,

- Та хоёр бараг л хоцорлоо гэв.

Үүнийг хэлэгч нь зуухны өмнө талд сууж байсан учир өрөөнд орж ирсэн хоёр хүн эхэндээ энэ дүрсийг ялган харахад бэрхтэй байв. Тэд харанхуйд царайг нь ялган харах үед халзан толгой, могойн нүхтэй хамар, босоо хүүхэн хараа бүхий гялалзсан улаан нүд харагдав. Тэр гялалзсан сувдыг санагдуулам цонхигор цагаан байлаа.

- Северус, ийшээ! гээд Волдеморт баруун талын сандлаа зангаж,

- Яксли Долоховын дэргэд суу гэв.

Хоёр эрэгтэй хүн заасан газар суулаа. Ширээнд суугсдын ихэнхи нь Волдемортын түрүүлж хандсан явдалд Снеггийг дагуулан харав.

- Тэгэхээр?

- Эзэнтээн, Фениксийн бүлгэм Харри Поттерыг одоогийн байгаа газраас нь ирэх бямба гаригийн үдэш гаргахаар төлөвлөж байгаа.

Энэ мэдээ тойрон суугчдын анхаарлыг мэдэгдэхүйц татахад зарим нэг нь хөшиж, зарим нь хавчигнан бусад нь Снегг, Волдеморт хоёроос нүд салгалгүй ширтэв.

- Бямба гаригийн ... үдэш гэж Волдеморт давтав. Түүний улаан нүд Снеггийн хар нүдтэй харц тулгарахад зарим нэг ширтэгч түлэгдэхээс айсан мэт харц буруулав. Снегг Волдемортын царай руу тайван ширтэхэд хормын дараа түүний уруулгүй аманд инээмсэглэлтэй адил зүйл тодорлоо.

- Сайн байна. Маш сайн байна. Энэ мэдээлэл хаанаас ...

- Бидний ярилцсан эх сурвалжаас.

- Эзэнтээн гээд Яксли урт ширээн дээгүүр бөхийн Волдеморт, Снегг хоёр руу харав. Бүгдийн царай түүн рүү эргэлээ.

- Би өөр зүйл сонссон, эзэнтээн.

Яксли хариу хүлээн чимээгүй болсон ч Волдеморт ярьсангүйд цааш үргэлжлүүлэн,

- Мракоборец Долиш, Поттер гучны үдэш арван долоо хүрэх хүртлээ байрнаасаа хөдлөхгүй гэж байсан гэв.

Снегг инээмсэглэв.

- Миний эх сурвалж хэд хэдэн хуурамч төлөвлөгөө тарсан гэж хэлсэн. Энэ харваас тэдний нэг байх. Долиш гарцаагүй Конфундус шившлэгийн нөлөөн

дор байсан байж таарна. Энэ ч түүний хувьд анхны удаа биш хэрэг дээ. Тэр эртнээс энэ шившлэгэнд хялбархан өртдөг болсон нь тодорхой.

- Таньд итгүүлэн хэлэхэд, эзэнтээн Долиш бүрэн итгэлтэй байсан гэж Яксли хэлэв.

- Конфундус шившлэгийн хувьд энэ нь бүрэн боломжтой гэж Снегг татгалзаад,

- Яксли таньд итгүүлэн хэлэхэд мракобореций төв байр Харри Поттерын хамгаалалттай ямар ч холбоогүй. Бүлэг ид шидийн яамаар дүүрэн манай тагнуулууд байгаа гэж бодож байгаа гэв.

- Энэ тохиолдолд бүлгийн зөв биш үү? гэж Якслигаас холгүй сууж байсан тагдгар эрэгтэй сөөнгөтөн инээд алдахад ширээн дээгүүр цуурайтлаа.

Волдеморт инээмсэглэсэнгүй. Тэр ширээн дээгүүр удаанаар эргэлдэж буй бие рүү харан бодлогоширов.

- Эзэнтээн, Долиш мракоборецууд хүүг шилжинэ гэдэгт итгэлтэй байсан гэж

Яксли үргэлжлүүлэв.

Волдеморт том цагаан гараа өргөхөд Яксли чимээгүй болоод эзэн нь ахин Снеггэд хандсанд гомдолтой болов.

- Тэд хүүг хааш нь нуух гэж байгаа юм бол?

- Бүлгийн гишүүдийн нэгнийх нь гэрт. Миний эх сурвалжаас үзэхэд энэ газар бүлэг болон ид шидийн яамны бүх төрлийн шившлэгээр хамгаалагдсан байгаа. Эзэнтээн хэрвээ ирэх бямба гаригаас өмнө ид шидийн яамыг гартаа оруулдаггүй юм бол бидэнд түүнийг тэндээс авах өчүүхэн ч найдлага байхгүй. Энэ нь бидэнд түүний байгаа газрыг илрүүлэх боломж өгч шидийн хамгаалалтыг тайлан дотогш нэвтрэх боломжтой болно.

- За, Яксли бид ирэх бямба гариг гэхэд ид шидийн яамыг гартаа оруулж амжих уу? гэж Волдеморт ширээн дээгүүр хэлэхэд галын гэрэлд улаан нүд нь хачирхалтай гялсхийв.

Бүгд ахин Яксли руу эргэлээ. Тэр мөрөө тэгшлээд,

- Эзэнтээн надад энэ талаар сайн мэдээ байна. Би ихээхэн хүч чармайлт гаргаж байж Пиус Тикнессийг Империус шившлэгийн нөлөөнд оруулсан билээ гэв.

Якслиг тойрон сууж байсан олонхи хүмүүст энэ нь сэтгэгдэл төрүүлэхэд түүний хөрш урт мурий нүүртэй Долохов нуруун дээр нь алгадлаа.

- Сайн эхлэл байна. Гэвч Тикнесс бол ердөө ганц хүн. Намайг тоглоомд оролцохоос өмнө Скримжерийг манай хүмүүсээр хүрээлүүлэх хэрэгтэй. Сайдын аминд хүрэх нэг л бүтэлгүй оролдлого бидний бүх хөдөлмөрийг нураах болно гэж Волдеморт хэллээ.

- Тиймээ эзэнтээн энэ бол үнэн. Гэхдээ Тикнесс ид шидийн хуулийг албадан хэрэгжүүлэх хэлтсийг тэргүүлдэг болохоор зөвхөн сайдтай харьцаад зогсохгүй бүх гол хэлтсийг хянах чадвартай. Бид одоо өндөр албаны

түшмэлүүдийг хараандаа амархан оруулж чадна гэж бодож байгаа бөгөөд ингэснээрээ Скримжерийн хүчийг сулруулах юм.

- Хэрвээ зөвхөн манай найз Тикнесс бусдыгаа элсүүлэхээс өмнө илчлэгдэхгүй юм бол. Ямар ч гэсэн ид шидийн яам ирэх бямба гариг гэхэд минийх болох боломж бага байна. Хэрвээ бид түүнийг хөдлөхөд нь л саад хийхгүй юм бол хүүгийн шинээр нуугдах гэж буй газрыг илрүүлж чадахгүй.

- Бидэнд үүнд давуу тал бий, эзэнтээн гээд Яксли харваас ямар нэгэн магтаал хүлээсэн бололтой. Ид шидийн тээврийн хэлтэст хэдийн манай тагнуулууд байгаа. Хэрвээ Поттер шилжих юмуу нисдэг дарь ашиглахыг оролдвол бид энэ тухай шууд мэдэх болно.

- Тэр тийм зүйл хийхгүй. Бүлэг ид шидийн яамны хяналтанд байгаа ямар нэг тээврийн хэрэгсэл ашиглахаас зайлсхийж байгаа болохоор энэ газартай холбоотой юунд ч итгэхгүй байгаа гэж Снегг хэлэв.

- Тэгсэн нь дээр. Тэгвэл тэр нээлттэй хөдөлж бидэнд барьж авахад илүү хялбар болно гэж Волдеморт хэлээд ахин удаанаар эргэлдэж байгаа бие рүү харснаа,

- Би хүүгийн учрыг өөрөө олно. Харри Поттертой холбоотой бүхэнд хэтэрхий олон алдаа гарсан. Үүний зарим нь минийх. Хүүгийн амьд байгаа нь юунаас түрүүнд миний алдаа гэв.

Ширээ тойрон сууж байсан хүмүүс Харри Поттерын оршин байгаад буруутгагдахаас болгоомжилсон мэт Волдеморт руу эмээнгүй харлаа. Гэвч Волдеморт тэднээс илүү өөртэйгээ ярьсан бололтой өмнөхийн адил ширээн дээр өлгөөстэй байгаа амьгүй бие рүү харсаар байлаа.

- Би хайхрамжгүй байсан учир төлөвлөгөөгөө биелүүлэх боломжоо алдсан.

Одоо л би өмнө ойлгохгүй байсан зүйлээ ойлгож байна. Харри Поттерыг алах хүн нь зөвхөн би байх ёстой.

Энэ үгэнд хариу өгөх мэт гэнэтхэн аймшигтай зовж шаналсан хашгиралт сонсогдов. Ширээ тойрон сууж байсан хүмүүс энэ чимээ хөл дороос гарсан мэт айн шал руу харлаа.

- Сүүлтээ би чамд олзлогдогч чимээгүй байх ёстой гэж хэлээгүй бил үү? хэмээн Волдеморт аяархан бодлогоширонгуй хэлэхдээ эргэлдэж буй биенээс харц салгасангүй.

- Тиймээ, эзэнтээн гэж ширээний дунд суудал дээрээ атийн суусан жижигхэн хүн хэлэхэд анхны харцаар хоосон юм шиг харагдав. Дараа нь тэр сандлаас гулган буугаад өрөөнөөс яаран гарахдаа ардаа хачирхалтай мөнгөлөг гэрэл гялсхийлгэв.

- Би өмнө нь хэлсэн гэж Волдеморт дагалдагч нарынхаа царай руу харан үргэлжлүүлээд,

- Одоо надад олон зүйл тодорхой болж байна гэж. Жишээлбэл би Поттерыг алахад та нарын нэгний саваа шаардагдах болно гэв.

Энэ нь хэн нэгний гарыг авахыг хүссэн мэт бүгдийн царайд айдас тодорлоо.

- Сайн дурааараа өгөх хүн алга уу? гэж Волдеморт хэлснээ,

- Харцгаая ... Люциус би чамд саваа чинь цаашид шаардагдах боломжыг олж харахгүй байна гэв.

Люциус Малфой түүн рүү харцаа өргөлөө. Түүний арьс зуухны гэрэлд шаргалдуу өнгөтэй лав шиг харагдаад нүд нь харанхуйлав. Тэр сөөнгөтөн,

- Эзэнтээн? гэлээ.

- Чиний саваа, Люцуис. Би савааг чинь шаардаж байна.

- Би ...

Малфой эхнэр рүүгээ хяламхийн харлаа. Тэр нөхөр шигээ цонхийн цайсан бөгөөд урт цайвар үс нуруугаа даган унжуулжээ. Тэр нарийхан хуруугаараа Люциусын бугуйнд ажиглагдамгүй хүрлээ. Малфой энэ хүрэлтийг мэдрээд жанчин дотроо гараа шургуулж саваагаа гаргаж ирээд улаан нүдээрээ шинжин харж буй Волдемортод сунгав.

- Энэ юугаар хийгдсэн бэ?

- Эзэнтээн, хайлаас гэж Малфой шивнэлээ.

- Дотор нь?

- Лууны ... лууны хатаасан зүрх.

- Сайн байна гээд Волдеморт савааг авч өөрийнхтэйгээ уртыг нь харьцуулав.

Люциус Малфой агшин зуур Волдеморт саваагаа өөрийнхөөр нь солино гэж найдсан мэт санамсаргүй хөдөлгөөн хийв. Волдеморт энэ хөдөлгөөнийг ажигламагц нүд нь хорсолтой томорлоо.

- Би чамд саваагаа өгөх үү, Люциус? Өөрийнхөө савааг уу? Ширээнд хэн нэгэн хөхөрлөө.

- Би чамд эрх чөлөөг чинь буцаан олгосон, Люциус. Чинийхээр бол энэ нь багадаад байна уу? Тэгээд ч би сүүлийн үед чи болон гэр бүлийнхэн чинь тийм ч баяртай бус байгааг ажигласан. Чамд миний гэрт чинь байгаа нь таалагдахгүй байна уу, Люциус?

- Огтхон ч үгүй, эзэнтээн тийм биш!

- Юутай хуурамч үг вэ, Люциус ...

Аяархан хоолой исгэрэлт болон хувираад Волдемортын ам хөдлөхөө болив. Исгэрэлт чангарах үед ямар нэг хүнд зүйл ширээн доогуур мөлхөж зарим шидтэн чичирлээ.

Тэгтэл Волдемортын суудал руу аварга могой удаанаар өгсөн ирэв. Тэр өндийн өндийсөөр төгсгөлгүй сунах мэт санагдсан ч эцэст нь Волдемортын мөрөн дээр

тогтлоо. Тэр зузаан хүзүүтэй бөгөөд үл цавчих босоо хүүхэн хараа бүхий нүдтэй ажээ. Волдеморт Люциус Малфойг ширтсэн хэвээр амьтныг урт нарийхан хуруугаараа илэв.

- Малфой чи яагаад сэтгэл хангалуун биш байна вэ? Чи олон жилийн турш миний эргэн ирж хүчээ авахыг хүсэж байсан гэж батлаагүйсэн билүү?

- Тиймээ, эзэнтээн гээд Люциус Малфой чичирсэн гараараа уруулынхаа дээдэх хөлсийг арчив.

- Бид үүнийг хүсч байсан ... одоо ч хүсч байна.

Түүний зүүн талд хөшин сууж байсан эхнэр нь толгой дохисноо Волдеморт болон могой руу нь харав. Харин баруун талд сууж байсан хүү Драко амьгүй бие рүү харж байснаа Волдеморт руу түргэн хяламхийснээ харц тулахаас айсан мэт буруулав.

- Эзэнтээн, та манай гэрт байгаа нь томоохон хүндэтгэл. Үүнээс илүү баяртай зүйл байхгүй билээ гэж ширээний дунд сууж байсан эмэгтэй хэллээ.

Тэр хар үс хүнд зовхитой бөгөөд дүүтэйгээ гадна төрх болон биеэ авч явах байдлын хувьд огт адилгүй байлаа. Нарцисса дэргэд нь хөдөлгөөнгүй тайван суухад Беллатриса Волдеморт руу ойртохыг хүссэн мэт бөхийв.

- Баяртай зүйл үгүй гэнээ хэмээн Волдеморт давтаад толгойгоо үл ялиг бөхийн

Беллатрисагийн царай руу харлаа.

- Чамаас үүнийг сонсох нь таатай байна, Беллатриса. Түүний царай гийж нүдэнд нь баярын нулимс дүүрлээ.

- Эзэнтээн та намайг цэвэр үнэнийг хэлж байгааг мэднэ!

- Үүнээс баяртай зүйл байхгүй ... Тэр ч байтугай энэ долоо хоногт танай гэр бүлд болсон зүйлтэй харьцуулахын аргагүй биз дээ?

Беллатриса амаа нээн тэвдэнгүй харлаа.

- Би таныг юуны тухай ярьж байгааг ойлгосонгүй, эзэнтээн.

- Би чиний зээгийн тухай ярьж байна, Беллатриса. Люциус, Нарицисса та гурвын. Тэр саяхан хүн чоно Римус Люпинтэй гэрлэсэн байна. Та нар мэдээж үүгээр их бахархаж байгаа байх.

Ширээнд сууж байсан хүмүүс хөхрөлдөв. Тэдний олонхи нь бие бие рүүгээ бөхийн шолоонгуй харц солилцоход зарим нэг нь ширээ нударгаараа нүдлээ. Аварга могой энэ чимээ шуугианд уурсан исгэрсэн ч Үхэл залгигчид сонссонгүй Беллатриса болон Малфойн гутаагдсан явдалд баясан инээлдэв. Беллатрисагийн царайнаас саяхны баяр хөөр алга болоод хүрэн толбо гарч ирэв.

- Тэр манай зээ биш, эзэнтээн! гэж тэр хашгираад,

- Манай эгч бохир цустантай гэрлэсэн цагаас хойш Нарцисса бид хоёр нэг ч удаа уулзаагүй. Түүнийг адгуустай гэрлэснээс хойш бидний хооронд ямар ч харьцаа байгаагүй гэв.

- Харин чи юу хэлмээр байна, Драко? гэж Волдеморт тохуутай инээмсэглэн асуулаа. – Гөлгийг нь харах гэж байна уу?

Хөгжилтэй инээд улам ихэслээ. Драко Малфой айдаст автан эцэг рүүгээ харснаа дараа нь эх рүүгээ харав. Тэгснээ үл мэдэг толгой сэгсрээд ойлгомжгүй харцаар эсрэг талын хана руу ширтлээ.

- Хангалттай гэж Волдеморт уурссан могойг илбэн хэлэв.

- Хангалттай.

Инээд агшин зуур бөхлөө.

- Манай хуучны олон гэр бүлийн мод цаг хугацааны явцад өмхөрсөн байна. Беллатриса амьсгаа даран түүн рүү гуйн ширтлээ.

- Та нар түүний эрүүл байдлыг хадгалахын тулд өвчтэй хэсгийг нь тайрч хаях нь зүйн хэрэг бус уу? Модны эрүүл мэндэд заналхийлж байгаа мөчрүүдийг нь авч хая.

- Тиймээ, эзэнтээн гэж Беллатриса шивнээд нүд нь ахин талархлын нулимсаар дүүрч,

- Анхны боломж өгөөч! гэв.

- Чи түүнийг авлаа. Тэгээд ч танай гэр бүл болон бүх ертөнц дээр ... бид судсанд нь цэвэр цус байхгүй хорхойд идэгдсэн бүх хэсгийг нь устгах ёстой.

Волдеморт Люциус Малфойн савааг өргөөд ширээн дээр удаанаар эргэлдэж байгаа дүрс рүү чиглүүлэн хөнгөхөн дохив. Дүрс амь орон ёолоод үл үзэгдэх олсноос мултрахыг хичээлээ.

- Чи манай зочныг таньж байна уу, Северус?

Снегг эргэж буй царай руу харав. Бүх Үхэл залгигчид олзлогдогч руу сонирхох зөвшөөрөл өгсөн мэт харлаа. Эмэгтэйн нүүр гал руу эргэмэгц айдас дүүрэн хоолойгоор,

- Северус! Надад туслаач! гэлээ.

- Тиймээ тэгэлгүй яахав гэж Снегг олзлогдогч ахин цааш эргэмэгц хэлэв.

- Харин чи, Драко? гэж Волдеморт саваагүй гараараа могойн толгойг илэн хэллээ.

Драко толгойгоо огцом сэгсрэв. Одоо эмэгтэй сэхээ орсон ч хэнийг ч ялган харж чадсангүй.

- Тийм л дээ чи түүний хичээлд яваагүй. Та нарын мэдэхгүйд чинь хэлэхэд бидэн дээр өнөөдөр урьд нь ид шидтэний Хогвартс сургуульд багшилж байсан Чарити Бербиж зочилж ирээд байна.

Ширээнд дэмжиж ойлгосон шуугиан дэгдэв. Махлаг биетэй эмэгтэй орсгой шүдээ гарган хөхрөөд,

- Тиймээ ... профессор Бербиж шидтэнгүүдийн хүүхдэд маглуудыг ... биднээс ялгагдахгүй гэж тайлбарладаг байсан ... гэв.

Нэг Үхэл залгигч шал руу нулимав. Чарити Бербиж ахин Снегг руу эргэн харлаа.

- Северус ... гуйж байна ... гуйж байна ...

- Чимээгүй! гээд Волдеморт ахин Малфойн савааг даллахад Чарити чимээгүй болж аманд нь алчуур чихэгдэв.

- Профессор Бербижэд шидтэнгүүдийн хүүхдүүдийн оюун ухааныг бохирдуулсан нь багадаад зогсохгүй өнгөрсөн долоо хоногт «Өдөр тутмын Зөнч» сонинд бохир цустангуудыг хамгаалсан өгүүлэл гаргасан байна. Шидтэнгүүд түүний үгээр бол эгэл хүмүүсийг тэврэлтэндээ авч шидийн мэдлэгээ хуваалцах ёстой юм гэнэ. Түүнчлэн манай цэвэр цусны шидтэнгүүд хамгийн хүсэн хүлээсэн нөхцөлд байгаа юм байх ... Тэр биднийг маглуудтай нөхөрлүүлэхийг хүсэж ... эсвэл эргэлзээгүй хүн чононуудтай ...

Волдемортын хоолойд эргэлзээгүй уур хилэн жигшил зэвүүцэл сонсогдсонд энэ удаад хэн ч инээсэнгүй. Чарити Бербиж гурав дахь удаагаа Снеггийн царай луу эргэлээ. Түүний нүднээс үсийг нь даган нулимс урсаж байв. Снегг түүний нүүр лүү тоомсоргүй харав.

- Авада Кедавра!

Ногоон гэрэл гялсхийгээд зочны өрөөний өнцөг булан бүрийг гийгүүлэв.

Чарити ширээн дээр лүгхийн унахад хүндийн жинд нь тавцан чахран чичирлээ. Хэд хэдэн Үхэл залгичид сандлынхаа түшлэгийг налж, Дракo шалан дээр уналаа.

- Идэж болно Нагайна гэж Волдеморт аяархан хэлэхэд аварга могой мөрөн дээгүүр нь гулган ширээний толигор гадарга дээгүүр мөлхөв.

БҮЛЭГ 2: ДУРСАМЖ

Цус урссаар байлаа. Харри баруун гараараа зүүнээ барьж аяархан хараасаар унтлагын өрөөний хаалгыг мөрөөрөө түлхэн гарлаа. Тэгтэл хөл дор нь шаазан хагарах чимээ сонсогдов. Тэр хаалганы гадаа шалан дээр тавьсан хүйтэн цайтай аягыг гишгэжээ.

- Ямар ...

Харри эргэн тойрноо харсан ч Улаан модон гудамжны шатны талбай хоосон байлаа. Магадгүй аягатай цай Дадлигийн бодож олсон хорон занга байж болзошгүй. Харри цус болсон гараа дээшээ өргөсөөр нөгөө гараараа шаазангийн хэлтэрхийг хаман авч унтлагын өрөөний дүүрэн хогтой хогийн сав руу хийлээ. Дараа нь угаалгын өрөөнд ороод шархадсан гараа угаагуурт сунгав.

Хэдийгээр энэ нь тэнэг хэрэг ч гэсэн ахиад дөрвөн өдөр шид хэрэглэж болохгүй нь гомдолтой байв ... Тэр шарх анагааж сураагүй болохоор ойрын төлөвлөгөөнийхөө тухай бодоод үзэхэд ид шидийн боловсролд нь ноцтой дутагдал байх шиг санагдав. Тэр Гермиона үүнийг яаж хийх байсан тухай бодсоор жорлонгийн цаас авч шалан дээр асгарсан цайг арчаад дараа нь унтлагын өрөөндөө орон хаалга хаав.

Энэ өглөө Харри зургаан жилийн туршид анх удаагаа сургуулийнхаа чемоданыг хоосолж өнгөрүүлжээ. Тэр хичээлийн жилийн эхэнд ердийнхөөрөө ойролцоогоор дөрөвний гурав хүртэлх зүйлсийг нь шинээр сольж өмнөх жилийн хуучин галууны өдөн үзэг, хатсан цохны нүд, хос нь алга болсон оймс зэргийг хогийн сав руу хаядаг байсан юм. Тэгтэл хэдэн хормын өмнө баруун гарандаа юм зоогдон өвдөхийг мэдрээд харвал долоовор хуруунаас нь цус гоожиж байлаа.

Одоо Харри илүү болгоомжтой ажиллав. Тэр чемоданыхаа хажууд өвдөглөөд ёроолыг нь тэмтчин «СЕДРИКИЙГ ДЭМЖИЖ БАЙНА» гэсэн бичиг «ХАРРИ ПОТТЕР ӨМХИЙ» гэсэн үгээр сулхан анивчин солигдох хуучин тэмдэг, эвдэрсэн вредноскол, Р.А.Б-ын зурвас нуугдаастай байсан алтан зүүлт гаргаад эцэст нь гараа зүссэн шовх үзүүртэй зүйлийг олов. Ингээд шууд танилаа. Энэ бол загалмайлсан эцэг Сириусынх нь бэлэглэсэн хоёр дюймийн урттай шидэт толины хэлтэрхий байлаа. Харри хагархайг гаргаад чемоданы ёроолыг болгоомжтой тэмтчин загалмайлсан эцгийнхээ бэлгийн үлдэгдэл болох ямар нэг зүйл олохыг хичээсэн ч гялалзсан зүйл харагдсангүй.

Харри явган суугаад хуруугаа зүссэн үзүүртэй хэлтэрхийнд хурц ногоон нүднийхээ тусгалыг харлаа. Тэр хагархайг орон дээр хэвтэж байгаа «Өдөр тутмын зөнч» сонин дээр тавиад толь хагарсан гашуун дурсамжыг санахгүйг хичээн чемоданы ёроолд үлдсэн зүйлсийг хогийн саванд хийхээр дайралтанд оров.

Үүнийг бүрэн хоослоход ахин нэг цаг шаардсан бөгөөд ямар ч ашиггүй зүйл болон хэрэглэхгүй зүйлсээ тусад нь ялгалаа. Сургуулийн дүрэмт хувцас, квиддичийн бэлтгэлийн хувцас, тогоо, цаас, үзэг болон сурах бичгийн ихэнхи хэсгийг өрөөний зүүн буланд овоолов. Сонирхолтой нь нагац ах эгч хоёр нь үүнд яаж хандах бол?

Магадгүй хаа нэгтээ хамгийн харанхуй шөнө аймшигтай гэмт хэрэг хийж байгаа мэт гудамжинд гарч шатаах биз. Түүнчлэн маглын хувцас, үл үзэгдэх цув, уусмал бэлтгэх орц болон зарим нэг ном, Хагридын бэлэглэсэн гэрэл зургийн цомог, боодол захиаг шидэт савааны хамт авч хуучин үүргэвчинд хийлээ. Урд талын халаасанд нь Тэнүүлчний газрын зураг, Р.А.Б-ийн зурвастай зүүлтийг хийв. Энэ нь зүүлт үнэ цэнэтэйдээ хүндэтгэлийн байрыг эзэлсэн хэрэг биш үнэн хэрэгтээ ямар ч үнэгүй бөгөөд зорьсон хэргийнх нь шалтгааныг сануулж буйд байлаа.

Ингээд зөвхөн ширээн дээр цасан цагаан уулийн хажууд тэвхийтэл хураасан сонингийн учрыг олох үлдэв. Энэ нь зуны амралтаараа Улаан модон гудамжинд хичнээн өдрийг өнгөрүүлснийг илтгэж байлаа.

Харри шалнаас босоод суниаснаа ширээ руу очиход Хэдвиг хөдөлсөнгүй. Тэр сонинг дугаараар нь ялгаж эхлээд нэг нэгээр нь хогийн сав руу хаяж байлаа. Ууль унтаж байгаа юмуу эсвэл сүүлийн үед торноос нь гаргахгүй байгаад уурлан дүр үзүүлж байгаа бололтой.

Сонин багахан хэмжээтэй үлдмэгц Харри тэднийг анхааралтайгаар судлан энд ирснийхээ дараа бараг шууд авсан эхний хуудсан дээрээ Хогвартст багшилж байсан Чарити Бербиж гэдэг хүний тухай товч мэдээлэл бүхий хэрэгтэй дугаараа хайлаа. Ингээд эцэст нь олж аравдугаар хуудсыг нээгээд сууж нийтлэлийг уншиж эхлэв.

АЛЬБУС ДАМБЛДОРЫН ТУХАЙ ДУРСАМЖ Элфиас Дож

Би Альбустай арван нэгэн настай байхдаа Хогвартс явах анхны өдрөө танилцаж билээ. Бидний хооронд нэг нийтлэг зүйл байсан нь сургуульд хоёулаа өөрсдийгөө гадны хүн гэж мэдэрч байсан явдал юм. Би сургуульд явахын өмнөхөн лууны тууралтаар өвдсөн болохоор нүүрэн дээр үлдсэн ногоовтор толбонууд сурагчдыг надаас зайлсхийхэд хүргэж байлаа. Харин Альбусын хувьд гэвэл Хогвартст тийм ч сайнгүй нэртэй ирсэн юм. Ердөө дөнгөж жилийн өмнө эцэг Альбус Персивал нь гурван залуу маглын эсрэг хэрцгий дайралт хийсэн учраас буруутгагдан хоригдсон юм.

Альбус хэзээ ч эцгээ энэ гэмт хэрэгт буруугүй (Азкабанд эцсийн өдрөө хүртэл хоригдсон) гэж үгүйсгэхийг оролдож байгаагүй. Харин ч эсрэгээрээ намайг энэ тухай зориглон асуухад эцгийгээ гэмт хэрэгт буруутай гэж боддог тухайгаа хэлсэн. Хэдийгээр олон хүн түүнээс энэ тухай асуухыг хичээж байсан ч бусдад энэ гунигтай зүйлийн тухай ярихаас татгалзсан юм. Түүнчлэн зарим нэг хүмүүс Альбус магл үзэн ядагч байсан болохоор эцгээ тийм алхам хийсэн явдалд дэмжиж байсан гэж бодож байгаа байх. Гэвч тэд гүнзгий төөрөлдөж байна. Альбусыг мэддэг байсан хэн ч түүнийг маглуудын эсрэг өчүүхэн ч муу зүйл хийж байгаагүй гэдгийг батлах болно. Үнэн хэрэгтээ тэр маглуудыг хамгаалах шийдэмгий алхам хийснийхээ төлөө сүүлийн жилүүдэд багагүй дайсантай болсон билээ.

Ердөө хэдэн сар өнгөрсний дараа эцгийнх нь хиртүүлсэн Альбусын нэр хүнд мандаж эхэлсэн юм. Хичээлийн жилийн төгсгөлд түүнийг магл үзэн ядагчийн хүү биш сургуулийн хамгийн гялалзсан сурагч гэдгээр мэддэг болсон байлаа. Найз нь болох аз

тохиосон бидний хувьд олон зүйлийн тусламж дэмжлэг авахад тэр үргэлжид өгөөмөр байсан. Тэгэхэд тэр үедээ надад багшийн ажлыг амьдралын баяр баясгалан гэж боддог тухайгаа хэлсэн юм.

Альбус зөвхөн сургуулийн нэрэмжит бүх шагналыг авааД зогсохгүй тухайн үеийнхээ хамгийн алдартай шидтэнгүүд болох алдарт алхимич Николас Фламел, түүхч Батильда Бэгшот, ид шидийн онолч Адальберт Уоффлинг нартай мөр зэрэгцэн гарч ирсэн юм. Түүнчлэн шинжлэх ухааны «Өнөөдрийн хувиргал», «Шившлэгийн асуудал»,

«Уусмалын дадлага» зэрэг сэтгүүлүүдэд хэд хэдэн нийтлэл гаргасан билээ. Бүгд Дамблдороос гялалзсан амжилт хүлээж байсан болохоор түүнийг хэзээ ид шидийн яамны сайд болох бол гэсэн цорын ганц асуулт тавигдаж байлаа. Сүүлчийн жилүүдэд олон удаа түүнийг энэ суудлыг эзлэх байх гэсэн яриа явж байсан ч тэр хэзээ ч сайдын албан тушаал хөөцөлдөж байгаагүй билээ.

Гурван жилийн дараа Хогвартст түүний дүү Аберфорт элсэн орж ирсэн. Тэд хоорондоо төстэй байгаагүй. Аберфорт хэзээ ч номонд дурлаж байгаагүйгээрээ Альбусаас ялгаатай бөгөөд маргаанд оролцон халз тулаан хийхийг эрхэмлэдэг байсан. Итгэмээргүй хэдий ч олон зүйлээр ах дүү хоёр найз нөхөд биш байлаа. Гэсэн ч шударгаар хэлэхэд Аберфорт Альбусын сүүдэрт амьдрах нь тийм ч сайн хувилбар

биш байсан. Альбус шударга сайн талаараа гэр бүлийнхээ муу нэрийг халхалж байсан бол дүү нь илүү таагүй байлаа.

Хогвартсыг төгсөөд Альбус бид хоёр цаашдын замаа хөөн салахаас өмнө дэлхийг тойрох аялал хийн хилийн чанад дахь шидтэнгүүдтэй уулзахаар шийдсэн юм. Гэвч үүнд золгүй явдал саад болсон билээ. Биднийг аялалаа эхлэхээс өмнө Альбусын ээж Кендра нас барж тэрбээр гэр бүлийнхээ цорын ганц тэжээгч нь болон үлдсэн юм. Би удаан хугацаагаар салж явахаас өмнө Кендрагийн оршуулганд хүндэтгэл үзүүлэн оролцсон бөгөөд үүнийхээ дараа аялалаа цор ганцаар үргэлжлүүлсэн. Тэгэхэд Альбусын гар дээр эрэгтэй эмэгтэй хоёр бага дүү нь үлдсэн учир надтай хамт явж чадахааргүй байлаа

Энэ үеэс хойш бид ховорхон уулзах болсон. Би Альбусд аялалын явцад учирсан гайхамшигт адал явдал болох Грект химерээс зугтсан тухайгаа болон Египетийн алхимичидтэй туршилт хийсэн тухай бичсэн. Түүнээс ирсэн цөөхөн захиа надад Альбусын өдөр тутмын амьдралыг өгүүлэхэд тийм гялалзсан шидтэний хувьд уйтгарлан гонсойж байгаа гэдэг нь ойлгомжтой байлаа. Би сэтгэгдэл дүүрэн аялалаа төгсгөх үедээ түүний гэр бүлд ахин нэг эмгэнэлт явдал тохиолдон дүү Ариана нь үхсэн тухай мэдээг айдаст автан сонссон юм.

Хэдийгээр Ариана удаан удаан хугацааны турш бие муутай байсан ч түүний нас барсан явдал эхийгээ алдаад удаагүй байсан ахынх нь сэтгэлд хүнд цохилт болон гүнзгий шарх үлдээсэн юм. Альбуст ойрхон хүмүүс (үүнд би өөрийгөө жаргалтайгаар тооцно) түүний Арианагийн үхэлд өөрийгөө буруутгаж байсныг мэдэх билээ.

Би гэртээ буцаж ирээд зовж шаналсандаа хөгширсөн залуу хүнтэй уулзсан. Түүнчлэн энэ золгүй байдал дээр нэмэрлэн Арианаг алдсан явдал ах дүү хоёрыг улам ойртуулах битгий хэл эсрэгээрээ хөндийрүүлсэн (Сүүлчийн жилүүдэд тэд

харьцаагаа сэргээсэн ч энгийнээр найрсаг харьцдаг байв). Түүнчлэн Альбус эцэг эх болон Арианагийн тухай маш ховор ярьдаг байсан тул найзууд бид ч сануулах гэж нэг их хичээдэггүй байв.

Дараагийн жилүүдэд тэрбээр ид шидийн мэдлэгт тоолж баршгүй хувь нэмэр оруулсаны тоонд лууны цус хэрэглэх арван хоёр арга зүй ёсоор орно. Түүнчлэн цэцэн мэргэн ухаанаараа товойн Визенгамотын дээд шүүхийн гишүүн болсон юм. Олон хүмүүс 1945 онд Дамблдор Гриндевальд хоёрын дунд болсон халз тулаантай эн зэрэгцэх тулаан ид шидийн түүхэнд байхгүй гэж үздэг. Тэр үед гэрчээр байсан хүмүүс эгнэшгүй шидтэнгүүдийн тэмцлийг айдаст автан бишрэн харж байсан тухайгаа бичсэн байдаг. Дамблдорын ялалт нь шидтэний түүхэнд эргэлт хийсэн явдал болох Олон улсын нууцлалын холбоо байгуулагдсан болон Хэцүү нэртийг уналттай эн зэрэгцэхээр зүйл билээ.

Альбус Дамблдор хэзээ ч хийсэн зүйлсээрээ бардамнаж байгаагүй бөгөөд энэ агуу хүнийг алдсан явдал нь бидний хувьд нөхөж баршгүй хүнд гарз юм. Хэдийгээр би түүнтэй нөхөрлөж байсан хүний хувьд гүнээ эмгэнэж байгаа ч шидэт ертөнцөд тохиолдсон гарзтай харьцуулахын аргагүй билээ. Тэр Хогвартсуудын захирал дунд

эргэлзээгүй хамгийн гялалзсан захирал байлаа. Тэр үхсэн нь ч сүүлчийн амьсгалаа авах хүртэл лууны тууралттай хүүтэй анх уулзаад тусламжын гар сунгасан шигээ сайн үйлсэд хувь нэмэр оруулж байсан гэдэг нь эргэлзээгүй.

Харри уншиж дуусаад хавсралт хөрөг рүү харав. Дамблдор түүн рүү танил дотно инээдээрээ инээмсэглэн сонингийн цаасан дээрээс ч тэр Харриг цоо ширтэж байгаа юм шиг санагдахад уй гашуу доромжлогдсон мэдрэмж нэгэн зэрэг төрөв.

Тэр Дамблдорыг сайн мэддэг гэж бодсон ч бараг юу ч мэдэхгүй гэдгээ ойлгов. Тэр нэг ч удаа Дамблдор хүүхэд байхдаа юмуу эсвэл залуу байхдаа ямар байсан тухай төсөөлж байсангүй. Дамблдор яг л Харрийн мэддэгээр хөгшин мөнгөлөг үс сахалтай төрсөн юм шиг санагдана. Түүний өсвөр насны тухай төсөөлөх нь яг л Гермиона тэнэг болох юмуу эсвэл соплохвосттой нөхөрлөх гэж байгаатай адил туйлын хачирхалтай зүйл байлаа.

Түүнчлэн Харрийн толгойд хэзээ ч Дамблдорын өнгөрсөн үеийн тухай асуух бодол орж байсангүй. Мэдээж тийм асуулт хачирхалтай эрээ цээргүй санагдах ч эцсийн эцэст бүгд түүний Гриндевальдтай хийсэн домогт тулааныг мэдэг болохоор энэ ямар байсан болон бусад алдартай ололт амжилтыг нь асууж байсангүй. Үгүй тэд үргэлж Харригийн тухай, өнгөрсөн үеийнх нь тухай, ирээдүйнх нь тухай, төлөвлөгөөнийх нь тухай ярьдаг байсан ... Ингээд одоо Дамблдорын тухай асуух эцсийн боломжыг алдсан юм шиг санагдсан ч цорын ганц асуултанд нь үнэн хариулаагүй юм шиг санагдав.

«Та толинд харах үедээ юу хардаг вэ?»

«Би юу? Би өөрийгөө гартаа хос ноосон оймс барьсанаар хардаг».

Харри хэдэн хормыг бодлогоширон өнгөрүүлээд «Зөнч» сонинг нямбайлан хуйлж

«Хар урлагаас хамгаалах гарын авлага» ботийн дотор шургуулав. Дараа нь үлдсэн сонинг хогийн сав руу хаяад өрөөн дундуур эргэж харлаа. Одоо илүү цэвэрхэн

харагдаж байв. Цорын ганц хэвийн бус зүйл гэвэл дээрээ хагарсан толины хэлтэрхий бүхий «Өдөр тутмын зөнч» сонины дугаар орон дээр хэвтэж байлаа.

Харри өрөөн дундуур яваад сонинг авч эргүүлэв. Өнөөдрийн өглөөний уулийн шуудангаар ирэхэд нь тэр эхний нүүрийг хальт харахад Волдемортын тухай юу ч гараагүй байсан. Гэсэн ч ид шидийн яамнаас Волдемортын тухай мэдээ гаргахыг

«Зөнч» сонинд хориглосон гэдгэт итгэлтэй байлаа. Тэгтэл ажиглаагүй өнгөрсөн зүйлээ олж харав.

Хуудасны доод хэсэгт Дамблдорын түгшсэн зураг доор жижигхэн гарчиг тавьжээ.

ДАМБЛДОРЫН ТУХАЙ ЭЦСИЙН ҮНЭН ҮҮ?

Сүүлчийн долоо хоногт олон хүний цаг үеийнхээ хамгийн агуу гэж боддог шидтэний тухай цочирдуулсан мэдээ гараад байна. Түүний тухай бүгдийн мэдэх амирлангуй мөнгөн сахалтай цэцэн мэргэн ухаантай гэсэн дүр зургийг Рита Скитер хүнд хэцүү хүүхэд нас болон замбараагүй залуу нас, удаан хугацааны өс хонзон, өөртэйгээ булшинд цуг авч одсон гутамшигтай нууцийн тухай ярилцлагаараа өөрчилж байна.

Яагаад энэ хүн ид шидийн яамны сайдын суудлаас татгалзан жирийн нэг сургуулийн захирлаар үлдэхийг эрхэмлэсэн юм бол? Ямар зорилготойгоор Фениксийн бүлгэм нэртэй нууц байгуулагыг удирдаж байсан юм бол? Үнэн хэрэгтээ Дамблдор гэж хэн байв?

Энэ болон бусад олон асуултанд шуугиан тарьсан намтар болох «Альбус Дамблдорын хуурамч амьдрал»-ыг бичсэн Рита Скитер хариулж байна. Арван гуравдугаар хуудсанд түүнээс Бетти Брейтуэйтын авсан ярилцлагыг уншина уу.

Харри сонинг эргүүлээд арван гуравдугаар хуудсыг оллоо. Ярилцлагын дээр танил царай болох цайвар мушгиа үс, үнэт чулуугаар чимэглэсэн нүдний шилтэй эмэгтэй шүдээ яралзуулан инээмсэглэж уншигчид руу гараа даллаж байгаа нь үзэгдэв. Харри энэ дотор муухайрам үзэгдэлд анхаарал хандуулсангүй ярилцлагыг уншлаа.

Рита Скитерийн хүний хувьд аятайхан сэтгэгдэл төрүүлэм бөгөөд алдартай хүмүүсийн тухай бичсэн олон нийтлэлээрээ нэрд гарсан билээ. Би түүнтэй тохилог гэр бүлийнх нь гал зууханд аяга цай, зүсэм бялуугаар зочлуулан уулзахдаа сүүлийн үед гарсан цуу ярианы тухай ярилцлаа.

- Тиймээ, тэгэлгүй яахав Дамблдор бол мөрөөдлийн намтар. Тийм удаан дүүрэн амьдрал. Миний ном олон зүйлийн тэргүүнд байх болно гэдэгт итгэлтэй байна гэж Скитер хэлэв.

Скитер хэзээ ч хугацаа алдаж байсангүй. Ном есөн зуун хуудастай бөгөөд Дамблдорын зургаан сард нууцлагаар үхсэнээс хойш ердөө дөрвөн долоо хоногийн дотор бэлэн болжээ. Би түүнээс яаж ийм их хурдтай бичиж чадсаныг асуулаа.

- Өө, би төрөлхийн товлосон хугацаанд ажилладаг сэтгүүлч хүн. Би шидтэний ертөнц түүний намтар дүүрэн амьдралыг мэдэхийг хүснэ гэдгийг мэдэж байсан болохоор үүнийг түрүүлж биелүүлэхийг хүссэн юм.

Би саяхан Альбус Дамблдорын эртний найз, Визенгамотын зөвлөх Элифиас Дожын хэлсэн «Скитерийн номд шоколадан мэлхий дээрх зурагнаас ч бага баримт байгаа» гэснийг дурьдлаа.

Скитер толгойгоо гэдийлгэн хөхөрлөө.

- Хонгор Дожинька! Би түүнээс хэдэн жилийн өмнө усны хүмүүсийн тухай ярилцлага авснаа санаж байна. Тэгэхэд л бүрэн зөнөчихсөн байсан даа. Түүнд бид нуурын ёроолд сууж байгаа юм шиг санагдсан бололтой намайг загаснаас болгоомжлохыг гуйсан шүү.

Ингээд Элифиас Дожын тухай буруутгалыг орхиж шидэт ертөнцөд болсон явдлын тухай ярилцлаа. Скитер үнэхээр ахархан дөрвөн долоо хоногт Дамблдорын ер бусын урт гайхалтай амьдралын тухай бүрэн дүүрэн төрхийг олж чадсан гэж үү?

- Өө, хонгор минь гэж Скитер нүүр дүүрэн инээмсэглэн хэлээд миний гаран дээр элэгсэгээр цохилоо.

- Бид хоёул ямар мэдээлэл уут дүүрэн галлеон хүрдэгийг мэдэх болохоор Түргэн бичигч үзэгнээс «үгүй» гэсэн үг сонсохыг хүсэхгүй л байна шүү! Хэн

Дамблдорын тухай бохир үнэнийг ярихыг хүсэх юм бэ. Гэхдээ хөгшин Дожиньки Дожын хувьд үүлэн дээр хөвөхөө больсон нь дээр гэж зөвлөх байна. Яагаад гэвэл би бусад олон сурвалжлагчын шидэт саваагаа өгөх байсан эх сурвалжаас мэдээгээ авсан юм. Тэгээд ч тэр хэзээ ч Дамблдорын хүнд хэцүү залуу насных нь үед ойр байгаагүй.

Скитер номоо урьдчилсан байдлаар Дамблдорын өө сэвгүй амьдралд итгэгчдийг цочирдолд оруулах болно гэж сурталчилж байна. Үүнээс хамгийн том гэнэтийн бэлэг нь юу вэ? гэж би асуулаа.

- Боль доо, Бетти. Би номоо худалдахаас өмнө ямар нэг мэдээлэл өгөхгүй! гэж

Скитер инээд алдаад,

- Зөвхөн ганц зүйлийг амлахад Дамблдорыг сахал шигээ цэвэр цагаан гэж итгэж буй хүмүүсийг том урам хугарал хүлээж байгаа гэдгийг сануулъя! Түүнчлэн түүний Хэцүү нэртийн эсрэг хурц тод тэмцлийнх нь тухай сонссон хэн ч залуудаа өөрөө Хар урлагаар хөөцөлдөж байсан гэдгийг мэдэхгүй гэдгийг хэлэх байна! Сүүлчийн жилүүдэд тэр бүгдийн нүдэн дээр хүлцэнгүй аяглаж байсан ч залуудаа огтхон ч тийм үзэлтэй байгаагүй юм. Тиймээ Альбус Дамблдорын өнгөрсөн үе эргэлзээтэй гэр бүлийнх нь тухай үнэнийг ярилтгүйгээр туйлын бараан зүйл билээ гэв.

Би Скитерээс Дамблдорын дүү Аберфорт арван таван жилийн өмнө Визенгамотын шүүхэд ид шидийг хууль бусаар ашигласаны улмаас буруутгагдаж байсан тухай асуулаа.

- Тиймээ, Аберфорт бол зөвхөн овоолоостой шивхний өнгөн тал. Үгүй, үгүй би дүүгийнх нь ямаан дээр шившлэг хэрэглэсэн, эцгийнх нь магл гэмтээснээс ч долоон дор зүйлийн тухай ярьж байна. Тэдний үйлдлийг Дамблдор нууж чадаагүй бөгөөд хоёул Визенгамотоор шүүгдсэн. Үгүй миний сонирхлыг

туйлаас татаж байгаа зүйл гэвэл эх болон охин дүүгийнх нь богино амьдралын тухай бөгөөд жаахан түншиж үзээд тун бохир заваан зүйл олсон. Ер нь бол та бүхэнд хэлэхэд есөөс арван хоёр дугаар хуудаснаас тодорхой мэдээлэл авч болно. Одоо бол зөвхөн ганц л зүйлийг хэлж чадах байна. Дамблдор хэзээ ч хамраа хугалсан тухайгаа ярьж байгаагүйд гайхах юм алга гэж хэлье.

Хэрвээ гэр бүлийн ясыг өндөлзүүлэхээ болих юм бол Скитер Дамблдорын ид шидийн гялалзсан нээлтүүдийг үгүйсгэж байгаа хэрэг үү?

- Тиймээ түүнд үнэхээр толгой заясан гэж Скитер зөвшөөрөөд,

- Хэдийгээр Дамблдорын хүртсэн бүх ололт амжилтын талаар олон асуулт байдаг ч арван зургадугаар хуудсанд байгаа Ивор Дилонсбигийн үгээр бол түүний лууны цус хэрэглэх найман аргыг олж нээсэн цаасыг Дамблдор зээлдсэн гэсэн юм гэв.

Гэвч Дамблдорын хүртсэн зарим нэг ололт амжилтыг үгүйсгэх нь боломжгүй хэрэг билээ. Скитер түүний Гриндевальдтай тулалдсан домогт ялалтын тухай юу хэлэх бол?

- Өө, чамайг Гриндевальдын тухай сануулсанд баяртай байна нь гэж Скитер шаналангуй инээмсэглэн хэлээд,

- Би Дамблдорын гялалзсан ялалтанд итгэж байгаа хүмүүст жинхэнэ бөмбөг тэслэх байна хэмээн айж байна ... эсвэл магадгүй шивхэн бөмбөлөг ч юмуу. Тэр бол үнэхээр бохир түүх. Миний хэлж чадах зүйл гэвэл энэхүү домогт халз тулаан үнэн хэрэгтээ болсон гэдэгт итгэх хэрэггүй юм. Миний номыг уншсан хүмүүс Гридевальд ердөө шидэт савааны үзүүрт цагаан алчуур уяад чимээгүйхэн явсныг дуустал унших биз! гэв.

Энэ тухай болон сонирхсон олон сэдвээр Скитер хариу хэлэхээс татгалзсан учир бид уншигчдийн илүү сонирхох асуудалд орлоо.

- Өө, тийм л дээ, би Дамблдор болон Поттерын харьцааны талаар бүтэн бүлэг бичсэн байгаа. Тэднийг эрүүл бус тэр ч байтугай муу ёрын гэж нэрлэдэг. Мэдээж бүтэн түүхийг мэдэхийн тулд уншигчид миний номыг худалдан авч Дамблдор эхэндээ Поттерыг зүй бусаар сонирхож байсныг мэдэх боломжтой. Түүнд хүү үнэхээр ашигтай байсан уу? Үүнийг харцгаая. Гэхдээ Поттерын өсвөр насны амьдрал маш хүнд байсан нь хэн бүхний хувьд нууц биш хэрэг билээ.

Би Скиттерийг дэмжин өмнөх жил Харри Поттероос авсан алдартай ярилцлагынх нь тухай асуулаа. Тэр ярилцлаганд Харри Поттер Хэцүү нэрт эргэн ирсэн гэдэг шуугиан тарьсан мэдээлэл хийсэн билээ.

- Тиймээ, тэгэлгүй яахав бид маш ойрын холбоотой. Хөөрхий Поттерд жинхэнэ найз маш цөөн үлдсэн амьдралынх нь хамгийн хүнд хэцүү мөч болох Гурван шидтэний тэмцээний үеэр бид уулзаж байсан юм. Магадгүй зөвхөн би л жинхэнэ Харри Поттерыг мэдэх хүн байх.

Энэ нь биднийг Дамблдорын амьдралын сүүлчийн мөчтэй холбоотой маш олон дэгдсэн цуу ярианд хөтлөн авчирлаа. Скитер үнэхээр Поттерыг түүнийг үхэх агшинд хамт байсан гэдэгт итгэж байгаа болов уу?

- Би олон зүйлийг хэлэхийг хүсэхгүй байна. Энэ бүхэн номон дээр байгаа. Гэвч тэр үед шилтгээний дотор байсан хүмүүс Харри Поттер Дамблдорын унаж, үсэрч эсвэл түлхүүлсэн үйл явдал болсон газраас хэдэн хормын дараа гүйн гарахыг харсан байна. Үүнийхээ дараа Харри Поттер Северус Снеггийн эсрэг мэдүүлэг өгсөн. Энэ бүхэн үнэхээр тийм байсан гэж үү? Энэ тухай тодорхой мэдэхийг хүсвэл шидтэнгүүдийн ертөнц миний номыг уншаарай.

Энэхүү өдөөн хатгасан мэдэгдэл дээр би зочинтойгоо салах ёс гүйцэтгэсэн билээ. Скитерийн ном агшин зуур гүйлгэгдэн бестселлар болох нь эргэлзээгүй. Тэр үед Дамблдорын тоо тоомшгүй олон бишрэн шүтэгчид баатрынхаа тухай мэдэхээс эмээх бизээ.

Харри ярилцлагыг төгсгөл хүртэл уншаад хуудас руу гөлрөн харлаа. Уур хилэн жигшил зэвүүцэл төрөхөд сонинг базаад хана руу хүчтэй чулуудсанд дүүрэн хогтой хогийн саван дээр унав.

Тэр өрөөн дундуур холхиж эхлэн хоосон шүүгээг онгойлгон ямар нэг ном хайснаа дараа нь байранд нь буцааж тавиад бараг юу хийж байгаагаа мэдсэнгүй. Толгойд нь зөвхөн Ритагийн ярилцлагийн «Дамблдор Поттер хоёрын харилцааны тухай бүтэн бүлэг бичсэн байгаа ... тэднийг эрүүл бус тэр ч байтугай муу ёрын гэж нэрлэдэг ... тэр залуудаа өөрөө хар урлагаар хөөцөлдөж байсан ... би ихэнхи сурвалжлагчдын шидэт саваагаа өгөх байсан эх сурвалжаас мэдээллээ авсан» гэх зэрэг үгнүүд эргэлдэнэ.

- Худалч! гэж Харри гэнэтхэн хашгираад хөрш нь хэрхэн зүлэг услагчаа ажиллуулахаа больж дээшээ түгшин харахыг харлаа.

Харри орон дээрээ хүчтэй суухад хагарсан толины өөдөс түүн рүү үсрэв. Тэр хагархайг авч хуруундаа эргүүлээд Дамблдорын тухай болон Рита Скитерийн нэр төр гутаасан худал үгсийн тухай бодлоо ...

Хурц цэнхэр гэрэл гялсхийв. Харри хөшөөд зүссэн хуруугаа толины хурц ирмэгт гүйлгэн толинд харав. Төсөөлөгдсөн юм болов уу. Тэр Петунья эгчийн сонгосон эвгүйцэм тоорын өнгөтэй хана руу харав. Тэнд толинд туссан шиг ямар ч цэнхэр зүйл байсангүй. Тэр ахин толины хэлтэрхий руу харахдаа ногоон нүднийхээ тусгалыг харлаа.

Тиймээ төсөөлснөөс ондоо ямар ч тайлбар байх боломжгүй. Тэр үхсэн захирлынхаа тухай бодож байсан учир тэгж санагджээ. Хэрвээ ямар нэг зүйл гарцаагүй гэвэл тэр хэзээ ч Альбус Дамблдорын хурц цэнхэр нүдийг харахгүй нь тодорхой байлаа.

БҮЛЭГ 3: ДУРСЛИЙНХАН ЯВСАН НЬ

Үүдний хаалга тасхийх чимээ сонсогдоод «Хөөе чи!» гэж хашгирах чимээ дуулдав. Арван зургаан жилийн турш Харри иймэрхүү хандлагад дассан болохоор хэнд энэ

дуудлага хамаарагдаж байгаад эргэлзсэнгүй ч хариулах гэж яарсангүй. Тэр хормын

өмнө Дамблдорын нүд харагдах шиг санагдсан толины хагархай руу ширтсэн хэвээр байлаа. Тэгтэл нагац ахынх нь «Залуу!» гэж дуудах сонсогдлоо. Харри удаанаар босоод унтлагын өрөөний хаалга руу явахдаа хагархайг авч явах юмтай үүргэвчиндээ хийлээ.

- Чи юундаа хөдөлж ядаад байгаа юм! Буугаад ир. Ярих хэрэгтэй байна! гэж

Вернон Дурсль Харриг шатны талбай дээр гарч ирмэгц хэлэв. Харри гараа өмднийхөө халаасанд хийгээд гишгүүр уруудан буулаа.

Тэр зочны өрөөнд ороод Дурслийнханд бүрэн бүрэлдэхүүнээрээ байхыг харав. Тэд замд гарахаар хувцасласан бөгөөд Вернон ах хуучин хүрэмнийхээ цахилгааныг татан, Петунья эгч ягаан пальто өмсөж харин махлаг цайвар үстэй булчинлаг үеэл ах нь болох Дадли арьсан хүрэм өмссөн байв.

- За? гэж Харри асуулаа.

- Суу! гэж Вернон ах тушааснаа Харриг хөмсгөө үл ялиг өргөмөгц,

- Гуйж байна! гэж нэмэрлэхдээ энэ үг хоолойг нь маажсан мэт үрчийлээ.

Харри суулаа. Тэр юу болохыг мэдэж байв. Нагац ах нь зочны өрөөн дундуур урагш хойш холхиж эхлэхэд Петунья эгч, Дадли хоёр түгшсэн харцаар дагуулан харав. Эцэст нь Вернон ахын бодолд автсан том ягаан царай Харригийн урд зогсоод,

- Би бодлоо өөрчиллөө гэв.

- Ямар гэнэтийн бэлэг вэ гэж Харри хэлэв.

- Бүү тэгж ярь ... гэж Петунья эгч эхэлсэн ч Вернон ах гар даллан чимээгүй болгов.

- Энэ бүхэн чинь утгагүй зүйл! Би та нарын нэг ч үгэнд итгэхгүй байхаар шийдсэн. Бид хаашаа ч явахгүй үлдэнэ гээд Вернон ах Харри руу жижигхэн тооройн нүдээр харлаа.

Харри нагац ах руугаа харахдаа уур хилэн, хөгжилтэй болохыг мэдэрлээ. Сүүлчийн дөрвөн долоо хоногт Вернон Дурсль хорин дөрвөн цаг бүрт бодлоо өөрчилж тэр болгондоо тээшээ машинд ачиж буулгаж байлаа. Харрид бүхнээс илүү таалагдсан зүйл гэвэл Вернон ах Дадлийн чемодандаа гимнастикийн гантель хийснийг мэдэхгүй сүүлд тээшийн саванд хийх гэж оролдоод хөл дээрээ унаган өвдсөндөө орилон хараасан юм.

- Чиний үгээр бол Петунья, Дадли бид гуравт аюул заналхийлж байгаа хэрэг үү

... танай зүгээс ... танай ... гээд Вернон Дурсль ахин зочны өрөөн дундуур холхиж эхлэв.

- Тиймээ манай нэг зүгээс.

- Тэгвэл би үүнд чинь итгэхгүй байна гэж Вернон ах давтаад ахин Харрийн урд зогслоо.

- Би шөнөжингөө унтахгүй хэвтэж энэ тухай бодоод чамайг байшин эзэмдэхийг оролдон энэ яриаг үүсгэсэн болохыг ойлгосон.

- Байшинг гэнээ? Ямар байшин? гэж Харри асуулаа.

- Энэ байшин! гэж Вернон ах орилоход духны судас нь гүрийв.

- Манай байшин! Эндхийн бүс нутагт амьдрахад газар их үнэтэй! Чи биднийг эндээс явахыг хүсээд дараа нь ямар нэгэн фоукус мокус гээд ойлгож ч амжаагүй байхад байшин чиний нэр дээр болсон байх биз ...

- Та чинь ухаан солиороо юу? Байшинг эзэмдэхийг оролдсон гэнээ? Та үнэхээр тэнэг юм уу эсвэл дүр үзүүлээд байгаа хэрэг үү?

- Чи яаж зүрхэлж байна! хэмээн Петунья эгч хашгирсан ч Вернон ахин гар даллан зогсоолоо.

- Хэрвээ та нар мартсан бол надад загалмайлсан эцгийн минь үлдээсэн байшин байгаа. Иймбайхад би танайхыг хүсэх үү? Аз жаргалаар дүүрэн дурсамжын төлөө юу?

Энэ удаад Вернон ах чимээгүй болов. «Энэ маргаан илүү итгүүлэх шиг боллоо» гэж

Харри бодов.

- Чи танай лорд чинь итгэлтэй байна уу ... юу гэдэг билээ ... гээд Вернон ах ахин холхиж эхлэв.

- Волдеморт гэж Харри тэвчээргүйхэн хэлээд,

- Бид энэ тухай зуун удаа ярилцсан. Тэгээд ч энэ таавар биш баримт. Дамблдор таньд өнгөрсөн зун хэлсэн бас Кингсли, ноён Уизли хоёр ... гэв.

Вернон Дурсль ууртай агзасхийхэд Харри нагац ах нь хоёр насанд хүрсэн шидтэн зуны амралтын анхны өдөр урьдаас мэдэгдэлгүй айлчилан ирсэн тухай бодлоо хөөхийг оролдож байгааг ойлголоо. Кингсли Бруствер, Артур Уизли хоёр гэрт нь ирсэн явдал Дурслийнхнийг таагүй цочирдолд оруулсан билээ. Харри үнэндээ ноён Уизли зочны өрөөний хагасыг нураасан болохоор түүний ахин ирэлт нь Вернон ахыг баярлуулаагүй гэдэгт итгэлтэй байв.

- Кингсли, ноён Уизли хоёр та нарт бас тайлбарласан гэж Харри өрөвдөх сэтгэлгүй үргэлжлүүлэв.

- Намайг арван долоо хүрэхэд энэ байшинг хүрээлсэн хамгаалалтын шид эвдэгдэх учир та нар надаас дутуугүй аюултай байдалд орно. Бүлэг Волдеморт та нарыг барьж миний хаа байгааг хэлүүлэхээр тамлана гэдэгт

итгэлтэй байгаа тул хэрвээ барьцааны хүн болох гээгүй бол би та нарыг аврахыг хичээж байна.

Вернон ахын харц Харрийнхтай тулгарлаа. Харри энэ агшинд хоёул нэг зүйл бодож байгаа гэдэгт итгэлтэй байв. Дараа нь Вернон ах үргэлжлүүлэн алхаж эхлэхэд Харри,

- Та нар зайлшгүй нуугдах хэрэгтэй үүнд бүлэг туслахад бэлэн байгаа. Байж болох хамгийн сайн хамгаалалтыг санал болгож байна гэв.

Вернон ах хариулсангүй урагш хойш үргэлжлүүлэн холхисон хэвээр байлаа. Гадаа нар гудайж амьд бургасан хашааны оройг гийгүүлэв. Хөршийн зүлэг услагч ахин доголдлоо.

- Би танайд ид шидийн яам байдаг гэж бодсон юмсан? хэмээн Вернон Дурсль гэнэтхэн огцом хэлэв.

- Байдаг гэж гайхсан Харри хэллээ.

- Тэгвэл тэр чинь яагаад бид нарыг хамгаалж болдоггүй юм бэ? Минийхээр бол бид тэмдэгтэй хэн нэгэн хөөгдөж байхад гэм зэмгүй хохирогчид болохоор хамгаалах ёстой!

Харри инээд алдав.

- Та ноён Уизли, Кингсли хоёрын юу хэлэхийг сонссон. Бид яаманд дайсны тагнуул байгаа гэж бодож байгаа.

Вернон ах ахин зуухны өмнө хүндээр амьсгаадан холхиход том хар сахал нь өрвийж царайны өнгө нь хүрэн улаан болов.

- За, сайн байна гэж тэр хэлээд Харрийн урд зогсож,

- Сайн байна бид энэ хамгаалалтыг авахыг зөвшөөрье. Гэхдээ биднийг яагаад танай Кингсли хамгаалж болохгүйг ойлгохгүй байна гэв.

Харри нүдээ эргэлдүүлэхгүй байж арайхийн тэслээ. Энэ асуултыг тэр хэдийн арав дахиа сонсоод байгаа билээ.

- Бид таньд хэлсэн биз дээ. Кингсли сайдыг хамгаалж байгаа гэж ... танай ерөнхий сайдыг гэж шүд зуун хэлэв.

- Тийм л дээ! Яагаад гэвэр тэр хамгийн илүү! гэж Вернон ах батлаад хуруугаараа зурагтын харанхуй дэлгэц рүү заав. Дурслийнхан мэдээн дээрээс Кингсли ямар нэг эмнэлэг рүү маглуудын ерөнхий сайдын хамт алхан орж байсныг харжээ. Энэ бүхэн дээр нэмээд Кингсли маглууд шиг хувцаслаж удаан бөгөөд гүн тайвшируулсан хоолойгоор ярьдаг нь Дурслийнханд ямар ч шидтэнгээс илүү нөлөөлсөн юм. Гэхдээ үнэн хэрэгтээ тэд дуртай ээмгээ зүүсэн байхыг нь нэг ч удаа хараагүй билээ.

- Ер нь бол тэр завгүй байгаа. Гэхдээ Гестия Жонс, Дедалус Дингл хоёр энэ ажилд илүү тохиромжтой ...

- Хэрвээ тэд бидэнд ямар нэг баримт үзүүлэхгүй бол ... гэж Вернон ах эхлэхэд Харрийн тэвчээр барагдлаа. Тэр хөл дээрээ үсрэн босоод нагац ах руугаа очин энэ удаад өөрөө зурагтын хоосон дэлгэц рүү зааж,

- Эдгээр золгүй явдлууд бол ямар ч золгүй явдал биш. Авто машины осол, дэлбэрэлт болж байгааг бид сүүлийн үеийн мэдээгээр харсан. Хүмүүс алга болж үхэж байгаагийн ард Волдеморт байгаа. Би түүнийг зөвхөн хөгжилтэй байхын тулд маглуудыг алдаг гэж та нарт олон удаа хэлсэн. Тэр ч байтугай манан хүртэл ... тэднийг Дементорууд үүсгэж байгаа юм хэрвээ та нар санахгүй бол, хүүгээсээ асуу! гэв.

Дадлийн гар өргөгдөн амаа дарлаа. Дараа нь тэднийг харж байгааг мэдсэн бололтой гараа удаанаар буулгаж,

- Тэд ... илүү олон уу? гэв.

- Олон уу гэнээ? хэмээн Харри инээвхийлээд,

- Чам руу дайрсан хоёроос илүү гэж асууж байна уу? Мэдээж тэд их. Тэд хүний айдас цөхрөлөөр хооллодог болохоор зуугаад байсан ч одоо мянга болсон байж болзошгүй ...

- За за! Чи биднийг итгүүллээ гэж Вернон Дурсль сөөнгөтөв.

- Найдаж байна яагаад гэвэл намайг арван долоон нас хүрэх өдөр энэ бүх Үхэл залгигчид, Дементорууд магадгүй инферналууд ч байж магадгүй ... хар шидтэний илбэдсэн хүүр ... та нарын байгаа газар руу дайрах болно. Хэрвээ та сүүлчийн шидтэй тэмцсэн оролдлогоо санаж байвал тусламж шаардагдана гэдгийг зөвшөөрч байгаа биз дээ.

Хэсэг зуур нам гүм болоход алсад Хагридын үүд эвдэлсэнтэй адилхан чанга чимээ цуурайтав. Петунья эгч Вернон ахаас нүд салгалгүй ширтэхэд, Дадли Харри руу харлаа. Эцэст нь Вернон ах,

- Миний ажил яах болж байна? Бас Дадлигийн сургууль? Энэ бүх зүйлээ хийх ажилгүй шидтэнгүүдийн тулд орхих болж байна уу? гэлээ.

- Та ойлгосонгүй гэж үү? Тэд та нарыг эцэг эхийг минь алсан шиг зовоон алах болно! гэж Харри дуу алдав.

- Аваа. Аваа ... би энэ бүлэгтэй явсан нь дээр гэж бодож байна хэмээн Дадли чанга хэлэв.

- Дадли чи амьдралдаа анх удаа ухаалаг зүйл хэллээ гэж Харри хэлэв.

Тэр энэ тэмцэлд хожсон гэдгээ ойлгожээ. Хэрвээ Дадли айж бүлгээс тусламж авахыг зөвшөөрч байгаа бол эцэг эх нь түүнтэй нэгдэх болно. Тэд Диднькагаасаа холдохыг зөвшөөрч чадахгүй шүү дээ. Харри зуухны тавиур дээр байгаа цаг руу харснаа,

- Тэд энд таван хормын дараа ирнэ гэж хэлээд Дурслийнхны хэн нэгэн хариу хэлэхээс өмнө зочны өрөөнөөс гарлаа. Нагац ах, эгч, үеэл ахтайгаа салах ёс гүйцэтгэх явдал нь үргэлж хөгжилтэй байдаг бөгөөд үүнд огтхон ч

гомддоггүй байлаа. Арван зургаан жил бие биенээ хайрлаагүй амьдарсан хүмүүсийн хувьд өөр юу хэлэх гэж?

Харри унтлагын өрөөндөө эргэж ирээд чиглэсэн юмгүй үүргэвчээ ухаж уулийн самар аваад Хэдвигийн торонд шургуулав. Түүнийг торны ёроолд унахад Хэдвиг тоосонгүй.

- Бид эндээс удахгүй явна. Тэгэхэд чи ахиж нисэж чадна гэж Харри хэллээ. Хаалганы хонх дуугарлаа. Харри бага зэрэг тээнэгэлзсэнээ унтлагын өрөөнөөс гарч доош уруудав. Тэр Дурслийнхан Гестия, Дедалус хоёртой түүний үгүйд учраа ололцож чадна гэж бодсонгүй.

- Харри Поттер! Ямар их хүндэтгэл вэ, үргэлжид! гэж түүнийг хаалга онгойлгохтой зэрэгцэн догдолсон хоолой гараад ягаан бортгон малгайтай жижигхэн хүн бөхийн ёслов.

- Баярлалаа, Дедалус гээд Харри хар үстэй Гестия руу ичингүйрэн инээмсэглэв.

- Би та нарыг ийшээ ирсэнд их талархаж байна ... Тэд тэнд байгаа миний нагац ах, эгч, үеэл ах ...

- Харри Поттерын хамаатнуудад сайхан өдрийг хүсье! гэж Дедалус зочны өрөөнд ороод баяртай хэлэв.

Дурслийнхан тийм мэндчилгээ хүлээгүй бололтойд Харри бодлоо өөрчлөх вий гэж айлаа. Дадли шидтэнгүүдийг хармагц эхдээ наалдав.

- Та нарын замд гарахад бэлэн болсныг харж байна. Маш сайн байна!

Төлөвлөгөөг Харри та нарт хэлсэн байх гээд Дедалус хантаазныхаа дотор халааснаас том цаг гарган харж,

- Бид Харригаас урьд замд гарах юм. Танай гэрт ид шид хэрэглэх нь аюулгүй биш ... Харри насанд хүрээгүй байгаа болохоор тийм алхам ид шидийн яаманд баривчлах шалтаг өгч болох юм ... Бид арван миль яваад дараа нь аюулгүй газраас та нарыг авч шилжинэ. Ингэхэд та машин жолоодож чадах уу? гэж Вернон ахаас асуулаа.

- Намайг чадах уу гэнээ? Чөтгөр ав, мэдээж чадна! гэж Вернон ах дуу алдав.

- Таны зүгээс их ухаалаг хэрэг байлаа, ноёнтоон. Би энэ товчлууруудын учрыг олж чадахгүй будилаад байдаг юм гэж Дедалус хэлэв. Тэр харваас төлөвлөгөөний тухай хэлсэн үгийнх нь дараа итгэлтэй байдлаа алдсан Вернон Дурсльд тал засах гэж бодсон бололтой.

- Жолоо ч барьж чаддаггүй юм байна гэж тэр ууртай бувтнасан ч аз болоход Дедалус, Гестия хоёр энэ үгийг сонссонгүй.

- Харри та энд хамгаалалт хүлээх ёстой. Манай төлөвлөгөөнд зарим нэг өөрчлөлт орсон ... гэж Дедалус үргэлжлүүлэв.

- Тэгсэн гэж үү? Би Хурц нүдэт ирээд түүний хамт шилжинэ гэж бодсон юмсан.

- Үгүй. Хурц нүдэт таньд бүх зүйлийг тайлбарлаж өгнө гэж Гестия хэлэв.

Дурслийнхан тэдний яриаг сонссон хэдий ч ойлгосонгүй гэтэл «Яараарай!» гэх чанга хоолой гарахад цочлоо. Харри эргэн тойрноо харснаа энэ хоолой Дедалусын халаасны цагаас гарсан болохыг ойлгов.

- Таны зөв бид маш их шахуу хуваартай гэж Дедалус цагандаа толгой дохин хэлээд хантаазныхаа халаасанд хийлээ.

- Бид цаг нь болохоор Харри таны төрөл төрөгсдийг шилжих газар хүргэнэ.

Тийм аргаар хамгаалалтын ид шид цуцлагдах агшинд та бүгд аюулгүй газар очих юм гээд Дурслийнхан руу эргээд,

- Тэгэхээр замд гарахад бүх зүйл бэлэн болсон уу? гэв.

Түүнд хэн ч хариулсангүй. Вернон ах айсан шинжтэй нүдээ бүлтийлгэн Дедалусын хантаазны халаас руу харлаа.

- Бид гадаа үүдэнд хүлээж байсан нь дээр байх, Дедулас гэж Гестия аяархан хэлэв. Тэр харваас зочны өрөөнд үлдэх нь Харриг Дурслийнхантай нулимс дүүрэн салах ёс гүйцэтгэхэд саад болно гэж бодсон нь бололтой.

- Хэрэггүй гэж Харри хэлэхэд Вернон ах цаашид илүүц тайлбар хүлээсэнгүй чангаар,

- За, тэгэхээр баяртай шив хүү минь гэв.

Тэр Харри руу гар барихаар баруун гараа сунгасан авч хамгийн сүүлчийн агшинд гараа зангидан дээш доош савчлаа.

- Чи бэлэн үү, Дидди? гэж Петунья эгч асуугаад Харри руу харахаас зайлсхийн цүнхнийхээ түгжээг шалгалаа.

Дадли хариулсангүй амаа ангайн зогссон нь Харрид аварга биет Гроххыг санагдуулав.

- Тэгвэл явцгаая гэж Вернон ах хэллээ.

Түүнийг зочны өрөөний үүд рүү бараг хүрч байтал Дадли,

- Ойлгохгүй байна гэж бувтналаа.

- Чи юу ойлгосонгүй гэж, үр минь? гээд Петунья эгч хүү рүүгээ харлаа. Дадли махлаг гараа өргөөд Харри руу заалаа.

- Тэр яагаад бидэнтэй хамт явахгүй байгаа юм?

Вернон ах, Петунья гэч хоёр шалнаас ургасан мэт зогсоод Дадли бүжгийн жүжигчин болохыг хүссэн аятай мэлрэн харлаа.

- Юу? гэж Вернон ах чанга асуув.

- Тэр яагаад бидэнтэй хамт явахгүй байгаа юм бэ?

- Тэр ... тэр хүсэхгүй байгаа гэж Вернон ах хэлээд Харри руу ууртай харж,

- Чи үүнийг хүсэхгүй байгаа биз дээ? гэв.

- Өчүүхэн ч үгүй гэж Харри хэлэв.

- Харж байна уу. За, явцгаая.

Тэр зочны өрөөнөөс гаран үүдний хаалга онгойлгосон ч Дадли байрандаа зогссон хэвээр байсан тул Петунья эгч итгэлгүйхэн хэдэн алхам хийснээ бас зогслоо.

- Одоо бас юу вэ? гэж Вернон ах ахин зочны өрөөний босгон дээр гарч ирээд зандарлаа.

Дадли харваас үгээр гаргаж хэлэхэд хэтэрхий хүнд бодолтойгоо тэмцэж байгаа бололтой. Тэгснээ хэдэн хормын зовлонтой тэмцлийн эцэст,

- Тэр тэгвэл хаачих гэж байгаа юм бэ? гэв.

Петунья эгч, Вернон ах хоёр бие бие рүүгээ харав. Дадли тэднийг айлгасан нь илт. Нам гүмийг Гестия Жонс эвдэн,

- Гэхдээ ... та нар зээгээ хаашаа явах гэж байгааг мэдэж биз дээ? хэмээн бодлогоширон асуулаа.

- Мэдээж бид мэдэж байгаа гэж Вернон Дурсль хэлээд,

- Та нарын нэг рүү биз дээ? За болно, Дадли машинд суу яарах хэрэгтэй байна гэв.

Вернон Дурсль ахин үүдний хаалга руу явсан ч Дадли түүний араас хөдөлсөнгүй.

- Манайхны нэг рүү гэнээ?

Гестия гарцаагүй уурслаа. Харри шидтэнгүүд түүний ойрын хамаатангууд алдартай Харри Поттерыг хэр сонирхдогийг ойлгохгүй болохоороо гаргадаг энэ царайны хувирлыг сайн мэдэх билээ.

- Бүх зүйл хэвийн. Үнэнийг хэлэхэд энэ чухал биш гэж Гестияг итгүүлэв.

- Чухал биш гэнээ? хэмээн Гестия хоолойгоо өндөрсөн хэлээд,

- Үнэхээр энэ хүмүүс таны хаашаа явах гэж байгааг чинь ойлгохгүй байгаа гэж үү? Ямар аюул заналхийлж байгааг мэдэхгүй байгаа юм уу? Волдемортын эсрэг тэмцлээрээ хүмүүсийн зүрхэнд ямар ховор байр эзэлснийг чинь төсөөлөхгүй байгаа хэрэг үү? гэв.

- Э-э-э ... үгүй, ойлгохгүй. Үнэн хэрэгтээ тэд намайг дасал болсон газар луугаа

...

- Би чамайг тийшээ явна гэж бодоогүй.

Хэрвээ Харри Дадлийн уруул хөдлөхийг хараагүй байсан бол чихэндээ итгэхгүй байлаа. Ингээд хэдэн хором Дадли руу харж энэ үг үнэхээр түүний үеэл ахаас гарсан гэдгийг тодруулав. Харри гайхсандаа эвгүйцэхээ мэдэрлээ.

- За ... э-э-э ... баярлалаа, Дадли.

Түүнд ахин Дадли бодолтойгоо тэмцэх шиг санагдсанаа,

- Чи миний амьдралыг аварсан гэв.

- Ер нь бол амьдрал биш л дээ. Дементорууд зөвхөн чиний сэтгэл санааг авна.

Тэр үеэл ах руугаа сониучирхан харлаа. Энэ зун тэд хоорондоо бараг яриагүй бөгөөд Харри Улаан модон гудамжинд эргэн ирээд ихэнхи цагаа өрөөндөө өнгөрүүлсэн билээ. Түүнд одоо гэнэтхэн аяга хүйтэн цай занга биш гэдэг нь ойлгомжтой болов. Дадли амаа хэдэнтээ хамхиж нээснээ хүрэнтэн чимээгүй болов.

Тэгтэл Петунья эгч гэнэтхэн нулимс асгаруулав. Гестия Жонс түүнийг дэмжсэн харцаар урамшуулсан ч Харри руу биш Дадлиг ухасхийн тэвэрсэн явдалд эгдүүцэн уурслаа.

- Ямар эелдэг юм, Дадли ... тийм сайн хүү ... б-баярлалаа гэж хэлдэг хэмээн нүсэр том цээжийг нь тэврэн мэгшлээ.

- Тэр ерөөсөө баярлалаа гэж хэлээгүй! хэмээн Гестия уурсан дуу алдаад,

- Тэр ердөө Харриг тийшээ явна гэж бодохгүй байна гэж хэлсэн гэв.

- Дадлийнхаар бол энэ нь «Би чамд хайртай» гэж хэлж байгаа юм хэмээн Харри уурлах баярлахын хооронд инээх хүслээ арай ядан дарж хэлэхэд Петунья эгч Дадлиг тэврэн зогссоор байлаа.

- Бид явахгүй юмуу үгүй юм уу? хэмээн зочны өрөөний хаалган дээр ахин гарч ирсэн Вернон ах орилов.

- Хэн нэгэн шахуу хуваарийн тухай яриад байгаагүй билүү!

- Тиймээ, тийм явцгаана хэмээн болсон үйл явдлыг мэгдэн харж байсан

Дедалус Дингл сэхээ орон дуугарснаа,

- Бид үнэхээр явах хэрэгтэй. Харри ... гээд түүн рүү алхан хоёр гараараа алгыг нь хавсарлаа.

- ... амжилт хүсье. Ахин уулзана гэж найдъя. Шидэт ертөнцийн найдлага таны мөрөн дээр байгаа шүү.

- Өө, тийм л дээ. Баярлалаа.

- Баяртай, Харри. Бидний зүрх сэтгэл үргэлж таньтай хамт гээд Гестия бас гар барилаа.

- Би тэдний бүх зүйл хэвийн гэж бодож байна гээд Харри Петунья эгч, Дадли хоёр руу харлаа.

- Эцэст нь бид сайн нөхөд болно гэдэгт итгэлтэй байна гэж Дингл хөгжилтэй хэлээд зочны өрөөг орхихдоо бүрхээрээ даллав. Гестия түүний араас дагав.

Дадли ээжийнхээ тэврэлтээс алгуур мултарч Харри руу ирээд том ягаан гараа сунгалаа.

- Бурхан минь, Дадли! Чи чинь яагаа вэ, Дементорууд чамайг өөрчилчихөө юу?

гэж Харри Петунья эгчийн цурхиралтыг давахын тулд чанга хэллээ.

- Мэдэхгүй. Дараа уулзая, Харри.
- Тиймээ гээд Харри Дадлигийн гарыг барьж сэгсэрлээ.
- Магадгүй л юм. Болгоомжтой байгаарай, том Дэ.

Дадли бараг л инээмсэглээд зочны өрөөнөөс гарав. Харрид түүний хайрга шажигнуулан алхах дуулдсанаа дараа нь машины хаалга тас хийн хаагдах чимээ сонсогдов.

Петунья эгч нүүрэндээ нусны алчуур наагаад цурхиран уйлж байснаа энэ чимээгээр эргэн тойрноо харлаа. Тэр харваас Харритай ганцаар үлдэнэ гэж бодоогүй бололтой. Яаран алчууraа халаасандаа хийгээд,

- За ... баяртай гээд эргэж харалгүй хаалга руу явлаа.
- Баяртай гэж Харри хэлэв.

Тэр зогссоноо эргэж харлаа. Агшин зуур Харрид тэр ямар нэг зүйл хэлэхийг хүссэн юм шиг хачирхалтай мэдрэмж төрлөө. Гэвч Петунья эгч ердөө түүнийг хулчгардуу харцаар харж ам нээснээ дараа нь толгойгоо сэгсрээд зочны өрөөнөөс гүйн гарч нөхөр хүүгийнхээ араас явлаа.

БҮЛЭГ 4: ДОЛООН ПОТТЕР

Харри шатаар гүйн унтлагын өрөөндөө ороод цонхоор Дурслийн машин гудамжны замаар явахыг харав. Арын суудалд Петунья эгч Дадли хоёрын дунд суусан Дедалусын бортгон малгай цухуйж үзэгдэнэ. Улаан модон гудамжны эцэст машин баруун тийш эргэхэд жаргаж буй нарны туяа цонхонд нь гялсхийгээд нүднээс далд оров.

Харри Хэдвигийн тор, «Аянга», үүргэвчээ аваад сүүлчийн удаа дасал болоогүй цэмцгэр болсон унтлагын өрөөгөө тойруулж харан доош уруудаж шатны хөлд тор, шүүр, үүргэвчээ тавилаа. Бүрэнхий болж эхлэн үдшийн сүүдэр унажээ. Ийм нам гүмд зогсон одоохон энэ гэрийг үүрд орхих гэж байна гэдэг нь туйлын хачирхалтай хэрэг байлаа. Дурслийнхан эртнээс хаа нэг тийш явахдаа түүнийг ганцаар орхих нь Харрийн хувьд ховорхон тохиолдох зүйл байв. Гал зуух руу хөргөгчнөөс ямар нэг амттай зүйл авахаар гүйх юмуу, дээшээ Дадлигийн компьютерийн тоглоомоор ухасхийж эсвэл зурагт асааж дуртай сувгаа солин үзэж болно. Одоо тэр үеэ санахад дотор нь ойлгомжгүй хоосон мэдрэмж төрлөө.

- Сүүлчийн удаа байшинг харахыг хүсч байна уу? гэж тэр толгойгоо далавчин дороо гомдолтой шургуулан торонд сууж байсан Хэдвигээс асуулаа.

- Бид ийшээ хэзээ ч эргэж ирэхгүй. Чамайг энд байхад тохиолдсон таатай бүх зүйлсийн тухай санахыг хүсэхгүй байгаа биз дээ? Жишээлбэл энэ үүдний хивсийг хардаа. Ямар дурсамж агуулж байна гээч ... Дадли энд намайг Дементороос аварсны дараа унасан ... Ингээд тэр эцэст нь надад талархсан гэвэл чи итгэх үү? ... Харин өнгөрсөн зун энэ хаалгаар Дамблдор орж ирж билээ.

Харрийн бодол агшин зуур үймсэн ч Хэдвиг цэгцлэхэд нь туслах хүсэлгүй толгойгоо далавчин дороо шургуулсан хэвээр байв. Харри үүдний хаалганаас эргэлээ.

- Харин энд би унтдаг байсан юм, Хэдвиг гээд шатны хонгилын хаалгыг нээснээ,

- Бид тэгэхэд танилцаагүй байсан. Бурхан минь, би ямар жижигхэн гэдгийг нь мартчихаж ... гэв.

Тэр овоолсон хуучин гутал шүхэр рүү харснаа өглөө бүр шатны дор сэрэхдээ хоёр аалз хардаг байснаа саналаа. Тэдгээр өдрүүдэд эцэг эх нь хэрхэн үхсэн яагаад эргэн тойронд нь янз бүрийн зүйлс болж байдаг гэдгийг мэддэггүй байв. Гэвч ганц зүйл болох ойлгомжгүй ногоон гэрэл гялсхийдэг зүүдийг одоо хүртэл санасан хэвээр бөгөөд нэг удаа Вернон ах Харрийн моторт дугуйгаар ниссэн тухай сонсоод золтой л машины осолд ороогүй билээ ...

Гэнэтхэн дэргэд нь шахуу чих дөжрөм чимээ гарав. Харри огцом өндийхдөө толгойгоо намхан адарт цохьчихлоо. Тэр Вернон ахын дуртай хараалын үгийг сонсохыг хэсэг зуур хүлээзнэснээ толгойгоо барьсаар гал зуух руу орж цэцэрлэг рүү харсан цонхоор харлаа.

Харанхуй цэцэрлэг чичирэн долгиолох шиг санагдав. Дараа нь нэг нэгээрээ Хувирах шидээс тайлагдсан хүмүүсийн дүрс ялгагдаж эхлэв. Эдгээр хүмүүсийн голд хамгаалалтын шил бүхий дуулгатай Хагрид хар шаахайтай том мотоцикль дээр суусан байлаа. Түүнийг эргэн тойрон дахь хүмүүс ердийн арга болох шүүрнээс бууж хоёр нь ясархаг морин дээр суужээ.

Харри арын хаалга нээн яаран тэдний дунд орлоо. Угтан хашгирах баяртай дуу сонсогдоод Гермиона түүнийг тэвэрч, Рон нуруун дээр нь алгадан харин Хагрид,

- Харри, чи явахад бэлэн үү? гэв.

- Мэдээж. Гэхдээ би та нарыг ийм олуулаа ирнэ гэж бодсонгүй! хэмээн Харри баясан инээмсэглэж хэллээ.

- Төлөвлөгөө өөрчлөгдсөн гэж хоёр том үүргэвч үүрсэн Хурц нүдэт сөөнгөтөөд шидэт нүд нь толгой эргэм хурдтайгаар харанхуй тэнгэр болон байшин цэцэрлэг рүү эргэлдэв. - Алив ярихаас урьд байшинд орцгооё.

Харри гал зууханд тэргүүлэн ороход тэд инээлдэн хөөрөлдсөөр Петунья эгчийн гялалзтал цэвэрлэсэн сандал болон бусад тавилга дээр суугаад нэг ч толбогүй хана налав. Өндөр туранхай Рон, өтгөн үсээ урт нарийхан сүлжсэн Гермиона, адилхан инээмсэглэсэн Фред, Жорж хоёр, урт үс эвгүй сорвитой Билл, элдэгхэн царай хазайсан нүдний шилтэй ноён Уизли, хурц цэнхэр нүд нь аягандаа зогсолтгүй эргэж байгаа доголон Грюм, өнөөдөр богино үс нь дуртай хурц ягаан өнгийн болж хувирсан Тонкс, улам буурал болж үрчлээ нь нэмэгдсэн Люпин, гоолиг үзэсгэлэнтэй мөнгөлөг урт үстэй Флер, халзан толгой өргөн мөртэй Кингсли, толгойгоороо адар мөргөхгүйн тулд бөхийн зогссон өтгөн үс сахалтай Хагрид, жижигхэн бие бохир ширэлдсэн үс, гунигтай анч нохой шиг нүдтэй Наземникус Флетчер нар байлаа. Харри итгэмээргүй зочдоо тойруулан харахдаа тэдэнд хичнээн дасал болсноо мэдэж зүрх нь халуу оргин тэр ч байтугай сүүлчийн уулзалтаараа боомилж алах шахсан Наземникусыг хүртэл харахад таатай байлаа.

- Кингсли би таныг маглуудын ерөнхий сайдыг харж байгаа гэж бодсон юмсан?

гэж гал зуухны дундуур хуучин танилдаа хандан хэлэв.

- Тэр намайг үгүйд нэг шөнө болно биз. Чи илүү чухал гэж Кингсли хэлэв.

- Харри, чи энэ юу болохыг тааварла даа? гээд Тонкс угаалгын машин дээрээс зүүн гараа өргөхөд бөгж гялсхийв.

- Та хоёр гэрлээ юу? гэж Харри дуу алдаад Люпин руу харлаа.

- Чи тэнд байгаагүй чинь харамсалтай байна, Харри. Бүх зүйл их чимээгүй болсон доо.

- Ямар гайхамшигтай хэрэг вэ, баяр ...

- За болно, болно бидэнд дараа ярилцах цаг олдоно гэж Грюм зандрахад гал зууханд даруй чимээгүй болов. Тэр үүргэвчээ шалан дээр буулгаад Харри руу эргэж,

- Дедалиус чамд төлөвлөгөө өөрчлөгдсөн гэдгийг хэлсэн байх. Пиус Тикнесс дайсны талд урвасан нь бидэнд ноцтой асуудал болоод байна. Тэр ид шидийн

яамаар энэ гэрийн нисдэг дарины сараалж, зөөвөрлөгч ашиглах боломжыг хянаж тэр ч байтугай дурын шилжих оролдлого хийсэн хэнийг ч гэмт хэрэгтэн болгон шоронд суулгахад бэлэн байна. Энэ бүгдийг чамайг Хэцүү нэртийн дайралтаас хамгаалан аюулгүй байдлын чинь төлөө хийж байгаа гэсэн. Гэхдээ чи эхийнхээ найдвартай хамгаалалтанд байгаа болохоор энэ бүхэн утгагүй хэрэг. Үнэн хэрэгтээ тэр чамайг эндээс аюулгүй авахад саад болох гэж оролдож байгаа юм. Хоёр дахь асуудал гэвэл чи насанд хүрээгүй хэвээр байгаа болохоор Хяналтын шидийн үйлчлэл дор байгаа.

- Би ...

- Тиймээ Хяналтын, Хяналтын! гэж Хурц нүдэт тэвчээргүйхэн хэлээд,

- Энэ бол ид шидийн яамнаас насанд хүрээгүй шидтэнийг хянахад хэрэглэдэг шидийн үйлдэл юм! Хэрвээ чи юмуу эргэн тойронд чинь хэн нэгэн шившлэг хэрэглэвэл ийшээ дуудлага ирж Тикнесс энэ тухай мэдэх бөгөөд Үхэл залгигчид ч гэсэн адил мэдэх юм гэв.

- Чамайг арван долоо хүрэх агшинд эхийн чинь хамгаалалт тайлагдах болохоор бид Хяналтын шид тайлагдахыг хүлээх боломжгүй юм. Товчхондоо хэлэхэд Пиус Тикнесс чамайг гарцаагүй буланд шахахаар бодсон байгаа.

Харри үл таних Пиусын хандлагыг зөвшөөрч чадсангүй.

- Тэгээд бид юу хийх ёстой вэ?

- Хяналтын шидэнд илрүүлэгдэхгүй тээврийн хэрэгслийг ашиглах болно. Учир нь бидэнд шүүр, фестрал, Хагридын мотоциклийг ашиглахад ямар ч шившлэг хэрэггүй.

Харри тэгэхэд л энэ системд дутагдал байхыг харсан ч Хурц нүдэт түүнд хандсан явдалд амаа хамхилаа.

- Тэгэхээр энэ бүх эхийн чинь өгсөн шидийг зөвхөн хоёр зүйлээр эвдэж болно.

Чамайг насанд хүрэх юмуу эсвэл энэ газрыг гээд Грюм гараа цэмцгэр гал зуухан дундуур зангаж,

- Гэр гэж тооцохоо больсон үед. Өнөө шөнө чи болон нагац ах, эгч чинь өөр өөрсдийн замаар явж ахин хэзээ ч энд хамт амьдрахгүй болно ойлгов уу? гэлээ.

Харри толгой дохилоо.

- Энэ тохиолдолд чи эндээс явмагц буцах зам үгүй болохоор шившлэг үүдний босгоор алхахад тайлагдана. Бид үүнийг эртхэн эвдэхээр шийдсэний учир нь гэвэл Хэцүү нэрт чамайг арван долоо хүрэхэд барихаар энд өөрийн биеэр ирнэ гэж бодож байгаа.

- Бидэнд ганц л давуу тал байна. Хэцүү нэрт чиний өнөө шөнө хүрэх газрыг мэдэхгүй. Бид ид шидийн яаманд хуурамч мэдээлэл дамжуулсан учир тэд чамайг

гучин хүртэл хөдлөхгүй гэж бодож байгаа. Гэхдээ Хэцүү нэртийн хувьд бол зөвхөн өдөр саранд хууртагдахгүй. Тэр гарцаагүй хоёр Үхэл

залгигчийг энэ бүс нутагт харуулдуулахаар илгээсэн байгаа. Ийм учраас бид арваад байшинд бүх төрлийн боломжтой хамгаалалт хийсэн. Тэд бүгд л чамайг нууж болох бүлэгтэй холбоотой газрууд болох миний гэр, Кингслигийн байшин, Молли Артурын гэр, нагац эгч Мюриэлийнх ... ер нь бол чамайг ойлгосон байх гэж бодож байна.

- Тиймээ гэж Харри хэлсэн ч энэ төлөвлөгөөнд цоорхой байгааг олж харсан учир итгэлгүй байлаа.

- Чи Тонксын эцэг эх рүү явах юм. Хамгаалалтын шидний хязгаарыг нэвтлэхтэй зэрэгцэн бид чамайг байшингаас Үүр лүү зөөвөрлөгчөөр авах болно. Асуулт байна уу?

- М-м ... тийм. Тэд магадгүй намайг эхэндээ арван хоёр найдвартай байшингийн хаашаа чиглэснийг мэдэхгүй байж болох ч гэхдээ энэ илэрхий биш байна гэж үү гээд эргэн тойрон дахь толгойнуудаа түргэн тоолж,

- Арван дөрвөн хүн Тонксын эцэг эх рүү нисэх гэдэг? гэв.

- Аан тийм л дээ би чамд гол зүйлийг нь хэлэхээ мартчихаж. Арван дөрвөн хүн Тонксын эцэг эх рүү нисэхгүй. Энэ шөнө тэнгэрт долоон Харри Поттер дагалдагчтай нисэж тус бүр аюулгүй байшин руугаа чиглэх болно.

Ингээд Грюм жанчин дороосоо бохир шингэнтэй дашмаг гаргаж ирлээ. Тэр төлөвлөгөөний үлдсэн хэсгийг тайлбарлаагүй ч Харри дор нь ойлголоо.

- Үгүй! Яасан ч үгүй! гэж тэр чангаар дуу алдахад гал зуухны өрөөгөөр цуурайтав.

- Би ийм зүйл болно гэж анхааруулсан биз дээ хэмээн Гермиона сэтгэл хангалуун хэлэв.

- Хэрвээ та нар намайг өөрийнхөө төлөө зургаан хүний амь насыг эрсдэлд оруулна гэж бодож байгаа бол ...

- Анхны удаагаа биш дээ гэж Рон дуугарлаа.

- Намайг дуурайх бол өөр хэрэг ...

- Чи биднийг үнэнээсээ хүсэж байгаа гэж бодож байна уу, Харри? Гэнэтхэн хэн нэгэн биднийг илбэдвэл үүрд туранхай нүдний шилтэй хэвээр үлдэнэ гэж төсөөлөөд үздээ хэмээн Фред чухалчлан хэлэв.

Харри инээмсэглэсэнгүй.

- Миний оролцоогүй та нар үүнийг хийж чадахгүй. Та нарт миний үс шаардагдана.

- Тиймээ, энэ чинь л бидний төлөвлөгөөг сүйрүүлж байгаа юм. Хэрвээ чи бидэнд туслахгүй бол нэг ширхэг үс ч авах боломж байхгүй гэж Жорж хэлэв.

- Тийм шүү, арван гурван хүн ид шид хэрэглэх хориотой залуу хүний эсрэг байхад ямар боломж байх билээ хэмээн Фред дэмжив.

- Инээдтэй байна. Маш хөгжилтэй байна.

- Хэрвээ үүнд хүч хэрэглэх шаардлага гарвал бид хэрэглэх болно гэж Грюм сөөнгөтөөд шидэт нүд нь аяганаасаа гарах шахам эргэлдэн Харри руу чиглэв.

- Энд байгаа хүн бүхэн насанд хүрсэн бөгөөд эрсдэлд ороход байна, Поттер.

Наземниукс мөрөө хавчаад үрчийхэд шидэт нүд түүний зүг харлаа.

- Маргаж боллоо. Явах цаг болоод байна. Надад чиний хэдэн үс хэрэгтэй байна, хүү минь даруйхан.

- Гэхдээ энэ чинь ухаангүй хэрэг тэдэнд ямар ч хэрэггүй ...

- Хэрэггүй гэнээ хэмээн Грюм зандраад,

- Хэцүү нэрт талдаа ид шидийн яамны хагасыг оруулаад байх уу? Поттер хэрвээ бидэнд аз таарвал тэр гучинд хөдлөнө гэсэн хуурамч мэхэнд үнэмшинэ. Гэхдээ тэр дүүрчихсэн тэнэг биш бол ганц хоёр Үхэл залгигч биднийг харуулдан үлдээсэн байгаа. Би тэгж л хийх байсан. Тэд чамайг гэртээ эхийн чинь шившлэг дор байхад ойртохгүй ч эвдэгдмэгц байршилыг даруй илрүүлэх болно. Бидний цорын ганц боломж гэвэл адилхан болох явдал юм. Тэр ч байтугай Хэцүү нэртэд хүртэл долоо хуваагдах чадвар байхгүй.

Харри Гермионагийн нүдтэй харц тулгарахад цааш харлаа.

- Тэгэхээр Поттер ... элдэг байж хэдэн үсээ өгнө үү. Харри Рон руу харахад ярвайгаад алив гэлээ.

- Түргэл! гэж Грюм зандрав.

Харри хэдэн үс зулгаан авахдаа бүгдийн харцыг мэдэрлээ.

- Сайн байна гээд Грюм доголон Харри руу ойртож дашмагаа сунгаад,

- Харин одоо ийшээ хийгээдэх гэв.

Харри үсийг бохир шингэн рүү унагалаа. Түүнийг шингэний гадаргууд нь хүрэв үү үгүй юу уусмал хөөсрөн буцалж агшин зуур алтлаг хурц өнгөтэй болов.

- Харри чамайг Крэбб, Гойл хоёроос амттай байх гэж бодож байна гэж

Гермиона хэлээд Роны хөмсөг өргөгдөхийг хармагц улайгаад,

- Гэхдээ чи Гойлынх нустай адил байсныг мэдэж байгаа биз дээ гэв.

- Хуурамч Поттерууд жагсацгаа! гэж Грюм тушаав.

Рон, Гермиона, Фред, Жорж, Флер нар нэг эгнээ болон Петунья эгчийн гялалзсан угаалтуурын өмнө жагсав.

- Нэг нь алга байна гэж Люпин хэллээ.

- Энэ байна гэж Хагрид сөөнгөтөөд Наземникусын шилэн хүзүүнээс өргөн Флерийн дэргэд тавихад цаадах нь хамраа үрчийлгэснээ Фред, Жорж хоёрын дунд байр эзлэв.

- Надад сайн хамгаалалт өгөхийг гуйж байна гэж Наземникус гонгинов.

- Дуугаа тат! гэж Грюм зандраад,

- Аймхай өт хорхой минь би чамд Үхэл залгигчид Поттерыг барихыг хичээж байгаагаас биш алах гээгүй гэж хэдийн хэлсэн. Дамблдор үргэлж Хэцүү нэрт Поттерыг өөрийн биеэр дуусгахыг хүсдэг гэж хэлдэг байсан. Хамгаалагчид л бүхнээс муу байх болно яагаад гэвэл Үхэл залгигчид түүнийг алахыг хичээнэ.

Энэ нь Наземникусыг тайвшируулсангүй бололтой гэвч Грюм хэдийн жанчин дороосоо зургаан өндөгний хэмжээтэй шил гаргаад тус бүрийг нь Хувиргагч уусмалаар дүүргэв.

- Одоо бүгд зэрэг ...

Рон, Гермиона, Фред, Жорж, Флер, Наземникус нар уусмалаа уулаа. Уусмал хоолойдоо ормогц тэд бүгд дуу алдан ярвайснаа царай нь халуун лав шиг хөөсөрч хэлбэр дүрсээ алдан мурийлаа. Гермиона, Наземникус хоёр өссөн бол Рон, Фред, Жорж гурав багасаж үс нь харлан, Гермиона, Флер хоёрын толгой дээш сунав.

Грюм болж буй үйл явдалд анхаарал хандуулалгүй үүргэвчээ газар тавиад зургаан ширхэг амьсгаадан зогсож буй Харри Поттер луу харлаа.

Фред, Жорж хоёр бие бие рүүгээ эргэж харснаа нэгэн зэрэг,

- Хөөх бид адилхан болчихож! гэв.

- Гэхдээ мэдэхгүй байна минийхээр бол би илүү хөөрхөн болсон юм шиг гэж

- Фред тусгалаа данхны гадаргууд судлан хэлэв.

- Түй. Билл над руу битгий хараарай аймшигтай харагдаж байна гэж Флер бичил долгионы зуухны хаалганд өөрийгөө хараад дуу алдав.

- Хэний хувцас томдсон нь эндээс бага хэмжээтэйг олж болно гэж Грюм хэлээд эхний үүргэвчтэйг зааж,

- Эсвэл эсрэгээрээ. Тэгээд бас нүдний шилээ зүүхээ бүү мартаарай. Зургаан ширхэг хажуу талын халаасанд нь байгаа. Ачаа тээш хоёр дахь үүргэвчинд байгаа гэлээ.

Жинхэнэ Харри Поттерд амьдралдаа үүнээс илүү гайхалтай зүйл хараагүй юм шиг болж маш хачирхалтай санагдав. Тэр зургаан ширхэг түүнтэй адилхан хүн хэрхэн үүргэвч ухан хувцас сонгож нүдний шилээ зүүхийг харлаа. Тэднийг ичгүүргүй хувцаслаж эхлэхэд биеийнх нь нууц хэсгүүдэд хүндэтгэлтэй хандаасай гэж дотроо хүслээ.

- Би Жинниг шивээсний тухай худал хэлсэн гэж мэдээд байсан юмаа гээд Рон нүцгэн цээжээ харлаа.

- Харри чиний хараа ямар муу юм бэ гээд Гермиона нүдний шилээ зүүлээ.

Хуурамч Поттерууд хувцаслаж дуусаад хоёр дахь үүргэвчнээс тус бүрдээ цагаан уультай тор гарган Харрийн адил үүргэвч үүрлээ.

- Сайн байна гээд Грюм долоон адилхан хувцаслаж, нүдний шил зүүж үүргэвч үүрсэн хүнийг хараад хэлэв,

- Дагалдагч бүртэйгээ хос болон хуваагдана. Наземникус надтай хамт шүүрээр явна ...

- Би яагаад таньтай биш гэж? хэмээн хаалганд ойрхон огсож байсан жинхэнэ

Харри асуулаа.

- Яагаад гэвэл чамайг нүднээс далдлах хэрэгтэй гэж Грюм шидэт нүдээрээ Наземникусыг нүд салгалгүй харж хэлээд,

- Артур Фред хоёр ... гэв.

- Би Жорж гэж Грюмын заасан ихрүүдийн нэг хэлээд,

- Та үнэхээр биднийг Харри болж хувирсан хойно ч ялгахгүй байна уу? гэв.

- Уучлаарай, Жорж ...

- Тоглосон юм, би Фред байна ...

- Тэнэгтэхээ больж үз! гэж Грюм зандраад,

- Хоёр дахь Жорж, Фред хоёрын хэн ч байсан гэсэн Римустай. Хатагтай Делакур ... гэв.

- Би Флерийг фестралаар авч ниснэ. Тэр шүүрэнд дургүй гэж Билл хэлэв.

Флер түүн рүү ойртоод дэргэд нь зогсож Харрийн нүүрэнд хэзээ ч илэрч байгаагүй хүлцэнгүй халамж тавьсан өнгөөр ширтэв.

- Хатагтай Грэйнжер, Кинсли хоёр бас фестрал дээр ...

Гермиона Кингсли руу баяртай инээмсэглэхэд Харри түүний шүүрэн дээр биеэ итгэлгүй авч явдагыг мэдэж байв.

- Зөвхөн бид хоёр үлджээ, Рон! гэж Тонкс хөгжилтэй дуу алдаад гараа даллахдаа ширээн дээр байсан аяга унагаалаа.

Рон Гермиона шиг сэтгэл хангалуун харагдсангүй.

- Харин бид хоёр болвол эсэргүүцэхгүй биз дээ, Харри? гэж Хагрид түгшин асуугаад,

- Намайг фестрал болон шүүрэнд хүнддэх болохоор мотоциклоор нисэж байгаа болохыг ойлгож байгаа биз дээ. Үнэндээ би мотоциклынхоо ихэнхи зайг эзлэх болохоор чи шаахайд нь суух юм гэв.

- Сайн байна гэж Харри итгэлгүйхэн худал хэлэв.

- Бид нар Үхэл залгигчид чамайг шүүрэн дээр нсэхийг хүлээж байгаа гэж бодож байна хэмээн Грюм Харрийн таагүй байдлыг ажиглан хэлээд,

- Снеггэд чиний тухай урьд нь дурсаж байгаагүй бүх зүйлийг ярих цаг хангалттай байсан. Ийм учраас хэрвээ бид Үхэл залгигч нартай тулгарвал тэд шүүрэн дээр сууж байгаа Поттерыг сонгох болно. За боллоо гээд үүргэвчиндээ хуурамч Поттеруудын хувцсыг хийж арын хаалга руу чиглээд,

- Хөдлөхөд гурван минут үлдлээ. Хаалга түгжих нь ухаангүй явдал, Үхэл залгигч нар ийшээ ирвэл түгжээ зогсоохгүй нь мэдээж ... За урагшаа ... гэлээ.

Харри яаран үүдний өрөөнд орж үүргэвч, «Аянга», Хэдвигийг аваад дараа нь тэдэнтэй арын цэцэрлэгт нэгдлээ.

Тэд хэдийн шүүрэндээ мордож байсан бөгөөд Кингсли Гермионаг фестрал дээр суулгаж байлаа. Билл Флерийг өөр нэг дээр суулгаж харагдана. Хагрид ахин нүдний шилээ зүүгээд мотоциклийнхоо дэргэд зогсож байв.

- Энэ тэр үү? Сириусын мотоцикль уу?

- Яг мөн гэж Хагрид инээмсэглэн хэлээд,

- Чи хамгийн сүүлд үүгээр нисэх үедээ алганд багтах хэмжээтэй байсан даа!

гэв.

Харри шаахайд суухад доромжлогдсон юм шиг сэтгэгдэл төрөв. Толгой нь бусдаас хамаагүй дор цухуйж байлаа. Рон түүнийг тоглоомон автомашинд суусан хүүхэд адил шоолонгуй харав. Харри шүүр болон үүргэвчээ хөл дороо тавьж Хэдвигийн торыг өвдөг хоорондоо тавилаа. Энэ нь тун аягүй байлаа.

- Артур энэ зүйлийг илбэдсэн гэж Хагрид Харрийн тухгүй байхыг харж хэлээд мотоциклдоо мордоход чахран газарт хэдэн инч шигдэв.

- Одоо энэ хоёр зүйл шууд жолоотой холбоотой байгаа. Харин энэ бол миний санаа л даа.

Тэр бүдүүн хуруугаараа хурд хэмжигчийн дэргэд байгаа ягаан товчлуур руу заалаа.

- Хагрид, чамаас гуйя болгоомжтой байж үзээрэй гэж шүүрний дэргэд зогсож байсан ноён Уизли хэлээд,

- Би энэ зүйлийг ашиглах эсэхдээ одоо хүртэл итгэлгүй байгаа шүү. Ямар ч гэсэн зөвхөн онцгой байдалд хэрэглээрэй гэв.

- За сайн байна. Бүгд бэлтгээрэй. Бид нэгэн зэрэг хөдлөхгүй бол манай сатааруулах төлөвлөгөө бүтэхгүй шүү гэж Грюм хэллээ.

Бүгд шүүрэндээ суулаа.

- Чанга бариарай, Рон гэж Тонкс хэлэхэд Рон Люпин руу бууутай харц шидсэнээ бүсэлхийгээр нь тэвэрлээ.

Хагрид хаазаа гишгэн моторoo асаахад луу адил хүржигнэн шаахай нь чичирлээ.

- Бүгдэд амжилт хүсье! Ойлролцоогоор цагийн дараа Үүрэнд уулзацгаая. Гурав хүртэл тоолно шүү. Нэг ... хоёр ... гурав гэж Грюм хашгирав.

Мотоцикль улам чанга хүржигнэхэд Харри шаахай эвгүй хазайгаад агаарт хөөрөхийг мэдэрч нүдэнд нь нулимс цийлэгнэн үс нь хойш хийсэв. Түүний эргэн тойронд шүүр

хөөрч дэргэдүүр нь фестралын урт хар сүүл өнгөрлөө. Шаахайд байсан хөл нь Хэдвигийн тор, үүргэвчтэй зайгүй чихэлдсэний улмаас чилж эхэллээ. Тэр тавгүйцсэндээ болоод сүүлчийн удаа Улаан модон гудамж руу харахаа хүртэл мартаад шаахайны хажуугаар шагайх үед нь хэдийн ялгагдахааргүй цэг болсон байлаа. Тэд тэнгэрт улам өндөр хөөрсөөр байв.

Тэгтэл хаа нэгтээгээс хүмүүс тойрон бүслэв. Гучаас доошгүй юүдэнтэй дүрс агаарт том цагариг үүсгэн дүүжигнэн хөвж байсан бөгөөд төвд нь орох хүртэл бүлгэмийн гишүүдийг ажигласангүй ...

Орилж хашгирах чимээ гарч ногоон гэрэл зүг бүрт гялсхийв. Хагрид орилоод мотоцикль уруугаа харлаа. Харри зүг чигээ алдаж гудамжны гэрэл толгой дээгүүр нь зурсхийн өнгөрөхөд хаа сайгүй хашгиралт сонсогдов. Тэр бүх хүчээ гарган шаахайнаас зуурлаа. Хэдвигийн тор, «Аянга» болон үүргэвч нь өвдгөн завсраас нь мултарлаа ...

- Үгүй ... Хэдвиг!

Шүүр газар луу эргэлдэн унахад Харри үүргэвчнийхээ оосор болон торны орой дээрээс шүүрч амжсан ч тэр агшинд мотоцикль эргэн зөв байрлалдаа оров. Секунтын санаа амралтын дараа ахин ногоон гэрэл гялсхийж ууль муухай гууглаад торны ёроолд унав.

- Үгүй ... үгүй!

Мотоцикль бүх хүчээ аван урагш ухасхийлээ. Хагрид Үхэл залгигчдын эгнээг нэвтлэхэд бут үсрэн сарних нь зэрвэс үзэгдэв.

- Хэдвиг ... Хэдвиг ...

Гэвч ууль торныхоо ёроолд тоглоом адил өрөвдөлтэй хөдөлгөөнгүй хэвтэнэ. Харри юу болсныг сайн ухаараагүй ч бусад нь нэн тэргүүнд чухал байлаа. Түүнийг хойш эргэж харах үед бөөн хүмүүсийн дунд ногоон гэрэл гялсхийн алсад хоёр хүн унасан шүүр холдоход хэн болохыг нь ялгахын аргагүй байв.

- Хагрид бид буцах ёстой! Буцах ёстой! гэж тэр хөдөлгүүрийн чанга дүнгэнээн дундуур хашгираад саваагаа гарган авч уулиа үхсэн гэдэгт итгэлтэй болоод Хэдвигийн торыг шалан дээр тавилаа.

- Хагрид, Эргээч!

- Миний ажил бол чамайг аюулгүй хүргэх явдал, Харри! гэж Хагрид хашгираад хаазаа тултал гишгэлээ.

- Зогс! Зогс! гэж Харри хашгирав.

Тэр эргэмэгц зүүн чихний хажуугаар нь хоёр ногоон гал гялсхийн өнгөрлөө. Дөрвөн Үхэл залгигч цагаригнаас тасран араас нь хөөхдөө Хагридын өргөн нуруу руу саваагаа чиглүүлэв. Хагрид замаасаа хазайсан ч Үхэл залгигчид хоцорсонгүй бөгөөд мотоцикль руу ар араасаа шившлэг илгээхэд Харри шаахай руу булталн тонгойлоо.

Тэр эргэж хараад «Дөжир!» гэж хашгирахад саваанаас нь улаан өнгийн оч гарч Үхэл залгигчид хоёр тийшээ сарнив.

- Бариарай, Харри одоо тэд үүнийг хүртэх болно! гэж Хагрид хашгирав.

Харри түүн рүү эргэж хараад Хагридын бүдүүн хуруу шатахууны заагуурын ойролцоо ногоон товчлуур дарахыг харлаа.

Мотоциклийн яндангаас хатуу тоосгон хана гараад агаарт тэлэн сунав. Гурван Үхэл залгигчид булташ амжихад дөрөв дэхэд нь аз бага тохиолдож хананы цаагуур алга болоод хугарсан шүүрний хэлтэрхийтэй хамт доош унав. Тэдний нэг унаж байгаа нөхрөө аврахаар хурдаа удаашируулахад Хагрид жолоо руугаа бөхийн хурдаа нэмлээ.

Араас хөөж буй хоёр Үхэл залгигчийн саваанаас алах шившлэг гарч Харрийн толгойны дэргэдүүр нисэн өнгөрлөө. Тэд Хагрид руу чиглүүлж байлаа. Харри тэдэнд хариу Хөшөөх шид илгээхэд улаан ногоон оч агаарт мөргөлдөн өнгө бүрийн гэрэл болон бутарлаа ...

- Одоохон би тэдэнд үзүүлээд өгнө, Харри бариарай! гэж Хагрид хашгираад хоёр дахь товчлуурыг дарлаа.

Энэ удаад яндангаас том тор нисэн гарахад Үхэл залгигчид үүнд бэлэн байлаа. Тэд булташ холдоход ард хүнээ аврахаар хоцорсон нэг нь ирж нэгдлээ. Тэр гэнэтхэн харанхуйгаас гарч ирээд гурвуул болж мотоциклийн араас шившлэг илгээн хөөцөлдөв.

- Энэ гарцаагүй болно, сайн бариарай Харри! гэж Хагрид орилоод гараараа хурд хэмжигчийн дэргэдэх улаан хүрэн товчлуурыг цохилоо.

Яндангаас хүрхрэх адил чимээ гараад лууных шиг цагаан цэнхэр өнгийн гал тургилахад мотоцикль урагш сум шиг хурдлан төмөр тасхийх чимээ гарав. Харри Үхэл залгигчид хэрхэн үхлийн аюултай галаас зугтахыг харах агшинд шаахай сүрдэм савлаж их биетэй холбогдсон холбоос төмөр нь саллаа.

- Зүгээр дээ, Харри! гээд Хагрид хойшоо суудлаа налахад мотоцикль жолоодлогогүй болж шаахай галзуурсан нислэгт улам хазайлаа.

- Би бүгдийг засчихна, Харри айх хэрэггүй! гээд Хагрид халааснаасаа ягаан шүхрээ гаргалаа.

- Хагрид! Хэрэггүй! Алив би!

- Репаро!

Чих дөжрөм чимээ гарч эцэст нь шаахай мотоциклоос мултарлаа. Харри эрчиндээ мотоциклийн хамт ниссэнээ өндрөө алдан унаж эхлэв.

Тэрбээр шаахай руу саваагаараа цөхрөн хатгаж хашгирлаа.

- Вингардиум левиоса!

Шаахай дээшээ лонхны бөглөө адил бүлт үсрэн жолоодлогогүй хөөрлөө. Агшин зуур Харри санаа амарсан ч дэргэдүүр нь шинэ шившлэг нисэн өнгөрч гурван Үхэл залгигч ойртон ирэв.

- Би очиж байна, Харри! гэж Хагрид харанхуйгаас орилоход Харри шаахай ахин доошилж эхлэхийг мэдрээд дотогш бөхийн саваагаа дунд талын дүрс рүү чиглүүлж,

- Импедимента! гэж хашгирав.

Шившлэг дунд талын Үхэл залгигчийн цээж руу оноход агаарт үл үзэгдэх саадыг зогсоох гэж байгаа мэт гар нь дэлгэгдэн нэг дагалдагчтайгаа золтой л мөргөлдсөнгүй.

Дараа нь шаахай унаж эхлэхэд Үхэл залгигчдийн чиглүүлсэн шившлэг дэргэдүүр нь маш ойрхон өнгөрөхөд доошоо бөхийн булталдаа бүхээгийн ирмэгт шүдээ цохьчихлоо ...

- Би очиж байна, Харри!

Том гар Харрийн жанчнаас зууралд огцом унаж байгаа шаахайнаас суга татан өргөхөд үүргэвчээ авч амжаад мотоцикль дээр Хагридын ард сундалдан суулаа. Тэд дээшээ хоёр Үхэл залгигчийг ардаа орхин өндөрт хөөрөхөд Харри цусаа нулимаад саваагаа унаж байгаа шаахай руу чиглүүлэн,

- Шат! гэж хашгирлаа.

Дэлбэрэх чимээ гарахад дотор нь Хэдвиг байгааг мэдэж байгаа болохоор Харрийн дотор хүчтэй өвдлөө. Шаахайны ойролцоо байсан Үхэл залгигч дэлбэрэлтэнд өртөн шүүрнээсээ унаж түргэн хараанаас далд ороход дагалдагч нь бас алга болов.

- Намайг уучлаарай, Харри уучлаарай. Би засаж чадсангүй ... Чи одоо суух газаргүй боллоо ...

- Энэ чухал биш хамгийн гол нь нисэх! гэж Харри хашгираад харанхуйгаас хоёр Үхэл залгигч ахин мотоциклийг хөөн гарч ирэхийг харлаа.

Тэдний хорондох зай ахиад л ойртоход Хагрид шившлэгээс булган тахирлан нислээ. Харри түүнийг зорчигчийн суудалд найдваргүй сууж байгаад Хагрид ахин лууны товчлуурыг дарж зүрхлэхгүй байгааг ойлголоо. Тэр дагалдагч нартаа ахин нэг Хөшөөх шившлэг илгээн хоорондох зайгаа арайхийн барилаа. Дараа нь илгээсэн шившлэгийг нь хаахад ойролцоох Үхэл залгигч шарван булташ юүдэн нь гулган унаад ахин нэг Хөшөөх шившлэгийн улаан гэрэлд Стэн Шанпайкын хачирхалтай хоосон царай харагдав ... Стэнийх ...

- Экспеллиармус! гэж Харри хашгирлаа.

- Энэ тэр байна, жинхэнэ нь! гэж юүдэнтэй хоёр дахь Үхэл Залгигч хөдөлгүүрийн хүржигнээнд орилоод дараагийн агшинд хөөгсөд алга болов.

- Харри, юу болоо вэ? Тэд хаашаа явчихав?

- Мэдэхгүй!

Харри айдаст автлаа. Үхэл залгигч жинхэнэ гэж хашгирсаныг юу гэж ойлгох вэ? Харри хоосон харанхуй руу хараад аюул заналыг мэдрэв. Тэд хаачаа вэ? Тэр эргээд Хагридын хүрэмнээс чанга зуурлаа.

- Хагрид ахин нэг удаа лууны галаа хэрэглээрэй алив эндээс явцгаая!

- Тэгвэл сайн бариарай, Харри!

Чих дөжрөм хүржигнэх чимээ гаран яндангаас цагаан цэнхэр дөл тургилав. Харри суудлын үзүүр лүү гулгахаа мэдрээд Хагридаас зуурахад аварга биет жолоогоо арай ядан барьж явлаа ...

- Тэднээс салах шиг боллоо, Харри. Би тэгж бодож байна! гэж Хагрид хашгирав.

Гэвч Харри үүнд итгэлтэй байсангүй. Зүрхэнд нь айдас хуралдан баруун зүүн тийш харж дагагсдыг ахин гарч ирнэ гэдэгт итгэлтэй байлаа ... Гэхдээ тэд яагаад үлдсэн юм бол? Нэгийх нь гарт саваа байсан шүү дээ ... «Энэ тэр байна, жинхэнэ нь!» ... Тэд Стэнийг зэвсэггүй болгохоор оролдсоны дараа ингэж хашгирсан ...

- Бид бараг хүрлээ, Харри бараг хүрлээ! гэж Хагрид хашгирлаа.

Ингээд Харри мотоцикль доошилохыг мэдрээд газар байгаа галын гэрэл алсад анивчих одод шиг санагдав.

Тэгтэл духан дээрх сорви нь төөнөн өвдөж мотоциклийн хоёр талаар Үхэл залгигчид гарч ирэхэд хоёр алах шившлэг Харрийн толгойноос инчийн зайтай зөрлөө ...

Тэгэхэд л Харри харлаа. Волдеморт салхинд туугдсан утаа адил шүүргүй, фестралгүй нисэж байсан бөгөөд харанхуйд могойн царай нь гялалзан цагаан хуруундаа саваагаа өргөжээ ...

Хагрид айсандаа орилоод мотоцикль эгц дээш хөөрлөө. Харри амьдралаас цөхрөн зууралдаж таамгаар Хөшөөх шившлэг илгээв. Тэр дэргэдүүрээ бие нисэн өнгөрөхийг хараад нэгийг нь оносноо ойлгосон ч хөдөлгүүрт цохилт ирэн оч хаялж мотоцикль бүрэн жолоодлогогүй болон доошоо уналаа ...

Эргэн тойрон ногоон оч харван өнгөрлөө. Харри дээр доор хаана байгаагаа мэдэхээ больж сорви нь халуу шатан өвдөхөд ойрын агшинд үхэх гэж байгаа юм шиг санагдав. Ойролцоогоор футын зайд шүүрэн дээр байсан юүдэнтэй хэн нэгэн гар сунгав.

- Үгүй!

Хагрид уурсан хашгираад мотоциклоос Үхэл залгигч руу үсрэхэд Харри тэднийг шүүрэн дээр зууралдан харанхуйд алга болохыг айдаст автан харлаа ...

Харри огцом унаж буй мотоциклийг өвдгөөрөө хавчтал Волдемортын «Минийх!»

гэж хашгирах сонсогдов.

Волдеморт харагдаж үзэгдээгүй ч хаана байгаа нь ойлгомжтой байлаа. Нэг Үхэл залгигч түүний замаас түргэхэн холдоход,

- Авада ... гэх нь сонсогдов.

Харрийн сорви янгинан өвдөж нүдээ анитал саваа нь өөрөө хөдлөв. Тэр түүний саваатай гар хэрхэн том соронзонд татагдсан аятай сунаж алтлаг улаан оч гялсхийхийг хагас аниатай нүднийхээ завсраар хартал тас хийх чимээ гараад уурссан хашгиралт сонсогдлоо. Үлдсэн нэг Үхэл залгигч түүн рүү чиглүүлэхэд Волдеморт

«Үгүй!» гэж хашгирав. Тэгтэл Харри ойлгомжгүй аргаар урдаа гэнэтхэн лууны галтай хүрэн товчлуур байхыг харлаа. Тэр түүнийг сул гараараа цохиход мотоцикль агаарт дөл тургилж газар луу улам хурдтай ойртов.

- Хагрид! гэж Харри бүх хүчээ гарган жолооноос зууран дуудлаа.

- Хагрид! Акцио, Хагрид!

Мотоцикль газарт хүчтэй татагдан ойртов. Харри нүүрнийхээ өмнө жолооны бариулаас ондоо зүйл харсангүй ч алсад байсан гал улам урган томорсоор байлаа. Тэр одоохон газар унаж сүйрэх бөгөөд үүнийг зогсоох юу ч байхгүй. Ард нь ахин нэг хашгиралт сонсогдож,

- Саваагаа Селвин, надад саваагаа өг! гэв.

Харри Волдеморт түүнийг харж байгааг мэдрэв. Тэр дэргэдээ байгаа улаан нүдийг хараад амьдралдаа харсан хамгийн сүүлчийн зүйл болохыг ойлголоо. Волдеморт түүний зүг ахин нэг шившлэг илгээхээр бэлтгэж байв ...

Тэгтэл тэр алга боллоо. Харри доошоо газар сунан унасан Хагридыг хараад мөргөхөөс зайлсхийн жолоогоо эргүүлтэл шавартай цөөрөмд нисэн унаад чих дөжрөм чимээ гарч газар чичирлээ.

БҮЛЭГ 5: УНАСАН ДАЙЧИН

- Хагрид!

Харри хэмхэрсэн төмрийн хэлтэрхий суудлын бүрээсэн дундаас гарахыг хичээв. Тэр босохыг оролдтол нэг гар нь усанд дүрэгдлээ. Тэр Волдеморт хаачсан болон харанхуйгаас юу тохиолдохоор заналхийлж байгааг ойлгосонгүй. Ямар нэг халуун нойтон зүйл духыг нь даган эрүү рүү нь урсав. Тэр цөөрөмд дөрвөн хөллөөд босож гуйвсаар Хагридын нүсэр том хар дүрс хэвтэж байгаа газар луу ойртов.

- Хагрид! Хагрид ямар нэг юм хэлээч ... Гэвч хар дүрс хөдөлсөнгүй.

- Энд хэн байна? Поттер уу? Та Харри Поттер уу?

Харри энэ хүний хоолойг таньсангүй. Араас нь эмэгтэй хүний хоолой,

- Тэд унасан, Тед! Цэцэрлэгт унасан! гэлээ. Харрийн толгой эргэхэд,

- Хагрид гэж давтаад өвдөг нь нугларан уналаа.

Дараагийн агшинд хэвтээд тэр нуруугаараа ямар нэг сандал дээр хэвтээд хавирга болон баруун гар нь халуу оргихыг мэдэрлээ. Унасан шүд нь ахиж ургажээ. Духны сорви нь лугшин өвдөнө.

- Хагрид!

Харри нүдээ нээгээд үл таних гэрэлтэй зочны өрөөнд буйдан дээр хэвтэж байгаагаа харлаа. Буйдангаас холгүй шалан дээр норж бохирдсон үүргэвч нь байв. Дэргэд нь цайвар үстэй том гүзээтэй эрэгтэй хүн зогсоод Харри руу сэтгэл түгшин харж байв.

- Хагридын бүх зүйл хэвийн, хүү минь. Эхнэр минь одоо түүнийг харж байгаа.

Ингэхэд бие чинь ямар байна? Өөр зүйл хугараагүй биз дээ? Хугарсан хавирга, шүд гарыг чинь би эмчилсэн. Намайг Тед гэдэг. Тед Тонкс ... Дорагийн эцэг.

Харри огцом өндийн суухад дотор нь харанхуйлж толгой эргэн муухайрлаа.

- Волдеморт ...

- Тайвшир гээд Тед Тонкс Харрийн мөрөн дээр дарж дэрэн дээр нь эргэн хэвтүүлэв.

- Чи сая маш эвгүй газардсан. Ингэхэд юу болсон бэ? Мотоциклийн чинь ямар нэг зүйл эвдрээ юу? Артур Уизли ахиад л маглуудын ямар нэг бүтээлийг өөрчлөө юу?

- Үгүй гээд Харри сорви нь ангархай шарх адил хорсон өвдөхийг мэдэрлээ.

- Үхэл залгигчид тэд олуулаа байсан ... Тэд биднийг хөөсөн ...

- Үхэл залгигчид гэнээ? хэмээн Тед огцом асуугаад,

- Үхэл залгигчид гэдэг чинь юу гэж байгаа юм? Бид тэднийг та нарын өнөө шөнө хөдлөхийг мэдээгүй гэж бодсон юмсан ... гэв.

- Тэд мэдэж байсан гэж Харри хэлэв.

Тед Тонкс тэнгэр рүү харахаар найдсан мэт адар руу ширтэв.

- Гэхдээ манай хамгаалалтын шивлэг тэднийг нэвтрүүлэхгүй. Иймээс тэд байшинд зуун ярдаас дотогш ойртож чадахгүй.

Одоо л Харри Волдеморт яагаад алга болсныг ойлголоо. Энэ нь мотоцикль бүлгийн хамгаалалтын саадыг давснаас болжээ. Зөвхөн саад цаашид тэсээсэй гэж найдах үлдлээ. Тэр Волдемортыг энэ хоромд зуун ярдын дээр хөөрөн түүнийг дотогш яаж нэвтэрснийг ойлгохыг хичээж байгаа болохыг төсөөлөв.

Тэр Хагридын эрүүл амьд гэдгийг харах хэрэгтэй байсан тул буйдангаас хөлөө буулгав. Гэвч Харриг дөнгөж бостол хаалга нээгдэж Хагрид цус шаварт хутгалдсан нүүртэй доголсоор орж ирсэн ч гайхамшигаар амьд үлдсэн байлаа.

- Харри!

Хагрид хоёр том алхаад Харрийн саяхан эдгэрсэн хавиргыг шажигнатал тэвэрлээ.

- Чөтгөр гэж, Харри чи яаж чадав аа? Би хоёулаа сүйрлээ л гэж бодсон.

- Би ч гэсэн тэгж бодсон. Итгэж ч чадахгүй нь ...

Харри Хагридын араас орж ирсэн эмэгтэйг хараад чимээгүй болсноо,

- Та! гэж хашгираад халаас руугаа гараа сунгасан ч хоосон байлаа.

- Чиний саваа энэ байна, хүү минь гээд Тед Харрийн гар руу тогшив.

- Дэргэд чинь хэвтэж байхаар нь авсан юм ... Харин одоо чи миний эхнэр рүү хашгирч байна.

- Өө, намайг ... уучлаарай.

Хатагтай Тонкс өрөөн дундуур явахад гадаад төрх байдал нь Беллатрисаг санагдуулам байлаа. Гэсэн ч түүний хүрэн үс арай цайвар агаад нүд нь том эелдэгхэн ажээ. Тэгсэн ч Харри түүний бага зэрэг ихэмсэг болохыг олж харлаа.

- Миний охинд юу тохиолдоо вэ? Хагрид та хоёрыг отож байсан гэж хэлсэн.

Нимфадора хаана байна?

- Мэдэхгүй. Бид бусдад юу тохиолдсоныг мэдэхгүй байна гэж Харри хэлэв.

Тед эхнэртэйгээ бие бие рүүгээ харлаа. Харри тэдний царайг хараад айдас гэмшил хутгалдан төрөв. Хэрвээ хэн нэгэн үхсэн бол зөвхөн тэр л буруутай байх болно. Тэр л тэдний төлөвлөгөөг зөвшөөрч үсээ өгсөн билээ ...

- Зөөвөрлөгч гэж Харри гэнэтхэн санаад дуу алдлаа.

- Биднийг Үүрэнд эргэж очвол ... тэгвэл та нарт хэлэх боломжтой болно ... эсвэл Тонкс ийшээ өөрөө ирээд ...

- Дорагийн бүх зүйл хэвийн, Дромеда. Тэр ажлаа сайн мэддэг. Зөөвөрлөгч энд байгаа. Хэрвээ ашиглахыг хүсэж байвал та нарт гурван хором үлдлээ гэж Тед хэлэв.

- Тиймээ хүсэж байна гээд Харри үүргэвчээ мөрөн дээрээ тохлоо. Би ...

Тэр хатагтай Тонкс руу харж айдастай үлдээж байгаадаа уучлал гуйхыг хүссэн авч нэг ч үг хэлж чадсангүй.

- Би Тонкст хэлье ... Дораг ... та нартай холбоо барь гэж ... бидэнд хийсэн бүх зүйлийн чинь төлөө баярлалаа. Би ...

Тэр өрөөг Тед Тонксын араас орхиж хонгилд гараад сэтгэл нь амарлаа. Хагрид араас нь гарч ирэхдээ хаалганы хөндлөвчинд толгойгоо цохихгүйн тулд бөхийв.

- Тийшээ яв, хүү минь. Зөөвөрлөгч тэр байна гээд ноён Тонкс жижигхэн угаалгын өрөөний ширээн дээр хэвтэж байгаа мөнгөлөг сойзыг заалаа.

- Баярлалаа гээд Харри явахад бэлдэн сойзонд хуруугаа хүргэлээ.

- Хүлээгээрэй, Харри гээд Хагрид зүг бүр тийш харж,

- Хэдвиг хаана байна? гэлээ.

- Тэр ... түүнийг оночихсон.

Болж өнгөрсөн үйл явдал бодолд нь ахин ханаран орж ирэхэд Харри нүдэнд нь нулимс цийлэгнэсэн явдалд ичингүйрлээ. Ууль түүний нөхөр байсан бөгөөд Дурслийнд байхад нь шидэт ертөнцтэй холбодог цорын ганц зүйл байлаа.

Хагрид том гараараа Харрийн мөрөн дээр өвдтөл алгадаад,

- Гашуудах хэрэггүй дээ. Гашуудах хэрэггүй. Тэр гайхамшигтай удаан амьдралыг туулсан гэж сөөнгөтөн хэлэв.

- Хагрид! гэж Тед Тонкс анхааруулан хэлээд хурц цэнхэр өнгөтэй болсон сойз руу зааж хуруугаа хүргэхэд бага хугацаа үлдсэнийг санууллаа.

Тэгтэл Харрийн хүйснээс үл үзэгдэх дэгээгээр татах шиг болж хуруугаа зөөвөрлөгчөөс салгалгүй Хагридын хамт харанхуйд эргэлдэн ноён Тонксынхоос нислээ. Хоёр секунтын дараа Харрийн хөл хатуу газар хүчтэй газардахад Үүрний хашаанд дөрвөн хөллөн унав. Хэн нэгэн хашгирах сонсогдов. Харри хэрэггүй болсон сойзоо хаяад найган босож үүдний довжоон дээрээс гүйж ирж байгаа хатагтай Уизли, Жинни хоёрыг харав. Тэр агшинд Хагрид хөл дээрээ хүндхэн босож ирлээ.

- Харри? Чи жинхэнэ Харри мөн үү? Юу болсон бэ? Бусад чинь хаа байна? гэж хатагтай Уизли хашгирав.

- Та юуны тухай ярьж байна? Хэн ч эргэж ирээгүй багаа юм уу? гэж Харри асуулаа.

Хариулт хатагтай Уизлийн цонхигор царайн дээр бичээстэй байлаа.

- Үхэл залгигчид биднийг хүлээж байсан. Биднийг өнөө шөнө ниснэ гэдгийг тэд мэдэж байсан. Бусаддаа юу тохиолдсоныг мэдэхгүй байна. Тэднээс дөрөв нь бидний араас хөөхөд зугтахыг оролдсон. Харин дараа нь бидний араас Волдеморт хөөсөн ...

Тэр хоолойныхоо цагаатгасан өнгөө сонсоод хатагтай Уизлийн хөвгүүдэд юу тохиолдсоныг мэдэхгүй байгаа явдалд гуйн дуугарч буйгаа мэдрэв ...

- Бурханы авралаар чи мэнд байна гээд хатагтай Уизли Харриг түүний бодлоор хүртэх гавъяагүй тэвэрлээ.

- Молли чамд шарз байхгүй биз? Анагаах чадвартай? гэж Хагрид чичирсэн хоолойгоор асуув.

Тэр шид хэрэглэж чадах байсан ч үүнийхээ оронд яаран гэр лүүгээ ороход Харри түүний царайгаа харуулахыг хүсээгүй болохыг ойлголоо. Тэр Жинни рүү эргэхэд шуудхан асуулт тавиагүй байхад хариуллаа.

- Рон, Тонкс хоёр түрүүлж ирэх ёстой байсан ч амжаагүй болохоор зөөвөрлөгч нь тэдэнгүй эргэж ирсэн гээд холгүй газар хэвтэж байгаа зэвтэй тосны савыг заалаа.

- Харин хоёрдугаарт аав Фред үүгээр ирэх ёстой байсан гээд хуучин шаахай руу зангав. Хагрид та хоёр гуравт ирсэн. Жорж, Люпин хоёр амжвал хормын дараа ирнэ гээд цагаа харлаа.

Хатагтай Уизли лонхтой шарз барьсаар эргэж ирээд Хагридад өглөө. Тэр бөглөөг онгойлгоод шуудхан залгилав.

- Ээжээ! гэж Жинни хашгираад хуруугаараа хэдэн алхамын зайд байгаа зүйлийг заалаа.

Харанхуйд цэнхэр гэрэл ярсхийснээ улам томрон хурц болоод Люпин, Жорж хоёр эргэлдэн уналаа. Харри агшин зуур ямар нэг зүйл болсон гэдгийг ойлголоо. Люпин ухаангүй Жоржыг дэмжин царай нь нил цус болсон байлаа.

Харри тэдэн рүү гүйж очоод Жоржыг хөл дээр нь босголоо. Тэр Люпинтэй хамт Жоржыг гэр лүү оруулаад гал зуухыг өнгөрөн зочны өрөөний буйдан дээр хэвтүүлэв. Жоржын толгой гэрэлд гармагц Жинни дуу алдахад Харрийн дотор палхийлээ. Жорж ердөө ганц чихтэй болжээ. Түүний толгойны энэ хэсэг хүзүүгээ даган цусанд будагдсан байлаа.

Хатагтай Уизли хүү рүүгээ тонгоймогц Люпин Харрийн тохойноос зуураад гал зуух руу чирэн оруулав. Хагрид хаалгаар орох гэж зүтгэлсэн ч дэндүү том биетэй болохоор багтсангүй.

- Хөөе! Түүнийг тавь! Харриг тавь! гэж Хагрид уурсан хэллээ. Люпин түүнийг сонссонгүй.

- Чамайг Хогвартсад анх миний өрөөнд орж ирэхэд буланд ямар зүйл байсан бэ? Хариул! гэж Харриг дугтран асуулаа.

- Э-э-э ... том шилэн савand усны чөтгөр байсан. Люпин Харриг орхиод гал зуухны шүүгээ наллаа.

- Энэ чинь одоо юу гээч нь вэ? гэж Хагрид дуугарав.

- Уучлаарай, Харри би заавал шалгах ёстой байлаа. Биднээс урвасан.

Волдеморт биднийг өнөөдөр ниснэ гэдгийг мэдэж байсан. Түүнд цорын ганц хэлж чадах хүн гэвэл төлөвлөгөөтэй холбоотой хүмүүс л чадна. Чи хууран мэхлэгч байж болно шүү дээ.

- Тэгвэл чи яагаад намайг шалгахгүй байгаа юм? гэж Хагрид хаалгаар амьсгаадан зүтгэлж хэлэв.

- Чи чинь хагас аварга биет шүү дээ ... Хувиргагч уусмал зөвхөн хүмүүст үйлчилдэг гэж Люпин Хагридыг ширтэн хэллээ.

- Бүлгийн нэг ч гишүүн биднийг энэ шөнө хөдлөнө гэж Волдемортод хэлээгүй гэж Харри хэлэв. Тэдний хэнд ч итгэж чадахааргүй байсан болохоор энэ бодол аймшигтай байлаа.

- Волдеморт намайг эцэст нь хөөх хүртлээ жинхэнэ гэж мэдээгүй. Хэрвээ төлөвлөгөө задарсан бол тэр эхнээсээ л намайг Хагридтай явна гэдгийг мэдэх байсан.

- Волдеморт чамайг хөөсөн гэнээ? Юу болсон юм? Чи яаж зугтсан юм? гэж

Люпин огцом асуулаа.

Харри Тонксын эцэг эхийнд очихын өмнө түүний араас Үхэл залгигчид хэрхэн хөөсөн болон нэг нь жинхэнэ Поттер гэдгийг мэдмэгц Волдемортыг дуудахын тулд хөөхөө больсон тухай ярилаа.

- Чамайг таньсан гэнээ? Гэхдээ яаж? Чи юу хийсэн юм?

- Би ... гээд Харри санахыг хичээхэд адал явдал нь бүдэг зураг шиг үзэгдэв.

- Би Стэн Шанпайкыг харсан ... «Шөнийн хүлэг баатар» автобусны тасалбар түгээгч гэдгийг нь санаж байгаа биз дээ? Тэгээд түүнийг зэвсэггүй болгохыг оролдсон юм ... гэхдээ тэр яаж жинхэнэ гэдгийг мэдсэн болохыг ойлгохгүй байна. Түүнийг харваас Империус шившлэгээр удирдаж байсан!

Люпин айдаст автлаа.

- Харри чи зэвсэггүй болгох шид хэрэглэсэн гэнээ! Тэдгээр хүмүүс чамайг барьж алахыг оролдож байхад! Хэрвээ чи тэднийг алахад бэлэн биш байсан юм бол хөшөөж болох л байсан!

- Гэхдээ бид газраас тавин футын өндөрт байсан! Стэн үнэхээр өөрийгөө авч явж байсан биш болохоор хөшөөвөл газар унаж үхээд Авада кедавра ашигласнаас ялгаагүй болох байсан! Экспеллиармус намайг Волдемортоос хоёр жилийн өмнө аварсан гэж Харри эсэргүүцлээ. Люпин түүнд ДА-д зэвсэггүй болгох хичээл заах үед Пуффендуйн Захария Смит хэрхэн басамжилж байсныг санагдуулав.

- Мэдээж Харри гэж Люпин үүраа барьж ядан хэлээд

- Үхэл залгигчидын ихэнхи нь юу болсныг харсан. Чамд үхлийн аюулд авч явсаныг уучлаарай. Гэхдээ давтаж хэлэхэд үүнийг хэн ч амиа хорлосон хэрэг гэж хэлнэ.

- Та намайг Стэн Шанпайкыг алах ёстой байсан гэж бодож байгаа юм уу? гэж

Харри уурсан дуу алдав.

- Мэдээж тэгж бодоогүй. Гэхдээ ний нуугүй хэлэхэд ямар ч Үхэл залгигч чамайг хариу цохилт өгөхийг хүлээж байсан! Экспеллиармус шившлэг ашигтай ч гэхдээ Харри Үхэл залгигчид чиний стилийн хөдөлгөөнийг мэдэх болохоор ахин хэрэглэхгүй байхыг ихэд гуйх байна!

Харри хичнээн тэнэг болохоо мэдэрсэн ч бууж өгсөнгүй.

- Би хүмүүсийг зөвхөн замд саад болсны төлөө алж чадахгүй. Энэ чинь

Волдемортын хийдэг ажил.

Люпины үг сөргөсөнгүй. Хагрид эцэст нь хаалгаар чихэн орж орж сандал дээр очиж суухад нуран уналаа. Түүний хараахыг тоолгүй Харри Люпинээс,

- Жоржын бүх зүйл хэвийн үү? гэж асуулаа. Үүнийг асуусан явдалд Люпин сэтгэлээр унав бололтой.

- Тийм гэж бодож байгаа ч шившлэгийг буцаах боломжгүй болохоор эргэж чихтэй болохгүй.

Гадаа чимээ шуугиан сонсогдов. Люпин арын хаалга руу ухасхийхэд Харри

Хагридын хөл дээгүүр үсрэн хашаа руу гүйн гарлаа.

Хашаанд хоёр хүн бий болов. Харри тэдэн рүү гүйн очихдоо нэг нь хэдийн ердийн хэвдээ орсон Гермиона болон Кингсли болохыг мэдлээ. Гермиона Харриг тэврэхээр ухасхийсэн ч Кингсли тэднийг хараад ямар ч баярласан шинж үзүүлсэнгүй. Харри Гермионагийн мөрөн дээгүүр түүнийг хэрхэн Люпины цээж рүү саваагаа чиглүүлэхийг харлаа.

- Бидний Альбус Дамблдороос сонссон хамгийн сүүлчийн үгийг хэл!

- Харри бол бидний гол найдлага. Түүнд итгэ гэж Люпин тайван хэлэв. Кингсли саваагаа бариад Харри руу эргэсэн ч Люпин,

- Энэ тэр мөн, би шалгасан! гэлээ.

- Сайн байна гээд Кингсли саваагаа жанчныхаа дотор шургуулав.

- Гэхдээ хэн нэгэн биднээс урвасан! Тэд биднийг өнөө шөнө явна гэдгийг мэдэж байсан!

- Тийм бололтой. Гэхдээ долоон Поттер болно гэдгийг мэдээгүй гэж Люпин хэлэв.

- Ямар өчүүхэн тайвширал вэ! гэж Кингсли уцаарлаад,

- Өөр хэн эргэж ирсэн бэ? гэв.

- Зөвхөн Харри, Хагрид, Жорж бид нар. Гермиона аяархан дуу алдан амаа дарлаа.

- Та нарт юу тохиолдсон юм? гэж Люпин Кингслигээс асуулаа.

- Таван хүн дагаснаас хоёр нь шархдаж нэг нь лавтай алагдсан. Гэхдээ бид замынхаа хагаст Хэцүү нэрт нэгдэхийг харсан ч маш түргэн алга болсон. Римус тэр ...

- Нисэж байсан гэж Харри хэлээд,

- Би ч гэсэн Хагрид бид хоёр луу дайрахад харсан гэв.

- Тийм учраас л биднийг орхисон хэрэг байх нь! гэж Кингсли дуу алдаад,

- Харин би түүнийг яагаад алга болсныг ойлгоогүй юм. Юу түүнийг байгаа өөрчилөхөд хүргэсэн юм бол? гэлээ.

- Харри Стэн Шанпайкад хэтэрхий эелдэг хандсан байна гэж Лпин тайлбарлав.

- Стэн гэнээ? Би түүнийг Азкабанд байгаа гэж бодсон юмсан хэмээн Гермиона гайхлаа.

Кингсли хөгжилгүйхэн инээд алдав.

- Гермиона тэнд том хэмжээний орголт болсон. Би юүдэнтэй хүн рүү шившлэг илгээхдээ бас шоронд сууж байгаа гэж бодсон Трэверсийг харсан. Гэхдээ чамд юу тохиолдоо вэ, Римус? Жорж хаа байна?

- Тэр чихгүй болсон.

- Чихгүй болсон гэнээ? хэмээн Гермиона нарийхан хоолойгоор асуулаа.

- Снеггийн хийсэн ажил.

- Снегг гэнээ? Та хэлэх гээгүй биз дээ ...

- Тэр хөөх үед юүдэн нь доошоо буусан. Тиймээ Сектусемпра үргэлж Снеггийн дуртай зэвсэг байсаар ирсэн. Би түүнд хариуг нь өгөхийг хүссэн ч Жоржыг шүүрэн дээр тогтоохын тулд бүх хүчээ гаргах хэрэгтэй байлаа. Тэр шархадснаас болж хэтэрхий их цус алдсан.

Дөрвүүлээ чимээгүй болж тэнгэр лүү хараа. Тэнгэрт ямар ч хөдөлгөөн байсангүй одод доошоо анивчилгүй хайхрамжгүй ширтэнэ. Рон хаана байна? Фред болон ноён

Уизли хаачаа вэ? Билл, Флер, Тонкс болон Хурц нүдэт Грюм, Наземникус хаана байна?

- Харри туслаарай! гэж Хагрид хаалган дээрээс сөөнгөтөн дуудав. Харри ямар нэг хийх юм олдсонд баяртайгаар Хагридыг зочны өрөөнөөс хоосон гал зуух руу түлхэн оруулахад хатагтай Уизли Жинни хоёр Жоржыг үргэлжлүүлэн сувилсаар байв. Хатагтай Уизли цус алдахыг зогсоосон бөгөөд Харри лааны гэрэлд Жоржын чих байсан газар нүх бий болсныг харлаа.

- Тэр хэр байна?

Хатагтай Уизли түүн рүү эргээд,

- Энэ хар шидийн зүйл болохоор би чихийг буцаан ургуулж чадахгүй. Гэхдээ үүнээс ч дор байж болох байлаа ... Тэр амьд байна гэв.

- Тиймээ. Бурханы авралаар гэж Харри хэлэв.

- Би чимээ шуугиан сонслоо. Хэн нэгэн эргэж ирсэн үү? гэж Жинни асуув.

- Гермиона, Кингсли хоёр.

- Бурханд баярлалаа гэж Жинни шивнээд тэд бие бие рүүгээ харлаа. Харри түүнийг тэврэхийг хүссэн ч хатагтай Уизлийн дэргэд чадсангүй. Тэгтэл гал зууханд чимээ шуугиан сонсогдов.

- Би хэн гэдгээ Кингслид батласан болохоор харин одоо явж хүүгээ хармаар байна замаас холдоцгоо!

Харри хэзээ ч ноён Уизлигийн ингэж хашгирахыг сонсож байсангүй. Түүнийг зочны өрөөнд орж ирэхдээ халзан толгой дээр нь хөлс гялалзаж нүдний шил нь хазайжээ. Фред түүний араас дагалдан орж ирэхэд хоёулаа цонхийсон ч бүрэн бүтэн байлаа.

- Артур! Бурханы авралаар! гэж хатагтай Уизли дуу алдав.

- Тэр хэр байна?

Хатагтай Уизли Жоржын дэргэд өвдөглөв. Харри анх удаа Фредийг үг хэлэх чадвараа алдахыг харлаа. Фред шархадсан ах руугаа харан алмайран зогсоод харсан зүйлдээ итгэж чадахгүй байгаа бололтой.

Жорж эцгийгээ ирэхэд ухаан орон хөдлөв.

- Бие чинь ямар байна, Жорж? гэж хатагтай Уизли шивнэлээ. Тэр хуруугаараа толгойгоо тэмтэрснээ,

- Нялцгай биет шиг л байна гэж бувтналаа.

- Түүнд юу тохилдоо вэ? Тархинд нь нөлөөлөх үү? гэж Фред сөөнгөтөн асуув.

- Яг л нялцгай биет шиг гэж Жорж давтаад нүдээ нээн ихэр лүүгээ харлаа.

- Чи өөрөө харж байгаа биз дээ ... Нялцгай биет. Дунгүй эмгэн хумс. Фред ойлгов уу?

Хатагтай Уизли чанга цурхирлаа. Фредийн царай улайв.

- Чи найдлагагүй болж дээ. Найдлагагүй! Дэлхийн бүх баялагыг цуглуулсан ч чихийг чинь байранд нь буцаан тавьж чадахгүй!

- За болно гээд Жорж нулимс асгаруулж байгаа эх рүүгээ харан инээж,

- Одоо ээж биднийг ялгаж чадах боллоо гээд эргэн тойрноо харснаа,

- Сайн уу, Харри! Чи Харри мөн биз дээ? гэв.

- Тиймээ гээд Харри буйданд ойртлоо.

- Ямар ч гэсэн чи бүтэн эргээд ирж. Харин Рон, Билл яагаад оронд байгаа өвчтөнийг эргэхгүй байгаа юм бол?

- Тэд эргэж ирээгүй байна гэж хатагтай Уизли хэлэхэд Жоржын инээмсэглэл бөхлөө. Харри Жинни рүү харж эрүүгээрээ дохиод зочны өрөөнөөс гарлаа.

- Тэднийг гал зууханд орж ирэх үед Жинни аяархан,

- Рон, Тонкс хоёр одоо эргэж ирэх ёстой. Тэдний зам хол биш нагац эгч Мюриэль холгүй амьдардаг гэв.

Харри үг хэлсэнгүй. Тэр Үүрэнд байгаа хором тутамд айдаст автахгүйг хичээж байсан ч одоо цээжийг нь баглах шиг санагдав. Тэднийг шатны гишгүүр уруудан харанхуй хашаанд гарах үед Жинни гараас нь барилаа.

Кингсли хашаан дотор урагш хойш холхин эргэх бүрдээ тэнгэр рүү ширтэж байлаа. Харри Вернон ах зочныхоо өрөөнд ингэж холхиж байсан тухай бодтол мянган жилийн өмнө юм шиг санагдав. Хагрид, Гермиона, Люпин нар мөр мөрөө түшин зогсоод тэнгэр лүү чимээгүй ширтэнэ. Харри, Жинни хоёр чимээгүйхэн нэгдэхэд тэдний хэн ч эргэж харсангүй.

Хором тус бүр жил шиг өнгөрч байлаа. Салхи сулхан исгэрэх болгонд бүгд огцом эргэн мод бут руу найдангуй харж бүлгийн алга болсон гишүүдийн нэг бэртэж гэмтээгүй гараад ирэх байгаадаа гэж ...

Эцэст нь тэдний толгой дээр шүүр харагдан доошоо буулаа ...

- Энэ тэд байна! гэж Гермиона чанга хашгирав. Тонкс хайрга үсчүүлэн уртаар шарван газардлаа.

- Римус! гэж тэр хашгираад шүүрнээсээ үсрэн бууж Люпиныг тэврэхээр ухасхийлээ. Түүний царай зэвхий цагаан болжээ. Рон бүдэчсээр Гермиона, Харри хоёр луу гүйлээ.

- Чи бүтэн байна гэж тэр Гермионаг чанга тэврэхийн урьд бувтналаа.

- Би бодохдоо ... бодохдоо ...

- Би зүгээр дээ гээд Рон түүний нурууг илж,

- Бүх зүйл сайн гэв.

- Рон сайн байсан гэж Тонкс Люпинээс хөндийрөн хэлээд,

- Гайхамшигтай. Үхэл залгигчдын нэг бай луугаа чиглүүлэх гээд шүүрний хажуугаар орж ирэхэд хөшөөсөн ... гэв.

- Үнэн үү? гээд Гермиона Роны хүзүүгээр тэвэрсэн хэвээр царай луу нь харлаа.

- Үргэлж л ийм гайхсан өнгөтэй байх юм гэж Рон дургүйцэн үглээд,

- Ингэхэд бүгд эргэж ирсэн үү? гэв.

- Үгүй бид Билл, Флер, Хурц нүдэт, Наземникус нарыг хүлээж байна. Би явж ээж аавд чиний сайн байгаа гэдгийг хэлье гэж Жинни хэлэв.

Тэр гэр лүү гүйлээ.

- Чи яагаад ингэж их саатав? Юу болсон юм бэ? гэж Люпин Тонксоос уурсангуй асуулаа.

- Беллатриса. Би түүнд Харригаас дутуугүй хэрэгтэй юм шиг санагдсан. Тэр намайг алахыг их хичээсэн, Римус. Түүнд хариуг нь өгч чадаагүй нь харамсалтай байна. Тэр надад өртэй. Бас бид Родольфусыг шархдуулсан ... Дараа нь нагац эгч Мюриэлийнд хүрхэд зөөвөрлөгчид амжаагүй болохоор тэр сандарсандаа ...

Люпины эрүүний булчин чичигнэлээ. Тэр үг хэлж чадсангүй бололтой толгой дохив.

- Харин та нарт юу тохиолдоо вэ? гэж Тонкс Харри, Гермиона, Кингсли нар луу эргээд асуулаа.

Тэд түүнд нислэгийнхээ адал явдлын тухай ярьж Билл, Флер, Хурц нүдэт, Наземникус нарыг үргэлжлүүлэн хүлээсэн ч энэ бүх хугацаанд дотор нь хүйт оргихыг тоохгүй байх улам хүнд болж байлаа.

- Би Дауниг-Стритэд буцаж очих ёстой. Намайг тэнд цагийн өмнөөс хүлээж байгаа гээд Кингсли сүүлчийн удаа тэнгэр лүү харж,

- Тэднийг буцаж ирэхээр надад мэдэгдээрэй гэлээ.

Люпин ахин толгой дохив. Кингсли бүгдэд даллан салах ёс гүйцэтгээд хаалгаар гарлаа. Харри түүний Үүрний хязгаар дээрээс шилжих аяархан тас хийсэн чимээг сонсов.

Ноён ба хатагтай Уизли довжоогоор гүйн гарч ирэхэд Жинни араас нь ирлээ. Эцэг эх нь Роныг тэврээд дараа нь Люпин, Тонкс хоёр луу эргэлээ.

- Хүүгийн минь төлөө хийсэн бүхэнд баярлалаа гэж хатагтай Уизли хэлэв.

- Тэнэг юм ярих хэрэггүй дээ, Молли гэж Тонкс даруйхан хэллээ.

- Жорж хэр байна? гэж Люпин асуув.

- Жорж яасан юм? гэж Рон асуулаа.

- Тэр чихээ ...

Гэвч хатагтай Уизлийн сүүлчийн үг хашгиралт болон хувирав. Тэнгэрт хаа нэгтээгээс фестрал гарч ирснээ төдхөн тэдэнд ойртон газардав. Билл, Флер хоёр нуруунаас үсрэн газардахад хоёул бүрэн бүтэн байлаа.

- Билл! Бурханд баярлалаа ... бурханд баярлалаа ...

Хатагтай Уизли хүү рүүгээ ухасхийхэд Билл юу хийж байгаагаа ойлголгүй тэвэрч аваад эцгийнхээ нүд рүү ширтэн,

- Хурц нүдэт үхсэн гэлээ.

Энэ үгийг сонсоод хэн ч хөдөлсөнгүй. Харрийн дотор нэг юм цөмрөн газар дэлхийг үүрд орхих шиг болов.

- Тэр бидний нүдэн дээр үхсэн гэж Билл хэлэхэд Флер толгой дохив. Цонхны гэрэлд түүний хацар дээр нулимсны мөр харагдав.

- Бүх зүйл бид цагаригийг нэвтлэсний дараа болсон. Хурц нүдэт бидэнд ойрхон байсан болохоор хойд зүг рүү бас ниссэн юм. Волдеморт ... тэр нисэж чадаж байсан ... шууд тэдэн рүү ойртсон. Наземникус сандралд ороод яаж орилохыг нь би сонссон.

Хурц нүдэт түүнийг зогсоох гэж оролдсон ч амжаагүй шилжсэн. Волдемортын шившлэг Грюмын шууд нүүр лүү оноход шүүрнээсээ унаад ... бидний араас арваад Үхэл залгигч хөөж байсан болохоор юу ч хийж чадаагүй гээд Биллийн хоолой чимээгүй боллоо.

- Мэдээж чадахгүй байсан гэж Люпин хэлэв.

Тэд зогсоод бие бие рүүгээ харлаа. Харри юу болсныг нэг л сайн ойлгосонгүй. Хурц нүдэт үхсэн гэдэг байж боломгүй юм ... Хурц нүдэт тийм хатуу чанга зоригтой амьдралынхаа төлөө сайн тэмцдэг хүн ...

Эцэст нь бүгд цаашид хашаанд хүлээх нь утгагүй хэрэг гэдгийг ойлгосон тул ноён ба хатагтай Уизлийн араас даган Үүрний зочны өрөөнд ороход Фред, Жорж хоёр инээлдэн тоглоом хийж байлаа.

- Ямар нэг зүйл болоо юу? Юу болсон юм? Хэн ...? гэж Фред орж ирэгсдийн царайг хараад хэлэв.

- Хурц нүдэт үхсэн гэж ноён Уизли хариуллаа.

Ихрүүдийн царайд айдас тодров. Хэн ч цаашид юу хийхээ ойлгосонгүй. Тонкс нусны алчуур руу чимээгүйхэн уйлна. Харри түүнийг Хурц нүдэтийн ойрын найз байсныг мэдэж байлаа. Хагрид өрөөний буланд шалан дээр суугаад бүтээлгийн хэмжээтэй нусны алчуурт мэгшүүлж байв.

Билл шүүгээ рүү очоод галт шарзтай лонх шилэн аяганууудын хамт авлаа.

- Энэ гээд тэр саваагаа даллан өрөөнд байсан хүмүүсийн тоогоор арван хоёр шилэн аяга дүүргэж арван гуравдахыг нь өндөр өргөлөө.

- Хурц нүдэтийн төлөө.

- Хурц нүдэтийн төлөө гэж бүгд давтаад уулаа.

- Хурц нүдэтийн төлөө гэж Хагрид мэгшин хэлэв.

Галт шарз Харрийн хоолойг зурлаа. Түүнд ахин шатаж байгаа юм шиг мэдрэмж төрөхөд болж өнгөрсөн үйл явдал бодит бус юм шиг санагдав.

- Тэгэхээр Наземникус шилжсэн хэрэг үү? гээд Люпин ганц балгалтаар аягатайг хооослов.

Өрөөний уур амьсгал даруй өөрчлөгдөв. Бүгд хөшөөд Люпин рүү харахдаа яриаг нь үргэлжлүүлэн сонсохоос айсан юм шиг харагдав.

- Би чиний юу бодож байгаа мэдэж байна гэж Билл хэлээд.

- Би наашаа ирэх замдаа энэ тухай бодсон. Биднийг отож байсан юм шиг санагдахгүй байна уу? Гэхдээ Наземникус биднээс урваагүй. Үхэл залгигчид долоон Харри байна гэж мэдээгүй болохоор биднийг гарч ирэхэд сандарсан. Бас энэ мэхийг Наземникус бодож олсныг сана. Тэр тэдэнд яагаад хамгийн гол зүйлийг нь хэлээгүй байдаг билээ? Би Наземникусыг сандралд орсон гэж бодож байна. Тэр эхэндээ үүнд оролцохыг хүсээгүй ч Хурц нүдэт түүнийг албадсан. Тэгээд ч Хэцүү нэрт дэргэдээ нисэж байхыг хараад хэн ч цочирдолд орох байсан гэв.

- Хэцүү нэрт яг л Хурц нүдэтийн хэлсэн шиг биеэ авч явж байсан гэж Тонкс хамраа шуухитнуулан хэлээд,

- Грюм түүнийг жинхэнэ Харри хамгийн бөх бат хамгийн чадвартай мракоборецыг дагана гэж бодох болно гэсэн. Тэр хамгийн түрүүнд Грюм рүү дайрч Наземникусыг зугтахад Кингслигийн араас хөөсөн ...

- Энэ бүхэн чинь их с'йн хэрэг гэж Флер тасхийлээ.

- Гэхдээ хэн ч тэднийг 'Арри энэ шөнө нисэх болсныг мэдсэнийг тайлбарлаж чадахгүй байгаа биз дээ? Хэн нэгэн х'йхрамжгүй хандсан байна. Хэн нэгэн гадны хүнд өдөр сарыг хэлсэн байна. Ийм учраас тэд өдрийг мэдэж байсан ч тодорхой төлөвлөгөөг мэдээгүй байна.

Флерийн үзэсгэлэнтэй царайд нулимсны мөр үлдсэн агаад хэн үгүйсгэхийг хүлээсэн мэт зочны өрөөг ууртай харцаар ажиглав. Хэн ч эсэргүүцсэнгүй. Нам гүмийг зөвхөн Хагридын нусны алчууртаа мэгших чимээ эвдэж байлаа. Харри саяхан түүнийг аврахын төлөө амь насаа эрсдэлд оруулсан Хагрид руу харлаа ... түүнийг хайрлаж ... түүнд итгэдэг ... Волдемортод чухал мэдээллийг лууны өндөгөөр арилжсан Хагрид ...

- Үгүй гэж Харри чанга хэлэхэд бүгд гайхан түүн рүү харлаа. Магадгүй галт шарз дууны өнгийг нь өсгөсөн бололтой.

- Миний хэлэхийг хүссэн зүйл гэвэл хэрвээ хэн нэгэн алдаа гаргасан гэвэл санаатайгаар хийгээгүй гэдэгт итгэлтэй байна. Энэ тэдний буруу биш гэж ердийнхөөсөө арай чанга давтаад,

- Бид бие биендээ итгэх хэрэгтэй. Би бүгдэд итгэж байгаа бөгөөд хэн ч намайг

Волдемортод барьж өгөх гээгүй гэж бодож байна гэв.

Энэ үгийн дараа ахин чимээгүй боллоо. Бүгд Харри руу харахад нүүр нь улайж шарзаа балгалаа. Энэ нь түүнд Хурц нүдэт үргэлж Дамблдорын хүмүүст итгэдэг явдалд зэвүүцдэг байсныг санагдуулав.

- Сайхан хэллээ, Харри гэж Фред гэнэтхэн хэлэв.

- Тиймээ, Сонсоцгоо бүх чихээрээ сонсоцгоо гэж Жорж дэмжээд ярвайсан

Фред рүү хяламхийн харлаа.

Люпин Харри руу өрөвдсөн байртай хачирхалтай өнгөөр харав.

- Та намайг тэнэг гэж бодож байна уу? гэж Харри шаардангуй асуулаа.

- Үгүй би чамайг найздаа итгэхгүй байх нь гутамшигтай хэрэг гэж боддог байсан Жеймс шиг гэж бодож байна.

Харри түүний хааш нь хазайлгасныг ойлголоо. Тэр эцгийнх нь найз Питер Петтигрю урвасан тухай ярьж байлаа. Харри уур хилэнд автлаа. Тэр Люпинтэй маргахыг хүссэн ч цааш эргээд аягаа ширээн дээр тавьж Биллд хандан,

- Ахиад нэг ажил байна. Би Кингслигээс гуйж ... гэв.

- Үгүй би чамтай хамт явахад бэлэн байна.

- Хаашаа тэр вэ? гэж Тонкс, Флер хоёр зэрэг асуулаа.

- Хурц нүдэтийн бие рүү. Түүнийг авчрах хэрэгтэй гэж Люпин хэллээ.

- Энэ чинь боломжгүй гэж хатагтай Уизли хэлээд Билл руу гуйн харлаа.

- Хүлээх хэрэг үү? Хэрвээ Үхэл залгигчид түүнийг түрүүлж олоосой гэж хүсээгүй бол боломжгүй хэрэг.

Ахин нам гүм болов. Люпин, Билл хоёр хамт гараад явлаа.

Харригаас бусад үлдсэн хүмүүс сандал дээр суулаа. Түүнд гэнэтхэн энэ өрөөнд хий үзэгдэл шиг суух нь байж боломжгүй санагдав.

- Би бас явах ёстой.

Арван хос нүд түүн рүү ширтлээ.

- Бүү тэнэг юм ярь, Харри. Чи юуны тухай яриад байна? гэж хатагтай Уизли хэлэв.

- Би энд үлдэж чадахгүй гээд тэр хатгуулан өвдсөн сорвио үрлээ.

- Намайг энд байгаа үед та нар аюултай байдалд байхыг хүсэхгүй байна ...

- Гэхдээ энэ чинь тэнэг хэрэг шүү дээ! гэж хатагтай Уизли дуу алдлаа.

- Энэ шөнө чамайг бүрэн бүтэн авчирсанд бурханд талархаад баршгүй. Бас Флер Францад биш энд гэрлэхийг зөвшөөрөөд бүгд хуриманд бэлтгэж хүн бүр чамайг үлдэхийг ...

Тэр хэлсэн үгээрээ байдлыг улам дордуулж байгаагаа ойлгосонгүй.

- Хэрвээ Волдеморт намайг энд байгаа гэдгийг мэдэх юм бол ...

- Тэр яаж мэдэх юм?

- Чиний байж болох арваад байшин байгаа, Харри. Түүнд чиний хаа нуугдсаныг мэдэх боломжгүй гэж ноён Уизли хэлэв.

- Би өөртөө санаа зовоогүй байна!

- Бид мэдэж байна гэхдээ хэрвээ чи явах юм бол бидний өнөөдөрийн бүх хүчин чармайлтыг утгагүй болгоно.

- Чи хаашаа ч явахгүй. Чөтгөр гэж Харри эцсийн эцэст биднийг ийшээ ирсний дараа юу? гэж Хагрид нүргэлүүлэв.

- Тиймээ бас миний цустай чихний дараа юу? Би итгэж ... гээд Жорж дэрнээсээ өндийлөө.

- Хурц нүдэт үүнийг хүсэхгүй ...

- Би мэднэ! гэж Харри хэдэрлэв.

Тэр эргэн тойрноосоо дарамт мэдэрч байв. Үнэхээр бүгд түүний юу хийснийг ойлгохгүй байна гэж үү. Ийм учраас л өөр хэн нэгэн зовохоос өмнө явахыг хүсэж

байгааг мэдэхгүй байна гэж үү? Зочны өрөөнд удтал эвгүйцэм нам гүм бий болоход Харрийн сорви хатуулан өвдсөөр байлаа. Эцэст нь нам гүмийг хатагтай Уизли эвдэв.

- Хэдвиг хаа байна, Харри? гэж тэр аргадангуй асуугаад,

- Бид түүнийг Гахайтай хамт хооллох гэсэн юм гэв.

Харрийн дотор том нударга зангирах шиг болов. Тэр үнэнийг хэлж чадсангүй. Иймээс хариулахаас зайлсхийн шарзаа уулаа.

- Хүлээгээрэй чиний ахиад юу хийснийг бүгд мэдэх хэрэгтэй. Чи түүнээс зугтахдаа цохилт биз дээ гэж Хагрид хэллээ.

- Энэ би биш. Энэ миний саваа. Тэр бүгдийг өөрөө хийсэн гэж Харри хэлэв. Хэдэн хормын дараа Гермиона аяархан,

- Гэхдээ энэ чинь боломжгүй хэрэг шүү дээ, Харри. Чи магадгүй өөрөө биш зөнгөөрөө шид хийсэн гэж хэлэхийг хүссэн байх л даа гэв.

- Үгүй. Мотоцикль унаж эхлэхэд Волдемортын хаана байгааг би ойлгоогүй ч саваатай гар минь хөдөлж түүн рүү танихгүй шившлэг илгээсэн. Миний саваанаас хэзээ ч тийм алтлаг оч гарч байгаагүй.

- Тийм зүйл байдаг юм. Хүн гарах гарцгүй байдалд орохоороо мөрөөдөж ч байгаагүй шид хэрэглэх нь байдаг гэж ноён Уизли хэлэв.

- Тийм биш гэж Харри шүд зуун хэллээ. Сорви нь халуу шатан өвдөхөд уур хилэн урам хугарлыг мэдрээд бүгд түүнийг Волдеморттой эгнэх хүчийг эзэмшсэн гэж бодож байгаа явдлыг үзэн ядлаа.

Бүгд чимээгүй болов. Харри түүнд хэн ч итгээгүй мэдэж байв. Үнэндээ өөрөө хэзээ ч шидэт саваа бие даан шид гаргасан тухай сонсоогүй билээ.

Сорви нь улам халуу шатан өвдөхөд Харри ёолохгүйг хичээв. Тэр цэвэр агаарт гарах тухай бувтнаад аягаа ширээн дээр тавьж зочны өрөөнөөс гарлаа.

Түүнийг харанхуй хашаанд гарах үед ясархаг том фестрал том далавчаа шажигнуулан харснаа ахин ногоо руу эргэв. Харри хашаанд цэцэрлэг рүү харж зогсоод духаа үрэн Дамблдорын тухай бодлоо.

Дамблдор түүнд итгэх байсан гэдэгт Харри эргэлзсэнгүй. Дамблдор Харрийн савааг яагаад бие даан ажилласныг ойлгох байсан. Яагаад гэвэл Дамблдорт үргэлж ямар ч асуултын хариу байдаг юм. Тэр савааны тухай олон зүйл мэддэг болохоор Харрид Волдеморт болон тэдний савааны хоорондын хачирхалтай холбоосын тухай тайлбарласан билээ ... Гэхдээ Дамблдор, Хурц нүдэт шиг, Сириус, Харрийн эцэг эх шиг, хөөрхий цагаан ууль шиг нь одсон болохоор хэзээ ч тэдэнтэй ярьж чадахгүй. Тэр хоолой нь галт шарзтай ямар ч холбоогүй халуу шатахыг мэдрэв.

Тэгтэл гэнэтхэн сорвины өвдөлт тэсвэрлэхийн аргагүй болов. Тэр духаа даран нүдээ аниад толгойд нь хоолой сонсогдож,

- Чи өөр саваа ашиглахад тохиолдсон асуудлын учрыг хэл! гэв.

Харри эцэнхий туранхай хөгшин чулуун шалан дээр хэвтээд зовж шаналсандаа аймшигтай орилохыг харлаа ...

- Үгүй! Үгүй! Гуйж байна танаас, гуйж байна ...
- Чи лорд Волдемортод худал хэлсэн, Олливандер!
- Үгүй ... тангараглая үгүй ...
- Чи Поттерд надаас зугтахад тусалсан!
- Тангараглая энэ тийм биш ... би өөр саваа болно гэж итгэсэн ...
- Тэгвэл юу болсныг тайлбараад аль. Люциусын саваа хугарсан!
- Би ойлгохгүй байна ... холбоос ... зөвхөн ... та хоёрын саваанд байсан ...
- Худалч!
- Гуйж байна ... танаас гуйя ...

Ингээд Харри Волдеморт уурсан хилэгнэж саваатай цагаан гараа өргөхөд шалан дээрх хөгшин зовж шаналсандаа ...

- Харри!

Бүх зүйл эхэлсэн шигээ түргэн дуусав. Харри харанхуйд чичирэн зогсоод зүрх нь галзуурсан юм шиг цохилж сорви нь хатгуулсан хэвээр байлаа. Тэр дэргэдээ Рон, Гермиона хоёр зогсож байна гэдгийг мэдэхийн тулд хэдэн хором шаардагдав.

- Харри байшин руу буцаж оръё. Чи явахгүй биз дээ? гэж Гермиона шивнэлээ.
- Тиймээ, найз минь чи үлдэх ёстой гээд Рон Харрийн мөрөн дээр алгадлаа.
- Бие чинь зүгээр үү? гээд Гермона Харрийн нүүр лүү ойртон харснаа,
- Чи аймшигтай харагдаж байна! гэлээ.
- Гэхдээ ямар ч гэсэн Олливаендраас дээр харагдаж байгаа байх ... гэж Харри чичирсэн хоолойгоор хэлэв.

Түүнийг харсан зүйлээ ярьж дуусахад Рон хирдхийсэн бол Гермиона айдаст автлаа.

- Гэхдээ энэ зогсох ёстой! Чиний сорви ... Тэр үүнийг! Та хоёрын холбоо ахин сэргэх боломж бүү өг ... Дамблдор чамайг түүнээс оюун ухаанаа хаахыг хүсэж байсан! гэж Гермиона хэлэв.

Харри хариулсангүйд тэр гараас нь зуурлаа.

- Харри тэр ид шидтэний яам, сонин хэвлэл болон шидтэний ертөнцийн хагасыг эзэлсэн! Түүнд бас толгой руугаа нэвтрэх боломж бүү өг!

БҮЛЭГ 6: ХҮРЭМТЭЙ ОРООЛОН

Хурц нүдэтийг алдсан гашуудал байшинг дараагийн өдрийн турш нэрвэлээ. Харри түүнийг мэдээ дамжуулахаар ирсэн бүлгийн бусад гишүүд шиг модон хөлөө тогшин орж ирэхийг хүлээсээр байлаа. Ингээд сая л жинхэнээсээ уй гашуу гэмшилийг мэдэрч крестражуудыг устгахаар яаралтай явах ёстой болохоо ойлгов.

- Чи арван долоо хүрээгүй байгаа болохоор ... гээд Рон чимээгүйхэн уруулаа хөдөлгөн «крестраж» гэж хэлснээ,

- Юу ч хийх боломжгүй. Чи Хяналтын шидийн дор байгаа. Харин бид энд байхдаа хайх талаар төлөвлөгөө зохиовол ямар вэ? Эсвэл чи түүний хаана байгааг мэдэж байгаа юм уу? гэлээ.

- Үгүй.

- Минийхээр бол Гермиона чамд энэ талаар ямар нэг зүйл хэлж чадах байх. Тэр үргэлж чамайг энд ирэхээр хэлнэ гэдэг байсан юм.

Тэд өглөөний цайгаа ууж байлаа. Ноён Уизли, Билл хоёр дөнгөж сая ажилдаа явжээ. Хатагтай Уизли Гермиона, Жинни хоёрыг сэрээхээр дээшээ өгсөж харин Флер угаалгын өрөө рүү явсан байв.

- Хяналтын шид гучин нэгэнд тайлагдана. Тэгэхээр надад зөвхөн дөрвөн өдөр хүлээх үлдлээ. Дараа нь би ...

- Тав гэж Рон шийдэмгий засаад,

- Бид хуриманд үлдэх ёстой. Тэгэхгүй бол тэд биднийг ална гэлээ. Харри «тэд» гэж Флер, хатагтай Уизли хоёрыг хэлж байгаа болохыг ойлгов.

- Ердөө ганц нэмэлт өдөр гэж Рон Харрийн эсэргүүцсэн төрхийг хараад хэлэв.

- Тэд үнэхээр үүнийг хичнээн чухал гэдгийг ойлгохгүй байгаа хэрэг үү?

- Мэдээж ойлгохгүй. Тэд юу ч мэдэхгүй юм чинь. Ингэхэд хурим гэснээс чамтай нэг зүйл ярих хэрэгтэй байна.

Рон үүдний хаалга руу өнгийн хатагтай Уизли ирж байгаа эсэхийг харснаа Харри руу бөхийв.

- Ээж Гермиона бид хоёроос асуухыг оролдсон. Бидний юу хийх гэж байгаа тухай. Одоо тэр чамайг барьж авах болно. Аав, Люпин хоёр бас асуусан ч Дамблдор чамайг биднээс өөр хэнд ч хэлж болохгүй гэсэн гэж хэлсэн. Ээжийн хувьд бол өөр хэрэг. Тэр шийдсэн байгаа.

Роны анхааруулга цагийн дараа биелэлээ олов. Үдийн хоолны дараа хатагтай Уизли түүний үүргэвчнээс нь гарсан байж болзошгүй оймсны тухай асуухаар бусдаас хол аваачлаа. Ингээд сав суулга угаадаг хэсэгт аваачаад байцааж эхэллээ.

- Рон, Гермиона хоёр та гурвыг Хогвартсыг орхиж байгаа гэсэн хэмээн тэр энгийн аясаар эхлэв.

- Аан тийм л дээ. Бид сургуулиас гарч байгаа.

Булангийн хатаагчид ноён Уизлийн хантаазтай төстэй зүйл танигдахгүй болтлоо мушгигдав.

- Тэгвэл яагаад боловсролоо тасалдуулж байгаа гэдгийг чинь асууж болох уу?

гэж хатагтай Уизли сонирхов.

- Ойлгож байна уу, Дамблдор надад нэг зүйл ... даалгасан. Рон, Гермиона хоёр түүнийг мэдэх болохоор туслахыг хүсч байгаа юм.

- Нэг зүйл гэдэг чинь юу юм?

- Уучлаарай, хэлж чадахгүй нь ...

- Ний нуугүй хэлэхэд Артур бид хоёр үүнийг мэдэх эрхтэй гэж бодож байна.

Бас ноён ба хатагтай Грейнжер ч гэсэн мөн адил! хэмээн хатагтай Уизли мэдэгдэв.

Эцэг эхчүүдийн сэтгэл зовсон дайралтаас Харри юунаас илүү болгоомжилж байлаа. Иймээс биеэ албадан хатагтай Уизлийн нүд рүү харахад Жиннигийн адил болсон байв. Энэ тус болсонгүй.

- Дамблдор энэ тухай хэн нэгэн мэдэхийг хүсээгүй, хатагтай Уизли. Намайг уучлаарай. Рон, Гермиона хоёр надад заавал туслах албагүй. Тэд өөрсдөө л сонгосон ...

- Би та нарыг яагаад заавал сургуулиас гарах ёстойг ойлгохгүй байна! гэж тэр сүр үзүүлсэн төрхөө орхин хэлээд,

- Та нар дөнгөж сая насанд хүрсэн. Юун дэмий зүйл вэ. Хэрвээ Дамблдорт ямар нэг зүйл хийх хэрэг гарсан бол түүнд бүхэл бүтэн бүлэг байгаа! Чи түүнийг лав буруу ойлгосон байх, Харри. Тэр магадгүй ямар нэг зүйл хийж дуусгахыг хүсэж байна гэж хэлснийг чи үүнийг өөрийгөө гэж бодож... гэв.

- Үгүй би бүгдийг зөв ойлгосон. Үүнийг зөвхөн би хийж чадна гэж Харри хатуу хэллээ.

Тэр хатагтай Уизлид алтан зэгсний зурагтай өрөөсөн оймсыг буцааж өгөв.

- Энэ минийх биш байна. Би «Пэдмор Юнайтед» багийг дэмждэггүй.

- Тийм л дээ гээд хатагтай Уизли гэнэтхэн ердийн өнгөөр,

- Би өөрөө тааварлаж болох байж. За яахав Харри гэхдээ та нар энд байгаа үедээ Билл, Флер хоёрын хуримын бэлтгэлд туслах хэрэгтэй байна. Хичнээн их хийх ёстой ажил байна гээч.

- Үгүй ... би ... тэгэлгүй яахав гэж Харри сэдвийн гэнэтийн өөрчлөлтөнд тэвдэн хэлэв.

- Ямар элдэг юм бэ гээд тэр инээмсэглэн сав суулга угаах өрөө рүү эргэлээ.

Энэ мөчөөс эхлэн хатагтай Уизли Харри, Рон, Гермиона гурвыг хуримын бэлтгэлтэй холбоотой ажлаар дарж өөр юуны ч тухай бодох цаг үлдээсэнгүй. Түүний энэ байдлыг хамгийн элдэгээр Хурц нүдтийн айдас дүүрэн нислэгийн тухай бодлоос салгах гэсэн хэмээн тайлбарлаж болох байлаа. Гэвч дараагийн хоёр өдрийг

тасралтгүй галт тогооны хэрэгсэл цэвэрлэж, цэцэг туузаар баглан, цэцэрлэгийг анахайгүй болгон хатагтай Уизлийн талх шарахад туслах үедээ Харри өөр шалтгаан байгаа эсэхэд сэжиглэж эхэллээ. Түүний даалгасан ажил бүхэн Рон, Гермиона хоёрыг хол байлгаж байлаа. Эхний шөнө тэр найзууддаа Волдеморт Оливандерийг зовоож буй тухай ярьсанаас хойш тэдэнтэй ахин ганцаарчилан үлдэж ярих боломж байсангүй.

- Минийхээр бол ээж хэрвээ та нарт ярилцах боломж өгөхгүй байвал явахгүй гэж бодсон юм шиг байна хэмээн Жинни Харриг үүрэнд ирснээс хойш гурав дахь өдөр хоёул оройн хоолны ширээ цэвэрлэж байхад нам дуугаар хэлэв.

- Түүний бодлоор цаашид яах болж байна? Хэн нэгэн өөр хүнийг Волдеморт алж байхад бид махан хачиртай бялуу бэлтгэж байх хэрэг үү? гэж Харри бувтналаа.

Тэр энэ үгийг бодолгүй хэлээд Жинни цайхыг харлаа.

- Тэгэхээр энэ үнэн үү? Чамайг ямар нэг зүйл бодож олсон гэж?

- Би ... үгүй ээ ... тоглосон юм гэж Харри булзан хэллээ.

Тэд бие бие рүүгээ ширтэхэд Жиннигийн царайд гайхширал тодорлоо. Гэнэтхэн Харри сургуулийн хашааны буланд хамтдаа зогсож байснаас хойш анх удаагаа хоёул үлдсэнээ мэдрэв. Тэр Жинниг энэ тухай санаж байгаа гэдэгт эргэлзсэнгүй. Тэгтэл хаалга нээгдэж ноён Уизли, Кингсли, Билл нар орж ирэхэд хоёул цочив.

Одоо хоолон дээр бүлгийн гишүүд цаг үргэлж ирэх болсон бөгөөд Үүр Гриммогийн арван хоёрдугаар байшингийн штабын байрны үүргийг өөртөө авчээ. Ноён Уизли үүнийг тэдний нууц хадгалагч болох Дамблдорын үхлийн дараа түүний итгэж байсан хүн бүр Гриммогийн байшингийн оршин буй газрын нууц хадгалагч болсон гэж тайлбарлажээ.

- Бидэнд тийм хүн хориод байгаа болохоор итгэлцлийн шидийн хүч суларсан.

Үхэл залгигчид энэ нууцыг хэн нэгнээс нээх боломж хорь дахин их байна. Бид цаашид түүнийг удаан барьж чадахгүй.

- Гэхдээ Снегг хаягийг нь Үхэл залгигчидад хэдийн хэлсэн байлгүй гэж Харри хэлэв.

- Хурц нүдэт тэр газар Снегг түүгээр очсон тохиолдолд хоёр шид үлдээсэн байгаа. Бид шидийг түүнийг ойртуулахгүй байх хүчтэй гэж найдаж байгаа ч хэн нэгэнд хэлэхгүй гэх бүрэн итгэл алга байна. Иймээс цаашид штабын байраар тэр газрыг ашиглах нь найдлагагүй бөгөөд ухаангүй хэрэг юм.

Энэ үдэш гал зууханд дүүрэн хүн байсан учир хутга сэрээгээ хөдөлгөхөд амаргүй байлаа. Харри Жиннигийн хажууд чихэлдэн суугаад тэдний хоорондхэлээгүй

өнгөрсөн зүйлдээ харамсаж үүнээсээ аль болох татгалзахыг оролдов. Тэр гарыг нь шүргэхгүйг хичээн тахиагаа арай ядан зүсэнгээ,

- Хурц нүдэт Грюмын талаар ямар нэг шинэ зүйл байна уу? гэж Биллээс асуулаа.

- Юу ч алга.

Билл, Люпин хоёр Грюмын биеийг нь олоогүй болохоор оршуулах ёслол болсонгүй. Харанхуйд тэмцэл замбараагүй байсан учир унасан газрыг эрж олоход хэцүү байв.

- «Өдөр тутмын зөнч» сонинд түүнийг үхсэн тухай болон биеийг нь олсон тухай нэг ч үг дурдаагүй. Гэхдээ энэ нь юу ч илэрхийлэхгүй гэсэн үг биш. Сүүлийн үед «Зөнч» олон зүйлийн талаар дуугүй өнгөрдөг болоод байгаа гэж Билл хэллээ.

- Насанд хүрээгүй байж ид шид ашиглан Үхэл залгигчдаас зугтсан явдалд ид шидийн яам дуудлага өгөхгүй хэрэг үү? гэж Харри ноён Уизлигаас асуухад толгой сэгсэрлээ.

- Нэг бол тэд үүнийг надад өөр сонголт байгаагүй гэж ойлгосон эсвэл бүгдэд над руу Волдеморт дайрсан гэж хэлэхийг хүсээгүй байх.

- Сүүлийнх нь үнэн гэж бодож байна. Скримжер Волдемортыг хүчирхэгжин, Азкабанаас их хэмжээний хүн оргосон гэж мэдэгдэхийг хүсэхгүй байгаа.

- Яагаад хүмүүст үнэнийг хэлж болдоггүй юм? гэж Харри асуугаад хутгатай гараа чанга атгахад дээр нь бичигдсэн «би худал хэлэхгүй» гэсэн сорви цайрлаа.

- Эсвэл ид шидийн яаманд түүний эсрэг тэмцэх хүн байдаггүй юм уу? гэж Рон ууртай асуулаа.

- Мэдээж бий, Рон гэвч олонхи хүмүүс айж байна. Дараагийн удаа алга болох юм уу хүүхдүүд рүү нь дайрахаас айж байна! Түүнчлэн аймшигтай цуу яриа дэгдэж байна. Жишээлбэл би Хогварстын магл судлалын багш ажлаасаа зүгээр л халагдсан гэдэгт итгэхгүй байна. Түүнийг олон өдрийн турш хэн ч хараагүй. Харин энэ үед Скримжер өдөржингөө өрөөндөө нам гүм сууж байгаа. Түүнийг ямар нэг ажиллагааны төлөвлөгөө зохиож байгаа гэж найдахаас.

Нам гүм болоход хатагтай Уизли хоосон тавагнуудыг илбэдэн алимны бялуу бий болгов.

- Бид чиний зүсийг яаж хувирг`хаа шийдэх хэрэгтэй байна, `Арри гэж Флер бүгдийг амттан авахад хэлснээ,

- Хуримын үеэр гэж түүний гайхсан царайг нь хараад нэмэрлэв.

- Мэдээж Үх`л залг`гчид манай зочин байхгүй ч тэдний шампан дарс хэрэглэхийг х`риглож чадахгүй.

- Тиймээ сайхан бодол байна гэж ширээний голд сууж байсан хатагтай Уили зөвшөөрөөд хамар дээрх нүдний шилээ засаж хийх ажлын жагсаалт бүхий урт хуйлаастай цаасыг харав.

- Рон чи одоо нэн даруй унтлагын өрөөгөө цэвэрлэх хэрэгтэй байна?

- Яагаад? гэж Рон дуу алдаад халбагаа ширээн дээр тасхийтэл тавьж эх рүүгээ уурсан харлаа.

- Яагаад би унтлагын өрөөгөө нэн даруй цэвэрлэх ёстой гэж? Харри бид хоёр түүнд сайн байгаа!

- Залуу хүн минь хэдэн өдрийн дараа энэ байшинд чиний ахын хурим болох гэж байна ...

- Тэгээд тэд миний унтлагын өрөөнд гэрлэх гэж хэрэг үү? Үгүй! Яагаад Мерлиний нэрийг ...

- Эхтэйгээ ийм өнгөөр бүү ярь гэж ноён Уизли хатуу хэлээд,

- Юу хэлснийг нь хий гэв.

Рон хөмсөг зангидан эцэг эх рүүгээ харснаа халбагаа авч алимны бялууны үлдсэн хэсгээ халбагадав.

- Би бас хог тарьсан болохоор туслая гэж Харри Ронд хэлсэн ч хатагтай Уизли төлөвлөгөөг нь тасалдуулав.

- Үгүй Харри хонгор минь, би чамайг Артурт тахианы байр янзлахад тусалсан нь дээр гэж бодож байна. Харин Гермиона ноён ба хатагтай Делакурын орны даавууг соливол ихэд талархах байна. Тэд маргааш өглөө арван нэгэн цагаас ирэх юм.

Гэсэн ч тахианы байранд хийх ажил бараг байсангүй.

- Э-э-э ... Моллид энэ тухай бүү дурсаарай гэж ноён Уизли тахианы тор хаших зууpаа Харрид хэлээд,

- Гэхдээ ... э–э ... харж байна уу Тед Тонкс надад Сириусын мотоциклоос үлдсэн хэсгийг авчирч өгсөн болохоор энд нуугаад тахианы байшинг янзална гэж хэлсэн юм. Гайхалтай машин шүү утааны яндан, гайхамшигтай аккумлятортой бас тоормос нь яаж ажилладагыг мэдэх сайхан боломж гарч ирлээ. Би үүнийг ахин босгохыг хүсч байгаа ч Молли ... цаг өгөхгүй байгаа юм гэв.

Тэднийг байшинд эргэж орох үед хатагтай Уизли үзэгдсэнгүйд Харри дээшээ Роны унтлагын өрөө рүү орлоо.

- Би хийж л байна шүү дээ, хийж л байна! Аан энэ чи юу гэж Рон Харриг хараад санаа амран хэлснээ саяхан үсрэн боссон бололтой ор луугаа буцаж хэвтлээ.

Өрөөний бүх зүйл долоо хоногийн өмнө байсан шигээ замбараагүй хэвээр байв. Цорын ганц шинээр нэмэгдсэн зүйл гэвэл Гермиона алсын буланд суугаад хөлд нь сахлаг үстэй муур Живоглот байж дэргэдээ хоёр хэсэг ном овоолсны дунд зарим нь Харрийн мэдэх ном байлаа.

- Сайн уу, Харри гээд тэр эвхдэг орон дээр суув.

- Чи яаж мултарч ийшээ ирээ вэ?

- Өө, Роны ээж Жинни бид хоёрыг өчигдөр орны даавуу солихыг гуйснаа мартчихсан гээд Гермиона «Шидэт тооны ухааны дүрэм зүй» гэсэн номыг нэг багана дээр нь тавиад «Хар урлагийн уналт хөгжилт»-ийг нөгөө дээр нь тавилаа.

- Бид сая Хурц нүдэтийн тухай ярьж байлаа. Миний бодлоор тэр амьд үлдсэн байх гэж Рон хэлэв.

- Гэхдээ Билл түүнийг үхлийн шившлэгт өртсөнийг харсан шүү дээ.

- Тийм л дээ гэхдээ Билл бас энэ үед дайралтанд өртсөн байсан. Яаж харсан зүйлд нь итгэлтэй байх юм?

- Хэрвээ үхлийн шившлэг түүнийг оноогүй бол Хурц нүдэт мянган ярдын өндрөөс унасан гээд Гермиона алгандаа «Англи болон Ирландын квиддичийн багууд» гэсэн лавлахыг өргөн дэнслэв.

- Тэр Бамбай шид ашиглаж чадах байсан ...

- Флер түүний сабааг гараас нь мултарсан гэсэн хэмээн Харри дуугарлаа.

- За яахав хэрвээ чи түүнийг үхэхийг хүсээд байгаа бол ... гэж Рон янзгүй хэлснээ дэрээ аятайхан хэлбэртэй болгон заслаа.

- Мэдээж хэн ч түүнийг үхэхийг хүсээгүй! гэж Гермиона цочирдон хэлээд,

- Түүний үхсэн гэдэг чинь аймшигтай биз дээ! Гэхдээ бид бодит байдалтай эвлэрэх хэрэгтэй! гэв.

Харри анх удаагаа Хурц нүдэтийн бие Дамблдорийнх шиг унаад шидэт нүд нь аяган дотроо үргэлжлүүлэн эргэлдсээр байгааг төсөөлөв. Тэгтэл жигших хачирхалтай инээх хүсэл холилдон төрөв.

- Үхэл залгигчид түүнийг түрүүлж олсон болохоор бид олоогүй байх гэж Рон хэлэв.

- Тийм шүү. Яг л Барти Краучыг Хагридын арын цэцэрлэгт яс болгон хувиргаад оршуулсан шиг. Грюмыг ч гэсэн тэгж хувиргасан гэж бодож байна

...

- Хангалттай! гэж Гермиона чанга дуу алдав.

Айсан Харри эргэж харахад түүний нүднээс нулимс дусалж байлаа.

- Чи яасан бэ? гээд Харри түүний ор луу ухасхийж,

- Гермона би чамайг сэтгэлээр унагахыг хүсээгүй ... гэлээ.

Гэвч Рон орны пүрш чахруулан үсэрч буугаад Гермиона руу түрүүлж ухасхийв. Тэр нэг гараараа тэврээд нөгөөгөөрөө жинсэн өмднийхөө халааснаас юм цэвэрлэхдээ хэрэглэж байсан халтар алчуур гаргаж ирснээ яаран шидэт саваа гаргаж ирээд алчуурт хүргэн,

- Тергео! гэв.

Саваа алчуурын ихэнхи толбыг арилгав. Рон сэтгэл хангалуунаар үл мэдэг уугьсан алчуурыг Гермионад өглөө.

- Өө ... баярлалаа, Рон ... намайг уучлаарай гээд нусаа нийж аяархан мэгшсэнээ,

- Энэ аймшигтай биш гэж үү? Дамблдорын араас ... би хэзээ ч Хурц нүдэтийг үхнэ гэж төсөөлж байсангүй. Тэр хичнээн хатуу чанга билээ дээ! гэв.

- Тиймээ би ойлгож байна гээд Рон түүний мөрөөр тэвэрлээ. Гэхдээ чи Хурц нүдэт энд байсан бол юу хэлэх байсныг мэдэж байгаа биз дээ?

- Ү-үргэлж сонор сэрэмжтэй бай гээд Гермиона нүдээ арчив.

- Яг тийм. Тэр үргэлж биднийг болсон явдлаас суралц гэдэг байсан. Тэгээд ч энэ удаад намайг хулчгар Наземникуст итгэхгүй байхыг сургалаа.

Гермиона сулхан инээмсэглээд урагш хоёр ном авахаар бөхийв. Секунтын дараа Рон түүний мөрнөөс гараа огцом татан авсанд Гермиона «Мангасуудын тухай аймшигт ном»-оо унагачихлаа. Номын тэлээ задармагц ууртайгаар тас няс хийн Роны шагайнаас хазав.

- Өө, намайг уучлаарай, уучлаарай! гэж Гермиона уулга алдахад Харри номыг даран Роны хөлөөс холдуулаад түгжлээ.

- Чи ер нь эдгээр номоор юу хийдэг юм? гэж Рон асуугаад ор луугаа хазганан буцав.

- Бид крестражыг эрэхээр явахдаа алийг нь авч явах эсэхээ шийдэхийг оролдож байна.

- Өө, тэгэлгүй яахав. Би Волдемортын араас хөөцөлдөхөд хөдөлгөөнт номын сан хэрэг болно гэдгийг мартчихаж гээд Рон духаа алгадав.

- Ха-ха гээд Гермиона өвдгөн дээрээ хэвтэж байсан ном руугаа харлаа.

- Сонирхолтой нь бидэнд эртний дүрс бичгийн орчуулга хэрэг болох болов уу?

Магадгүй л юм ... үүнийг юу ч гэсэн авчихъя.

Тэр номыг ойролцоох том овоолго дээр тавиад шалан дээрээс «Хогвартсын түүх»-ийг авлаа.

- Сонсооч гэж Харри хэлээд өндийн суухад Рон, Гермиона хоёр түүн рүү эсэргүүцсэн байртай харлаа.

- Би Дамблдорын оршуулгын дараа та хоёрыг надтай явна гэснийг мэдэж байна.

- За эхэллээ гэж Рон Гермионад хэлээд нүдээ эргэлдүүлэв.

- Мэдээд байсан юм гээд тэр санаа алдан ахин ном руугаа харснаа,

- Мэдэж байна уу, би «Хогвартсын түүх»-ийг авч явна. Хэрвээ бид эргэж ирэхгүй бол түүнгүйгээр байж чадна гэж бодохгүй байна ... гэв.

- Сонсооч! гэж Харри давтлаа.

- Үгүй ээ, Харри чи биднийг сонс. Бид чамтай хамт явна. Бүх зүйл хэдийн сарын өмнө ... үнэндээ жилийн өмнө шийдэгдсэн гэж Гермиона татгалзав.

- Гэхдээ ...

- Амаа тат гэж Рон түүнд зөвлөв.

- Та нар үнэхээр ингэж бодож байгаа гэдэгтээ итгэлтэй байна уу? гэж Харри шаргуу дуугарлаа.

- За яахав харцгаая гээд Гермиона «Савдагийн жимээр» номыг хэрэггүй номын овоолго руу тавиад уурссан шинжтэй харлаа.

- Би бүх юмаа хэдэн долоо хоногийн өмнөөс цэгцэлж дурын агшинд энэ газраас хөдлөхөд бэлэн болгосон. Үнэндээ чамд мэдээлэл олж авахад төвөгтэй хэцүү шидийн заль мэх хэрэглэгдэх болохоор Хурц нүдэтийн Хувиргагч уусмалын нөөцийг Роны эхийн хамар дороос авсан.

- Бас эцэг эхийнхээ ой дурсамжыг сольсон болохоор тэд одоо Венделл болон Моника Уилкинс болсон гэдэгтээ итгэлтэй байгаа. Тэдний амьдралын мөрөөдөл бол Австралид оршин суух явдал бөгөөд үүнийгээ хэдийн хийсэн. Одоо Волдеморт тэднийг мөрдөж олон миний тухай асуухад хэцүү байх болно ... Хэрвээ би крестражыг эрж олсныхоо дараа амьд үлдвэл ээж аавaа хайж олоод шидийг тайлах болно. Хэрвээ үгүй бол шид тэднийг хангалттай аюулгүй жаргалтай амьдруулна гэж бодож байна. Венделл болон Моника Уилкинс хоёр тэдэнд охин байгаа гэдгийг мэдэх ч үгүй.

Гермионагийн нүд ахин нулимсаар дүрлээ. Рон орон дээр нь суугаад мөрөөр нь тэвэрч Харрийн бүтэлгүй арга барилд хөмсөг зангидан толгой сэгсэрлээ. Харри Роны арга барил бүтэлгүй гэж зааж байгаа ер бусын явдалд юу хэлэхээ мэдсэнгүй.

- Би ... Гермиона, намайг уучлаарай ... би тэгэх гээгүй ...

- Рон бид хоёрыг чамтай явснаараа юу тохиолдохыг сайн ойлгохгүй байгаа гэж бодож байгаа юм уу? Бид ойлгож байгаа. Рон түүнд юу хийснээ хэл дээ.

- Боль доо тэр саяхан хооллосон.

- Зүгээр тэр мэдэх хэрэгтэй!

- За яахав. Явъя Харри гээд Рон Гермионагийн мөрөн дээрээс хоёр дахь удаагаа гараа аван хаалга руу очлоо.

- Явъя.

- Яах гэж? гээд Харри Роны араас шатны жижигхэн талбай руу гарав.

- Десцендо! гэж Рон бутвнаад саваагаа намхан адар руу чиглүүлэв.

Тэдний дээр нүх нээгдэхэд хөл дор нь шат гулсан бууж ирлээ. Дөрвөлжин нүхнээс аймшигтай сорж байгаа ч юм шиг ёолж байгаа ч юм шиг чимээ гаран бохирын хоолой онгойлгосон юм шиг эвгүй үнэр ханхлав.

- Энэ танай ороолон уу? гээд Харри хэзээ ч шөнийн нам гүмийг эвдэх ийм амьтантай тулгарч байсангүй.

- Тиймээ мөн. Гарч ирээд хардаа гээд Рон шатаар дээшээ өгсөв.

Харри Роныг дагалдан жижигхэн дээврийн хөндийд гарав. Түүний мөр толгой цухуймагц хоёр алхамын зайд харанхуйд амаа том ангайн бөх унтаж байгаа амьтныг харав.

- Гэхдээ тэр ... юу гээч ... ороолон жирийн хүрэм өмсдөг гэж үү?

- Үгүй. Үгүй ээ ер нь бол шаргал үстэй байх нь ховор бас батга нь ч бага байдаг юм.

Харри унтаж буй амьтаныг зэвүүцэн харлаа. Тэрбээр хүний биеийн хэмжээтэй бөгөөд Роны хуучин хүрмийг өмсчээ. Гэхдээ тэр ороолонг хэзээ ч үстэй байгаагүй салсархаг халзан толгойтой бөгөөд биен дээр нь улаан өнгийн цэврүү байдаггүй гэдэгт итгэлтэй байлаа.

- Энэ бол би ойлгож байна уу? гэж Рон хэлэв.

- Үгүй ойлгохгүй байна.

- Би чамд өрөөнд орж байгаад бүгдийг тайлбарлая. Одоо энэ үнэр дотор муухайруулаад байна гэж Рон хэлэхэд тэд шатаар доош уруудан адрын таглааг хаагаад ном ялгаж буй Гермионатай нэгдлээ.

- Биднийг эндээс явах үед ороолон доошоо миний өрөөнд орж ирэх юм. Би түүнийг тэсч ядан хүлээж байгаа гэж бодож байгаа ч ... хэлэхэд хэцүү байна учир нь ердөө тэр ердөө ёолж шүлсээ гоожуулж чадна. Бас дохиж чадна. Ер нь бол тэр миний оронд байх бөгөөд зөвхөн тууралтаар өвдсөн байх юм. Гайхалтай байгаа биз?

Харри түүн рүү хараад юу ч ойлгосонгүй.

- Тиймээ гайхалтай! гэж Рон түүний гялалзсан санааг ойлгоогүй явдалд урам хугаран хэлээд,

- Чи ойлго, биднийг Хогвартст эргэж очихгүй болохоор хүн бүр Гермиона бид хоёрыг чамтай хамт байгаа гэж бодно биз дээ? Харин үүнийг Үхэл залгигчид мэдвэл шууд чиний байгаа газар болох манай гэр бүлийнхэнд хүрч ирнэ.

- Миний хувьд гэвэл бүх зүйл хэвийн ээж аавтайгаа явсан юм шиг харагдах болно. Одоо олон магл гаралтай хүмүүс хаа нэгтээ нуугдах тухай ярьж байгаа гэж Гермиона хэлэв.

- Харин манай гэр бүлийнхэнд бол нуугдах боломж байхгүй. Энд тэдний ажил байгаа. Биднийг явахаар намайг хүнд өвдсөн учир сургуульдаа буцаж чадаагүй гэж цуу яриа тараах юм. Хэрвээ хэн нэгэн ийшээ шалгахаар ирвэл

ээж аав хоёр миний оронд хэвтэж байгаа булдруутай ороолонг үзүүлнэ. Тууралт их халдвартай учир түүнд хэн ч ойртож чадахгүй. Бас түүний хэл нь мөөгөнцөртсөн болохоор ярьж чадахгүй.

- Ээж аав хоёр чинь энэ төлөвлөгөөг зөвшөөрч байгаа юм уу?

- Аав зөвшөөрсөн. Тэр Фред, Жорж хоёртой хамт ороолонг хувиргахад тусалсан. Харин ээж ... чи ээжийг мэднэ биз дээ. Биднийг эндээс явахаас нааш үүнтэй эвлэрч чадахгүй.

Өрөөнд нам гүм болоход зөвхөн Гермионагийн ном эмхлэн хоёр талд тавих нь дуулдаж байлаа. Рон суугаад түүн рүү харахад Харри юу ч хэлж чадсангүй. Тэд гэр бүлээ хамгаалах гэж бодсоноороо түүнийг эцэст нь ятгаж найзууд нь үнэхээр

түүнтэй яван ямар аюул заналхийлж байгааг ойлгож байгаа бололтой. Харри энэ нь түүний хувьд хичнээн чухал гэдгийг хэлэхийг хүссэн ч хэрэгтэй үгээ олж чадсангүй.

Дараа нь нам гүмийг эвдэн бөглүү чимээ гарахад хатагтай Уизли ямар нэгэн зүйл дөрвөн давхарт хашгирлаа.

- Магадгүй Жинни анзааралгүй бөгжтэй амны алчуураар тоос арчсан байх.

Гэхдээ Делакурынхан яагаад бидэн дээр хуримаас хоёр хоногийн өмнө ирэх гэснийг ойлгохгүй байна гэж Рон хэллээ.

- Флерийн дүү сүйт бүсгүйг дагалдах болохоор дүрдээ тоглохын тулд бэлтгэл хийх хэрэгтэй байгаа юм гээд Гермиона «Цус сорогчтой тулгарсан нь» номоо тээнэгэлзэн харлаа.

- Зочдын ирэлт ээжийн сэтгэлийн дарамтыг хөнгөлөхөд тус болохгүй гэж айж байна хэмээн Рон хэлэв.

- Бид эндээс яваад хаачихаа шийдэх хэрэгтэй байна гээд Гермиона «Хамгаалах шидийн онол»-ыг удаан бодолгүй хогийн сав руу чулуудаад «Европын ид шидийн боловсролд үнэлгээ өгөх нь» гэдэг номыг авч.

- Би чиний Годрикийн хонхорт түрүүлж очихыг хүсч байна гэж хэлснийг ойлгож байгаа ч, Харри ... ер нь бол крестраж бидний эхний зорилт биз дээ? гэв.

- Хэрвээ бид крестражууд хаана байгааг мэдэж байсан бол чиний хэлснийг зөвшөөрч болох юм гээд Харри Гермиона үнэхээр Годрикийн хонхорт очих хүслийг нь ойлгохгүй байгаа гэдэгт итгэсэнгүй.

Тэр тийшээ зөвхөн эцэг эхийнхээ булшыг эргэхээр очих гэсэнгүй. Тэндээс олон асуултын хариуг олох болно гэсэн бүдэгхэн мэдрэмж төрж байлаа. Магадгүй энэ газарт л Волдемортын үхлийн шившлэгээс амьд үлдсэн болохоор гавъяагаа давтан бүх зүйл яаж болсныг ойлгохыг хүсч байлаа.

- Чи Волдеморт Годрикийн хонхорыг харуулдаж байж болзошгүй гэж бодохгүй байна уу? Тэр чамайг чөлөөтэй болмогц эцэг эхийнхээ булшыг эргэхээр очиж болох юм гэж бодсон байж магадгүй биз дээ?

Энэ санаа Харрийн толгойд орсонгүй. Тэр эсэргүүцэх зүйл бодож олохоор оролдсон ч Роны харваас шал өөр зүйл бодож байгаа бололтой.

- Энэ Р.А.Б. Санаж байна уу жинхэнэ зүүлтийг хулгайлсан хүн? гэв.

Гермиона толгой дохилоо.

- Тэр устгасан гэсэн зурвас үлдээсэн байсан биз дээ?

Харри үүргэвчнээсээ Р.А.Б-ын зурвас байсан хуурамч крестражыг гаргалаа.

Би жинхэнэ крестражыг устгахаар авсан бөгөөд үүнийг удахгүй хийх болно.

- Хэрвээ тэр түүнийг устгачихсан бол? гэж Рон хэллээ.

- Эсвэл тэр гэж Гермиона үг хавчуулав.

- Тэгвэл бидэнд хийх ажил багасах болно!

- Тиймээ гэхдээ бид зүүлтийг үнэхээр устгагдсан гэдгийг тодруулахын тулд жинхэнэ зүүлтийн ул мөрийг олох хэрэгтэй байна гэж Гермиона хэлэв.

- Бас нэг юм байна. Бид жинхэнэ крестражыг олох үед түүнийг яаж устгах болж байна? гэж Рон асуулаа.

- Би энэ талаар жаахан юм уншсан гэж Гермиона хэллээ.

- Хаанаас тэр вэ? гэж Харри гайхширлаа. Би крестражын тухай ямар нэг ном номын санд үлдээгүй гэж бодсон юмсан.

- Үлдээгүй гэж Гермиона батлаад улайснаа,

- Дамблдор тэднийг бүгдийг нь холдуулсан ч ... устаагүй гэв. Рон цэхлэн сууж нүдээ бүлтийлгэн ширтэв.

- Мерлиний өмдийг барин асуухад чи крестражын тухай номыг гартаа оруулсан юм биш биз?

- Энэ ... энэ бол хулгай биш! гэж Гермиона дуу алдаад Харри, Рон хоёр руу цөхрөн харж,

- Дамблдор тэднийг тавиураас буулгасан ч тэд урьдын адил номын санд байсан. Ямар ч гэсэн тэр үнэхээр хэн нэгэнд өгөхийг хүсээгүй ...

- Тодорхой хэл! гэж Рон дуу алдав.

- Ер нь бол ... энэ амархан байсан л даа. Ердийн Татдаг шид. Та нар Акцио гэдгийг нь мэднэ биз дээ. Тэгээд л ... тэд Дамблдорын өрөөний цонхоор нисэн гарч охидын унтлагын өрөөнд газардсан.

- Чи үүнийг хэзээ хийсэн юм? гээд Харри Гермиона руу гайхах үл итгэх зэрэгцэн харлаа.

- Оршуулгын дараа ... Дамблдорын. Бид сургуулиас явж крестражыг хайхаар тохиролцсон байсан. Би дээшээ гарч юмаа цуглуулахдаа ... гэнэтхэн толгойд тэдний талаар мэдвэл амар байх болов уу гэсэн санаа орж ирсэн юм... би тэнд ганцаар байсан ... тэгээд оролдож үзсэн чинь ... бүтсэн. Тэднийг онгорхой

цонхор нисэн орж ирэхэд нь ... чемдоандаа хийсэн гээд шүлсээ залгиснаа гуйсан хоолойгоор,

- Би Дамблдорыг надад уурлах байсан гэж бодохгүй байна. Бид үүнийг ашиглан крестражыг хэрхэн бүтээх тухай мэдээлэл авч болно биз дээ? гэв.

- Чи биднийг үүнд чинь гомдоллоно гэж бодоо юу? Тэр номууд хаана байна?

гэж Рон асуулаа.

Гермиона овоолго онгичон хар арьсан хавтастай боть гаргаж ирснээ ямар нэг үхсэн амьтан барьж байгаа аятай зэвүүцэн барилаа.

- Энд крестражыг хэрхэн бүтээх тухай тодорхой заавар байсан. «Хар урлагийн нууцууд» ... аймшигтай ном, маш аймшигтай ёрын шидээр дүүрэн! Сонирхолтой нь Дамблдор тэднийг номын сангаас хэзээ зайлуулсан юм бол?

... Захирал болсныхоо дараа гэж мөрийцсөн ч бэлхэн байна. Волдеморт шаардлагатай бүх зүйлээ уншсан байх.

- Тэгвэл тэр крестражыг яаж бүтээхийг мэдэж байсан юм бол Слизнортоос яах гэж асуусан юм? гэж Рон асуув.

- Тэр Слизнортод зөвхөн хүн сүнсээ долоон хэсэг болон хуваах аргыг мэдэх гэж хандсан. Дамблдор Реддлийг Слизнортоос асуух үедээ крестраж хэрхэн бэлтгэх аргыг мэддэг байсан гэдэгт итгэлтэй байсан. Чиний зөв гэж бодож байна, Гермиона тэр үүнээс хялбархан мэдээлэл авч чадах байж гэж Харри хэлэв.

- Би тэднээс олон зүйл уншаад түүнийг үнэхээр зургаан крестраж бэлтгэсэн гэдэг нь үнэхээр аймшигтай санагдсан. Номонд сүнсээ хуваах гэдэг маш тогтворгүй зөвхөн ганц крестражын хувьд ч гэсэн байсан.

- Үүнийг ямар нэг аргаар буцаан цуглуулж болох уу? гэж Рон сонирхов.

- Бий гэж Гермина хөндий инээмсэглэн хэлээд,

- Гэхдээ тэсэхийн аргагүй өвдөж шаналах болно гэв.

- Яагаад? Үүнийг хийхэд юу хэрэгтэй юм? гэж Харри асуулаа.

- Гэмшил. Чи үүнийг жинхэнээсээ мэдрэх ёстой. Үүнд л тайлбар нь байгаа юм.

Харваас гэмшсэн шаналал хүнийг устгах хүчтэй бололтой. Гэхдээ би Волдемортыг тийм оролдого хийсэн гэж бодохгүй байна. Харин чи юу гэж бодож байна?

- Үгүй гэж Рон Харрийн дуугарахаас урьд хэлээд,

- Энэ номд крестражыг яаж устгах тухай байсан уу? гэлээ.

- Тиймээ гээд Гермиона хуудсыг амьтны ялзарсан гэдэс дотор мэт хүрч ядан эргүүлэв.

- Номонд крестражыг хамгаалах шид маш хүчирхэг байх ёстой гэж анхааруулсан байсан. Миний уншсанаар бол Харри Реддлын өдрийн тэмдэглэлийг цөөхөн найдвартай аргын нэгээр устгасан байсан.

- Чи Василискийн соёоны тухай ярьж байна уу? гэж Харри асуулаа.

- Өө, тэгэхэд бидэнд аз тааraад соёо олдож. Би түүгээр юу хийж болохыг тааварласан юмаа гэж Рон хэлэв.

- Үүнд заавал Василискийн соёог ашиглах албагүй гэж Гермиона тэвчээртэй тайлбарлаад,

- Зөвхөн крестражыг ахин босч ирж чадахгүй болтол нь сөнөөх зүйл байх ёстой. Василискийн хорноос авардаг цорын ганц маш ховор зүйл ... гэв.

- Галт шувууны нулимс гэж Харри толгой дохив.

- Яг тийм. Бидний асуудал гэвэл Василискийн хор шиг устгах чадвартай хэдхэн зүйл байдаг ч тэд зөөж явахад хэтэрхий аюултай. Энэ асуудлыг ямар нэг аргаар шийдэх хэрэгтэй учир нь крестражыг эвдэлж, сүйтгэх юмуу бяцлах нь боломжгүй. Түүнийг ахин босч ирэхээргүй болтол нь хийх хэрэгтэй.

- За яахав гэж Рон хэлснээ,

- Бид түүнийг эвдэлсэн ч сүнсний хэсэг амьд үлдэх юм байна. Гэхдээ тэр яагаад өөр нэг тийшээ шилжиж болдоггүй юм бэ? гэв.

- Яагаад гэвэл крестраж хүний амьдралын эсрэг зүйл юм гээд Гермиона Харри, Рон хоёрыг будилж гүйцэхийг хараад яаран,

- Хараач Рон хэрвээ би одоо илд аваад чамайг нэвт хатгавал чиний сүнсэнд ямар ч гэмтэл учрахгүй гэв.

- Энэ чинь намайг үнэхээр тайвшируулж байна гэж Рон хэлэхэд Харри инээд алдав.

- Үнэн хэрэгтээ бол тийм! Гэхдээ би өөр зүйлийн тухай ярьж байна чиний биед юу тохиолдсон ч гэсэн сүнсэнд хамааралгүй бөгөөд амьд үлдэнэ. Харин крестраж бол эсрэгээрээ. Сүнсний хэсгийг агуулж байгаа зүйлээс илбэдсэн бие хамааралтай байдаг. Тэр энэ хэсэггүйгээр амьдрах боломжгүй.

- Өдрийн тэмдэглэл намайг нэвт хатгах үед үхсэн гээд Харри цоорсон хуудаснаас бэх шиг цус асгарсныг саналаа.

- Чамайг дэвтрийг устгах үед дотор нь хориотой байсан сүнсний хэсэг амьдрах боломжгүй болсон. Жинни өмнө нь дэвтрээс салахыг оролдож урж жорлонгийн усанд шидсэн ч дараа нь эргээд шинэ юм шиг болсон байсан гэсэн.

- Хүлээгээрэй. Сүнсний дэвтэрт байсан хэсэг Жинниг эзэмдэж байсан биз дээ?

Энэ яаж болсон юм бол? гэж Рон хөмсөг зангидан хэлэв.

- Шидийн агуулж буй зүйл бүтэн үед дотор нь нуугдаастай сүнсний хэсэг крестражад хэн нэгэн хэтэрхий ойрхон ирэхэд гарч чадна. Би крестражыг гартаа барьж байсан тухай яриагүй байна гэж Гермиона Роныг амаа нээхээс өмнө нэмэрлээд,

- Хүрэлт үүнтэй ямар ч холбоогүй. Би сэтгэлийн хөдөлгөөнтэй холбоотой зүйлийн тухай ярьж байна. Жинни дэвтэртэй сэтгэл зүрхээрээ холбоотой байж өөртөө хэтэрхий эмзэг ханддаг байсан. Ингэхээр крестражад хэтэрхий татагдах юмуу хамааралтай болвол таагүй явдал болдог байна.

- Дамблдор бөгжийг яаж устгасан юм бол? Би яагаад түүнээс асуусангүй вэ? Би хэзээ ч жинхэнээсээ ... гээд Харрийн хоолой сааралтав.

Тэр Дамблдороос асуух байсан бүх зүйлийнхээ тухай бодсон ч захирал нь үхсэн болохоор хичнээн их зүйл мэдэх боломжоо алдсан юм шиг санагдав ... бүгдийг мэдэх юмсан.

Нам гүмийг эвдэн хаалга саван онгойход өрөөний хана чичигнэлээ. Гермиона хашгираад «Хар урлагийн нууцууд» номоо шалан дээр унагаж, Живоглот орон доогуур харайн ороод ууртай хүржигнэхэд, Рон орноос үсрэн босохдоо шоколадан мэлхийн цаасанд хальтарч толгойгоороо хана мөргөчихлөө. Харрийн гар өөрийн мэдэлгүй шидэт саваа руугаа явсан ч ердөө хатагтай Уизли сэгсийсэн үс уурандаа таталдсан царайтай зогсож байв.

- Та нарын таатай яриаг тасалдуулсан явдалд их харамсалтай байна. Би та нарт амралт хэрэгтэй гэдэгт эргэлзээгүй ч ... Гэхдээ миний өрөөнд хуримын бэлэг овоороод учрыг даруй олох хэрэгтэй байгаа болохоор та нарын туслана гэсэн амлалтыг саналаа.

- Өө, тэгэлгүй яахав гээд Гермиона айсан шинжтэй үсрэн босоход шалан дээр ном асгарлаа,

- Бид одоохон ... уучлаарай ...

Тэр Рон, Харри хоёр руу зовсон шинжтэй харснаа хатагтай Уизлиг дагалдан өрөөнөөс яаран гарлаа.

- Гэрийн үйлчлэгч шиг л амьдарч байна гэж Рон аяархан гомдолсноо толгойгоо илсээр Харрийн хамт эхийнхээ өрөө рүү зүглэв. Ямар ч сэтгэл ханамжгүй ажил. Энэ хурим түрэн дуусвал би аз жаргалтай байх юмсан.

- Тийм шүү, үүний дараа бидэнд ердөө крестражуудыг хайх ажил үлдэнэ. Энэ чинь амралт гэсэн үг биз дээ?

Рон инээсэн ч хатагтай Уизлийн өрөөнд хүлээж байгаа овоолоостой бэлгийг хармагц инээмсэглэл нь гараар арчсан юм шиг алга болов.

Делакурынхан маргааш өглөө нь арван нэгэн цагаас ирэв. Харри, Рон, Гермиона, Жинни нар Флерийн гэр бүлийнхэн ирэх гэж буй явдалд таагүйхэн хандан Рон ижилхэн өнгөтэй оймс өмсөхөөр шатаар өгссөн бол, Харри үсээ илэн толигор болгохыг оролдлоо. Тэдний гадаад үзэмж хангалттай гэж бодох үед гадаа нарны гэрэлтэй хашаанд зочдыг угтахаар гарав.

Харри хашаа ийм цэмцгэр байхыг хэзээ ч харж байсангүй. Довжооны хажууд байнга тавиастай байдаг дүүрэн усны гуталтай зэвэрсэн тогоо алга болж оронд нь хаалганы хоёр талд том савтай бут тавьжээ. Салхигүй байсан ч бутын мөчир залхуутайхан сэрчигнэнэ. Хашааг шүүрдэн, тахианууды тугжиж, цэцэрлэгийн бутны оройг тайрсан нь Харрид таалагдсан ч анахайнуудын эзгүйд нэг л хөндий хоосон юм шиг харагдаж байлаа.

Харри эртнээс Үүрийг хамгаалсан ид шидийн яам болон бүлгийн шидийн тоог алдсан болохоор хэн ч шидийн тусламжтай энэ газар ирж чадахгүйг мэдэж байв. Ийм учраас ноён Уизли Делакурынхныг угтахаар зөөвөрлөгчөөр ирэх ёстой ойролцоох толгод руу явжээ. Тэдний ойртож буйн эхний шинж гэвэл ер бусын өндөр цангинасан инээд байсан бөгөөд ноён Уизли хаалгаар ачаа тээш барин орж ирэхдээ урт ногоон жанчтай үзэсгэлэнтэй цонхигор эмэгтэй дагуулсан нь Флерийн эх болж таарлаа.

- Ээж! Аав! гэж Флер дуу алдаад тэврэхээр ухасхийв.

Ноён Делакур эхнэр шигээ аятайхан хэдий ч арай намхан агаад жижигхэн шөвгөр хар сахалтай байлаа. Гэвч сайхан сэтгэлтэй харагдана. Тэр хатагтай Уизлийн зүг өндөр өсгийтэй гутлаараа харайн очоод хацрыг нь хоёр удаа үнсэхэд улайлаа.

- Бид та нарт их төвөг удлаа. Фл`р та нарыг маш их `жиллаж байгаа гэсэн.

- Өө, юутай дэмий үг вэ! Ямар ч асуудалгүй! гэж хатагтай Уизли инээмсэглэв. Рон савтай бутны нэгээс цухуйсан анахайг өшиглөлөө.

- Хонгор хатагтай! гэж ноён Делакур хатагтай Уизлийн гарыг алгаараа хавчин баяртай инээмсэглэн хэлээд,

- М`най хоёр гэр бүлийн хоорондын холбоог маш их хүндэтгэл гэж бодож байна! Таньд `хнэр Апполинаа т`нилцуулахыг зөвшөөрнө үү гэв.

Хатагтай Делакур урагш алхан хатагтай Уизлиг үнсэхийн тулд бөхийлөө.

- Их таатай байна. Танай ‘өхөр бидэнд маш хөгжилтэй түүх ярьсан!

Ноён Уизли галзуу хүн шиг хөхөрснөө хатагтай Уизлийн харцанд ширвүүлэн чимээгүй болоод хэвтэрт байгаа найзаа эргэхээр ирсэн хүний төрхтэй болов.

- Энэ манай бага `хин Габ`гиэл та нар мэдээж таних байх! гэж ноён Делакур хэлэв.

Габриэль Флерийн арван нэгэн настай үеийг санагдуулам жижигхэн агаад бүсэлхий хүрсэн урт мөнгөлөг үстэй байлаа. Тэр хатагтай Уизли руу нүд гялбам инээмсэглэн тэврээд дараа нь сормуусаа анивчин Харри руу гийн харлаа. Жинни чанга ханиалгав.

- За орцгооно уу, орцгооно уу! гээд хатагтай Уизли Делакурынхыг гэр лүү оруулах зуураа олонтоо «Үгүй дээ, танаас гуйя!», «Таны дараа!» гэлээ.

Удалгүй Делакурынхан ихэд еелдэг хүмүүс гэдэг нь илт болоход гэрийн эзэгтэйд дурын тусламж үзүүлэхэд бэлэн байлаа. Тэд бүгд хуримын бэлтгэл ажилд баяртай оролцов. Ноён Делакур зочдын суудлын төлөвлөгөөг чангаар уншаад тааламжтай байна гэлээ. Хатагтай Делакур гэрийн эзэгтэйн шидийг эзэмшсэн болохоор агшин зуур зуух цэвэрлэж, Габриэль эгчийнхээ араас хаа сайгүй дагалдан туслахыг хичээнгээ франц хэлээр дуржигнуулж байлаа.

Үүрний дутагдалтай тал гэвэл олон хүн байрлуулах зай багатайд байв. Ноён ба хатагтай Уизли одоо зочны өрөөндөө унтах болсон бөгөөд ноён ба хатагтай

Делакурын эсэргүүцлийг үл харгалзан унтлагын өрөөгөө тавьж өгсөн байна. Габриэль, Флер хоёр шөнийг Персигийн хуучинд өрөөнд өнгөрүүлж харин Билл өөрийнхийгөө Румынаас ирсэн Чарлитай хуваалцлаа. Харри, Рон, Гермиона гуравт ямар нэг төлөвлөгөө ярилцах цаг үлдсэнгүйд цөхөрсөндөө олон хүнтэй байшингаас зугтаахаар тахиа тэжээхээр гарлаа.

- Тэр биднийг тайван орхихгүй нь! гэж Рон хатагтай Уизли тэдний хоёр дахь уулзалтыг таслан зогсоохоор хашаанд цагаан хэрэгслэлийн сагс барьсаар гарч ирэхэд уцаарлав.

- Аан, сайн байна тахиагаа тэжээчихсэн үү гэж тэр ойртон ирээд хэллээ.

- Та нар сайн хаасан нь дээр байх маргааш ажилчид ирэх болохоор ... хуримын асар барихын тулд гэж тайлбарлаад тахианы байр луу шагайхаар зогсов. Тэр эцэж ядарсан харагдаж байлаа.

- Милламантын шидийн асар ... тэр хамгийн сайн нь. Билл ажилчдыг дагалдах болно ... Харри чи тэднийг энд ирэх үед гэрээс гарахгүй байсан нь дээр шүү. Гэрийн эргэн тойронд шидийн хамгаалалттай байхад хурим зохион байгуулах нь их хэцүү юм.

- Надад их харамсалтай байна гэж Харри хэлэв.

- Өө, тэнэг юм ярих хэрэггүй дээ хонгор минь! Би тэгж хэлэх гээгүй ... чиний аюулгүй байдал хамгаас чухал! Үнэндээ би чамайг төрсөн өдрөө яаж тэмдэглэн өнгөрүүлэхийг хүсэж байгааг асуух гэсэн юм. Арван долоон нас гэдэг бол их чухал өдөр шүү ...

- Би ямар ч чимээ шуугиангүй өнгөрөөхийг хүсч байна гэж Харри түргэн хэлээд бүгдэд нэмэлт ажил удахыг мэдэж байсан тул,

- Үгүй, үнэн шүү хатагтай Уизли ердийн хоол байхад болно. Хуримын өмнөх өдөр болохоор ... гэв.

- Өө, хэрвээ чи тэгж бодож байгаа бол, хонгор минь. Би Римус болон Тонксыг урья за юу? Бас Хагридыг урьвал ямар вэ?

- Энэ гайхамшигтай хэрэг. Зөвхөн танаас гуйхад өөртөө битгий төвөг удаарай.

- Юу гэж дээ юуных нь төвөг байхав ... ямар ч асуудалгүй ...

Хатагтай Уизли түүн рүү удтал харснаа инээмсэглээд яльгүй гашуудалтай хашаа руу явлаа. Харри түүнийг угаасан юм өлгөдөг хэц рүү саваагаа даллахад чийгтэй хувцаснууд сагснаас агаарт хөөрөн өлгөгдөхийг хартал гэнэтхэн сэтгэл нь харуусан шаналахыг мэдэрлээ.

БҮЛЭГ 7: АЛЬБУС ДАМБЛДОРЫН ГЭРЭЭСЛЭЛ

Тэр уулын замаар өглөөний хүйтэн агаарт явж байлаа. Алсад манан дунд жижигхэн хот үзэгдэв. Тэнд амьдардаг хүнийг эрж байгаа юм болов уу? Хүн түүнд их хэрэгтэй байсан болохоор зөвхөн түүний тухай, асуудлыг нь шийдвэрлэх тухай бодож байлаа

...

- Хөөе сэрээрэй.

Харри нүдээ нээлээ. Тэр ахин Роны бүдэг гэрэлтэй өрөөнд эвхдэг орон дээр хэвтэж байв. Гахай жижигхэн далавчин дороо толгойгоо шургуулан унтана. Харрийн сорви хатгуулан өвдлөө.

- Чи зүүдэндээ бувтнаад байсан.

- Үнэн үү?

- Аанхан. Грегорович. Чи цаг үргэлж Грегорович гээд давтаад байсан.

Харри нүдний шилээ зүүгээгүй байсан тул Роны царай бүүдгэртэн үзэгдэв.

- Грегорович гэж хэн бэ?

- Би хаанаас мэдэх юм. Чи л түүний нэрийг хэлсэн биз дээ.

Харри духаа үрэн бодлогоширов. Түүнд энэ нэрийг хаа нэгтээ сонссон юм шиг санагдсан ч хаана гэдгээ санаж чадсангүй.

- Би Волдеморт түүнийг эрж байгаа гэж бодож байна.

- Хөөрхий амьтан гэж Рон хэлэв.

Харри суугаад сорвио илсээр бүрэн сэргээгүй л байв. Тэр зүүдээ тодорхой санахыг хичээсэн ч ой ухаанд нь зөвхөн тэнгэрийн хаяан дахь уудам хөндийд жижигхэн хот сүүмэлзэн үзэгдэж байсан тухай бүдэг бадаг орж ирэв.

- Би түүнийг хилийн чанадад байна гэж бодож байна.

- Хэн? Грегорович уу?

- Волдеморт. Тэр хилийн цаана Грегоровичийг эрж байна гэж бодож байна.

Англид үүнтэй адил газар байдаггүй юм.

- Чи ахин түүний ухаанд нэвтэрсэн гэж бодож байна уу? хэмээн Рон сэтгэл түгшин хэллээ.

- Эелдэг байж энэ тухай Гермионад бүү хэлээрэй. Тэр намайг ийм зүйл харахыг зогсоохыг хүсэж байгаа болохоор ...

Тэр Гахайн жижиг тор руу хараад хаанаас энэ «Грегорович» гэдэг нэрийг мэдэх болохоо санахыг хичээв.

- Минийхээр бол тэр квиддичтэй ямар нэг хамааралтай байх. Тэдний дунд нэг холбоо байгаа ч санаж чаддаггүй гэж Харри удаанаар хэлэв.

- Квиддичтэй гэнээ? Чи Горгорович биш гэдэгт итгэлтэй байна уу?

- Хэн юм?

- Драгормир Горгович ангууч хоёр жилийн өмнөөс «Педдлийн их буу»-нууд багт тоглож эхэлсэн юм юм. Квоффл барьсан тоогоороо улирлын дээд амжилт тогтоосон.

- Үгүй. Би Горговичийн тухай лав бодоогүй.

- Би ч гэсэн энэ тухай бодохгүй байхыг хичээж байна. Ямар ч гэсэн чиний төрсөн өдөр шүү дээ.

- Чөтгөр гэж би мартчихаж! Би арван долоо хүрч байгаа юм байна!

Харри дэргэдээ байсан сабааг аваад замбараагүй хөглөрсөн ширээ рүү чиглүүлэн

«Акцио, нүдний шил!» гэлээ. Хэдийгээр тэдний дунд ердөө метр хүрэхгүй зай байсан ч түүнийг агаарт хэрхэн нисэхийг харахад таатай байлаа. Тэгтэл нүдний шил Харрийн нүд рүү арай хатгачихсангүй.

- Сайн ажил боллоо гэж Рон тургилав.

Хяналтын шидээс зугтсанаа тэмдэглэхээр Харри Роны эд зүйлсийг өрөөн дундуур нисгэхэд Гахай сэрээд хөөрөн далавчаа дэвлээ. Тэр кэтнийхээ үдээсийг шидээр үдэхийг оролдож (үр дүнд нь хэдэн минутын турш зангилааг нь гараар тайлах хэрэг гарчээ) түүнчлэн баяртайгаар Роны өрөөний ханан дээрх «Педдлийн их буунууд» багийн шаргал өнгөтэй зурагт хуудсыг цэнхэр болгон хувиргалаа.

- Би чиний оронд байсан бол цамцаа товчлох байсан даа гэж Рон түүнд зөвлөөд

Харри хэрхэн яаран шалгахыг хараад инээд алдлаа.

- Энэ чиний бэлэг. Ээжийн нүднээс холхон энд задлаарай.

- Ном уу? гээд Харри дөрвөлжин булантай хуйлаасыг авлаа. Уламжлалаас хазайсан юм шиг санагдахгүй байна уу?

- Энэ бол энгийн ном биш. Цэвэр алт гэсэн үг. «Эмэгтэй хүний сэтгэлийг булаах арван хоёр найдвартай арга». Чи эндээс охидын тухай бүгдийг мэдэх болно. Би өнгөрсөн жил үүний тусламжтайгаар Лавандагаас яаж зугтахаа мэдсэн юм ... Ер нь бол Фред, Жорж хоёр надад энэ номыг өгөөд олон зүйл сурсан. Чи тэнд зөвхөн саваагаар ажилладаггүй гэдгийг хараад гайхах болно.

Тэд гал зуух руу уруудахад ширээн дээр Харрийн бэлэг овоолоостой хүлээж байлаа. Билл, ноён Делакур хоёр өглөөний цайгаа ууж дуусган, хатагтай Уизли хайруулын тавагт юм шарангаа тэдэнтэй ярилцаж байлаа.

- Артур чамд арван долоон насны баярын мэнд хүргэхийг гуйсан, Харри. Тэр ажил руугаа эрт явах хэрэг гарсан болохоор оройн хоол хүртэл эргэж ирэхгүй. Манай бэлэг энэ байна хамгийн дээр нь гэж тэр инээмсэглэн хэллээ.

Харри суугаад түүний заасан дөрвөлжин хуйлаасыг авч нээлээ. Дотор нь ноён ба хатагтай Уизлийн Роны арван долоон насны өдрөөр өгсөнтэй тун адилхан тооны оронд эргэлддэг ододтой алтан цаг байлаа.

- Уламжлал ёсоор шидтэнг насанд хүрэхэд цаг бэлэглэдэг юм гэж хатагтай

Уизли зуухны хажуугаас сэтгэл зовнин хэлээд,

- Гэхдээ Роных шиг шинэ биш л дээ энэ миний ах Фабианаас уламжлагдан ирсэн юм. Харин тэр эд зүйлдээ тийм нямбай биш болохоор ар тал нь жаахан хонхойсон ... гэв.

Хатагтай Уизлийн үгийн төгсгөлийг хэн ч сонссонгүй яагаад гэвэл Харри түүнийг тэврэхээр үсрэн бослоо. Тэр түүнд хэзээ ч хэлж байгаагүй зүйлээрээ тэврэлтээрээ илэрхийлэхийг хичээсэнд ойлгосон бололтой учир нь Харрийн гар тавигдах үед эв хавгүйхэн хацрыг нь илснээ саваагаа даллан хайруулын тавагт байсан гахайн утсан махны хагасыг шалаар нэг тараачихлаа.

- Төрсөн өдрийн мэнд, Харри! гээд Гермиона гал зуухан дундуур яаран ирж бэлгээ хамгийн дээр нь тавилаа.

- Тийм том бэлэг биш л дээ гэхдээ чамд таалагдана гэж найдаж байна. Харин чи түүнд юу бэлэглэсэн бэ? гэж Роноос асуухад асуултыг нь сонссонгүй бололтой,

- Алив Гермионагийнхийг задлаарай! гэж хэлэв.

Гермиона түүнд шинэ вредноскоп бэлэглэжээ. Бусад хуйлааст Билл, Флер хоёрын бэлэглэсэн шидэт сахлын хутга (Өө тийм л дээ ямар ч сахалгүй юм шиг толигор болгоно. Гэхдээ юу хэрэгтэйгээ тодорхой хэлэхгүй бол ямар ч үс үлдэхгүй байх шүү гэж ноён Делакур хэлэв), Делакурынхны шоколад, Фред Жорж хоёрын «Уизлийн бүх төрлийн шидэт эдлэл» дэлгүүрээс явуулсан том хайрцагтай бэлэг байлаа.

Харри, Рон, Гермиона гурав гал зууханд удаан саатсангүй хатагтай Делакур, Флер, Габриэль нар нар ирсэн тул давчуу тухгүй байлаа.

- Би бүгдийг нь авчихъя гэж Гермиона хөгжилтэй хэлээд Харрийн бэлгийг авч шатаар хамт өгсөв.

- Би бараг бүх зүйлээ баглаж дууссан ч угаалганаас Роны дотуур хувцас ирэхийг хүлээж байгаа ...

Роны ууртай дууг даран хоёр давхарын хаалга чахран онгойлоо.

- Харри чи нашаа түр ороод ирж чадах уу?

Энэ бол Жинни байлаа. Рон огцом зогсоход Гермиона түүний тохойноос бариад дээшээ чирлээ. Харри бухимдангуй Жиннигийн өрөө рүү орлоо.

Тэр хэзээ ч энэ жижигхэн гэгээлэг өрөөнд орж байсангүй.

Нэг талын ханан дээр «Эмгэн шулмас» хамтлагийн том зурагт хуудас өөр нэг дээр нь

«Холхедский Гарпий» эмэгтэйчүүдийн квиддичийн багийн ахмад Гвеног Жонсын зураг наажээ. Онгорхой цонхны дэргэд бичгийн ширээ байсан бөгөөд тэдний Рон,

Гермиона хоёрын эсрэг хамтдаа квиддич тоглож байсан жимсний цэцэрлэг рүү ханджээ. Тэнд одоо том сувдан цагаан асар босож алтлаг дарцаг нь Жиннигийн цонхоор цухуйна.

Тэр Харрийн царай руу харснаа гүн амьсгал авааД,

- Арван долоон нас хүрсний баяр хүргэе гэв.

- Аан ... баярлалаа.

Жинни түүнийг үргэлжлүүлэн ширтэхэд хурц гэрэлд гялбаж байгаа мэт урдаас нь харахад хэцүү байлаа.

- Сайхан харагдаж байна гэж тэр сулхан бувтнаад цонх руу заав. Үүнд Жинни хариулсангүй. Түүнийг буруутгах шалтаг ч байсангүй.

- Би чамд юу бэлэглэхээ бодож чадсангүй.

- Чи заавал ингэх хэрэггүй ... Тэр үүнийг ч бас хэрэгссэнгүй.

- Юу ашигтай байж болохыг мэдээгүй юм. Тийм ч том биш чи өөртэйгээ цуг авааД явж болохоор.

Харри түүн рүү харахаар шийдлээ. Жиннигийн нүдэнд нулимс байсангүй. Түүний олон гайхамшигтай чанарын нэг нь ховорхон уйлдаг юм. Харри заримдаа үүнийг ах нараасаа өвлөн авсан байх гэж боддог байлаа.

Жинни түүн рүү алхам ойртов.

- Тэгээд чамд намайг санагдуулж байх зүйл өгөх хэрэгтэй гэж бодлоо. Чи гэнэтхэн ажлаа хийж яваад ямар нэг вейлатай учирах ч юм билүү.

- Үнэнийг хэлэхэд надад охинтой уулзах боломж туйлын бага.

- Зөвхөн энэ найдлага намайг тайвшируулж байна гэж тэр шивнээд урьд хэзээ ч байгаагүйгээр үнссэнд Харри хариу үнсэж ямар ч галт шарзын өгч чадахгүй цэнгэлийг мэдэрлээ. Жинни түүнд жинхэнэ мэдрэмж төрүүлэхэд нэг гараараа нуруугаар нь тэврээд нөгөө гараараа урт анхилуун үнэртэй үсийг нь ... Тэдний ард хаалга нээгдэхэд бие биенээсээ үсрэн холдлоо.

- Өө, өршөөгөөрэй гэж Рон ёжтой хэлэв.

- Рон! гэж түүний ард ялимгүй амьсгаадсан Гермиона дуудлаа. Тэднийг чимээгүй болоход Жинни өнгөгүй хоолойгоор,

- За, төрсөн өдрийн мэнд хүргэе, Харри гэв.

Роны чих улайхад, Гермиона бухимдлаа. Харри тэдний хамрын урд хаалга хаахыг хүссэн авч хаалганы онгойхтой зэрэгцэн өрөөнд хүйтэн болж гайхамшигтай мөч савангийн хөөс адил замхрав. Роныг өрөөнд байхад тэр Жиннигээс холбоогоо таслах гэсэн бүх шалтгаан эргэн ирж холхон байхыг хүсэн бүх аз жаргал нь сарнин алга болов.

Тэр үг хэлэхийг хүссэн ч юу хэлэхээ мэдсэнгүй тул Жинни руу харахад цаашаа эргэлээ. Харри түүнийг эцэст нь уйлж байна гэж бодсон ч Роны нүдэн дээр тайвшируулж чадсангүй.

- За дараа уулзая гээд найзуудыгаа дагалдан Жиннигийн унтлагын өрөөнөөс гарлаа.

Рон шатаар доош уруудан дүүрэн хүнтэй гал зуухыг өнгөрөөд хашаанд гарлаа. Харри түүнээс хоцорсонгүйд айсан Гермиона бас дагав.

Шинэхэн хадсан зүлгэн дээр хүрээд Рон Харри руу огцом эргэлээ.

- Чи түүнийг хаясан! Харин одоо тархийг нь эргүүлж байгаа хэрэг үү?

- Би түүний тархийг эргүүлээгүй гэж Харри Гермиона түүнийг гүйцэхэд хэлэв.

- Рон ...

Гэвч Рон гараа даллан түүнийг чимээгүй болгов.

- Тэр чамайг хаях үед хэсэг болон сүйрсэн ...

- Би ч гэсэн. Гэхдээ чи намайг яагаад тэгснийг мэдэж байгаа ... энэ бүхнийг хүсээгүй гэдгийг.

- Тиймээ тэгвэл одоо түүнтэй үнсэлдэн ахиад найдлага төрүүлэх гээ юу.

- Жинни тэнэг биш тэр үүнийг боломжгүй гэдгийг мэдэж байгаа хүлээх хэрэггүй гэрлэх боломжгүй гэдгийг ...

Тэр энэ үгийг хэлмэгц толгойд нь Жинни цагаан даашинз өмсөж өндөр нүүргүй үл таних хүнтэй гэрлэж байгаа таагүй дүр зураг төсөөлөгдөв.

Толгой эргэм нэг мөчид тэр бүх ирээдгүй нь саад тотгоргүй болж ... түүний урд ердөө ганц Волдеморт байгааг ойлголоо.

- Чи түүнд аятай мөчид наалдах гэж байна ...

- Ийм явдал давтагдахгүй гэж Харри огцом хэлэхэд хэдийгээр үүлгүй өдөр байсан ч гэлээ наргүй болох шиг санагдав.

- Чиний сэтгэлд энэ таарч байна уу?

Рон унтууцаж ичингүйрсэн харагдсанаа хойш урагш хойш найган,

- За тэгвэл яахав ер нь бол түүнийг ... тийм л дээ гэв.

Ингээд Харри өдрийн турш Жиннитэй ганцаар үлдэх арга хайсангүй бөгөөд тэд хоорондоо эелдэгээр ярилцаж байлаа. Тэгтэл Чарли ирж Харрийн санааг амраалаа. Хатагтай Уизли Чарлиг сандалд суулгаад үсийг нь тайрна гэж шидэт саваагаа сүрдүүлэн зангасан бөгөөд энэ нь их хөгжилтэй байлаа.

Харрийн төрсөн өдрийн оройн зоог дээр Чарли, Люпин, Тонкс, Хагрид нар байлцах учир Үүрний гал зууханд багталгүй гадаа цэцэрлэгт хэдэн ширээ нэмж заслаа. Фред, Жорж хоёр агаарт зочдын дээгүүр «17» гэсэн тоогоор чимэглэсэн олон тооны улаан

дэнлүү хөөргөв. Хатагтай Уизлийн сувилгааны ачаар Жоржын шарх эдгэрч цэвэрхэн болсон ч Харри урьд нь чих байсан харанхуй нүхэнд дасаж чадсангүй. Гэвч ихрүүд үүнийг үл харгалзан тоглоом хийх аж.

Гермиона сабааныхаа үзүүрээс алтлаг улаан тууз гаргаад мод бутанд өлгөн чимэглэв.

- Аятайхан болж гэж Рон Гермиона сүүлийн удаа саваагаа занган бутанд тууз өлгөхөд хэлээд,

- Чамд ийм зүйлд үнэхээр авъяас байна гэв.

- Баярлалаа, Рон! гээд Гермиона ичингүйрэн харахад Харри хариу инээмсэглэв.

Харри Жиннигийн харцтай тулгармагц инээмсэглэснээ Ронд өгсөн амлалтаа санамагц яаран ноён Делакуртай ярилаа.

- Зам тавиарай, зам тавиарай! гэх хатагтай Уизлийн дуу гараад урдаа хийлсэн бөмбөгийн хэмжээтэй снитч хөөргөн ирэв. Секунтын дараа Харри энэ нь баярын бялуу бөгөөд хатагтай Уизли овон товонтой газар унагах эрсдэл гаргахгүйн тулд шидэт саваагаараа залан яваа болохыг ойлгов. Бялууг ширээн дээр газардмагц Харри,

- Гайхамшигтай харагдаж байна, хатагтай Уизли гэв.

- Өө, зүгээр дээ хонгор минь гэж тэр эелдэгхэнээр хэлэхэд Рон мөрөн дээгүүр нь хоёр хуруугаа гозойлгон сайн байна гэж хэллээ.

Долоон цагаас бараг бүх зочид цугларахад Фред, Жорж хоёр цэцэрлэг рүү хөтлөн гаргаж байв. Хагрид энэ явдлыг тохиолдуулан аймшигтай хүрэн өнгийн үсэрхэг костюмаа өмсчээ. Люпин гар бариад инээмсэглэсэн ч Харрид золгүй харагдаж байгаа юм шиг санагдав. Хачирхалтай нь гэвэл Тонкс түүнтэй цуг ирсэн хэр нь баясан гийж байв.

- Төрсөн өдрийн мэнд, Харри гээд Тонкс түүнийг чанга тэвэрлээ.

- Арван долоо энэ чинь л хэрэгтэй байгаа юм! гээд Хагрид Фредийн өгсөн хувингийн хэмжээтэй дарсны аягыг аваад,

- Зургаан жилийн өмнө бид анх уулзаж билээ, Харри. Тэр өдрийг санаж байна уу? гэв.

- Бараг л гээд Харри аварга биет рүү инээмсэглэлээ.

- Чи тэгэхэд үүдний хаалга эвдэж, Дадлиг гахайн сүүлтэй болгоод, намайг шидтэн гэдгийг мэдэгдсэн биз дээ?

- Нарийн үйл явдлыг нь мартчихаж. За Рон, Гермиона хоёроор юу байна даа?

- Маш сайн. Харин танаар юу байна? гэж Гермиона хэлэв.

- Муугүй дээ. Хэдэн ганц эвэрт унагалаад жаахан завгүй болсон. Би эргэж очихоор чинь үзүүлнэ гээд Хагрид халаасаа ухаж эхлэхэд Харри Рон, Гермиона хоёртой харц тулгарахгүй байхыг хичээв.

- Энэ байна, Харри. Чамд юу бэлэглэхээ мэдэхгүй байснаа дараа нь үүнийг саналаа.

Тэр жижигхэн үслэг хүзүүндээ зүүж болмоор урт оосортой хүүдий гаргалаа.

- Илжигний арьс. Дотор нь ямар нэг юм хийхэд эзнээсээ өөр хэнийг ч хүргэхгүй. Ховор эд байгаа юм.

- Баярлалаа, Хагрид!

- Зүгээр дээ гээд Хагрид хогийн савны хэмжээтэй гараа савчин,

- Хараач тэнд байна, Чарли! Хөөе, Чарли! гэлээ.

Чарли гараа даллан ойртон ирэхэд үс нь богиносож өрвийжээ. Тэр Роноос намхан агаад булчинлаг гартаа олон тооны түлэгдэж маажуулсан сорвитой байлаа.

- Сайн уу, Хагрид амьдрал ямар байна даа?

- Би бараг зуун жил чамд бичсэнгүй. Норберт хэр байна даа?

- Норберт гэнээ? Норвегийн луу юу? Түүний одоо Норберта гэдэг болсон хэмээн Чарли инээлээ.

- Хо! Тэр охин байсан юмуу?

- Өө, тэгэлгүй яахав.

- Тэднийг яаж ялгадаг юм? гэж Гермиона асуулаа.

- Тэд илүү хэрцгий байдаг юм гэж Чарли тайлбарлаад эргэж харснаа дуугаа намсган,

- Аав яарах хэрэгтэй болж дээ. Ээж бухимдаж эхлээд байна гэв.

Бүгд хатагтай Уизлийн зүг рүү харлаа. Тэр хатагтай Делакуртай яриа дэлгэх зуураа хаалга руу тасралтгүй хяламхийж харагдана.

- Артурыг хүлээлгүй эхэлсэн нь дээр гэж бодож байна гэж тэр хормын дараа хэлснээ хашаа руу эргээд,

- Тэр ахиад саатсан бололтой ... өө! гэв.

Бүгд түүн рүү зэрэг харахад судалтай гэрэл хашаанд нисэн орж ирээд ширээн дээр үентэй төстэй мөнгөлөг амьтан газардсанаа арын сарвуун дээрээ суугаад ноён Уизлийн хоолойгоор,

- Надтай ид шидийн яамны сайд ирж байна гэв.

Патронус агаарт уусан арилахад Флерийн гэр бүлийнхэн алга болсон газар луу нь гайхан харцгаав.

- Бидэнд энд хийх зүйл алга. Уучлаарай, Харри чамд дараа тайлбарлая ... гэж

Люпин даруйхан хэлэв.

Тэр Тонксын бүсэлхийгээр тэврээд хашаанаас гарч нүднээс далд оров. Хатагтай Уизли мэгдэж гүйцжээ.

- Сайд гэнээ ... гэхдээ яагаад? ... Ойлгохгүй байна.

Гэвч энэ тухай ярих цаг байсангүй секунтын дараа ноён Уизли хаалганы цаадах агаарт Руфус Скримжерийн хамт бий болоход зогдорыг санагдуулам буурал үс нь агшин зуур танигдав.

Тэд хоёул хашаагаар орж ирээд бүгдийн чимээгүй сууж байгаа дэнлүүний гэрэлтэй ширээ рүү ойртон ирлээ. Скримжер гэрэлд гарч ирмэгц Харри сайдын сүүлд уулзсанаас хойш хөгширч туран илүү баргар болсныг харлаа.

- Түгшээсэн явдалд өршөөнө үү. Ялангуяа баярт урилгагүй ирсэн явдалд гээд Скримжер ширээний дэргэд хазганан зогссоноо харц нь аварга том снитч дээр туслаа. Таньд урт удаан амьдралыг хүсье.

- Баярлалаа гэж Харри хэлэв.

- Би таньтай ганцааарчилан ярих хэрэгтэй байна. Бас ноён Рональд Уизли болон хатагтай Гермиона Грейнжер нартай мөн адил гэж тэр үргэлжлүүлэв.

- Бидэнтэй гэнээ? Бид таньд ямар хэрэгтэй юм? гэж гайхсан Рон асуулаа.

- Энэ тухай илүү тохиромжтой газар ороод ярья гээд Скримжер хатагтай Уизли руу эргэж,

- Энд тийм газар олно гэж найдаж болох уу? гэлээ.

- Мэдээж тэгэлгүй яахав. Э-э ... зочны өрөөг та ашиглаж болно гэж хатагтай

Уизли хэлэв.

- Биднийг тийш нь хүргэнэ үү гэж Скримжер Ронд хэлээд,

- Артур та хоёр биднийг заавал дагалдах албагүй гэлээ.

Ноён ба хатагтай Уизли түгшсэн харц солилцоход Харри, Рон, Гермиона нар бослоо. Тэд чимээгүйхэн байшинд ороход Харри хоёр найз нь түүний адил зүйл бодож байгаа болохыг ойлгов. Скримжер ямар нэг аргаар тэднийг Хогвартсаас гарах гэж байгааг мэдсэн бололтой.

Тэднийг Үүрний гал зуухыг өнгөрөн зочны өрөө рүү орох үед Скримжер юу ч хэлсэнгүй. Гадаа цэцэрлэгт үдшийн зөөлхөн алтлаг гэрэлтэй байсан бол байшинд хэдийн харанхуйлжээ. Тэднийг хуучны тохилог зочны өрөөнд ороход Харри саваагаа даллан тосон дэн асаав. Скримжер ердийн үед ноён Уизлийн суудаг зөөлөн сандлыг эзэлмэгц Харри, Рон, Гермиона нар буйдан дээр зэрэгцэн суулаа. Тэднийг дөнгөж суумагц Скримжер,

- Надад та гурваас асуух асуулт байгаа болохоор ганцааарчилан ярьсан нь дээр гэж бодлоо. Би эхлээд Рональдтай ярих болохоор харин та хоёр дээшээ гараад хүлээж бай гэж Харри, Гермиона хоёрыг хуруугаараа заан хэлэв.

- Бид хаашаа ч явахагүй гэж Харри хэлэхэд Гермиона дэмжин толгой дохилоо.

- Та биднийг хамт байхад ярихгүй бол хэнтэй нь ч ярихгүй. Скримжер Харриг хүйтэн цэгнэсэн харцаар ширтэв.

- За сайн байна тэгвэл хамтдаа байхад чинь ярья гээд мөрөө хавчсанаа хоолой засан ханиалгаад,

- Би ийшээ Альбус Дамблдорын гэрээслэлтэй холбоотой асуудлаар ирсэний учрыг та нар мэдэж байгаа байх гэж бодож байна.

Харри, Гермиона, Рон нар бие бие рүүгээ харлаа.

- Та нар гайхаж байх шиг байна! Дамблдор та нарт ямар нэг зүйл орхисон гэж мэдээгүй хэрэг үү?

- Бидэнд бүгдэд үү? Гермиона бид хоёрт бас уу? гэж Рон асуулаа.

- Тиймээ, хүн бүрт ...

Гэвч Харри түүний үгийг таслав.

- Дамблдор сарын өмнө үхсэн. Та яагаад ийм удаан хугацааны дараа бидэнд түүний үлдээсэн зүйлийг өгч байгаа юм бэ?

- Энэ илэрхий биш байна гэж үү? хэмээн Гермиона Скримжерийг хариулахаас өмнө хэлээд,

- Тэд бидэнд үлдээсэн зүйлийг шалгахыг хүсч гээд Скримжер рүү эргэн чичирсэн хоолойгоор,

- Таньд үүнийг хийх ямар ч эрх байхгүй! гэлээ.

- Надад бүрэн эрх байгаа гэж бодож байна хэмээн Скримжер үл ойшоон дуугараад,

- Хуулийн дагуу ид шидийн яамнаас гэрээслэсэн зүйлийг хураан авах эрхтэй ... гэв.

- Энэ хууль шидтэнгүүдийн хооронд хар шидийн зүйл залгамжлагдахад саад болохын тулд зохиогдсон. Тэгээд ч яамнаас хууль бус зүйл эзэмшиж байсан байвал өмчилөхөөс өмнө хураан авах эрхтэй байдаг! Та үнэхээр Дамблдор бидэнд хар шидийн зүйл дамжуулахыг оролдоно гэж бодож байна уу?

- Та цаашид ид шидийн хуулийн хэлтэст ажиллахаар төлөвлөж байгаа юм биш биз, хатагтай Грэйнжер? гэж Скримжер асуулаа.

- Үгүй, тийм биш. Би хүмүүст ямар нэг ашигтай юм хийнэ гэж найдаж байна!

гэж Гермиона ширүүн дуугарав.

Рон инээд алдсанд Скримжер түүн рүү харснаа ахин Харри дээр харц тусав.

- Тэгвэл бидэнд одоо яагаад гэрээслэлийг өгөхөөр шийдсэн юм? Цаашид түүнийг хадгалах шалтгаан байхгүй болоо юу?

- Үгүй дээ, ердөө гучин нэгэн өдөр өнгөрсөн. Тэд энэ хугацаанд аюултай гэдгийг нь баталж чадаагүй бол цаашид хадгалах боломжгүй болно. Тийм биз дээ? гэж Гермиона хэлэв.

- Та Дамблдортой ойрхон байсан гэж хэлж чадах уу, Рональд? гэж Скримжер

Гермионаг үл тоомсорлон асуухад Рон бодлогоширлоо.

- Би юу? Үгүй ... тийм биш ... Харри л үргэлж ...

Рон Харри, Гермиона хоёрын чимээгүй байхыг анхааруулсан харцыг харсан ч хэлсэн үгээ буцаах боломжгүй болсон байлаа. Скримжер харваас яг л ийм зүйл сонсохыг хүсч байсан бололтой Роны хариултыг махчин шувуу адил шүүрч авлаа.

- Хэрвээ та Дамблдорт ойрхон байгаагүй юм бол ямар учраас гэрээслэлдээ дурьдсан хэрэг байх вэ? Түүний хувийн өмчид хамаарах зүйл тийм ч олон биш. Түүний ихэнхи хэсэг болох номын сан, шидийн хэрэгслэлүүд болон хувийн бусад зүйлс нь Хогвартст үлдэх болно. Тэр яагаад таныг онцолсон болохыг юу гэж бодож байна?

- Би ... мэдэхгүй байна. Би ... ойр дотно байсан гэж хэлж чадахгүй ... Гэхдээ түүнийг надад сайн ханддаг байсан гэж бодож байна ...

- Даруухан байх хэрэггүй дээ, Рон. Дамлбдор чамд их хайртай байсан гэж Гермиона хэлэв.

Энэ бол худал байлаа. Харри Рон, Дамблдор хоёр хэзээ ч удаа ганцаарчилан уулзаж байгаагүй бөгөөд тэдний хоорондын уулзалт хуруу тоолом цөөн болохыг мэдэж байв. Гэвч Скримжер үүнийг сонссонгүй. Тэр гараа жанчныхаа дотор шургуулан Хагридын бэлэглэснээс томхон хүүдий гаргаж ирснээ хуйлаастай цаас гаргаад дэлгэн чанга уншлаа.

- «Альбус Персиаль Вулфрик Брайн Дамблдорын сүүлчийн гэрээслэл ...». Тиймээ, энд байна ... «Рональд Билиус Уизлид би делюминаторoо үлдээж намайг дурсан ашигтай хэрэглэнэ гэж найдаж байна».

Скримжер хүүдийнээс Харрийн урд нь харж байсан мөнгөлөг асаагууртай төстэй ганц шархийлгэхэд ямар ч гэрлийг асааж унтрааж чаддаг зүйл гаргаж ирлээ. Скримжер урагш тонгойн Ронд делюминаторыг өгөхөд мэгдэн аваад хуруундаа эргүүлэв.

- Энэ зүйл маш үнэтэй зүйл гэж Скримжер Роноос нүд салгалгүй харж хэлээд,

- Магадгүй ховор ч гэж хэлж болох юм. Бас Дамблдор үүнийг өөрийн биеэр хийсэн гэдэг. Тэр таньд яагаад ийм ховор зүйл орхисон юм бол? гэв.

Рон гайхширан толгой сэгсэрлээ.

- Дамблдорт мянгаас доошгүй сурагч байсан. Гэтэл тэр дундаас зөвхөн та гуравт гэрээслэл үлдээж. Яагаад? Ингэхэд та үүнийг яаж ашиглахыг мэднэ биз дээ, ноён Уизли?

- Магадгүй гэрэл асааж болох байх гэж Рон бувтнаад,

- Түүгээр өөр юу хийж болно? гэв.

Скримжерт харваас энэ нь ямар ч санаа төрүүлсэнгүй бололтой. Тэр хэдэн хормын турш Рон руу харснаа дараа нь ахин Дамблдорын гэрээслэл рүү эргэв.

- «Хатагтай Гремиона Жин Грейнжерт би өөрийн «Бидл Бардын үлгэрүүд» номоо орхиж сургамжтай зүйл олно байх гэж найдаж байна».

Тэгээд Скримжер хүүдийнээс дээр хэвтэж байгаа «Хар урлагийн нууцууд»-тай адил элэгдэж хуучирсан багахан ном гаргаж ирлээ. Түүний хавтас нь ховхрон толбо болсон байв. Гермиона чимээгүйхэн Скримжерээс номыг аваад өвдөг дээрээ тавин харлаа. Харри номон дээр байсан дүрс үсэг рүү харсан ч юу болохыг нь мэдсэнгүй. Тэр тэдэн рүү харахад дүрс тэмдэгэн дээр нулимс дуслав.

- Харин Дамблдор яагаад таньд энэ номыг орхисон гэж бодож байна, хатагтай Грэйнжер? хэмээн Скримжер сониучирхав.

- Тэр ... тэр намайг номонд дуртай гэдгийг мэддэг байсан гэж Гермиона хүчилсэн хоолойгоор хэлээд нулимсаа ханцуйгаараа арчлаа.

- Гэхдээ яагаад заавал энэ номыг гэж?

- Мэдэхгүй. Магадгүй надад таалагдана гэж бодсон байх.

- Та хэзээ нэгэн цагт Дамблдортой түлхүүр үг болон өөр бусад нууц үг дамжуулах аргын тухай ярилцаж байсан уу?

- Үгүй, ярилцаж байгаагүй гэж Гермиона нүдээ арчсан хэвээр хэлээд,

- Хэрвээ ид шидийн яам гучин нэгэн өдөрт номноос нууц түлхүүр илрүүлж чадаагүй бол би үүнийг чадна гэдэгтээ эргэлзэж байна гэв.

Тэр мэгшин уйллаа. Гурван найз буйдан дээр маш нягт шахалдан суусан учир Рон гараа хүндхэн сунгаж Гермионагийн мөрөөр тэвэрлээ. Скримжер ахин гэрээслэл рүү харлаа.

- «Харри Жеймс Поттерд» гэж тэр уншихад Харрийн дотор догдолсондоо агших шиг болов.

- «Би цөхрөлтгүй зангийнх нь шагнал болгон Хогвартсын анхны квиддичийн тэмцээн дээр барьсан квиддчийг үлдээж байна».

Скримжер хүүдийнхээс жижигхэн хушганы хэмжээтэй алтан бөмбөлөгийг гаргаж ирэхэд мөнгөн далавч нь сулхан дэрвэлзсэнд Харри сэтгэлээр унахгүй байж чадсангүй.

- Дамблдор яагаад таньд снитч үлдээсэн юм бол?

- Ойлгох юм алга. Таны уншсан шалтгаанаар байх гэж бодож байна ... надад сануулахын тулд ... цаашид шургуу байхыг.

- Тэгвэл та үүнийг цэвэр бэлэг тэмдэгийн чанартай зүйл гэж бодож байгаа хэрэг үү?

- Магадгүй л юм. Өөр ямар байж болно гэж?

- Асуултыг би тавих болно гээд Скримжер сандлаа хөдөлгөн буйданд ойртуулав.

Гадаа харанхуй болоод зочны өрөөний цонхоор амьд бургасан хашаан дээгүүр сүндэрлэсэн асар хий үзэгдэл шиг цайрна.

- Би таны төрсөн өдрийн бялуу снитчийн дүрстэй болохыг ажигласан. Яагаад тэр вэ? гэж Скримжер Харрид хандан хэлэв.

Гермиона шоолонгуй инээд алдсанаа,

- Өө, мэдээж Харри сайн баригч болохоор энэ хэтэрхий энгийн зүйл биз дээ.

Бас түүний дотор Дамблдорын нууцалсан илгээмж байж болно! гэв.

- Би түүний дотор нууцалсан зүйл байгаа гэж бодохгүй байна. Гэхдээ снитч жижигхэн зүйл нуухад маш тохиромжтой. Мэдээж та яагаад гэдгийг нь мэдэж байгаа биз дээ?

Харри мөрөө хавчлаа. Гэсэн ч Гермиона,

- Яагаад гэвэл снитч дурсамж хадгалдаг гэв.

- Юуны? хэмээн Харри, Рон хоёр Гермионагийн квиддичийн мэдлэг өчүүхэн гэж боддог байсан явдалд гайхширан зэрэг асуулаа.

- Зүйтэй гэж Скримжер батлаад,

- Снитчийг тоглоомд барьдаг ч хэн ч түүнийг нүцгэн гараараа барьдаггүй, бэлтгэхдээ хүртэл бээлийтэй ажилладаг. Снитч өөртөө шидийг агуулсан байдаг болохоор эхэлж хүрсэн хүнийг санах чадвартай байдаг юм ... Энэ снитч таны хүрэлтийг санаж байгаа, Поттер гэв.

- Ингээд бодож үзтэл надад Дамблдор гайхамшигтай шидтэн болохоор снитчийг зөвхөн таньд онгойлгож чадахаар илбэдсэн гэсэн санаа төрсөн юм.

Харрийн зүрх түргэн цохилов. Скримжерын зөв гэдэгт тэр эргэлзсэнгүй. Тэр яаж сайдын нүдэн дээр снитчийг нүцгэн гараар барихаас татгалзах вэ?

- Та чимээгүй байна. Магадгүй дотор нь юу байгаа болохыг мэдэж байгаа байх тийм үү?

- Үгүй гээд Харри үргэлжлүүлэн яаж снитчэд хүрэлгүй барихаа гайхав. Хэрвээ тэр легилменцийг эзэмшсэн бол дэргэдээ сууж байгаа Гермионагийн юу бодож байгааг унших байлаа.

- Түүнийг ав гэж Скримжер аяархан хэлэв.

Харри сайдын шар нүд рүү хараад сонголт үгүй болсныг ойлгов. Тэр гараа сунгахад

Скримжер удаан бөгөөд болгоомжтойгоор снитчийг алган дээр нь тавив.

Юу ч болсонгүй. Харрийн хуруу снитчэд хүрэхэд далавч нь ядрангүй дэрвэлзсэнээ зогсов. Скримжер Рон, Гермиона нар Харрийн хуруунд байгаа бөмбөг ямар нэгэн өөр зүйл болон хувирахыг найдсан мэт хомхойрон ширтлээ.

- Маш сэтгэл хөдлөм байлаа гэж Харри хүйтнээр хэлэхэд Рон, Гермиона хоёр инээлдлээ.

- Болсон гэж найдаж болох уу? гээд Гермиона буйдангаас өндийв.

- Үгүй ээ болоогүй гээд Скримжер одоо жинхэнээсээ уурлаж эхэллээ.

- Дамблдор тань ахин нэг зүйл гэрээслэсэн, Поттер.

- Ямар? гэж Харри асуугаад сэтгэл нь ахин хөөрлөө. Энэ удаад Скримжер гэрээслэлийг уншсангүй.

- Годрик Гриффиндорын илд.

Гермиона, Рон хоёр балмагдан хөшлөө. Харри бариулан дээрээ бадмааараг шигтгэсэн илдийг эрсэн ч Скримжер хүүдийнээсээ гаргаж ирсэнгүй.

- Тэр хаана байна? гэж Харри сэжигтэй асуулаа.

- Харамсалтай нь Дамблдор илдийг өгөөгүй. Годрик Грффиндорын илд түүхийн маш чухал зүйл болохоор харъяалагдах ...

- Тэр Харрид хамаарагдана! гэж Гермиона унтууцан хашгирав.

- Илд түүнийг сонгосон. Харри илдийг хуваарилгагч бүрх малгайнаас гаргаж авсан ...

- Түүхийн найдвартай эх сурвалжаас үзэх юм бол илд Гриффиндорын хэнд ч харъяалагдаж болох юм. Харин түүнийг ноён Поттерын өмчинд өгөөгүйн учрыг Дамблдор тэгж шийдсэн байж болох.

Ингээд Скримжер муухан хуссан хацраа маажсанаа Харри руу цоо ширтлээ.

- Та яагаад гэж бодож байна ...?

- Дамблдор надад яагаад илдийг өгөхийг хүссэн гэж үү? хэмээн Харри уураа арай ядан барьж хэлээд,

- Магадгүй миний ханан дээр байх нь сайхан харагдана гэж бодсон байх гэв.

- Энэ тоглоом биш, Поттер! гэж Скримжер зандраад,

- Магадгүй Дамблдор Годрик Грффиндорын илд Слизериний залгамжлагчыг ялж чадна гэж итгэсэн байх? Таньд илдийг өгөхийг хүссэний учир нь олон хүний адил Хэцүү нэртийг устгах устгах тавилантай гэдэгт итгэсэн байх?

- Сонирхолтой онол байна. Тэгвэл хэн ч яагаад илдээр Волдемортыг хатгахыг оролдож үзээгүй юм бэ? Магадгүй ид шидийн яам Азкабанаас гэмт хэрэгтэнгүүд зугтсаныг нуун делюминаторыг судалж цаг үрж байхын оронд хэдэн хүнийг энэ даалгавар биелүүлэхээр томилсон нь дээр байх. Тэгвэл сайд та өрөөндөө хааж суугаад снитчийг онгойлгохыг хичээх хэрэггүй болно биз дээ? Хүмүүс үхэж би золтой л тэдний нэг болоогүй. Волдеморт миний араас гурван хүнтэй хөөж Хурц нүдэт Грюмыг алсан ч ид шидийн яамны хэн нь ч энэ тухай үг дурсаагүй биз дээ. Тэгсэн хэрнээ намайг хамтран ажиллана гэж найдсан хэвээр байдаг!

- Та хэтэрхий цаашилж байна! гэж Скримжер хашгираад босоход Харри бас үсрэн бослоо. Скримжер түүн рүү доголон алхаад цээж рүү нь саваагаар хатгахад тамхи шиг уугьсан үзүүр нь Харрийн футболканд нүх үлдээв.

- Өө! гэж Рон хашгираад бас босож саваагаа өргөсөн ч Харри түүнийг зогсоолоо.

- Үгүй ээ! Чи түүнд биднийг бүгдийг баривчлах боломж өгөхийг хүсээд байгаа хэрэг үү?

- Та нар сургуульд байгаа биш гэдгээ бүү мартаарай, ойлгомжтой юу? гэж

Скримжер Харрийн нүүр лүү амьсгаадан хэлээд,

- Бас намайг дуулгаваргүй ичгүүргүй занг чинь өршөөдөг Дамблдор биш гэдгийг бүү март. Та магадгүй титэм шиг сорви зүүсэн байж болох юм, Поттер. Гэхдээ чам шиг арван долоо хүрсэн хүү надад хийх ажлыг минь заадаг юм биш! Энэ удаад таньд хүмүүсийг хүндэтгэхийг заая! гэв.

- Та үүнийг хүртэх эрхтэй! гэж Харри хэлэв.

Шал чичирсэнээ довжоогоор яаран гүйх хөлийн чимээ гараад зочны өрөөний хаалга нээгдэн ноён ба хатагтай Уизли орж ирэв.

- Бид ... сонсогдох шиг санагдлаа ... гэж ноён Уизли хэлээд сайд Харритай хамраа тулах шахам зогсож байгааг түгшин харлаа.

- Уурласан хоолой гэж хатагтай Уизли хэлэв.

Скримжер Харригаас хоёр алхам холдоод футболкан дээрх нүх рүү нь харлаа. Тэр харваас үүндээ харамсаж байгаа бололтой.

- Энэ ... зүгээр дээ юу ч биш. Би ... таны хандлагад харамсаж байна гэж

Харрийн нүд рүү харж хэлээд,

- Та харваас ид шидийн яам хүсэхгүй, таныг хүсэхгүй байна гэж бодоо юу ...

Дамблдорын хүсэж байсан шиг ... Бид хамтдаа ажиллах ёстой.

- Надад таны арга барил таалагдахгүй байна, сайдаа. Та мартаа юу?

Ингээд тэр хоёр дахь удаагаа баруун гараа өргөн Скримжерт цайвар гялалзсан «Би худал хэлэхгүй гэсэн» сорвио үзүүлэв. Скрмжерийн царай хөшлөө. Тэр өөр нэг ч үг хэлэлгүй эргээд доголсоор зочны өрөөг орхив. Хатагтай Уизли түүний араас яаран дагалдаад үүдний хаалга нээх нь сонсогдсоноо хормын дараа,

- Тэр явчихлаа! гэж хашгирав.

- Түүнд юу хэрэгтэй байсан юм? гэж ноён Уизли Харри, Рон, Гермиона гурваас асуухад эхнэр нь яаран зочны өрөөнд орж ирлээ.

- Бидэнд Дамблдорын гэрээслэлийг өгөх гэсэн. Тэд саяхан шалгаж дуусчээ гэж

Харри хэлэв.

Хэдэн хормын дараа гадаа цэцэрлэгт оройн хоолны ширээн дээр тэдэнд өгсөн зүйлийг бүгд гар дамжуулан үзэцгээв. Хүн бүр делюминатар болон «Бидл бард»-ын

үлгэрийг хараад уулга алдан Скримжер илдийг өгөхөөс татгалзсан явдалд харамссан ч хэн ч Дамблдор Харрид хуучин снитч үлдээсний учрыг тайлбарлаж чадсангүй. Ноён Уизли Делюминаторыг дөрөв дэх удаагаа шалгахад эхнэр нь хулчгардуухан,

- Харри хонгор минь бүгд их өлсөж байгаа ч бид чамгүй эхэлж чадсангүй ...

Оройн зоогоо эхлэх үү? гэлээ.

Үүний дараа бүгд яаран суугаад хэдэнтээ «Төрсөн өдрийн мэнд хүргэе!» гэж хашгиран баярын бялуугаа идэцгээлээ. Хагрид маргааш өдрийн хуримд уригдсан ч Үүрэнд унтахад хэтэрхий том болохоор асарт шөнийг өнгөрүүлэх болов.

- Дээр уулзъя. Бүгдийг ор луугаа явсны дараа гэж Харри тэднийг хатагтай Уизлид цэцэрлэгийг ердийн байдалтай болгоход тусалж байхад Гермионад шивнэв.

Дээврийн өрөөнд Рон Делюминатороо судлан, Харри Хагридын өгсөн хүүдийг алтаар биш харахад үнэгүй хэдий ч өөрт үнэ цэнэтэй зүйлс болох Тэнүүлчний газрын зураг, Сириусын шидэт толины хэлтэрхий, Р.А.Б-ын зүүлт зэргээр дүүргээд хүзүүндээ зүүлээ. Тэр гартаа хуучин снитчийг бариад далавч нь сулхан чичигнэхийг харж суулаа. Эцэст нь Гермиона хаалга цохиод өлмий дээрээ гэтэн орж ирэв.

- Дүлийр! гэж тэр шивнээд шатны зүг саваагаа даллав.

- Чамайг энэ шившлэгийг дэмждэггүй гэж бодсон юмсан гэж Рон хэлэв.

- Цаг үе өөрчлөгдсөн. Алив бидэнд Делюминатороо үзүүлээч.

Рон даруйхан гаргаж ирээд урдаа барьж шархийлгэхэд өрөөний дэнлүү унтарлаа.

- Үүнийг бид Перугийн хар дарьд хэрэглэж болох байх гэж Гермиона харанхуйд шивнэлээ.

Аяархан шархийх чимээ гараад адрын гэрэл буцаж аслаа.

- Янзтай гэж Рон дуу алдаад,

- Бас тэд үүнийг Дамблдор өөрөө зохиосон гэж хэлсэн байдаг! гэв.

- Тэр чамд үүнийг гэрэл асаалгахаар өгөөгүй гэдгийг мэдэж байна!

- Дамблдор ид шидийн яамнаас гэрээслэлийг бидэнд өгөхийн өмнө шалгахыг мэдэж байсан гэж бодож байна уу? гэж Харри асуулаа.

- Гарцаагүй. Тэр бидэнд үлдээснээ гэрээслэлд хэлсэн ч яах гэж гэдгийг нь тайлбарлах боломжгүй байсан ...

- Тэр яагаад үүнийгээ биднийг амьд байхдаа өгөөгүй юм бол? гэж Рон асуулаа.

- Яг тийм гээд Гермиона үлгэрийг харж,

- Эдгээр зүйлс их чухал болохоор ид шидийн яамны хамрын урд өгөх гэж бодсон байх ... хэрвээ үүнийг илэрхий гэж тооцоогүй л юм бол гэв.

- Хэрвээ тэр алдсан байвал яах вэ? Би түүнийг үргэлж солиотой гэж хэлдэг байсан биз дээ. Гялалзсан шидтэн хэдий ч жаахан хэвийн бус. Харрид хуучин снитч орхино гэдэг чинь юу гэж байгаа юм? гэж Рон хэлэв.

- Ойлгох юм алга. Гэхдээ Скримжер снитчийг чамд өгөхөд би ямар нэг зүйл болно гэдэгт итгэлтэй байсан, Харри.

- Тийм л дээ гээд Харри снитчийг өргөлөө.

- Би сайдын урд хэтэрхий хүрэхгүй байхыг хичээсэн.

- Энэ чинь юу гэж байгаа юм? хэмээн Гермиона асуулаа.

- Энэ снитчийг би хамгийн анхны тэмцээн дээр барьж авсаныг санаж байна уу? Гермиона мэл гайхахад, Рон дуу алдсанаа,

- Энэ чиний залгих шахсан снитч мөн биз дээ! гэв.

- Яг тийм гээд Харрийн зүрх түргэн цохилоход снитчийг уруулдаа хүргэлээ.

Гэвч снитч нээгдсэнгүй. Урам хугарч гонсойсон Харри алтан бөмбөгийг холдуулахад Гермиона,

- Бичиг! Хараач түүн дээр бичиг байна! гэж хашгирлаа. Харри гайхсандаа болоод снитчийг золтой л унагасангүй.

Гермионагийн зөв байлаа. Секунтын өмнө юу ч байгаагүй дээд талын гөлгөр гадаргуу дээр жижигхэн дөрвөн үсэгтэй налуу бичиг байхыг Харри Дамблдлорынх гэж танив.

Би төгсгөл нь ирэхээр онгойлгоно.

Харри дөнгөж уншиж амжтал үг ахин алга болов.

- Би төгсгөл нь ирэхээр онгойлгоно ... Энэ юу байж болох вэ?

Рон, Гермиона хоёр гайхширан толгой сэгсрэв.

- Би төгсгөл нь ирэхээр онгойлгоно ... төгсгөл ... би төгсгөл нь ирэхээр онгойлгоно.

Тэд энэ үгийг олон янзын өнгөөр давтсан ч юу ч болсонгүй.

- Илдний хувьд бол гэж Рон эцэст нь үгийг давтахаа болиход хэлээд,

- Тэр яагаад Харрид илдийг өгөхийг хүссэн юм бол? гэв.

- Бас яагаад надад энэ тухайгаа надад хэлээгүй юм бол? Илд өнгөрсөн жил бидний ярианы туршид ханан дээр өлгөөтэй байсан биз дээ! Хэрвээ тэр илдийг өгөхийг хүссэн бол яагаад тэгэхэд өгөөгүй юм бол?

Тэр шалгалтан дээр суугаад хариултыг нь мэдэх ёстой асуулт харж байгаа юм шиг сэтгэгдэл төрсөн ч толгой нь ажилласангүй. Магадгүй Дамблдорын өнгөрсөн жил хийсэн урт яриандаа ямар нэг зүйл орхисон юм биш байгаа даа? Энэ юу болохыг тэр

мэдэх ёстой юм болов уу? Эсвэл Дамблдор түүнийг бүгдийг ойлгоно гэж найдсан хэрэг үү?

- Тиймээ, бас энэ ном гэж Гермиона хэлээд,

- «Бидл Бардын үлгэр» ... Би хэзээ ч энэ тухай сонсож байсангүй! гэлээ.

- Чи «Бидл Бардын үлгэр»-ийг хэзээ ч сонсож байгаагүй гэнээ? Тоглож байна уу? гэж Рон үл итгэн хэлэв.

- Үгүй, тоглоогүй. Харин чи мэддэг юм уу? гэж Гермиона гайхан дуугарав.

- Мэдэхгүй яах юм!

- Харри үүнд хөгжин тэдэн рүү харлаа. Рон Гермионагийн уншаагүй номыг уншсан нь урьд хожид байгаагүй тохиолдол байв.

- Боль доо! Бүх хуучны хүүхдийн үлгэрт Бидлийг бичсэн байдаг биз дээ? Аз жаргалын усан оргилуур, Үсэрдэг тогоотой шидтэн, Хөгжилтэй туулай ... гээд л.

- Өршөөгөөрэй? гэж Гермиона хөхрөөд,

- Юуны тухай гэнээ? гэв.

- За больж үз. Чи лав туулайны тухай сонссон байлгүй дээ гэж Рон Харри, Гермиона хоёр луу итгэлгүйхэн харж хэллээ.

- Рон чи биднийг маглуудын дунд өссөн гэдгийг мэдэж байгаа биз дээ. Биднийг жаахан байхад хэн ч ийм үлгэр биш «Цасан цагаан ба долоон одой»,

«Золушка» ярьдаг байсан юм ...

- Энэ чинь өвчтөн юм уу? гэж Рон асуулаа.

- Харваас хүүхдийн үлгэр байгаа биз дээ? гээд Гермиона ахин дүрс үсэг рүү тонгойлоо.

- Тийм л дээ. Гэхдээ бүх хуучны үлгэрүүд Бидлээс эхтэй байдаг юм. Харин жинхэнэ хувилбар нь ямар байдгийг мэдэхгүй юм.

- Гэхдээ Дамблдорт яагаад намайг уншихыг хүссэн юм бол? Шатны дор ямар нэг зүйл хагарлаа.

- Магадгүй Чарли ээжийг унтаж байгаа дээр нь ахиад үсээ ургуулж байгаа биз гэж

Рон хэлэв.

- Бид ч гэсэн унтах хэрэгтэй. Тэгэхгүй бол маргааш өглөө нойрмог ялаа шиг юм байх болно гэж Гермиона шивнэв.

- Тийм шүү гэж Рон зөвшөөрөөд,

- Хэрвээ ээж хэрцгий гурван аллага хийвэл шинээр гэрлэгсэдийн хурим сүйрэх байлгүй. За би гэрэл унтраая гэв.

Ингээд Гермионаг өрөөнөөс гармагц тэр Делюминатороо шархийлгэлээ.

БҮЛЭГ 8: ХУРИМ 73

Маргааш нь үдээс хойшийн гурван цагаас Харри, Рон, Фред, Жорж нар жимсний цэцэрлэгт том цагаан асрын гадна зогсоод хуримын зочид ирэхийг хүлээж байлаа. Харри Хувиргагч уусмал хэрэглэн хөрш тосгон болох Оттери-Сент-Кэчоулаас Фредийн Татах шидийн тусламжтайгаар үсийг нь авсан шаргал үстэй хүү болжээ. Харриг үеэл дүү Барни болгон танилцуулах санаа гарахад Уизлийнхан дэмжсэн байна.

Дөрвүүлээ гартаа зочдын төлөвлөгөө барин зогсоод хүмүүсийг хэрэгтэй газраа суухад нь туслах ёстой байлаа. Цагаан жанчтай бүлэг үйлчлэгч нар улаан хувцастай найрал хөгжмийн хамтлагтай цагийн өмнө хүрэлцэн иржээ. Одоо энэ шидэт ах дүүс холгүйхэн модны дор суугаад гаанснаасаа цэнхэр дөл уугиулж байлаа.

Харрийн ард талд асрын үүд байсан бөгөөд урт улаан хивсний хоёр талаар алтан сандлууд эгнүүлэн тавьсан нь ярайн харагдана. Асрын багануудыг цагаан болон алтан цэцэгсээр ороон чимэглэжээ. Билл, Флер хоёрын удахгүй эхнэр нөхөр болох гэж байгаа газар Фред, Жорж хоёр яаран аварга том алтлаг бөмбөлөг хөөргөв. Гадаа шивээлсэн бут ногоон дээгүүр эрвээхэй, цох залхуутайхан нисэж зуны сайхан өдөр байсан ч Харрийн дотор тавгүй байв. Түүний хувирсан магл хүү арай махлаг болохоор ёслолын жанч багадан бие барьж халууцуулна.

- Би гэрлэх үедээ ийм утгагүй юманд санаа зовохгүй гээд Фред жанчныхаа захыг угзарч,

- Бүгд дуртайгаа өмсөж харин ээжид шившлэг илгээгээд бүх зүйл дуустал тайван хэвтэж байх болно гэв.

- Өглөө тэр муугүй байсан. Персиг байхгүй гэж жаахан уйлсан ч ер нь тэр хэнд хэрэгтэй юм бэ. Өө, чөтгөр гэж эхэллээ тэд ирж байна гэж Жорж хэлэв.

Алсад хашааны зах дээгүүр нэг нэгнийхээ араас хурц өнгийн дүрснүүд гарч ирэв. Хэдэн хормын дараа тэд бүтэн урсгал болж цэцэрлэгийн замаар мушгиралдан асрын зүг ойртож ирэв. Эмэгтэй шидтэнгүүдийн малгай дээр этгээд цэцэгс болон далавчаа дэвсэн илбэдсэн шувуу байх агаад олон хүний хүзүүний алчуурт үнэт эрдэнийн чулуу гялалзаж байлаа. Хүмүүсийн асар руу ойртож ирэхэд хоорондоо ярилцах дуу нь цохны дүнгэнээн мэт сонсогдов.

- Маш сайн байна, би хэдэн үеэл вейлагаа олж харах шиг боллоо гэж Жорж хүзүүгээ өлийлгөн хэлээд,

- Тэдэнд манай анги ёс заншлыг ойлгоход тусламж хэрэгтэй болохоор би үүнд нь санаа тавья ... гэв.

- Тэд тийм ч хурдан биш юм гээд Фред настай эмэгтэйгээр толгойлуулсан цувааг харж,

- Таньд туслахыг зөвшөөрнө үү гэлээ.

Хоёр хөөрхөн франц охид инээлдэн түүнд үнэхээр асарт дагуулан орохыг зөвшөөрөв. Жорж настай эмэгтэйд туслахаар үлдэхэд Рон ид шидийн яаманд ноён

Уизлийн хамт ажилладаг Перкинсэд туслах үүргийг өөртөө авлаа. Харрийн хувьд настай дүлий хөгшин оногджээ.

- Сайн уу гэх танил хоолой түүнийг асраас гарахад сонсогдоод дарааллын түрүүнд Тонкс, Люпин хоёр зогсож байх нь үзэгдэв. Тонкс баярт зориулан үсээ цайвар болгон хувиргажээ.

- Артур чамайг буржгар үстэй гэж хэлсэн. Өчигдөрийн явдалд уучлаарай гэж

Тонкс тэднийг эгнээ хооронд дагуулан явахад хэлээд,

- Ид шидийн яам хүн чононуудын эсрэг шүд зуусан байгаа болохоор бидний ирэлт чамд ямар ч таатай зүйл авчирахгүй гэж бодлоо гэв.

- Бүх зүйл хэвийн би ойлгож байна гэж Харри Люпинээс илүү Тонкст хандан хэллээ.

Люпин инээмсэглэсэн хэдий ч тэднийг эргэх үеэр Харри царай нь ахин золгүй болохыг харлаа. Тэр яагаад гэдгийг нь ойлгосонгүй ч учрыг нь олж байх цаг байсангүй. Хагрид хэдийн сандал дээр сууж хэдэн сандал эвдэлжээ. Тэр итгэлгүйхэн Фредийн дохионоос түүнд зориулан шидийн аргаар томруулсан бөх сандал дээр биш харин ердийн таван сандал дээр сууснаа ойлготол тэдгээр нь хугархай шүдэнз шиг болсон байлаа.

Ноён Уизли Хагридын чангаар уучлал гуйхыг үл харгалзан эвдэрсэн зүйлийг засахад Харри буцаж гаран Рон этгээд шидтэнтэй ярьж байхтай тааралдав. Тэр яльгүй сөлөр нүд, чихрийн хөөсөнцөр шиг мөрөө хүрсэн цагаан үс, хамрынхаа урдуур унжуулсан цацагтай малгай, өндөгний нүдийг санагдуулам шаргал жанч өмсчээ. Түүнчлэн гурвалжин нүдийг санагдуулам хачирхалтай бэлэг тэмдэг бүхий алтан гинж хүзүүндээ зүүсэн байлаа.

- Ксенофилиус Лавгуд гэж тэр хэлээд Харрийн гарыг барьж,

- Бид охинтойгоо эндээс холгүй толгод дээр амьдардаг болохоор Уизлийнхан урьсан нь ямар таатай хэрэг вэ. Бас чамайг Полумнаг таних байх гэж бодож байна? гэж Ронд хандан нэмэрлэв.

- Тиймээ. Гэхдээ тэр хаана байна?

- Танай гайхамшигтай цэцэрлэгт анахайтай танилцахын тулд яльгүй саатсан!

Хичнээн цөөхөн хүмүүс жижигхэн анахай ухаалаг болохыг ойлгодог гээч ... магадгүй тэднийг Гернумбили гарденси гэж нэрлэх ёстой байх.

- Манай анахайнууд олон тооны хараалын үг мэднэ. Минийхээр бол Фред, Жорж хоёр л тэдэнд зааж өгсөн байх гэж Рон хэлэв.

Тэр асар руу бүлэг шидтэн оруулж ирэхтэй зэрэгцэн Полумна орж ирлээ.

- Сайн уу, Харри!

- Э-э-э ... намайг Барни гэдэг гэж Харри тэвдэн хэлэв.

- Өө, чи нэрээ ингэж сольсон юм уу? гэж тэр хөгжилтэй асуулаа.

- Чи намайг яаж мэдэв ээ?

- Чиний нүүрний хувиралаар.

Полумна эцэгтэйгээ адилхан тод шаргал өнгийн жанч өмсөж үсэндээ том наранцэцэг хатгасан байв. Тэр хурц тод харагдаж байсан ч гадна төрх нь аятайхан байлаа. Ямар ч гэсэн энэ удаад чихэнд нь улаан лууван байсангүй.

Ксенофилиус танил шидтэнгүүдтэйгээ үг солилцох зуур Полумна, Харри хоёр сонсож байв. Тэгснээ шидтэнгүүдтэй салах ёс гүйцэтгээд охин руугаа эргэхэд хуруугаа өргөөд,

- Аваа хараач, намайг анахай хазсан! гэлээ.

- Ямар гайхамшигтай юм бэ! Анахайн шүлс маш ашигтай! гэж ноён Лавгуд мэдэгдээд охиныхоо хурууг барьж цус болсон ормыг нь харлаа.

- Полумна хонгор минь, хэрвээ чи өнөөдөр авъяасаа үзүүлэхийг хүсч байгаа бол ... магадгүй лусын охины хэлээр дуурь дуулах хүсэл төрөх ч юмуу ... түүнийгээ дарах хэрэггүй! Энэ бол Гернумблийн авъяас байж болно!

Энэ үеэр дэргэдүүр нь өнгөрч байсан Рон чанга тургиллаа.

- Рон хичнээн инээсэн ч болно гэж Полумна Харри тэднийг суудалд нь хүргэхэд тайван хэлээд,

- Гэхдээ аав Гернумблийн шидийн талаар маш их судалгаа хийсэн гэлээ.

- Үнэхээр үү? гэж Харри эртнээс Полумна болон аавынх нь өвөрмөц үзлийн талаар маргалдахаа больсон ч хэлээд,

- Чи хуруугаа ямар нэг зүйлээр боохыг хүсэхгүй байна уу? гэлээ.

- Үгүй дээ, бүх зүйл хэвийн гээд Полумна хуруугаа хөхөн Харрийн хөлөөс толгой хүртэл мөрөөдөнгүй харснаа,

- Чи сайхан харагдаж байна. Би аавд ихэнх зочид ёслолын хувцастай ирнэ гэж хэлсэн болохоор тэр хуримд нарны өнгөтэй хувцас өмсөхийг хүссэн юм ... аз жаргал ойлгож байна уу? гэв.

Түүнийг аавынхаа хойноос явсан хойно Рон настай шидтэнгийн гараас хөтлөн гарч ирлээ. Тэр унжуу хамар, улаан хөвөөтэй нүдтэй агаад өдтэй ягаан малгай өмссөн нь хэрүүлч хотон шувуу шиг харагдана.

- Чиний үс хэтэрхий урт байгаа болохоор би эхлээд Жиневра юм болов уу гэж бодлоо, Рональд. Мерлиний сахал минь Ксенофилиус Лавгуд юугаа өмсчихөө вэ? Тэр яг л шарсан өндөг шиг харагдаж байна. Харин чи хэн бэ? гэж Харриг хараад хэлэв.

- Аан тийм л дээ нагац эгч Мюриэл танилц энэ бол үеэл Барни.

- Бас нэг Уизли юу? Танай угсаа яг л анахай шиг болжээ. Ингэхэд Харри Поттер энд байгаа юу? Би түүнтэй танилцана гэж найдаж байгаа шүү. Тэр таны найз болохоор үүгээрээ бахархаж байгаа байх тийм үү?

- Үгүй ... тэр ирж чадаагүй ...

- Хм-м. Булташ шалтаг олоо юу? Сонингийн зурган дээр харагдаж байгаа шигээ тийм ухаангүй биш гэж найдъя. Би дөнгөж сая сүйт бүсгүйд титмээ яаж өмсөхийг заалаа! гэж Харри руу хашгирснаа,

- Албингийн хийцийн эд манай гэр бүлд зууны өмнөөс хадгалагдаж ирсэн юм.

Тэр үзэсгэлэнтэй охин хэдий ч франц шүү дээ. За яахав Рональд надад сайн суудал олоод өг зуун долоон настай болохоор хөл дээрээ удаан зогсож чадахгүй байна гэв.

Рон Харрийн дэргэдүүр учиртай ширтэн өнгөрлөө. Түүнийг ахин үүдэнд ирэхэд Харри хэдийн арваад зочныг суулгаж амжаад байлаа. Асар бараг дүүрч үүдний дараалал эцэст нь алга болов.

- Мюриэль эгч хар дарсан зүүд л гэсэн үг хэмээн Рон духныхаа хөлсийг ханцуйгаараа арчин хэлээд,

- Тэр өмнө нь бидэн дээр жил болгон зул сарын баяраар ирдэг байсан ч бурханы авралаар Фред, Жорж хоёр үдийн хоолон дээр сандлых нь дор шивхэн бөмбөг дэлбэлсэнд гомдсон юм. Аав үргэлж тэднийг гэрээслэлээсээ хасна гэж баталдаг юм ... Бодоод үзэхэд энэ тэднийг зовоох ёстой байх түүгээр бол манай гэр бүлийн хамгийн баян хүмүүс болж болно гэснээ ойртон ирж буй Гермиона руу нүдээ анивчин хараад,

- Хөөх! Чи маш сайхан харагдаж байна! гэлээ.

- Үргэлж л ийм гайхсан өнгөтэй байх юм гэж Гермиона инээмсэглэв. Тэр хөх ягаан өнгийн даашинз, өндөр өсгийтэй гутал өмсөж гялалзсан үсээ толигор самнасан байлаа.

- Чиний хамаатны нагац эгч Мюриэль үүнийг зөвшөөрөөгүй. Би саяхан түүнийг Флерт титмийг зүүлгэж байх үед нь тааралдахад намайг хараад

«Бурхан минь энэ чинь магл гаралтай юмуу?» гээд дараа нь «муухан биеийн харьцаа ясархаг шагайтай юм» гэсэн.

- Үүнд анхаарал хандуулах хэрэггүй дээ тэр бүгдтэй бүдүүлэг харьцдаг юм гэж

Рон хэлэв.

- Та нар Мюриэлийн тухай ярьж байна уу? гэж Фредийн хамт асарт орж ирсэн Жорж асуулаа. Тиймээ, тэр миний чихийг гажууд байна гэж хэлсэн. Хөгшин ууль. Нагац ах Билиус байхгүй болсон нь харамсалтай тэр ч хуриман дээр хөгжилдэж чаддаг хүн шүү.

- Энэ нөгөө Үл өршөөлийг хараад хорин дөрвөн цагийн дараа үхсэн хүн мөн үү? гэж Гермиона сонирхов.

- Тиймээ тэр жаахан хачирхалтай төгсгөл болсон гэж Жорж хэлэв.

- Гэхдээ тэр хуримд байх дуртай. Бүтэн лонх галт шарз уугаад дараа нь бүжиглэж жанчин дороосоо баглаа цэцэг гаргаж эхэлдэг юм ...

- Тиймээ, үнэхээр сэтгэл татам хүн байж хэмээн Гермиона хэлэхэд Харри инээд алдлаа.

- Харин яагаад ч юм хэзээ ч гэрлээгүй Рон хэлэв.

- Энэ ч намайг гайхуулж байна шүү гэж Гермиона хэллээ.

Тэд инээлдэн хөгжилтэй байсан болохоор хэн ч хар үс, бүргэд хамар, өтгөн хөмсөгтэй залуу хүн дөхөн ирэхийг анзаарсангүй. Тэр Ронд урилгаа өгөөд Гермиона руу харж,

- Чи гайхамшигтай харагдаж байна гэлээ.

- Виктор! гэж тэр орилоод жижигхэн шүрэн цүнхээ газар унагахад түн хийх чимээ гарав. Тэр яаран цүнхээ аваад улайж,

- Би мэдсэнгүй чамайг ... бурхан минь ... чамайг харахад ямар таатай байна ...

Чи ямар шуу байна даа? гэлээ.

Роны чих улайлаа. Тэр Крамын урилгыг итгэхгүй байгаа мэт уншсанаа чангаар,

- Чи энд яаж ирэв? гэж асуулаа.

- Флер урьсан юм гэж Крам хөмсгөө өргөн хэлэв.

Харри Крамд дургүйцэх зүйл байхгүй болохоор гар бариад дараа нь Роноос холдуулсан нь дээр гэж шийдэн суудал руу нь хүргэхийг санал болгов.

- Чиний найз чинь намайг хараад тийм ч их баярлахгүй байгаа бололтой гэж

Крам тэднийг дүүрэн хүнтэй асар дундуур явахад хэлээд,

- Эсвэл тэр чиний хамаатан уу? гэв.

- Үеэл ах гэж Харри бувтнасан ч Крам түүнийг сонссонгүй.

Крамын ирэлт үеэл вейлануудын дунд сэтгэлийн хөөрөл үүсгэв. Эцсийн эцэст тэр квиддичийн алдартай тоглогч байлаа. Зочид түүнийг сайн харахын тулд хүзүү өлийлгөхөд Рон, Гермиона, Фред, Жорж нар үүдээр яаран орж ирлээ.

- Суух цаг боллоо гэж Фред Харрид хэлэв.

Харри, Рон, Гермиона нар хоёрдугаар эгнээнд Фред, Жорж хоёрын хамт өөрсдийн байраа эзэллээ. Гермиона ялимгүй ягаарсан бол Роны чих час улаан болжээ.

Хэдэн хормын дараа тэр Харрид,

- Чи түүний ургуулсан тэнэг сахлыг харсан уу? гэлээ. Харри учир нь олдохгүй үг бувтнав.

Асар сэтгэл хөөрлөөр дүүрч аяархан яриа хөөрөө дундуур инээд хадна. Хаалгаар ноён ба хатагтай Уизли инээмсэглэн толгой дохьсоор орж ирэхдээ усан болор шиг ягаан өнгөтэй шинэ жанч ижилхэн малгай өмсчээ.

Хормын дараа асрын өнцгөөс Билл, Чарли хоёр энгэртээ том цагаан цэцэг хатгасан ёслолын жанчтай гарч ирлээ. Фред исгэрэхэд үеэл вейланууд хөхрөлдлөө. Алтан бөмбөлөгийн дор хөгжим дуугарах шиг болоход цугласан хүмүүс чимээгүй болов.

- Ө-о-о-о-о! гэж Гермиона дуу алдаад үүд рүү харахаар суудал дээрээ эргэв. Цугласан зочид шүүрс алдахтай зэрэгцэн үүдээр ноён Делакур, Флерийн хамт орж

ирлээ. Флер хөвөх мэт явахад ноён Делакур баяртай инээмсэглэж байв. Флер энгийн

цагаан даашинз өмссөн ч гэлээ нүд гялбам мөнгөлөг гэрэл туяарч байх шиг санагдана. Түүний гоо үзэсгэлэнгийн хажууд хүмүүс ердийнхөөрөө дарагдан бүдгэрдэг ч гэлээ өнөөдөр бүгдээс үзэсгэлэнтэй харагдаж байлаа. Жинни, Габриэль хоёр алтлаг даашинз өмсөөд ердийнхөөс илүү хөөрхөн харагдаж байва. Флер Билл рүү түүнийг хэзээ ч Фенрир Сивыйтэй уулзаагүй мэт ойртов.

- Ноёд хатагтай нараа гэх нэгэн хэвийн хоолой гарахад Харри гайхширан хараад Дамблдорын оршуулга дээр байсан босоо үстэй жижигхэн шидтэн Билл, Флер хоёрын урд зогсож байхыг харлаа.

- Бид өнөөдөр энд хоёр үнэнч зүрхийг нийлүүлсэний баярт цуглараад байна ...

- Тиймээ, миний титэм маш сайхан харагдаж байна гэж нагац эгч Мюриэль шивнээд,

- Гэхдээ Жиневрагийн даашинз хэтэрхий богинохон юм гэв.

Жинни эргэж Харри руу нүд ирмэн инээмсэглэснээ түргэхэн урагш харлаа. Харрийн бодол асраас хаа нэгтээ хальж Жиннитэй хоёулхнаа сургуулийн буланд зогсож байсан үе рүүгээ буцав. Тэр удаан жилийн өмнөх юм шиг санагдсан тул одоо үнэн гэхэд хэтэрхий сайхан санагдаж ... духан дээрээ цахилгаантай төстэй сорвигүй жирийн хүний амьдралын хамгийн гялалзсан мөч болох ...

- Уилъям Артур та Флер Изабеллийг сонгож байна уу?

Эхний эгнээнд сууж байсан хатагтай Уизли, хатагтай Делакур хоёр сүлжмэл алчууранд чимээгүйхэн уйлцгаав. Арын эгнээнээс бүрээ үлээх адил чимээ гарахад хүн бүрт Хагрид халааснаасаа бүлээлэг шиг нусны алчууraa гаргасан нь ойлгомжтой байлаа. Гермиона Харри руу нулимс дүүрэн нүдээр эргэж харан инээмсэглэв.

- ... Ингээд би та хоёрын амьдралыг холбосноо зарлаж байна.

Өрөвгөр үстэй шидтэн Билл, Флер толгой дээгүүр саваагаа даллахад мөнгөлөг одод асгаран тэднийг ороон эргэлдэв. Фред, Жорж хоёр хамгийн түрүүнд алга ташихад гэрлэгсдийн дээр байсан алтан бөмбөлөг хагаран агаарт диваажингийн шувууд нисэлдэн, алтан хонх жингэнэн дуугарав.

- Ноёд хатагтай нараа бүгд босцгооно уу!

Бүгд босон нагац эгч Мюриэль аягүйцсэндээ чангаар гомдоллож тэр саваагаа ахин даллав. Зочдын сууж байсан сандал агаарт сүр жавхлантай хөөрөн асрын хөшгөн хана алга болоод одоо бүгд нарны гэрэл туссан жимсний цэцэрлэгт алтан баганатай

асарт зогсож байлаа. Дараагийн агшинд асрын дунд хайлсан алт асгаран гялалзсан бүжгийн талбай бий болоход жижигхэн цагаан бүтээлэгтэй ширээг тойрон сандал бий болж, алтан хүрэмтэй хөгжимчид тавцан дээр гарч ирлээ.

- Сайхан ажил байна гэж Рон дэмжингүй хэлэхэд эргэн тойрон гэнэтхэн мөнгөлөг тавиуртай хулууны шүүс, цөцгийний шар айраг, галт виски юмуу өөр бусад бялуу хачиртай талх барьсан үйлчлэгч нар гарч ирлээ.

- Бид явж тэдэнд баяр хүргэх хэрэгтэй байх гээд Гермиона баяр хүргэхийг хүссэн хүмүүсийн дунд алга болсон Билл, Флер хоёрыг өлмийгөө өргөн харлаа.

- Амжина гайгүй гээд Рон мөрөө хавчсанаа дэргэдүүрээ өнгөрч байсан тавиураас цөцгийний шар айрагтай гурван аяга авч нэгийг нь Харрид өглөө.

- Гермиона аваарай явж ширээ олъё ... Зөвхөн энд л биш шүү! Мюриэлээс холхон шиг!... гэв.

Рон тэргүүлэн хоосон бүжгийн талбайгаар явахдаа баруун зүүн тийшээ харж байсан нь Харрид Крамыг харж байх шиг санагдав. Тэднийг асрын нөгөө өнцөгт хүрэх үед ширээний ихэнхи хэсэг хэдийн эзэнтэй болоод хоосон байсан нэгд Полумна ганцаар сууж байлаа.

- Биднийг хамт суувал дургүйцэхгүй биз дээ? гэж Рон асуулаа.

- Мэдээж үгүй! Аав Билл, Флер хоёрт бэлгээ гардуулахаар явсан гэж баяртай хэлэв.

- Арай амьдралын турш нь грудын үндэсээр хангах юм биш биз дээ? гэж Рон сонирхов.

Гермиона түүнийг ширээн доогуур өшиглөсөн ч оронд нь Харрийг онолоо. Тэр өвдсөндөө нүдэнд нь нулимс дүүрээд цаашдын яриаг сонссонгүй.

Оркестр хөгжим тоглож эхлэв. Билл, Флер хоёр бүжгийн талбай руу түрүүлж гарахад чанга алга ташилт сонсогдон түүний араас ноён Уизли хатагтай Делакуртай, хатагтай Уизли Флерийн эцэгтэй гарлаа.

- Ямар сайхан дуу вэ гээд Полумна хөгжмийн аяар толгойгоо ганхуулж байснаа үсрэн босоод бүжгийн талбай руу очин нүдээ аниад гараа даллан байрандаа эргэлдэв.

- Тэр дажгүй байгаа биз тийм үү? Үргэлж сайн байх юм гэж Рон хэлэв.

Гэвч Полумнагийн байрыг Виктор Крам эзлэхэд түүний инээмсэглэл салхинд хөөгдсөн мэт алга болов. Гермона догдлон сандарсан ч энэ удаад Виктор түүнтэй ярьсангүй харин ууртайгаар хөмсөг зангидан,

- Энэ шаргал хувцастай хүн хэн бэ? гэлээ.

- Ксенофилиус Лавгуд манай сайн найзын эцэг нь байгаа юм гэж Рон хэлэв.

Түүний хэрүүлч өнгө өдөөн хатгасан аястай байлаа. Тэгснээ,

- Алив явж бүжиглэе гэж Гермионад ширүүн хэллээ.

Гермиона балмагдсан ч таатайгаар Роны хамт босож бүжгийн талбайн гүнд оров.

- Тэд одоо хамт байгаа юм уу? гэж Крам асуув.

- Ер нь бол тийм гэж Харри хэллээ.

- Харин чи хэн бэ?

- Барни Уизли. Тэд гар барилцлаа.

- Сонсооч Барни ... чи энэ Лавгудыг сайн мэдэх үү?

- Үгүй, зөвхөн өнөөдөр танилцсан. Тэгээд юу гэж?

Крам уух юман дээгүүрээ хэдэн шидтэнгүүдтэй бүжгийн талбайн нөгөө захад ярилцаж буй Ксенофилуис руу муухай харлаа.

- Хэрвээ тэр Флерийн зочин байгаагүйсэн бол цээжиндээ зүүсэн жигшүүртэй тэмдгийнх нь төлөө би түүнийг халз тулаанд дуудах байлаа.

- Тэмдэг гэнээ? гээд Харри бас Ксенофилиус руу харахад цээжин дээр нь хачирхалтай гурвалжин нүд гялалзав.

- Яагаад? Тэр яагаад сайн биш гэж?

- Гридевальд сайн биш байсан. Энэ бол Гриндевальдын бэлэг тэмдэг.

- Гриндевальд гэнэ ээ ... Дамблдорын дийлсэн шидтэн үү?

- Яг тийм.

Крамын юм зажилж байгаа юм шиг эрүүний булчингаа гүрэлзүүлснээ дараа нь,

- Гриндевальд олон хүнийг хөнөөсний дотор миний өвөө ч гэсэн орсон.

Мэдээж тэр танай оронд хэзээ ч хүчирхэгжиж байгаагүй Дамблдороос айдаг байсан гэж ярьцгаадаг. Хэрвээ тэр түүнийг дуусгасныг санах аваас үнэн хэлж. Гэхдээ энэ гээд хуруугаараа Ксенофилиусыг зааснаа,

- Тэмдгийг би шууд таньсан. Гриндевальд түүнийг манай сургуулийн хана дээр сийлсэн байдаг юм. Бидний дундаас түүнийг даган хуулбарлаж сурах бичиг болон хувцсан дээрээ дүрслэх тэнэгүүд олдсон гэв.

Крам ясархаг нударгаа сүрдүүлэн зангидсанаа ахин Ксенофилиус руу ууртай харлаа. Харри будилж гүйцэв. Полумнагийн эцэг Хар урлагыг дэмждэг гэдэг нь итгэмээргүй санагдсан ч энэ асарт гурвалжин дүрсийг санагдуулам өөр дүрс өөр хаана ч байсангүй.

- Харин чи ... э-э ... Гриндевальдын тэмдэг гэдэгт итгэлтэй байна уу ...?

- Би алдаагүй. Хэдэн жилийн турш дэргэдүүр нь өдөр болгон өнгөрч байсан болохоор сайн мэдэж байна гэж Крам хүйтнээр хэлэв.

- Заавал тийм байх албагүй. Ксенофилиус дүрс тэмдэг үнэн хэрэгтээ юу болохыг мэдээгүй байх. Лавгудынхан бол ... ер бусын хүмүүс. Тэр хаа нэгтээ энэ дүрсийг хараад үрчгэр эвэрт юмуу өөр юмны адил шүтэх улс.

- Юу шүтсэн гэнээ?

- Би юу болохыг нь сайн мэдэхгүй байгаа ч тэр зун охинтойгоо хамт хайсан ... Харри Полумна болон эцгийнх нь талаар муухан тайлбарласнаа мэдэв.

- Тэр түүний охин байна гээд ганцаараа бүжиглэнгээ шумуул хөөж буй аятай гараа авчиж байгаа Полумнаг заалаа.

- Тэр юу хийж байгаа юм?

- Магадгүй тархи сатаарууллагчаас ангижирах гэж байгаа байх гэж Харри шинж тэмдэгийг таниад өгүүлэв.

Крам харваас ойлгосонгүй бололтой инээх эсэхээ мэдсэнгүй. Тэр жанчин дороосоо саваагаа гарган авч ташаа руугаа заналхийлэн тогшиход үзүүрээс нь оч асгарлаа.

- Грегорович! гэж Харри чанга дуу алдав. Крам айн давхийсэн ч Харри үүнд анхаарал хандуулахтай манатай байлаа. Тэр Крамын савааг хараад Олливандер Гурван шидтэний тэмцээний өмнө анхааралтай судалж байсныг санажээ.

- Энэ чинь юу гэж байгаа юм? гэж Крам сэжигтэй асуув.

- Тэр шидэт саваа хийдэг мастер биз дээ!

- Би үүнийг мэднэ.

- Чинийхийг ч гэсэн хийсэн! Тэгээд л миний толгойд ... квиддичийн тухай санаа орж ирсэн байна.

Крамын сэжиглэл улам гүнзгийрлээ.

- Чи хаанаас миний савааг Грегорович хийсэн гэдгийг мэдээ вэ?

- Би ... магадгүй хаа нэгтээгээс уншсан байх ... спортын сэтгүүлээс. Энэ үг Крамыг тайвшируулав.

- Спортын сэтгүүлд миний савааны тухай бичсэнийг мэдсэнгүй.

- Тэгэхээр ... э-э ... Грегорович одоо хаана байна? Крамыг энэ асуулт бодлогошируулав.

- Тэр хэдэн жилийн өмнө тэтгэвэртээ гарсан. Би Грегоровичийн савааг худалдан авсан сүүлчийн хүмүүсийн нэг байсан юм. Тэр хамгийн сайн хэдий ч ... англичууд та нар Олливандер болон өөр бусад мастеруудыг дээрд үздэг болохыг мэдэж байна.

Харри хариулсангүй. Тэр Крамын адил бүжиглэж буй хүмүүсийг харж буй дүр эсгэсэн ч өөр зүйлийн тухай бодлогоширч байв. Волдеморт алдартай савааны мастерыг хайж байгаагийн учрыг холоос эрэх хэрэг байсангүй. Тэр Харриг хөөдөг шөнө саваатай нь холбоотой зүйлээс гэдэгт итгэлтэй байлаа. Түүний зээлдэн авсан галт шувууны өдөөр хийсэн саваа хугарсан бөгөөд Олливандер үүнийг яагаад гэдгийг тайлбарлаж чадаагүй юм. Магадгүй Грегорович учрыг нь илүү олох юм болов уу? Магадгүй тэр Олливандераас илүү байгаад түүний мэдэхгүй нууцыг эзэмдсэн юм болов уу?

- Хөөрхөн охин байна гэж Крам хэлэхэд Харри хуримын асар руу эргэж ирлээ.

Крам дөнгөж сая Полумна дээр очсон Жинниг зааж байв.

- Тэр бас чиний хамаатан уу?

- Тиймээ гээд Харри гэнэтхэн уурсахаа мэдэрч,

- Гэхдээ түүнд хамтрагч байгаа. Маш хартай том биетэй. Түүнийг уурлуулах хэрэггүй шүү гэв.

Крам үл тоолоо.

- Ямар гээчийн бодол вэ, дэлхий даяар квиддичийн алдартай тоглогчдыг бүх үзэсгэлэнтэй охид хөөцөлддөг биз дээ? гээд аягатайгаа хослон ширээнээс бослоо.

Түүнийг явахад Харри дэргэдүүрээ өнгөрсөн үйлчлэгчээс хачиртай талх аваад хэнтэй ч мөргөлдөхгүйн тулд бүжгийн талбайн захаар явлаа. Тэр Роныг хайн Грегоровичйн тухай ярихыг хүссэн авч тэр Гермионатай цуг хамгийн гүнд нь бүжиглэж байлаа. Харри алтан багана налаад Фред, Жорж, Ли Жордон нартай бүжиглэж байгаа Жинниг харахдаа Ронд өгсөн амлалтдаа гэмшсэн сэтгэл мэдрэхгүй байхыг хичээв.

Тэр урьд нь хэзээ ч хурим дээр байж үзээгүй ч энэ баярлаж хөөрсөн шидтэнгүүд маглуудаас ялгаатай нь хуримын бялуунаас галт хоёр галт шувуу нисэн гарах юмуу эсвэл лонхтой шампан дарс хүмүүсийн дунд тусламжгүй хөөрч байгаа гэдэгт итгэлтэй байлаа. Үдшийн бүрийн ороход дэнгийн эрвээхэй цугларан алтан дэнлүүг тойрон эргэлдэхэд хөгжил цэнгэл улам хүчтэй болов. Фред, Жорж хоёр харанхуйд удтал Флерийн хоёр үеэлтэй алга болоход Чарли, Хагрид болон тагдгар шидтэн буланд «Одо баатар» дууг дуулж байлаа.

Харри Роны согтуу өвөөгөөс зугтахын тулд хүмүүсийн дунд шургалангаа (энэ зочин Харри түүний хүү мөн эсэхийг ялгаж чадсангүй) ширээнд ганцаар суугаа хөгшин шидтэнг ажиглалаа. Түүний хөвсгөр цагаан үс нь хөгшин багваахай цэцгийг санагдуулам агаад цагаан эрвээхэйд идэгдсэн улаан малгай өмсчээ. Түүнийг яагаад ч юм таньдаг юм шиг сэтгэгдэл төрөхөд Харри тархиа ажиллуулаад гэнэтхэн Фениксийн бүлгийн гишүүн Дамблдлорын дурсамжын зохиогч Элфиас Дож болохыг танилаа.

Харри түүнд ойртов.

- Та надад суухыг зөвшөөрөхсөн болов уу?

- Мэдээж, мэдээж гэж Дож хэржигнэсэн хоолойгоор хэлэв. Харри түүн рүү бөхийгөөд,

- Ноён Дож, би Харри Поттер байна гэлээ. Дож дуу алдав.

- Хүндэт хүү минь! Артур таныг энд өөр төрхтэй байгаа гэж хэлсэн ... би их баяртай байна!

Ингээд Дож догдолсоноо чичирсээр Харрийн аяганд шампан дарс дүүргэлээ.

- Би таньд захиа бичих гэж байлаа ... Дамблдорын дараа ... цочирдол ... таны хувьд ч гэсэн итгэлтэй байна.

Дожын жижигхэн нүдэнд нулимс дүүрэв.

- Би таны «Өдөр тутмын зөнч»-д бичсэн дурсамжыг уншсан. Таныг профессор

Дамблдорыг сайн мэддэг гэж бодоогүй шүү.

- Бусдаас илүү биш гээд Дож нүдээ амны алчуураар арчлаа.

- Мэдээж би Аберфортыг эс тооцвол түүний тухай эртнээс мэддэг байсан ... гэхдээ яагаад ч юм хэн ч Аберфортыг тоож үздэггүй юм.

- Ингэхэд «Өдөр тутмын зөнч» сонин гэснээс ... би таныг харсан эсэхийг мэдэхгүй байна, ноён Дож?

- Өө, танаас гуйя хүндэт хүү минь намайг ердөө Элфиас гэхэд болно.

- Элфиас таныг Дамблдорын тухай Рита Скитерийн ярилцлагыг харсан эсэхийг мэдэхгүй байна.

Дожын царайд уур хилэн хуралдав.

- Тиймээ, Харри харсан. Энэ эмэгтэй үнэнийг хэлэхэд тас намайг түүнтэй тодорхой сэдвээр ярилцахыг хүссэн юм. Үнэнийг хэлэхэд би эцэст нь бүдүүлгээр түүнийг бусдын хэрэгт хөндлөнгөөс ордог хулд загас гэж нэрлэснээ хүлээн зөвшөөрөхөд ичгүүртэй байна. Үр дүнд нь намайг эрүүл ухаантай бус гэж гутаан доромжилсныг хараа биз дээ.

- Тэгэхээр Рита Скитер ярилцлагандаа профессор Дамблдор залуудаа хар урлагтай ороцолдож байсан гэсэн.

- Түүний нэг ч үгэнд бүү итгэ! гэж Дож даруйхан хэлээд,

- Нэг ч үгэнд нь, Харри. Таньд Альбус Дамблдорын дурсамжыг гутаах боломж бүү өг! гэв.

Харри Дожын буурьтай зовж шаналсан царай руу харснаа итгэлтэй болохын оронд урам хугарлаа. Үнэхээр Дож ийм хялбархнаар Харри итгэхгүй гэж бодоо юу? Тэр үнэхээр Харрид тодорхой мэдэх нь чухал болохыг ойлгохгүй байна гэж үү?

Харваас Дож Харрийн юу бодож байгааг тааварласан бололтой түргэн санаа тавьсан өнгөөр,

- Харри, Рита Скитер аймшигтай эмэгтэй ... гэв. Тэдний яриаг чанга хөхрөх дуу тасаллаа.

- Рита Скитер гэнээ? Өө, би түүнийг бичсэнийг үргэлж унших дуртай!

Харри, Дож хоёр харцаа өргөөд тэдний ширээний урд нагац эгч Мюриэль өд нь хазайсан малгайтай гартаа хундагатай шампан дарс барин зогсохыг харлаа.

- Тэр Дамблдорын тухай ном бичсэн биз дээ!

- Сайн уу, Мюриэль. Бид ярьж байлаа ...

- Хөөе, чи! Алив надад сандлаа өгөөдөх, би зуун долоон настай!

Уизлийн ахин нэг шаргал үстэй үеэл давхийн үсрэн босоход нагац эгч Мюриэль түүний сандлыг угз татан аваад Дож, Харри хоёрын дунд суулаа.

- Ахиад мэнд хүргэе, чамайг Барри гэдэг байх аа. Тэгэхээр та нар Рита Скитерийн тухай ярьж байсан хэрэг үү, Элфиас? Та нар түүнийг Дамблдорын намтарыг бичсэн гэдгийг мэднэ биз дээ? Би түүний номыг «Флориш Блотс»- оос захиалаад тэсэн ядан хүлээж байна!

Үүнийг сонсоод Дож барайсан ч нагац эгч Мюриэль аягатайгаа хоослоод хуруугаа чадхийлгэн дэргэдүүр өнгөрч явсан үйлчэгчийг дуудан ахин шинийг авлаа. Дараа нь тэр дарсаа том балгаад хэхэрснээ,

- Та хоёр чинь яагаад хос чихмэл мэлхий шиг хөөчихөө вэ! Альбусын шударга журмаас урьд түүний талаар маш сонирхолтой цуу яриа явж байна! гэв.

- Дотор муухайрмаар зүйл гэж Дож лууван адил улайгаад хэллээ.

- Та л тэгж ярьж байгаа юм, Элфиас гэж нагац эгч Мюрэиль тургилаад,

- Би таныг эелдэгээр дурсамждаа бүх хурц үзүүрийг нь далдалсныг ажигласан!

гэв.

- Таньд тийм сэтгэгдэл төрсөн нь харамсалтай гэж Дож хүйтнээр хэлэв.

- Өө, бүгд таны Дамблдорын шүтэн биширдэг тухай мэднэ. Зүрхэлж хэлэхэд тэр өөрийн дүү сангасваагаа дуусгасан байхад та түүнийг гэгээнтэн гэж бодсоор байх юм даа!

- Мюриэль! гэж Дож уулга алдав.

Харрийн цээжинд шампан дарстай ямар ч хамаагүй хүйт даалаа.

- Энэ чинь юу гэж байгаа юм? Та түүний дүүг сангасваа байсан гэж хэлсэн үү?

Би түүнийг өвдсөн гэж бодсон юмсан? гэж Мюриэлээс асуулаа.

- Буруу бодож, Барри! хэмээн нагац эгч түүнд сэтгэгдэл төрсөн явдалд сэтгэл хангалуун мэдэгдээд,

- Ямар ч гэсэн та энэ тухай юу ч мэддэггүй бололтой? Бүх зүйл маш олон жилийн өмнө болсон болохоор тэр үед амьдарч байсан хүмүүс ч үнэн хэрэгтээ юу болсон тухай мэддэггүй юм. Ийм учраас л би Скитерийн номыг хүлээж илүү ихийг мэдэхийг хүсч байна. Дамблдор үргэлж дүүгийнхээ талаар дуугүй байсан!

- Худал! Тэр чигээрээ худал! гэж Дож сөөнгөтөв.

- Тэр хэзээ ч надад дүүгээ сангасваа байсан гэж хэлж байгаагүй хэмээн Харри бодолгүй дуугараад өмнөхийн адил дотор нь хүйт оргисон хэвээр байлаа.

- Тэр яагаад таньд энэ тухай хэлэх ёстой гэж? гэж Мюриэль хашгирснаа Харри руу харахын тулд үл мэдэг ганхав.

- Альбусд Арианагийн тухай ярихгүй байх шатгаан байсан. Минийхээр бол энэ тодорхой байна. Тэр дүүгийнхээ үхэлд хэтэрхий гашуудсан болохоор ...

- Тэгвэл яагаад хэн ч түүнийг харж байгаагүй юм бэ, Элфиас? Яагаад бидний нэг хэсэг Ариана байдаг гэдгийг гэрээс нь авсыг нь гаргаж оршуулах хүртэл мэдээгүй юм бэ? Таны гэгээн Альбус чинь Арианаг зооринд цоожтой суулгаж байсан

биз дээ? Хогвартсад гялалзаж байх үедээ нэг ч удаа гэрт нь юу болж байгаа тухай бодож үзээгүй!

- Зооринд түгжинэ гэдэг чинь юу гэж байгаа юм? Яаж тэр вэ? гэж Харри асуулаа.

Дож ихээхэн золгүй төрхтэй болов. Харин нагац эгч Мюриэль хөхрөөд Харрид,

- Дамблдорын ээж аймшигтай эмэгтэй байсан, маш аймшигтай. Магл гаралтай ч дүр эсгэн миний сонссоноор ...

- Тэр хэзээ ч дүр эсгээгүй! Кендра гайхалтай эмэгтэй байсан гэж Дож өрөвдөлтэй шивнэсэн ч нагац эгч Мюрэиль түүнийг үл тоомсорлов.

- Түрэмгий эзэрхэг эмэгтэй байсан учир сангасваа төрсөн нь үхлээс дор хэрэг байлаа.

- Ариана сангасваа байгаагүй! гэж Дож сөөнгөтөв.

- Энэ та л тэгж хэлж байгаа юм, Элфиас. Тэгвэл тэр яагаад Хогвартст хэзээ ч сураагүй болохыг тайлбарлаадах? гэж нагац эгч Мюриэль сониучирхаад ахин Харри руу эргэлээ. Бидний хувьд сангасваа ховорхон тааралддаг юм. Түүнийг бүгдэд мэдэгдэж байснаас охиноо ертөнц дээр байхгүй юм шиг гэртээ түгжин

...

- Би тийм байгаагүй гэж хэлээд байгаа биз дээ! гэж Дож хашгирсан ч нагац эгч

Мюриэль хэтэрхий хадуурсан учир Харрид хандан ярьсаар байлаа.

- Сангасваа ихэвчилэн маглуудын сургуульд явж тэдний ертөнцөд амьдрахыг дэмждэг. Энэ нь шидтэний ертөнцөд байр эзлэхээр оролдож байснаас илүү зүйтэй хэрэг бөгөөд учир нь тэд үргэлж хоёрдугаар ангилалд ордог юм. Гэхдээ Кендра Дамблдорын толгойд хэзээ ч охиноо маглуудын сургуульд өгөх бодол орж байгаагүй ...

- Ариана бие муутай байсан. Явахыг зөвшөөрөхөд хэтэрхий эмзэг ... гэж Дож цөхрөн хэлэв.

- Гэрээс нь гаргахын аргагүй юу? гэж Мюриэль тургилаад,

- Үүнээс гадна түүнийг хэзээ ч гэгээн Мунгогийн эмнэлгт аваачиж анагаагч нарт үзүүлж байгаагүй! гэв.

- Үнэхээр гэж үү, Мюриэль та хаанаас мэдээ вэ ...

- Таньд хэлэхэд Элфиас тэр үед миний үеэл Ланселот гэгээн Мунгогоийн эмнэлэгт анагаагчаар ажилладаг байсан юм. Тэр надад Арианаг хэзээ ч тэнд хараагүй гэсэн. Бүх зүйл сэжигтэй гэж Ланселот бодож байгаа юм!

Дож нулимс дуслуулахын даваан дээр байв. Нагац эгч Мюриэль өөрөөрөө бахархаж байгаа бололтой хуруугаа чадхийлгэн ахин нэг шампан дарс шаардав. Мэгдсэн Харри Дурслийнхэн хэрхэн түүнийг шидтэн гэдгийн төлөө гэрээс гаргахгүй түгжин хэний ч нүдэнд өртүүлэхгүй байхыг хичээж байсныг саналаа. Үнэхээр Дамблдор

дүүгээ хувь заяаны эсрэг тийм тохиолдлоос болж зовоож байсан гэж үү? Үнэхээр түүнийг шидтэн биш байсны төлөө түгжиж байсан гэж үү? Түүнийг ийм хувь заяатай нь орхиод Хогвартсад гялалзсан авъяасаа үзүүлэхээр явсан гэж үү?

- Хэрвээ Кендра түрүүлж үхээгүй бол гэж нагац эгч Мюриэль ахин ярьж эхлээд,

- Би түүнийг Арианаг дуусгахыг оролдсон гэж хэлэх гэсэн юм ... гэв.

- Яаж чадаж байна, Мюриэль! Эх нь охиноо ална гэдэг чинь? Юу хэлж байгаагаа бодоод үз! гэж Дож ёолов.

- Хэрвээ санах аваас ээж нь түүнийг энэ бүх жилүүдэд цоожтой байлгаж байсан биз дээ? Гэхдээ би Кендра түрүүлж үхсэн болохоор тэгсэн гэж хэлээгүй ... хэн ч эцсийг нь хүртэл ойлгоогүй байгаа ...

- Өө, мэдээж түүнийг Ариана алсан байлгүй гэж Дож элэглэн хэлээд,

- Яагаад үгүй гэж? гэв.

- Тиймээ, Ариана чөлөөлөгдөхийг оролдон цөхөрсөн оролдого хийх үеэр Кендра алагджээ. Толгойгоо хичнээн сэгсэрсэн ч болно, Элфиас. Та чинь Арианагийн оршуулганд оролцсон биз дээ?

- Тиймээ оролцсон. Үүнээс гашуудалтай зүйлийг санаж чадахгүй юм байна.

Альбусын зүрх эмтэрсэн ... гэж Дож чичирсэн хоолойгоор дуугарав.

- Зөвхөн зүрх нь ч тэгсэн юм биш. Аберфорт түүний хамрыг хугалсан юм биш үү?

Хэрвээ одоог хүртэл Дож айдаст автаж байсаны хажууд энэ нь юу ч биш байлаа. Мюриэль түүний цээж рүү нь хутга дүрэхтэй амжилт гаргажээ. Тэр чанга инээснээ ахин шампан дарсаа залгихдаа эрүү рүүгээ гоожуулав.

- Та хаанаас ...? гэж Дож сөөнгөтөв.

- Миний ээж хөгшин Батильда Бэгшоттой найзалдаг байсан юм гэж нагац эгч

Мюриэль баяртай хэлээд,

- Батильда түүнд болсон бүх зүйл явдлыг ярих үед би хаалганы гаднаас сонсож байсан юм. Авсны хажууд зодолдсон гэсэн! Батильдагийн үгээр бол Аберфорт Арианагийн үхэлд зөвхөн Альбусыг буруутай гэж хашгираад нүүр лүү нь цохьсон гэсэн. Түүнчлэн хамгийн хачирхалтай нь Альбус биеэ хамгаалаагүй байна. Тэдний хооронд халз тулаан болсон бол Альбус Аберфортыг хоёр гараа ардаа хүлүүлсэн ч устгаж чадах байсан гэв.

Мюриэль ахин шампан дарсаа уулаа. Тэр үүнийг ярихдаа хуучны хэрүүл шуугианд хөөрсөн нь Дожоос дутуугүй аймшигтай харагдав. Харри түүний юу бодож байгааг ойлгоогүй ч үнэн хэлсэн гэдэгт итгэж байлаа. Дож зөвхөн Арианагийн эрүүл мэндийн тухай хальт мэддэг байж. Харри Дамблдорын гэрт ийм хэрцгий зүйл болж байхад оролцоогүй гэсэнд итгэх хүч байсангүй. Энэ бүх түүхэнд эргэлзээгүй ямар нэг хачирхалтай зүйл байлаа.

- Би таньд хэлсэн биз дээ гэж Мюриэль сулхан хэлээд,

- Батильда энэ бүхнийг Рита Скитерт ярьсан байх. Санаж байна уу Скитер ярилцлагадаа Дамблдорт ойрхон найдвартай эх сурвалжаас авсан гэснийг ... Бурхан минь тэр тэнд байсан болохоор Арианагийн тухай бүгдийг мэддэг байсан. Тэр бол эх сурвалж нь! гэв.

- Батильда Рита Скитертэй хэзээ ч ярихгүй! гэж Дож шивнэлээ.

- Батильда Бэгшот уу? Ид шидийн түүхийн зохиогч уу?

Энэ нэр Харрийн сурах бичгийн нэгний хавтсан дээр байдаг ч тэр хэзээ нэг цагт анхааралтай уншиж байсангүй.

- Тиймээ гэж Дож түүний асуултыг живсэн хүн хөвүүр шүүрэн авах мэт хэлээд,

- Авъяаслаг түүхч Албьсын эртний найз байсан юм гэв.

- Түүнийг одоо зөнөсөн гэж ярьж байна хэмээн нагац эгч Мюриэль хөөрөн хэлэв.

- Хэрвээ тийм бол Скитер давуу талаа ашигласан нь гутамшигтай хэрэг байна.

Батильдагийн ярианаас авах зүйл байхгүй гэж Дож хэлэв.

- Түүнийг дурсамжыг авах янз бүрийн арга бий. Тэгээд ч би Рита Скитер үүнийг эзэмшсэн гэдэгт итгэлтэй байна. Тэр ч байтугай Батильда бүрэн солиорсон байсан ч хуучны гэрэл зураг болон захиа хадгалагдан үлдсэн байж болох юм. Тэр Дамблдорыг олон жилийн өмнөөс мэдэх болохоор ... түүн рүү Годрикийн хонхорт очсон байх.

Харри цөцгийний шар айраг балгаснаа хахчихлаа. Дож түүний нуруун дээр цохиход ханиалгаснаа нулимс цийлэгнэсэн нүдээр нагац эгч Мюриэль рүү ширтэв. Эцэст нь хоолойгоо эзэмдэх үед,

- Батильда Бэгшот Годрикийн хонхорт амьдардаг юм уу? гэв.

- Өө, тэгэлгүй яахав үргэлж тэнд амьдардаг байсан. Дамблдорынхон

Персивалийг хоригдсоны дараа тэр газраас явахад хөрш нь байсан юм.

- Дамблдор бас Годрикийн хонхорт амьдарч байсан юм уу?

- Тиймээ, Барри би чамд сая энэ тухай хэлсэн биз дээ гэж нагац эгч Мюриэль шүлсээ үсчүүлэн хэлэв.

Харри дотор нь хоосрохоо мэдрэв. Зургаан жилийн туршид Дамблдор нэг ч удаа хоёул Годрикийн хонхорт амьдарч төрөл төрөгсдөө алдсан тухай ярьж байсангүй. Яагаад? Лили, Жеймс хоёрын оршуулга Дамблдорын дүү, эхийнхээс холгүй байдаг болов уу? Хэрвээ Дамблдор тэднийг эргэхээр очсон бол Харрийн эцэг эхийн булшны дэргэдүүр өнгөрсөн байх даа? Гэхдээ тэр хэзээ ч энэ тухай Харрид ярьж байсангүй ... хэлэхийг ч оролдож байсангүй.

Энэ яагаад ийм чухал болохыг Харри тайлбарлаж чадаагүй ч Дамблдор чимээгүй байсан нь худал хэлсэнтэй тэнцүү гэдэгт итгэлтэй байлаа. Тэр урагш ширтсэн ч эргэн тойрноо анхаарсангүй бөгөөд Гермиона хүмүүсийн дундаас сугаран дэргэдэх сандал дээр нь сууснуг ч анзгаарсангүй.

- Боллоо цааш нь бүжиглэж чадахгүй нь гэж тэр амьсгаадан хэлээд гутлаа тайлан өсгийгөө үрлээ.

- Рон цөцгийний шар айраг эрэхээр явсан. Хачирхалтай нь би сая Виктор

Полумнагийн эцэгтэй маргалдаж байхыг харлаа гэснээ дуугаа намсган,

- Харри чи зүгээр үү? гэв.

Харри юунаас эхлэхээ мэдээгүй ч оройтжээ. Энэ агшинд ямар нэг том мөнгөлөг зүйл бүжгийн талбайн дээгүүр хөөрөн ирээд гялалзсан шилүүс зөөлхөн газардав. Бүгдийн царай түүн рүү хандахад Патронус амаа нээн Кингсли Брустверын чанга бөгөөд гүн хоолойгоор,

- Ид шидийн яам унасан. Скримжер алагдсан. Тэд ирж байна гэлээ.

БҮЛЭГ 9: НУУГДСАН НЬ

Бүх зүйл бүдгэрэн удаашрах шиг болов. Харри, Гермиона хоёр үсрэн босоод саваагаа гаргалаа. Олонхи хүмүүс дөнгөж ямар нэг хачирхалтай зүйл болсныг ойлгосон бололтой мөнгөлөг шилүүс агаарт уусан алга болсон зүг ширтэн нам гүм хүйтэн болов. Дараа нь хэн нэгэн хашгирлаа.

Харри, Гермиона хоёр үймсэн олны дунд орлоо. Зочид тал бүр тийшээ гүйлдэн

Үүрийг хамгаалж байсан шид эвдэгдсэний улмаас ихэнхи нь шилжлээ.

- Рон! Чи хаана байна? гэж Гермиона хашгирлаа.

Тэднийг бүжгийн талбай дундуур гүйх үед Харри юүдэнтэй багтай дүрсүүд ойртон ирэхийг харж дараа нь Люпин, Тонкс хоёр саваагаа өргөөд «Протего!» гэж хашгирахыг сонслоо.

- Рон! Рон! гэж Гермиона уйлах шахам дуудахад айдаст авсан зочид тэднийг түлхэн гүйлдлээ.

Харри түүнийг алдахгүйн тулд гараас нь барихтай зэрэгцэн толгой дээгүүр нь гэрэл исгэрэн өнгөрөхөд хамгаалах шид юмуу өөр эсвэл үүнээс дор зүйл болохыг мэдсэнгүй ...

Эцэст нь Рон тэдний өмнө гарч ирэв. Тэр Гермионагийн сул гараас барихад Харри түүний байрандаа эргэхийг нь мэдрэн эргэн тойрон дуу чимээ өөрчлөгдөж харанхуйд зөвхөн Гермионагийн гарыг мэдрэн Үүрийг орхиход тэнгэрт Үхэл залгигч нисэн ирж байлаа. Эсвэл Волдеморт өөрөө ч байж болох юм ...

- Бид хаана байна? гэх Роны хоолой сонсогдов.

Харри нүдээ нээлээ. Түүнд агшин зуур хуримын цайллага дээр үлдсэн юм шиг санагдаж эргэн тойронд нь хүмүүс харагдав.

- Тотенхам-Корт-Роуд гэж Гермиона амьсгаадан хэлээд,

- Алив яваарай, бид хувцас солих газар олох хэрэгтэй байна гэв.

Харри түүний хэлснээр хийлээ. Тэднийг гүйх алхах хоёрын завсар харанхуй гудамжаар явах зуур толгой дээр нь одод анивчиж эгнэсэн дэлгүүрүүд хаалттай байлаа. Дэргэдүүр нь хоёр давхар автобус хүнгэнэн өнгөрөхөд бүлэг халамцуу хүмүүс уушийн газраас гарч ирээд талимааран ширтэв. Харри, Рон хоёр ёслолын жанчтай хэвээр байв.

- Гермиона бид ямар нэг зүйл сольж өмсөх хэрэгтэй байна гэж Рон залуухан эмэгтэй түүнийг хараад цангинатал инээд алдахад хэллээ.

- Би яагаад үл үзэгдэх цуваа авч яваагүй юм бол? гэж Харри өөрийн хичнээн тэнэг болохоо зүхэн хэлээд,

- Өнгөрсөн жилийн турш өөртэйгээ хамт авч явсан байж ... гэв.

- Бүх зүйл хэвийн би цувыг чинь та хоёрын хувцастай хамт авсан гэж Гермиона хэлээд,

- Зүгээр л байгаагаараа байж бай. Аан энд болох юм байна гэв.

Тэр тэднийг хажуугийн гудамж руу дагуулан ороод харанхуй буланд очив.

- Чи миний цувыг хувцастай хамт авсан гэсэн үү ... гээд Харри гартаа барьсан жижигхэн шүрэн цүнх рүү нь хөмсөг зангидан харлаа.

- Тиймээ энд байгаа гэж Гермиона батлаад Харри, Рон хоёрын гайхлыг төрүүлэн цүнхнээсээ хоёр хос жинс, футболка, хүрэн оймс эцэст нь мөнгөлөг үл үзэгдэх цув гаргаж ирлээ.

- Гэхдээ ямар чөтгөр нь ...?

- Үзэгдэхгүй өргөсгөх шид. Энэ хэдий хэцүү байсан ч гэхдээ би чадсан бололтой ямар ч гэсэн бүх хэрэгтэй зүйлээ дотор нь хийсэн.

Тэр цүнхийг сэгсрэхэд контейнер дотор хүнд зүйл өнхрөлдөх мэт чимээ гарав.

- Өө, чөтгөр гэж энэ номнууд л байх гээд Гермиона дотогш харж,

- Би тэднийг сэдвээр нь ялгасан байсан юмсан ... за яахав ... Харри чи үл үзэгдэх цуваа өмссөн нь дээр байх. Рон түргэн хувцаслаарай! гэлээ.

- Чи үүнийг хэзээ хийгээ вэ? гэж Харри асуухад Рон жанчаа тайлав.

- Би Үүрэнд байхдаа чамд хэдэн өдрийн өмнөөс шаардлага гарвал түргэн явахын тулд хэрэгтэй бүх зүйлээ авсан гэж ярьсан даа. Чиний үүргэвчийг өнөө өглөө гадна төрхөө өөрчилсөн хойно чинь авсан юм ...

- Чи гайхамшигтай гэдгээ мэдэх үү гээд Рон бөөрөнхийлсөн жанчаа сунгалаа.

- Баярлалаа гэж Гермиона жанчыг цүнхэндээ хийж сулхан инээмсэглээд,

- Харри, чамаас гуйж байна үл үзэгдэх цуваа өмс! гэв.

Харри үл үзэгдэх цуваа мөрөн дээгүүрээ нөмрөөд толгойгоо бүтээн алга болов. Тэр одоо л юу болсныг ойлгож эхэллээ.

- Бусад ... хурим дээр байсан хүмүүс ...

- Бидэнд одоо бусдын тухай санаа зовж байх цаг байхгүй. Тэд чиний хойноос ирсэн, Харри. Хэрвээ бид эргэж очвол бүгдийг улам аюултай байдалд оруулах болно гэж Гермиона шивнэлээ.

- Түүний зөв. Тэнд бүлгийн ихэнхи гишүүд байгаа болохор бусдадаа санаа тавьж чадна гэж Рон хэлээд Харриг маргахыг мэдсэн бололтой царай руу нь харсангүй.

Харри толгой дохисон ч найзууд нь түүнийг харсангүйд,

- Тиймээ гэлээ.

Гэхдээ тэр Жиннигийн тухай бодоход дотор нь хүчил шиг гашуун айдас хуралдлаа.

- Явъя эндээс холдсон нь дээр байх гэж Гермиона хэлэв.

Тэд эргээд хажуугийн гудамжаар орж ахин төв гудамжинд гарахад эсрэг талын явган хүний зам дээр хэсэг эрэгтэй хүн дуулан найган зогсож байлаа.

- Яагаад заавал Тотнем-Корт-Роудыг сонгосон юм бэ? гэж Рон Гермионагаас асуулаа.

- Мэдэхгүй зүгээр л толгойд ороод ирсэн юм. Гэхдээ бид маглуудын ертөнцөд аюулгүй байна гэдэгт итгэлтэй байна. Тэд биднийг энд байгаа гэж тааварлах ч үгүй.

- Яг үнэн гэхдээ жаахан ...ил юм шиг санагдахгүй байна уу? гээд Рон эргэн тойрноо харлаа.

- Өөр хаачих байсан юм? гээд Гермиона гудамжны нөгөө өнцөгт зогсож байсан эрэгтэй чанга исгэрэхэд давхийлээ.

- Бид Цоорхой тогоонд өрөө захиалж болохгүй байсан биз дээ? Гриммогийн байшингийн хувьд тэнд Снегг ирж болно ... Магадгүй эцэг эхийн минь гэрт болох ч тэндхийг шалгаж магадгүй гэж айж байна ... Өө, тэд амаа хамхидаг болоосой!.

- Хөөе, хонгор минь! Юм уухыг хүсэхгүй байна уу? Шаргал үстээ хаяад бидэн дээр хүрээд ир! гэж зам дээр байсан согтуу эрэгтэй хашгирлаа.

- Алив хаа нэг газар орж сууцгаая гэж Гермиона Роны хашгирахаар ам нээхэд хэлээд,

- Хараач ийшээ оръё! гэлээ.

Тэд жижигхэн шөнийн кафед ороход тос болсон хуванцар тавцантай ширээнүүд нь хоосон байлаа. Харри ширээнд түрүүлж суухад Рон дэргэд нь сууж Гермиона эсрэг талд нь үүд рүү нуруугаа харуулан суугаад агзасхийснээ мөрөн дээгүүрээ эргэж харав. Харрид энэ газар таалагдсангүй ч гадуур явах нь бай болох аюултай байлаа. Тэр нөмрөг дор Хувиргагч уусмалын үйлчлэл гаран хөл гар нь ердийн хэвдээ орохыг мэдрэв. Тэр халааснаасаа нүдний шилээ гарган зүүлээ.

Хоёр хормын дараа Рон,

- Бид «Цоорхой тогоо» -ноос холгүй байгааг мэдэж байна уу ... зөвхөн Чаринг-Кросс руу явахад болно гэв.

- Болохгүй, Рон! гэж Гермиона хэллээ.

- Би тэнд үлдэх ярих гээгүй байна зүгээр л юу болсныг мэдэх гэсэн юм!

- Бид юу болсныг мэднэ! Эсвэл чи Волдеморт ид шидийн яамыг эзэлснийг мэдэхийг хүсээд байгаа юм уу?

- За яахав, энэ зүгээр л санаа байсан юм!

Тэд уурсан чимээгүй болцгоов. Бохь зажилсан үйлчлэгч ирэхэд Гермиона хоёр капуччино захиалан, Харри үл үзэгдэх хэвээр байсан тул юм захиалах нь утгагүй хэрэг байлаа. Кафед хоёр том биетэй ажилчин орж ирээд хөрш ширээнд суулаа.

- Бид чимээгүй газар олоод хөдөө тийшээ шилжсэн нь дээр байх. Бид тэндээс бүлэгт илгээмж илгээж чадна гэж Гермиона аяархан хэлэв.

- Чи ярьдаг Патронусыг илгээж чадах юм уу? гэж Рон асуув.

- Би жаахан сургуулилсан болохоор болно гэж бодож байна.

- Хэрвээ бид тэднийг хүнд нөхцөлд орхиогүй байсан бол ... тэднийг хэдийн баривчлагдсан гэж бодож байна. Бурхан минь ямар гай зовлон бэ! гээд Рон хөөстэй саарал кофе уулаа.

Үйлчлэгч шинэ ирэгсэдээс захиалга авахаар ирэхэд Рон түүнийг таагүй харав. Харри ажилчдын нэг өндөр том бие цайвар үстэй нь түүнийг цаашаа яв гэж дохихыг харлаа. Үйлчлэгч доромжлогдсондоо нүд нь дүгэрэглэв.

- За тэгвэл явцгаах уу би энэ заваан юмыг уухыг хүсэхгүй байна. Гермиона чамд үүнийг төлөх маглуудын мөнгө байна уу? гэж Рон хэллээ.

- Би Үүрэнд очихын өмнө банкнаас бүх хадгаламжаа авчихсан. Зөвхөн жаахан мөнгө үлдсэн гээд Гермиона санаа алдан цүнх рүүгээ гар сунгав.

Ажилчид ижилхэн хөдөлгөөн хийхэд Харри өөрийн мэдэлгүй саваагаа зэрэг авлаа. Рон секунтын дараа юу болсныг ойлгомогц Гермионаг түлхэн сандал дээр унагахад Үхэл Залгигчийн илгээсэн шид толгой байсан газрын хананы хавтанг онон хэмхэлж Харри ажиглагдахгүй хэвээр үлдээд,

- Дөжир! гэж хашгирлаа.

Том биетэй цайвар үстэй Үхэл залгигчийн нүүр лүү улаан оч оноход ухаан алдаад хажуу тийш унав. Түүнийг нөхөр хаанаас шившлэг гарсныг ойлгоогүй бололтой Рон руу ахин нэг шившлэг илгээхэд савааны үзүүрээс гялалзсан хар олс гарч хөлөөс нь толгой хүртэл хүллээ. Үйлчлэгч орилоод кафены хаалга руу гүйхэд Харри Хөшөөх шившлэг Роныг хүлсэн Үхэл залгигч руу илгээсэн ч хачирхалтай тохиолдлоор дэргэдүүр нь өнгөрөөд цонхонд ойн үйлчлэгчийг онож хаалганы өмнө унав.

- Экспульсо! гэж Үхэл залгигч орилоход Харрийн сууж байсан ширээ дэлбэрлээ. Дэлбэрэлтийн хүч түүнийг хана руу авч чулуудаад гараас нь саваа нь мултарч цув нь гулган уналаа.

- Петрифиус Тоталус! гэж Гермиона хашгирахад Үхэл залгигч урагшаа хөшин унахдаа духаараа ширээн дээр байсан кофены аягыг цохин унаж хагалав. Гермиона чичирсээр сандал дороос гарч ирээд үсэндээ тогтсон хагархайны өөдсийг сэгсэрлээ.

- Д-диффиндо гээд тэр Рон руу саваагаа чиглүүлэхэд өвдсөндөө орилоод өвдөгний жинс нь урагдан гүн зүсэгдлээ.

- Өө, өршөөгөөрэй Рон миний гар чичирээд! Диффиндо!

Олс хэрчигдэн унахад Роны үлдсэн хэсгийг нь гараараа авч хаялаа. Харри шалан дээрээс саваагаа аваад хэмхэрсэн ширээ дээгүүр алхан цайвар үстэй Үхэл залгигчын хэвтэж байгаа сандал руу ойртлоо.

- Би түүнийг таних ёстой байж. Тэр Дамблдорыг үхдэг шөнө цамхаг дээр байсан гээд хоёр дахь Үхэл залгигчийг хөлөөрөө эргүүлэхэд нүд нь Харри, Рон, Гермиона нар луу түргэн гүйлээ.

- Долохов байна. Би түүнийг зарлалын хуудас дээр харсан юм байна. Харин хоёр дахь нь Торфинн Роули байх гэж Рон хэлэв.

- Тэдний нэр хэнд хамаатай юм! гэж Гермиона хэлээд,

- Тэд биднийг яаж олсон юм бол? Бид одоо яах вэ? гэлээ. Тэгтэл Харрийн толгойноос сандрал алга болох шиг болов.

- Хаалга түгж, Гермиона. Харин Рон гэрэл унтраа.

Тэр Долоховын мэдээ алдсан бие рүү харан бодлогоширохоод үүдний цоож түгжигдэх чимээ гарч, Рон Делюминаторoo ашиглан кафег харанхуй болголоо. Харри алсад согтуу хүмүүс энэ удаад өөр эмэгтэйг дуудаж байхыг сонсов.

- Одоо бид тэднийг яах вэ? гэж Рон харанхуйд шивнээд,

- Алах уу? Тэд биднийг алах байсан. Тэд одоо хөнгөхөн олз гэв. Гермиона чичирснээ алхам ухрав. Харри толгойгоо сэгсэрлээ.

- Зөвхөн ой санамжыг нь арчихад хангалттай. Ингэсэн нь мөр бууруулах хамгийн сайн арга. Хэрвээ алчихвал биднийг энд байсныг ойлгоно.

- Чи бидний гол хүн шүү дээ гэж Рон гүнээ санаа амран хэлснээ,

- Гэхдээ би хэзээ ч Мартуулах шившлэгийг хэзээ ч ашиглаж байгаагүй гэв.

- Би ч гэсэн. Гэхдээ онолыг нь мэднэ гэж Гермиона хэллээ.

Тэр тайвширахын тулд гүнзгий амьсгал авснаа саваагаа Долоховын дух руу чиглүүлэн,

- Март! гэлээ

Агшин зуур Долоховын нүд түргэн эргэлдсэнээ нойрмог юм шиг болов.

- Янзтай! гээд Харри Гермионагийн нуруун дээр алгадлаа.

- Одоо өөр нэгэнд нь болон үйлчлэгчид санаа тавиарай. Рон бид хоёр эндхийг цэвэрлээдэхье.

- Цэвэрлэх гэнээ? Яах гэж? гээд Рон кафены хэмхэрсэн хэсгийг харлаа.

- Хэрвээ эндхийг саяхан бөмбөг дэлбэрсэн мэт үлдээвэл тэд юу болсоныг ойлгохгүй гэж бодож байна уу?

- Аан тийм л дээ ...

Рон халааснаасаа шидэт саваагаа арайхийн гаргаж ирлээ.

- Би үүнийг шууд гаргаж чадаагүйд гайхах юм алга. Гермиона чи миний багадсан хуучин жинсийг авчихаж.

- Өө, намайг уучлаарай гээд Гермиона үйлчлэгчийг цонхноос холдуулан Ронд саваагаа далд хийх зөвөлгөө өгөх нь сонсогдов.

Тэд кафег өмнөх байдлаар нь сэргээн Хоёр Үхэл залгигчыг урьдын адил өөд өөдөөс нь харуулан суулгав.

- Тэд биднийг яаж олсон юм бол? Бидний энд байгаа гэдгийг яаж мэдэв ээ? хэмээн Гермиона асуугаад хоёр хөдөлгөөнгүй эрэгтэйг харснаа Харри руу эргэлээ,

- Чи ... чи Хяналтын шидийн дор байгаа гэж бодохгүй байна уу, Харри?

- Энэ боломжгүй. Хяналт хүнийг арван долоон нас хүрэхээр тайлагддаг хуультай болохоор насанд хүрсэн хүнд байх боломжгүй.

- Чи л тэгж бодож байгаа юм. Хэрвээ Үхэл залгигчид түүнийг арван долоон наснаас дээш хүнд ашиглах арга олсон бол яах юм?

- Гэхдээ Харри дээр сүүлчийн хорин дөрвөн цагт нэг ч Үхэл залгигч ирээгүй биз дээ.

Гермиона хариулсангүй. Харри эвгүйцэхээ мэдэрлээ. Магадгүй Үхэл залгигчид түүнийг үнэхээр тэгж олсон байвал яана?

- Хэрвээ би шид ашиглаж болохгүй бол та хоёр ч гэсэн миний дэргэд болохгүй

...

- Бид салж болохгүй! гэж Гермиона шийдэмгий хэлэв.

- Тэгвэл аюулгүй нуугдах газар хэрэгтэй. Сайтар бодож болохоор гэж Рон хэлэв.

- Гриммогийн байшин гэж Харри хэлэхэд Гермиона, Рон хоёр гайхсандаа амаа ангайлаа.

- Бүү тэнэг юм ярь, Харри тэнд чинь Снегг байгаа!

- Роны эцэг хэлэхдээ түүний эсрэг шившлэг тавьсан гэсэн ... хэрвээ үйлчилэхээ болиогүй л бол гэж Харри хэлснээ Гермионад маргах боломж өгөлгүй,

- Тэгээд юу гэж? Снеггтэй тааралдахаас илүү таатай зүйл байхгүй гэж тангарагласан ч болж байна гэлээ.

- Гэхдээ ...

- Гермиона өөр хаачина гэж? Энэ бидний хамгийн сайхан боломж. Снегг бол цорын ганц Үхэл залгигч. Хэрвээ би Хяналтын шидний дор байсан хэвээр байвал бид хаашаа ч явсан тэд ирэх болно.

Тэр маргах байртай харагдсан ч үг хэлсэнгүй. Түүнийг кафены үүдний цоожыг онгойлгох үед Рон Делюминатороо чадхийлгэн гэрэл асаав. Дараа нь тооцоогоо хийгээд шившлэгт өртсөн гурван хүнээ орхиход нойрмогдуухан хөдөлж байлаа. Харри, Рон, Гермиона нар газар дээрээ эргэлдсэнээ харанхуйд ахин алга болов.

Хормын дараа Харрийн уушиг таатай амьсгалахад нүдээ нээгээд гурвуул танил жижигхэн талбай дээр зогсож байлаа. Тэдний эргэн тойронд хэмхэрхий нурсан барилгууд сүндэрлэнэ. Тэд арван хоёрдугаар байшинг хараад яаран зүглэхдээ араасаа хүн дагаж буй эсэхийг шалгав. Гурвуул чулуун гишгүүрээр өгсөхөд Харри үүдний хаалгыг саваагаараа тогшив. Тэгтэл төмөр цоож шархийх чимээ гарснаа хаалганы гинж хангинан чахран онгойход босгоор яаран орлоо.

Харриг хаалга хаах үед хуучин загварын тосон дэнлүү үүдний танхимыг гэрэлтүүлэв. Эндхийн бүх зүйл Харрийн санаж байсанчлан аймаар эвгүй, аалзны тороор дүүрсэн, ханан дахь үйлчлэгч нарын толгойноос шатан дээр хачирхалтай дүрс тусаж харагдана. Урт хар хөшигний цаана Сириусын ээжийн хөрөг байлаа. Цорын ганц дадал болоогүй зүйл гэвэл савдгийн хөлний хэмжээтэй шүхэр Тонкс ахин бүдэрч унасан мэт хажуулдан хэвтэнэ.

- Хэн нэгэн энд байсан бололтой гэж Гермиона түүнийг заан шивнэв.

- Эсвэл бүлэг эндээс явахдаа унагасан байж болох юм гэж Рон бувтналаа.

- Тэгвэл Снеггийн эсрэг шид хаа байгаа юм бол?

- Магадгүй зөвхөн түүнийг ирэхэд ажилладаг байх? гэж Рон хэлэв. Тэд цааш явахаас эмээн үүдний хивсэн дээр нуруугаа нийлүүлэн зогслоо.

- За яахав энд үүрд зогсолтой нь биш гээд Гермиона урагш алхав.

- Северус Снегг үү? гэж шивнэх Хурц нүдэт Грюмын хоолой харанхуйгаас дуулдахад гурвуул айн ухрав.

- Бид Северус биш! гэж Харри хэлсэн ч ямар нэг хүйтэн агаар сэнгэнэн хэл нь ээдрэн сөөнгөтөв. Тэр амандаа хэлээ мэдрэхээс урьтаж ахин ярих чадвартай боллоо.

Хоёр найзад нь ч гэсэн таагүй сэтгэгдэл төрсөн бололтой. Рон хий огиулахад

Гермиона ээрэн,

- Энэ м-магадгүй Хурц Нүдэтийн Снеггийн эсрэг хийсэн х-хэл хөшөөдөг шившлэг байх! Гэв ...

Харри урагш болгоомжтой алхав. Тэгтэл үүдний танхимын төгсгөлд ямар нэг зүйл сүүмэлзэн үг хэлж амжихаас урьтаж тоостой хивснээс аймшигтай дүрс босож ирлээ. Гермиона чанга хашгирахад хатагтай Блэкийн хөрөгний хөшиг нээгдэв. Харин саарал дүрс тэдний зүг бүсэлхий хүрсэн урт үс сахлаа намируулан ойртоход хөнхөр царай, хоосон нүдний ухархай бүхий танил айдас хүрэм өөрчлөгдсөн тэрбээр гараа өргөн Харриг заалаа.

- Үгүй! гэж Харри хашгираад саваагаа өргөсөн ч толгойд нь ямар ч шившлэг орж ирсэнгүй.

- Үгүй! Бид биш! Бид таныг алаагүй ...

Алаагүй гэдэг үгийг сонсоод дүрс дэлбэрч тоостой саарал үүл босов. Харри ханиалгаад нулимстай нүдээр харвал Гермиона хаалганы дэргэд толгойгоо гарааараа даран суугаад Рон хөлөөсөө толгой хүртлээ чичирсээр мөрийг нь эв хавгүйхэн илж,

- Бүх зүйл х-хэвийн ... тэр я-явчихсан гэв.

Эргэн тойрон манан адил тоос бужигнахад тосон дэнлүүний бүдэг гэрэлд хатагтай

Блэк,

- Бохир цустангууд, зэвүүн гутамшигтай амьтад, миний эцгийн гэрийг бузарлаж зүрхэлнэ гэнээ хэмээн хашгирав.

- Амаа тат! гэж Харри зандраад саваагаа зангахад тасхийн улаан оч гялсхийж хөшиг ахин хаагдан хатагтай Блэк чимээгүй боллоо.

- Энэ ... энэ ... гэж Гермиона гонгиноход Рон түүнд босоход туслав.

- Тиймээ гэхдээ жинхэнэ биш байгаа биз дээ? Зөвхөн Снеггийг айлгахын тулд юм байна гэж Харри хэлэв.

«Хэрвээ энэ ажилласан бол Снегг хэдийн аймшигт дүрсийг Дамблдорыг алсан шигээ дэлбэлсэн болов уу?» гэж Харри бодоод зоригоо хөвчлөн цааш явахдаа ямар нэг аймшигтай зүйл дайрахыг хүлээсэн ч юу ч болсонгүй бөгөөд зөвхөн банзан хавтангийн цаана хулгана часхийн дуугарна.

- Цаашаа явахаас өмнө шалгасан нь дээр гэж бодож байна гэж Гермиона шивнээд саваагаа өргөн,

- Хоменум ревелио! гэв. Юу ч болсонгүй.

- Чи саяхан гүн цочирдолд орсон. Юу хийх гэсэн юм? гэж Рон элдэгээр асуув.

- Би хүссэн зүйлээ хийсэн! гэж Гермиона уцаарлан хэлээд,

- Энэ шившлэг өөр хүнийг илрүүлдэг юм. Энд биднээс өөр хэн ч алга! гэв.

- Биднээс гадна тоос гээд Рон саяхан хүүр босож ирсэн хивс рүү харлаа.

- За явцгаая гээд Гермиона бас айсан шинжтэй хивс рүү харснаа шат чахруулан өгсөж хоёр давхрын зочны өрөө рүү оров.

Тэр саваагаа даллан хуучин тосон дэн асаагаад үл мэдэг дагжсанаа буйдан дээр элгээ тэврэн суулаа. Рон цонх руу очиж хүнд хилэн хөшгийг сөхөж харав.

- Юу ч харагдахгүй байна. Хэрвээ Харри Хяналтын шидний дор байсан бол тэд бидний араас ирэх байсан. Байшинд орж чадахгүйг нь мэдэж байгаа ч ... Юу болоо вэ? Харри.

Харри өвдсөндөө хашгираад сорви нь ахин халуу шатаж нүдний урд хурц гэрэл гялсхийв. Тэр том хар сүүдрийг хараад уур хилэндээ бие нь цахилгаан тогоор цохиулсан мэт чичирч байхыг мэдэрлээ.

- Чи юу хараа вэ? Тэр манай гэрийг олж уу? гэж Рон асуув.

- Үгүй, би ердөө уур хилэнг нь мэдэрч байна ... тэр аймшигтай уурлаж байна ...

- Магадгүй Үүрэнд байх даа. Эсвэл өөр газар юм уу? Чи өөр зүйл харсан уу?

Тэр хэн нэгнийг зовоож байна уу?

- Үгүй би зөвхөн уур хилэнг мэдэрч байна ... өөр зүйл хэлж чадахгүй нь ... Харри дарамтанд орохоо мэдрэхэд Гермиона айсан хоолойгоор,

- Ахиад л чиний сорви уу? Юу болоо вэ? Би та хоёрын холбоо хаагдсан гэж бодсон юмсан? гэв.

- Түр зуур гэж Харри бувтнахад сорви нь өвдөж төвлөрөхөд саад болов.

- Би ... түүнийг биеэ хянах чадвараа алдах үед ахин холбогдсон гэж бодож байна.

- Гэхдээ чи түүнээс оюун ухаанаа хаах ёстой! Харри Дамблдор чамайг энэ холбоог ашиглахыг хүсээгүй. Чамайг окклюменцийд сурч хаахыг хүч байсан!

- Тэгээд ч Волдеморт чиний ухаанд нэвтэрч хуурамч дүрс үзүүлснийг бүү мартаарай ...

- Тиймээ, би санаж байна баярлалаа гэж Харри шүд зуун хэлэв.

Тэр түүний хэлсэн хэлээгүй энэ холбооны тусламжтай Волдеморт түүнийг занганд оруулан Сириусын үхлийн шалтгаан болсон гэдгийг мэдэж байлаа. Тэр найзуудыгаа Волдеморт цонхоор шагайж байгаа мэт айлгаснаа хараад ийм зүйл хэлсэндээ харамслаа.

Сорви нь лугшин өвдсөн хэвээр байсанд хананд өлгөөтэй байгаа Блэкийн гэр бүлийн модны зургийг харах гэж буй мэт дүр үзүүлэн тэднээс эргэлээ. Тэгтэл Гермиона часхийн орилов. Харри саваагаа аваад огцом эргэн хартал зочны өрөөний цонхоор мөнгөлөг Патронус хөөрөн орж ирээд шалан дээр газардан Артур Уизлийн хоолойгоор,

Гэр бүл аюулгүй байдалд байна, бүү хариулаарай биднийг мөрдөж байгаа гэлээ. Патронус агаарт уусан алга болов. Рон гаслах дуу гарган ёолоод буйдан дээр лагхийн

суулаа. Гермиона дэргэд нь суун гарыг нь атгаад,

- Тэдний бүх зүйл сайн, бүх зүйл хэвийн! гэж шивнэхэд тэрбээр инээвхийлэн тэвэрлээ.

- Харри би ...

- Асуудалгүй дээ. Энэ чиний гэр бүл болохоор чи мэдээж түгших нь ойлгомжтой. Би ч гэсэн адил зүйл мэдэрч байна гээд Жиннигийн тухай бодсоноо,

- Тиймээ яг ийм зүйл мэдэрч байна гэв.

Өвдөлт оргилдоо хүрч Үүрний гадаа цэцэрлэгт байсан үеийнх шиг болов. Тэр

Гермионагийн,

- Би ганцаараа үлдэхийг хүсэхгүй байна. Унтлагын хөнжлөө авчраад энд хоноцгооё гэж хэлэхийг сулхан сонслоо.

Рон түүнд зөвшөөрсөн хариу хэлэхэд Харри өвдөлтөө цаашид тэвчих хүчгүй болоод,

- Би угаалгын өрөөнд орлоо гэж бувтнаад зочны өрөөнөөс гарахдаа бүх хүчээ гарган гүйхгүй байхыг хичээв.

Тэр арай ядан угаалгын өрөөнд хүрээд чичирсэн гараараа хаалга хаагаад зовж шаналсандаа толгойгоо цохин шалан дээр унаж атиралдахад бусдын уур сэтгэл санааг нь эзэмдэж ханан зуухнаас гэрэл гарч байгаа урт өрөөнд том бие цайвар үстэй Үхэл залгигч тарчлан хаширч дээрээс нь дүрс бөхийн зогсох нь үзэгдээд саваагаа сунгахад Харри өрөвдөх сэтгэлгүй хүйтэн хоолойгоор ярилаа.

- Роули эсвэл чи бид чамаар Нагайна тэжээхийг хүсээд байгаа юм уу? Лорд Волдеморт энэ удаад өршөөхдөө итгэлтэй биш байна ... Чи намайг ийшээ Харри Поттер ахин зугтсан гэдгийг хэлэхээр дуудаа юу? Драко Роулид ахин нэг удаа биднийг таагүй байдлыг амсуулаад өг ... Эсвэл чи өөрөө миний уур хилэнг мэдэрмээр байна уу!

Зуухнаас түлээ унахад дөлний гэрэл айдас дүүрэн царайг гийгүүлж Харри гүнзгий уснаас гарах мэт болоод нүдээ нээн амьсгаадав.

Тэр хүйтэн хар гантиг шалан дээр сунан хэвтээд хамраас нь хэдхэн инчийн урд мөнгөн могойтой том угаалгын онгоц байлаа. Харри өндийн суулаа. Малфойн туранхай айж мэгдсэн царай нүдэнд нь харагдсаар байв. Тэр Волдемортын Драког ашиглах арга олсон явдалд дотор нь муухайрлаа.

Тэгтэл хаалга чанга тогших чимээ гарахад давхийн цочоод Гермионагийн хоолойг сонслоо.

- Харри чамд шүдний сойз хэрэггүй биз? Би аваад ирлээ.

- Тиймээ, сайн байна баярлалаа гэж тэр ердийн хоолойгоор дуугарахыг хичээгээд хаалга онгойлгохоор бослоо.

БҮЛЭГ 10: КИКИМЕРИЙН ЯРИА

Маргааш өглөө нь Харри эрт сэрэхэд зочны өрөөнд унтлагын хөнжилтэй хэвтэж байв. Хөшигний завсраар үүр хагацахын өмнөх хүйтэн харанхуй тэнгэр харагдана. Нам гүмийг Рон, Гермиона хоёрын удаанаар амьсгалах чимээ эвдэх аж. Харри дэргэдээ хэвтэж байгаа найзуудынхаа хар дүрс рүү харлаа. Рон уужим сэтгэл гарган Гермионаг буйдангийн дэртэй унтахыг шаардсан учир одоо түүний дэрээс тонгойно. Түүний гар шалан дээр Роны хуруунаас хэдхэн дюймийн зайд байсанд Харри тэдний гараасаа барьж унтсан эсэхийг гайхлаа. Тэгтэл энэ нь түүнд хачирхалтай ганцаардсан мэдрэмжийг төрүүлэв.

Тэр харанхуй адрын аалзны шүлсэнд хучигдсан бүрхүүл рүү ширтлээ. Хорин дөрвөн цагийн өмнө тэр нарны гэрэлд асрын үүдэн дээр зогсоод хуримын зочдыг хүлээн авч байсан. Гэтэл одоо үүний хооронд бүхэл бүтэн амьдрал өнгөрсөн шиг санагдав. Тэдэнд одоо ямар байгаа бол? Тэр хэвтээд крестражын тухай, Дамблдорын даалгасан айдас хүрэм хэцүү даалгаварын тухай бодлоо ...

Дамбдорын үхэлд гашуудаж байсан явдал одоо өөр болжээ. Тэр хурим дээр Мюриэлийн буруутгалыг сонсоод шүтдэг шидтэнийх тухай дурсамжыг гутаасан явдалд сэтгэл өвдсөн билээ. Дамблдор үнэхээр ийм зүйл тохиолдож байхад тайван хандсан гэж үү? Үнэхээр Дадли хүртэл ямар ч доромжлолтой эвлэрэхэд бэлэн байхад түүнд хамаагүй байсан хэрэг үү? Тэр үнэхээр дүүгээ хүмүүсээс нуун цоожтой байлгаж байсан гэж үү?

Харри Годрикийн хонхор болон Дамблдорын нэг ч удаа дурсаагүй булшны тухай, ямар ч тайлбаргүй нууцлаг зүйл гэрээслэн үлдээсэн тухай бодтол гомдоллох сэтгэл төрлөө. Дамблдор яагаад түүнд юу ч хэлээгүй юм бол? Яагаад юу ч тайлбарлаагүй юм бол? Эсвэл зөвхөн түүнд зэвсэг адил хандан хэзээ ч итгээгүй юм болов уу?

Тэр зочны өрөөний шалан дээр цаашид гашуудалтай бодолтойгоо хэвтээд байж чадсангүй. Ямар нэг зүйл хийж сатаарах цөхөрсөн хүсэл төрөхөд унтлагын хөнжлөөс босоод саваагаа аваад зочны өрөөнөөс чимээгүйхэн гарлаа. Шатны талбай дээр

«Люмос» гэж шивнээд савааны гэрлээ тусган өгсөж эхлэв.

Хоёр давхарт Роны хамт энд хамгийн сүүлд унтаж байсан унтлагын өрөө байсанд түүгээр шагайлаа. Хувцасны шүүгээний хаалга нээлттэй цагаан хэрэглэл асгарчээ. Харри нэг давхарт харсан савдагийн хөлний тухай саналаа. Хэн нэгэн энэ газар бүлгийг орхисны дараа юм хайсан байх нь. Снегг юм болов уу? Эсвэл Наземникус Сириусын үхлийн дараах шиг юм хулгайлахаар ийшээ ирээ юу? Харри Сириусын өвөг эцэг болох Финеас Найжелус Блэкийн байсан хөрөг рүү харахад хоосон бөгөөд зөвхөн бохир арын фон үлджээ. Харваас Финеас Найжелус энэ шөнийг Хогвартсын захирлын өрөөнд өнгөрүүлэхээр шийдсэн нь илт.

Харри ахин дээшээ өгсөж шатны хамгийн дээд талын зөвхөн хоёр хаалга байдаг талбайд хүрлээ. Нэгэн дээр нь «Сириус» гэсэн бичиг байв. Харри загалмайлсан эцгийнхээ унтлагын өрөөнд урьд нь хэзээ ч орж байсангүй. Тэр аль болох сайн гэрэлтүүлэхийн тулд саваагаа өргөөд түлхлээ.

Өрөө уужим цэлгэр хэдий ч урьдын сүр жавхлангаа алджээ. Сийлбэртэй модон толгой бүхий том ор, урт хилэн хөшгөөр бүтээсэн өндөр цонх, зузаан тоос дарсан лааны бүрхүүл дээрээс хайлсан тос урсан хатжээ. Орны толгойн ханан дээр тоосонд хучигдсан зургууд байлаа. Лааны бүрхүүл болон хувцасны модон шүүгээн дээгүүр аалз гүйлдэж, өрөөний гүнд орох үед хулгана час хийх чимээ сонсогдлоо.

Өсвөр насны Сириус ханан дээгүүр олон тооны зурагт хуудаснууд наасан мөнгөлөг саарал хана дөнгөж цухуйж үзэгдэнэ. Харри Сириусын эцэг эх тэднийг ханан дээр тогтоож байгаа Үүрд мөнхийн шидийг тайлж чадаагүй юм болов уу гэж бодлоо. Учир нь тэд харваас хүүгийнхээ сонирхлыг дэмжихээргүй байв. Сириус харваас эцэг эхээ яаж уурлуулахаа мэддэг бололтой. Энд Сириусын гэр бүлийнхэн бүгд Слизеринийг төгссөнийг үл харгалзан хэд хэдэн өнгө нь гандсан алтлаг улаан Гриффиндорын далбаа байлаа. Ихэнхи зураг дээр маглуудын мотоциклийн зураг байж, зарим дээр нь маглуудын охидын усны хувцастай зураг байлаа. Тэдгээр хөдөлгөөнгүй инээмсэглэн нүд нь гялалзсан зургуудын дэргэд цорын ганц шидэт зураг болох Хогвартсын сурагчид гэрэл зургийн дурангийн өмнө өмнө гар гараасаа бариад инээлдэн зогсох зураг байлаа.

Харри эцгээ таниад сэтгэл нь догдлов. Түүний хар үс яг л Харрийн адил арзайсан бөгөөд бас шил зүүжээ. Дэргэд нь царайлаг хайхрамжгүй Сириус зогсоод үл ялиг бардам царай нь ихэд залуухан Харрийн санаж байсан шиг хөгжилтэй байлаа. Сириусын баруун талд зогсч байсан Петтигрю мөрөнд нь арай хүрэхээргүй намхан бөгөөд сургуулийн хамгийн үймээн тарьдаг бүлэг болох шүтэн биширдэг Жеймс, Сириус нарын хүмүүстэй нийлж байгаадаа усархаг нүдээ баяртай гялалзуулан зогсож байлаа. Жеймсийн зүүн талд Люпин зүдэнги төрхтэй зогсчээ ... Эсвэл Харри түүнийг тийм байсныг мэддэг болохоор тэгж санагдсан юм болов уу? Тэр эцсийн эцэст Сириусын өв залгамжлагч болохоор зургийг авахыг хичээлээ. Гэвч зураг байрнаасаа хөдөлсөнгүй. Сириус эцэг эхдээ өрөөгөө шинэчлэх ямар ч боломж өгөөгүй бололтой.

Харри шал руу харлаа. Гадаа тэнгэр гийхэд цаас, ном болон бусад хивсэн дээр асгарсан жижиг сажиг зүйлс ялгагдан үзэгдэв. Харваас хэн нэгэн Сириусын унтлагын өрөөнд бас нэгжлэг хийсэн бололтой хэд хэдэн номыг бүдүүлгээр онгичин хаясан нь хуудас нь нээлттэй шалан дээр хөглөрнө.

Харри бөхийгөөд шалан дээрээс хэдэн хуудас авч харлаа. Нэг нь Батильда Бэгшотын

«Ид шидийн түүх»-ийн хуудас байсан бол нөгөө дээр нь мотоцикль жолоодох гарын авлага байлаа. Гурав дахь дээр нь гараар бичсэн байсанд Харри тэнийлгэн уншив.

Хүндэт Тэнүүлч ээ!

Харрид төрсөн өдрийн бэлэг илгээсэн явдалд чамд их баярлалаа! Тэр түүний хамгийн дуртай зүйл байх болно. Тэр ердөө нэг ойтой хэдий ч чиний тоглоомон шүүрээр нисэж сураад ямар баяртай байгааг хавсаргасан зурган дээрээс хараарай. Чиний мэдэж байгаачлан шүүр газраас ердөө хоёр футын өндөрт нисдэг ч Харри мууpаа алах шахан Петунья эгчийн зул сараар илгээсэн аймшигтай ваарыг хагалсан (үүнд гомдоллох явдал байхгүй). Мэдээж Жеймс энэ бүхнийг хөгжилтэйгээр хүлээн

авч хүүг квиддичийн агуу тоглогч болно гэж ярьж байгаа. Гэхдээ бидэнд бүх гоёл

чимэглэлийн зүйлсээ түүний замаас холдуулан эмхлэх хэрэг гарч гэр дотуур нисэх үед нь нүд салгахгүй харж байгаа.

Төрсөн өдөр маш чимээгүй өнгөрсөн бөгөөд бидэн дээр хөгшин Батильда зочлон ирсэн. Бид чамайг ирж чадаагүйд ихэд харамсаж байгаа ч мэдээж бүлгийн ажил чухал болон түүнчлэн Харри төрсөн өдөр нь гэдгийг ойлгохооргүй бяцхан байна! Жеймс энд цоожтой сууж байгаадаа бухимдаж хэдийгээр үүнийгээ нуухыг хичээж байгаа ч би харж байна. Бас Дамблдор түүний үл үзэгдэх цувыг эргүүлж өгөөгүй байгаа болохоор ойр зуур гарах боломж байхгүй юм. Хэрвээ чи бидэн дээр зочилвол түүнийг ихэд баярлуулна даа. Өнгөрсөн амралтын өдөр бидэн дээр Сүүлт ирээд Маккинноновын тухай мэдээ авчирсан. Би түүний оройжингоо уйлахыг сонссон.

Батильда бидэн рүү бараг өдөр бүр ирж байгаа. Тэр гайхамшигтай хөгшин болохоор Дамблдорын тухай сонирхолтой зүйлс ярьсан ч түүнийг энэ тухай мэдвэл баярлахгүй байх гэж бодож байна. Үүнд итгэх эсэхээ мэдэхгүй байгаа ч Дамблдорт яагаад ч юм итгэмээргүй зүйлс байх шиг ...

Харрийн хөл гар хөшлөө. Тэр хөдөлгөөнгүй зогсоод гартаа барьж байгаа гайхалтай хуудсыг харахад дотор нь уй гашуу баяр хөөр холилдон төрлөө. Тэр хүндхэн орон дээр суулаа.

Тэр захиаг ахин нэг удаа уншаад ямар ч шинэ сэтгэгдэл төрсөнгүйд бичгийн хэв рүү нь харлаа. Ээж нь «Г» үсгийг түүнтэй адилхан тавьж. Харри захианы үсэг бүр рүү харах тусмаа сэтгэл нь улам догдолж байлаа. Захиа Лили Поттер амьдарч байсан, үнэхээр энэ дэлхий дээр амьдарч байсан гэдгийн баталгаа болсноороо итгэмээргүй эрдэнэс байлаа. Түүний дулаахан гар энэ цаасан дээр эдгээр үсэг, үг түүний тухай, Харригийн тухай, хүүгийнхээ тухай бичжээ.

Тэр яаран нүднийхээ нулимсыг арчаад захиаг ахин уншихдаа энэ удаад бүрэн төвлөрөхөд яг л дуу хоолойг нь сонсож байгаа юм шиг болов.

Түүнд муур байж ... магадгүй эцэг эхийнх нь адил Годрикийн хонхорт үхсэн байх даа ... эсвэл тэжээх хүнгүй болоод зугтсан биз ... Сириус түүнд хамгийн анхны шүүрийг нь авч өгч ... эцэг эх нь Батильда Бэгшотыг мэддэг байж магадгүй тэднийг Дамблдор танилцуулсан юм болов уу? Дамблдор түүний үл үзэгдэх цувыг эргүүлж өгөөгүй байгаа болохоор ... Харин энд л хачирхалтай зүйл байлаа ...

Харри эхийнхээ үгний тухай бодлоо. Дамблдор яагаад Жеймсийн үл үзэгдэх цувыг авсан юм бол? Харри урьд нь захирлынхаа «Надад үзэгдэхгүй болоход үл үзэгдэх цув хэрэггүй» гэж хэлснийг сайн санаж байлаа. Эсвэл бүлгийн өөр нэг авъяаслаг гишүүнд шаардагдаад тэр зөвхөн өгөхийг гуйсан юм болов уу? Харри цааш нь уншлаа.

Бидэн дээр сүүлт ирсэн ... Петтигрю урвагч. Магадгүй тэр сүүлчийн удаа Лили, Жеймс хоёрыг амьд харж байгаа гэдгээ мэдэж байсан байх.

Ингээд эцэст нь Батильда Дамблдорын тухай сонирхолтой зүйслийг ярьж ...

Дамблдорт ямар нэг итгэмээргүй зүйл байх шиг ...

Дамблдорт юу байсан юм бол? Гэхдээ Дамблдорт итгэмээргүй санагддаг олон зүйл байлаа жишээлбэл тэр хувиргалын шалгалтан дээр хамгийн доод оноо авсан, Аберфорт ямаан дээр шившлэг хэрэглэсэн гээд л ...

Харри босож шалан дээр захианы төгсгөл байгаа эсэхийг анхааралтай харлаа. Тэр цаасыг бариад жинхэнэ эхийг нь олохыг хичээн шургуулга татаж, ном сэгсрэн, сандал дээр зогсон шүүгээний дээд талын хэсгийг нэгжин, ор болон сандал доогуур шагайж үзэв.

Эцэст нь шалан дээр нүүрээ наан хэвтэн байж шүүгээн дороос Лилийн захиандаа дурьдсан урагдсан зурагны хэсгийг олов. Зурган дээр хар үстэй хүү чанга хөхрөн жижигхэн шүүрэн дээр нисээд харваас Жеймсийн бололтой хоёр хөл араас нь хөөж байлаа. Харри зургийг халаасандаа хийгээд үргэлжлүүлэн эрлээ.

Арван таван хором эрэл хийсэн ч эхийнх нь захианы төгсгөлийн хэсэг олдсонгүй. Тэр зүгээр л арван зургаан жилийн өмнө урагдсан эсвэл унтлагын өрөөнд орсон эхний хүн авсан юм болов уу? Харри ахин захиаг уншаад хоёр дахь хэсгийн учрыг олохыг хичээв. Тоглоомон шүүрний тухай түүх Үхэл залгигчидын сонирхлыг татах байсан. Түүнд байгаа ганц боломж гэвэл Дамблдорын тухай мэдээлэл байлаа. Дамблдорт ямар нэг итгэмээргүй зүйл байх шиг ... Юу юм бол?

- Харри! Харри! Харри!

- Би энд байна! Юу болоо вэ?

Шатан дээр хөлийн чимээ гараад Сириусын унтлагын өрөөнд Гермиона нисэн орж ирлээ.

- Бид сэртэл чи хаа ч байдаггүй! гэж тэр амьсгаадан хэлээд цаашаа эргэж,

- Рон! Оллоо! гэж хашгирав.

- Сайн байна! Түүнд миний өмнөөс ямаа гэдгийг нь хэлээрэй! гэсэн Роны ууртай хоолой дороос сонсогдов.

- Харри гуйя, ингэж битгий алга болоорой бид их айлаа! Ингэхэд чи яах гэж ийшээ ирээ вэ? гээд тэр өрөөг харж,

- Энд юу хийсэн юм бэ? гэлээ.

- Хараач би юу олсныг.

Тэр эхийнхээ захиаг сунгав. Гермиона захиаг авч уншихад Харри түүнийг харж байлаа. Тэр хуудасны төгсгөл хүртэл уншаад дээшээ харан,

- Өө, Харри минь дээ ... гэв.

- Бас энэ байна.

Тэр урагдсан зургыг сунгахад Гермиона шүүрэн дээрх хүүг харж инээмсэглэв.

- Би захианы төгсгөлийг хайсан ч байгаагүй. Гермиона эргэн тойрноо харлаа.

- Чи энд юм нэгжсэн хэрэг үү?

- Хэн нэгэн надаас өмнө өрөөг нэгжсэн байсан.

- Би тэгж бодсон юмаа. Миний шагайсан өрөөнүүд бас адилхан замбараагүй байсан. Чинийхээр бол тэр юу хайсан юм бол?

- Хэрвээ энэ Снегг байсан бол бүлгийн тухай мэдээлэл хайсан байх.

- Гэхдээ тэр бүлэгт байсан юм чинь хэрэгтэй бүх зүйл нь байгаа гэж бодохгүй байна уу?

- За яахав тэгвэл Дамблдорын мэдээллийн тухайд яах болж байна? Тэд жишээлбэл энэ захианы төгсгөлийг хайсан ч юм билүү. Ингэхэд чи миний ээжийн дурьдсан Батильдаг мэдэх үү?

- Хэн юм?

- Батильда Бэгшот зохиогч ...

- Ид шидийн түүхийн гэж Гермиона сонирхон хэлээд,

- Эцэг эх чинь түүнийг мэддэг байсан юм уу? Тэр гайхамшигтай түүхч байсан гэлээ.

- Тэр одоо хүртэл амьд байгаа Годрикийн хонхорт амьдардаг юм. Роны нагац эгч Мюриэль түүний тухай хурим дээр ярьсан. Батильда бас Дамблдорын гэр бүлийг мэддэг юм билээ. Түүнтэй ярилцвал сонирхолтой байх даа?

Гермионагийн инээмсэглэл хэтэрхий ойлгосон төрхтэй байсан нь Харрид таалагдсангүй. Тэр захиа болон зургийг буцааж аваад хүзүүндээ зүүсэн хүүдийд хийлээ.

- Би чамайг яагаад Батильдатай эцэг эх болон Дамблдорын тухай ярихыг хүсч байгааг ойлгож байна. Гэхдээ энэ крестражыг эрэхэд бидэнд юугаар ч туслахгүй биз дээ? гээд түүний хариулсангүйд үргэлжлүүлэн,

- Харри би чамайг Годрикийн хонхорт очихыг хүсч байгааг мэдэж байгаа ч ... өчигдөрийнх шиг Үхэл залгигчид биднийг олох вий гэж айж байна. Эцэг эхийн чинь оршуулга дээр л тэд чамайг гарцаагүй хүлээж байгаа гэлээ.

- Зөвхөн тэдний тухай биш гэж Харри түүний нүд рүү харахгүйг хичээн хэлээд,

- Хуриман дээр Мюриэль Дамблдорын тухай олон зүйл ярьсан. Би үнэнийг мэдмээр байна ... гэв.

Ингээд тэр Гермионад Мюриэлээс сонссон бүх зүйлээ ярилаа. Түүнийг яриагаа дуусгах үед Гермиона,

- Мэдээж би чамайг яагаад сэтгэлээр унасныг ойлгож байна, Харри ... гэв.

- Сэтгэлээр унаагүй. Би зүгээр л үнэнийг нь мэдэхийг хүсч байна ...

- Харри чи үнэхээр жигшүүртэй Мюриэль юмуу Рита Скитерээс үнэнийг сонсож болно гэж бодоо юу? Чи яаж тэдэнд итгэж чадаж байна аа? Чи Дамблдорыг мэднэ биз дээ!

- Мэднэ гэж бодсон юмсан гэж бувтналаа.

- Гэхдээ чи Рита бүгдэд чиний тухай хэр үнэн зүйл бичсэнийг мэдэж байгаа биз дээ! Дожын зөв. Чи эдгээр хүмүүст Дамблдорын тухай дурсамжыг гутаах боломж өгч болохгүй.

Харри түүний харцнаас зайлсхийн хажуу тийш харав. Ахиад л итгэх хэрэгтэйгээ сонгох хэрэгтэй боллоо. Тэр итгэхийг хүсч байна. Яагаад хүн бүр түүнээс ингэж шаардаад байгаа юм бол?

- Гал зуух руу явах уу? Ямар нэг өглөөний цай уухаар зүйл ольё гэж Гермиона хэсэг дуугүй байсныхаа дараа хэлэв.

Харри дургүйхэн зөвшөөрөөд шатны талбайгаар даган явахдаа хоёр дахь хаалганы дэргэдүүр өнгөрлөө. Тэнд будаг нь ховхорсон жижигхэн хаяг байсныг харанхуйд анзааралгүй өнгөрсөн бололтой. Тэр хаягыг уншихын тулд зогсов. Энэ нь Перси Уизли унтлагын өрөөний үүдэн дээрээ нямбайлан бичсэн байдаг шиг сүржин бичиг байлаа.

Регулус Арктурус Блэкийн зөвшөөрөлгүй

Орж болохгүй

Догдлол Харрин сэтгэлийг хаман авахад юунаас болсныг шууд ойлгосонгүй. Тэр хаягыг ахин нэг удаа уншлаа. Гермиона хэдийн шатаар бууж байв.

- Гермиона эргээд ирдээ гэж дуудахдаа хоолой нь тайван байгаа явдалд өөрөө ч гайхлаа.

- Яасан бэ?

- Р.А.Б. Би түүнийг олчих шиг боллоо. Гермиона дуу алдаад шатаар гүйн гарч ирэв.

- Ээжийн чинь захианд байсан уу? Би анзаарсангүй ...

Харри толгой сэгсрээд Регулусын хаяг руу заалаа. Гермиона бичгийг уншаад

Харрийн гарыг өвдтөл базав.

- Сириусын дүү юу? гэж тэр шивнэлээ.

- Тэр Үхэл залгигч байсан. Сириус түүний тухай надад ярьсан. Залуухан байхдаа Үхэл залгигч болоод дараа нь гарахыг хүссэн ч ... түүнийг алсан гэсэн.

- Тэгвэл бүх зүйл тохирч байна! Хэрвээ тэр Үхэл залгигч байгаад Волдемортод урам хугарсан бол түүнийг унахыг хүсч л тараа!

Тэр Харрийн гарыг тавиад шатны хашлага дээгүүр бөхийн,

- Рон! Рон! Наашаа түргэн хүрээд ир дээ! гэж хашгирлаа. Хормын дараа Рон амьсгаадсаар саваагаа бэлхэн барин хүрч ирэв.

- Юу болоо вэ? Ахиад л том аалз хараа юу? Алив явж хоолоод дараа нь ... Тэр духаа үрчийлгэснээ Гермионагийн чимээгүйхэн заасан хаягийг уншлаа.

- Тэгээд юу гэж? Энэ чинь Сириусын дүү биз дээ? Регулус Арктурус ... Регулус ... Р.А.Б! Зүүлт ... Чи тэгж бодож байна уу?

- Алив учрыг нь олъё гээд Харри хаалгыг түлхсэнд түгжээтэй байлаа. Гермиона хаалганы бариул руу саваагаараа заагаад,

- Алохомора! гэв.

Чаг хийх чимээ гарч хаалга онгойлоо.

Гурвуул босго даван ороод эргэн тойрноо харав. Регулусын унтлагын өрөө Сириусынхээс бага хэдий ч үзэсгэлэнтэй сайхан өрөө байлаа. Хэрвээ Сириус гэр бүлийн гишүүдтэйгээ холбоотой зүйлээс аль болох татгалзахыг оролдож байсан бол Регулус эсрэгээрээ үүнд ихээхэн ач холбогдол өгчээ. Слизериний маргад ногоон мөнгөлөг өнгө орны бүтээлэг, хана, цонх гээд л алхам тутамд тааралдаж байлаа. Орны дээр Блэкийн гэр бүлийн сүлдийг дүрслэн «Цэвэр цус үүрд мөнх» гэжээ. Түүний дор хуучирч шарласан сонингийн хайчилбар өлгөжээ. Гермиона түүнийг харахаар очив.

- Бүх хайчилбар нь Волдемортын тухай юм байна. Регулус түүнийг Үхэл залгигч болохоосоо өмнө шүтэж байсан бололтой.

Тэр тоос манаруулан орны бүтээлэг дээр суугаад хайчилбарыг уншив. Харри энэ хооронд Хогвартсын квиддичийн багийнхан инээмсэглэн гар даллаж байгаа өөр нэг зураг руу харлаа. Тэр түүн рүү ойртож хараад тоглогч бүр Слизериний могойн бэлэг тэмдэг цээжин дээрээ дүрсэлснийг харав. Регулус эхний эгнээний дунд сууж байсан бөгөөд агшин зуур танигдав. Тэр хар үс ихэмсэг төрхөөрөө ахтайгаа адилхан хэдий ч жижигхэн туранхай бөгөөд Сириус шиг царайлаг байсангүй.

- Тэр баригч байж гэж Харри хэлэв.

- Юу? гэж Волдемортын хайчилбарт улайрсан Гермиона гайхширан асуулаа.

- Тэр эхний эгнээний дунд сууж байна. Энэ бол баригчийн суудал ... Гэхдээ энэ нэг их чухал биш дээ гэж Харри хэн ч түүнийг сонсохгүй байгааг ойлгоод хэллээ.

Рон шүүгээний доогуур харахын тулд дөрвөн хөллөжээ. Харри өрөөний эргэн тойронд юм нуучихаар газар хайн харснаа бичгийн ширээ рүү очлоо. Шургуулгыг саяхан онгичсон бололтой тоос нь арчигдсан бөгөөд ямар ч үнэ цэнэтэй зүйл байсангүй. Шарласан галууны өдөн үзэг, хуучирсан сурах бичиг, хагарсан бэхийн савны хэлтэрхий ёроолын эд зүйлстэй холилдон хэвтэнэ.

- Арай амархан аргаар оролдоод үзье гэж Гермиона Харри бэх болсон гараа өмдөндөө арчихыг харан хэлээд саваагаа өргөж,

- Акцио, зүүлт! гэв.

Гэвч юу ч болсонгүй. Хөшиг нэгжиж байсан Рон урам хугаран эргэлээ.

- Тэгэхээр ийм байна. Тэр энд алга.

- Магадгүй шидийн эсрэг хамгаалалтай байгаа байх. Татдаг шид хэрэглэж болохооргүй гэж Гермиона хэлэв.

- Тиймээ Волдемортын агуйн аяганд байсан шиг гээд Харри хуурамч зүүлтийг хэрхэн дуудсанаа саналаа.

- Тэгвэл бид түүнийг яаж олох болж байна? гэж Рон асуув.

- Гараар хайхаас өөр зам алга гэж Гермиона хэлэв.

- Маш сайхан санаа байна гэж тэр нүдээ эргэлдүүлэн хэлээд ахин хөшиг нэгжлээ.

Цагийн дараа тэд унтлагын өрөөний хэсэг бүрийг самнасан ч зүүлт энд байсангүй. Нар өндөрт хөөрч нүд гялбам хурц туяа баргар цонхоор тусав.

- Тэр энэ гэрийн хаана ч байж болох юм гэж Гермиона шатаар буухдаа тэднийг урамшуулах санаатай хэлэв. Харр, Рон хоёрын итгэл алдарсан ч тэр илүү шийдэмгий байлаа.

- Тэр устгасан ч бай үгүй ч бай Волдемортоос зүүлтийг нуух хэрэгтэй байсан биз дээ? Бид энд сүүлд байхдаа аймшигтай зүйлсээс салсныг санаж байна уу? Цаг сумаар буудан, Роныг хуучин жанч боомилохыг оролдсон. Регулус магадгүй тэднийг зүүлтийг нуусан газрыг хамгаалахаар тавьсан ч бид ойлголгүй ...

Харри, Рон хоёр түүн рүү эргэлээ. Гермиона нэг хөл дээрээ зогсоод мартах шившлэгт өртсөн хүн шиг болж нүд нь төвлөрөхөө болилоо.

- ... тэр үед гэж шивнэн дуусгав.

- Юу болоо вэ? гэж Рон асуулаа.

- Тэнд зүүлт байсан.

- Юу? гэж Харри, Рон хоёр зэрэг асуулаа.

- Зочны өрөөнд байсан шүүгээнд. Хэн ч түүнийг онгойлгож чадаагүй. Харин бид ... бид ...

Харрид дотор палхийлээ. Тэр хүн бүр зүүлтийг гар дамжуулан үзэж нээхийг оролдсоноо саналаа. Дараа нь зүүлтийг хогийн савand хийх хэрэггүй зүйлсийн уутанд хөөрөг, хөгжмийн хайрцагны дэргэд чулуудсан билээ.

- Кикимер тэгэхэд бидний хаясан зүйлээс хулгайлсан гэж Харри хэллээ. Энэ бол тэдний цорын ганц боломж сулхан найдлага байсан болохоор үүнийгээ алдахгүйг хичээн,

- Түүний гал зуухны пинд дүүрэн хог новш байсан. Явцгаая гэлээ.

Тэр шат доошоо хоёр гишгүр алгасан уруудахад найз нь араас нь пижигнүүлэн дагалдав. Тэдний гаргасан чимээ шуугиан үүдний өрөөнд хадаж Сириусын эхийг сэрээлээ.

- Бузар! Бохир цустангууд! Шаарнууд! гэж тэр араас нь орилсон хэдий ч хонгилын гал зуух руу ороод хаалга хаалаа.

Харри гал зуухан дундуур гүйн пингийн өмнө гулган зогсоод огцом нээлээ. Тэнд Кикимерийн унтаж байсан навсгар бохир хөнжил байсан ч авран хамгаалсан

гялалзсан эд зүйлс нь байсангүй. Зөвхөн «Язгууртан шидтэнгүүдийн уг гарал» гэсэн хуучин ном үлджээ. Харри нүдэндээ итгэлгүй хөнжлийг аваад сэгсэрлээ. Дотроос нь үхсэн хулгана унав. Рон дуу алдан ёолоод гал зуухны ширээнд суухад Гермиона нүдээ анилаа.

- Энэ ч бас болоогүй байна гээд Харри чангаар,

- Кикимер! гэж дуудлаа.

Чанга тас хийх чимээ гараад Харрийн Сириусээс дургүйхэн залгамжлан авсан гэрийн үйлчлэгч хүйтэн хоосон ханан зуухны урд гарч ирлээ. Тэр жижигхэн хүний биений хагастай тэнцэх хэмжээтэй бөгөөд цайвар арьс нь үрчлээтэн, сарьсан багваахай шиг чихийг тойроод цагаан үс ёрдойж байлаа. Тэр анхны уулзалтаараа танил болсон бохир алчуур өмссөн бөгөөд эзэмшигч нь өөрчлөгдсөн явдалд Харри руу зэвүүцэнгүй харлаа.

- Эзэн миний эзэгтэйн хуучин байшинд цусаа доромжлогч Уизли, бохир цустантай хамт эргэн иржээ ... гэж Кикимер бах мэлхий шиг гуаглаад өвдгөө хүртэл мэхийн ёслов.

- Би чамд тэднийг цусаа доромжлогч болон бохир цустан гэж нэрлэхийг хорилож байна! гэж Харри зандарахад Кикимерийн богинохон хамар дээрх цус хүрсэн нүдэнд нь оч гялсхийв.

- Би чамаас юм асуухын тулд дуудсан юм. Тэгээд үнэн хариулахыг тушааж байна. Ойлгов уу? гэж Харри үргэлжлүүлээд үйлчлэгч рүү харахад зүрх нь хурдтай цохилов.

- Тиймээ, эзэнтээн гээд Кикмер ахин бөхийн ёслов.

Харри үйлчэгчийн уруул чимээгүйхэн хөдлөхийг хараад чанга хэлэхийг хориглосон болохоор аяархан доромжилсон байх гэж бодлоо.

- Хоёр жилийн өмнө дээр зочны өрөөнд том алтан зүүлт байсан. Бид түүнийг гаргаж хаяхад чи хулгайлсан биз дээ? гэж Харри хэлэхэд зүрх нь улам хүчтэй цохилов.

Агшин зуур чимээгүй болоход Кикимер цэхлэн зогсож Харрийн нүүр лүү харснаа дараа нь,

- Тиймээ гэв.

- Тэр одоо хаана байна? гэж Харри баярлан асуухад Рон, Гермиона хоёр баясан гийлээ.

Кикимер дараагийн үгэндээ гарах хариу үйлдлийг харахгүйн тулд нүдээ анилаа.

- Алдсан.

- Алдсан гэнээ? хэмээн Харри давтаад баяр хөөр нь арилав.

- Алдсан гэдэг чинь юу гэж байгаа юм? Үйлчлэгч чичирсэнээ найгав.

- Кикимер. Би чамд хэлэхийг тушааж байна... гэж Харри уурсан хэлэв.

- Наземникус Флетчер гэж үйлчлэгч нүдээ чанга анин сөөнгөтөөд,

- Наземникус Флетчер хатагтай Белл болон хатагтай Цессигийн зураг, миний эзэгтэйн бээлий, Мерлиний нэгдүгээр зэргийн одон, гэр бүлийн сүлдтэй цом гээд бүх зүйлийг хулгайлсан бас ... гээд цээжээ төвийлгөн гүн амьсгал авснаа нүдээ нээж дотор зарсхийм хоолойгоор,

- Бас зүүлт ... Регулус эзний зүүлтийг авсан. Кикимер муу зүйл хийсэн, Кикимер тушаал биелүүлээгүй! гэж хашгирлаа.

Харри зөнгөөрөө хөдөллөө. Тэр Кикимерийг ханан зуухны сараалжин дээр байсан шилээгүүр рүү ухасхийхэд үсрэн шалан дээр дарав. Гермиона чанга хашгирахад Харри хоёуланд нь хашгиран,

- Кикимер чамд энэ хэвээрээ үлдэхийг тушааж байна! гэв.

Үйлчлэгчийн бие суларахад Харри бослоо. Кикимер чулуун шалан дээр хэвтээд нүднээс нь нулимс урсав.

- Харри, түүнийг өндийлгө! гэж Гермиона шивнэлээ.

- Өөрийг нь шилээгүүрээр цохиулахын тулд уу? гээд Харри тургилснаа дэргэд нь өвдөглөн суулаа.

- Би тэгж бодохгүй байна. Сайн байна, Кикимер би үнэнийг мэдэхийг хүсч байна. Чи зүүлтийг Наземникус Флетчер хулгайлсан гэдгийг яаж мэдсэн юм бэ?

- Кикимер түүнийг харсан! гээд үйлчлэгч эхэр татахад хамрыг даган нулимс урсаж саарал шүдтэй ам руу нь оров.

- Кикимер түүнийг пингээсээ гар дүүрэн Кикимерийн эрдэнэстэй гарч ирэхийг харсан. Кикимер түүнийг хулгай хийхээ боль гэхэд Наземникус Флетчер инээмсэглээд зугтчихсан ...

- Чи Регулус эзний зүүлт гэж хэлсэн. Яагаад? Тэр хаанаас аваа вэ? Регулус үүгээр юу хийсэн юм? Кикимер суугаад надад зүүлтний тухай Регулустай холбоотой бүх зүйлийг яриад өгдөө!

Эльф бөмбөг шиг атийн суугаад нойтон нүүрээ өвдөгний завсраа хийж урагш хойш ганхан ярьж эхэллээ. Түүний хоолой нам байсан ч чимээгүй гал зууханд сайн дуулдаж байв.

- Сириус эзэн зугтаж салж амарсан. Тэр муу хүү байсан болохоор хууль бус зам сонгож эзэгтэйн зүрхийг эмтэлсэн. Харин Регулус эзэн сайн хүү байж Блэкийн нэрийг зүүж байгаадаа болон цэвэр цус судсанд нь байгаад бахархдаг байсан. Олон жилийн турш тэр Хар лордын тухай маглууд болон магл гаралтай хүмүүсээс болж шидтэнгүүд сүүдэрт байгаа тухай ярьж байсан ... Тэр арван зургаан нас хүрэхдээ Хар лордтой нэгдсэн. Тэр үүгээрээ маш их бахархаж зүтгэж байгаадаа жаргалтай байсан ...

- Гэхдээ үүнээс жилийн дараа нэг өдөр Регулус эзэн гал зууханд Кикимертэй ярилцахаар ирсэн. Регулус эзэн үргэлж Кикимерт хайртай байдаг юм. Тэгээд Регулус эзэн хэлэхдээ... тэр хэлэхдээ ...

Хөгшин үйлчлэгч улам хүчтэй ганхлаа.

- ... тэр Хар лордод үйлчлэгч шаардагдсан гэсэн.

- Волдемортод үйлчлэгч шаардагдсан гэнээ? хэмээн Харри асуугаад Рон, Гермиона хоёр руу харлаа.

- Тийм. Тэгээд эзэн Регулус түүнд Кикимерийг санал болгосон. Энэ бол түүний хувьд ч Кикимерийн хувьд ч томоохон хүндэтгэл гэж эзэн хэлээд Хар лордын даалгасан бүхнийг хийгээд ... дараа нь гэртээ эргэж ир гэсэн.

Кикимер найгасан хэвээр нулимс асгаруулав.

- Кикимер Хар лордод очсон. Хар лорд Кикимерт юу хийх гэж байгаагаа хэлээгүй хамт авч яваад тэнгисийн дэргэдэх агуй руу очсон. Агуйд өөр том агуй дотор нь хар нуур байсан ...

Харрийн үс бослоо. Түүнд Кикимерийн сөөнгө хоолой харанхуй усан дундаас дуулдаж байх шиг санагдав. Тэр өөрөө тэнд байсан болохоор юу болсныг маш сайн ойлголоо.

- ... бас тэнд завь байсан.

Мэдээж тэнд завь байсан. Харри жижигхэн ногоовтор өнгөтэй нуурын дунд талын арал руу нэг л хохирогч болох шидтэнг зөөвөрлөх үүрэгтэй завийг саналаа. Волдеморт крестражын хамгаалалтаа шалгахын тулд ганц удаа хэрэглээд хаячих амьтанаар гэрийн үйлчлэгчийг сонгожээ ...

- Арал дээр дүүрэн шингэнтэй аяга байсан. Хар лорд Кикимерийг уу гэж тушаасан ... гээд үйлчлэгч хөлөөсөө толгой хүртлээ чичирлээ.

- Кикимер уусан, уугаад аймшигтай зүйл харсан ... Кикимерийн дотор шатсан

... Кикимер Регулус эзнээс аврахыг гуйсан, эзэгтэй Блэкийг хашгиран дуудсан ч Хар лорд зөвхөн инээмсэглэсэн ... тэр Кикимерт бүх шингэнийг уулгаад ...

хоосон аяганд зүүлтийг хийж ... ахин уусмалаар дүүргэсэн. Дараа нь Хар лорд

Кикимерийг арал дээр үлдээгээд явсан.

Харри юу болсныг харлаа. Волдемортын могой адил царай харанхуйд уусан алга болохын өмнө өрөвдөх сэтгэлгүй улаан нүд нь галт шингэнийг уугаад хормын дараа үхэх гэж чичирэн атиралдаж буй үйлчлэгчийг харж ... Цааш нь Харри Кикимер тэндээс яаж аврагдсаныг ойлгосонгүй болохоор төсөөлж чадсангүй.

- Кикимерт ус хэрэгтэй байсан болохоор арлын эрэг рүү мөлхөөд харанхуй нуурааc уусан ... тэгтэл үхсэн хүний гар уснаас цухуйж Кикимерийг усанд чирэн оруулсан ...

- Чи тэндээс яаж гараа вэ? гэж Харри шивнэн асуулаа.

Кикимер толгойгоо өргөөд Харри руу том цус хурсан нүдээрээ ширтэж,

- Регулус эзэн Кикимерийг буцааж дуудсан гэв.

- Ойлгомжтой ... гэхдээ чи яаж инферналуудаас аврагдсан юм бэ? Кикимер харваас юу асуусныг ойлгосонгүй бололтой.

- Регулус эзэн Кикимерийг буцааж дуудсан гэж давтлаа.

- Би мэднэ гэхдээ ...

- Энэ илэрхий байгаа биз дээ, Харри? Тэр шилжсэн байна гэж Рон хэлэв.

- Гэхдээ ... агуйд шилжиж болохгүй байсан Дамблдор хүртэл ...

- Үйлчлэгч нарт бидэнтэй адилгүй өөрийн гэсэн шид бий. Тэд Хогвартсад дуртай газраа шилжиж байхад бид чаддаггүй биз дээ.

Нам гүм болоход Харри сонссон зүйлээ бодлогширлоо. Волдеморт яаж ийм алдаа хийж чаддаг байна аа? Гэхдээ түүнийг энэ тухай бодож амжихаас урьтаж Гермиона хүйтнээр,

- Мэдээж Волдеморт хэзээ ч гэрийн үйлчлэгчид шиг амьтдыг анзаарч байгаагүй

... Түүний санаанд хэзээ ч мэдэхгүй шидийг нь эзэмшсэн гэсэн бодол ороогүй байх гэв.

- Гэрийн үйлчлэгчийн хувьд эзний тушаал бол хууль. Кикимерийг гэртээ харихийг тушаасан, Кикимер гэртээ харьсан ...

- Харин чи юу хэлээд байсан биз дээ? Тэгэхээр чи тушаал биелүүлээгүй биш байна! гэж Гермиона эелдэгээр хэлэв.

Кикимер толгойгоо сэгсэрээд түргэн найгалаа.

- Чамайг эргэж ирсэн хойно юу болсон бэ? Регулусд болсон явдлыг ярьсаны дараа юу гэж хэлсэн бэ?

- Регулус эзэн их түгшсэн, маш их шүү. Регулус эзэн Кикимерийг нуугдаад гэрээсээ битгий гар гэж хэлсэн. Дараа нь ... жаахан хойхон ... Регулус эзэн шөнө Кикимерийн хонгил руу шөнө ирээд хачирхалтай ухаан солиорсон юм

шиг зүйл хэлсэн ... тэр Кикимерт агуй руу аваачихыг тушаасан. Кикимерийн

Хар лордтой байсан агуйд ...

Ийм учраас тэд буцжээ. Харри ахин болсон бүх зүйлийг төсөөлөн харлаа. Айсан хөгшин гэрийн үйлчэгч, Сириусыг санагдуулам баргар баригч ... Кикимер газар дорх агуйн нууц үүдийг яаж нээхийг мэдэж байсан болохоор жижигхэн завь руу очоод энэ удаад Регулусын хамт уусмалтай аяга бүхий арал руу явжээ.

- Тэр чамд уусмалыг уулгасан уу? гэж Харри зэвүүцэн асуулаа.

Гэвч Кикимер толгой сэгсэрснээ уйллаа. Гермиона ямар нэг зүйл ойлгосон бололтой гараараа амаа дарав.

- Э-эзэн Регулус халааснаасаа Хар лордынх шиг зүүлт гаргаж ирсэн гэж Кикимер нулимс дуслуулан хэлээд,

- Тэр Кикимерт түүнийг авч аяга хоосрохоор зүүлтийг соль гэсэн ... гэв.

Кикимерийн цурхиралт болон хэржигнэсэн дуу болон хувирахад Харри үгийг нь ойлгохын тулд анхаарлаа төвлөрүүлэв.

- Ингээд тэр тушаасан ... Кикмерийг түүнгүйгээр явахыг ... Тэр Кикимерийг гэртээ харь гэсэн ... тэгээд хэзээ ч эзэгтэйд ... хийсэн зүйлийнх нь тухай бүү хэл гэсэн ... гэхдээ эхлээд зүүлтийг устга гэсэн. Тэр дараа нь ... бүх уусмалыг уухад ... Кикимер зүүлтийг сольж ... Регулус эзнийг ус руу чирэн оруулахыг харсан ... тэгээд ...

- Өө, Кикимер! гэж Гермиона уйлагнан дуу алдав. Тэр үйлчлэгчийн дэргэд сөхрөн суугаад тэврэхийг оролдлоо. Гэвч цаадахь нь түлхээд үсрэн холдов.

- Бохир цустан Кикимерт хүрлээ, тэр зөвшөөрөх ёсгүй байсан юм эзэгтэй энэ тухай юу гэж хэлэх бол?

- Би чамд түүнийг бохир цустан гэж битгий нэрлэ гэсэн биз дээ! гэж Харри зандрахад үйлчлэгч хэдийн өөрийгөө шийтгэн шалан дээр унаад духаараа газар мөргөлөө.

- Түүнийг зогсоо ... зогсоогооч! гэж Гермиона хашгирав.

- Чи түүнд муу байгааг харахгүй байна уу? Тэр чиний ямар ч тушаалыг биелүүлэх болохоор!

- Кикимер ... зогс! Зогс! гэж Харри хашгирлаа.

Үйлчлэгч шалан дээр хэвтээд амьсгаадан чичирч хамраас нь нус гоожин, газар мөргөсөн дух нь цайрч, цус хурсан нүд нь бүлтийгээд нулимсаар дүүрэв. Харри хэзээ ч үүнээс өрөвдөлтэй зүйл харж байсангүй.

- Тэгэхээр чи зүүлтийг гэрт авчирсан юм байж гэж бүх зүйлийг мэдэхийн тулд хэрцгий хэлээд,

- Тэгээд устгахыг оролдсон уу? гэв.

- Кикимер юу ч хийсэн түүнд зураас ч гаргаж чадаагүй. Кикимер мэддэг бүх зүйлээ оролдож үзсэн ч юу ч тус болоогүй ... Зүүлтэнд маш хүчирхэг шившлэг байсан. Кикимер зүүлтийг устгахын тулд нээхийг мэдэж байсан ч онгойлгож чадаагүй ... Кикимер өөрийгөө шийтгээд ахин оролдож үзсэнээ шийтгээд, дараа нь ахин шийтгэсэн. Кикимер тушаалыг биелүүлж чадаагүй, Кикимер зүүлтийг устгаж чадаагүй! Харин эзэгтэй Регулусыг алга болсонд гашуудан ухаан солиорсон ч Кикимер түүнд юу болсныг хэлж чадаагүй яагаад гэвэл эзэн Регулус түүнд гэр бүлийн хэнд ч агуйд юу болсныг ярихгүй байхыг даалгасан ...

Кикимер эхэр татан уйлаад цаашид үг хэлэх чадваргүй болов. Гермионагийн хацрыг даган нулимс урссан ч түүнд хүрч зүрхэлсэнгүй. Тэр ч байтугай Рон хүртэл Кикимер рүү сэтгэлээр унасан байртай харлаа. Харри ахин суугаад толгой сэгсрэн тайлбарлахыг хичээв.

- Би чамайг ойлгохгүй байна, Кикимер. Волдеморт чамайг алахыг оролдож, Регулус түүнийг унагахын үхсэн байхад чи баяртайгаар Сириусээс урвасан биз дээ? Баяртайгаар Нарцисса, Беллатриса хоёрт Волдемортын хүссэн мэдээллийг дамжуулсан ...

- Харри Кикимер ингэж бодоогүй гээд Гермиона нулимсаа гарынхаа араар арчиж,

- Тэр бол боол. Гэрийн үйлчлэгч нар үүнээс ч муу хэрцгий харьцаанд дасал болсон байдаг юм. Кикимерийн Волдемортын тухайд хийсэн зүйлд ер бусын зүйл алга. Шидтэнгүүдийн дайн Кикмерт ямар хамаатай юм бэ? Тэр түүнд элэгсэг ханддаг хүн болох хатагтай Блэк бас Регулуст зүтгэж үйлчилж байсан. Би чиний юу хэлэхийг хүсч байгааг мэдэж байна гэж Харриг эсэргүүцэхээр завдахад хэлээд,

- Регулусын бодол өөрчлөгдсөн ... Гэхдээ тэр энэ тухай Кикмерт хэлээгүй бололтой. Би яагаад гэдгийг нь мэдэж байна. Кикимер болон Регулсын гэр бүлийнхэн эртнээс цэвэр цусаа аюулгүй хадгалахын төлөө зүтгэж байсан. Регулус тэднийг хамгаалахыг хичээсэн байна.

- Сириус ...

- Сириус Кикимертэй аймшигтай харьцдаг байсан, Харри. Над руу ингэж харах хэрэггүй чи үүнийг үнэн гэдгийг сайн мэдэж байгаа. Сириус энд амьдрахаар ирэх үед Кикимер олон жилийг өлсөж цанган ганцаар өнгөрүүлсэн байсан. Би хатагтай Цисси, хатагтай Белла нар Кикимертэй хүссэн зүйлээ хэлүүлэхийн тулд их эелдэг харьцсан гэдэгт итгэлтэй байна. Би эртнээс шидтэнгүүд үйлчлэгч нартай ингэж харьцдагийнхаа хариуг төлөх болно гэж хэлж байсан биз дээ. Волдеморт төлсөн ... Сириус ч гэсэн.

Харри маргасангүй. Тэр шалан дээр цурхирч байгаа Кикимер рүү хараад Дамблдорын Сириусын үхлийн дараа хэлсэн «Сириус хэзээ ч Кикимерийг амьд амьтан гэж бодож байгаагүй» гэснийг саналаа.

- Кикимер чамд арай дээр байх ... сууж үзээч гэж Харри хэсэг хугацааны дараа хэлэв.

Хэдэн хормын дараа Кикимерийн мэгшилт зогсов. Тэр өндийн суугаад жижигхэн хүүхэд шиг нүдээ арчив.

- Би чамаас нэг юм гуйх гэсэн юм, Кикимер гээд тэр тусламж эрэн Гермиона руу харлаа. Тэр тушаалаа захирангуй биш зөөлөн өгөхийг хичээв. Түүний өөрчлөгдсөн өнгийг ажигласан бололтой Гермиона талархан инээмсэглэв.

- Кикимер би чамайг Наземникус Флетчерийг олохыг хүсч байна. Бид зүүлт хаана байгааг мэдэх хэрэгтэй байна. Бидэнд ... Регулус эзний чинь зүүлт хэрэгтэй байна. Энэ маш чухал. Бид Регулусын эхэлсэн ажлыг дуусгахыг хүсч байгаа болохоор ... түүний үхэл дэмий үрэгдэхийг хүсэхгүй байна.

Кикимер гараа буулгаад Харри руу харснаа,

- Наземникус Флетчерийг олох гэнээ? хэмээн сөөнгөтөв.

- Тэгээд түүнийг ийш нь Гриммогийн байшин авааД ир. Чи үүнийг хийж чадах уу?

Кикимер толгой дохиод босоход Харрид гэнэтхэн нэг санаа төлөө. Тэр Хагридын өгсөн хүүдийнээс Регулусын Волдемортод зурвас үлдээсэн зүйл болох хуурамч крестражыг гаргалаа.

- Кикимер би ... чамайг энэ зүйлийг авахыг хүсч байна. Тэр Регулусын зүйл болохоор хэрвээ чамайг авбал түүнийг баярлах байсан гэдэгт итгэлтэй байна гээд зүүлтийг үйлчлэгчийн гарт бариулав.

- Дэндүүлчихлээ, найз минь гэж Рон үйлчлэгч зүүлтийг гашуудалтайгаар авч ахин шалан дээр суун гингэнүүлэхэд хэлэв.

Кикимер тайвширахад бараг хагас цаг орсон бөгөөд Блэкийн гэр бүлийн уламжлагдсан зүйлийг авсан явдалд хөл дээрээ тогтож чадсангүй. Түүнийг эцэст нь хөдлөх чадвартай болоод зүүлтийг пингийн бохир хөнжилд ороон аюулгүй нуухыг гурвуул хараад түүний эзгүйд хамгаалж байхаа амлав. Тэр Харри болон Ронд гүнзгий бөхийн ёслоод тэр ч байтугай Гермионад инээдтэй бөхийн салах ёс гүйцэтгэв. Дараа нь ердийнхөөрөө тасхийх чимээ гаргаад шилжлээ.

БҮЛЭГ 11: ХАХУУЛЬ

Харри Кикимер инферналаар дүүрэн нуураас мултарч чадсан юм чинь Наземникусыг хэдхэн цагийн дараа бариад өглөө гэхэд гэрт авчирч баяртай мэдээ дуулгана гэдэгт итгэлтэй байлаа. Гэвч Кикимер өглөө эргэн ирсэнгүй өдөр дунд ч гэсэн адил. Бүрэнхий болоход Харрийн урам хугарч сэтгэл нь түгшин Гермиона оройн хоолон дээр янз бүрийн арга хэрэглэсэн ч сэтгэл санаа нь дээрдсэнгүй.

Кикимер дараагийн өдөр нь эргэж ирсэнгүй түүний дараагийн өдөр ч гэсэн мөн адил. Түүнчлэн гадаа талбай дээр хоёр жанчтай дүрс бий болоод шөнөжингөө холхин үл үзэгдэх байшингийн зүг ширтэнэ.

- Үхэл залгигчид байна. Тэднийг бидний энд байгааг мэдэж байгаа гэж бодож байна уу? хэмээн Рон, Харри, Гермиона хоёрын хамт зочны өрөөний цонхоор ширтэж байхдаа хэлэв.

- Тэгж бодохгүй байна. Хэрвээ мэдсэн бол бидэн рүү Снеггийг явуулах байсан биз дээ? гэж Гермиона айсан шинжтэй хэллээ.

- Гэхдээ тэр энд хэдийн ирээд Грюмын хэл хөшөөх шившлэгт өртсөн юм шиг санагдахгүй байна уу?

- Тиймээ магадгүй л юм үгүй бол тэдэнд яаж дотогш орохыг хэлэх байсан.

Гэхдээ тэд биднийг энд ирж болзошгүй учир энэ газрыг харуулдаж байгаа байх. Тэд байшин Харрид залгамжлагдсан гэдгийг мэдэж байгаа.

- Чи хаанаас мэдээ вэ? гэж Харри асуув.

- Бүх шидтэнгүүдийн гэрээслэлийг ид шидийн яамнаас шалгадаг биз дээ? Тэнд

Сириус чамд байшин орхисон илэрхий шүү дээ.

Зэргэлдээ Үхэл залгигчид холхиж байгаа явдал нь арван хоёрдугаар байшингийн уур амьсгалыг таагүй болгон өөрчлөв. Ноён Уизлийн Патронус Гриммогийн байшинд ирснээс хойш тэд гадаад ертөнцийн тухай мэдээ сонсоогүй байлаа. Рон тайван бус ууртай болж Делюминатороор тоглох таагүй дадал зуршилтай болов. Ялгангуяа энэ нь Кикимерийн ирэхийг хүлээнгээ «Бидл бардын үлгэрүүд»-ийг уншиж байсан Гермионагийн тэвчээрийг барсан бөгөөд асаж унтрах гэрэл огтхон ч баярлуулсангүй.

- Үүнийгээ больж үзээч! гэж тэр Кикимерийг явснаас хойш гурав дахь үдэш зочны өрөөний гэрэл асаж унтарахад хашгирлаа.

- Уучлаарай, уучлаарай! Би өөрийн мэдэлгүй ингэчихлээ! гээд Рон

Делюминатороо шархийлгэн гэрэл асаав.

- Өөр ямар нэг ашигтай зүйл хийж болохгүй байна уу?

- Ямар? Хүүхдийн үлгэр унших уу?

- Рон надад энэ номыг Дамблдор орхисон.

- Тэр ч гэсэн надад Делюминаторыг орхисон болохоор ашиглаж болно биз дээ!

Харри цаашид тэдний маргааныг тэвчих хүчгүй болоод чимээгүйхэн зочны өрөөнөөс гарч Кикимерийг удахгүй ирнэ гэсэн итгэлтэйгээр доошоо буулаа. Түүнийг шатны хагаст хүрэх агшинд хаалга аяархан цохих сонсогдоод төмөр цоож шархийж гинж харжигналаа.

Харрийн мэдрэл эцэстээ хүртэл хөвчирлөө. Тэр саваагаа гаргаад гэрийн үйлчлэгч нарын толгойны дорх сүүдэрт хөшин хүлээлээ. Хаалга нээгдэхэд гадаа талбайн дэнлүүний гэрэл хальт гялсхийгээд үүдний танхимд жанчтай хүн орж ирэн хаалга хаалаа. Түүнийг дөнгөж нэг алхав уу үгүй юу Грюмын хоолой «Северус Снегг үү?» гэж асуулаа. Дараа нь үүдний танхимын нөгөө өнцгөөс үхээрийн гараа сунгасан тоостой хий үзэгдэл босож ирэв.

- Би чамайг алаагүй, Альбус гэж орж ирэгч аяархан хэлэв.

Шид цуцлагдаж тоостой дүрс ахин дэлбэрээд саарал үүл босож орж ирэгчийг таних аргагүй болгов.

Харри тоосны гол руу саваагаа чиглүүлээд,

- Бүү хөдөл! гэв.

Тэр хатагтай Блэкийн хөргийг мартсан байсан ч хашгирах дуунаар нь хөшиг нээгдэж,

- Бохир цустангууд, бузар амьтад миний гэрээс зайлцгаа ... гэж хашгирлаа. Харрийн нурууны ард шат чахрах чимээ гарч Рон, Гермиона хоёр гүйж ирээд гараа

өргөн зогссон үл таних хүн рүү саваагаа чиглүүлэв.

- Битгий шившлэг илгээгээрэй, би Римус байна!

- Өө, бурханд баярлалаа гэж Гермиона сулхан хэлээд саваагаа хатагтай Блэкийн зүг чиглүүлэхэд тас хийх чимээ гарч хөрөг хаагдан чимээгүй боллоо. Рон бас саваагаа буулгасан ч Харри тэгсэнгүй.

- Үүнийгээ батал! гэж хашгирлаа. Люпин гэрлийн дор гараа өргөн гарч ирлээ.

- Би Римус Жон Люпин, хүн чоно, Солиот гэдэг хочтой, Тэнүүлчний газрын зургийг зохиосон дөрвөн хүний нэг, Тонкс гэсэн нэрээр дуудагддаг Нимфадортай гэрлэсэн, бас би чамд бугын хэлбэртэй Патронус гаргахыг заасан, Харри.

- Тиймээ бүх зүйл хэвийн гээд Харри саваагаа буулган,

- Гэхдээ шалгах хэрэгтэй байсныг ойлгож байгаа биз дээ? гэв.

- Чиний хар урлагийн багш байсан хүний хувьд шалгахыг зөвшөөрч байна.

Харин Рон, Гермиона та хоёр хамгаалалтаа тэгж хурдан буулгах хэрэггүй байсан юм.

Гурвуул түүн рүү шат уруудан гүйлээ. Люпин аян замын хар замын жанч өмсөөд ядарсан хэдий ч тэднийг хараад баяртай байлаа.

- Тэгэхээр Северусын ямар нэг шинж тэмдэг мэдэгдсэнгүй юу?

- Үгүй. Юу болсон бэ? Бүгд бүрэн бүтэн үү? гэж Харри асуув.

- Тиймээ Гэхдээ бүгдийг мөрдөж байгаа. Бас гадаа талбай дээр хоёр Үхэл залгигч байсан.

- Бид мэднэ.

- Би шатны дээд талын гишгүүр рүү хаалганы урд шилжих хэрэг гарсан болохоор тэднийг хараагүй гэдэгт итгэлтэй байна. Тэд та нарын энд байгааг мэдээгүй байх тэгсэн бол бүр олуулаа байх байсан юм. Үхэл залгигчид чамтай холбоотой бүх газар харуулдаж байгаа, Харри. Доошоо бууцгаая би та нарт олон зүйлийг ярих хэрэгтэй байна. Бас Үүрийг орхисноос хойш юу болсныг мэдэхийг хүсч байна.

Тэд гал зуух руу уруудан буухад Гермиона саваагаа ханан зуухны сараалж руу чиглүүлэв. Дөл дүрсхийн асаж харанхуй чулуун ханыг гийгүүлэхэд урт модон ширээ гэрэлтлээ. Люпин жанчин дотроосоо хэдэн шил цөцгийний шар айраг гаргаж ирээд бүгд суулаа.

- Би ийшээ гурван өдрийн өмнө ирэх байсан ч дагалдаж байгаа Үхэл залгигч нараас салах хэрэгтэй байлаа. Тэгэхээр та нар хуримын дараа шууд ийшээ ирээ юу?

- Үгүй, бид Тотнем-Корт-Роудад хоёр Үхэл залгигчтай тулгарсны дараа ийшээ ирсэн гэж Харри хэлэв.

Люпин цөцгийний шар айрныхаа ихэнхийг цээж рүүгээ цалгиулан асгачихлаа.

- Юу гэнээ?

Тэд түүнд болсон явдлыг тайлбарлахад энэ нь Люпиныг ихэд айлгав бололтой.

- Гэхдээ тэд яаж та нарыг тийм түргэн олсон юм бол? Хэрвээ сүүлчийн мөчид зуураагүй л бол шилжсэн хүнийг дагах боломжгүй шүү дээ.

- Тэд Тотнем-Корт-Роудад зүгээр л зугаалж байсан юм болов уу? гэж Харри хэлэв.

- Бид ингэж бодлоо. Харри гэнэтхэн Хяналтын шидний дор байвал яах вэ гэж?

хэмээн Гермиона итгэлгүйхэн хэлэв.

- Энэ боломжгүй гэж Люпин хэлэхэд Рон бардмаар цээжээ түхийлгэн, Харрийн сэтгэл амарлаа.

- Харри Хяналтын шидтний дор байсан бол Үхэл залгигчид энд байгаа гэдгийг нь бас мэдэх байсан. Би тэднийг хэрхэн Тотнем-Корт-Роудад дагасныг ойлгохгүй байгаа ч намайг энэ их түгшээж байна.

Люпин сэтгэл зовнисон төрхтэй болоход Харри энэ сэдвээр асуулт тавихаа хүлээхээр шийдлээ.

- Биднийг явсны дараа юу болсныг яриач. Роны аав гэр бүл аюулгүй байгаа гэсэн ч юу болсон тухай мэдээгүй л байна.

- Ер нь бол Кингсли биднийг аварсан. Түүний анхааруулгын ачаар хуримын ихэнхи зочид тэднийг ирэхээс өмнө шилжсэн.

- Тэд Үхэл залгигчид байсан уу яамны хүмүүс байсан уу? гэж Гермиона асуув.

- Холимог хүмүүс. Ер нь бол одоо тэдний дунд ялгаа үгүй болсон. Тэд ойролцоогоор арвуулаа байсан ч Харри тэнд байсан гэдгийг мэдээгүй. Артур Скримжерийг алахаас өмнө чамайг хаана байгааг мэдэх гэж тамалсан тухай сураг сонссон. Хэрвээ энэ үнэн бол тэр чамайг барьж өгөөгүй.

Харри Рон, Гермиона хоёр руу харахад царайд нь түүний адил айдас талархал холилдон байлаа. Тэр Скримжерт хэзээ ч дуртай байгаагүй ч Люпины хэлсэн үнэн бол энэ хүн сүүлчийн амьсгалаа хураах хүртэл Харрийг хамгаалахыг оролдсон байна.

- Үхэл залгигчид Үүрийг дээрээс нь доошоо хүртэл нэгжээд ороолонг олсон ч түүнд ойртоогүй. Дараа нь хоёр цагийн турш байшинд үлдсэн бүх хүмүүсийг байцаасан. Харри, тэд чиний тухай мэдээлэл авахыг оролдсон ч бүлгийн гишүүдээс өөр хэн ч тэнд байсан гэдгийг чинь мэдээгүй. Тэднийг хурим дээр ирэхтэй зэрэгцэн өөр бусад Үхэл злагигч нар бүлэгтэй холбоотой бүх байшинд нэгжлэг хийсэн. Гэхдээ хэн ч үхээгүй гэж Люпин түргэн нэмэрлээд,

- Гэсэн ч тэд их бүдүүлэг байсан. Дедалус Динглын байшинг шатаасан ч дотор нь хүн байгаагүй. Тонксын эцэг эхийг Криуцатиусаар тамлаж чамайг сүүлчийн удаа тэнд очих үеэр юу болсныг тодруулахыг оролдсон. Тэдний бие сайн ... гайхалтай нь эрүүл амьд байгаа.

- Тэгэхээр Үхэл залгигчид бүх хамгаалалтын шидийг эвдсэн хэрэг үү? гэж Харри шид Тонксын эцэг эхийн цэцэрлэгт газардах үеэр сайн ажилласныг санаад хэллээ.

- Ойлго Харри, одоо Үхэл залгигчдын талд ид шидийн яамны хүч чадал байгаа болохоор тэд хамгийн хэрцгий шидийг ч баривчлагдана гэх айдасгүйгээр хэрэглэж чадах болсон. Тэд бидний бүх хамгаалалтыг эвдсэн учир дотогш нэвтрэхэд чөлөөтэй болсон.

- Гэхдээ тэд Харрийн хаана байгааг мэдэхийн тулд хүмүүсийг тамлаж байна гэж үү? хэмээн Гермиона жингэнэсэн хоолойгоор асуулаа.

- Юу гэвэл ... гээд Люпин тээнэгэлзсэнээ жанчин дороосоо «Өдөр тутмын зөнч» сонины дугаар гаргаж ирээд,

- Үүнийг чи эрт орой хэдий ч мэдэх байсан. Тэд энэ шалтгаанаар чамайг хөөж байна гээд Харри руу сонинг түлхлээ.

Харри сонинг дэлгэлээ. Сонины тэргүүн нүүрийг түүний том гэрэл зураг эзэлжээ. Доор нь дараахь гарчиг байлаа.

АЛЬБУС ДАМБЛДОРЫН ҮХЭЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН ЭРЭН СУРВАЛЖИЛЖ БАЙНА

Рон, Гермиона хоёр ууртай дуу алдсан ч Харри юу ч хэлсэнгүй. Тэр сонинг холдуулан түлхээд цааш уншихыг хүссэнгүй. Тэнд юу гарсан нь илэрхий байлаа. Дамблдорын үхлийн үеэр цамхагийн орой дээр түүнээс өөр хүн байгаагүй болохоор жинхэнэ хэн ч алуурчинг мэдэхгүй бөгөөд Рита Скитер хэдийн Дамблдорын унасан газраас хормын дараа Харрийн гүйж гарахыг харсан гэж мэдэгдсэн билээ.

- Уучлаарай, Харри гэж Люпин хэлэв.

- Тэгэхээр «Өдөр тутмын зөнч» бас Үхэл залгигчдын гарт орсон хэрэг үү? гэж

Гермиона ууртай асуулаа. Люпин толгой дохив.

- Гэхдээ хүмүүс юу болсныг ойлгож байгаа биз дээ?

- Халаа чимээ шуугиангүй явагдсан. Сикримжерийг албан ёсоор огцрон Империус шившлэгээр удирдагдаж байгаа Пиус Тикнесст суудлаа өгсөн гэж зарласан.

- Гэхдээ яагаад Волдеморт өөрөө яамны сайд болоогүй юм бэ? гэж Рон асуулаа. Люпин инээд алдав.

- Түүнд энэ хэрэггүй, Рон. Тэр сайд болсон ч гэсэн өрөөнд суух ямар хэрэгтэй юм бэ? Түүний тоглоомын хүүхэлдэй Тикнесс өдөр тутмын ажлыг нь хийж Волдеморт ид шидийн яаманд чөлөөтэйгээр засаглалаа тогтоож байна.

- Гэхдээ олон хүмүүс юу болоод байгааг ойлгосон. Сайдын сүүлийн жүжигчилсэн өөрчлөлтийн дараа Волдеморт энэ бүхний ард байгаа гэсэн яриа явж байгаа. Гэхдээ бүх зүйл шивнэхээс хэтрэхгүй байна. Хэн ч энэ тухай бусадтай ярилцаж зүрхлэхгүй итгэж болох эсэхээ мэдэхгүй байгаа бөгөөд хүн бүр сэжиглэлд орж гэр бүлийнхэн нь хохирогч болохоос айж байна. Тиймээ Волдеморт маш ухаалаг тоглож байна. Тэр бослого хийн өөрийгөө илрүүлж чадах байсан ч сүүдэрт үлдэн бусдын айдасаар тоглож байна.

- Тэгээд сайдын жүжигчилсэн өөрчлөлтийн дараа шидэт ертөнцөд Волдеморт биш намайг аюултай гэж хэлж байгаа юмуу? хэмээн Харри сонирхлоо.

- Энэ эргэлзээгүй нэг хэсэг нь. Одоо Дамблдор үхэж чи амьд үлдсэн хүү болохоор Волдемортын эсрэг тэмцлийн бэлэг тэмдэг болоод байна. Бүгдэд чи үхлийн баатар болж, Волдеморт чиний толгойг үнэлээд зогсохгүй хамгаалж болох бүх хүмүүсийг айдас эргэлзээнд оруулж байна.

- Бас энэ хооронд ид шидийн яам магл гаралтай хүмүүсийн эсрэг хөдлөөд эхэлсэн гээд Люпин «Өдөр тутмын зөнч сонин»-ыг түлхлээ.

- Хоёрдугаар нүүрийг хараарай.

Гермиона сонингийн хуудсыг «Хар урлагийн нууцууд» номын адил жигшин эргүүллээ.

- Магл гаралтай хүмүүсийг бүртгэж байна. Ид шидийн яамнаас магл гаралтай хүмүүсийг шидийн нууцуудыг хэрхэн эзэмшсэн талаар нь нарийвчилсан шалгалт хийж эхэллээ. Саяхан нууцын хэлтсээс ид шидийн хүч зөвхөн жинхэнэ

шидтэнгээс төрсөн хүнд уламжлагдах талаар судалгаа хийж эхэлсэн байна. Удам угсаанд нь шидтэн байсан гэдгийг батлаагүй магл гаралтай хүмүүсийг шидийн хүчийг хулгайлсанд тооцох болно. Ид шидийн яамнаас хууль бусаар шидийн хүчийг олж авсан магл гаралтай хүмүүсийн эсрэг шийдэмгий хөдөлж Магл бүртгэлийн комиссийг байгуулсан байна.

- Хүмүүс ийм зүйл болохыг зөвшөөрөхгүй гэж Рон хэлэв.

- Хэдийн болчихсон. Магл гаралтай хүмүүсийг авлаад эхэлчихсэн.

- Тэд ямар аргаар шидийн хүчийг хулгайлсан нь сонирхолтой юм? Энэ нь оюун ухаанд байдаг болохоор хулгайлж болохгүй тэгсэн бол ямар ч сангасваа байхгүй байсан биз дээ?

- Би мэднэ. Гэхдээ чи ойрын хамаатандаа нэгээс багагүй шидтэн байсан гэж баталж чадахгүй бол шидийн хүчийг хууль бус аргаар олж авсан гэж шийтгэл хүлээх болно.

Рон, Гермиона руу харснаа,

- Хэрвээ цэвэр цусын шидтэн магл гаралтай хүнийг гэр бүлийнхээ нэг хэсэг гэж баталвал яах вэ? Би бүгдэд Гермионаг миний үеэл гэж хэлж болох юм ... гэв.

Гермиона Роны гарыг чанга атгалаа.

- Баярлалаа Рон би чамайг ...

- Чамд сонголт байхгүй. Би чамд гэр бүлийн модоо танилцуулж ямар ч асуултанд хариулж чадахаар болгоно гэж Рон уурсан хэлэв.

Гермиона сулхан инээмсэглэв.

- Рон бид Харри Поттер гэдэг орон даяар эрэн сурвалжлагдаж байгаа гэмт хэрэгтэний хамт зугтаж байхад энэ чухал биш гэж бодож байна. Хэрвээ би сургуульд эргэж очих байсан бол өөр хэрэг. Ингэхэд Волдеморт Хогвартсын хувьд юу гэж төлөвлөж байгаа юм бол?

- Залуу шидтэн бүр заавал сурах ёстой. Энэ тухай өчигдөр үдэш мэдэгдсэн.

Өмнө нь заавал биелүүлэх албагүй байсныг өөрчилсөн юм. Мэдээж англий шидтэн бүр Хогвартсад боловсрол эзэмшдэг хэдий ч эцэг эх нь хэрвээ хүсвэл хилийн цаана сургахаар илгээдэг байсан. Харин одоо бүх шидтэнгүүд насанд хүртлээ Волдемортын хараанд байх боллоо. Үүнээс гадна магл гаралтай сурагчид суралцахаасаа өмнө цусны түвшин тогтоон шидтэний удамтай гэдгээ ид шидийн яаманд батлах ёстой.

Харри уур хилэнд автахаа мэдэрлээ. Тэр энэ агшинд арван нэгэн нас хүрсэн хүүхдүүд хөөрөн шидэт сурах бичиг худалдан авч Хогвартсыг хэзээ ч харахгүй гэдгээ магадгүй гэр бүлээ хэзээ ч харахгүй гэдгээ мэдэхгүй байгаа тухай бодов.

- Энэ ... энэ гээд тэр уурандаа хэрэгтэй үгээ олохыг хичээсэн ч Люпин аяархан,

- Би мэднэ гээд хэсэг эргэлзсэнээ,

- Харри би чамайг юу ч хэлэхгүйг ойлгож байгаа ч гэхдээ бүлэгт Дамблдор чамд даалгавар өгсөн гэсэн сэтгэгдэл төрсөн юмсан гэв.

- Өгсөн. Рон, Гермиона хоёр мэдэх болхоор надтай хамт яваа.

- Чи надад даалгаварын талаар тодруулж болохгүй юу?

Харри түүний буурал үсээр хүрээлэгдсэн үрчлээтэй царай руу харснаа нэг л хариулт өгөх болсондоо харамслаа.

- Чадахгүй нь, Римус уучлаарай. Хэрвээ Дамблдор таньд хэлээгүй бол би чадна гэж бодохгүй байна.

- Би чамайг ингэж хэлнэ гэдгийг мэдэж байсан юм гэж Люпин урам хугаран хэлээд,

- Гэхдээ би та нарт зарим талаар ашигтай байж болох юм. Чи намайг юу чадахыг мэдэж байгаа. Би та нарыг хамгаалж чадна. Харин та нар надад юу хэлэх гэж байгаагаа заавал хэлэх албагүй гэлээ.

Харри тээнэгэлзлээ. Энэ нь маш үгэнд нь ормоор ятгалаг байсан ч тэр үргэлж дэргэд нь байвал яаж нууц даалгавар биелүүлэхээ төсөөлсөнгүй.

Гермиона бодлогоширсон харагдсанаа,

- Тонкс яах болж байна? гэж асуулаа.

- Тонкс яасан гэж?

- Гэхдээ та хоёр чинь гэрлэсэн биз дээ! Яаж түүнийг орхиод бидэнтэй хамт явж болох юм бэ?

- Тонкс бүрэн аюулгүй байдалд байгаа. Тэр одоо эцэг эхийнхээ гэрт байгаа.

Люпины хоолойд ямар нэг ойлгомжгүй бараг хүйтэн гэмээр өнгө илэрлээ. Тэдэнд Тонкс эцэг эхийндээ сууж байна гэдэг нь хачирхалтай сангдсан төдийгүй тэр бүлгийн гишүүн бөгөөд Харрийн мэдэж байгаагаар үйл явдлын хамгийн гүнд нь орохыг эрмэлздэг билээ.

- Римус түүний бүх зүйл хэвийн үү ... та ойлгож байна уу ... та хоёрын хооронд гэж Гермиона итгэлгүйхэн хэлэв.

- Баярлалаа, бүх зүйл хэвийн гэж Люпин ширүүн дуугарахад Гермиона улайлаа.

Хэсэг зуур амаргүй чимээгүй болсны эцэст Люпин таагүй зүйл хүчлэн хэлж байгаа хүний маягтай,

- Тонкс хүүхдээ хүлээж байгаа гэлээ.

- Хөөх ямар сайхан хэрэг вэ! гэж Гермиона дуу алдав.

- Гайхалтай! гэж Рон урам зоригтой нэмэрлэв.

- Баяр хүргэе гэж Харри хэллээ.

Люпин хүчлэн ярвайх адил инээмсэглэснээ дараа нь,

- Тэгэхээр ... та нар миний саналын хувьд юу гэж бодож байна? Гурван хүн дөрөв болж болно биз дээ? Би хувьдаа Дамблдорыг үүнд сэтгэл хангалуун байхгүй байсан гэж бодохгүй байна. Эцсийн эцэст тэр өөрөө намайг хар урлагаас хамгаалах хичээлийн багшаар сонгосон. Иймээс минийхээр бол бид хэний ч харж тэр ч байтугай төсөөлж ч байгаагүй ид шидтэй тулгарах болно гэдэгт итгэлтэй байна гэв.

Рон, Гермиона хоёр Харри руу харлаа.

- Зүгээр л ... зүгээр л тодруулах гэсэн юм. Та Тонксыг эцэг эх дээр нь орхиод бидэнтэй хамт явах гэж байгаа юм уу?

- Түүнд ямар ч аюул учрахгүй эцэг эх нь санаа тавих болно гэж Люпин хайхрамжгүй хэлээд,

- Харри би Жеймс намайг чиний дэргэд байхыг хүсэх байсан гэдэгт итгэлтэй байна гэв.

- Юу гэвэл гэж Харри удаанаар хэлээд,

- Харин би үүнийг хүсэхгүй байна. Тэгээд ч эцэг минь таныг яагаад хүүхдийнхээ дэргэд биш миний дэргэд байхыг хүссэнийг сонирхох болно гэдэгт итгэлтэй байна гэв.

Люпин цонхийн цайлаа. Гал зуухны өрөөний температур арван градусаар унах шиг болов. Рон гал зуухны өрөөний бүх зүйлийг тогтоож авахыг хүссэн мэт нэг бүрчлэн ширтэхэд, Гермионагийн нүд Харри дээр туссанаа Люпин руу харав.

- Чи ойлгохгүй байна гэж Люпин эцэст нь хэллээ.

- Тэгвэл тайлбарла.

- Би Тонкстой гэрлэснээрээ алдаа гаргасан. Би үүндээ их харамсаж байна.

- Ойлгомжтой, ийм учраас л та түүнийг хүүхэдтэй нь хаяж бидэнтэй зугтах гэж байгаа юм уу?

Люпин хөл дээрээ үсрэн босоход сандал нь хойш унав. Тэр тэдэн рүү уурсан харахад

Харри амьдралдаа анх удаа царайд нь чонын төрх илрэхийг харлаа.

- Чи намайг эхнэртээ болон төрөөгүй хүүхэддээ юу хийснийг ойлгохгүй байна!

Би түүнтэй гэрлэх ёсгүй байсан, би түүнийг шоовдор хүн болгон хувиргасан!

гээд Люпин хажуулдан унасан сандлаа босгоод суув.

- Чи үргэлж намайг бүлгийн гишүүдийн дунд юмуу Хогвартст Дамблдорын хамгаалалтанд байхыг харж байсан! Тиймээс над шиг хүний хувьд шидтэний ертөнц яаж ханддагийг мэдэхгүй! Тэд миний өвдөлтийн тухай мэдэнгүүт ярилцахаа больдог! Чи миний юу хэлж байгааг ойлгож байна уу? Түүний төрөл төрсөгдийн хувьд бол бидний гэрлэлт бол айдас гэсэн үг. Ямар эцэг эхчүүд охиноо хүн чонотой гэрлэхийг хүсэх юм бэ? Харин хүүхэд ... хүүхэд ... гээд Люпин үсээ зулгааснаа галзуу юм шиг харагдав.

- Миний төрлийнхөн хэвийн төрдөггүй! Түүнийг над шиг төрнө гэдэгт итгэлтэй байна! Би яаж гэмгүй хүүхдэд өвчнөө халдаасандаа өөрийгөө уучилж чадах юм бэ? Хэрвээ ямар нэг шидээр намайг дуурайдаггүй юмаа гэхэд тэр эцэггүй өсвөл ичихгүй явдалгүй зуу дахин дээр байх болно!

- Римус! Та юу хэлж байна? Яаж хүүхэд танаас ичиж болох юм бэ? гэж

Гермиона нулимс мэлтэлзүүлэн шивнэлээ.

- Мэдэхгүй байна, Гермиона. Жишээлбэл надад түүнээс ичгүүртэй байна.

Харри яагаад тэж их уурласнаа ойлгоогүй ч бас хөл дээрээ бослоо. Люпин түүн рүү цохиулсан аятай харав.

- Хэрвээ шинэ дэглэм магл гаралтай хүмүүсийг муу гэж бодож байгаа бол түүнд хагас хүн чоно эцэг нь бүлэгт байгаа биз дээ? Миний эцэг намайг болон эхнэрээ хамгаалахын тулд үхсэн. Харин та түүнийг хүүхдээсээ татгалзан бидэнтэй хамт адал явдал эрхээр явах байсан гэж бодож байна уу?

- Яаж ... Чи яаж зүрхэлж байна? Энэ бол аюул осол болон алдар гавъяа эрмэлзсэн хэрэг биш ... чи яаж иймэрхүү зүйл ярьж чадаж байна ...

- Би таныг жаахан зориг зүрх мэдэрсэн гэж бодож байна. Тэгээд Сириусын байрыг эзлэхийг хүсч байгаа ...

- Харри, хэрэггүй! гэж Гермиона гуйсан хэдий ч тэр Люпины зэвхийрсэн царай руу хараад,

- Би хэзээ ч намайг Дементортой тэмцэхэд хулчгар хүн сургасан гэдэгт итгээгүй гэв.

Люпин саваагаа маш хурдтай гаргахад Харри өөрийнх рүүгээ ч гар сунгаж амжсангүй. Чанга тасхийх чимээ гарч тэр арагш нисэхээ мэдрээд гал зуухны хана мөргөн шалан дээр гулгаж унахдаа хаалганы цаагуур Люпины жанч зурсхийхийг харлаа.

- Римус, Римус эргээд ирээч! гэж Гермиона хашгирсан ч Люпин хариулсангүй.

Хормын дараа тэд үүдний өрөөний хаалга хаагдахыг сонсов.

- Харри чи яаж чадав аа? гэж Гермиона дуу алдан ёолов.

- Амархан хэрэг гээд тэр босоход толгойны арын хана мөргөсөн хэсэг дээр булдруу үүсчээ. Тэр бас л уур хилэндээ чичирсэн хэвээр байлаа.

- Над руу ингэж харахгүй хэрэггүй! гэж Гермионаг зандарлаа.

- Өөрөө түүн рүү тэгж битгий хар! гэж Рон тасхийв.

- Үгүй, үгүй маргалдах хэрэггүй! гээд Гермиона тэдний дундуур оров.

- Чи Люпинтэй ингэж ярих хэрэггүй байсан юм гэж Рон хэллээ.

- Тэр үүнийг хүртэх гавъяатай гэж Харри хэлэхэд ухаанд нь Сириус хөшиг рүү унаж, Дамблдорын бие агаарт хөшсөнөө унаж буй дүр зураг төсөөлөгдөн ногоон гэрэл зурсхийн эхийнх нь үнэн зүрхнээсээ гуйсан хоолой сонсогдлоо

...

- Эцэг эхчүүд хүүхдээ хаях ёсгүй хэрвээ ... хэрвээ тэдэнд энэ нь хэрэггүй л биш бол ...

- Харри ... гээд Гермиона тайвшируулахын тулд мөрөн дээр нь гар тавьсан ч тэр сэгсрээд холдож гал руу ууртай ширтэв. Урьд нь нэг удаа энэ зууханд Люпинтэй ярьж билээ. Тэр тэгэхэд Жеймсийг дурьдаж Люпин түүнийг тайвшируулсан. Харин одоо Люпины зовж шаналсан зэвхий царай нүдний урьд хөвөн гарч ирэхэд гэмшин харуусахаа мэдрэв. Рон, Гермиона хоёр чимээгүй байсан ч түүний ард чимээгүй ярьж байгаа эсэхийг мэдсэнгүй.

Түүнийг эргэж харахад тэд яаран бие биенээсээ харц буруулав.

- Би түүнийг хулчгар гэж нэрлэх ёсгүй байснаа ойлгож байна.

- Тэгэх хэрэгүй байсан гэж Рон батлав.

- Гэхдээ тэр биеэ яг л тэгж авч явж байсан.

- Тэгсэн ч гэсэн ... гэж Гермиона хэлэв.

- Мэдэж байна. Гэхдээ тэр үүний дараа Тонкс руу эргэж очвол би зөв зүйл хийсэн биз дээ?

Тэр хоолойны өнгөндөө гуйсан өнгө тодруулахгүй байж чадсангүй. Гермиона өрөвдсөн байртай ширтэхэд, Рон итгэлгүйхэн харлаа. Харри шат ширтээд эцгийнхээ тухай бодов. Жеймс түүний Люпинд хэлсэн үгэнд хүүдээ уурлах байсан болов уу?

Гал зууханд чимээгүй болж зөвхөн саяхан болж өнгөрсөн үйл явдалд цочирдсон Рон, Гермиона хоёрын чимээгүй зэмлэл сонсогдоно. Люпины авчирсан «Өдөр тутмын зөнч» сонины дугаар ширээн дээр хэвтсэн хэвээр эхний нүүрэн дээр нь Харрийн царай байлаа. Тэр ширээнд очиж суугаад сонинг нээж уншиж буй дүр эсгэв. Гэсэн хэдий ч нэг ч үг ялгаж чадалгүй ой ухааныг нь Люпин эзэлжээ. Харри сонингийн хуудасны цаана Рон, Гермиона хоёр ахин чимээгүй ярилтаа сэргээсэн гэдэгт эргэлзсэнгүй. Тэр хуудсыг чимээтэй эргүүлтэл нүдэнд нь Дамблдорын нэр тусав. Хормын дараа Харри гэр бүлийн гэрэл зурган дорх бичээсийг уншлаа.

Дамблдорын гэр бүл. Зүүн талаасаа Альбус, Персиваль шинэ төрсөн Арианаг тэврээд, Кендра, Аберфорт.

Тэр анхааралаа төвлөрүүлэн зургыг анхааралтай харлаа. Дамблдорын эцэг Персиваль нүдэнд дулаахан хүн бөгөөд энэ хуучирсан зурган дээрээс ч харц нь гэрэлтэж байлаа. Жижигхэн Ариана талхнаас томгүй бөгөөд тодорхой дүрс харагдсангүй. Харин эх Кендра нь тас хар үсээ овоолон самнажээ. Тэр сийлсэн юм шиг сайхан царайтай агаад торгон даашинз өмсчээ. Харрид түүний хар нүд, өргөн шанаа, шулуун хамар

яагаад ч юм америкийн индианчуудыг сануулав. Альбус, Аберфорт хоёр ижилхэн торон захтай хүрэм өмсөөд үс нь мөрөө хүртэл урт байлаа. Альбус дүүгээсээ хэдэн нас ах байсан ч өөрөөр бол хөвгүүд хоорондоо маш адилхан бөгөөд гэрэл зурган дээр Альбус нүдний шил зүүж эхлээгүй, хамар нь хугараагүй байлаа.

Дүүрэн аз жаргалтай жирийн гэр бүл сонингийн хуудсан дээрээс найрсаг инээмсэглэн ширтэнэ. Жижигхэн Арина гараа даллах аж. Харри гэрэл зургийн дээр байгаа гарчгийг олж харлаа.

АЛЬБУС ДАМБЛДОРЫН НАМТАРААС ТҮҮВЭРЛЭН АВАВ

Зохиогч Рита Скитер

Үүнийг уншвал одоогийнхоос илүү муу болохгүй гэж шийдээд Харри уншиж эхлэв.

Нөхөр Персивалаа баривчлагдан Азкабанд хоригдсоны дараа ихэмсэг бардам Кендра Дамблдор цаашид Насыпном Нагорьед амьдарч тэвчсэнгүй. Иймээс тэрбээр оршин суудаг газраа өөрчлөн гэр бүлийнхээ хамт Харри Поттер Хэцүү нэртээс хачирхалтайгаар аврагдсан газар болох Годрикийн хонхор нэртэй тосгонд шилжин суурьшихаар шийджээ.

Наспном Нагорьегийн адилаар Годрикийн хонхорт багагүй тооны шидэт гэр бүл амьдарч байсан хэдий ч Кендра тэдний хэнийг ч танихгүй учир нөхрийнхөө хийсэн гэмт хэргээс болж өмнөх газар шигээ хүмүүсийн нүдэнд өртөх явдал гарсангүй. Тэр хэдэн удаа хөршүүдийнхээ нөхөрлөх оролдлогыг эрс няцаасан учраас удалгүй түүний гэр бүлийг тайван орхижээ.

- Би тэднийг нүүж ирсэнд баяр хүргэхээр гэртээ хийсэн тогоон боов аваад очиход хаалгаа миний урд хааж билээ гэж Батильда Бэгшот ярьжээ.

- Анхны жилдээ тэднийг оршин сууж байх үед би зөвхөн хоёр хөвгүүнийг хардаг байлаа. Би охин байдаг гэж мэдээгүй ч тэднийг ирсний дараа сарны гэрэлд өвлийн шөнө Кендра Арианаг арын цэцэрлэгтээ зугаалуулахыг харсан. Тэр охиныхоо гараас чанга бариад байшингаа хоёр удаа тойрсон. Би энэ тухай юу бодохоо ч мэдээгүй.

Харваас Кендра Годрикийн хонхорт ирснээрээ Арианаг гадны нүднээс үүрд нуух боломж гарлаа гэж бодсон бололтой. Энэ бодол түүний толгойд жилийн өмнөөс орсон нь эргэлзээгүй. Цаг хугацаа үүнд багагүй үүрэгтэй байсан бөгөөд Ариана бараг л долоон нас хүрч түүнийг хараанаас гарах гэж байлаа. Долоон нас гэдэг бол хэрвээ хүүхдэд заяагдсан аваас шидийн авъяас илрэн гарч ирэх үе юм. Ийм учраас Кендра үүнийг нууж тэдний гэр бүлд сангасваа төрсөн гэдэг ичгүүрийг давахыг хүсээгүй байна. Арианаг мэдэх найз нөхөд болон Кендрагийн хөршүүд үргэлж охиноо гэртээ цоожтой байлгадагыг мэдэж байсан. Үүнээс хойш ч түүнийг байгааг мэдэх хүмүүс хуруу дарам цөөхөн бөгөөд нууцыг хадгалахад бэлэн байлаа. Тэдний тоонд орсон хоёр ах нь таагүй асуултанд эхийнхээ захиснаар «Дүү минь сургуульд сурч чадахааргүй бие муутай» гэж хэлэхэд хүрч байлаа.

Дараагийн долоо хоногт Альбус Дамблдор Хогвартст хэрхэн хуурамчаар шагнал хүртсэн тухай уншаарай.

Харри алджээ уншсан зүйл сэтгэлийг нь улам дордуулав. Тэр ахин аз жаргалтай гэр бүлийн зураг руу харлаа. Энэ үнэн болов уу? Үүнийг яаж тайлбарлах вэ? Түүнд Батильда ярьж чадахааргүй ухаантай байсан ч Дамблдор болон ойрын төрөл төрөгсөд нь амьдарч байсан Годрикийн хонхорт очих хүсэл төрөв. Тэр Рон,

Гермиона хоёрын бодлыг асуухаар сонингоос өндийтөл чих дөжрөм чанга тасхийх чимээ гарав.

Сүүлийн гурван хоногт анх удаа Харри Кикимерийн тухай мартсан байлаа. Түүнийг толгойг Люпины эргэн ирэлт эзэлсэн учир агшин зуур сандлынх нь хажууд шалан дээр өнхрөлдөж байгаа дүрсүүдийг хараад юу болсныг ойлгож чадсангүй. Тэр яаран босож Кикимерийг салгахад Харрид бөхийн ёслоод,

- Кикимер хулгайч Наземникус Флетчерийг авчирлаа, эзэнтээн гэв.

Наземникус шалан дээрээс босч ирээд саваагаа гаргасан ч Гермиона түүнийг хориглож,

- Экспеллиармус! гэв.

Наземникусын саваа агаарт хөөрөхөд тэр барьж авлаа. Наземникус галзуурсан юм шиг нүдтэй шат руу ухасхийсэн ч Рон замыг нь хаан чулуун шалан дээр дарж унав.

- Юу? гэж тэр Роны чанга тэврэлтээс чөлөөлөгдөх оролдлого хийн хашгирав.

- Би юу хийсэн юм? Над руу галзуу үйлчлэгч явуулаад. Яасан гэж? Би юунд ч буруугүй намайг тавиадах ...

- Та хүн сүрдүүлэх нөхцөлд биш байна гэж Харри хэллээ. Тэр сонингоо холдуулаад гал зуухан дундуур том алхлан очиход Наземникус эсэргүүцэхээ болиод айсан байртай харав. Рон амьсгаадан босож Харри саваагаа Наземникусын хамарт тулгалаа. Түүнээс хөлсний эвгүй үнэр тамхитай холилдон ханхлана. Үс нь ширэлдэж жанч толбо болсон байлаа.

- Кикимер хулгайчийг авчирахыг удаасандаа өршөөл гуйж байна, эзэнтээн.

Флетчер яаж булталаа мэддэг болохоор нуугдах газар хань хамсаатан олонтой. Ямар ч гэсэн Киккмер эцэст нь түүнийг буланд шахлаа.

- Чи гайхамшигтай ажилласан байна, Кикимер гэж Харри хэлэхэд эльф түүнд гүнээ бөхийн ёслов.

- Тэгэхээр бидэнд таньд тавих хэдэн асуулт байна гэж Харри Наземникус руу харж хэлэхэд даруйхан,

- Би цочирдолд орсон ойлгож байна уу? Би тэдэнтэй хамт явахыг хүсээгүй.

Хэзээ ч чиний төлөө сайн дурааараа үхэхийг хүсээгүй. Бас тэгээд чөтгөрийн Хэцүү нэрт миний дэргэд нисч байхад өөр яах байсан юм ... Би бүгдэнд чинь үүнийг хийхийг хүсэхгүй байна гэж хэлсэн биз дээ ... гэв.

- Таны шилжсэн тухай хэн ч яриагүй байна гэж Гермиона хэлэв.

- Тэгвэл та нар намайг баатар болохыг хүсээ юу? Би хэзээ ч тэгж амиа хорлох хүн биш ...

- Бид таныг яагаад Грюмыг яагаад орхиж зугтсаныг сонирхоогүй гээд Харри саваагаа түүний цус хурсан нүдний өмнө тулгаад,

- Бид таны өөдгүй хулчгар амьтан гэдгийг хэдийн мэдэж байсан гэлээ.

- За яахав тэгвэл над руу үйлчлэгч илгээдэг чинь яаж байгаа юм? Эсвэл ахиад л цомын тухай юу? Тэгвэл надад нэг ч үлдээгүй бөгөөд буцаах боломжгүй болсон ...

- Цом бидний анхаарлыг татахгүй байна. Амаа татаад сонс.

Тэр үнэнийг хэлүүлэхийн тулд юу хийх ёстойгоо сайн мэдэж байлаа. Харрийн савааны үзүүр Наземникусын хамарт тулахад сөлөр харснаа хэвийн харахыг хичээв.

- Та энэ гэрийн үнэтэй зүйлсийг нь хулгайлсан байна гэж Харри эхэлсэн ч

Наземникус ахин үгийг нь тасалж,

- Сириуст тэдгээр зүйлс хэрэггүй байсан гэв.

Тэгтэл яарсан алхаа сонсогдоод зэс гялсхийхэд дараа нь чанга цохилт ирэн өвдсөндөө хашгирах чимээ гарч Кикимер Наземникусын толгой руу хайруулын тавгаар цохьжээ.

- Энэ амьтанаа холдуул. Торонд хийх хэрэгтэй! гэж Наземникус гараарааа хаан орилоход Кикмер хүнд хайруулын тавгаа ахин өргөжээ.

- Кикимер боль! гэж Харри хашгирав.

Кикимерийн нарийхан гар хүнд хайруулын тавагны хүндийн жинд чичирснээ.

- Ахиад нэг удаа болох уу эзэнтээн? Азын төлөө? гэв. Рон инээд алдлаа.

- Бидэнд тэр ухаантай үлдэх хэрэгтэй байна, Кикимер гуйя гэж Харри хэлэв.

- Их баярлалаа, эзэнтээн гээд Кикимер бөхийн ёсолж хэдэн алхам ухраад

Наземникус руу үзэн ядсан харцаар ширтэв.

- Та энэ гэрийн энэ цэнэтэй зүйлсийг хуу хамах үедээ гал зуухын пингээс хэдэн зүйл авсан байна. Тэнд зүүлт байсан гээд Харрийн ам гэнэтхэн хатсанаа Рон, Гермиона хоёрын хөшихийг мэдрээд,

- Та түүгээр юу хийсэн бэ? гэлээ.

- Юу гэнээ? Тэр үнэтэй юм уу?

- Тэр таньд байгаа юу! гэж Гермиона дуу алдав.

- Үгүй ээ. Тэр зүүлтийг их үнэ хүргэхийг хүссэн байх гэж Рон хэллээ.

- Их гэнээ? Би түүнээс ихийг асуухын оронд үнэгүй өгсөн. Сонголт байгаагүй.

- Энэ чинь юу гэж байгаа юм? гэж Харри асуулаа.

- Би юмнуудаа Тахир гудамжинд зарж байтал тэр ирээд шидэт зүйлсийг худалдах зөвшөөрөл байна уу гэсэн. Хөгийн шиншлэгч. Намайг торгохыг хүссэн ч зүүлт түүний нүдэнд тусахад хэрвээ би түүнийг өгвөл зүгээр тавина гэсэн юм.

- Ямар эмэгтэй байсан юм?

- Хэн мэдэх юм, яамны ямар нэг шулмас биз гээд Наземиникус духаа үрчийлгэн бодлогоширов. Намхан эмэгтэй. Толгойны оройдоо тууз зүүсэн гээд үрчийснээ,

- Яг л бах гэсэн үг гэв.

Харри саваагаа буулгахад Наземникусын хамрын урд улаан оч ярсхийж хөмсөг нь шатлаа.

- Агументи! гэж Гермиона хашгирахад сабааны үзүүрээс ус гарч Наземникус хахаж цацан амьсгаадав.

Харри найзууд руугаа хараад түүнээс дутуугүй цочирдсоныг олж харав. Ингээд баруун гар дээрх сорви нь чимчигнэхийг мэдэрлээ.

БҮЛЭГ 12: ШИДИЙН ХҮЧ

Найман сар сунасаар эцэстээ хүрэхэд Гриммогийн байшингийн урд талын талбайн өвс наранд хатан гандаж хүрэн шаргалдуу болжээ. Арван хоёрдугаар байшинд хэн ч амьдарч суудаггүй бөгөөд хөршүүдийн хэн ч энэ байшингийн оршин байдагийг мэддэггүй байлаа. Гриммогийн байшинд эртнээс амьдарч буй маглууд хөгжилтэй алдаа гарган арван нэгдүгээр байшин, арван гуравдахьтай шууд хил залган тоолно.

Үнэндээ байшинд анхаарал татах зочин ирэхгүй тул харваас энэ нь анхаарал татахгүй зүйл байлаа. Гэсэн ч гадуур нь нэг юмуу хоёр хүн холхихгүй өдөр ховор тохиолдож арван нэг ба арван гуравдугаар байшинг тусгаарласан шатны хашлагыг нүд салгахгүй ширтэх аж. Тэдгээр хүмүүс өдөр бүр өөрчлөгдөх хэдий ч бараг бүгд жирийн хувцас өмсөх дургүй юм шиг харагдана. Лондончуудын ихэнхи нь эртнээс эдгээр этгээд хүмүүсийн дэргэдүүр өнгөрөхдөө анхаарал хандуулахаа больсон бөгөөд зөвхөн зарим нэг нь ийм халуунд урт нөмрөгтэй байгааг нь гайхширан харах аж.

Харваас эдгээр ажиглагчид ажилдаа сэтгэл хангалуун бус байлаа. Үе үе тэдний нэг нь ямар нэг сонирхолтой зүйл олж харсан мэт урагш ширтсэнээ урам хугаран эргэх нь бий.

Есдүгээр сарын нэгэнд талбай дээр ердийнхөөс илүү их хүн цугларлаа. Ойролцоогоор зургаа орчим урт жанч өмссөн хүмүүс чимээгүйхэн болгоомжтой зогсож арван нэг, арван гуравдугаар байшингийн зүг рүү үргэлжид байдаг шигээ нүд салгалгүй ширтэнгээ баригдашгүй хүн гарч ирэх гэж байгаа мэт байлаа. Үдэш гэнэтхэн хүчтэй салхилснаа энэ долоо хоногт анх удаагаа хүйтэн бороо асгарахад тэдний нэг нь гэнэтхэн тайлбарлах боломжгүй сонирхолтой зүйл харсан харсан мэт болов. Хачирхалтай мурий царайтай хүн дэргэдэх нөхөр болох намхан зэвхий царайтай хүнийг хуруугаараа хатган урагш хормын турш ширтсэнээ эцэст нь урам хугарч сэтгэл гонсойсон шинжтэй урьдын адил хөдөлгөөнгүй боллоо.

Энэ агшинд арван хоёрдугаар байшингийн үүдний өрөөнд Харри орлоо. Тэр шатны дээд талын гишгүүр рүү шилжихдээ тэнцвэр алдан арай унаагүй тул Үхэл залгичид тохойг нь хальт харсан байх гэж бодов. Тэр үүдний хаалгыг хааж түгжээд үл үзэгдэх цуваа тайлан гар дээрээ тохож «Өдөр тутмын зөнч» сонин барьсаар яаран хонгилын гал зуух руу алхав.

Түүнийг ердийнхөөр «Северус Снегг үү?» гэх сөөнгө шивнэлт угтан хүйтэн салхи сэвэлзсэнээ хэл нь агшин зуур орооцолдлоо.

- Би чамайг алаагүй гэж тэр ээдэрсэн хоолойгоор дуугартал дүрс дэлбэрэн тоос болж хувирлаа. Түүнийг гал зуухын шатаар бууж байх үед хатагтай Блэкийн тоосон үүлэн дунд хашгирах чимээ дуулдсанд чангаар,

- Надад та нарт дуулгах таагүй мэдээ байна гэв.

Гал зуух танигдахын аргагүй болон өөрчлөгджээ. Өрөөний зэс сав суулга, хайруулын таваг гээд бүх зүйлийг гялалзтал зүлгэсэн нь гэрэл ойлгож, урт модон ширээний гадаргуу гялтагнан, пор пор буцлах тогооны дор хөгжилтэй улалзах галын

гэрэл дээр нь өрөөстэй оройн хоолны таваг цомыг гэрэлтүүлнэ. Үүнээс хамгийн гайхалтай өөрчлөлт гэвэл Харриг угтан гэрийн үйлчлэгч ухасхийлээ. Түүний хувцас цас шиг цагаан, үс чих нь хөвөн адил цэвэрхэн хөвсгөр бөгөөд туранхай цээжиндээ Регулусын зүүлтийг зүүжээ.

- Харри эзэнтээн, хоол идэхийн өмнө гутлаа тайлж гараа угаана уу гэж Кикимер сөөнгөтөн хэлээд үл үзэгдэх цувыг саяхан угаасан хуучин нөмрөгийн дэргэдэх ханын дэгээнд өлгөв.

- Юу болсон бэ? гэж Рон болгоомжлон асуув. Гермиона тэр хоёр гал зуухны урт ширээний төгсгөлд овоолсон сараачсан тэмдэглэл, газрын зураг харж байснаа өндийхөд Харри дэргэд нь очоод сонингоо тавилаа.

Түүн дээр унжуу хамар хар үстэй танил хүний том гэрэл зургийн дор «СЕВЕРУС СНЕГГ ХОГВАРТСЫН ЗАХИРАЛЫН АЛБАН ТУШААЛД ТОМИЛОГДОВ» гэсэн гарчиг байлаа.

- Байж боломжгүй юм! гэж Рон, Гермиона хоёр дуу алдав. Гермиона Роноос түрүүлж сэхээ орон сонинг аваад чанга уншиж эхлэв.

- «Ид шидтэн илбэчний Хогвартс сургуульд удаан хугацааны турш уусмалын хичээл зааж байсан Северус Снегг өнөөдөр эртний түүхтэй энэхүү сургуулийн захирлын албан тушаалд томилогдсон бөгөөд багш нарын бүтцэд хэдэн чухал өөрчлөлт хийжээ. Үүний дагуу өмнөх ажлаасаа халагдсан магл судлалын багшийн орыг Алекто Кэрроу эзэлж, түүний ах Алекто Амикус хар урлагаас хамгаалах хичээлийн багш болсон байна.

- Би цэвэр шидтэнгүүдийн шидтэнгүүдийн уламжлалыг дэмжих болсондоо баяртай байна». Хүмүүсийг алахын тулд чихийг нь тайрна гэдэгт итгэлтэй байна! гэж Гермиона тургилаад,

- Снегг захирал болж! Снегг Дамблдорын өрөөнд байна ... Мерлиний өмд минь! гэж гэнэтхэн чанга дуу алдахад Харри, Рон хоёр давхийн цочлоо. Гермиона ширээнээс үсрэн босч гал зуухнаас гүйн гарахдаа,

- Одоохон ирнэ ээ! гэж хашгирлаа.

- Мерлиний өмд минь гэнэ үү? хэмээн Рон хөгжин хэлээд,

- Тэр харваас сэтгэлээр их унасан бололтой гэв.

Тэр сонинг татаад Снеггийн тухай нийтлэлийг анхааралтай харлаа.

- Бусад багш нар үүнийг тэвчихгүй. МакГонагалл, Флитвик, Стебль бүгд Дамблдорын хэрхэн үхсэн тухай үнэнийг мэдэж байгаа. Тэд Снегг захирал болохыг зөвшөөрөхгүй. Ингэхэд Кэрроу гэж хэн бэ?

- Үхэл залгигч. Тэдний зурган дунд байдаг. Тэд цамхагийн орой дээр Снегг Дамблдорыг алах үед хамт байсан болохоор одоо хуучин найзууд ахин нэгдсэн бололтой. Бас гэж Харри гашуунаар хэлээд сандалд сууж,

- Бусад багш нарт сургуульд үлдэхээс өөр ямар ч боломж байхгүй байх. Хэрвээ Снеггийн ард ид шидийн яам, Волдеморт байвал Азкабанд хэдэн жилийг өнгөрүүлснээс багшаараа үлдсэн нь дээр биз дээ. Тэгээд ч тэднийг явалгүй сурагчдыг хамгаалахыг оролдох болно гэж бодож байна.

Кикимер гартаа том савтай шөл барин ширээнд яаран ойртож ирснээ цэвэр тавганд хийхээс өмнө үлээв.

- Баярлалаа, Кикимер гээд Харри Снеггийн царайг харахгүйн тулд «Зөнч»

сонинг хуйлж,

- Ямар ч гэсэн бид Снеггийн хаана хайхаа мэддэг боллоо гэв.

Тэр шөлөө халбагадан уулаа. Кикимер Регулусын зүүлтийг авснаас хойш хоолны чадвар нь эрс дээшилж өнөөдөрийн франц сонгинотой шөл Харрийн идэж үзсэн хамгийн амттай шөл байлаа.

- Байшингийн гадаа бүлэг Үхэл залгигчид байна гэж тэр халбагадах зууpаа

Ронд хэлээд,

- Гэхдээ ердийнхөөс арай их байсан. Харваас биднийг сургуулийн чемодантай гараад «Хогвартс экспресс» рүү гүйхийг хүлээж байгаа бололтой гэв.

Рон цагаа харлаа.

- Би энэ тухай өдөржингөө бодлоо. Галт тэрэг бараг зургаан цагийн өмнө хөдөлсөн. Бид очиж чадах байсан ч яваагүй. Хачирхалтай мэдрэмж байгаа биз тийм үү? гэв.

Харри уурын улаан галт тэрэгний бүхээгт Роны хамт суугаад дэргэдүүр нь толгод, талбай жирэлзэн өнгөрч байна гэж төсөөлөв. Тэр одоо Жинни, Невилл, Полумна нар хамтдаа суугаад Рон, Гермиона тэр гурвын хаачсаныг тааварлан эсвэл Снеггийн шинэ дэглэмийг хэрхэн эсэргүүцэхээ ярилцаж байгаа гэдэгт эргэлзсэнгүй.

- Тэд намайг буцаж ирэхд арай л хараагүй. Би шатны дээд талын гишгүүр дээр эвгүй газардаад нөмрөг яльгүй сөхөгдсөн.

- Надад бол ийм зүйл үргэлж тохиолдож байдаг. Өө тэр ирж байна гэж Рон

Гермионагийн гал зууханд эргэн орж ирэхийг хүзүүгээ өлийлгөн харж хэлээд,

- Ямар нэгэн зүйл авчирч байна гэж Мерлиний нэрээр тангараглая гэв.

- Би гэнэтхэн үүнийг саналаа гэж Гермиона амьсгаадан тайлбарлалаа.

Тэр том жаазтай зураг авчирсан бөгөөд шүүгээн дээр байгаа сувдан цүнхэндээ хийхийн өмнө шалан дээр тавилаа. Тэр цүнхээ онгойлгоод тийм жижигхэн цүнхэнд хэт томдохоор зургийг хийхэд хэдхэн секунтын дараа цүнхний гүнд байгаа бусад эд зүйлсийн адил алга боллоо.

- Финеас Найжелус гэж Гермиона хэлээд цүнхээ ширээн дээр тавихад дотор нь харжигнах чимээ гарав.

- Өршөөгөөрэй? гэж Рон хэлсэн ч Харри бүгдийг ойлголоо. Финеас Найжелус Гриммогийн байшин болон Хогвартсын захирлын өрөөнд байгаа хуулбар зурагны хооронд шилжиж чаддаг билээ. Гэтэл одоо Снегг цамхагийн дээд талын дугуй өрөөнд эргэлзээгүй суугаад Дамблдорын мөнгөн эдлэлийг бахдан, гүн ухааны цүнхээл, хуваарилагч бүрх малгай хэрвээ хаа нэг тийш авч яваагүй бол Гриффиндорын илдийг эзэмшиж болсон юм.

- Снегг ийш нь Финеас Найжелусыг байшинг харуулахаар илгээж магадгүй гэж

Гермиона ширээнд суунгаа тайлбарлаад,

- Гэхдээ одоо оролдоод үзэг л дээ. Финеас зөвхөн миний цүнхэний дотор талыг харах болно гэв.

- Сайн бодож! гэж Рон урамтай хэлэв.

- Баярлалаа хэмээн Гермиона инээмсэглээд тавагтай шөлөө дөхүүлж,

- За, Харри өнөөдөр өөр юу болсон бэ? гэлээ.

- Юу ч болоогүй. Ид шидийн яамны үүдийг долоон цаг харуулдлаа. Түүний ямар ч шинж тэмдэг харагдсангүй. Роныг аавыг л харсан. Сайн харагдаж байсан.

Рон талархан толгой дохилоо. Тэд ноён Уизлиг ид шидийн яам руу орж байхад нь юмуу гарч байхад нь ярилцахаар бодсон ч үргэлж бусад ажилчдаар хүрээлэгдэн явах тул хэтэрхий осолтой байлаа. Хэдийгээр түүнийг хальт харахад ядарсан түгшсэн харагдаж байсан ч гэлээ энэ нь тайвширам зүйл байв.

- Аав үргэлж ид шидийн яамны ажилчдын ихэнхи нь нисдэг дарь ашиглан ажилдаа ирдэг гэсэн. Ийм учраас л бид Амбрижийг харахгүй байгаа байх. Тэр өөрийгөө хэтэрий чухал хүн гэж боддог болохоор хэзээ ч явган явахгүй гэж Рон хэлэв.

- Чинийхээр бол бараан хөх жанчтай жижигхэн шидтэн хэн болж байна? гэж

Гермиона сонирхлоо.

- Өө, тэр үү шидийн үйлчилгээний хэлтсийнх.

- Чи түүний тэнд ажилладагыг яаж мэдэж байгаа юм? гэж Гермиона халбагаа өргөн асуулаа.

- Аавын хэлснээр бол шидийн үйлчилгээний хэлтсийнхэн бараан цэнхэр өнгийн хувцас өмсдөг гэсэн.

- Гэхдээ чи энэ тухай бидэнд хэзээ ч хэлээгүй!

Гермиона халбагаа тавган дээр тавиад Харриг гал зууханд орж ирэхэд Роны хамт харж байсан газрын зураг тэмдэглэлээ татан ойртуулснаа,

- Энд бараан цэнхэр өнгийн жанчны тухай юу ч алга гээд хуудсуудыг эргүүлэв.

- Энэ тийм чухал гэж үү?

- Рон, бүх зүйл чухал! Хэрвээ бид ид шидийн яаманд нэвтрэхийг хүсч байвал бүх зүйлийг ширхэгчилэн мэдэх хэрэгтэй байна! Бид энэ тухай бараг зуу дахин ярилцсан. Тэгээд ч хэрвээ чи мэдэж байгаа зүйлээ хэлэхгүй бол бидний судалгаа ...

- Чөтгөр ав гэж, Гермиона би үүнийг мартчихаж ...

- Чи одоо бидний хувьд дэлхий дээр ид шидийн яамнаас аюултай газар байхгүй гэдгийг ойлгохгүй байгаа юм уу ...

- Маргааш тийшээ очсон нь дээр гэж бодож байна хэмээн Харри хэлэв. Гермиона үгээ дуусгалгүй чимээгүй болоход, Рон шөлөндөө хахаж цацлаа.

- Маргааш гэнээ? Чи үнэхээр хэлж байна уу, Харри? гэж Гермиона асуулаа.

- Үнэхээр. Бид ид шидийн яамны үүдэн дээр ахин нэг сар нуугдвал үүнээсээ дээрдэнэ гэж бодохгүй байна. Хэрвээ үүнээс илүү удах юм бол цаашид зүүлтийг олохгүй ч байж магад. Амбриж зүүлтийг онгойхгүй болохоор нь хаясан ч байж болно шүү дээ.

- Үгүй бол Амбриж түүнийг онгойлгоод эзэмдүүлсэн байх гэж Рон хэлэв.

- Түүний хувьд энэ ямар ч ялгаа байхгүй тэр үргэлжид хорон байдаг биз дээ хэмээн Харри мөрөө хавчлаа.

Гермиона бодолд автан уруулаа хазлав.

- Бид бүх чухал зүйлийг мэднэ. Тэдний ид шидийн яаман дотор шилжихийг хориглосныг мэднэ. Хамгийн чухал албан хаагчдын гэр ид шидийн яамны нисдэг дарины сараалжтай шууд холбоотой байдаг тухай Рон сонсож ирсэн. Бас Амбрижийн өрөө хаана байдаг тухай чи сахалтай хүн найздаа ярьж байхыг нь сонссон ... гэснээ,

- Би нэгдүгээр давхар руу явах хэрэгтэй байна, Долорес надтай уулзах гэж байгаа юм гэж цээжээр хэллээ.

- Яг тийм ... Үүнээс гадна ямар нэг хачирхалтай зоос юмуу бэлэг тэмдэг ашигладагийг мэднэ ... би тэдний нэг нь нөгөөгөөсөө зээлэхийг харсан болохоор ... гэж Харри хэлэв.

- Гэхдээ бидэнд тийм зүйл байхгүй!

- Хэрвээ төлөвлөгөө бүтвэл бий болно гэж Харри тайван хэлэв.

- Мэдэхгүй юм даа, Харри мэдэхгүй юм ... ямар ч тохиолдолд хэрэглэхэд хичнээн их зүйл хэрэгтэй байгаа гээч ...

- Тэгвэл үүнд бэлтгэхэд ахин гурван сар үрсэн ч байгаагаараа үлдэнэ. Хөдлөх цаг болсон.

Тэр үүнийг хэлмэгц Рон, Гермиона хоёрын айсан царайг хараад өөртөө итгэлгүй байсан ч төлөвлөгөөгөө эхлэх цаг болсон гэдэгт эргэлзсэнгүй.

Өнгөрсөн дөрвөн долоо хоногийг тэд үл үзэгдэх цув ээлжлэн өмсөж ид шидийн яамны үүдний гарцан дээр харуулдан өнгөрүүлжээ. Тэд ид шидийн яамны ажилчдыг

араас нь дагаж яриа хөөрөөг нь сонсон тэдний өдөр бүр нэг цагтаа ирдэг болон ганцаар явдаг эсэхийг тодруулжээ. Заримдаа тэдэнд хэн нэгний цүнхнээс «Өдөр тутмын зөнч» сонин хулгайлах боломж олддог байлаа. Түүнчлэн удаанаар ид шидийн яамны барилгын ноорог зураг гаргасан нь одоо Гермионагийн урд хэвтэнэ.

- За сайн байна гэж Рон удаанаар хэлээд,

- Бид маргааш явах болно ... Гэхдээ үүнд Харри бид хоёр байхад хангалттай гэж бодож байна гэв.

- Өө, бурхан минь ахиад бүү эхэлж үзээрэй дээ! Бид бүгдийг тохиролцсон юм шиг санагдах юм гээд Гермиона санаа алдав.

- Үүдэн дээр цувтай байна гэдэг бол Гермиона нэг хэрэг, харин одоо бол өөр зүйлийн тухай ярьж байна гээд Рон арван өдрийн өмнөх «Өдөр тутмын зөнч» сониныг хуруугаараа хатгалаа.

- Чи магл гаралтай хүмүүсийн байцаагдах хүмүүсийн жагсаалтанд орсон!

- Харин чи Үүрэнд тууралтаар өвдсөн байгаа! Хэрвээ хэн нэгэн явах ёсгүй бол

Харрийн толгой арван мянган галленоор үнэлэгдсэн ...

- Сайн байна, би энд үлдэе. Тэгвэл Волдмеортыг дуусгасныг чинь яаж мэдэх вэ?

Рон, Гермиона хоёр инээд алдахад Харрийн духан дээрх сорви янгиналаа. Тэр гараа духандаа хүргэснээ Гермионагийн нүд нарийсахийг хараад үсээ илсэн хөдөлгөөн болгон өөрчлөв.

- Хэрвээ бид гурвуулаа явбал тус тусдаа шилжих хэрэгтэй болно. Нэг үл үзэгдэх цуван дор багтахгүй гэж Рон хэлэв.

Харрийн сорви улам янгинахад бослоо. Түүн рүү Кикимер яаран хүрч ирэв.

- Эзэн шөлөө дуусгасангүй. Магадгүй эзэн жигнэсэн мах юмуу бурамтай бялуу идэхийг эрхэмлэж байгаа болов уу?

- Баярлалаа, Кикимер гэхдээ би түр явах хэрэгтэй байн а ... э-э ... угаалгын өрөө рүү.

Тэр Гермионагийн сэжигтэй ширтэхийг мэдрээд яаран үүдний өрөө рүү өгсөж хоёр давхарын угаалгын өрөөнд ухасхийн ороод хаалга хаалаа. Тэгээд өвдсөндөө аяархан дуу алдаж амаа ангайсан могойн дүрс бүхий цорготой угаалтуурыг налан суугаад нүдээ анилаа ...

Тэр бүрэнхий гудамжинд байлаа. Хоёр талаар нь өндөр дүнзэн байшингууд эгнэнэ. Тэр нэг руу нь дөхөж очоод урт цагаан хуруутай гараараа хаалга цохиход сэтгэл нь хөөрөн догдлов.

Хаалга нээгдэхэд босгон дээр инээмсэглэсэн эмэгтэй гарч ирэв. Тэр Харрийн царайг хармагцаа хөгжилтэй байдал нь айдсаар солигдов ...

- Грегорович? гэж тэр өндөр хүйтэн хоолойгоор асуулаа.

Эмэгтэй толгойгоо сэгсрэн хаалга хаахыг хичээсэн ч цагаан гар чанга барьж байсан тул байрнаас нь хөдөлгөсөнгүй.

- Надад Грегорович хэрэгтэй байна!

- Er wohnt hier nicht mehr! гээд эмэгтэй хашгиран толгой сэгсэрлээ.

- Тэр энд амьдардаггүй! Амьдардаггүй! Би тийм хүнийг мэдэхгүй!

Тэр хаалга хаах оролдлогоо орхин харанхуй хонгил руу ухрахад Харри араас нь даган орохдоо урт хуруундаа саваагаа барилаа.

- Тэр хаана байна?

- Das weiff ich nicht! Тэр явсан! Би мэдэхгүй, юу ч мэдэхгүй!

Харри саваагаа өргөхөд эмэгтэй хашгирлаа. Үүдний өрөөнд хоёр хүүхэд гүйж ирэв. Эмэгтэй тэднийг гараараа хамгаалахыг оролдов. Ногоон гэрэл гялсхийлээ ...

- Харри! Харри!

Тэр нүдээ нээхэд шалан дээр сууж байлаа. Гермиона ахин үүд нүдэв.

- Харри онгойлго!

Харри ямар нэг зүйл хашгирсан гэдгээ ойлголоо. Тэр босож хаалга нээхэд Гермиона ухасхийн орж ирэхдээ унах шахаж эргэн тойрныг сэжигтэй харлаа. Түүний араас Рон орж ирээд хүйтэн угаалгын өрөөний өнцөг булан бүрийг бухимдангуй ажиглав.

- Чи энд юу хийж байсан юм? гэж Гермиона ширүүн асуув.

- Чинийхээр бол юу хийж байсан гэж? хэмээн Харри сулхан зоригтой дуугарав.

- Чи толгойгоо авхуулах гэж байгаа юм шиг орилсон гэж Рон хэллээ.

- Аан тийм л дээ ... би зүүрмэглэсэн байх эсвэл ...

- Харри, гуйя биднийг тэнэг гэж бүү бод гээд Гермиона гүнзгий санаа алдсанаа,

- Бид чиний сорви ахиад өвдсөнийг мэдэж байна. Чи бүр даавуу шиг цайчихаж гэв.

Харри угаалгын онгоцны ирмэг дээр суулаа.

- За сайн байна. Би сая Волдеморт эмэгтэйг алж байхыг харлаа. Тэр одоо магадгүй бүх гэр бүлээр нь алсан байх. Ямар ч хэрэггүй байсан гэсэн. Тэд яг л Седрикийн адил түүний гарт өртсөн ...

- Чи үүнийг болих ёстой, Харри! гэж Гермиона хашгирахад дуу нь угаалгын өрөөний цуурайтлаа.

- Дамблдор чамайг окклюменийд сургахыг хүсч байсан. Тэр энэ холбоог аюултай гэж бодож байсан ... Волдеморт ашиглаж болно гэж! Нэгэнт чи

тэдэнд тусалж чадахгүйгээс хойш түүний хэрхэн хүмүүсийг алах юмуу тамлахыг харах ямар хэрэгтэй гэж?

- Тэгж түүний юу хийж байгааг мэддэг юм.

- Тэгэхээр чи түүнээс холбоогоо салгахыг хүсэхгүй байгаа юм уу?

- Би чадахгүй, Гермиона. Чи намайг окклюменций сураагүй гэдгийг мэднэ. Би хэзээ ч түүнээс жинхэнээсээ хийж үзээгүй.

- Тиймээ чи хэзээ ч оролдож үзэж байгаагүй! Би чамайг ойлгохгүй байна, Харри. Эсвэл чамд энэ онцгой холбоо эсвэл харьцаа ч юмуу таалагдаад байгаа юм уу ...

Тэр тээнэгэлзэн чимээгүй болоод босохыг нь дагуулан харав.

- Таалагдах гэнээ? Харин энэ чамд таалагдах байсан уу?

- Надад ... үгүй ... уучлаарай, Харри. Би хүсээгүй ...

- Би энэ холбоог үзэн яадж байгаа ч түүнийг улам аюултай болохыг нь харж байна. Би үүнийг ашиглаж байна.

- Дамблдор ...

- Дамблдорын тухай март. Энэ бол хэний ч биш миний сонголт. Би яагаад түүнд Грегорович хэрэг болсон гэдгийг мэдэхийг хүсч байна.

- Хэн гэнээ?

- Гадаадын шидэт саваа зохион бүтээгч алдартай мастер. Тэр Крамын савааг хийсэн. Тэр түүнийг хамгийн шилдэг гэж боддог юм билээ.

- Гэхдээ чи Волдеморт Оливандерыг хаа нэгтээ хорьж байгаа гэж хэлсэн биз дээ. Хэрвээ түүнд хэдийн нэг мастер байгаа бол бол хоёр дахь нь ямар хэрэгтэй гэж? хэмээн Рон хэлэв.

- Магадгүй Крамын хэлсэнчилэн Грегорович илүү гэж бодсон байж мэднэ.

Эсвэл Грегорович түүнд миний араас хөөхөд саваа юу хийснийг тайлбарлаж чадна гэж бодсон ч байж магадгүй. Олливандер үүнийг хэлж чадаагүй.

Харри хагарсан тоостой толь руу харахад Рон, Гермиона хоёр ард нь учиртай харц солилцов.

- Харри чи үргэлж үүнийг саваа чинь хийсэн гэж батлаад байх юм. Гэхдээ чи үүнийг хийсэн биз дээ! Яагаад чи тийм хүчийг эзэмдэж байгаа гэдгээсээ татгалзаад байгаа юм бэ?

- Яагаад гэвэл надад ямар ч хүч байхгүй гэдгийг ойлго! Бас Волдемортод ч гэсэн, Гермиона! Бид хоёулаа юу болсныг мэдэж байгаа!

Тэд бие биенээ уурсан харахад Харри Гермионаг итгүүлж чадаагүй бөгөөд савааны тухай онол болон Волдемортын ухааныг харахын эсрэг байгааг нь ойлголоо. Тэгтэл Харрийн санааг амраан маргаанд Рон оролцов.

- Боль доо. Энэ түүний хэрэг. Гэхдээ бид маргааш өглөө ид шидийн яаманд орох гэж байгаа бол бүгдээрээ ахин нэг удаа төлөвлөгөөгөө бодож үзэх хэрэгтэй байна.

Гермиона дургүйхэн цааш эргэсэн ч Харри түүнийг анхны боломжоор дайралтаа ахин эхлэхийг ойлгож байлаа. Тэднийг гал зууханд эргэн ороход Кикимер хэдийн ширээ дээр жигнэсэн мах, бурамтай бялуу тавьсан байв.

Тэд шөнө орой болтол унталгүй хэдэн цагийн турш төлөвлөгөөгөө ахин дахин хэлэлцэж бие биендээ цээжлүүлэв. Харри одоо Сириусын өрөөнд унтаж байгаа болохоор сабааны гэрэлдээ эцэг, Сириус, Люпин, Петтигрюгийн хуучин гэрэл зургийг харж төлөвлөгөөгөө арван хором шивнэн давтав. Тэр сабааныхаа гэрлийг унтраагаад ахин хувиргагч уусмал, бөөлжүүлдэг чихэр, ид шидийн яамны бараан өнгийн жанчны тухай бодохгүй байхыг хичээн Грегорович Волдемортоос хэр удаан нуугдаж чадахыг бодлоо.

- Чи аймшигтай харагдаж байна гэж өглөө түүнийг сэрээхээр ирсэн Рон хэлэв.

- Энэ удаан үргэлжлэхгүй гээд Харри эвшээлээ.

Тэднийг гал зууханд орох үед Гермиона шалгалтын өмнөх шиг царайтай суугаад

Кикимер өмнө нь кофе, шарсан талх тавьж байв.

- Жанч гэж тэр Рон, Харри хоёрыг мэндлэн толгой дохиход дуу алдаад ахин цүнхээ ухаж эхлэв ...

- Хувиргагч уусмал ... үл үзэгдэх цув ... анхаарал сатааруулагч ... ямар ч гэсэн хоёрыг авчихья ... бөөлжүүлдэг болон цус гоожуулдаг чихэр, Уртасгагч чих ...

Тэд өглөөний ундаа уугаад үүдний өрөө рүү өгсөхөд Кикимер бүгдэд нь бөхийн ёсолж үдсэн бөгөөд эргэж ирэхэд нь бөөртэй хуушуур, бифштекс хийсэн байхаар амаллаа.

- Тэр ямар эелдэг юм бэ. Харин би толгойг нь огтолж хананд өлгөхийг хүсч байсан гэж Рон найрсагаар хэлэв.

Тэд довжооны дээд гишгүүр дээр болгоомжтой гарахад манантай талбай дээр хоёр Үхэл залгигч зогсож байв. Гермиона эхэлж Роны хамт шилжээд дараа нь Харри руу эргэж ирэв.

Ердийн дотор давчидсан богино нислэгийн дараа Харри тэдний төлөвлөгөөний эхний хэсэг хэрэгжих ёстой жижигхэн давчуу гудамжинд газардлаа. Хэрвээ хоёр том хогийн савыг эс тооцвол гудамж хоосон байсан бөгөөд эхний ид шидийн яамны ажилчин энд ирэх ёстой байлаа.

- За тэр энд таван хормын дараа ирэх ёстой гэж Гермиона цагаа харан хэлээд,

- Тэгэхээр нь би түүнийг хөшөөнө гэлээ.

- Бид үүнийг мэднэ, Гермиона. Гэхдээ түүнийг ирэхээс өмнө хаалга онгойлгосон нь дээр гэж бодож байна хэмээн Рон ширүүн дуугарлаа.

Гермиона дуу алдсанаа,

- Мартах шахлаа! Хойшоо ухраарай ... гэв.

Тэр саваагаа үүдний цоожинд хүргэхэд сараачсан бичигтэй хаалга чахран онгойж хоосон театр руу хүргэдэг харанхуй хонгил нээгдэв. Гермиона хаалгыг хааж ахин цоожтой юм шиг харагдуулахаар болголоо.

- Харин одоо бид ахин үл үзэгдэх цуваа өмсөж ... гэж тэр гудамжны дунд зогсож байсан Рон, Харри хоёр руу эргээд хэлэв.

- Тэгээд хүлээнэ гэж Рон дуусгаад цуваа Гермионагийн толгой дээгүүр нөмөргөхөд торонд орсон шувуу адил Харри руу нүдээ эргэлдүүлэн харлаа.

Хормын дараа аяархан тасхийх чимээ гарч тэднээс метрийн зайд ид шидийн яамны жижигхэн буурал үстэй, шидтэн эмэгтэй нарны хурц гэрэлд нүдээ анивчсаар шилжин ирэв. Тэгтэл Гермиона чимээгүйхэн Хөшөөх шившлэг цээж рүү нь илгээхэд газар уналаа.

- Сайн ажиллаа, Гермиона гээд Рон хогийн савны араас гарахад Харри үл үзэгдэх цуваа тайллаа.

Тэд хоёул хамтдаа жижигхэн шидтэн эмэгтэйг тайзны арын харанхуй хүйтэн хонгил руу чирэн оруулав. Гермона түүнээс хэдэн үс зулгаан авч сувдан цүнхнээсээ гаргаж ирсэн дашмагтай Хувиргагч уусмалд хийв. Рон энэ зуур цүнхийг нь нэгжлээ.

- Түүнийг Муфалда Хмелкирк гэдэг юм байна гэж ид шидийг хууль бусаар ажиллахтай тэмцэх хэлтсийн үнэмлэхийг нь уншиж хэлээд,

- Чи үүнийг авсан дээр байх, Гермиона. Май энэ таних тэмдгийг нь ч гэсэн гэв.

Рон түүнд түрийвчнээс нь авсан хэдэн жижигхэн алтан зоос өглөө.

Гермиона Хувиргагч уусмалыг уугаад таагүй ягаан өнгөтэй болсноо хормын дараа хоёр дахь Муфалда Хмелкирк болон зогсож байв. Тэр Муфалдагийн шилийг зүүхэд, Харри цагаа харлаа.

- Бид хоцорч байна шүү. Ноён шидийн үйлчилгээний хэлтсийн ажилчин одоохон энд ирнэ.

Тэд яаран жинхэнэ Муфалдаг хийсэн хаалгыг хаалаа. Энэ удаад үл үзэгдэх цуван дор Рон, Харри хоёр нуугдаж Гермиона ил үлдэв. Хормын дараа ахин нэг тасхийх чимээ гараад жижигхэн өмхий хүрэн шиг шидтэн гарч ирэв.

- Өө сайн байна уу, Муфалда.

- Сайн байна уу гэж Гермиона чичирсэн хоолойгоор хэлээд,

- Таны бие өнөөдөр ямар байна? гэлээ.

- Үнэнийг хэлэхэд тийм ч сайн биш байна гэж жижигхэн шидтэн урвагар царайлан дуугарав.

Гермиона түүний хамт төв гудамж руу чиглэхэд Харри, Рон хоёр араас нь дагав.

- Таны бие муу байгаа нь харамсалтай байна гээд Гермиона шидтэнг гудамжинд гаргахгүйн тулд хажуугаас нь түшин,

- Май, энэ чихрийг ав гэлээ.

- Юу? Аан үгүй дээ баярлалаа ...

- Гэхдээ би шаардаж байна! гэж Гермиона түрэмгий хэлээд хэлээд хамар дор нь чихрээ тулгахад жижигхэн шидтэн айсандаа нэгийг авлаа.

Энэ нь хоромхон зуур үйлчлэв. Шидтэн түүнийг хэлдээ хүргэв үү үгүй юу хөөрхий амьтан бөөлжиж эхэлсэн тул Гермиона зулайнаас нь хэдэн үс зулгаан авсныг мэдсэнгүй.

- Өө бурхан минь! гэж тэр хэлээд,

- Магадгүй та өнөөдөр ажилдаа очихгүй байсан нь дээр байх гэлээ.

- Үгүй ... үгүй! гээд тэр хий огуилснаа хана түшин зогсож,

- Түүнд ... Би ... өнөөдөр ... тийшээ явах ёстой гэв.

- Гэхдээ энэ чинь тэнэг хэрэг шүү дээ! гэж Гермиона түгшин дуу алдсанаа,

- Та ажилдаа ийм байдалтай очиж болохгүй. Гэгээн Мунгогийн эмнэлэг рүү явсан нь дээр байх гэв.

Шидтэн дөрвөн хөллөн унаад төв гудамж руу мөлхөн зүтгэлсэн хэвээр байлаа.

- Ийм байдалтай ажилдаа явж болохгүй! гэж Гермиона хашгирав.

Эцсийн эцэст шидтэн түүнийг зөвшөөрч Гермионагаас зууран босоод байрандаа эргэн алга болохдоо сүүлчийн агшинд суга татан авсан Роны гарт цүнхээ үлдээж агаарт бөөлжисийн үлдэгдэл үсрэв.

- Түй! гээд Гермона нөмрөгөн дор бөөлжисөөс зугтан орж ирснээ,

- Түнийг хөшөөсөн нь дээр байсан юм гэв.

- Тийм л дээ гэхдээ би ухаангүй бие байх нь хэтэрхий анхаарал татна гэж бодсон юм гээд Рон цүнхийг гартаа барьж,

- Гэхдээ тэр ажилдаа их дуртай юм тийм үү? Алив үсийг нь уусмалд хийцгээе гэв.

Хоёр хормын дараа Рон тэдний өмнө өмхий хүрэнтэй төстэй жижигхэн өвдсөн шидтэнтэй төстэй болоод зогсож байв. Тэр цүнхнээс олсон бараан хөх өнгийн жанчыг өмсчээ.

- Тэр өнөөдөр яагаад ажилдаа өмсөж яваагүй нь хачирхалтай юм. Ингэхэд жанчин дээрх нэрнээс үзэхэд намайг Реж Кроткотт гэдэг бололтой.

- Энд хүлээж бай. Хэдэн хормын дараа чамд үс авч өгье гэж Гермиона үл үзэгдэх цуван дор Харри руу харж хэллээ.

Тэр Муфалдаг хөшөөсөн хаалган дээр арван хором хүлээсний эцэст Рон, Гермона хоёр эргэн ирлээ.

- Хэн болохыг нь мэдсэнгүй гээд Гермиона Харрид хэдэн буржгар хар үс сарвайж,

- Гэхдээ тэр хамраас нь аймшигтай цус гараад гэр лүүгээ харьсан. Хүлээгээрэй тэр их биерхүү болохоор чамд том жанч шаардагдана гэв.

Тэр цүнхнээсээ Кикимерийн угаасан хуучин жанч гаргаж ирэхэд Харри уусмалыг уухын тулд холдлоо.

Эмзэглэм өвдсөн хувиргалтын дараа тэр зургаан фут болон өсч булчинлаг гараа хараад хүчихэг болсноо мэдлээ. Үүн дээр нэмээд бас сахалтай болсон байв. Харри шинэ хувцсан дор үл үзэгдэх цув, нүдний шилээ нуугаад найзуудтайгаа нэгдлээ.

- Чөтгөр гэж, ямар аймшигтай юм бэ хэмээн Рон Харрийн сүндэрлэсэн төрхийг хараад хэлэв.

- Муфалдагийн нэг таних тэмдэгийг ав. Явъя бараг ес болох нь гэж Гермиона дуугарлаа.

Тэд гудамжинд хамтдаа гарлаа. Холгүйхэн зам дээр бөөн хүмүүс «эрэгтэй»,

«эмэгтэй» гэж бичсэн төмөр хашлагатай хоёр ондоо шатаар бууж байв.

- За, хормын дараа уулзацгаая гэж Гермиона түгшин хэлээд эмэгтэйчүүдийн шатыг уруудав. Харри, Рон хоёр олон тооны хачирхалтай хувцастай хүмүүстэй нийлэн ердийн хар цагаан хавтантай нийтийн жорлонд орлоо.

- Өглөөний мэнд, Реж! гэж Рон руу бараан хөх өнгийн жанчтай шидтэн алтан таних тэмдгээ бүхээгний хаалганы завсарт шургуулан хашгирлаа.

- Чөтгөр ав юу болоод байна? Тэд яагаад биднийг ажилдаа ийм янзаар очиход хүргэж байна. Хэнээс сэргийлнэ гэж хүлээсэн юм бол, Харри Поттероос уу?

Шидтэн ухаангүй хөхрөхөд Рон хүчлэн инээд алдсанаа,

- Тиймээ. Энэ тэнэг хэрэг биз дээ? гэв. Харри тэр хоёр зэргэлдээ орших бүхээгт орлоо.

Харрийн зүүн баруун талд жорлонгийн ус татах чимээ сонсогдоно. Тэр доошоо суугаад зэргэлдээ бүхээгт байгаа хос гутал жорлон руу авирахыг харлаа. Дараа нь зүүн тийш эргэхэд Рон нүд ирмэлээ.

- Бид жорлон дотор орох хэрэгтэй юм биш биз? гэж Рон шивнэлээ.

- Тийм бололтой гэж Харри шивнэсэн ч хахир дуутай болсноо мэдлээ.

Тэд бослоо. Харри өөрийн хичнээн тэнэг болохоо мэдэрсээр жорлон руу хоёр хөлөө шургуулав.

Ингээд шууд зөв хийснээ ойлгожээ. Усан дотор зогсож байсан ч гутал хувцас нь хуурай байв. Харри гараа сунган гинжийг татахад дараагийн агшинд муу усны цооног руу орсноо ид шидийн яамны зууханд гарч ирлээ.

Тэр дасал болоогүй нүсэр биеэрээ эв хавгүйхэн өндийлөө. Аварга том үүдний танхим Харрийн санаж байснаас илүү баргар байлаа. Урьд нь танхимын төвд алтан усан оргилуур байж гэрэл нь толигор модон, шал ханан дээр тусаж байдаг байсан. Одоо энд хар чулуун хөшөө ноёлж байв.Энэ айдас хүрэм том уран баримал бөгөөд

шидтэнгийн хаан сууж байгааг дүрсэлж дэргэдүүр нь зуухнаас гарсан ид шидийн яамны ажилчид доош харан яаран өнгөрнө. Хөшөөн дээр том үсгээр «ИД ШИДИЙН ХҮЧ» гэж сийлжээ.

Ямар нэг зүйл Харрийн хөлийг өвдтөл цохиод ханан зуухнаас ахин нэг шидтэн гарч ирлээ.

- Замаас холд ... өө, уучлаарай, Ранкорн!

Халзан толгойтой шидтэн айсан янзтай яаран холдлоо. Түүний байдлаас үзэхэд

Харрийн хуулбарласан шидтэн сүрдүүлэгч бололтой.

- Псст! гэх чимээ гарахад эргэн тойрноо харвал жижигхэн шидтэн эмэгтэй болон өмхий хүрэнтэй төстэй шидтэн хоёр хөшөөний хажууд зогсоод зангаж байлаа. Харри яаран тэдэн рүү очив.

- Бүх зүйл хэвийн үү? гэж Гермиона Харрид шивнэлээ.

- Үгүй тэр гахай шиг харагдаж байна гэж Рон хэлэв.

- Өө, маш инээдтэй байна ... Аймшигтай байгаа биз тийм үү? Чи тэдний юун дээр сууж байгааг харав уу? гэж тэр хөшөө рүү харж буй Харрид хэллээ,

Харри анхааралтай хараад үнэн хэрэгтээ хааны суудал гэдэг нь овоолсон хүний сийлбэр бөгөөд зуу зуун нүцгэн эрэгтэй, эмэгтэй хүн, хүүхдүүд үзэсгэлэнтэй сайхан жанч бүхий шидтэнгүүдийн жин дор тэнэгдүүхэн муухай царайлан хэвтэхийг харлаа.

- Маглууд. Энэ тэдний байх ёстой газар нь. Алив ээ, явцгаая гэж Гермиона шивнэв.

Тэд шидтэнгүүдийн урсгалтай нэгдэн үүдний танхимын төгсгөлд байгаа алтан хаалга руу явлаа. Гурвуул нууцгайхан харж байсан ч Долорес Амбрижийн бараа хаа ч байсангүй. Тэд хаалгаар ороод багахан танхимд байх хориод цахилгаан шатны алтан сараалжны өмнө дараалал үүссэнийг харлаа. Тэднийг ойролцоох нэг рүү очиход хэн нэг нь,

- Кроткотт! гэлээ.

Харри эргэж хараад дотор нь палхийлээ. Тэдэн рүү Дамблдорын үхдэг шөнө байсан Үхэл залгигчдын нэг ирж байв. Ид шидийн яамны ажилчид хажуу тийшээ чимээгүйхэн зай тавьж өгөөд харц буруулав. Харри тэднийг айдас нөмрөн авахыг мэдэрлээ. Зэвүүн харцтай энэхүү хүний хэрцгий царай алтан утсаар хатгамласан

сайхан жанчтай нь хачирхалтай хосолж харагдана. Цуглагсдын хэн нэг нь бялдуучлангуй «Өглөөний мэнд, Якслі!» гэлээ. Якслі үүнийг үл тоомсорлов.

- Би үйлчилгээний хэлтсийнхэнд өрөөндөө юм хийлгэх хүсэлт тавьсан, Кроткотт. Тэнд бороо орсон хэвээр байна.

Рон хэн нэгэн ярихыг хүлээж эргэн тойрноо харсан ч бүгд чимээгүй байлаа.

- Бороо гэнээ ... таны өрөөнд юу? Энэ ... сайн биш тийм үү? гээд Рон бухимдангуй инээд алдав. Якслийн нүд томорлоо.

- Таньд энэ инээдтэй санагдаж байна уу, Кроткотт? Цахилгаан шатны дараалалаас хоёр шидтэн яаран гарлаа.

- Үгүй ... мэдээж үгүй ...

- Намайг одоо эхнэрийг чинь байцаахаар явж байгааг мэдэж байна уу, Кроткотт? Үнэнийг хэлэхэд тэр таныг доошоо бууж гараас нь барихыг хүлээгээгүй байвал би ихэд гайхах байна. Түүнийг хэдийн найдлагагүй жагсаалтанд бичсэн. Дараагийн удаад цэвэр цусны шидтэнтэй гэрлэхийг хичээгээрэй дээ.

Гермиона айсандаа аяархан дуу алдав. Якслы түүн рүү харахад ханиалгаснаа эргэж харлаа.

- Би ... би гэж Рон ээрэв.

- Хэрвээ миний эхнэрийг бохир цустан гэж буруутгасан бол ... хэзээ ч алдаа гаргаж тийм жигшүүртэй эмэгтэйтэй гэрлэхгүй байлаа. Энэ бол ид шидийн хуулийг албадан хэрэгжүүлэх хэлтсийн ажил. Би энэ хэлтэст ажилладаг болохоор түүнийг хийх давуу эрхтэй, Кроткотт. Та намайг ойлгов уу?

- Тийм гэж Рон шивнэлээ.

- Тэгвэл ажлаа хий, Кроткотт! Хэрвээ цагийн дараа гэхэд миний өрөө хуурай болоогүй байвал эхнэрийн цусны түвшин одооныхоос илүү эргэлзээтэй болно шүү.

Тэдний урд алтан сараалж чахран нээгдлээ. Харри толгой дохиод таагүй инээмсэглэхэд, Якслы өөр цахилгаан шат руу орлоо. Харри, Рон, Гермиона гурав өөрсдийнх рүү ороход хэн ч дагасангүй. Сараалж хяхтнан хаагдмагц цахилгаан шат дээшээ өгслөө.

- Би одоо юу хийх вэ? гэж Рон мэгдэн асуугаад,

- Хэрвээ би үүнийг хийхгүй бол миний эхнэрийг ... Кроткоттын эхнэрийг гэх гэсэн юм л даа ... гэв.

- Бид хамтдаа байх хэрэгтэй болохоор чамтай явна ... гэж Харри хэлсэн Рон толгой сэгсэрлээ.

- Чи чинь галзуурав уу? Бидэнд хангалттай цаг байхгүй. Та хоёр яваад Амбрижийг эрж ол харин би Якслийн өрөө рүү очъё ... гэхдээ бороог яаж зогсоохоо мэдэх юм алга.

- Фините инкантатумыг ашиглаад үз гэж Гермиона даруйхан хэлэв.

- Хэрвээ бороо шившлэгээр үүссэн бол энэ туслана. Хэрвээ үгүй бол цаг агаарын шидэд ямар нэг зүйл буруу болсон бололтой. Тэгвэл үүнийг засахад Империус шидээс хамгаалах адил хэцүү юм болно ...

- Ахин нэг удаа удаан хэлээч гэж Рон гуйгаад халааснаасаа үзэг гаргатал цахилгаан шат чичигнэн зогсож тунгалаг эмгэтэй хүний хоолой,

- Дөрөвдүгээр давхар. Шидэт амьтаныг хянан зохицуулах болон Албинтай холбоо тогтоох хэлтэс гэхэд сараалж гулган нээгдэж хоёр шидтэн орж ирээд хөх ягаан цаасан онгоц бүрхүүл тойрон эргэлдэв.

- Өглөөний мэнд, Албert гэж өтгөн сахалтай шидтэн хэлээд Харри руу инээмсэглээд Ронд шивнэн зөвөлгөө өгч буй Гермиона руу хяламхийн хартал цахилгаан шат хяхтан дээшилэв. Шидтэн Харри руу бөхийгөөд,

- Дирк Кресвелл үү? Албингуудтай холбоо тогтоох хэлтсийнх биз дээ? Сайн ажиллаа, Альберт! Харин би одоо түүний ажлыг авна гэдэгтээ итгэлтэй байна! гэв.

Тэр нүд ирмэхэд Харри хангалттай гэж найдан инээмсгэлэв. Цахилгаан шат зогсож сараалж ахин онгойлоо.

- Хоёрдугаар давхар. Ид шидийн хуулийг албадан хэрэгжүүлэх болон ид шидийг хууль бусаар ашиглахтай тэмцэх хэлтэс, Мракоборецуудын төв, Визенгамотын удирдах алба.

Гермиона Роныг үл мэдэг түлхэхэд хоёр шидтэнг даган цахилгаан шатнаас яаран гарч Харри, Гермиона хоёрыг үлдээв. Алтан хаалга хаагдахад Гермиона түргэнээр,

- Ер нь бол Харри би түүнтэй явсан нь дээр байх. Тэр юу хийхээ мэдэхгүй байгаа болхоор манай ... гэв.

- Нэгдүгээр давхар. Ид шидийн яамны сайд болон тусламжын алба. Алтан сараалж ахин гулган нээгдэхэд Гермиона аяархан дуу алдав.

Цахилгаан шатны өмнө дөрвөн хүн зогсож байсны хоёр нь гүнзгий яриа өрнүүлж байсан бөгөөд нэг нь урт үстэй алтлаг хар сайхан жанчтай харин нөгөө нь намхан бахтай төстэй агаад богинохон үсэндээ хилэн тууз зүүж цээжиндээ тэмдэглэлийн дэвтэр тэвэрсэн байлаа.

БҮЛЭГ 13: МАГЛ ГАРАЛТАЙ ХҮМҮҮСИЙГ БҮРТГЭХ КОМИСС

- Өө, Муфалда! Трэверс таныг илгээсэн үү? гэж Амбриж Гермионаг хармагц дуу алдав.

- Т-тийм гэж Гермиона түгдэрэн хэлэв.

- Маш сайн байна гээд тэр алтлаг хар жанчтай шидтэн рүү эргэн харснаа,

- Тэгвэл асуудал шийдэгдлээ, сайдаа. Хэрвээ Муфалда протокол хөтөлвөл бид одоо шууд эхэлсэн ч болох юм гээд тэмдэглэлийн дэвтэр рүүгээ шагайж,

- Өнөөдөр бидэнд арван хүн байгаагийн нэг нь яамны ажилтаны эхнэр байна.

Энд ид шидийн яамны гол зүрхэнд гээд бодоод үз дээ! гээд цахилгаан шатанд орж Гермонагийн дэргэд зогсоход түүнийг дагалдан сайдын яриаг сонсож байсан хоёр шидтэн орж ирлээ.

- Бид шууд доошоо шүүх хурлын танхим руу явна шүү, Муфалда. Өглөөний мэнд, Альберт та гарахгүй юм уу?

- Тиймээ, тэгэлгүй яахав гэж Харри Ранкорны гүн хоолойгоор хариуллаа.

Тэр цахилгаан шатнаас гарахад алтан сараалж ард нь хяхтан хаагдав. Харри өндөр шидтэний хажууд зогсож байгаа Гермионагийн түгшсэн царай руу хальт хартал Амбрижийн хилэн тууз мөртэй нь чацуу байлаа.

- Таныг юу ийшээ авчрав, Ранкорн? гэж шинэ ерөнхий сайд асуув. Тэр мөнгөлөг судал татсан урт хар үс, сахалтай бөгөөд өргөн духныхаа сүүдэрт гялалзсан нүд нь Харрид чулууны дороос ширтэж буй наймаалжыг санагдуулав.

- Артур Уизлитэй түргэхэн ярилцах хэрэгтэй байна гэж Харри тээнэгэлзэн хэлснээ,

- Надад түүнийг нэг давхарт байдаг гэж хэлсэн гэв.

- Аан. Тэр сэжигтэнтэй холбоо тогтоогоо юу?

- Үгүй, ерөөсөө ч тийм биш гэж Харри хэлэхэд хоолой нь хатлаа.

- За яахав. Энэ бол ердөө цаг хугацааны асуудал. Хэрвээ миний бодлыг мэдэхийг хүсч байвал цэвэр цусаа доромжлогч бохир цустангаас дээрдэх зүйл ер үгүй. Өдрийг сайхан өнгөрүүлээрэй, Ранкорн.

- Таньд ч гэсэн, сайдаа.

Харри зузаан хивсэн дээгүүр холдох Тикнессийн араас дагуулан харлаа. Тэгээд сайдыг нүднээс далд оров уу үгүй юу зузаан хар жанчныхаа халааснаас үл үзэгдэх цуваа гаргаж ирэн нөмрөөд хонгилын эсрэг зүг рүү явлаа. Ранкорн өндөр болохоор Харри том хөлийг нь нуухын тулд бөхийх хэрэг гарчээ.

Сандрал түүнийг бүчин авлаа. Тэр гялалзсан модон хаалгануудыг ээлжлэн өнгөрөхөд тус бүр дээр нь өрөөний эзний нэр болон ямар албан тушаал эрхлэдгийг нь бичсэн

модон хаяг байв. Гэсэн ч ид шидийн яамны бүтэц аугаа том болохоор Рон, Гермиона хоёрын хамт сүүлийн дөрвөн долоо хоногт зохиосон төлөвлөгөө нь инээдтэй хүүхдийн юм шиг санагдаж эхэллээ. Тэдний анхаарал болон бүхий л хүчин чармайлт ердөө ид шидийн яаманд анзаарагдахгүй ороход чиглэсэн байсан тул одоо салсан цагт юу хийхээ мэдэхгүй байв. Харин одоо Гермиона шүүхийн танхимд нэгээс илүү цаг байх нь лавтай бөгөөд, Рон эмэгтэй хүний эрх чөлөөний төлөө хүч хүрэхгүй мэдэхгүй шид хэрэглэхийг оролдож, Харри дээд давхраар тэнүүчилэн явахдаа олз нь дөнгөж сая мултраад цахилгаан шатаар доош явсныг мэдэж байлаа.

Тэр хана налан зогсоод цаашид юу хийх тухайгаа бодохыг хичээв. Эндхийн нам гүм түүнийг дарангуйлж яриа хөөрөө, яарсан алхаа хивсэн дээр сонсогдохгүй байсан нь энэхүү газрыг Дөжрөөх шившлэгээр шившсэн мэт санагдуулна.

«Хаа нэгтээ түүний өрөө байх л ёстой доо» гэж Харри бодлоо.

Мэдээж Амбрижад үнэ цэнэтэй өрөө байх нь илт байсан тул түүнийг хайхгүй байх нь тэнэг хэрэг байлаа. Ингээд Харри ахин хонгилоор явахад урдаас нь хөмсөг зангидан агаарт хөвөх үзгэндээ ямар нэг заавар хэлэн бичүүлэх шидтэн зөрөн өнгөрөв.

Тэр хаалганы нэрсийг анхааралтай харан явсаар булан тойроод шинэ хонгилын хагаст хүрмэгц сургуулийг санагдуулам толигор сандал ширээ эгнүүлэн тавьсан арваад шидтэнгүүд суух уужим танхимд орж ирлээ. Харри тэдний хийж байгаа зүйлд сэтгэл татагдан зогслоо. Тэд саваагаа зэрэг даллахад өнгө бүрийн дөрвөлжин цааснууд зүг бүр тийш жижигхэн ягаан онгоц шиг нисэлдэх аж. Хормын дараа Харри үүнд ямар нэг хэмнэл байгааг ойлгосон бөгөөд ижилхэн дөрвөлжин хуудаснууд шидийн аргаар эвхэгдэн хүн бүрийн дэргэд нямбайлан хураагдаж байв.

Харри болгоомжтой ойртоход шидтэнгүүд ажилдаа улайраад хивсэн дээгүүр алхах чимээг сонссонгүй. Тэр залуухан шидтэний дэргэдэх бэлэн болсон товхимол руу дөхөж очоод үл үзэгдэх цуван дороосоо харлаа. Ягаан хавтсан дээр алтан үсгээр доорхи үгийг бичжээ.

БОХИРЦУСТАНГУУД

Тэд цэвэр цусны шидтэнгүүдийн ертөнцөд аюултай

Дүйнгэтэн инээж буй улаан сарнайн дэлбээ соёотой ногоон зэрлэг ургамлыг боомилж байлаа. Хуудсан дээр зохиогчийн нэр байсангүй ч Харрид баруун гарынх нь сорви ахин чимчигнэх шиг санагдав. Тэгтэл түүний дэргэд сууж байсан залуухан эмэгтэй сэжиглэлийг нь батлан саваагаа далланган,

- Хөгшин шулам бохир цустангуудыг өдрийн турш байцаах эсэхийг мэдэх хүн байна уу? гэж асуулаа.

- Болгоомжтой гэж түүний хөрш эргэн тойрноо түгшин харж хэлэхэд нэг хуудас шалан дээр уналаа.

- Яасан түүнд зөвхөн шидэт нүд төдийгүй чих байгаа юм биш биз дээ?

Шидтэн танхим дундуур гялалзсан улаан зандан хаалга руу харлаа. Харри бас тийшээ хартал уур хилэн нь өөрийн эрхгүй оволзов. Хаалганы ердийнхөөр бол

маглуудын шагайвар байх газар Аластор Грюмын том дугуй хурц цэнхэр нүдийг байрлуулжээ.

Агшин зуур Харри юу хийж байгаагаа мартав. Тэр ч байтугай үл үзэгдэх гэдгээ ч мартжээ. Тэр хаалга руу очоод нүд рүү харлаа. Нүд хөдөлсөнгүй урдаас нь хөдөлгөөнгүй гөлийн ширтэнэ. Түүний доохон талд:

Долорес Амбриж

Сайдын нэгдүгээр зэргийн орлогч гэжээ.

Арай доохон талд нь өөр нэг гялалзсан шинэхэн хаяг байлаа.

Магл гаралтай хүмүүсийг бүртгэх

Комиссийн тэргүүн

Харри танилцуулах хуудас хийж буй хүмүүс рүү эргэж хараад ажилдаа төвлөрсөндөө хоосон өрөөний хаалга онгойхыг харахгүй гэж найдав. Ингээд халааснаасаа хаймран бүрээ шиг хэлбэртэй жижигхэн хөлөө сарвалзуулж байгаа зүйлийг гаргалаа. Дараа нь суугаад үл үзэгдэх цуван доогуур анхаарал сатааруулагчыг шалан дээр тавив.

Анхаарал сатааруулагч гүйн шидтэнгүүдийн хөл дор орлоо. Агшин зуур Харри хаалганы бариулаас бариад хүлээтэл чанга тасхийх чимээ гарч өрөөний буланд эхүүн хар утаа суунаглав. Эхний эгнээнд сууж байсан залуу шидтэн эмэгтэй хашгирахад ягаан хуудаснууд асгаран хүмүүс үсрэн босож үймээний эх сурвалжыг хайх агшинд Харри бариулыг эргүүлээд Амбрижын өрөөнд орж хаалга хаалаа.

Түүнд өнгөрсөн үе рүү буцаад ирэх шиг санагджээ. Энэ бол Амбрижын Хогвартст байсантай адилхан өрөө байсан бөгөөд торон бүтээлэг, амны цаас хатсан цэцэг тавьжээ. Хананд өлгөсөн тавагнууд дээр өнгө бүрийн тууз зүүсэн муурнууд цовхчин тоглох нь өхөөрдөм санагдахын оронд дотор зэвүүцэм харагдав. Бичгийн ширээн дээр тод өнгийн цэцэгтэй бүтээлэг дэвсэж, Грюмын нүдний ард хаалганы гадаа ажиллаж байгаа хүмүүсийг тагнах дуран суурилуулсан байлаа. Харри түүгээр шагайгаад бүгд эргэн тойрон анхаарал сатааруулагчид үймэхийг харав. Тэр дуранг хаалганаас сугалан авч шидэт нүдийг халаасандаа хийлээ. Дараа нь ахин өрөө рүү эргээд саваагаа өргөн аяархан,

- Акцио, зүүлт гэв.

Юу ч болсонгүй бөгөөд Харри ч болно гэж хүлээсэнгүй. Мэдээж Амбриж хамгаалалтын шидийг мэддэг болох нь эргэлзээгүй. Тэр ширээ рүү очоод шургуулгыг нь нэгжиж эхлэв. Тэнд галууны өдөн үзэг, тэмдэглэлийн дэвтэр, шидэт наалдамхай тууз, могой шиг мушгирсан цаасны хавчаар, гоёмсог хайрцгаар дүүрэн үсний тууз байсан ч зүүлтний ямар ч шинж тэмдэг байсангүй.

Ширээний ард шүүгээ байсанд Харри очоод нэгжиж эхлэв. Энэ нь Филчийн

Хогвартсын шүүгээний адил хавтсаар дүүрэн байв. Тэгээд шүүгээний ёроолд хүртэл

«Уизли» гэж бичсэн хавтсыг олж харлаа. Тэр аваад онгойлгов.

АРТУР УИЗЛИ

Цусны түвшин: Цэвэр цусны хэдий ч маглуудыг дэмждэг тохиромжгүй хандлагатай. Фениксийн бүлгэмийн гишүүн.

Гэр бүл: Эхнэр (цэвэр цусны), долоон хүүхэдтэй. Хоёр нь Хогвартсад сурдаг. Бага хүү нь хүнд өвдөөд гэртээ байгаа. Ид шидийн яамны шалгалтаар баталгаажсан.

Аюулгүй байдлын түвшин. ХАРААНД БАЙЛГАХ ШААРДЛАГАТЙ. Бүх хөдөлгөөн нь хяналтанд байгаа. Номер нэг сэжигтэн этгээдтэй итгэмээргүй харилцаатай (өмнө нь тэдний гэрт бууж байсан).

- Номер нэг сэжигтэн гэж Харри сонсогдох төдий шивнээд ноён Уизлийн хавтсыг байранд нь хийж шүүгээг хаалаа.

Тэр энэ сэжигтэн хэн болохыг мэдэх шиг санагдсанд өндийгөөд өрөөнд нууц зүйл байх боломжтой газар эрэн хартал хананд түүний зурагт хуудасны цээжин дээр

«НОМЕР НЭГ СЭЖИГТЭН» гэж бичсэн нь үзэгдэв. Зурагт хуудасны буланд жижигхэн ягаан цаас наалттай байсанд Харри дөхөж очоод Амбрижийн «эрүүгийн шийтгэл оноовол зохино» гэж бичсэнийг уншлаа.

Тэр өмнөхөөсөө улам их уурсан хатсан цэцэгтэй сав руу өнгийсөн ч зүүлт байсангүйд ер гайхсангүй. Харри ахин өрөөг ажиглатал зүрх нь гэнэт хүчтэй цохилов. Ширээний дэргэдэх номын тавиурын дээр байсан жижигхэн дөрвөлжин хүрээтэй толиноос Дамблдор түүн рүү харж байв.

Харри ухасхийн түүнийг авахдаа толь биш болохыг нь ойлгов. Дамблдор гял цял номын хавтсан дэрээс мөрөөдөнгүй инээмсэглэж харагдана. Харри түүний малгайны дээр угалзтай ногоон үсгээр «Альбус Дамблдорын хуурамч амьдрал» гэж бичсэнийг харлаа. Түүнчлэн цээжин дээр нь арай багахан үсгээр «Армандо Диппет төгс төгөлдөр үү усан тэнэг үү? бестселлер номын зохиогч Рита Скитер» гэсэн байв.

Харри номыг онгойлгоход эхний хуудсан дээр нь өсвөр насны хоёр хүү инээлдэн бие биенийхээ мөрөөр тэвэрсэн том зураг байв. Дамблдорын үс бараг бүсэлхийгээ хүртэл урт байсан бөгөөд Крамын эрүүний Роныг уурлуулдаг сахал адил жирэвгэр сахал ургаж эхэлжээ. Дамблдорын хажуугын хүү чимээгүйхэн хөгжилтэй инээж харагдана. Тэр мөрөө хүрсэн алтлаг бужгар үстэй аж. Магадгүй энэ залуу Дож байх гэж Харри бодсон ч тайлбарыг нь уншиж амжихаас урьтаж өрөөний хаалга нээгдэв.

Хэрвээ Тикнесс өрөөнд орж ирэхдээ урагш хараагүй бол Харри үл үзэгдэх цуван дороо нуугдаж амжихгүй байлаа. Түүнийг дөнгөж амжтал Тикнесс ямар нэг хөдөлгөөн ажилгасан бололтой хэсэг зуур хөдөлгөөнгүй зогссоноо Харрийн алга болсон газар луу сонирхон ширтэв. Тэгснээ харваас Дамблдрын номын хавтсан

дээрх зураг хамраа маажихыг харсан бололтой гэж шийдэхэд Харри яаран тавиураас эргэлээ. Тикнесс ширээнд дөхөж очингоо бэхэнд дүрээстэй байсан галууны өдөн үзэг рүү саваагаа чиглүүлэхэд үсрэн гараад Амбрижад зориулан зурвас бичиж эхлэв. Харри удаанаар амьсгалахгүйг хичээн өрөөнөөс гарлаа.

Өмнөхийн адил бичиг цаасны танхимд анхаарал сарниулагч үймүүлж эргэн тойрон сулхан утаа суунаглуулсан хэвээр байлаа. Харри яаран тэдний дэргэдүүр өнгөрөхдөө залуухан шидтэн эмэгтэй, «Энэ зүйлийг ид шидийн туршилтын хэлтсээс зугтсан гэж мөрийцөх үү. Тэдний хортой нугасыг санаж байна уу?» гэхийг сонсов.

Тэр яаран цахилгаан шат руу очихдоо үлдсэн боломжоо эрэгцүүлэв. Зүүлт ид шидийн яаманд байсан ч Амбрижийн дүүрэн хүмүүстэй шүүхийн танхимаас авах ямар ч найдлага байсангүй. Одоо хамгийн гол нь илчлэгдэхээсээ өмнө яамнаас яаж гарах вэ гэдэг зорилт байсан бөгөөд ахин нэг цагт оролдож үзэж болох юм. Хамгийн түрүүнд Роныг эрж олоод түүний хамтаар Гермионаг шүүхийн танхимаас гаргах хэрэгтэй байлаа.

Цахилгаан шат хоосон ирлээ. Харри түүнд ороод доош уруудахдаа үл үзэгдэх цуваа тайлав. Гэтэл түүний санааг амраан хоёр давхарт голдоо хүртэл норсон Рон орж ирэв.

- Ө-өглөөний мэнд гэж тэр цахилгаан шат цааш хөдлөхөд бувтналаа.

- Рон энэ би, Харри байна!

- Харри! Чөтгөр гэж би чиний яаж харагдаж байсныг мартчихаж. Гермиона хаана байна?

- Тэр Амбрижтай хамт доошоо шүүгчдийн танхим руу уруудсан болохоор ...

Түүнийг яриагаа дуусгаж амжихаас өмнө цахилгаан шат ахин зогсоход хаалга онгойж ноён Уизли хижээл насны цайвар үсээ шоргоолжны үүрийг санагдуулам дээш овоолсон эмэгтэйтэй орж ирлээ.

- Би таны юу ярьж байгааг ойлгож байна, Ваканда. Тэгээд ч үүнд чинь оролцож чадахгүй гэж айж байна ...

Тэр Харриг ажигламагц чимээгүй боллоо. Ноён Уизли түүн рүү дургүйцэн муухай харах нь туйлын эвгүй зүйл байв. Цахилгаан шатны хаалга хаагдмагц дөрвүүл ахин доош явлаа.

- Аан Реж сайн уу гэж ноён Уизли Роны хувцаснаас ус дуслах чимээнээр харан хэлээд,

- Өнөөдөр таны эхнэрийг байцааж байгаа юу? Э-э ... Та чинь яагаа вэ? Яагаад ингэтлээ норчихсон юм? гэв.

- Якслийн өрөөнд бороо орж байгаа гэж Рон хажуу тийш харан хэлэхэд Харри түүний харц тулгаран эцэгтээ танигдахаас айж байгааг ойлголоо.

- Би түүнийг зогсоохыг оролдсон ч чадсангүй. Тэд намайг Берни руу явуулсан.

Пиллсуорт гэж түүнийг нэрлэдэг байхаа ...

- Тиймээ, сүүлийн үед олон өрөөнд бороо орж байгаа. Метео Реканто

шившлэг оролдож үзсэн үү? Тус болж магадгүй.

- Метео Реканто? хэмээн Рон бувтнаснаа,

- Үгүй, оролдож үзээгүй. Баярлалаа аа ... өө, уучлаарай баярлалаа Артур гэв.

Цахилгаан шатны хаалга нээгдэн шоргоолжны үүрэн үстэй шидтэн гарахад Рон түүний араас гарч алга болов. Харри бас гарах гэсэн ч гартаа барьсан бичгээ улайран уншиж байгаа Перси Уизли саад болов.

Хаалга ахин хаагдмагц Перси аавынхаа хамт байгааг анзаарлаа. Тэр ноён Уизлиг хармагц улайснаа цахилгаан шат дөнгөж зогсов уу үгүй юу үсрэн гарлаа. Харри түүний араас гарахыг оролдсон ч энэ удаад ноён Уизлийн гар түүнийг зогсоов.

- Түр хүлээгээрэй, Ранкорн.

Хаалга ахин хаагдаж цахилгаан шат хяхтнан доош явахад ноён Уизли,

- Би та нар өнөөдөр Дирк Кресвеллийг баривчилсан гэж сонслоо гэв.

Тэгтэл Харрид ноён Уизлийн уур хилэн Перситэй тулгарснаас болсон гэсэн сэтгэгдэл төрлөө. Иймээс мэдэхгүй дүр үзүүлэхээр шийдэв.

- Өршөөгөөрэй?

- Дүр эсгэх хэрэггүй, Ранкорн гэж ноён Уизли ширүүн хэлээд,

- Та шидийн аргаар гэр бүлийнхээ модыг хуурамчаар хийсэн биз дээ? гэв.

- Би ... би юу хийсэн гэнээ? хэмээн Харри асуулаа.

- Тэгсэн хэдий ч Дирк Крессвелл танаас арав дахин илүү шидтэн гэж ноён

Уизли аяархан хэлснээ улам нам дуугаар,

- Хэрвээ тэр Азкабанд орвол та эхнэр болон хөвгүүд төрөл төрөгсөд нь хариулах шаардлага гарна ... гэлээ.

- Артур таныг мөрдөж байгаа гэдгийг мэдэж байгаа юу? хэмээн Харри түүнийг үгийг таслан хэлэв.

- Энэ чинь сүрдүүлэг үү, Ранкорн? гэж ноён Уизли чанга хэллээ.

- Үгүй энэ бол баримт! Тэд таны алхам бүрийг харж байгаа ...

Цахилгаан шатны хаалга нээгдлээ. Тэд үүдний танхимд иржээ. Ноён Уизли Харри руу зэвүүцэнгүй харснаа гарлаа. Харри мэгдсэндээ байрнаасаа хөдөлсөнгүй. Ранкорноос өөр хүнийг дуурайвал дээр байж дээ ... Цахилгаан шатны хаалга хяхтнан хаагдав.

Харри үл үзэгдэх цуваа гаргаж нөмөрлөө. Тэр Гермионаг чөлөөлж, Ронд бороо зогсооход нь туслах хэрэгтэй байлаа. Цахилгаан шатны хаалга онгойх үед бамбарын гэрэлтэй чулуун хонгилд гарахад тэр цааш хүнгэнэн явлаа. Харри алсад байгаа нууцын хэлтсийн хар хаалга руу хартал дотор нь үл мэдэг зарсхийлээ.

Тэр урагшаа яваад хонгилын зүүн талын хананд байдаг хаалга руу эргэв. Түүний санаж байгаачилан шат шүүхийн танхимд хүргэх ёстой байлаа. Харри шатаар бууж байхдаа анхаарал сатааруулагч ашиглах уу эсвэл зүгээр хаалгыг цохиод Ранкорны төрхтэй орж Муфалдатай хэдэн хором ярилцахыг гуйвал яадаг бол гэсэн бодлоо шидвэрлэж чадсангүй. Өөр өнцгөөс бол Ранкорн өөрийн биеэр ирээд тийм алхам

хийгээд Гермиона эргэж ирэхгүй бол тэднийг холдож амжихаас өмнө ид шидийн яаманд эрж эхлэх байх ...

Тэр бодолдоо автаад манан адил ер бусын хүйтэн болсныг анзаарсангүй. Алхам тутамд хүйтэн улам нэмэгдсээр чөмгөндөө хүртэл даарлаа. Үүнийг дагалдан цөхрөл, найдлагагүй байдал сэтгэлээр уналт мэдрэгдэв ...

«Дементорууд» гэж тэр бодлоо.

Тэр шат урууданбаруун тийш эргээд аймшигтай дүр зургийг олж харлаа. Шүүхийн танхим хүрэх харанхуй хонгилд нүүрээ нуусан өндөр хар юүдэнтэй дүрсүүд дүүрэн хөвөх агаад тасалданги амьсгална. Байцаалтанд хүлээгдэж байгаа айж мэгдсэн магл гаралтай хүмүүс модон сандал дээр чичирэн шахцалдан сууцгаах аж. Тэдний ихэнхи нь нүүрээ алгаараа хаасан нь зөнгөөрөө Дементорын шунахай амнаас хамгаалах гэсэн бололтой. Зарим нь төрөл төрөгсөдтэйгээ зарим нь ганцаараа иржээ. Дементорууд тэдний урдуур урагш хойш холхиж цөхрөл хүйтэн найдлагагүй байдал энэ газар ноёрхож байсан нь Харрид хараал шиг нөлөөлөв ...

«Тэмц» гэж Харри өөртөө хэлэв. Тэр энд Патронусаа ашиглах нь өөрийгөө барьж өгөхийг ойлгож байсан тул чимээгүйхэн урагш явахдаа алхам бүрдээ ухаан нь царцах шиг санагдахад Рон, Гермона болон хэрэгтэй бусад зүйлсийнхээ тухай бодлоо.

Өндөр хар дүрснүүдийн дэргэдүүр өнгөрөхөд юүдэнгийн дор нуугдсан нүдгүй царай түүний зүг эргэх нь аймшигтай байлаа. Харри тэд түүний ямар нэг найдлага амьдралын хүч агуулсан хүн гэдгийг нь үнэрлэх юмуу мэдэрсэн гэдэгт итгэлтэй байв.

Тэгтэл чимээгүй хөлдүү нам гүмийг эвдэн газар доорхи хонгилын зүүн талын хаалга нээгдэхэд хашгирах дуу хадав ...

- Үгүй, үгүй би эрлийз гэж таньд хэлээд байгаа биз дээ! Миний эцэг шидтэн тэр байна харцгаа. Арки Олдертон шүүр зохион бүтээсэн алдартай шидтэн байсан түүнийг хар л даа. Би таньд хэлээд байгаа биз дээ ... гараа холдуул, надаас гараа холдуул ...

- Сүүлчийн удаа анхааруулъя гэх Амбрижын аяархан хоолой шидийн хүчээр эрэгтэйн цөхөрсөн дууг даван сонсогдлоо.

- Эсэргүүцсэн хэвээр байх юм бол Дементорт үнсүүлэх болно шүү. Эрэгтэйн хашгиралт агшин зуур намдан хуурай цурхиралтаар солигдов.

- Түүнийг гарга гэж Амбриж хэллээ.

Шүүхийн танхимын хаалгаар хоёр Дементор яртай гартаа ухаан алдсан эрэгтэйг барин гарч ирэв. Тэд хонгилийн дагуу түүнийг чирэн харанхуйд алга боллоо.

- Дараагийнх нь ... Мэри Кроткотт гэж Амбриж дуудав.

Сандлаас жижигхэн эмэгтэй хөлөөсөө толгой хүртлээ чичирсээр бослоо. Тэр шулуун хар үсээ ардаа боосон бөгөөд жирийн урт жанч өмсчээ. Түүний царай цусгүй

цонхийн цайжээ. Харри түүнийг Дементоруудын дэргэдүүр өнгөрөхдөө давхийн цочихыг харав.

Цааш нь тэр юу ч бодож амжилгүй зөнгөөрөө хийлээ. Учир нь газар дорхи хонгилд цааш ганцаар алхах хүч байсангүй тул хаалга хаагдахаас урьд эмэгтэйн араас шүүхийн танхимд шурган орлоо.

Энэ нь түүнийг хууль бус шид хэрэглэсэн гэж буруутгаж байсан шүүхийн танхим байсангүй. Арай багахан бөгөөд өндөр адартай ажээ. Түүнд ороод Харри гүнзгий худагт унасан адил зүйл мэдрэв.

Дементорууд энд байсан ч шүүгчдийн өндөр тавцангаас хол алсын буланд зогсож байв. Амбриж, Яксли Гермиона нар тавцанг тусгаарласан хашлаганы нэг талд суугаад цонхийн цайсан хатагтай Кроткотт нөгөө талд нь зогсож байв. Тавцангийн ёроолд мөнгөлөг өнгийн урт үстэй муур урагш хойш холхиж байсан нь Харрийн ойлгосноор бол яллагч нарт Дементорын найдалгагүй байдал цөхрөлийг түгээхээс хамгаалж байгаа аж. Энэ нь буруутгахааргүй мэдрэмж байлаа.

- Суу гэж Амбриж торгомсог хоолойгоор хэлэв.

Хатагтай Кроткотт тавцангийн урд талын шалан дээр байсан төмөр сандал руу бүдчин ойртов. Түүнийг суув уу үгүй юу сандлын бариул дээр өлгөөстэй байсан гинж хангинан гарыг нь гавлав.

- Та Мэри Элизабет Кроткотт уу? гэж Амбриж асуув. Хатагтай Кротктот чичирэн толгой дохив.

- Та шидийн үйлчилгээний хэсгийн Режинальд Кроткоттой гэрлэсэн үү? Хатагтай Кроткотт нулимс асгаруулан,

- Би түүний хаана байгааг мэдэхгүй байгаа ч над дээр ирэх ёстой! гэлээ. Амбриж үүнд огтхон ч анхаарал хандуулсангүй.

- Эх Мэйси, Элли болон Альфред Кроткотт уу?

- Тэд намайг гэртээ эргэж очихгүй гэж их айсан байгаа хэмээн хатагтай

Кроткотт улам нулимс асгаруулан хэллээ.

- Чимээгүй. Бохир цустангуудыг өрөвдөх сэтгэл бидэнд алга гэж Яксли хэлэв.

Хатагтай Кроткотын цурхиралт Харрийн тавцан руу болгоомжтой алхах хөлийн чимээг дарлаа. Түүнийг тавцан харуулдаж байгаа Патронус мууpын дэргэдүүр

өнгөрмөгц өрөөний температур өөрчлөгдөн дулаахан аятай боллоо. Харри Патронус Амбрижынх гэдэгт эргэлзсэнгүй бөгөөд учир нь тэр энд гол байж гартаа жаргалтайгаар хуулийг барьж байлаа. Харри удаанаар маш болгоомжтой тавцанг өнгөрөөд Амбриж, Яксли, Гермиона нарын суудлын ард гарав. Хамгийн гол нь Гермионаг айллгахгүй байх хэрэгтэй байлаа. Тэр Яксли, Амбриж хоёрт Дүлийрүүлэх шившлэг илгээх талаар бодож үзсэн ч үг шивнэх нь Гермионаг түгшээж болох байв. Тэгтэл Амбриж хоолойгоо өндөрсгөн хатагтай Кроткоттод үг хэлэх агшинд Харри үүнийг ашиглалаа.

- Би чиний ард байна гэж Гермионагийн чихэнд шивнэв.

Харрийн хүлээж байсанчлан тэр огцом эргэж харахдаа хөтөлж байсан тэмдэглэл дээрээ бэх золтой л асгасангүй ч Амбриж, Яксли хоёр хатагтай Кротктод төвлөрөөд үүнийг ажигласангүй.

- Та өнөөдөр ид шидийн яаманд ирэхдээ шидэт саваагаа хураалгасан, хатагтай Кроткотт. Гучин дөрвөн дюйм урт, интоорын мод ганц эвэртийн сүүлний хялгастай саваа. Та энэ шинж тэмдэгийг таньж байна уу?

Хатагтай Кроткотт ханцуйгаараа нүдээ арчин дохилоо.

- Та үүнийгээ ямар шидтэнгээс авснаа хэлж өгнө үү?

- А-авсан гэнээ? хэмээн хатагтай Кроткотт уйлагнан хэлээд,

- Үгүй би үүнийг ... хэнээс ч а-аваагүй. Би энэ савааг арван нэгэн настай байхдаа худалдаж авсан. Тэр ... тэр ... намайг сонгосон гэв.

Ингээд хатагтай Кроткотт өмнөхөөсөө илүү ширүүн цурхирлаа.

Амбриж охиных шиг жингэнэсэн хоолойгоор инээд алдахад Харри түүнийг ямар нэг зүйлээр цохих хүсэл төрөв. Тэр олзоо сайн харахын тулд урагш хаалтан дээгүүр тонгойход хүзүүндээ зүүсэн алтлаг зүүлт гялсхийв.

Гермиона бас түүнийг олж хараад аяархан дуу алдсан ч золиос руугаа харж байсан

Амбриж, Яксли хоёр анзаарсангүй.

- Үгүй дээ, үгүй би тэгж бодохгүй байна, хатагтай Кроткотт. Саваа зөвхөн шидтэнгүүдийг сонгодог. Харин та бол шидтэн биш. Надад таны бөглөсөн асуултын хуудас байна ... Муфалда, надад түүнийг аваад өгнө үү.

Амбриж гараа сунгах агшинд бахтай маш адилхан харагдсан тул Харри түүнийг богинохон хуруундаа сарьсгүй байгааг гайхлаа. Гермионагийн гар чичирэв. Тэр бичиг баримтыг онгичсоноо овоолсон цаасан дундаас хатагтай Кроткоттын нэр бүхий хуудсыг гаргаж ирэв.

- Ямар ... ямар сайхан юм бэ, Долорес гэж тэр Амбрижын цамцны захад гялалзах зүүлтийг заан хэллээ.

- Юу? хэмээн Амбриж зандарснаа доош харж,

- Аан тийм л дээ ... гэр бүлийн үнэт зүйл байгаа юм гээд бахим цээжиндээ зүүсэн зүүлтийг илэв.

- С гэдэг нь «Селвин» гэж байгаа юм ... харин би Селвиний гэр бүлд төрсөн.

Цэвэр цусны гэр бүл хэдий ч би хамаатнуудтайгаа нэг их холбоогүй байдаг юм. Харамсалтай нь үүнийг таньд хэлж чадахгүй нь дээ гээд хатагтай Кроткоттын бөглөсөн хуудас руу харж,

- Эцэг эхийн мэргэжил ногооны мухлагийн худалдагч гэв.

Яксли даажигнан хөхөрлөө. Дор сахлаг мөнгөн муур харуулдан холхиж, Дементорууд тушаал хүлээн буланд зогсоно.

Түүний худал үгийг сонсоод Харрийн тархинд цус хөөрөн аюул ослыг мартлаа. Энэхүү амьтан өрөвдөлтэй хулгайчаас хахуульд авсан зүүлтээ цэвэр цусны баталгаа юм гэнээ. Тэр үл үзэгдэх цуван дор нуух ч гэж хичээсэнгүй саваагаа өргөөд,

- Дөжир! гэв.

Улаан гэрэл гялсхийхэд Амбриж духаараа хашлаганы ирмэг мөргөн унаж өвдгөн дээрээс нь хатагтай Кроткоттын бичиг баримтууд шал руу асгарахад гэтэж байсан мөнгөн муур алга болж мөс шиг хүйтэн агаар тавцанг салхи шиг нөмрөн авлаа. Будилсан Яксли юу болсныг ойлгохыг хичээх зуур Харрийн гар агаарт өргөгдөн саваа түүн рүү чиглэхийг харлаа. Тэр өөрийнхийгөө гаргах гэсэн ч амжсангүй.

- Дөжир!

Яксли шалан дээр уналаа.

- Харри!

- Гермиона би түүний яриаг сонсоод сууж байж чадсангүй ...

- Хатагтай Кроткотт, Харри!

Харри эргэхдээ үл үзэгдэх цуваа авч хаяад булангийн Дементорууд сандал дээр сууж байсан эмэгтэй рүү гулган ирж байхыг харлаа. Патронус алга болсон учир тэднийг тогтоон барьж байх зүйл үгүй болсон байв. Хатагтай Кроткоттын эрүүнээс гулгамтгай яртай гар барихад толгойгоо гэдийлгэн аймшигтай хашгирлаа.

- Экспекто патронум!

Харрийн сабааны үзүүрээс мөнгөн буга гарч Дементоруудын зүг давхихад хойш ухран сүүдэрт орлоо. Гэрэлт буга танхимыг тойрон давхихад муурынхаас илүү хүчирхэг дулаахан боллоо.

- Крестражыг ав гэж Харри Гермионад хэлэв.

Тэр үл үзэгдэх цуваа хүзүүндээ зүүсэн хүүдийнд хийгээд хатагтай Кроткотт руу туслахаар гүйлээ.

- Та юу? Гэхдээ ... Реж таныг л намайг байцаалгах жагсаалтанд бичсэн гэж хэлсэн хэмээн тэр түүний царайг хараад хэлэв.

- Тэгсэн гэж үү? хэмээн Харри бувтнаад гинжийг угзарлаа.

- За яахав, тэгвэл намайг бодлоо өөрчилсөн гэж бод. Диффиндо! Юу ч болсонгүй.

- Гермиона гинжийг яаж салгах вэ?

- Хүлээж бай, би завгүй байна ...

- Гермиона бидний эргэн тойронд Дементорууд байна!

- Мэдэж байна, Харри гэхдээ тэр сэрээд зүүлт алга болсныг харах болохоор ... би түүнийг хуулбарлах хэрэгтэй байна ... Жеминио! Энэ түүнийг мунхруулах болно ...

Ингээд Гермиона бас тавцангаас уруудан гүйж ирлээ.

- Алив, харцгаая ... Релашио!

Гинж хангир жингэр хийн сандлын түшлэгэн дээр хураагдав. Хатагтай Кроткотт урьдынхаасаа илүү айсан байлаа.

- Би ойлгосонгүй! гэж тэр шивнэлээ.

- Бидэнтэй хамт яв гээд Харри түүнийг хөл дээр нь босгов.

- Гэр лүүгээ очиж хүүхдүүдээ аваад хилийн цаад руу зугт. Гаднах төрхөө өөрчилөөрэй. Та энд шударга шүүхийг хүлээх хэрэггүй гэдгийг харлаа шүү дээ.

- Харри бид эндээс яаж гарах вэ? Хаалганы гадаа дүүрэн Дементорууд байгаа биз дээ? гэж Гермиона хэлэв.

- Патронусуудаар гээд Харри саваагаа зангахад гялалзсан буга удааширснаа хаалганы зүг чиглэв. Тэгвэл илүү дээр. Гермиона өөрийнхийгөө дууд.

- Экспек ... Экспекто патронум гэж Гермиона хэлсэн ч үр дүнгүй болов.

- Заримдаа түүний хувьд энэ шившлэг болдоггүй юм гэж Харри мэл гайхсан хатагтай Кроткоттод хэлээд,

- Жаахан бүтэлгүйтлээ, үнэн шүү ... Алив ээ, Гермиона гэв.

- Экспекто патронум!

Гермионагийн сабааны үзүүрээс мөнгөлөг халиу хөөрөн гарч бугын хамт нэгдэв.

- Урагшаа гээд Харри Гермиона, хатагтай Кроткоттын хамт гарлаа.

Шүүхийн танхимаас Патронус гарахад газар дорхи хонгилд ээлжээ хүлээн суусан хүмүүс айсандаа хашгиралдав. Харри эргэн тойрноо харахад Дементорууд мөнгөлөг амьтадтай тулгарахын өмнө хэдэн тийшээ бутарч зугтлаа.

- Та бүхэн гэр лүүгээ явж гэр бүлийнхэнтэйгээ нуугдах шийдвэр гарсан гэж

Харри Патронусын гэрэлд гялбан дальдарсан хүмүүст хэлээд,

- Хэрвээ чадах бол хилийн чанадад зугт. Хамгийн гол нь ид шидийн яамнаас хол байгаарай. Тиймээ ... шинэ албан ёсны байдал. Харин одоо Патронусыг дагаад явбал үүдний танхимыг нэвтэрч чадна гэв.

Тэд чулуун гишгүүрийг алгасан гүйж цахилгаан шатанд хүрэхэд Харри эргэлзэж эхлэв. Хэрвээ тэр Гермионагийн хамт үүдний танхимд дэргэдээ мөнгөлөг буга, халиу хөөрүүлээд магл гаралтай гэж буруутгагдсан хориод хүмүүсийн хамт гарвал хүссэн ч хүсээгүй ч анхаарал татах болно. Түүнийг энэ таагүй бодлыг цахилгаан шат хяхтнан ирэх чимээ таслав.

- Реж! гэж хатагтай Кроткотт хашгираад Роны гараас зүүгдэв.

- Ранкорн намайг суллаж Амбриж, Якслы хоёр руу дайраад биднийг бүгдийг гадаад руу зугт гэсэн. Бид үүнийг хийсэн нь дээр байх гэж бодож байна, Реж! Алив түргэн гэртээ хараад хүүхдүүдээ авцгаая ... Чи яагаад ингэтлээ норчихоо вэ?

- Уснаас болж гэж Рон бувтнаад түүний гараас мултарлаа.

- Харри тэд Амбрижийн өрөөний хаалганд нүх гарсан болохоор яаманд гадны хүмүүс нэвтэрснийг мэдэж байна. Бидэнд таван хором л байгаа байх гэж бодож байна ...

Гермиона Харри руу үхтлээ айсан царайгаар эргэн харахад Патронус нь аяархан тасхийгээд алга болов.

- Харри хэрвээ бид энд занганд орвол ...

- Түргэн хөдөлвөл баригдахгүй гээд Харри ардаа зогсож байсан чимээгүй хүмүүс рүү эргэхэд бүгд амаа ангайн түүнийг ширтлээ.

- Хэн нэгэнд чинь саваа байна уу? Хагас нь гараа өргөв.

- Сайн байна тэгвэл саваагүй нэг нь саваатайгийнхаа хамт яваарай. Биднийг зогсоохоос өмнө яарах хэрэгтэй байна. Урагшаа.

Тэд хоёр цахилгаан шатанд хуваагдан орлоо. Харрийн Патронус алтан сараалж хаагдаж цахилгаан шат хөдлөхөд зогсон үлдэв.

- Наймдугаар давхар. Үүдний танхим гэх тунгалаг хоолой сонсогдов.

Харри цахилгаан шатнаас гармагцаа ямар нэг зүйл болсныг мэдэв. Үүдний танимд дүүрэн хүмүүс ханан зуухнаас гарах гарцыг битүүмжилж байлаа.

- Харри! Бид яаж явах вэ? гэж Гермиона хашгирлаа.

- Больцгоо! гэж Харри Ранкорны хүчирхэг хоолойгоор үүдний танхимыг цуурайтуулан хашгирлаа.

Ханан зуух хааж байсан хүмүүс чимээгүй болов.

- Миний араас гэж тэр айсан маглууддаа хэлээд Рон, Гермиона хоёрын хамт хөдлөв.

- Юу болоо вэ, Альберт? гэж ханан зууханд урьд нь тааралдсан хүнтэй адил халзан толгойтой шидтэн асуулаа.

- Эдгээр хүмүүс гарцыг битүүмжилэхээс өмнө гарах хэрэгтэй байна гэж Харри түүнд захирангуй хэллээ.

Түүний урд байсан бүлэг шидтэнгүүд нэг нэгэн рүүгээ харав.

- Бидэнд гарцыг хааж хэнийг ч гаргахгүй байхыг тушаасан ...

- Чи хэний урдаас маргаж байна? Би чиний гэр бүлийнхнийг шалгахыг хүсээ юу? Дирк Кресвеллийг мартаа юу? гэж Харри зандарлаа.

- Уучлаарай гээд тэр хойш ухарлаа.

- Би тэгэхийг хүсээгүй, Алберт гэхдээ ... тэднийг байцаалтанд дуудсан байх гэж бодлоо ...

- Тэдний цус цэвэр гэж Харри үүдний танхимыг нүргэлүүлэн хэлээд,

- Та нарын олонхоос ч цэвэр гэдгийг хэлэх байна. Алив явцгаа! гэж зандарахад магл гаралтай хүмүүс ханан зууханд хос хосоороо яаран орж алга болж эхлэв. Ид шидийн яамны шидтэнгүүд тэвдэж айсан байдалтай зогсоно. Тэгтэл ...

- Мэри!

Хатагтай Кроткотт эргэж харав. Цахилгаан шатнаас зэвхий царайлсан жинхэнэ Реж

Кроткотт гүйн гарч ирлээ.

- Ре-Реж үү?

Тэр нөхөр болон Рон руу харснаа чанга хараалаа.

Халзан толгойтой шидтэн ам нээснээ Реж Кроткотт болон өөр нэгийх нь дунд толгойгоо эргүүлэв.

- Хөөе ... энд юу болоод байна? Энэ чинь юу гэсэн үг юм?

- Гарцыг хаа! Битүүмжил!

Яксли өөр нэг цахилгаан шатнаас бүлэг хүмүүсийн хамт гарч ирэхэд хатагтай Кротокттыг эс тооцвол ханан зуухны дэргэд зогсож байсан маглууд бүгд хэдийн алга болсон байлаа. Халзан толгойтой шидтэн саваагаа өргөсөн ч Харри том нударгаа духанд нь буулгахад үсрэн уналаа.

- Тэр маглуудыг зугтахад тусалсан, Яксли! гэж Харри хашгирав.

Халзан толгойтой шидтэний нөхөд нь үймэлдэхэд Рон үүнийг ашиглан хатагтай Кроткттын гараас бариад онгорхой үлдсэн нэг зуух руу чирэв. Мэгдсэн Яксли Харри болон цохиулсан шидтэн рүү гайхширан харлаа. Тэгтэл жинхэнэ Реж Кротткотт,

- Миний эхнэр! Хэн миний эхнэрийг аваад явж байна? Юу болоод байна? гэж ориллоо.

Харри Якслийн хэрцгий царайд үйл явдлыг ойлгосны тэмдэг илрэхийг хараад,

- Алив ээ! гэж Гермионад хашгиран гараас нь барин ханан зууханд үсрэн ороход толгой дээгүүр нь түүний илгээсэн шившлэг нисэн өнгөрөв. Тэд эргэлдсэнээ секунтын дараа жорлонгийн бүхээгт уналаа. Харри хаалга нээв. Дэргэд нь Рон зогсоод гартаа эсэргүүцэн тэмцэх хатагтай Кроткоттыг барьжээ.

- Реж би ойлгохгүй байна ...

- Эндээс яв, би таны нөхөр биш гэр лүүгээ гүй!

Тэгтэл арын бүхээгт чимээ шуугиан гарахад Харри эргэж харвал Яксли гарч ирлээ.

- Явцгаая! гэж Харри хашгираад Гермиона болон Роны гараас зуурч байрандаа эргэлдэв.

Харанхуй тэднийг нөмрөн авахад дотор давчидсан мэдрэмж төрсөн ч ямар нэг зүйл буруу болж ... Гермионагийн гарны барилт гулгалаа ...

Түүнд одоохон амьсгалж чадахаа болих юм шиг санагдахад Роны гар Гермиона хуруунаас удаанаар мултархыг харлаа ...

Тэгтэл Гриммогийн арван хоёрдугаар байшингийн үүдний могойн дүрстэй цохиур үзэгдсэн ч амьсгал авч амжаагүй байтал хашгирах чимээ гараад улаан гэрэл гялсхийхэд Гермионагийн гар гэнэтхэн бахь шиг чангарч эргэн тойрны бүх зүйл харанхуй болов.

БҮЛЭГ 14: ХУЛГАЙЧ

Харри нүдээ нээхэд алтлаг ногоон гэрэлд гялбав. Тэр юу болсныг ойлгосонгүй ч ганц л зүйлийг мэдэж байсан нь мөчир навчин дунд хэвтэж байлаа. Тэр агаар амьсгалахыг хичээн навчсын завсар тусах хурц нарны гэрэлд нүдээ анивчлаа. Тэгтэл нүүрнийх нь дэргэд юм хөдлөв. Харри эргээд жижигхэн догшин амьтан барихад бэлнээр хүндхэн дөрвөн хөллөсөн ч оронд нь Роны хөлийг харав. Тэр эргэн тойрноо хартал Гермиона модны ёроолд хэвтэж байлаа.

Тэр эхэндээ Хориотой ойд байна гэж шийдээд (Хогвартсын газар нутагт ойртох нь ямар аюултай тэнэг хэрэг гэдгийг мэдэж байсан хэр нь) мододын завсраар Хагридын овоохой харагдах байх гэж бодлоо. Гэсэн ч хормын дараа Рон аяархан ёолоход Харри түүний зүг мөлхөхдөө Хориотой ой биш болохыг ойлгов. Эндхийн модод илүү залуухан агаад уужим ажээ.

Роны дэргэд хүрээд бас дөрвөн хөллөсөн Гермионатай тааралдав. Тэгтэл Роныг харах агшинд бүх бодол нь толгойноос нь хийсэн алга боллоо. Түүний зүүн тал цусанд хутгалдаж царай нь үнсэн саарал болжээ. Хувиргах уусмалын үйлчлэл гарч түүнээс Кроткоттын зүс арилснаа үс нь улайран шаргалтаж царай нь ердийн төрхөндөө оров.

- Тэр яагаа вэ?

- Хуваагдсан гээд Гермиона Роны ханцуйг цусанд харласан ханцуйг тайллаа.

Харри түүний Роны цамцыг хэрхэн цуулахыг айдаст автан харав. Түүнд хуваагдах нь үргэлж инээдтэй юм шиг санагдсан байсан ч энэ нь ... Гермиона Роны гарны хутганд зүсүүлсэн мэт алга болсон хэсгийг гаргахад Харрийн дотор эвгүйрхлээ.

- Харри, түргэл миний цүнхэнд «бадъяны ханд» ханд бичигтэй лонх байгаа ...

- Цүнх гэнээ ... аан тийм л дээ ...

Харри Гермионагийн газардсан хэсэг рүү гүйн очоод жижигхэн шүрэн цүнхийг авч уудлав. Гэтэл гарт нь арьсан хавтастай ном, ноосон ханцуйтай цамц, өндөр өсгийтэй гутал гээд янз бүрийн зүйлс тааралдав ...

- Түргэлээрэй!

Харри газраас саваагаа аваад шидэт цүнхний гүн рүү чиглүүлэн,

- Акцио, бадъян! гэв.

Цүнхнээс жижигхэн хүрэн шил үсрэн гарч ирэхэд яаран барьж аваад Гермиона руу эргэхэд Роны зовхи хагас нээгдэж нүд нь цагаарч үзэгдэв.

- Тэр ухаан алдчихаж гэж цонхийн цайсан Гермиона дуу алдлаа. Тэр Муфалдатай хэдийн төсгүй болсон ч үсний хаа нэгтээ буурал үс харагдана.

- Бөглөөг нь аваарай, Харри. Миний гар чичирээд байна.

Харри шилийг онгойлгож Гермионад өгөхөд цустай шархан дээр гурван дусал ханд дусав. Тэгтэл ногоон утаа уугьсанаа шархны цус гоожих нь тогтов. Дараа нь шарх аньж хэдэн өдрийн өмнө байсан шиг цэвэрхэн арьстай боллоо.

- Хөөх гэж Харри хэллээ.

- Энэ миний аюулгүй хийж чадах бүхэн. Шившлэг түүнийг хэвийн болгож чадах ч алдаа гаргаж байдлыг дордуулахаас айсан юм ... Тэр их цус алдсан болохоор гэж Гермиона чичирсэн хоолойгоор хэлэв.

- Тэр яаж шархадсан юм бол? Ер нь гээд Харри юу болсныг ойлгохын тулд толгойгоо сэгсэрээд,

- Бид яагаад энд байгаа юм бэ? Би Гриммогийн байшин руу буцсан гэж бодсон юмсан гэв.

Гермиона хүндээр санаа алдсанаа уйлах шахам харагдав.

- Харри бид тийшээ буцаж очихгүй гэж бодож байна.

- Чи юуны тухай яриад байна?

- Биднийг шилжих үед Яксли надаас зуураад хэтэрхий хүчтэй болохоор нь салж чадсангүй. Тэр надаас зуураастай бидний хамт Гриммогийн байшингийн дэргэд газардсан. Харин дараа нь ... хаалгыг хараад биднийг тэнд амьдардаг гэдгийг ойлгосон бололтой барилтаа жаахан сулруулсан. Тэгэхээр нь би түүнээс мултраад та хоёрыг ийш нь авчирсан юм.

- Тэр хаана байна? Хүлээгээрэй ... Чи түүнийг Гриммогийн байшинд байгаа гэж хэлэх гээ юу? Гэхдээ тэр байшинд орж чадахгүй.

Гермионагийн нүдэнд нулимс цийлэгнэснээ толгой дохиод,

- Харри, би түүнийг чадна гэж бодож байна. Би ... Би түүний барилтаас Зайлуулах шившлэгээр мултрах үед тэр хэдийн Итгэлцлийн шид үйлчилж байгаа хамгаалалтын дотор байсан. Дамблдорын үхлийн дараа бид нууц хадгалагч болсон болохоор би түүнд нууцыг үзүүлсэн хэрэг болно биз дээ? гэв.

Үүнд дүр эсгэх ямар ч хэрэггүй байсан бөгөөд Гермионагийн зөв гэдэгт Харри эргэлзсэнгүй. Энэ нь хүнд цохилт боллоо. Хэрвээ Яксли байшин дотор орсон бол тэдэнд Гриммогийн байшин руу буцах зам байхгүй. Одоо хэдийн бусад Үхэл залгигчидадаа дуудаад тийшээ шилжицгээсэн биз. Энэ байшин хичнээн баргар дарамттай байсан ч гэсэн тэдэнд аюулгүй орогнох боломж өгч Кикимер илүү хөгжилтэй нөхөрсөг болж эхлээд байлаа. Харри гэрийн үйлчлэгчийн тэдний хэзээ ч идэхгүй бөөртэй махан хуушуур хийж буй талаар төсөөлөв.

- Намайг уучлаарай, Харри уучлаарай!

- Тэнэг юм ярих хэрэггүй энэ чиний буруу биш! Хэрвээ үүнд хэн нэгэн буруутай бол би л буруутай ...

Харри халаасандаа гараа хийж Грюмын шидэт нүдийг гаргаж ирэхэд Гермиона айсандаа огло үсэрлээ.

- Амбриж түүнийг өрөөнийхөө хаалганд бусад ажилчдаа тагнуулдахын тулд тавьсан байсан. Би түүнийг тэнд орхиж чадсангүй ... ийм учраас л тэд гадны хүн ид шидийн яаманд нэвтэрсэн гэж мэдсэн хэрэг.

Гермионаг үг хэлж амжихаас өмнө Рон нүдээ нээн ёолов. Түүний царай зэвхийн сааралтаж хөлс гялтагнана.

- Чи ямаршуу байна даа? гэж Гермиона шивнэлээ.

- Олиггүй гэж Рон сөөнгөтөөд гэмтсэн гараа харж ярвайлаа. Бид хаана байна?

- Квиддичийн дэлхийн аварга зохиогдож байсан ойд байна гэж Гермиона хэлээд,

- Надад хаалттай нууцлаг газар хэрэгтэй байсан болохоор эндэх ...

- Хамгийн түрүүнд толгойд орж ирсэн гэж Харри яриаг нь дуусгаад хоосон ойн цоорхой руу харлаа. Тэр өмнө нь Гермионагийн толгойд орсон газар шилжихэд юу болсныг санав ... Үхэл залгигчид тэднийг хэдхэн хормын дараа олсон. Энэ нь легилменцийгээс болсон юм болов уу? Волдемортын хамсаатангууд энэ удаад Гермионагийн хаачсаныг мэдэх болов уу?

- Бид эндээс хөдөлсөн дээр юм шиг санагдахгүй байна уу? хэмээн Рон асуухад

Харри царай руу нь хараад адил зүйл бодож байгааг ойлголоо.

- Мэдэхгүй.

Рон цонхийн цайсан хэвээр сул дорой харагдаж байлаа. Түүнд хөдлөх хүч байсангүй учир суухыг ч оролдсонгүй. Ийм аймшигтай байдалд яаж хөдлөх болж байна?

- Алив эндээ үлдэцгээе гэж Харри хэллээ. Гермиона баярлан үсрэн босов.

- Чи хаачих нь вэ? гэж Рон асуулаа.

- Хэрвээ бид үлдвэл өөрсдийгөө тойруулаад хамгаалалтын шившлэг босгох хэрэгтэй гээд саваагаа өргөн Харри, Рон хоёрыг тойрон том тойрог яваад шидэт үгс бувтналаа. Харри тэдний эргэн тойронд Гермионагийн шившсэн манан үүсэхийг харлаа.

- Сальвио хексиа ... Протего тоталум ... Репелло маглетум ... Муплиато ...

Харри майхнаа барь ...

- Майхнаа гэнээ?

- Цүнхэнд байгаа!

- Аан тийм л дээ гэж Харри хэлэв.

Энэ удаад тэр хайж түвэг удсангүй шууд Татдаг шидийг ашиглахад майхан бөөгнөрсөн брезентен даавуу, олс, баганы хамт гарч ирэв. Харри түүнийг муурын

үнэрээр нь шууд таньсан бөгөөд энэ нь тэдний квиддичийн дэлхийн аваргын шөнө унтдаг майхан байлаа.

- Энэ ид шидийн яаманд ажилладаг Перкинсийн майхан мөн биз дээ? гээд

Харри гадасны орооцолдоо гаргав.

- Тиймээ, түүний радикилут хөдөлсөн учир эргүүлж өгөхийг гуйгаагүй гээд Гермиона саваагаараа агаарт наймын тооны адил түвэгтэй дүрс хөдөлгөн зурснаа,

- Тиймээс Роны аав намайг түр авч болно гэж хэлсэн юм гээд,

- Баригд! гэж дуу алдаад брезент рүү саваагаа зангахад майхан агаарт хөөрөн баригдсанаа газарт падхийн унахад Харрийн гарт байсан гадас мулт үсрэн олс нь татагдав.

- Каве инимикум гэж Гермиона сүүлчийн шившлэгээ хэлээд тэнгэр лүү огцом зангаж,

- Энэ миний чадах бүхэн. Ер нь бол тэднийг ойртвол бид мэдэх болно. Зогсоож чадахгүй ч Волде ... гэв.

- Түүний нэрийг бүү хэл! гэж Рон ширүүн дуугарлаа. Харри, Гермиона хоёр бие бие рүүгээ харав.

- Уучлаарай гээд Рон ёолон өндийгөөд,

- Гэхдээ надад энэ нэр хараал агуулсан юм шиг санагддаг байсан. Хэцүү нэрт гэж нэрлэцгээе за юу? гэв.

- Дамблдор энэ нэрийг хэлэхээс айдаггүй ... хэмээн Харри эхлэв.

- Чи Хэцүү нэртийн нэрийг хэлснээрээ Дамблдор сайнаар дуусаагүй гэдгийг ажиглаагүй бололтой гэж Рон хэдэрлээд,

- Зүгээр л ... зүгээр л Хэцүү нэртэд хүндэтгэл үзүүлэх хэрэгтэй байгаа юм гэв.

- Хүндэтгэл гэнээ? хэмээн Харри асуухад Гермиона түүнийг Ронтой маргах хэрэггүй хэтэрхий суларч доройтсон гэж анхааруулсан харцаар харав.

Харри, Гермиона хоёр Роныг өргөх чирэхийн хооронд зөөн майханд оруулав. Дотор бүх зүйл Харрийн санаж байсанчлан бөгөөд жижигхэн угаалгын өрөө, гал зуухтай байлаа. Тэр хажууд нь байсан сандлыг түлхээд Роныг болгоомжтойгоор хоёр давхар орны доод талынх дээр тавив. Энэхүү богинохон аялалынхаа дараа Рон цайсан хэвээр гудсан дээр хэвтээд нүдээ анин хэсэг зуур дуугүй боллоо.

- Би цай чаная гэж Гермиона шивнэн хэлээд цүнхнээсээ данх, аяга гаргаж гал зууханд оров.

Халуун цай Харрид Хурц нүдэтийг үхдэг шөнийн галт шарз шиг нөлөө үзүүлэн дотор нь халуу шатахад айдас цээжийг нь баглав. Хормын дараа Рон,

- Та нар Кроткоттод юу тохиолдсон гэж бодож байна? гэлээ.

- Хэрвээ тэдэнд аз таарсан бол зугтсан байх гээд Гермиона гараа аягандаа наан дулаацуулж,

- Хэрвээ ноён Кроткотод эхнэрийнхээ хамт шилжих ухаан байсан бол одоо хүүхдүүдээ аваад энэ орныг орхисон байгаа. Ямар ч гэсэн Харри түүнд ингэж зөвлөсөн гэв.

- Чөтгөр гэж тэднийг аврагдсан гэж найдъя гээд Рон ахин дэрэн дээрээ хэвтэв.

Цай харваас түүнд нөлөөлсөн бололтой хацар нь үл мэдэг улайжээ.

- Гэхдээ бүгдийн намайг Реж Кроткотт гэж бодоод ярьж байгаа өнгөнөөс үзэхэд түүнээс онцгой ухаан хүлээх хэрэггүй байх. Бурхан минь тэднийг үүнийг хийж чадсан гэж найдъя. Хэрвээ тэд биднээс болж Азкабанд орвол ...

Харри Гермионагаас хатагтай Кроткотт нөхрийнхөө хамт шилжсэн эсэхийг асуух гэсэн ч хоолойгоор нь давсангүй. Гермиона Кроткоттын хувь заяанд зовж сэтгэл тавгүй байгаа Рон руу халамжлангуй харж байсан тул Харрид тэдний үнсэлдэж байгааг харж байгаа юм шиг мэдрэмж төржээ.

- Тэгэхээр тэр чамд байгаа юу? хэмээн Харри Гермионад өөрийнхөө байгааг сануулах гэж асуулаа.

- Тэр ... гэж юу юм? хэмээн тэр үл мэдэг давхийснээ хэлэв.

- Бид чинийхээр бол энэ бүхнийг юуны төлөө хийсэн болж байна? Зүүлт! Тэр хаана байна?

- Та нар түүнийг аваа юу? Тэгвэл яагаад чимээгүй байсан юм? Чөтгөр гэж надад хэлдэггүй! хэмээн Рон дэрэн дээрээсээ өндийн дуу алдав.

- Гэхдээ бид Үхэл залгигчдаас зугтаж байсан биз дээ? гээд Гермиона,

- Энэ байна гэв.

Тэр халааснаасаа зүүлтийг гаргаад Ронд сунгалаа.

Зүүлт тахианы өндөгний хэмжээтэй байв. Жижигхэн ногоон чулуун дээр сийлбэрлэсэн «С» үсэг майхны оройг нэвтлэн туссан бүдэг гэрэлд гялалзав.

- Кикимер түүнийг алдсаны дараа хэн нэгэн устгасан болов уу? Би крестражыг тэнд байгаа гэдэгт итгэлтэй байх хэрэгтэй гэж хэлэхийг хүссэн юм л даа? гэж Рон найдангуй хэлэв.

- Тийм гэж бодож байна. Хэрвээ крестражыг шидийн тусламжтай устгасан бол ямар нэг ул мөр үлдсэн байх ёстой гээд Гермиона зүүлтийг буцаан авч анхааралтай харлаа.

Тэр зүүлтийг Харрид өгөхөд авч хуруундаа эргэлдүүлэхэд чимэглэл нь өө сэвгүй цэвэрхэн харагдаж байлаа. Тэр тэмдэглэлийн дэвтрийн зэрэмдэг үлдэгдэл болон Дамблдор бөгжинд нуугдсан крестаржыг устгасны дараа чулуу нь ямар болсныг саналаа.

- Кикимерийн зөв гэж бодож байна. Бид түүнийг устгахын тулд яаж онгойлгохоо тодруулах хэрэгтэй гэж Харри хэлэв.

Тэр энэ үгийг хэлмэгц гэнэтхэн жижигхэн алтан хаалганы ард нуугдаастай байгаа зүйлийг ухаарах мэт болов. Зүүлтийг авахын тулд хичнээн их зүтгэл чармайлт гаргаснаа бодоход түүнийг аль болох цааш нь чулуудан хаях хүсэл төрлөө. Тэр биеэ эзэмдээд хуруугаараа гууг онгойлгохыг хичээж дараа нь Гермионагийн Регулусын өрөөний хаалгыг онгойлгосон шиг шид хэрэглэсэн ч бүтсэнгүй. Тэр зүүлтийг Рон,

Гермиона хоёрт дамжуулан өгөхөд тус бүрдээ онгойлгохыг оролдсон ч амжилтгүй боллоо.

- Чи түүнийг барихад юу мэдэрч байна? гэж Рон зүүлтийг гартаа атгаад аяархан асуув.

- Чи юуны тухай яриад байна?

Рон зүүлтийг Харрид буцааж өглөө. Хормын дараа Харри түүний юу ярьсан болохыг онгойлгов. Тэр судсанд цохилох адил зүйл мэдэрлээ эсвэл зүүлтэн дотор жижигхэн зүрх байгаа юм болов уу?

- Бид одоо түүнийг яах вэ? гэж Гермиона асуув.

- Яаж устгахаа мэдэх хүртэл хадгалах болно гээд Харри зүүлтийг дургүйхэн хувцсан дотроо Хагридын өгсөн хүүдийний хажууд хүзүүндээ зүүж,

- Бид нар үүнийг ээлжээр зүүж майхны гадаа харуулдсан нь дээр гэж бодож байна. Харин одоо хоол олох хэрэгтэй байна. Үгүй чи энд тайван үлд гэж Рон суухыг оролдоод царай нь ногоороход нэмэрлэв.

Тэд майхны ширээн дээр Гермионагийн Харрийн төрсөн өдөр бэлэглэсэн вредноскопыг тавьж өдрийн төгсгөл хүртэл Харри, Гермиона хоёр ээжлэн жижүүрлэлээ. Гэсэн ч өдрийн турш вредноскол тайван хөдөлгөөнгүй байж Гермионагийн хамгаалалтын болон магл түлхэгч шидийн ачаар хүмүүс ийшээ ирэхгүйн дээр эндхийн ойд шувуу хэрэм ч ховорхон үзэгдэх аж. Үдэш ямар ч өөрчлөлт гарсангүй. Арван цагт Харри саваагаа бариад Гермионагийн халааг авч хоосон газар руу харахад одот тэнгэрт сарьсан багваахай нисэхээс ондоо зүйл үзэгдсэнгүй.

Тэр өлссөндөө толгой нь эргэхээ мэдрэв. Гермиоа шөнө гэхэд Гриммогийн байшин руу буцаж очино гэж бодсон учир шидэт цүнхэндээ ямар ч хоол авч гарсангүй болохоор гурвуулаа түүний ойролцоох модноос түүсэн мөөгийг төмөр тогоонд чанасныг эс тооцвол ондоо зүйл идсэнгүй. Рон хэд халбагадсанаа тавгаа дотор нь муухайрсан юм шиг түлхсэн бол Харри өөрийнхийгөө Гермионаг гомдоохгүйн тулд хүчлэн идлээ.

Эргэн тойрны ой нам гүм агаад мөчир хугарахтай төстэй шажигнах чимээ гарна. Харри энэ чимээг хүмүүсээс илүү амьд амьтан гаргаж байгаа байх гэж бодсон ч саваагаа бэлхэн барьсаар байлаа. Мөөгнөөс өөр зүйл идээгүй болохоор гэдэс нь хонхолзож ойлгомжгүй түгшсэн сэтгэл төрөв.

Өмнө нь Харри крестражыг олвол аугаа их баярын сэтгэл төрөх байх гэж бодсон ч энэ нь яагаад ч юм болсонгүй. Тэр харанхуйд саваныхаа үзүүрийн гэрлийг ширтэн цаашид юу хийх талаараа түгшин бодлоо. Бүгд долоо хоног сар магадгүй жилийн

турш энэ агшныг хүртэл хурдалж байснаа харин одоо гэнэтхэн замаасаа гаран зогслоо.

Бусад крестражуудыг хаана эрэх талаар өчүүхэн ч төсөөлөл байсангүй. Тэр тэдний ямар болохыг ч мэдэхгүй байв. Иймээс цээжиндээ зүүгээстэй байгаа цорын ганц

олдсон крестражыг яаж устгах талаар төсөөлөв. Хачирхалтай нь зүүлт Харрийн биенд дулаацсангүй хүйтэн хэвээр үлдэж арьсыг нь хүйтэн уснаас гарсан мэт жиндэх аж. Харрид бодолдоо үе үе эсвэл төсөөлөлдөө жижигхэн зүрхний цохилт сонсогдох шиг санагдсан ч түүний өөрийнх нь байлаа.

Харанхуйд сууж байхад өгүүлэхийн аргагүй айдас сэтгэлд нь хуралдав. Харри тэднийг эсэргүүцэхийг оролдож холдуулан хөөсөн ч буцаж ирсээр байлаа. Тэдний нэг нь нөгөөгөө амьд байх үед тайван байж чадахгүй. Майханд Рон, Гермиона хоёрын аяархан ярилцах нь сонсогдоно. Тэд хүсвэл энэ бүхнийг хаяж чадах байтал харин тэр харин чадахгүй. Харри энд суугаад айдас ядралаа давахыг хичээж байтал крестраж цээжинд нь цаг шиг цохиллоо ... «Тэнэг бодол. Ингэж бодох хэрэггүй байсан юм» гэж өөртөө хэлэв.

Сорви нь ахин хатуулан өвдлөө. Харри энэ нь түүний бодлоос болсон гэж шийдээд өөр зүйл бодохыг хичээв. Тэр хөөрхий Кикимер гэртээ тэдний буцаж ирэхийг хүлээгээд оронд нь Якслиг авсан тухай бодлоо. Үйлчлэгч Үхэл залгигчдад мэдэж байгаа бүх зүйлээ хэлэх болов уу? Эсвэл чимээгүй байх юм уу? Харри сүүлчийн сар Кикимер түүнд хандах хандлагаа өөрчилсөн учир үнэнч байна гэдэгт итгэлтэй байсан ч юу тохиолдохыг хэн мэдэх билээ? Гэнэтхэн Үхэл залгигчид үйлчлэгчийг тамлавал яана? Дотор муухайрам дүр зураг Харрийн толгойд төсөөлөгдөхөд энэ бодлоо үлдэн хөөхийг хичээлээ. Тэр Гермионагийн хамт Кикимерийг ийш нь дуудах хэрэггүй гэж хэдийн шийдсэн. Түүнтэй хамт яамны хэн нэгэн ирэх ч юм билүү. Якслиг Гриммогийн байшинд Гермионагийн гараас зууралд ирсэн болохоор үйлчлэгч чөлөөтэй шилжинэ гэж бодох хэрэггүй юм.

Сорви нь улам хүчтэй төөнөв. Харри тэдний хэтэрхий олон зүйлийг мэдэхгүй байгаа тухай цааш эргэцүүлэв. Люпины хэн ч хэзээ ч харж төсөөлж байгаагүй шидтэй тулгарна гэж хэлсэн тухайд зөв. Дамблдор яагаад түүнд илүү их зүйл хэлсэнгүй вэ? Магадгүй хугацаа хангалттай түүний найз Николас Пламель шиг хэдэн зуун жил амьдарна гэж бодсон юм болов уу? Хэрвээ тэр алдсан бол яана ... Снегг үүнийг харсан ... Снегг өс санасан могой шиг цамхагийн оройгоос дайрсан ...

Тэгээд Дамблдор унасаар ... унасаар байлаа ...

- Надад үүнийг өг, Грегорович.

Харрийн хоолой өндөр хүйтэн болж урт цагаан хуруундаа саваа барьсан байлаа. Түүний чиглүүлсэн хүн агаарт үл үзэгдэх олсноос уруугаа харан дүүжлэгджээ. Тэр үл мэдэг найгахад хөл гар нь биедээ наалдаж доошоогоо харсны улмаас улаан хүрэнтсэн айдас хурсан царай нь Харрийн нүүртэй нэг түвшинд байв. Тэр өвлийн өвгөн адил өтгөн цагаан үс бавгар сахалтай аж.

- Тэр надад байхгүй! Олон жилийн өмнө хулгайд алдсан!

- Волдемортод бүү худал хэл, Грегорович. Тэр худал хэлэхийг шууд мэддэг юм ... Үргэлж мэддэг.

Өлгөөтэй хүний хүүхэн хараа айдаст автан томорсноо улам өргөссөөр эцэст нь Харриг харанхуй залгилаа ...

Тэр одоо харанхуй хонгилоор гүйгээд бадриун гартаа дэнлүү барьсан байв. Грегорович хонгилоор явж урлантай төстэй өрөөг дэнлүүгээрээ гэрэлтүүллээ. Модны үртэс гэрлийн тусгалд шаргалтан гялалзахад цонхны тавцан дээр алтлаг үстэй залуу хүн том шувуу адил сууж байв. Дэнлүүний гэрэл түүнийг эгшин зуур гийгүүлэхэд Харри баярлаж хөөрсөн үзэсгэлэнтэй царайг нь хараад үл таних хүн саваагаар Хөшөөх шившлэг илгээн хөхрөөд үсрэн бууж эргэхийг харлаа.

Ингээд Харри ахин хонгил шиг өргөн хүүхэн хараанаас буцаж Грегоровичийн айдас дүүрэн царайг харлаа.

- Хэн үүнийг хулгайлаа вэ, Грегорович? гэж хүйтэн хоолой асуув.

- Би мэдэхгүй, хэзээ ч мэдээгүй ... залуу хүн ... үгүй! Танаас гуйя! Гуйж байна! Хашгиралт дараа нь ногоон гэрэл гялсхийлээ.

- Харри!

Тэр амьсгаадан нүдээ нээхэд дух нь өвдөж байв. Тэр гадаа майхны хана налан сууж байснаа газар унасан байлаа. Тэгтэл дээр нь Гермионагийн өтгөн үсний завсраар тэнгэр болон харанхуй мөчир үзэгдэв.

- Зүүдэлсэн байна гээд түргэхэн сууж Гермионагийн гашуун харцтай тулгармагц гэмгүй дүр эсгэхийг хичээн,

- Би зүүрмэглэчихэж уучлаарай гэв.

- Би ахиад л л чиний сорви болохыг мэдэж байна! Энэ чиний нүүрэн дээр бичсээстэй байна! Чи ахиад л тархинд нэвтрэн орж Вол ...

- Түүнийг нэрийг бүү хэл! гэж Рон майханы гүнээс ууртай хашгирав.

- Сайн байна тэгвэл Хэцүү нэртийн тархинд! гэж Гермиона уцаарлангуй хэллээ.

- Би үүнийг хүсээгүй! Энэ бол зүүд байсан! Чи өөрийнхөө зүүдийг хянаж чаддаггүй биз дээ, Гермиона!

- Хэрвээ чи окклюменцийг ашиглаж сурсан бол ...

Гэхдээ Харри түүний яриаг сонирхсонгүй харсан зүйлийнхээ тухай ярихыг хүслээ.

- Тэр Грегоровичийг олсон, Гермиона. Минийхээр бол түүнийг алсан байх. Би түүний тархинаас гарахаас урьтаж алахыг нь харсан ...

- Би чамайг хэтэрхий яарсандаа болоод суугаагаараа унтсан гэж бодож байна хэмээн Гермиона хүйтнээр хэлээд,

- Би оронд чинь жижүүрлэе гэв.

- Үгүй, чи ч гэсэн ядарсан байна. Явж хэвтэж амар.

Гермиона гөжүүдлэсэн байртай майхны үүдэнд суулаа. Харри уурласан ч маргахыг хүссэнгүй дотогшоо оров.

Доод талын орон дээрээс түүн рүү Роны зэвхий царай харж байлаа. Харри дээд талынханд нь авираад хэвтэж брезентэн адар ширтэв. Хэдэн хормын дараа Рон үүдэн дээр сууж байгаа Гермионад сонсогдохооргүй аяархан хоолойгоор,

- Хэцүү нэрт юу хийсэн юм? гэлээ.

Харри нүдээ онийлгон харанхуйд харсан дүр зураг бүрээ санахыг хичээв.

- Тэр Грегоровчийг олсон. Хүлээд тамалж байсан.

- Гэхдээ тэгэх юм бол Грегорович түүнд яаж шинэ саваа хийж өгч чадах юм бэ?

- Мэдэхгүй ... хачирхалтай байгаа биз, тийм үү?

Харри нүдээ аниад харж сонссон зүйлийнхээ талаар бодлоо.

Ингээд илүү их зүйл санаж чадлаа. Волдеморт Харрийн сабааны тухай юу ч хэлээгүй, Грегоровичийг Харрийнхаас илүү хүчирхэг шинэ саваа хийж өг гэж гуйгаагүй ...

- Тэр Грегоровичаас ямар нэг зүйл авахыг хүссэн гэж Харри нүдээ нээлгүй хэлээд,

- Түүнд өгөхийг шаардсан ч Грегорович хулгайд алдсан гэж хэлсэн ... тэгээд дараа нь ... дараа нь ... гэв.

Тэр Волдемортын адил Грегоровичийн нүднээс дурсамжыг нь уншсанаа саналаа.

- Тэр Грегоровчийн бодлыг уншихад би тавцан дээр сууж байгаа залуу хүнийг харсан. Тэр Грегоровчид шившлэг илгээгээд нуугдсан. Тэр Хэцүү нэртийн хүсч байгаа зүйлийг хулгайлсан ... Гэхдээ би ... түүнийг хаа нэгтээ харсан юм шиг санагдаж байна ...

Харри энэ инээж буй залуугийн царайг хаана харснаа санахыг ихэд хүслээ. Грегоровичийн үгээр бол олон жилийн өмнө болсон гэсэн. Яагаад залуу хулгайч түүнд танил санагдсан юм бол?

Ойн чимээ майханд нэвтрэхгүй учир Харри зөвхөн Роны амьсгалахыг сонсож байв. Тэр хэсэг чимээгүй байснаа,

- Чи хулгайчын гартаа барьсан зүйлийг харж чадсангүй юу? гэв.

- Үгүй ... Энэ жижигхэн зүйл байсан.

- Харри! гээд Рон модон ор чахруулан байрлалаа өөрчилснөө,

- Харри, магадгүй Хэцүү нэрт крестраж болгон хувиргачихаар зүйл хайж байсан юм болов уу? гэв.

- Мэдэхгүй гэж Харри удаанаар хэлээд,

- Магадгүй юм. Гэхдээ түүнийг зохиоход аюулгүй биш биз дээ? Гермиона түүнийг хэдийн сүнснийхээ хүчийг шавхсан гэж хэлснийг санаж байна уу? гэв.

- Тиймээ, гэхдээ тэр энэ тухай мэдээгүй байж болох юм.

- Тиймээ ... болох л юм.

Тэр Волдеморт нэг зүрхтэй хоёр сабааны асуудлыг шийдэхийн тулд хуучин мастерын араас хөөцөлдөж байна гэдэгт итгэлтэй байсан ... гэтэл тэр түүнээс сабааны тухай нууцын тухай ганц ч асуулт асуулгүй аллаа.

Тэгвэл Волдеморт юугаа эрсэн юм бол? Бас яагаад ид шидийн яам болон шидэт ертөнц хөл дор нь байхад алсад Грегоровичийн эзэмшиж байсан үл мэдэгдэх хулгайчын хулгайлсан зүйлийн араас хөөцөлдөж явдаг билээ?

Харри цайвар үстэй залуухан хөгжилтэй царайг харсаар байлаа. Энэ нь Фред, Жорж хоёрын тоглоом хийдэг хөөрсөн өнгөтэй төстэй аж. Хулгайч цонхны тавцан дээрээс шувуу шиг хөөрөн буухад Харри түүнийг урьд нь харж байсан ч хаана гэдгээ санаж чадсангүй.

Одоо Грегорович үхсэн болохоор хөгжилтэй хулгайчид аюул заналхийлж байгаа талаар Харрийн бодол эргэлдэж байтал доод талын орон дээр Рон хурхирах чимээ гарахад тэр ч гэсэн удаанаар гүн нойронд автлаа.

БҮЛЭГ 15: АЛБИНГИЙН ӨС ХОНЗОН

Маргааш өглөө нь Харри эрт босоод найзуудаа сэрэхээс өмнө майхнаас гарч бахим мөчиртэй хөгшин мод эрж оллоо. Тэгээд үндэснийх нь холтсон дээр саваагаараа хэрчлээс гарган Грюмын нүдийг хийж оршуулав. Хурц нүдэт мэдээж Долорес Амбрижийн үүдэнд өлгөөтэй байснаас үүнийг эрхэмлэх байсан шүү дээ. Дараа нь эргэж майханд ороод андуудаа сэрэхийг хүлээгээд цаашид юу хийх талаараа ярилцлаа.

Харри, Гермиона хоёрын энд хэтэрхий саатах хэрэггүй гэж үзсэнийг Рон зөвшөөрч хачиртай талх, утсан мах зэрэг хүнсний нөөцөд хүрч болох ойрхон газар очихыг санал болгов. Гермиона майхан тойрсон шидийг тайлахад Харри, Рон хоёр тэднийг энд байсны бүх шинж тэмдгийг устгалаа. Үүнийгээ дуусгаад гурвуул жижигхэн хотын захад шилжин ирэв.

Тэднийг майхнаа барьж тойруулан хамгаалалтын шинэ шившлэг босгомогц Харри үл үзэгдэх цуваа нөмөрч идэх юм олохоор явлаа. Гэвч бүх зүйл бодсон шиг байсангүй. Түүнийг хотод дөнгөж ортол гэнэтхэн ер бусын хүйтэрч тэнгэр харанхуйлан манан дэгдэж байран дээр нь хөшөөжээ.

- Гэхдээ чи Патронусыг маш сайн дууддаг шүү дээ! хэмээн Рон Харриг майхандаа хоосон гар бүхий Дементорууд гэсэн ганц үгтэй ирэхэд эсэргүүцэн хашгирлаа.

- Би нэгийг ч гаргаж чадаагүй гэж тэр хүндээр амьсгаадан барьж хэлээд,

- Ер болсонгүй гэв.

Найзуудынхаа цочирдож урам хугарсан царайг харахад Харрид ичгүүртэй байлаа. Дөнгөж сая түүнд хар дарсан зүүд адил явдал тохиолджээ. Алсад Дементорын манан дундаас гулган ирэх нь үзэгдээд хүйтэнд мэдээ алдан хөшихөд чихэнд нь хашгиралт сонсогдон хамгаалах зүйл юу ч үгүй болов. Тэгэхэд Харри бүх хүчээ дайчилан байрнаасаа хөдөлсөн бөгөөд нүдгүй Дементорууд харах чадваргүй маглуудын дунд холхин цөхрөл найдлагагүй байдлын энерги хаа сайгүй ноёлж байв.

- Харваас тэнд ямар ч хоол байхгүй байсан.

- Амаа тат, Рон! гэж Гермиона зандраад,

- Юу болоо вэ, Харри? Чи яагаад Патронусаа дуудаж чадсангүй вэ? Өчигдөр чинийх маш сайн болж байсан биз дээ? гэв.

- Мэдэхгүй.

Харри Перкинсийн хуучин сандлын нэг дээр суугаад доромжлогдсон адил зүйлийг мэдрэв. Түүний дотор нэг л зүйл болохоо больж өчигдөрийн өдөр алсад юм шиг санагдана. Өнөөдөр тэр ахин «Хогвартс экспресс» галт тэргэнд ухаан алдан унаж байсан арван гурван настай хүүгийн адил байлаа.

Рон түүний сандлын хөлийг өшиглөснөө,

- Яасан? гэж Гермиона руу харан хэдэрлээд,

- Би өлсөж байна! Бас арай цусны хагасыг алдаагүй байж ердөө хоёрхон хортой мөөг идсэн байдаг! гэв.

- Тэгвэл явж Дементоруудыг нэвтэр л дээ гэж Харри үгээр хатгалаа.

- Чи миний гар сойлттой байгааг ажиглаагүй байж болох юм!

- Ямар таатай юм бэ.

- Энэ чинь юу ...?

- Тэгэлгүй яахав! гэж Гермиона хашгираад духаа алгадахад хоёул айсандаа чимээгүй боллоо. Харри алив наашаа зүүлтээ өг! Крестраж чамд байсан хэвээр байгаа биз дээ!.

Гермиона түүнд гараа сунгахад Харри алтан гинжийг тайллаа. Тэгтэл зүүлт арьснаас нь хөндийрөх агшинд чөлөөтэй болж дотор нь хачирхалтай хөнгөрөхийг мэдрэв. Тэр энэ агшиныг хүртэл ямар дарамтанд байснаа мэдээгүй байж.

- Дээрдэв үү? гэж Гермиона асуулаа.

- Хамаагүй дээрдлээ!

- Харри, тэр чамайг эзэмдэж байсан юм шиг санагдахгүй байна уу? гээд тэр эмнэлэгт хүнд өвчтэй хүн эргэхээр ирсэн мэт өмнө нь өвдөглөн суулаа.

- Юу гэнээ? Үгүй! Би бидний хийсэн бүх зүйлийг санаж байна. Хэрвээ тэр намайг эзэмдсэн бол юу хийж байснаа санахгүй байсан биз дээ? Жинни хэлэхдээ заримдаа юу ч санадаггүй байсан гэсэн.

- Хмм гээд Гермиона хүнд зүүлт рүү харснаа,

- За яахав бид түүнийг зүүх хэрэггүй байх. Майханд хэвтэж байг гэв.

- Крестражыг хаа нэгтээ орхиж болохгүй гэж Харри шийдэмгий хэлээд,

- Хэрвээ бид түүнийг хулгайд алдвал, гээвэл ... гэв.

- За сайн байна гэж Гермиона зөвшөөрөөд хүзүүндээ зүүлтийг зүүж,

- Зөвхөн ээлжлэн зүүнэ шүү гэлээ.

- Гайхамшигтай гэж уурссан Рон хэлээд,

- За яахав бид үүний учрыг олсон болохоор идэх юм олох талаар оролдоод үзэж болохгүй юу? гэв.

- Тэгвэл өөр газар хайцгаая. Энд Дементорууд эргэн тойрон хөлхөлдөж байгаа болохоор үлдэж болохгүй гээд Гермиона Харри руу хяламхийн харлаа.

Тэд эцэст нь том талбайн дундах ганц фирмийн дэргэд зогсож нэг шөнийг өнгөрүүлэхээр шийдээд талх өндөг олж авлаа.

- Энэ хулгай биш биз дээ? Би тахианы торон дор мөнгө орхисон хэмээн

Гермиона талх өндөг идэж байх зуур санаа зовон хэлэв.

Тэгтэл хацраа бөмбийтөл дүүрэн юм чихсэн Рон нүдээ эргэлдүүлээд,

- Эр-ми-ни чи хэрэггүй юманд дэндүү их санаа зовж байх юм! гэв.

Хооллосны дараа санаа зовох зүйл юу ч үгүй болж ая тухтай болоод Дементоруудын хэрүүл мартагдан хөгжилтэй инээд болон хувирахад Харри хөгжилдэн тэр ч байтугай өнгөрсөн гурван шөнийн туршид анх удаагаа найдлага төрлөө.

Энэ тэдэнд цатгалан гэдэс сайхан зан, хоосон нь уйтгар гуниг хэрүүл төрүүлдэгийн анхны баталгаа болов. Харри Дурслийнд байх үедээ арай л өлсөж үхэлгүй байдаг учир энэ нь бусдаас бага нөлөөлж байв. Гермиона тэр үдэш хог ухан хатсан жигнэмэг, жимснээс өөр зүйл олоогүй учир ааш зан нь ердийнхөөс ширүүн байж баргар чимээгүй байлаа. Рон ээж болон Хогвартсын үйлчлэгч нарын ачаар амьдралынхаа турш өдөрт гурван удаа амттай хоол идэж байсан учир өлсгөлөн түүнийг цочмог ууртай болгон хувиргаж байв. Хэрвээ энэ бүхэн дээр нэмэрлээд крестражыг зүүх юм бол тэрбээр тун эвгүй ааштай болж байлаа.

- Одоо хаачих вэ? гэж тэр хэлэв. Тэд бусад крестражыг хаана эрэх болон яаж устгах талаар шийдвэрлэхийг оролдсон ч цагийг үр дүнгүй өнгөрүүлсэн бөгөөд яриа хөөрөө ахин дахин давтагдаж ямар ч шинэ мэдээлэл үгүй байв.

Дамблдор Волдеморт крестражаа түүний хувьд маш чухал газар нуусан гэж хэлсэн болохоор Харри, Гермиона хоёр түүний амьдарч очиж байсан бүх газрыг тооцон үзлээ. Тэр өнчин хүүхдийн газар өсөн торниж, Хогвартсад боловсрол эзэмшээд, сургуулиа төгссөний дараа «Горбин ба Бэркс» мухлагт ажиллаж, Албанид хөөгдсөн жилүүддээ амьдарч байсан. Энэ нь тэдний үндсэн яриа байв.

- Тийм шүү, Албани руу явцгаая. Жижигхэн газар болохоор өдрийн хагаст туулчихна гэж Рон даажигнан хэлэв.

- Тэнд юу ч байхгүй гэж Гермиона хэлээд,

- Тэр хөөгдөж явахынхаа өмнө тав дахь крестражаа бүтээсэн болохоор Дамблдор могой зургаа дахь нь гэдэгт итгэлтэй байсан. Могой Албанид байгаагүй болохыг бид мэдэх болохоор ердийнхөөрөө Вол ... гэв.

- Би чамаас түүний нэрийг хэлэхгүй байхыг гуйсан уу үгүй юу?

- Сайн байна! Могой ердийнхөөрөө Хэцүү нэртийн дэргэд байдаг биз дээ ... За сэтгэл хангалуун байна уу?

- Тийм ч их биш.

- Би түүнийг «Горбин ба Бэркс»-т ямар нэг зүйл нууж чадна гэж бодохгүй байна гэж Харри хэдийгээр энэ тухай олон удаа ярилцсан ч одоо зөвхөн таагүй нам гүм байдлыг эвдэхийн тулд хэлэв.

- Горбин, Бэркс хоёр хар урлагийн мэргэжилтэнгүүд болохоор крестражыг анхны харцаар шууд таних байсан.

Рон илт эвшээлгэв. Харри түүнийг ямар нэг зүйлээр чулуудах хүслээ тэвчин үргэлжлүүлж,

- Минийхээр бол Хогвартсад ямар нэг зүйл нуусан байх гэв.

- Гэхдээ Дамблдор түүнийг олох байсан биз дээ, Харри! Харри энэ маргаанд бэлэн байсан тул онолоо хамгааллаа.

- Дамблдор надад хэзээ ч Хогвартсын бүх нууцыг мэддэг гэж бодохгүй байна гэж хэлсэн. Та нарт хэлэхэд Вол ... чухал газар гэвэл ...

- Ёо-о-о!

- За яахав, Хэцүү нэр! гэж Харри тэвчээр алдан хашгираад,

- Түүний хувьд чухал газар гэвэл Хогвартс л биз дээ! гэв.

- Боль доо. Сургууль уу? гэж Рон ярвайлаа.

- Тиймээ, түүний сургууль! Бусдаас ялгаатай нь гэвэл анх удаагаа жинхэнэ гэр нь болсон газар. Тэр ч байтугай явсных нь дараа ч гэсэн ...

- Бид Хэцүү нэртийн тухай ярьж байгаа биз дээ? Чиний тухай биш? гэж Рон даажигнан хэлэхэд Харри түүнийг гэнэтхэн хүзүүндээ зүүсэн крестражын гинжээр нь боохыг хүслээ.

- Чи бидэнд Хэцүү нэрт сургуулиа төгсөөд Дамблдороос ажил гуйсан гэж хэлсэн хэмээн Гермиона хэлэв.

- Гуйсан гэж Харри баталлаа.

- Харин Дамблдор түүнийг ахин нэг крестраж болгон хувиргаж болох залгамжлагчын зүйл олохын тулд сургуульд буцаж ирэхийг хүсч байсан гэж бодож байсан биз дээ?

- Тиймээ.

- Гэхдээ тэр ажилд ороогүй тийм үү? гэж Гермиона хэлээд,

- Тэгэхээр түүнд сургуульд залгамжлагчын зүйлийг хайх болон нуух боломж байгаагүй гэв.

- За яахав сайн байна. Хогвартсын тухай март гэж Харри хэлэв.

Ингээд Лондонгоор үл үзэгдэх цуван дор нуугдан явж Волдемортын өссөн өнчин хүүхдийн асрах газар хайж олох тухай ярилцлаа. Гермиона авч явсан номын сангаасаа бичиг баримтыг онгичин байшин олон жилийн өмнө нураагдсан болохыг илрүүлэв. Тэд байрлалыг нь мэдсэн ч оронд нь албан байгууллагын барилга сүндэрлэж байлаа.

- Магадгүй суурийг нь малтаж үзэж болох юм? гэж Гермиона итгэлгүйхэн хэлэв.

- Тэр энд крестражыг нуугаагүй гэж Харри хэллээ.

Тэр эхнээсээ л Волдеморт өнчийн хүүхдийн газраас дөлж байсан болохыг ойлгож байв. Тэр хэзээ ч сүснийхээ нэг хэсгийг тэнд нуухгүй байсан. Дамблдор Харрид Волдеморт сүр жавхлантай нууцлаг газар нууна гэж итгүүлсэн болохоор энэхүү Лондонгийн уйтгартай саарал гудамжны буланг Хогвартс болон гантиг шалтай ид шидийн яам Гринготтстой харьцуулахад хэцүү байв.

Өөр ямар ч санаа төрөөгүй тул тэд үргэлжлүүлэн нүүж үдэш бүр майхнаа аюулгүй шинэ газар барьж байв. Харин өглөө болгон тэнд байсныхаа ул мөрийг устгаад өөр ондоо хүнгүй бөглүү газар, ой болон цохионы харанхуй ангал, ягаан хонин арц битүү ургасан уулын энгэр, хайргатай хөндийг хэсүүчлэн явж байлаа. Хорин дөрвөн цаг болгонд тэд зүүлтийг ээлжлэн зүүх бөгөөд «итгэлийн дугтуй» гэдэг удаашруулсан тоглоом тоглож байгаа аятай ялагч нь хорин дөрвөн цагийн турш айдас түгшүүрийг тээн авч явж байлаа.

Харри сорви үе үе хатгуулан өвдөнө. Энэ нь ихэнхидээ крестражыг зүүх үед тохиолдох тул заримдаа өвдөлтөө нуух гэсэн оролдлого нь бүтэлгүй болдог байв.

- Яасан? Чи юу харав? гэж Рон Харрийн үрчийхийг харан асуулаа.

- Нүүр. Нөгөө л царай. Гергоровичийн хулгайчын нүүр гэж Харри аяархан хариулав.

Рон урам хугарснаа нуухыг ч оролдсонгүй. Харри түүнийг гэр бүл болон бүлгийн бусад гишүүдийн тухай сонин сонсохоор найдсаныг ойлгож байсан ч эцсийн эцэст тэр зурагтын антенн биш болохоор ердөө тухайн агшинд Волдеморт юу бодож байгааг юмуу хүсч байгаа зүйлийг нь хардаг байлаа. Харваас Волдемортын толгойноос залуугийн хөгжилтэй царай гарахгүй байгаа хэдий ч нэр болон оршин суудаг газрыг нь түүнээс илүү мэдэхгүй гэдэгт Харри итгэлтэй байв. Ингээд сорви нь үргэлжлүүлэн өвдсөөр ой ухаанд нь цайвар үстэй даажигнасан хүүгийн дүр зураг урган гарч ирэхэд найзууддаа хулгайчын тухай дурсахгүйн тулд өвдөлтийн шинж тэмдэгээ нуухад сурлаа. Тэд крестражыг хаана байгааг мэдэхгүй байгаа явдалд цөхөрч байсан тулд тэднийг буруутгасангүй.

Өдөр хоног сунан өнгөрсөөр долоо хоног болоход Харри Рон, Гермиона хоёр түүний ард ярилцаж байна гэж сэжиглэх боллоо. Тэд хэдэн удаа майханд нь орох үед чимээгүй болсон бөгөөд хоёр ч удаа алсад толгойгоо нийлүүлэн зогсож байснаа ойртоход нь яриагаа даруйхан зогсож мод цуглуулах юмуу ус авч байгаа дүр эсгэхийг харжээ.

Харри тэдний нууц төлөвлөгөө байгаа гэж бодсон учир утга учиргүй аялалд явахыг зөвшөөрсөн явдлыг ойлгож байлаа. Рон муухай аашаа нуухыг ч оролдсонгүй бөгөөд Гермиона түүний хөөрхийлөлтэй удирдлаганд урам хугарч байгаа юм шиг санагдах боллоо. Тэр цөхөрсөндөө Хогвартсаас гадна крестражыг хаана эрж болох талаар бодохыг хичээсэн ч толгойд нь юу ч орж ирсэнгүй бөгөөд Рон, Гермиона хоёрт Хогвартсын нэрийг ахин дурьдсангүй.

Намрыг тэд нүүдэллэн сүрэл навчин дунд майхнаа босгож өнгөрүүлэв. Байгалийн манан Дементоруудынхтай нийлж салхитай бороо орлоо. Тэднийг Волдемортын эсрэг дайнд хүний орчноос тасран явах зуур Гермиона идэж болдог мөөгөөр арай дээр хоол хийж сурчээ.

- Миний ээж амттай хоол агааранас гаргаж чаддаг хэмээн Рон тэднийг Уэлс голын хөвөөнд майхандаа сууж байхад мэдэгдэв.

Тэр сэрээгээ аваад тавган дахь түлэгдсэн загасны хэсэг рүү баргар харлаа. Харрийн өөрийн мэдэлгүй Роны хүзүү рүү хараад хүссэн зүйлээ болох крестражын алтан гинж гялтагнаж байхыг олж харав. Тэр Роныг хараахыг хүссэн ч маргааш крестражыг тайлахыг нь мэдэж байгаа болохоор ааш зан нь бага зэрэг дээрдэх байлаа.

- Хоолыг агаараас хэн ч тэр дундаа чиний ээж ч гаргаж чадахгүй гэж Гермиона хэлээд,

- Хоол бол Гэмпийн үндсэн таван хувиргалын хуулийн эхнийхэд нь ордог болохоор ... гэв.

- Хүний хэлээр ярьж болохгүй байна уу? гэж Рон яриаг нь таслан хэлээд шүднийхээ завсар орсон загасны ясыг авлаа.

- Хоол хийх нь ямар ч боломжгүй зүйл! Хэрвээ угаасаа чамд байгаа тохиолдолд байгаа газрыг нь мэдэж байгаа болохоор Татдаг шидээр дуудан хувиргаж хэмжээг нь ихэсгээд ...

- Сайн байна тэгвэл энэ жигшмээр зүйлийг ихэсгэхийг лав хүсэхгүй байна.

- Харри энэ загасыг барьж би чадлаараа бэлтгэсэн! Яагаад ч юм хоол хийх ажил үргэлж надад ногддог нь бодвол эмэгтэй хүн учраас байх!

- Үгүй дээ чи манай гол шидтэн шүү дээ!

Гермиона үсрэн босоход тавган дээр байсан шарсан цурхай газар уналаа.

- Маргааш чи хоол бэлдээрэй, Рон. Хэрэгтэй бүх зүйлээ шившлэгээр гаргаж ирээд аманд хийж болох зүйл бэлдээрэй. Харин би дэргэд чинь суугаад ярвайж ёолж байх болохоор ямар байхыг нь харах болно ...

- Чимээгүй! Түр хүлээгээрэй! гээд Харри босож хоёр гараа өргөлөө. Гермиона улам уурлалаа.

- Чи яаж түүнийг өмөөрч чадаж байна аа? Тэр нэг ч удаа хоол бэлтгэхэд оролцож байгаагүй ...

- Гермиона чимээгүй би хэн нэгний дуу сонсох шиг боллоо!

Харри ярихгүй байхыг анхааруулан гараа өргөсөн хэвээр чимээ анирдлаа. Тэгтэл үнэхээр ус цалгилах чимээ гарч дэргэдэх голын эрэг дээр яриа сонсогдов. Тэр вредноскоп руу харлаа. Ямар ч аюул ослын шинж үзэгдсэнгүй.

- Чи биднийг бүх шившлэгээр шившсэн биз дээ? гэж Гермионагаас шивнэн асуув.

- Би чадах л бүх зүйлээ хийсэн гэж тэр хариу шивнээд,

- Магл түлхэгч, Хувиргагч гээд бүгд л. Тэд биднийг харж сонсож чадахгүй.

Хэн нэгний хөлөө чирэх хүнд алхаа сонсогдсоноо дараа нь чулуу өнхрөх чимээ гарч хэдэн хүмүүс огцом налуу уруудан тэдний майхан байгаа давчуу эрэг дээр гарч иржээ. Гурвуул саваагаа бэлхэн барив. Тэдний тойруулсан шид хангалттай байсаны

дээр одоо бараг л харанхуй байсан тул маглууд болон шидтэн байсан ч харахааргүй байлаа. Хэрвээ энд Үхэл залгигчид ирсэн бол хамгаалалт нь хар шиднээс хамгаалах анхны шалгалтандаа орж болох юм.

Эрэг дээрх хоолой чанга байсан ч учрыг нь олох аргагүй байлаа. Харри тэднийг хорин футаас холгүй зайд байна гэж тооцоолсон ч голын хүрхрээнээс болж итгэлтэй хэлэх боломжгүй ажээ. Гермиона цүнхээ онгичин гурван Уртасгагч чих гаргаад Харри, Рон хоёрт нэг нэгийг өглөө. Гурвуул яаран ягаан уяаны төгсгөлийг чихэндээ нааж нөгөө үзүүрийг нь майхнаас гаргав.

Хормын дараа Харри ядарсан эрэгтэй хүний хоолой сонсов.

- Яргай загас энд байх ёстой доо. Эсвэл та нар улирал нь биш гэж бодож байна уу? Ацио яргай!

Алсад ус цалгилан алгадах чимээ сонсогдоод том загас хүний гарт баригдав. Харри Уртасгагч чихний үзүүрийг чихэндээ чанга наахад эрэг дээрх хоолой англиар биш хэзээ ч сонсогдоогүй хэлээр ярьж байлаа. Энэ нь бүдүүлэг хахир хэл байсан бөгөөд хамрын угаас дуулдах чимээг бодвол ярилцагчдын нэг нь нөгөөгсөө аяархан удаан дуутай байлаа.

Брезентийн нөгөө талд гал асаж түүдгийн дөл майхан сүүдэртэв. Агаарт шарж буй яргай загасны сайхан үнэр ханхаллаа. Дараа нь таваг сэрээ хангинан ахин эрэгтэй хүний хоолой сонсогдлоо.

- Энэ Дэгээдэгч, Горнак авааарай.

- Албингууд! гэж Харри Гермионад шивнэхэд толгой дохилоо.

- Баярлалаа гэж албингууд англиар зэрэг хэлэв.

- Та гурав зугтаж байгаа бололтой. Удаж байна уу? гэх шинэ таатай хоолой гарахад Харрид таньдаг юм шиг санагдан бүдүүн гэдэс хөгжилтэй царайтай эрэгтэй хүн төсөөлөгдөв.

- Зургаан долоо хоног ... Долоо ч билүү ... Санахгүй байна гэж ядарсан эрэгтэй хүн хэлээд,

- Анхны долоо хоногт би Дэгээдэгчтэй уулзаад хоёр өдрийн дараа Горнак бидэн дээр нэгдсэн. Бүлгээрээ байхад таатай юм гээд чимээгүй болон хутга тавганд хавиран газар тавьснаа аяга авлаа. Дараа нь,

- Та яагаад явсан юм бэ, Тед? гэв.

- Би тэдний над руу ирэхийг мэдэж байсан гэх Тедийн аяархан хоолой гарахад

Харри гэнэтхэн Тонксын эцэг болохыг нь ойлголоо.

- Өнгөрсөн долоо хоногт манай түүгээр Үхэл залгигчид ирэхэд тэднээс зугтсан нь дээр гэж шийдсэн юм. Магл гаралтай хүмүүсийг зарчмын хувьд бүртгэж байгаа ч эрт орой нэгэн цагт явахаа ойлгож байсан. Эхнэрийн хувьд юу ч тохиолдохгүй түүний цус цэвэр. Дараа нь би энд Динтэй тааралдсан. Хоёр өдрийн өмнө билүү, хүү минь?

- Тиймээ гэх ахин нэг хоолой гарахад Харри, Рон, Гермиона гурав нэг ангийн

Дин Томасын хоолойг таниад чимээгүйхэн түгшсэн харц солилцлоо

- Тэгэхээр чи магл гаралтай юм уу? гэж эхний эрэгтэйн хоолой асуув.

- Тодорхой хэлж чадахгүй нь. Аавыг явах үед би жижигхэн байсан болохоор надад түүнийг шидтэн гэдгийн баталгаа байхгүй.

Хэсэг зуур бүгд чимээгүй болсноо зөвхөн зажлах чимээ сонсогдож байтал дараа нь

Тед ахин ярьж эхлэв.

- Дирк би таныг зугтаж байгааг хараад гайхсанаа хэлэх ёстой. Гэхдээ гайхсан ч таатай байна. Таныг барьсан гэж ярьцгааж байсан.

- Намайг барьсан ч Азкабан хүрэх замын хагаст зугтчихсан юм. Долишийг хөшөөгөөд шүүрийг нь авч зугтсан. Энэ ч бодсоноос амархан болсон шүү. Би түүнийг тэр үед хэвийн байсан гэж бодохгүй байна. Магадгүй хэн нэгэн Конфундус илгээсэн байж мэднэ. Хэрвээ тэгсэн бол ийм зүйл хийсэн ямар ч шидтэний гарыг нь чанга атгахад бэлэн байна. Тэр миний амьдралыг аварсан.

Ахин чимээгүй болоход түүдэг гал шад падхийн дүрэлзэж гол хоржигнов. Дараа нь

Тед,

- Харин та хоёр энд яаж ирээ вэ? Надад албингууд Хэцүү нэртийн талд байгаа юм шиг сэтгэгдэл төрсөн юмсан гэв.

- Таньд буруу сэтгэгдэл төрсөн байна гэж бүдүүн дуутай албин хэлээд,

- Бид хэний ч талд биш. Шидтэнгүүд дайтаж байгаа бол энэ тэдний хэрэг гэв.

- Тэгвэл та нар яагаад нуугдаж байгаа юм бэ?

- Би үүнийг ухаалаг болгоомжлол гэж бодож байна. Би эрээ цээрээгүй хүсэлтийг биелүүлэхээс татгалзаад миний хувийн аюулгүй байдалд аюл заналхийлж байгааг ойлгосон юм.

- Тэд танаас юу хийхийг гуйсан юм? гэж Тед сонирхов.

- Манай овгийнхноос доод түвшний зүйл гэж албин бүдүүлэг байдалтай хэлээд,

- Би бол ердөө нэг гэрийн үйлчлэгч биш гэв.

- Харин та яагаа вэ, Дэгээдэгч?

- Мөн л тийм шалтгаанаар гэж арай өндөр хоолойтой нь хэлээд,

- Манай овгийнхон Гринготтсыг бүрэн хяналтандаа байлгахаа больсон. Харин би шидтэнгүүдийг эзнээ болгохыг хүсэхгүй байна гэв.

Тэр ямар нэг зүйл албины хэлээр нэмж хэлэхэд Горнак инээлээ.

- Тэр таньд юу хэлсэн бэ? гэж Дин асуулаа.

- Тэр шидтэнгүүдийн мэдэхгүй зүйлийн талаар хэллээ хэмээн Дирк хариулав. Хэсэг зуур нам гүм болов.

- Ойлгосонгүй гэж Дин дуугарлаа.

- Би явахаасаа өмнө бага зэрэг өшөө авсан гэж Дэгээдэгч хүний хэлээр хэлэв.

- Сайн залуу ... албин гэж хэлэх гэсэн юм л даа хэмээн Тед яаран засаад,

- Та нар Үхэл залгигчдыг найдвартай шүүгээнийхээ нэгд түгжсэн гэж найдаж болох уу? гэв.

- Хэрвээ би үүнийг хийсэн бол түүнийг тэндээс гарахад илд туслахгүй байлаа гэж Дэгээдэгч хэлэхэд Горнак ахин инээж Дирк хүртэл инээд алдав.

- Дин бид хоёр бас л юу ч ойлгосонгүй гэж Тед хэлэв.

- Северус Снегг гэсэн тэгсэн гэж бодож байна хэмээн Дэгээдэгч хэлэхэд албингууд хорсолтой хөхрөлдлөө.

Харрийн сэтгэл донслоход Гермиона руу ширтсэнээ яриаг бүх хүчээ гарган сонсохыг хичээв.

- Тэгэхээр та энэ тухай сонсоогүй хэрэг үү, Тед? Гриффиндорын хүүхдүүд Хогвартсад Снеггийн өрөнөөс илдийг авахыг оролдсон тухай? гэж Дирк асуулаа.

Харри цахилгаан хэлхээнд цохиулсан аятай биеийн хэсэг бүр нь татвалзах шиг болов.

- Нэг ч үг сонсоогүй. «Зөнч» сонинд энэ тухай бичээгүй биз дээ?

- Тиймээ магадгүй л юм. Дэгээдэгч надад хэлэхдээ энэ тухай банкинд ажилладаг Билл Уизлигаас сонссон гэсэн. Илдийг хулгайлахыг оролдсон хүүхдүүдийн нэг нь Биллийн бага дүү байжээ.

Харри Рон, Гермиона хоёр руу харахад Уртасгагч чихээ авралын үүд шиг бариад зогсож байв.

- Тэр хоёр найзынхаа хамт Снеггийн өрөөнд орж шилэн шүүгээг хагалан илдийг авсан байна. Снегг тэднийг шатан дээр илдийг авч явахад нь барьжээ.

- Ай, тэднийг бурхан өршөөг. Тэд илдээр юугаа хийх гэсэн юм бол? Хэцүү нэртийн эсрэг хэрэглэх гэсэн юм болов уу? Эсвэл Снеггийн үү? гэж Тед хэлэв.

- Тэд юу ч бодож үүнийг хийсэн байлаа гэсэн Снегг түүнийг урьдын байранд байлгах нь аюулгүй биш гэж шийдсэн. Ингээд хоёр өдөр Хэцүү нэртийн зөвшөөрлийг хүлээгээд илдийг Лондон дахь Гринготтс банкинд хадгалуулахаар өгчээ.

Албингууд ахин хөхрөлдөв.

- Би юу нь инээдтэй байгага ойлгосонгүй гэж Тед хэлэв.

- Энэ бол хуурамч байсан гэж Дэгээдэгч хяхтнан дуугарлаа.

- Гриффиндорын илд үү?

- Тиймээ мөн. Энэ бол дууриамал байсан. Үнэнийг хэлэхэд маш сайн хуулбар байсан. Жинхэнэ илдийг олон зууны өмнө албингуудыг хийсэн юм. Гэхдээ жинхэнэ

Гриффиндорын илд одоо хаана байгааг мэдэхгүй юм Гриффиндорын шүүгээнд лав байхгүй.

- Би одоо л ойлголоо. Харин та энэ тухай Үхэл залгигчдад хэлсэнгүй тийм үү?

гэж Тед хэлэв.

- Би ийм мэдээлэл өгөх ямар ч шалтгаан олж харахгүй байна гэж Дэгээдэгч сэтгэл хангалуун хэлэхэд Тед, Дин хоёр тэдний хамт хөхрөлдлөө.

Харри майханы дотор нүдээ аниад хэн нэгэн хэрэгтэй асуултыг нь тавихыг гуйтал арван хормын дараа Дин энэ талаар асуулаа.

- Жинни болон бусдад нь юу тохиолдсон бэ? Илдийг хулгайлахыг оролдсоны төлөө?

- Өө, тэднийг их хэрцгий шийтгэсэн гэж Дэгээдэгч хайхрамжгүй хэлэв.

- Гэхдээ тэд бүтэн биз дээ? гэж Тед түргэхэн асуугаад,

- Уизлийнханд ахин нэг хүүхэд нь гэмтэх хэрэггүй юмсан гэв.

- Миний мэдэж байгаагаар тэдэнд ямар ч ноцтой гэмтэл учраагүй.

- Тэгвэл тэдэнд аз таарсан байх нь. Снегг тэднийг амьд үлдээгээд хувийн хэрэгт нь тэмдэглэсэн явдалд баярлаж болох юм.

- Та энэ түүхэнд итгэдэг юм уу, Тед? Снегг Дамблдорыг алсан гэдэг? хэмээн

Дирк асуулаа.

- Мэдээж итгэж байна. Харин та Поттерыг энэ үхэлд оролцсон гэдэгт итгэж байна уу?

- Эдгээр өдрүүдэд юунд итгэхээ мэдэхэд хэцүү байна гэж Дирк бувтналаа.

- Би Харри Поттерыг мэднэ тэгээд ч гайхамшигтай хүн гэж бодож байна.

Хүсвэл сонгогдсон ч гэж хэлж болно хэмээн Дин хэллээ.

- Тиймээ, олон хүмүүс түүнийг тийм гэж итгэдэгийн тоонд би ч гэсэн орно, хүү минь. Гэхдээ тэр хаана байна? Зугтсан биз дээ. Хэрвээ түүнд бидний мэдэхгүй онцгой авъяас байсан бол одоо хаа нэгтээ нуугдахын оронд тулааны гүнд байх байсан. Түүнчлэн «Зөнч» түүнийг маш ноцтой зүйлээр буруутгаж байгаа гэж Дирк хэллээ.

- «Зөнч» гэнээ? хэмээн Тед тургилаад,

- Хэрвээ та энэ жигшүүртэй сонинг уншдаг бол зөвхөн худал үгийг л олох болно, Дирк. Тэгсэн дор «Шүүмжлэгч»-ийг уншсан нь дээр гэв.

Гэнэтхэн ханиалгах дуу гараад нуруун дээр алгадах чимээ гарахад Дирк загасны ясанд хахсан бололтой. Тэр эцэст нь үг хэлэх чадвартай болоод,

- «Шүүмжлэгч» гэнээ? Ксено Лавгудын уу? гэв.

- Тэр одоо солиотой юм бичихээ больсон. Та түүнийг шагайж үзэх хэрэгтэй шүү. Ксенофилуис «Зөнч» сонины үл тоомсорлосон бүх баримтуудыг хэвлэж сүүлийн дугаартаа үрчгэр эвэртийн тухай нэг ч дурдаагүй. Энэ бүхэн хэр удаан үргэлжлэхийг мэдэхгүй ч гэхдээ Ксено эхний хуудас болгон дээрээ Хэцүү нэртийн эсрэг тэмцэхийг хүссэн хүн бүхэн Харри Поттерт туслахыг эхний үүргээ болгох ёстой гэж тунхаглаж байгаа.

- Ертөнцөөс алга болсон хүүд туслах ч хэцүү хэрэг байна даа гэж Дирк хэлэв.

- Түүнийг одоо хүртэл бариагүй ямар ч амжилт олоогүй гэдгийг мэдэж байгаа биз дээ. Би түүний тухай ямар ч зүйлийг баяртай сонсох болно. Тэгээд ч бид түүнийг чөлөөтэй байлгахад тусалж болохгүй гэж үү?

- Тийм шүү гол учир нь энд л байгаа юм. Ид шидийн яам даяараа хүүг эрж байгаа ч бариагүй л байгаа. Хэдийгээр тэд түүнийг хэдийн бариад алсан гэж мэдэгдэж байгаа ч гэсэн.

- Өө, Дирк битгий тэгж ярь гэж Тед бувтналаа.

Удтал чимээгүй болсны эцэст хутга сэрээ хангиналаа. Дараа нь тэд хаана хоноглохоо ярилцаад модны нөмөрт түүдэг асаахаар шийдэн огцом эргээр буцаж өгсөхөд хоолой нь бөхөн алга болов.

Харри, Рон, Гермиона гурав Уртасгагч чихээ хумхив. Харри яриаг сонсож байхад чимээгүй байх нь хэцүү байсан хэр нь одоо үг хэлж чадсангүй зөвхөн,

- Жинни ... илд гэв.

- Мэдэж байна! гэж Гермиона хэллээ.

Тэр жижигхэн цүнхээ гаргаж ирснээ гараа шургуулан,

- Энд л байх ёстой доо ёроолыг нь хүртэл ухав.

Тэр гадагш удаанаар хээ хуартай том жааз гарч ирэв. Харри яаран түүнд туслан Финеас Найжелусын хоосон хөргийг гаргаж ирэхэд Гермиона дурын агшинд шившлэг илгээхэд бэлнээр саваагаа гаргаж ирлээ.

- Хэрвээ хэн нэгэн Дамблдорын өрөөнд байсан жинхэнэ илдийг хуурамчаар сольсон бол Финеас Найжелус бүгдийг харж чадах байсан. Түүний хөрөг шилэн шүүгээний дээр өлгөөстэй байдаг биз дээ гэж Гермиона хөргийг майхны хана түшүүлэн тавихад хэллээ.

- Хэрвээ тэр унтаж байгаагүй бол шүү дээ гэж Харри хэлэхэд Гермиона саваагаа хоосон хөрөгний гол руу чиглүүлж хоолой засан ханиалгаад,

- Э-э ... Финеас! Финеас Найжелус! гэв. Юу ч болсонгүй.

- Финеас Найжелус! гэж Гермиона ахин давтаад,

- Профессор Блэк! Танаас гуйя бидэнтэй ярилцаач дээ. Гуйж байна! гэв.

- Гуйж байна гэх үргэлж тусалдаг юм гэх хүйтэн даажигнасан хоолой гараад

Финеас Найжелус хөргөнд гарч ирлээ. Түүнийг дөнгөж хармагц Гермиона,

- Обскура! гэв.

Финеас Найжелусын ухаалаг хар нүдэнд хар боолт зүүгдэхэд духаараа жаазны хүрээ мөргөөд өвдсөндөө хашгирлаа.

- Юу ... чи яаж зүрхэлж байна ... чи яаж ... гэв.

- Надад их харамсалтай байна, профессор Блэк гэхдээ энэ бол урьдчилан сэргийлэх арга хэмжээ гэж Гермиона хэлэв.

- Одоохон энэ заваан зүйлээ авч хая! Хая гэж хэлж байна шүү! Чи агуу уран бүтээлийг сүйрүүллээ! Би хаана байна? Юу болоод байна?

- Та хаана байгаа нь чухал биш гэж Харри хэлэхэд Финеас Найжелус хөшсөнөө нүднийхээ боолтыг авч хаяхыг оролдон,

- Энэ хоолой баригдашгүй ноён Поттерынх юм биш биз? гэв.

- Бүрэн боломжтой гэж Харри Финеас Найжелусын сонирхохыг харан хэлээд,

- Бидэнд танаас Гриффиндорын илдний тухай асуух асуулт байна гэв.

- Аан гээд Финеас Найжелус толгойгоо эргүүлэн Харриг нүднийхээ булангаар харахыг хичээнгээ,

- Тийм л дээ. Тэнэг охин ухаалаг бус зүйл хийсэн гэв.

- Миний дүүгийн тухай тэгж битгий ярь! хэмээн Рон бүдүүлгээр зандрахад

Финеас Найжелус хөмсгөө ихэмсгээр өргөлөө.

- Та нартай хамт хэн байна вэ? Надад дууны өнгө нь таалагдахгүй байна! Охин болон түүний найзууд туйлын мунхаг зүйл хийсэн. Сургуулийн захирлын юмыг хулгайлана гэдэг чинь!

- Энэ хулгай биш. Илд Снеггэд хамааралгүй гэж Харри хэллээ.

- Тэр сургуулийг толгойлж байгаа болохоор профессор Снеггэд хамаарагдана гэж Финеас Найжелус мэдэгдээд,

- Түүнийг Уизлийн охин эзмшинэ гэх ямар дүрэм байгаа юм бэ? Тэр тэнэг

Долгопупс болон гажиг Лавгуд хоёрын хамт шийтгэл хүлээсэн гэв.

- Невилл тэнэг, Полумна гажиг биш! хэмээн Гермиона дуу алдав.

- Би хаана байна? гэж Финеас Найжелус давтсанаа ахин нүдний халхалсан зүйлийг авч хаяхыг оролдон,

- Та нар намайг хааш нь авчраа вэ? Яах гэж миний өвөг дээдсийн гэрээс холдуулав? гэлээ.

- Энэ чухал биш! Снегг Жинни, Невилл, Полумна нарт ямар шийтгэл оноосон юм бэ? гэж Харри шаардангуй асуулаа.

- Профессор Снегг тэднийг Хориотой ойд дүйнгэ Хагридтай хамт ажил хийлгэхээр явуулсан.

- Хагрид дүйнгэ биш! гэж Гермиона ахин хашгирав.

- Снегг үүнийг шийтгэл гэж бодсон байж болох ч Жинни, Невилл, Полумна нарын хувьд Хагридтай байх нь сайн зүйл юм. Хориотой ойд гэнэ шүү ... тэд Хориотой ойгоос ч илүү дор газар болох байлаа! гээд Харри хамгийн багадаа Круциатус шившлэг байж магадгүй гэж бодож байсан тул санаа амарлаа.

- Бид илдийг хэн нэгэн гадагш авч явсан эсэхийг мэдэхийг хүсч байна, профессор Блэк гэж Гермиона хэлээд,

- Магадгүй хаа нэг тийш нь ... цэвэрлэхийн тулд ч юм уу зөөсөн ч юмуу уу?

гэв.

Финеас Найжелус чимээгүйхэн инээлээ.

- Магл гаралтан минь. Албингийн хийсэн эдлэлийг цэвэрлэдэггүйг чи мэдэх үү.

Албингуудын мөнгө орчлон ертөнцийн бохироос гадуур хатаагдсан байдаг юм.

- Гермионаг тэгж нэрлэх хэрэггүй гэж Харри хэлэв.

- Би зөрчилдсөөр ядарч байна. Магадгүй захирлын өрөөнд эргэж очсон нь дээр байх гэж Финеас Найжелус хэллээ.

Тэр хөргөн дотроо сохроор тэмтчин Хогвартс руу буцах замаа олохыг хичээлээ. Тэгтэл Харрид гэнэтхэн нэг санаа төрлөө.

- Дамблдор! Та ийшээ Дамблдорыг авчирч чадах уу?

- Өршөөгөөрэй? хэмээн Финеас Найжелус гайхлаа.

- Профессор Дамблдорын хөрөг ... та түүнийг ийшээ хөргөндөө авчирч чадах уу?

Фиенас Найжелус толгойгоо Харрийн дуу гарсан зүг рүү эргүүлээд,

- Харваас зөвхөн магл гаралтай хүмүүс харанхуй бүдүүлэг биш бололтой, Поттер. Хогвартсын хөргүүд өөр хоорондоо ярилцаж чадахаас биш шилтгээнээс гадагш бие биенийхээ хөргөнд зочилж чадахгүй. Тиймээс Дамблдор ийшээ миний хамт ирж чадахгүй бөгөөд таны гаргаж буй зан авирын улмаас би ахин ирэхгүй гэдгээ итгүүлэн хэлэх байна гэв.

Харри үл мэдэг сэтгэлээр унаснаа Финеас Найжелус хөргийг орхихыг ахин оролдохыг хараад,

- Профессор Блэк та бидэнд илдийг хамгийн сүүлд хэзээ шүүгээнээс гаргасныг хэлэхгүй юу? Би Жиннигээс өмнө гаргасан тухай ярьж байна л даа гэв.

Финеас тэвчээргүйхэн тургилав.

- Миний санаж байгаагаар Гриффиндорын илдийг профессор Дамблдор хамгийн сүүлд бөгжийг эвдлэхийн тулд гаргасан юм байна.

Гермиона Харри руу огцом эргэсэн ч Финеас Найжелусын дэргэд ярилцаж зүрхэлсэнгүй.

- За тэгэхээр тавтай нойрсохыг хүсье гэж тэр хорон хэлээд хараанаас алга боллоо. Түүний малгай жаазны хөвөөнөөс үзэгдэхээ больмогц Харри гэнэтхэн,

- Хүлээгээрэй! Та энэ тухай Снеггэд хэлэх үү? гэж хашгирлаа. Финеас Найжелусын нүдний боолттой царай хөрөгт буцан ирлээ.

- Профессор Снеггэд Альбус Дамблдорын олон тооны жигтэй зүйлийн учрыг олж байхааргүй хангалттай их ажил байгаа. Баяртай, Поттер!

Ингээд тэр эцсийн удаа алга болохдоо ардаа бохир зотон хөрөг үлдээв.

- Харри! гэж Гермиона хашгирлаа.

- Би мэдэж байна! гэж Харри хашгираад биеэ барьж чадалгүй агаарт гараа цохилоо. Тэр майхан дундуур холхих зуураа олон миль гүйсэн мэт болж өлссөнөө ч мартлаа. Гермиона Финеас Найжелусын хөргийг цүнхэнд буцаан хийнгээ түгжээгээ горхилон Харри руу баясан харлаа.

- Илд крестражыг устгах чадвартай! Албингийн хийцийн бүтээл ... Харри илд василискийн хорыг шингээсэн!

- Дамблдор зүүлтийг устгахын тулд илдийг надад өгөөгүй юм байна ...

- ... магадгүй тэр илдийг гэрээслэлдээ үлдээвэл тэднийг өгөхгүй гэдгийг ойлгосон байх ...

- ... тэгээд хуулбарыг нь хийж ...

- ... хуурамчаа шилэн шүүгээнд байрлуулж ...

- ... харин жинхэнэ нуугаастай байгаа ... хаана байгаа юм бол?

Тэд бие бие рүүгээ харлаа. Харри хариулт хаа нэгтээ ойрхон байхыг мэдэрлээ. Дамблдор яагаад түүнд юу ч хэлээгүй юм бол? Эсвэл хэлсэн ч Харриг ойлгох цаг нь болоогүй гэж бодсон юм болов уу?

- Бод! гэж Гермиона шивнэлээ. Бод. Тэр илдийг хаана орхиж болох вэ?

- Хогварстад лав биш гэж Харри хэллээ.

- Хогсмидэд юм болов уу? хэмээн Гермиона санал болгов.

- Орилоо овоохойд ч байж болох юм? Хэн ч тийшээ явахаа больсон биз дээ.

- Гэхдээ Снегг тийшээ яаж орохыг мэдэх болохоор Дамблдор тийм эрсдэл гаргана гэж үү?

- Дамблдор Снеггэд итгэдэг гэж Харри сануулав.

- Гэхдээ л түүнд хуурамч илдний тухай хэлээгүй.

- Тийм шүү, чиний зөв! гэж Харри зөвшөөрөөд Дамблдор Снеггэд итгэдэг явдал хязгаарлагдмал байсанд баярлалаа.

- Тэгвэл тэр илдийг Хогсмидийг хаана нуусан байж болох вэ? Рон чи юу бодож байна? Рон?

Харри эргэн тойрноо харлаа. Нэгэн хормын турш Рон майханд байхгүй юм шиг санагдсан ч түүний чулуун царай доод талын орон дээр хэвтэж байх нь үзэгдэв.

- Өө, эцэст нь арайхийж миний тухай санав уу?

- Юу гэнээ?

Рон дээд талын ор луу харан тургилснаа,

- Үргэлжлүүлцгээ, үргэлжүүлцгээ. Надад та хоёрын баяр хөөрийг эвдэх хүсэл алга гэв.

Тэвдсэн Харри Гермиона руу тусламж эрэн харсан ч бас тэр түүнээс дутуугүй гайхсан бололтой толгой сэгсрэв.

- Ямар нэг асуудал гараа юу? гэж Харри асуув.

- Асуудал гэнээ? Ямар ч асуудал байхгүй гэж Рон урьдын адил Харри руу харалгүй хэлээд,

- Ямар ч гэсэн чинийхээр биш гэв.

Тэдний толгой дээрх брезентэн адар дээр хэдэн дусал унаж бороо орж эхэллээ.

- За яахав асуудал чамд байгаа юм байж. Алив тэгээд ярь л даа?

Рон орноос урт хөлөө буулгаад суулаа. Тэр хорсож уурласандаа өөрийгөө ч мэдэхээ больжээ.

- Сайн байна. Би хэлье. Гэхдээ намайг та хоёрын олсон тэнэг зүйлд баярласандаа майхнаар нэг гүйнэ гэж бүү бодоорой. Зөвхөн мэдэхгүй зүйлийнхээ жагсаалтанд нэмнэ биз.

- Мэдэхгүй гэнээ? Би юу мэдэхгүй гэж?

Түг, түг, түг. Бороо улам ширүүн орж эхлэхэд харанхуйд навчис сэрчигнэж, гол хоржигноно. Харрийн баяр хөөр усаар шүршүүлсэн мэт алга болов. Рон түүний сэжиглэж байсантай адил ярьж байлаа.

- Энд харваас миний амьдралын сайхан мөчүүд өнгөрөөгүй бололтой. Чи ойлгож байгаа биз дээ миний гар гэмтэн, идэх юм юу ч үгүй шөнө болгон даарч байна. Бас хэдэн долоо хоногийн турш ямар нэг зүйл олох болов уу найдаж байлаа.

- Рон гэж Гермиона аяархан хэлсэн ч борооны дуслах чимээнд сонссонгүй.

- Би чамайг юунд явж байгаагаа мэднэ гэж бодсон юмсан хэмээн Харри хэлэв.

- Тиймээ би ч гэсэн тэгж бодсон.

- Тэгвэл чинийхээр бол би юунд хариулаагүй юм бэ? гээд Харрийн уур хүрч эхэллээ. - Чи биднийг таван одтой зочид буудалд орно гэж бодоо юу? Крестражыг өдөр болгон олно гэж бодсон хэрэг үү? Эсвэл зул сарын баяраар ээж рүүгээ эргэн очих гээ юу?

- Бид чамайг юу хийж байгаагаа мэднэ гэж бодсон! хэмээн Рон босоод хашгирахад энэ үг нь Харрийг хутга шиг зүслээ. Дамблдор чамд юу хийх ёстойг хэлсэн гэж бодсон! Бид чамд жинхэнэ төлөвлөгөө байгаа гэж бодсон!

- Рон! гэж Гермиона борооны шаагих чимээнд сонсогдохуйц чанга хэлсэн ч

Рон үл тоомсорлов.

- Тэгвэл чамайг үүнд оролцуулсанд уучлаарай гээд Харри тайван байхыг хичээн хэлээд,

- Би эхнээсээ л чамд Дамблдороос сонссон бүхнээ хэлж байсан. Тэгээд ч хэрвээ чи ажиглаагүй бол бид нэг крестражыг олоод байна ... гэв.

- Тийм шүү түүнээс салах нь бусдыг нь хайж олохтой адил ойрхон байгаа.

Өөрөөр хэлбэл бид үүнийг хийж чадахгүй!

- Зүүлтийг тайл, Рон гэж Гермиона нарийхан хоолойгоор гуйгаад,

- Гуйж байна, тайлчих. Хэрвээ чи түүнийг өдөржин зүүгээгүй бол ингэж ярихгүй байсан гэв.

- Үгүй ярих байсан гээд Харри Роныг уучлахыг хүссэнгүй. Чинийхээр бол та хоёр миний ард яаж шивнэлдэж байхыг чинь хараагүй гэж бодоо юу? Та хоёрын юу гэж бодож байгааг тааварлаагүй гэж бодож байна уу?

- Харри, бид тэгээгүй ...

- Бүү худал хэл! гэж Рон түүн рүү хашгирлаа.

- Чи өөрөө урам хугарч байна гэсэн ... чи түүнийг толгойгоо жаахан ажиллуулах ёстой гэсэн ...

- Би ингэж хэлээгүй ... Харри, би тэгээгүй! гэж Гермиона хашгирлаа.

Бороо брезентыг бөмбөрдөхөд Гермионагийн хацар даган нулимс урсаж тэдний хэдхэн хормын баяр хөөр хоромхон дүрэлзсэн галт наадмын адил унтраад харнхуйд зөвхөн хүйтэн, чийг л үлдэв. Гриффиндорын илд хаана нуугаастай байгаа нь тодорхойгүй бөгөөд цорын ганц олсон амжилт гэвэл үхээгүй л байлаа.

- Тэгвэл чи яагаад энд байсан хэвээр байгаа юм бэ? гэж Харри Роноос асуув.

- Алсан ч мэдэх юм алга.

- Тэгвэл гэр лүүгээ яваач.

- Тийм шүү, явсан ч яадаг юм! гэж Рон хашгираад Харри руу хэд алхахад хойш ухарлаа.

- Чи тэднийг миний дүүгийн талаар юу ярихыг сонссон биз дээ? Гэхдээ энэ чиний хувьд юу ч биш л дээ зөвхөн Хориотой ой гэнэ шүү! Харри Поттерд

тэнд юу болж байгаа нь хамаагүй л дээ ... харин надад аварга том аалз болон бусад зүйлс байдаг нь хамаагүй ...

- Би зөвхөн тэднийг Хагридтай хамт байгаа бол гэж хэлсэн биз дээ ...

- Тиймээ, тийм би чамд хамаагүй гэдгийг хэдийн ойлгосон! Харин манай гэр бүлийн бусад хүмүүсийн хувьд яах болж байна? Уизлийнханд ахин нэг хүүхэд нь гэмтэх хэрэггүй юмсан гэхийг сонсоо биз дээ?

- Тиймээ, гэхдээ ...

- Энэ чиний санааг энэ зовоохгүй байгаа биз дээ?

- Рон! гээд Гермиона тэдний дундуур хүчээр орж,

- Цаашид юу болохыг бид мэдэхгүй. Бодоод үз л дээ, Рон Билл сорвитой болж, Жорж өрөөсөн чихээ алдаж, чи орондоо үхлүүт өвчтэй хэвтэж байгаа ч би түүнийг гэдэгт итгэлтэй байна ...

- Аа чи үүнд итгэлтэй байгаа юм уу? Тэгвэл сайн байна, би тэдэнд санаа зовохгүй. Та хоёрын эцэг эх аюулгүй нуугдаастай байгаа ...

- Миний эцэг эх үхсэн! гэж Харри дэлбэрлээ.

- Харин минийх тэгвэл үүнд чинь ойрхон байна! гэж Рон орилов.

- Тэгвэл яваач! Тэдэнд эргэж очоод тууралт чинь эдгэрсэн дүр үзүүлж ээжээрээ тэжээлгэ ...

Рон гэнэтхэн хөдөлгөөн хийхэд Харри хариу хөдөлсөн ч тэдний саваа халааснаас гарахаас урьтаж Гермиона өөрийнхийгөө өргөлөө.

- Протего! гэж тэр хашгираад дунд нь үл үзэгдэх бамбай бий болгоход хүчирхэг шившлэг тэднийг хэдэн алхам холдуулав. Уурсаж хилэгнэсэн Харри, Рон хоёр бие бие рүүгээ үл үзэгдэх саадыг нэвтлэн муухай харахад анх удаагаа тод харж байгаа юм шиг болов. Харрийн дотроос Роныг үзэн ядах сэтгэл хайрахад тэднийг холбож байсан зүйл үүрд хугарлаа.

- Крестражыг орхи гэж Харри хэлэв.

Рон толгойноосоо гинжийг авч зүүлтийг ойрын сандал дээр чулуудаад Гермиона руу эргэж,

- Чи яах гэж байна? гэлээ.

- Чи юуны тухай ярьж байна?

- Чи үлдэх гэж байгаа юмуу?

- Би гэж Гермиона зовж шаналан дуугараад,

- Тиймээ ... тийм үлдэнэ. Рон бид Харритай явж туслана гэж амласан шүү дээ ... гэлээ.

- Би чамайг түүнийг сонгож байгааг ойлгож байна.

- Үгүй, Рон ... гуйж байна ... битгий яваач, битгий яваач!

Гэвч Гермиона бамбай шидээ тайлж байх хооронд Рон хэдийн харанхуйд үсрэн гарчээ. Харри хөдөлгөөнгүй чимээгүй үлдээд түүнийг хэрхэн цурхиран мододын дунд Роны нэрийг дуудахыг сонслоо.

Хэдэн хормын дараа Гермиона норж нүүрэндээ наалдсан үстэй орж ирлээ.

- Тэр я-я-явчихлаа! Шилжчихсэн!

Тэр сандал дээр унаад атиралдан уйлав. Харриг мэгдэн зогсч байснаа крестраж руу бөхийн хүзүүндээ зүүлээ. Тэгээд Роны орон дээрх хөнжлийг авч Гермионаг хучив. Дараа нь өөрийнх дээрээ гараад харанхуй брежентэн адар өөд ширтэн бороо шаагих чимээг сонслоо.

БҮЛЭГ 16: ГОДРИКИЙН ХОНХОР

Маргааш өглөө нь Харри сэрээд өчигдөр юу болсныг санасангүй. Дараа нь энэ бүхэн зүүдлэгдсэн Рон урьдын адил байсан хэвээр хаашаа ч яваагүй гэсэн хүүхдийн найдлага төрөв. Гэвч толгойгоо эргүүлээд Роны хоосон орыг харлаа. Энэ нь үхсэн бие шиг харагдсан аятай нүдэнд туссан тул Харри орноосоо үсрэн буухдаа Роны ор луу харахгүй байхыг хичээлээ.

Гермиона хэдийн гал зууханд байсан бөгөөд Харриг орж ирэх үед өглөөний мэнд хүсэлгүй түргэхэн цааш харлаа. «Явчихаж» гэж Харри өөртөө давтлаа. «Явчихаж. Яваад эргэж ирэхгүй» гэж тэр нүүр гараа угаан хувцаслахдаа ганц л зүйлийн тухай бодлоо.

Энэ нь зайлшгүй жирийн үнэн байсан бөгөөд хэрвээ тэд байрлалаа солиход хүрвэл хамгаалалтын шившлэгээс болж Рон тэднийг олох боломжгүй болох ажээ.

Тэд өглөөний цайгаа чимээгүйхэн ууцгаав. Гермиоангийн нүд хавдаж улайсныг бодвол шөнөжингөө унтаагүй бололтой. Тэр юмаа цуглуулахдаа ердийнхөөс удаан хөдөлж байсан тул Харри голын эрэг дээрх байх хугацаагаа сунгахыг хүсч байгаа болохыг нь ойлгож байв. Түүнчлэн хэдэн удаа борооны чимээ алхаа шиг санагдсан бололтой толгойгоо огцом эргүүлж харсан ч мододын дунд шаргал дүрс байсангүй. Харри түүний араас дагуулан харах болгондоо (дотроо жаахан ч гэсэн найдахгүй байж чадсангүй) модны дунд зүсрэх бороноос өөр юу ч хараагүй тул уур хилэн нь дүрсхийв. Чихэнд нь Роны «Бид чамайг юу хийж байгаагаа мэднэ гэж бодсон!» гэсэн үг сонсогдоход хүндхэн зүрхтэйгээр юм хумаа үргэлжлүүлэн баглалаа.

Тэдний дэргэдэх шавартай гол үерлэн эргээ халих шахжээ. Тэд ердийнхөөсөө бүтэн цагийн турш саатав. Эцэст нь Гермиона гурав дахь удаагаа цүнхээ шалгаад цаашид байрандаа үлдэх шалтаг олж чадсангүй. Тэр Харрийн гараас хөтлөөд шилжин хонин арцаар хучигдсан салхитай толгод дээр гарч ирэв.

Гермиона шууд Харрийн гарыг орхиод цааш явснаа том чулуун дээр суугаад нүүрээ өвдгөндөө наан чичрэн уйллаа. Магадгүй түүнийг очиж тайвшируулах хэрэгтэй байсан ч Харри хөдөлж чадсангүй. Дотор нь бүх зүйл хөвчирч ахин Роны жигшүүртэй царайг харлаа. Тэр Гермионаг тойруулан арцан дундуур том алхалж ердийн хамгаалалтын шившлэгүүдээ босгов.

Дараагийн хэдэн өдөр тэд Роны тухай ярилцсангүй. Харри амьдралдаа ахин хэзээ ч түүний нэрийг дурсахгүй гэж хатуу шийдсэн ч Гермиона шөнө түүнийг унтсан гэж бодсон үедээ уйлж байх нь сонсогджээ. Тэр дасал болсон ёсоороо Тэнүүлчний газрын зургийг нээн шидэт савааны гэрэлд харлаа. Харри Хогвартсын хонгилд ахин Роны нэртэй цэг гарч ирэхийг хүлээж байсан бөгөөд энэ нь түүний тохьтой дулаан цамхагт цэвэр цусны хамгаалалтан дор очсоны баталгаа болох байлаа. Гэвч Рон зурган дээр гарч ирсэнгүй харин Жиннигийн нэр унтлагын өрөөнд хоёр охины хамт байхыг хараад баярлах сэтгэл төрлөө. Тэр гэнэтхэн ямар нэгэн аргаар түүнтэй уулзахыг хүсч бүх зүйл нь сайн гэдгийг мэдээсэй гэж хүслээ.

Тэд өдөр нь Гриффиндорын илд одоо хаана байгаа болон Дамблдор түүнийг хаана нуусан байж болох талаар ярилцсан ч ямар ч амжилт олсонгүй. Харри Дамблдор илдийг нууж болох газрын талаар дурссан эсэх талаар тархиа гашилгаж байв. Энэ үедээ Рон, Дамблдор хоёрын хэнд нь илүү уурлахаа мэдэхээ болих ажээ. «Бид чамайг юу хийж байгаагаа мэдэж байгаа гэж бодсон. Дамблдор чамд юу хийх ёстойг тайлбарласан гэж бодсон ... Бид чамд жинхэнэ төлөвлөгөө байгаа гэж бодсон!»

Түүнчлэн Роны зөв гэдгийг өөрөөсөө нуух аргагүй байлаа. Дамблдор түүнийг хоосон гартай үлдээжээ. Тэд нэг крестражыг олсон ч устгаж чадаагүй бөгөөд үлдсэн крестражуудын хувьд хаана байгаа нь мэдэгдэхгүй байсан хэвээр. Цөхрөл түүнийг баглан авахад найзуудаа итгэлтэйгээр хаашаа явж байгаа нь мэдэгдэхгүй утгагүй аялалд дагуулсан явдалдаа гайхлаа. Тэгтэл тэр юу ч мэдэхгүй бөгөөд цаашид яах талаараа өчүүхэн ч төсөөлөлгүй хором бүрд Гермионагийн хангалттай гэж хэлээд явахыг шаналан хүлээж байдаг.

Үдэш нь тэд бараг ярилцсангүй. Гермиона цүнхнээсээ Финеас Найжелусын хөргийг гаргаж ирээд Роны явсан орон зайг нөхөх юм шиг сандал дээр тавилаа. Тэрбээр ахин хэзээ ч ирэхгүй гэсэн ч Харриг хүсэлт тавихад эсэргүүцэж чадаагүй бөгөөд гарч ирэх тоолондоо нүдний боолттой болж байв. Харри түүний хорон даажинтай ч гэсэн ирж байгаа явдалд нь баярлалаа. Хэдийгээр тэд Хогвартсад юу болж байгаа тухай мэдээг шунахайран сонирхож байсан ч Финеас Найжелус үүнд тохирох мэдээлэгч байсангүй. Тэр Слизеринээс гарсан анхны захирал болох Снеггийг ихэд эрхэмлэж байсан тул Харри, Гермиона хоёр түүнийг шүүмжлэх юмуу хамаагүй асуулт тавьбал Найжелус даруйхан зургаа орхин алга болж байв.

Тэгсэн ч түүний ярианаас зарим зүйлийг мэдэх боломжтой байсан нь Снегг сурагчдын дэгдээсэн бослоготой нүүр тулгаран, Жинни Хогсмидэд зугаалах эрх нь хориглогджээ. Түүнчлэн Амбрижын хуучин тушаалыг эргэн сэргээж гурваас илүү сурагч хамтдаа цугларах юмуу сурагчдын ямар нэг бүлгэм дугуйлан ажиллахыг хориглосон байна.

Харри энэ бүхнээс үзэхэд Жинни, Полумна, Невилл нар Дамблдорын армийг үргэлжлүүлэхийг хичээж байна гэж дүгнэлээ. Энэ нь түүнд Жинниг харах хүчтэй хүслийг төрүүлэхийн зэрэгцээ Рон, Дамблдор болон Хогвартсыг санагалзан тэсэхийн аргагүй гуниглах сэтгэл төрүүлэв. Финеасын Снеггийн шийдвэртэй арга хэмжээний талаарх ярианаас Харри заримдаа сургуульдаа зүгээр л эргэж очоод бусдын хамт Снеггийн эсрэг тэмцэх ухаангүй хүсэл төрөх бөгөөд тэгвэл түүнд хоол унд, зөөлөн ор дэвсгэр зэрэг бусдын хувьд үнэгүй зүйл ч энэ агшинд хамгийн хүслэн болсон зүйл олдох байв. Гэвч номер нэг сэжигтэнээр зарлагдан толгойг нь арван мянган галлеоноор үнэлсэнийг санамагц одоо Хогвартст очих байтугай ид шидийн яамны хажуугаар өнгөрөхөд ч аюултай болжээ. Финеас Найжелус асуултанд хариулах үедээ санамсаргүй мэтээр хаана байгаагаа тодруулахыг хичээх бөгөөд ингэх болгонд нь Гермиона цүнхнийхээ гүнд хийж энэхүү бүдүүлэг салах ёсны дараагаар тэрбээр хэдэн өдөр ирэхээс татгалзах аж.

Цаг агаар муудаж улам хүйтрэхэд Харри, Гермиона хоёр нэг газраа удаан үдлэлгүй англий өмнөд хэсгийн бүс нутгаар нүүдэллэн явлаа. Тэд цас бороо холилдон орсон

шамарган дунд ууланд хоноглож, намгийн дунд хүйтэн усанд майхнаа барьж, шотландын нуурын дундах жижиг арал дээр хунгарлан орсон цасан дунд шөнийг өнгөрүүлж байв.

Байшингийн цонхнуудад зул сарын гацуур гялалзаж эхлэхэд Харри цорын ганц очоогүй газраа санал болгохоор зориглов. Тэд саяхан ер бусын амттай оройн хоолоо дуусаад байсан бөгөөд Гермиона үл үзэгдэх цув нөмрөн ойролцоох сүпермаркетад орж (мөнгөө шударгаар кассанд үлдээжээ) шпаггетиний гоймон, лаазалсан лийр авчирчээ. Түүнчлэн Харри хэдэн цагийн өмнө крестражаа тайлсан нь одоо орон дээр хэвтэж байлаа.

- Гермиона?

- М-м?

Тэр сандал дээр суугаад гартаа «Бидл Бардын үлгэрүүд»-ийг барьжээ. Түүнчлэн харваас ямар нэг зүйлийн учрыг тайлах гэж оролдож байгаа бололтой «Шидтэний дүрс үсгийн тайлал» гэсэн ном сандлын түшлэг дээр нээлттэй хэвтэж байсан учир Харри түүнийг номноос нь хэрхэн холдуулахаа төсөөлж чадсангүй.

Харри хоолой засан ханиалгахад хэдэн жилийн өмнө профессор МакГонагаллаас

Хогсмид явах зөвшөөрөл гуйхаар асуухдаа ийм зүйл мэдэрч байсан нь санаанд оров.

- Гермиона би бодлоо л доо ...

- Харри чи надад туслаж чадахгүй биз?

Тэр харваас түүнийг сонссонгүй бололтой урагш бөхийгөөд «Бидл Бардын үлгэрүүд»-ээ сунгаснаа,

- Энэ тэмдэгийг хараач гээд хуудасны дээд тал руу хуруугаараа заалаа.

Үлгэрийн гарчиган дээр гурвалжин нүдтэй адил зураг байсан бөгөөд дундуур нь босоо шугам татжээ.

- Гермиона би хэзээ ч эртний дүрс тэмдэг судалж байгаагүй.

- Энэ бол эртний дүрс тэмдэг биш дүрс үсгийн тайлалд байхгүй байсан. Би үүнийг жирийн нэг нүдний зураг гэж бодохгүй байна! Харж байна уу хэн нэгэн түүнийг ном бэлэн болсон хойно бэхээр зурсан байгаа биз дээ. Чи урьд нь үүнийг хаа нэгтээ харсан эсэхээ сана даа?

- Үгүй дээ ... үгүй ээ, хүлээгээрэй! гээд Харри ойртон харснаа,

- Энэ чинь Полумнагийн эцгийн хүзүүнд байсан зүүлттэй ижил тэмдэг биш үү?

гэв.

- Би ч гэсэн тэгж бодсон юм!

- Энэ чинь Гриндевалдын тэмдэг байна. Гермиона түүн рүү амаа ангайн харлаа.

- Юу гэнээ?

- Крам надад тэгж хэлсэн юм ...

Харри Виктор Крам Билл, Флер хоёрын хуриман дээр ярьсан зүйлийг ярихад Гермиона гайхан мэгджээ.

- Гриндевалдын бэлэгг тэмдэг гэнээ?

Тэр Харри руу харснаа нууцлаг тэмдэг рүү ахин харлаа.

- Гриндевальдад онцгой бэлэг тэмдэг байсан гэж сонсож байгаагүй юм байна.

Нэг ч номон дээр энэ тухай дурсаагүй байсан.

- Гэхдээ би хэлсэн биз дээ. Крам энэ тэмдэгийг Гриндевальд Дурмстрангийн ханан дээр сийлбэрлэн орхисон байсан гэж хэлсэн.

Гермиона хөмсөг зангидан хойшоо наллаа.

- Ямар хачирхалтай юм бэ. Хэрвээ энэ тэмдэг хар шидийнх юм бол хүүхдийн үлгэрийн номон дээр юу хийж байгаа юм бол?

- Тийм шүү хачирхалтай хэрэг гэж Харри зөвшөөрөөд,

- Скримжер түүнийг мэдэх ёстой байсан. Тэр сайд болохоосоо өмнө хар урлагийн мэргэжилтэн байсан биз дээ гэв.

- Мэдэж байна ... Магадгүй тэр үүнийг жирийн нүд гэж бодсон юм болов уу?

Бусад үлгэрүүдийн дээр ч гэсэн жижигхэн зураг нь байсан.

Тэр чимээгүй болоод ойлгомжгүй тэмдэг рүү харав. Харри ахин нэг оролдлого хийлээ.

- Гермиона!

- М-м?

- Би бодлоо л доо ... Годрикийн хонхорт очдог юмуу гэж.

Гермиона түүн рүү төвлөрөөгүй харцаар харсанаа харваас нууцлаг тэмдэгийнхээ тухай бодож байгаа бололтой.

- Тиймээ. Би бас энэ тухай бодсон. Би ч бас тэгж бодож байна.

- Чи миний хэлснийг сонссон уу?

- Тэгэлгүй яахав. Чи Годрикийн хонхорт очихыг хүсч байна гэсэн. Би чиний хэлснийг зөвшөөрч байна. Түүнээс өөр хаана байж болохыг нь төсөөлөхгүй юм. Энэ бол эрсдэлтэй аюултай хэрэг хэдий ч тэнд л байгаа байх.

- Э-э ... тэнд гэдэг чинь юу юм? гэж Харри гайхлаа. Гермиона түүн рүү үл итгэн харлаа.

- Илд л байхгүй юу, Харри! Дамблдор чамайг тийшээ эргэж очихыг хүснэ гэж мэдэж байсан байх. Бас Годрик Гриффиндор тэнд төрсөн шүү дээ ...

- Үнэн үү? Гриффиндор Годрикийн хонхорт төрсөн юм уу?

- Харри чи хэзээ ч «Ид шидийн түүх»-ийг уншиж байгаагүй юм уу?

- Э-э-э ... гээд тэр сүүлчийн сард анх удаагаа инээмсэглэн,

- Магадгүй худалдаж авах үедээ л онгойлгосон байх ... гэв.

- Тэгвэл тосгоныг түүний нэрээр нэрлэсэн гэдгийг таварлах ёстой байсан юм гэж Гермиона ширүүн хэлэхэд Харри түүнийг одоохон номын сангаа ухаж эхлэх байх гэж бодлоо.

- Хүлээж байгаарай тосгоны тухай «Ид шидийн түүх»-энд дурьдсан байсан ...

Тэр цүнхээ нээж онгичсоноо эцэст нь сургуулийн хуучин сурах бичиг болох

Батильда Бэгшотын «Ид шидийн түүх»-ийг гаргаж ирээд хэрэгтэй хуудсаа нээлээ.

- 1689 онд олон улсын нууцлалын холбоо байгуулагдсаны дараа шидтэнгүүд амьдралаа нууцлах болжээ. Энэ нь дотроо жижигхэн нийгмийн байгуулал шиг байлаа. Багахан гацаа сууринд шидэтний хэд хэдэн гэр бүлүүд нэгдэн амьдрах бөгөөд харилцан бие биеэ хамгаалж дэмжиж байв. Тэдгээр нь Тинворт, Корнуолле, Аппер-Флежли, Йоркшир, Оттери-Сент–Кэчуол зэрэг английн өмнөд эргийн алдартай суурин гацаанууд байсан бөгөөд шидтэний гэр бүлүүд маглуудтай хаяа дэрлэн амьдарч байлаа. Тийм хагас шидийн тосгонуудын нэгд баруун өмнөд хэсэгт орших Годрикийн хонхор гарцаагүй багтах болно. Энд алдарт шидтэн Годрик Гриффиндор болон анхны алтан снитчийг зохиосон Боумен Райт төржээ. Түүнчлэн олон зуун жилийн өмнө баригдсан жижиг сүмийн ардах нутгийн оршуулгын газарт эртний шидтэний гэр бүлийн нэрс болон хий үзэгдлүүдийг олж харах боломжтой.

- Профессор Бэгшот зөвхөн арван есдүгээр зууны эцэс үеийг бичсэн болохоор чи болон эцэг эх чинь дурьдагдаагүй байна гээд Гермиона номоо хааж,

- Чи харж байна уу? Годрикийн хонхор, Годрик Гриффиндор, Гриффиндорын илд гээд л ... Магадгүй Дамблдор чамайг энэ холбоог тааварлахыг хүлээж байсан юм болов уу? гэв.

- Өө, тийм л дээ ...

Харри Годрикийн хонхор луу очихоор санал болгохдоо илдний тухай бодоогүй гэдгээ хүлээн зөвшөөрөхийг хүссэнгүй. Түүнийг тосгон руу өөр зүйл болох эцэг эхийнх нь булш, азаар үхлээс аврагдсан байшин болон Батильда Бэгшот татаж байлаа.

- Мюриэль юу гэж хэлснийг санаж байна уу? гэж тэр эцэст нь асуулаа.

- Хэн гэнээ?

- Чи мэднэ дээ ... гээд Харри Роны нэрийг дурсахыг хүссэнгүй,

- Жиннигийн хамаатны эмээ. Чамайг ясархаг шагайтай гэж хэлсэн гэв.

- А-а ...

Энэ нь сэтгэл өвтгөм агшин байсан тул Харри түүний Роны нэрийг санасныг мэдээд яаран,

- Мюриэль Батильда Бэгшотыг одоо хүртэл Годрикийн хонхорт амьдарч байгаа гэж хэлсэн гэв.

- Батильда Бэгшот гэж Гермиона бувтнаад хуруугаа «Ид шидийн түүх»-ийн хавтсан дээр байсан Батильдагийн нэрэн дээгүүр гүйлгэснээ,

- Юу гэвэл ... гэв.

Тэр гэнэтхэн дуу алдахад Харрийн дотор хөрвөх шиг болж саваагаа бариад үүд рүү огцом эргэж харсан ч тэнд юу ч байсангүй.

- Яасан? гэж тэр уурлахын зэрэгцээ санаа амран хэлээд,

- Ахиж битгий ингээрэй! Би майханд Үхэл залгигчид орж ирсэн юм байх гэж бодлоо гэв.

- Хэрвээ Батильдад илд байвал яах вэ, Харри? Хэрвээ Дамблдор түүнд хадгалуулахаар өгсөн бол?

Харри боломжыг эрэгцүүлэв. Батильда одоо их хөгширч хэрвээ Мюриэлийн үгэнд итгэх аваас зөнөсөн байдаг. Дамблдор түүнд үнэхээр шидэт илдийг итгэж өгөх байсан гэж үү дээ? Хэрвээ тийм бол хэтэрхий тохиолдлын зүйл биш гэж үү? Дамблдор Харрид илдийг хуурамчаар сольсон тухайгаа болон Батильдатай нөхөрлөдөг байсан тухайгаа нэг ч үг дурсаагүй. Гэсэн ч одоо Гермионагийн онолд эргэлзэж байх цаг биш байлаа.

- Аанхан өгсөн байж болох юм! Тэгвэл Годрикийн хонхор луу явцгаах уу?

- Тиймээ, зөвхөн бүгдийг сайн бодох хэрэгтэй байна.

Гермиона харваас ахин төлөвлөгөө зохиож байгаа бололтой цэхлэн суулаа.

- Нэгдүгээрт гэвэл үл үзэгдэх цувны дор хамт шилжиж Хувиргах шид юмуу эсвэл Хувиргагч уусмал хэрэглэж болох юм? Тэгвэл хэн нэгний үс хэрэгтэй болно. Харри бид үүнийг жинхэнээсээ хийх гэж байгаа бол зүсээ маш сайн хувиргах хэрэгтэй ...

Харри яриаг нь тасалсангүй зөвшөөрч буй дүр үзүүлэн толгой дохисон ч ухаан бодол нь алсад байлаа. Түүнд Гринготтсд хуурамч илд хадгалагдаж байгаа гэдгийг мэдсэнээс хойш анх удаагаа баярлах сэтгэл төрөв.

Удахгүй гэр бүлийнхээ амьдарч байсан байшинд эргэж очих нь байна. Хэрвээ Волдеморт байгаагүй бол тэр Годрикийн хонхорт өсөн торниж амралтаа өнгөрүүлж болох байлаа. Зуны амралтаар найз нөхдөө гэртээ зочлохоор урьж болох байсан ... Түүнд эрэгтэй эмгэтэй дүү байж болох байлаа ... Арван долоон насны баярын бялууг нь өөр хэн нэгэн биш ээж нь хийх байсан ... Түүний амьдрал хэзээ ч тийм одооных шиг бодит санагдаж байсангүй. Үдэш нь Гермиона унтахаар хэвтэхэд Харри цүнхнээс нь үүргэвчээ аяархан аваад Хагридын олон жилийн өмнө бэлэглэсэн гэрэл зургийн цомгийг гаргаж ирлээ. Тэр ээж аавынхаа гар даллан инээмсэглэх хуучин гэрэл зургийг хэдэн сарын турш харсангүй. Харрид тэднээс үүнээс өөр юу ч үлдээгүй билээ.

Харри маргааш Годрикийн хонхорт очихдоо баяртай байсан ч Гермиона өөрөөр бодож байв. Тэр Волдеморт Харриг эцэг эхийнхээ үхсэн газар эргэж очино гэдэгт эргэлзээгүй гэдэгт итгэлтэй байсан тул зүсээ хувиргахад нямбайлан бэлтгэв. Тэд бүтэн долоо хоногийн турш үл үзэгдэх цувтай шилжиж нууцаар зул сарын худалдаа хийж буй юу ч сэжиглээгүй маглуудаас үс сугалан авсан хойно л Гермиона тийшээ очихыг зөвшөөрчээ.

Тэд Годрикийн хонхорт харанхуй нөмрөхтэй зэрэгцэн очихоор Хувиргагч уусмалаа уухад Харри халзан толгойтой хижээл насны магл болон хувирсан бол харин Гермиона түүний туранхай хулганатай төстэй эхнэр болон хувирлаа. Тэр цүнхэндээ бүх зүйлээ хийж (крестражыг Харри хүзүүндээ зүүжээ) пальтоныхоо дотор халаасандаа хийгээд товчоо товчилжээ. Харри хоёр биенээ үл үзэгдэх цуваар нөмөргөтөл танил дотор агшсан мэдрэмж төрөв.

Тэгээд зүрхээ хүндээр цохилохыг мэдэрсээр нүдээ нээхэд Гермионагийн хамт гараасаа бариад цастай зам дээр зогсож байв. Харанхуй хөх тэнгэрт анхны одод сулхан гялалзана. Давчуу гудамжинд зул сарын чимэглэлээ зүүсэн байшингууд эгнэжээ. Тэдний өмнөх замыг тосгоны төв талбай дахь гудамжны дэнлүүний алтлаг гэрэл сулхан гийгүүлнэ.

- Ямар их цас вэ! гэж Гермиона цуван дор шивнээд,

- Бид яагаад үүнийг бодсонгүй вэ? Зүсээ хувиргахад ингэж их бэлдчихээд одоо мөр үлдээх болж байдаг! Бид үүнээс салах хэрэгтэй ... Би арилгах болохоор чи түрүүлж яв гэв.

Харри тосгон руу жүжгийн морь шиг явах болсондоо инээмсэглэсэнгүй бөгөөд мөр устгахтай зэрэгцэн нөмрөгөн дороос цухуйхгүй байхыг хичээв.

- Алив цуваа тайлцгаая гэж Харри санал болгоод Гермиона айсан янзтай харагдахад,

- Өө алив л дээ, биднийг хараад таних хүн эргэн тойронд хэн ч алга гэв.

Тэр цуваа хүрэмнийхээ энгэртээ хийгээд урагшаа явахад хүйтэн агаар нүүр хорсгов. Тэд Лили, Жеймс хоёрын амьдарч байсан болон түүнчлэн одоо Батильда амьдарч байж болох байшингуудын дэргэдүүр өнгөрлөө. Харри үүдний хаалга болон дээвэр дээр тогтсоны цасыг харж санахыг хичээж байсан ч тэгэхэд ердөө ойтой байсан болохоор энэ нь боломжгүй хэрэг байв. Тэр хуучин байшингаа байгаа гэдэгт ч итгэлтэй байсангүй. Итгэлийн шид сулран хүмүүсийн үхлийн дараа юу болсныг мэдэхгүй байв. Гэнэтхэн нарийхан зөрөг зам зүүн тийш эргэхэд Харри, Гермиона хоёр тосгоны жижигхэн талбай руу оролоо.

Талбайн эргэн тойронд цэцгэн хэлхээ, өнгө бүрийн гэрлээр чимэглэж төвд нь дайны дурсгалын хөшөө салхинд бөхийсөн зул сарын гацуур адил дүнхийжээ. Тэнд хэд хэдэн дэлгүүр, шуудан, уушийн газар байсан бөгөөд алсын буланд нь үнэт чулуу шиг гэрэлтсэн цонхтой жижигхэн сүм байлаа.

Хөл дорх цас өдөржингөө хүмүүс явсаар байгаад гулгамтгай болжээ. Талбай дээгүүр тосгоны оршин суугчид яаран явах нь дэнлүүний гэрэлд зурсхийнэ. Уушийн газрын

үүд нээгдэхэд хөгжим инээд хадаж, жижигхэн сүмийн дотроос зул сарын найрал дуу сонсогдов.

- Харри өнөөдөр чинь зул сарын өмнөх өдөр байна шүү дээ! гэж Гермиона дуу алдлаа.

- Тийм гэж үү?

Тэд хэдэн долоо хоногийн турш сонин уншаагүй болохоор Харри цаг хугацааны баримжаагаа алджээ.

- Яг тийм гээд Гермиона сүмийн зүг харж,

- Тэд ... тэд тэнд байгаа байх даа? Чиний ээж аав ... сүмийн цаад талд оршуулгын газар байна гэв.

Харрид баяр хөөрөөс илүү айдастай төстэй мэдрэмж төрлөө. Байндаа тэгж их ойртсон байтал тэдний булшыг харахыг хүсч байгаа гэдэгтээ итгэлтэй байсангүй. Гермиона харваас түүний юу мэдэрснийг мэдсэн бололтой гараас нь хөтөлж урагш явлаа. Талбайн дунд тэр гэнэтхэн зогсов.

- Харри, хараач!

Тэр дайны дурсгалын хөшөө рүү заажээ. Тэднийг дэргэдүүр нь өнгөрөхөд хөшөө хувирч арзгар үстэй нүдний шилтэй эрэгтэй, урт үстэй эмэгтэй, ээжийнхээ гарт тэврүүлсэн хүүхэд гурвын дурсгал болжээ. Гурвуулангийх нь толгой дээр цас малгай шиг лавсан дарсан байв.

Харри ойртож очоод эцэг эхийнхээ царайг харлаа. Тэр хэзээ ч ийм дурсгал байна гэж төсөөлж байсангүй ... Өөрийнхөө чулуун дүрсийг харах нь туйлын хачирхалтай хэрэг байлаа. Аз жаргалтай хөгжилтэй духан дэрээ сорвигүй хүү ...

- Явъя гэж Харри бувтнаад ахин сүмийн зүг эргэв.

Зам гараад Харри эргэж харахад хөшөө ахин дайны дурсгал болж хувирсан байв. Сүмд ойртох тусам найрал дуу чангарлаа. Харрид энэ нь Хогвартсыг санагдуулахад

хоолой нь зангирав. Пивз хоосон дуулганы дотор нуугдаад зул сарын баярын

зохиосон дуугаа дуулж, Их танхимд зул сарын арван хоёр гацуур чимэглэгдээд, Дамблдор цаасан буу гаргасан цэцэгтэй малгай өмсөж, Рон гараар нэхсэн цамцтай ...

Тэд оршуулгын газрын өмнөх давчуу хаалга руу ирлээ. Гермиона чимээгүй онгойлгоод Харрийн хамтаар дотогш оров. Замын хоёр хажуугаар хүний хөлд гишгэгдээгүй цас хөвсийнө. Харри, Гермиона хоёр том дугуй барилгын гадуур явахдаа хурц гэрэлтэй цонхны сүүдрээр явахыг хичээв.

Сүмийн ард талын цастай булшны чулууны эгнээг цонхны цэнхэр, улаан, алтлаг ногоон оч туяаран гийгүүлнэ. Харри халаасан дахь саваагаа чанга атгаад ойролцоох булш руу очлоо.

- Хараач энд ямар нэг Аббот байна ... магадгүй Ханнагийн хамаатан байх!

- Аяархан ярь! гэж Гермиона гуйлаа.

Тэр оршуулгын газрын дундуур цааш явахдаа хуучин булшин дээрх бичээсийг харж харанхуйд хэн нэгэн дагаж байна уу гэж шалгаж байлаа.

- Харри, ийшээ!

Гермиона түүнээс хоёр эгнээний цаана байв. Харри цасанд бүдэчсээр түүн рүү очихдоо зүрх нь хүчтэй цохилов.

- Тэд үү?

- Үгүй ээ, чи өөрөө хар!

Тэр хар чулуу руу зааж байв. Харри бөхийгөөд хөлдүү боржин чулуун дээр «Кендра Дамблдор»-ын нас барсан өдөр сарынх нь бичээс болон арай доохон талд «түүний охин Ариана» гэж бичсэнийг харлаа. Бас чулуун дээр иш татсан үг байв.

Сэтгэл зүрх чинь байгаа газар чиний эрдэнэс бий.

Тэгэхээр Рита Скитер болон Мюриэлийн хэлсэн үгс үнэн байж. Дамблдор үнэхээр энд амьдарч байсан бөгөөд хэд хэдэн төрөл төрөгсөд нь үхжээ.

Булшийг нь өөрийн нүдээр харах нь бусдаас сонсохоос долоон дор хэрэг байлаа. Харри Дамблдор энэ оршуулгын газар болон холбоосныхоо тухай хэлээгүй талаар бодов. Тэд хамтдаа ийшээ ирж төрөл төрөгсдийнхөө булшыг эргэж болох байлаа. Тэр гэнэтхэн Дамблдорын хамт ийшээ хоёулхнаа ирж байна гэж төсөөлөв. Энэ тэднийг нэгтгэх байсан нь Харрийн хувьд хичнээн чухал хэрэг байв! Гэхдээ Дамблдорт харваас ойр дотны хүмүүс нь нэг оршуулгын газарт байх нь ямар ч сэтгэгдэл төрүүлээгүй бололтой ямар ч үүнтэй холбоотой даалгавар өгсөнгүй.

Гермиона Харри руу харахад царай нь сүүдэрт байгаадаа баярлав. Тэд ахин нэг удаа булшин дээрхэ бичээсийг уншив. Сэтгэл зүрх чинь байгаа газар чиний эрдэнэс бий. Тэр энэ үг юу илтгэж байгааг ойлгож чадсангүй. Магадгүй Дамблдор үүнийг эхийнхээ үхлийн дараа гэр бүлийнхээ тэргүүн болон үлдсэн хойноо зохиосон байх.

- Түүнийг энэ тухай юу ч дурсаагүй гэдэгт чи итгэлтэй байна уу ... гэж

Гермиона эхлэв.

- Үгүй. Алив цааш нь эрцгээе гээд Харри эргэхдээ чулууг харсандаа харамслаа.

Сэтгэл шимширч хором бүр улам таагүй боллоо. Дараа нь Гермиона харанхуйгаас дуудав.

- Ийшээ! Өө үгүй, уучлаарай. Надад энд Поттер гэсэн нэр харагдах шиг санагдсан юм.

Тэр хөвдтэй чулууны цасыг арилгаад хөмсөг зангидан харлаа.

- Харри түр хүлээгээрэй.

Тэр ахин ашиггүй зүйлд сатаарахыг хүсээгүй болохоор таагүй байлаа.

- Яасан?

- Үүнийг хараач!

Булш маш эртний байсан тул Харри арай ядан нэрийг ялгаж уншив. Гермиона түүний дээхэн талд байх дүрс тэмдгийг заалаа.

- Харри энэ номон дээр байсан тэмдэг байна!

Харри түүний заасан газар луу ойртон харахад чулуун дээр үнэхээр гурвалжинтай төстэй тэмдэг сийлсэн байсан хэдий ч нэр нь гаргагдсангүй.

- Тиймээ ... болох л юм ...

Гермиона сабааныхаа үзүүрээс гэрэл асаагаад булшин дээрх нэрийг гэрэлтүүлэв.

- Тэнд Иг ... Игнотус гэж бичсэн байх шиг байна.

- Би явж эцэг эхээ хайлаа, за юу? гэж Харри хэлээд цааш явахад Гермиона хуучин булш руу тонгойсоор үлдэв.

Түүнд Абботын овог шиг Хогвартсын танил овгууд алхам бүрд тааралдаж байлаа. Заримдаа нэг гэр бүлийн эгнээ үргэлжлэх бөгөөд өөр хүнийх гарч ирэх хүртэл нас барсан өдөр сараар нь Годрикийн хонхорт ирсэн юмуу явсан хугацааг тааварлаж болох аж. Тэр оршуулгын газрын улам гүнд орон явсаар ээлжит булшинд ойртох болгонд дотор нь эмээх сэтгэл төрж байв.

Харанхуй нам гүм улам гүнзгийрлээ. Харри эргэн тойрноо харж Дементоруудын тухай бодсон ч сүмийн найрал дуу дуусаад алсад тосгоны талбай дээр байгаа хүмүүсийн хоолой сулхан цуурайтахыг сонсов. Хэн нэгэн сүмийн гэрлийг унтраажээ.

Тэгтэл харанхуйд гурав дахь удаагаа Гермионагийн дуу сонсогдлоо.

- Харри тэд энд байна ... бараг дэргэд нь байж.

Харри түүний хоолойны өнгөнөөс энэ удаад эцэг эх нь болохыг ойлгов. Тэр ойртож очиход цээжинд нь ямар нэг зүйл зангирах шиг болон Дамблдорыг үхсэнийх дараах шиг гашуудал зүрхийг нь хүндээр дарлаа.

Булш Кендра, Ариана хоёроос ердөө хоёр эгнээний цаана байсан бөгөөд Дамблдорынхны адил цагаан гантигаар хийсэн нь харанхуйд гэрэлтэж уншихад хялбархан байв. Харри ойртон чулуун дээр сийлсэн бичигийг уншлаа.

ЖЕЙМС ПОТТЕР. 1960 оны гурван сарын 27 – 1981 оны арван сарын 31

ЛИЛИ ПОТТЕР. 1960 нэг сарын 30 – 1981 оны арван сарын 31

Сүүлчийн дайснаа үхэх хүртэл.

Харри удаанаар уншаад юу бичсэнийг ойлгосонгүй тул сүүлчийн үгийг чанга хэллээ.

- «Сүүлчийн дайснаа үхэх хүртэл ...» Энэ нь түүнд хүйт даасан аймшигтай бодол төрүүлэв. Энэ чинь Үхэл залгигчдын уриа бишүү! Яагаад энд байгаа юм бол?

- Үхэл залгигчдынх гэдэгтээ байгаа юм биш, Харри. Энэ бол ... чи мэднэ дээ ... үхлийн дараах амьдрал гэж Гермиона аяархан хэлэв.

«Гэхдээ тэд амьд биш. Байхгүй болсон» гэж Харри бодлоо. Хоосон үг юу ч өөрчилж чадахгүй бөгөөд эцэг эх нь энд цастай чулуун дор хэвтээд хайхрамжгүй юу ч

мэдэхгүй байгаа. Гэнэтхэн тогтоон дийлэхийн арга нулимс цийлэгнэж хацрыг нь даган халуу оргиулан урсахад арчиж чадсангүй. Харри уруулаа чанга жимийгээд Лили, Жеймс хоёрын сүүлчийн тайвширалыг олсон газар болох цас руу харлаа. Тэднээс одоо зөвхөн яс, хумхийн тоос үлдээд юунд ч санаа зовохгүй амьд үлдсэн хүү нь ийм ойрхон зогсож байгааг мэдэхгүй байгаа. Түүний зүрх талархал дүүрэн сэтгэлээр цохилоход тэдний хамт цасан дор хэвтэж байгаагүйдээ харамслаа.

Гермиона гараас нь чанга атгалаа. Тэр түүн рүү харж чадсангүй зөвхөн гарыг нь хариу атгаад шөнийн агаарыг чимээтэй амьсгалан бүх хүчээ гарган биеэ эзэмдэхийг хичээв. Ийшээ ямар нэг зүйл авчрах талаар санаанд нь орсонгүй тул оршуулгын газар зөвхөн хөлдсөн мөчир байлаа. Гэвч Гермиона шидэт саваагаа гаргаж ирээд агаарт тойрог зуран зул сарын цэцгэн хэлхээ гаргаж ирэв. Харри түүнийг авч эцэг эхийнхээ булшин дээр тавилаа.

Босов уу үгүй юу эндээс явах хүсэл төрөв. Тэр ахин нэг ч хором энд тэсэж чадсангүй. Харри гараа Гермионагийн мөрөн дээр тавиад тэр бүсэлхийгээр нь тэвэрч хоёул чимээгүйхэн эргээд цасан дээгүүр Дамблдорын ээж, дүүгийнх нь булшны дэргэдүүр өнгөрч харанхуй жижигхэн сүмийн давчуу хаалга руу явлаа.

БҮЛЭГ 17: БАТИЛЬДАГИЙН НУУЦ

- Харри, зогс!

- Юу болоо вэ?

Тэд дөнгөж сая үл мэдэгдэх Абботын булшны дэргэдүүр өнгөрчээ.

- Тэнд хэн нэгэн байна! Биднийг хараад байгааг нь мэдэрч байна. Тэнд бутны хажууд.

Тэд гар гараасаа барин байрандаа хөшөөд харанхуй оршуулгын газар луу харлаа. Харрид юу ч ялгаж чадсангүй.

- Чи итгэлтэй байна уу?

- Би тэнд нэг юм хөдлөхийг харсан. Амалсан ч болно ... гээд Гермиона гараа тавиад шидэт саваагаа авлаа.

- Бид чинь маглууд шүү дээ гэж гэж Харри түүнд сануулав.

- Аанхан маглууд дөнгөж сая чиний эцэг эхийн булшинд цэцэг өргөлөө! Харри, тэнд үнэхээр хэн нэгэн байна!

Харри «Ид шидийн түүх»-нд оршуулгын газарт хий үзэгдлүүд байдаг гэж бичсэн байсныг саналаа. Хэрвээ ... Тэгтэл шаржигнах чимээ сонсогдож Гермионагийн заасан бутны мөчрийн цас сэгсрэгдэв. Хий үзэгдэл ингэж чадахгүй.

- Муур юмуу шувуу байна гэж Харри хэсэг хүлээсний эцэст шийдлээ. Хэрвээ тэнд үхэл Залгигчид байсан бол бид хэдийн үхсэн байгаа. Эндээс холдоод үл үзэгдэх цуваа нөмөрцгөөе.

Тэд оршуулгын газраас гарахдаа олон дахин эргэж харлаа. Харри үнэн хэрэгтээ Гермионаг тайвшируулахаар өөдрөг сэтгэлтэй байгаагүй болохоор гулгамтай явган хүний зам дээр хүрсэн явдалдаа баяртай байлаа. Тэд ахин цуваа нөмрөв. Уушийн газарт сүмд дуулж байсан хүмүүс цуглараад урьдынхаас их хүнтэй болжээ. Харри тэнд нуугддаг юмуу гэж бодоод хэлэх гэсэн ч Гермиона «Ийшээ» гэж шивнээд тосгон руу орж ирснийх нь эсрэг талын харанхуй гудамж руу хөтлөв. Тэд алхаагаа түргэсгэлээ. Байшингийн цонхоор өнгө бүрийн гэрэл гялалзаж хөшигний завсраар зул сарын гацуурын мод харагдана.

- Батильдагийн байшинг яаж олох вэ? гээд Гермиона үл мэдэг чичирснээ эргэн тойрноо харж,

- Харри, чи юу гэж бодож байна? Харри! гэлээ.

Тэр гараас нь угзарсан ч Харри сонссонгүй. Тэр байшингуудын эгнээний төгсгөлийн том хар дүрснээс нүд салгасангүй. Тэгснээ гэнэтхэн Гермионаг чирэн ухасхийтэл мөсөн дээр хальтирлаа.

- Харри ...

- Хараач... Гермиона, хараач ...

- Би юу ч ... өө!

Харваас Итгэлцлийн шид Лили, Жеймс хоёрын хамт бөхжээ. Арван зургаан жилийн өмнө Хагрид жижигхэн Харриг нурангин дундаас гарган авсан тэр өдрөөс хойш таримал бургасан хашаа өндөрсөж бүсэлхий хүртэл өвс ургасан байлаа. Байшингийн ихэнх хэсэг хар ороонго ургамалд хучигдан дээд давхарын баруун хэсэг нурсан байсан тул Харри тэнд л хараал эргэж үйлчилсэн гэдэгт итгэлтэй байв. Тэр Гермионагийн хамт зогсоод эвдэрхий байшин руу харахад хөрш байшингуудаасаа ялгагдсангүй.

- Яагаадтүүнийг эргэн сэргээгээгүйг ойлгохгүй байна? гэж Гермиона шивнэлээ.

- Магадгүй барьж болохгүй юм болов уу? Магадгүй хар шидийн улмаас сүйрсэн болохоор засч болохгүй ч юм билүү.

Тэр үл үзэгдэх цуван дороосоо гараа гаргаад зэвэнд хучигдсан төмөр хаалганд хүрлээ.

- Чи дотогш орох гээ юу? Энэ аюултай байхаа ... өө, Харри хараач!

Түүнийг хаалганд хүрмэгц шид үйлчилсэн бололтой. Тэдний урд талын хогийн өвсөн дундаас хачирхалтай цэцэг ургах мэт болж модон самбар дээр алтан үсэг бичигдэв.

Энэ газар 1981 оны арван сарын 31-ны шөнө Лили, Жеймс Поттер хоёр алагдаж тэдний хүү Харри шидэт ертөнцөд үхлийн шившлэгээс амь мултарсан цорын ганц хүн болсон юм.

Энэ байшин маглуудад үзэгдэхгүй бөгөөд сүйрсэн хэсэг нь Поттерынхны дурсгалд зориулан гэр бүлийг салгасан хэрцгий явдлыг сануулан үлдсэн болно.

Самбарын эргэн тойронд амьд үлдсэн хүүгийн байшинг харахаар ирсэн олон тооны шидтэнгүүдийн сараачин бичсэн үгс байлаа. Зарим нэг нь мөнхийн бэхээр бичиж, өөр нэгэн нэрийн эхний үсгээ тавьж олонхи нь зурвас үлдээжээ. Тэдгээр дурсгал хурцаар гялалзаж байлаа.

Чи хаана ч байсан гэсэн амжилт хүсье, Харри.

Хэрвээ чи үүнийг уншиж байгаа бол бид чамтай хамт шүү, Харри! Сайн байна уу, Харри Поттер!

- Тэд самбар дээр бичиж болохгүй байсан юм! гэж Гермиона уурслаа. Гэсэн ч Харри баясан гийлээ.

- Энэ чинь сайхан хэрэг шүү дээ! Надад тэдний ингэж бичсэн нь таалагдаж байна. Би ...

Тэр огцом чимээгүй боллоо. Тэдний зүг том бигнэсэн дүрс хазганасаар ойртож ирэхэд сүүдэр нь тосгоны төв талбайн дэнлүүний гэрэлд гялсхийв. Хэлэхэд хэцүү

хэдий ч энэ нь эмэгтэй хүн бололтой. Тэр удаанаар цасан дээр гулгаж унахаас айсан мэт явна. Бөгтөр нуруу, нүсэр бие, хөлөө чирч байгаагаас нь үзэхэд их хөгшин хүн

байлаа. Харри, Гермиона хоёр чимээгүйхэн зогсоод дэргэдүүрээ өнгөрөхийг хүлээв. Харри хөгшин ямар нэг байшин руу эргээд орох нь гэж бодсон ч зөнгөөрөө ингэхгүй болохыг нь мэдэж байлаа. Хөгшин замын дунд тэднээс хэдхэн алхамын зайд зогсов.

Түүнд Гермионагийн гарыг чимхэх хэрэг ч байсангүй хөгшин магл биш гэдэг нь ойлгомжтой байв. Тэр шидтэнгүүдээс өөр хүнд үзэгдэхгүй байшингийн урд зогсоод харлаа. Гэхдээ тэр шидтэн байсан ч өвлийн шөнө зөвхөн сүйрсэн байшин сонирхохын тулд гарч ирсэн гэдэг нь хачирхалтай санагдана. Түүнчлэн шидийн бүхий л хуулиар бол Гермиона тэр хоёрыг олж харж чадахааргүй байв. Гэсэн ч Харрид үл таних хүн тэднийг энд байна гэдгийг мэдэж байна гэсэн тайлбарлаж боломжгүй мэдрэмж төржээ. Энэ түгшүүртэй бодол тархинд нь зурсхийх агшинд эмгэн бээлийтэй гараа өргөн түүнийг дуудлаа.

Гермиона цуван дор түүнд чанга наалдлаа.

- Тэр хаанаас мэдсэн юм бол?

Харри толгой сэгсэрлээ. Хөгшин ахин бүр эрчтэй даллав. Харри энэ дуудлаганд олон янзын шалтгаан бодож олж чадах байсан ч юуны түрүүнд тэд хоосон гудамжны дунд өөд өөдөөсөө харан зогсож байв.

Тэр үнэхээр ийм удаан хугацааны турш хүлээсэн гэж үү? Дамблдор үнэхээр түүнд хүлээхийг зарлигдаж Харриг заавал ирнэ гэж анхааруулсан юм болов уу? Магадгүй тэр оршуулгын газарт бутны сүүдэрт нуугдан зогсож байснаа ийшээ дагаж ирсэн юм биш байгаа даа? Эсвэл түүнийг үл үзэгдэх цуван дор байна гэдгийг Дамблдорынхны авъяасаар мэдэрсэн хэрэг юм болов уу? Харри урьд нь хэзээ ч ийм явдалтай тулж байсангүй.

Эцэст нь Харри үг хэлэхэд Гермиона санаангүй байсандаа цочлоо.

- Та Батильда юу?

Бигнэсэн дүрс толгой дохиод ахин гараа зангав.

Харри, Гермиона цуван дор өөд өөдөөсөө харлаа. Харри хөмсгөө асуунгүй өргөхөд, Гермиона түгшин толгой дохив.

Тэд эмэгтэйн зүг алхахад хөгшин тэдний ирсэн зүг рүү явав. Хэдэн байшин өнгөрсний эцэст хаалга руу эргэлээ. Харри, Гермиона хоёр араас нь даган өтгөн ургасан цэцэрлэгийн дундах замаар явлаа. Эмгэн түлхүүр хийн тэмтэчсэнээ хаалга нээж тэднийг урдаа оруулав.

Байшин аймшигтай муухай үнэртэй байлаа. Харри хамраа үрчийлгээд орж үл үзэгдэх цуваа тайлав. Тэр хөгшиний дэргэдүүр өнгөрөхдөө хичнээн намхан цээжтэй нь чацуу болохыг нь мэдэв. Хөгшин хаалга хаагаад цэнхэр толботой ясархаг хуруугаа сарвайлган Харрийн нүүр лүү харлаа. Түүний нүд хөнхийн цайж тунгалаг арьстай үрчлээтэй нүүрэндээ шигдсэн агаад царай нь дүүрэн толботой байлаа. Тэр юм харж

чадаж байгаа эсэх нь ойлгомжгүй ч хэрвээ харж байгаа бол өнөөдөр Харрийн хувирсан халзан толгойтой маглыг харж байгаа билээ.

Хөгшин цагаан эрвээхэйд идэгдсэн хар алчууpаа тайлахад хэдхэн цагаан үстэй хуйх нь гарч ирэв.

- Батильда юу? гэж Харри давтлаа.

Тэр ахиад толгой дохив. Харри гэнэтхэн цээжинд нь байгаа зүүлтний хүйтэн алт цохилохыг мэдэрлээ. Магадгүй дотор нь нуугдсан зүйл устгагдах аюулыг мэдэрсэн юм болов уу?

Батильда хөлөө чирсээр дэргэдүүр нь өнгөрөхдөө Гермионаг хараагүй мэт түлхэн өнгөрч зочны өрөө рүү цааш оров.

- Харри, би үүнд итгэлтэй биш байна гэж Гермиона шивнэлээ.

- Түүний бие ямар жижигхэн болохыг хараач. Хэрвээ байдал эвгүйдвэл бид дийлж чадна гэж бодож байна. Тэгээд ч би чамд хэлээгүй болохоос тэр жаахан хэвийн биш болсон байгаа. Мюриэль түүнийг зөнөсөн гэсэн.

- Ийшээ! гэж Батильда хаалганы цаанаас дуудав. Гермиона давхийснээ Харрийн гараас зуурлаа.

- Бүх зүйл хэвийн гэж тэр тайвшируулаад зочны өрөөнд түрүүлж оров.

Батильда өрөөн дотуур майжигнан явж лаа асаах хэдий ч энд маш харанхуй туйлын бохир заваан байлаа. Хөлийн дор зузаан тоос зурагдаж муудсан махтай төстэй хөгцөрсөн зүйлийн үнэр ханхлана. Харри Батильда дээр хэн нэгэн хамгийн сүүлд ирсэн эсэхийг гайхлаа. Тэр харваас шид хэрэглэхийг мартсан бололтой түлэгдэхээс айсан мэт нэг гараараа эв хавгүйхэн лаа асаана.

- Алив, би гэж Харри хэлээд түүнээс шүдэнзийг авлаа.

Батильда чимээгүйхэн зогсоод түүнийг лаа асаахыг харахад өрөөнд байгаа аяга сав суулга, овоолоостой ном, ширээн дээрх хагархай аяга гийгүүлэгдэв.

Харри сүүлчийн лааг асаахдаа намхан шүүгээн дээрх гэрэл зурагнуудыг харлаа. Галын гэрэлд тоостой шилэн дээр тусахад зурган дээр дүрслэгдсэн хүн үл мэдэг хөдлөв. Батильда ханан зууханд түлээ хийх үед Харри,

- Тергео! гэж шивнэлээ.

Зурагнуудын тоос арилсан ч арваад том жаазны зураг алга болжээ. Хэн тэдний зургийг авсан нь сонирхолтой. Батильда өөрөө юм болов уу? Тэгтэл Харри ард үлдсэн нэг гэрэл зургийг харлаа. Тэр зургийг авав.

Жаазнаас Харри руу Грегоровичийн цонхны тавцан дээр байсан алтлаг үстэй хөгжилтэй хулгайч залхуутай инээмсэглэн харж байлаа. Тэгэхэд л Харри энэ царайг хаана харснаа саналаа. Тэр «Альбус Дамблдорын хуурамч амьдрал» номон дээр

өсвөр насны Дамблдортой гараасаа барилцан зогсож байсан. Тэгэхээр үлдсэн бүх зургийг Рита Скитер авсан бололтой.

- Хатагтай ... хатагтай Бэгшот! гээд Харри үл мэдэг чичирсэн хоолойгоор,

- Энэ хэн бэ? гэлээ.

Батильда өрөөний дунд зогсоод Гермиона хэрхэн ханан зууханд гал асаахыг харна.

- Хатагтай Бэгшот? гэж Харри давтаад зургийг түүнд ойртуулав.

Ханан зууханд дөл ярсхийлээ. Батильда хүний дуугаар эргэж харахад цээжин дэх крестраж нь хурдтай цохилов.

- Энэ хүн хэн бэ? гээд тэр зургийг урагш сунгаж чанга асуугаад,

- Энэ хүн? Та түүнийг мэдэх үү? Түүнийг хэн гэдэг юм бэ? гэв.

Батильда Харри руу гөлрөн харлаа. Тэр гүнзгий цөхрөлд автахаа мэдрэв. Рита яаж түүнтэй ярилцаж чадсан юм бол?

- Энэ хүн хэн бэ? гэж тэр чангаар давтлаа.

- Харри чи юу хийж байгаа юм бэ? гэж Гермиона асуув.

- Гермиона зурган дээр Грегоровчийн зүйлийг хулгайлсан хулгайч байна! Гуйж байна, санаач! Энэ хэн бэ?

Хөгшин түүн рүү чимээгүйхэн харсаар байв.

- Та яагаад биднийг дуудсан юм хатагтай ... хатагтай Бэгшот? Та бидэнд ямар нэг зүйл хэлэхийг хүсээ юу? гэж Гермиона дуугаа өндөрсгөн асуулаа.

Гэвч Батильда Гермионаг сонссонгүй хөлөө чирэн Харри руу дөхөөд үүдний хаалга руу дохилоо.

- Та биднийг явахыг хүсч байна уу? гэж Харри асуув.

Тэр хөдөлгөөнөө давтаад энэ удаад хуруугаараа өөр лүүгээ зааснаа дараа нь адар луу заалаа.

- Аан, ойлголоо ... Гермиона тэр намайг дээшээ гарахыг хүсч байх шиг байна.

- За, явцгаая гэж Гермиона хэлэв.

Гэвч Гермионаг байрнаасаа хөдөлмөгц Батильда толгойгоо гайхалтай хурдан сэгсэрснээ өөр лүүгээ болон Харри руу заав.

- Тэр намайг ганцаар явахыг хүсч байна.

- Яагаад тэр вэ? гэж Гермиона огцом асуухад хоолой нь лааны гэрэлтэй өрөөнд цуурайтав. Эмгэн толгойгоо шажигнуулан сэгсрэв.

- Магадгүй Дамблдор түүнд илдийг надаас өөр хүнд өгч болохгүй гэж хэлсэн юм болов уу?

- Чи түүнийг үнэхээр хэн гэдгийг чинь мэднэ гэж бодож байна уу?

- Тиймээ. Тийм гэж бодож байна гээд Харри түүний сүүн цагаан нүд рүү харлаа.

- Сайн байна, тэгвэл түргэн буцаж ирээрэй, Харри.

- Явцгаая гэж Харри Батильдад хэлэв.

Тэр үүнийг ойлгосон бололтой хөлөө чирэн хаалга руу явлаа. Харри Гермиона руу урамшуулан инээмсэглэсэн ч харсан гэдэгт нь итгэлгүй байлаа. Тэр элгээ тэврэн зогсоод лааны гэрэлд номын тавиур рүү нүд салгалгүй харна. Харри өрөөнөөс гарахдаа үл таних хулгайчын мөнгөн жаазтай зургийг өвөртөө ажиглагдамгүй хийлээ.

Шат огцом өссөн давчуу ажээ. Харри Батильдагийн бахим нурууны хойно явахдаа хойшоо унаад ирэх вий гэж гараа урдаа өргөлөө. Тэр маш удаанаар сөөнгөтөн амьсгалж дээшээ өгссөнөө баруун тийш эргээд намхан адартай унтлагын өрөөнд оров.

Энд харанхуй бөгөөд улам аймшигтай үнэртэж байлаа. Харриг дөнгөж орон дор байсан хөтөвчийг ялган хармагц Батильда хаалга хааж өрөөнд тас харанхуй болов.

- Люмос! гэж Харри хэлэхэд шидэт саваа нь гэрэлтлээ. Тэр урагшаа харснаа хөгшин түүнд сонсогдолгүй ойртон ирсэн байсан явдалд цочлоо.

- Чи Поттер уу? гэж тэр шивнэлээ.

- Тийм.

Тэр удаанаар хөөрөн толгой дохив. Харрийн цээжин дэх крестраж өөрийнх нь зүрхний цохилт адил адил цохилсонд таагүй түгшсэн мэдрэмж төрөв.

- Таньд надад өгөх ямар нэг юм байна уу? гэж Харри түүнийг савааны гэрэлд сатаарахад нь асуугаад,

- Таньд надад өгөх юм байна уу? гэж давтлаа.

Тэгтэл хөгшин нүдээ аниад шуудхан хэдэн зүйл болов. Сорви нь шархиран өвдөж, крестраж цамцан дотор нь хүчтэй савчин, өмхий харанхуй өрөө агшин зуур уусан алга болоод тэр зүйрлэхийн аргагүй баяр хөөртэй хүйтэн хоолойгоор «Түүнийг барь!» гэж хэллээ.

Харри ганхлаа. Давчуу өмхий өнөө ахин бий болоход сая юу болсныг ойлгож чадсангүй.

- Таньд надад өгөх ямар нэг зүйл байна уу? гэж тэр гурав дахь удаагаа чанга давтлаа.

- Тэнд гэж тэр шивнээд булан руу заав.

Харри саваагаа өргөөд хөшигтэй цонхны дэргэдэх гоёл чимэглэлийн ширээн дээр замбараагүй хөглөрсөн дүрсийг харлаа.

Энэ удаад Батильда түүнийг дагуулсангүй. Харри хураагаагүй ор болон түүний хажуугаар өнгөрөхдөө саваагаа өндөрт өргөн хөгшинг хараанаасаа алдчихгүй байхыг хичээв.

- Энэ юу вэ? гэж тэр ширээнд хүрч угаагүй бохир хувцас шиг овоолоостой зүйлийг харж асуулаа.

- Тэнд гэж Батильда хэлээд хэлбэр дүрсгүй овоолгыг заав.

Харри илдний бариулыг чимэглэсэн бадмааргыг хайн хартал хөгшин огцом хөдөлгөөн хийлээ. Тэр үүнийг нүднийхээ булангаар ажигламагц сандран эргэтэл хөгшиний бие шалан дээр унаж дөнгөж сая хүзүү байсан газраас аварга могой гарч ирэхэд айдаст автан хөшлөө.

Могой дайрахад тэр шидэт саваагаа өргөсөн ч бугуйнаас нь хазахад үсрээд адар руу эргэлдэн унаж гэрэл нь унтарлаа. Могойн сүүлнээс хүчтэй цохилт ирэхэд Харрийн цээж оногдоод амьсгалж чадахаа болин ширээн дээрх бохир хувцасны овоолго дунд унаад хажуу тийш өнхөрмөгц аварга том сүүл шарван өнгөрч секунтын өмнө байсан газар нь буухад хагарсан хэлтэрхийн бороо асгарлаа. Нэг давхарт Гермионагийн,

- Харри! гэж дуудах сонсогдлоо.

Тэр түүнд хариулахаар амьсгал авч чадсангүй. Гөлгөр хүнд зүйл дээрээс нь дарж хүчирхэг булчин гулсах нь мэдрэгдэв ...

- Үгүй! гэж тэр дуу алдлаа.

- Тиймээ. Тиймммм ... чамайг барилаа ... би чамайг барьчихлаа гэж хоолой шивнэлээ.

- Ацкио ... Акцио, шидэт саваа!

Тэр гараа суллаж чадаагүй болохоор юу ч болсонгүй бөгөөд могой түүний их биеийг хүчтэй ороон баглахад крестраж цээжинд нь шахагдан мөс шиг хүйтэн төмөр цохилоход тархи нь хүйтэн цагаан гэрэлд живж, бүх бодол нь хаа нэгтээ алга болоод амьсгал нь тасалдтал алсад хөлийн чимээ гарч адарт хурц гэрэл зурсхийлээ ...

Цээжин дээр нь төмөр зүрх цохилоход тэр нисээд, ялалтандаа хөөрөн шүүргүй фестралгүй нисээд л ...

Харри гэнэтхэн сэхээ ороход харанхуйгаас эхүүн үнэр ханхлав. Нагайна түүнийг тавьжээ. Тэр өндийн босоод шатны талбай дээрх гэрэлд могойн дүрсийг харлаа. Могой урагш дайрахад Гермиона хашгирснаа үсрэн холдоход илгээсэн шившлэг нь хөшигтэй цонхыг онож хагалав. Өрөөнд хүйтэн агаар сэнгэнэн орж ирэхэд Харри бөхийн шилний хэлтэрхийнээс булталад хөл дор нь харандаатай адил зүйл өнхөрлөө

... шидэт саваа!

Харри түүнийг авсан ч могой өрөөнд аймшигтай сүүлээ нүдлээ. Гермиона харагдсангүйд Харри хамгийн муу зүйл бодтол чанга тасхийх чимээ гарч улаан оч гялсхийгээд могой агаарт шидэгдэхдээ Харрийн нүүрийг ороолгов. Тэгснээ хүнд

цагариг сунан дээшилсээр адарт хүрлээ. Харри саваагаа өргөтөл сорви нь гэнтхэн ойрын жилийн турш байгаагүйгээр аймшигтай өвдлөө.

- Тэр ирж байна! Гермиона тэр одоохон энд ирэх нь!

Харрийн хашгирахыг мэдрээд могой галзуурсан мэт исгэрэв. Эргэн тойрны бүх зүйл сүйрч ханан дахь тавиурууд нуран шалаар нэг шаазангийн хэлтэрхий асгарахад Харри орон дээгүүр харайгаад Гермионагийн хар дүрсийг барьж авлаа.

Тэр түүнийг орон дээгүүр чирэхэд өвдсөндөө хашгирав. Могой ахин толгойгоо өндийлгөсөн ч Харри түүнээс дор зүйл ойртож байгааг мэдэж байв. Магадгүй тэр хэдийн хаалгаар ороод ирсэн байх толгой нь хагарах шахам өвдлөө ...

Могой урагш ухахсхийхэд Харри үүднээс холдон харайлгахдаа Гермионаг чирэхэд дайрч буй могой руу,

- Конфринго! гэж хашгирав.

Шившлэг өрөөн дундуур ниссэнээ шүүгээний толинд ойн хана адрын дунд ойн үсчив. Харрийн гар халуу оргин шилний хэлтэрхий хацрыг нь зүсэхэд Гермионагийн хамт орон дээгүүр дамжин эвдэрсэн ширээн дээгүүр гүйгээд хагархай цонхоор хоосон руу үсэрлээ. Гермионагийн хашгиралт шөнийн агаарт цуурайтаж тэд агаарт мушгиралдан ...

Тэгтэл сорви нь халуу шатан өвдөж тэр Волдеморт болоод өмхий унтлагын өрөөнд орж ирэн цонхны тавцангаас урт хуруугаараа бариад халзан толгойтой эрэгтэй хүн, жижигхэн эхнэрийнхээ хамт агаарт уусан алга болохыг харж уур хилэндээ хашгирахад алсад харанхуй цэцэрлэгт охид хашгиралдан, зул сарын сүмийн хонх жингэнэлээ ...

Түүний хашгиралт Харрийн хашгиралт байж, өвдөлт нь Харрийн өвдөлт байлаа ... ийм явдал өмнө нь энд болж байсан ... тэр энэ гэрт ойртохдоо үхэж болохоо мэдэж байсан ... үхэл ... өөрийнхөө биенээс гарахад ... өвдөлт аймшигтай байсан ... гэхдээ тэр биегүй юм бол толгой нь яагаад ийм аймшигтай өвдөж байгаа юм бол ... хэрвээ үхсэн бол яагаад ийм тэсэхийн аргагүй хүйтэн байгаа юм бол үхсэн ч өвдөлт зогсолгүй үргэлжилсээр ...

Бороотой үдэш байлаа. Хоёр хулууны хувцастай хүүхэд талбай дээгүр явахад дэлгүүрийн цонхонд цаасан аалз болон маглуудын ертөнцөд байдаг гэж итгэдэггүй бас бус зүйлс өлгөжээ ... Тэр цааш явахад зорилго болон хүчээ мэдэрлээ ... Энэ нь уур хилэн биш ... сулхан сэтгэл байлаа ... гэхдээ баярлах ёстой ... тэр энэ мөчийг удаан хүлээж найдаж байсан ...

- Сайхан хүрэм байна, ноёнтоон!

Тэр юүдэн дорх царайг нь хараад хүүгийн царайнаас инээмсэглэл арилан одож цайхыг харлаа. Хүүхэд эргээд цааш гүйлээ ... Тэр жанчин дорх шидэт саваагаа хуруугаараа мэдрэв ... Нэг л хайхрамжгүй хөдөлгөөн хийхэд тэр хэзээ ч ээж рүүгээ очихгүй болно ... гэхдээ энэ илүүц, хэтэрхий илүүц зүйл байлаа ...

Тэр өөр харанхуй шинэ гудамжинд ороход аялалын зорилгын төгсгөл ирлээ. Итгэлцлийн шид эвдэгдсэн гэдгийг тэд мэдээгүй байгаа ... Тэр чимээгүйхэн хөдөлж навчсанд хучигдсан явган зам дээр гарахад харанхуй таримал бургасан хашаагаар орлоо ...

Хөшиг татаагүй байсан тул тэдний жижигхэн зочны өрөөндөө сууж байх нь тод үзэгдэнэ. Хар үстэй нүдний шилтэй эрэгтэй, цэнхэр хүрэмтэй хүүг хөгжөөхийн тулд шидэт саванаасаа янз бүрийн өнгийн утаа гаргаж байв. Хүү хөхрөн гараараа утааг барихыг оролдох аж ...

Хаалга онгойн урт хар үстэй ээж нь орж ирлээ. Түүний юу ярьж байгаа нь сонсогдсонгүй. Эцэг нь хүүгээ гар дээрээ өргөж эхэд нь өгөөд шидэт саваагаа буйдан дээр тавин эвшээлгэв ...

Хашааны хаалга онгойлгоход чахарсан ч Жеймс Поттер сонссонгүй. Тэр цагаан гараараа жанчин дороосоо шидэт саваагаа гаргаж ирээд хаалга руу чиглүүлэхэд тасхийн онгойв.

Түүнийг хэдийн босго давсан хойно Жеймс үүдний танхимд гүйж ирлээ. Энэ бүхэн маш амархан хэтэрхий амархан байсан тул тэр саваагаа авч амжихгүй ...

- Лили Харриг аваад зугт! Энэ тэр байна! Зугт! Түргэл! Би түүнийг саатуулъя

...

Түүнийг нүцгэн гараараа саатуулах юм гэнээ! Тэр инээн үхлийн шившлэг илгээлээ ...

- Авада кедавра!

Ногоон оч үүдний өрөөнд гялсхийн хананд шахсан хүүхдийн тэргийг гэрэлтүүлэхэд

... Жеймс Поттер утсан хүүхэлдэй адил уналаа.

Тэр дээд талын давхарт хашгиралт гарахыг сонслоо. Тэр санганд орсон ч хэрвээ биеэ эзэмдэх ухаан байгаа бол юу ч тохиолдохгүй ... Тэр шатаар өгсөөд хаалгаар сулхан саад болох оролдлого хийсэнд нь инээд хүрлээ ... Түүнд бас шидэт саваа байсангүй ... Тэд ямар тэнэг юм бэ найзуудынхаа үнэнчид итгэж л байдаг ...

Тэр саваныхаа залхуутай хөдөлгөөнөөр хаалгыг хүчээр нээж овоолсон сандал хайрцагыг холдуулав ... Тэр өрөөний голд хүүхдээ гартаа тэврэн зогсож байв. Түүнийг хараад хүүг орон дээр тавьж энэ нь хүүхэд үзэгдэхгүй болоход туслах юм шиг гараа дэлгэн зогслоо ...

- Зөвхөн Харриг л биш шүү, гуйж байна, хэрэггүй!

- Холд, тэнэг охин минь ... одоохон холд ...

- Гуйж байна, зөвхөн Харриг л биш шүү ... оронд нь намайг ал ...

- Сүүлчийн удаа анхаарууллаа шүү ...

- Гуйж байна, зөвхөн Харриг биш шүү ... Зөвхөн Харриг биш! Зөвхөн Харриг л биш! Би таны хүссэн бүхнийг хийе ...

- Холд ... Холд, эмэгтэй минь ...

Тэр түүнийг зүгээр л замаасаа зайлуулж болох байсан ч гэр бүлийнх нь хамт дуусгах хүсэл төрөв.

Өрөөнд ногоон оч гялсхийхэд тэр нөхрийнхөө адил уналаа. Энэ үе хүүхэд уйлсангүй. Тэр орны хашлаганаас барин зогсоод үл таних хүний царай руу магадгүй эцэг нь юүдэн дор нуугдаад, ээж нь хаа нэгтээ шүүгээнээс инээн гарч ирэх юм шиг сонирхон харлаа ...

Тэр саваагаа хүүхдийн царай луу анхааралтай чиглүүлэв ... Тэр энэ бүхэн яаж болохыг харахыг хүсэж өөрийн гараар тайлбарлаж боломгүй аюул заналыг

устгахыг хүслээ. Хүүхэд уйлж эхлэв ... Харваас түүний урд Жеймс байхгүй гэдгийг мэдсэн бололтой. Уйлалт түүнд таагүй нөлөөллөө, тэр өнчин хүүхдийн газарт байхдаа ч хүүхдийн уйлахыг тэвчдэггүй байсан.

- Авада кедавра!

Тэгтэл тэр сүйрчихлээ. Тэр юу ч биш, өвдөлт айдсаас ондоо юу ч үлдсэнгүй, тэр нуугдах ёстой зөвхөн энд л биш шүү, сүйрсэн байшинд айсан хүүхдийн уйлаанаас алсад, үүнээс маш алсад ...

- Үгүй гэж тэр ёолов.

Могой бохир шалан дээгүүр шар шурхийн мөлхөхөд тэр алахыг хүссэн хүү байлаа ...

- Үгүй ээ ...

Харин одоо тэр хөгшин Батильдагийн хагарсан цонхны дэргэд зогсоод дурсамжаа санагалзан хөл дор нь аварга могой хагарсан шаазангийн хэлтэрхий дундуур гулгана

... Тэр доошоо харлаа ... ямар нэг итгэмээргүй зүйл ...

- Үгүй ...

- Харри бүх зүйл сайхан болно.

Тэр бөхийж хагарсан хагарсан нүүртэй зургийг авлаа. Энэ байна түүний хичнээн их хугацааны турш эрсэн үл таних хулгайч ...

- Үгүй ... би түүнийг унагачихаж ... унагачихаж ...

- Харри бүх зүйл сайхан болно. Сэргэ л дээ, Харри!

Тэр Харри байлаа ... Волдеморт биш Харри ... тэгээд ч шар шурхийн мөлхөх аварга могой байхгүй.

Тэр нүдээ нээлээ.

- Харри чи зүгээр үү? гэж Гермиона шивнэлээ.

- Тиймээ гэж худал хэлэв.

Тэр майхны доод талын орон дээр хөнжил нөмрөн хэвтэж байв. Нам гүмд дээврийн завсраар хүйтэн цагаан гэрэл тусан удахгүй үүр гэгээрэх гэж байгаа бололтой. Харрийн бүх бие хөлөрч орны даавуу хөнжил нь нэвт норсон байв.

- Бид зугтсан.

- Тиймээ. Би чамайг орон дээр хөөргөх шидээр тавиагүй бол дээш нь гаргаж чадахгүй байлаа. Чи ... Ер нь бол жаахан ...

Түүний нүдэн дор хөхөрч гартаа нүүрийг нь арчиж байсан бололтой хөвөн барьсан байв.

- Чиний бие муу байсан. Маш муу байсан.

- Бид тэндээс ирээд удаж байна уу?

- Хэдэн цагийн өмнө ирсэн. Одоо бараг өглөө болж байна.

- Тэгэхээр би ... ухаангүй байсан гэсэн үг үү?

- Яг ч тийм биш. Чи хашгираад ёолоод байсан бас ... гэж таагүй өнгөөр төгсгөхөд Харрийн дотор эвгүйцлээ.

Тэр яасан юм бол? Волдемортын шившлэг илгээхэд модон орон дээр зогсож байсан жижигхэн хүүхэд шиг уйлсан юм болов уу?

- Би чамаас крестражыг арайхийж тайлж авсан гэж Гермиона сэдвийг өөрчлөн хэлээд,

- Тэр чиний цээжинд наалдчихсан байсан. Бүр ором үлдсэн байсан гээч. Чи намайг уучлаарай таслах шившлэг хэрэглэхгүй бол салгаж болохгүй байлаа. Бас могой чамайг хазсан болохоор шархыг чинь цэвэрлээд жаахан бадъяан хэрэглэсэн ... гэв.

Харри хөлсөнд норж нэвтэрсэн футболкоо тайлаад шалан дээр хаяж өөрийгөө харлаа. Зүрхний арай дээхэн талд зүүлтэнд түлэгдсэн хүрэн улаан ором байв. Бугуйн дээр нь могойн шүдний эдгэсэн ором харагдана.

- Чи крестражыг хаана тавьсан бэ?

- Цүнхэндээ. Тэнд хэвтэж байсан нь хамаагүй дээр.

Харри дэрэн дээрээсээ эргээд цонхийж сааралтсан царай руу нь харлаа.

- Годрикийн хонхор руу явах хэрэггүй байж. Энэ бүхэнд би буруутай, Гермиона намайг уучлаарай.

- Чи ганцаараа буруугүй. Би бас тэнд байхыг хүссэн. Би Дамблдор үнэхээр чамд илдийг тэнд орхисон гэж бодсон.

- Тиймээ ... тэгвэл бид алдсан бололтой.

- Юу болсон бэ, Харри? Тэр чамайг дээш нь гаргахад юу болсон юм бэ? Могой хоёр давхарт нуугдаж байсан юм уу? Үсэрч гарч ирээд чамайг алахаар дайрсан уу?

- Үгүй. Тэр могой байсан ... могой байсан ... эхнээсээ л.

- Юу?

Харри нүдээ анилаа. Тэр Батильдагийн гэрийн үнэрийг мэдэрсэн хэвээр болсон аймшигтай явдал тодхон үзэгдэв.

- Батильда эрт үхсэн байх. Харин могой ... түүний дотор байсан. Түүнийг Годрикийн хонхорт Хэцүү нэрт харуулдуулахаар үлдээсэн байсан. Чиний зөв байж. Тэр намайг эргэж очно гэдгийг мэдэж байсан.

- Могой Батильдагийн дотор байсан юм уу?

Харри ахин нүдээ нээлээ. Гермина дотор нь муухайрсан царайтай зогсож байв.

- Люпин биднийг хэзээ ч төсөөлж харж байгаагүй шидтэй тулгарна гэсэн хэмээн Харри бувтнаад,

- Тэр чамтай ярихыг хүсээгүйн учир нь могойн хэлээр ярьж байж. Үргэлж могойн хэлээр ярьж байсныг би ойлгосон мөртлөө ажигласангүй. Биднийг дээш өгсмөгц могой Хэцүү нэртэд дуудахад би ямар баяртайгаар намайг барь гэж хэлэхийг нь сонссон ... харин дараа нь ...

Харри могой хэрхэн Батильдагийн хүзүүнээс урган гарч ирснийг саналаа. Гермиона бүх зүйлийг нарийвчлан мэдэх шаардлагагүй байх.

- ... тэр өөрчлөгдөөд, могой болон хувирч дайрсан. Түүнд намайг ал гэж тушаагаагүй зөвхөн Хэцүү нэртийг иртэл саатуулах үүрэгтэй байж гээд могойн шүдний ором руу харлаа.

Хэрвээ тэр могойг устгасан бол бүх зүйл эсрэгээрээ эргэх байлаа ... Дотор нь гуниг төрөхөд хөнжлөө сөхөн суув.

- Үгүй, Харри чи амрах хэрэгтэй!

- Харин чамд л амралт хэрэгтэй байна. Гомдох хэрэггүй дээ, чи аймшигтай харагдаж байна. Харин би хэвдээ байгаа болохоор жижүүрлэж чадна. Миний шидэт саваа хаана байна?

Гермиона түүн рүү чимээгүйхэн ширтлээ.

- Миний саваа хаана байна, Гермиона? Тэр уруулаа хазаад нүдэнд нь нулимс дүүрэв.

- Харри ...

- Миний шидэт саваа хаана байна? Тэр шалан дээрээс юм авахаар тонгойв.

Саваа нь хоёр хуваагдаж зөвхөн галт шувууны өд торгоож байлаа. Харри савааг гартаа авахад сэтгэл нь шимрэн өвдлөө. Дотор нь айдаст автан саваагаа Гермионад сунгалаа.

- Түүнийг зас! Гуйж байна!

- Харри би тэгж бодохгүй байна ... тэр хугарсан болохоор ...

- Гуйж байна оролдоод үз л дээ, Гермиона!

- Р ... Репаро!

Хугарсан хэсэг ахин байрандаа ургав. Харри саваагаа даллалаа.

- Люмос!

Сулхан оч нисэн гарснаа бөхлөө. Харри Гермиона руу саваагаа чиглүүлэв.

- Экспеллиармус!

Гермионагийн саваа сулхан хөдөлснөө гарт нь үлдэв. Харрийн саваа ахин бүтэн болсон ч ямар ч шидийн хүчгүй болжээ. Харри түүн рүү эмээн харлаа. Шидэт саваа түүнийг амьд үлдэхэд хичнээн ...

- Харри, намайг уучлаарай ... Би түүнийг тэгсэн байх ... Ойлгож байна уу могой бидэн рүү дайрах үед би дэлбэрдэг шившлэг хэрэглэхэд хаа сайгүй ойгоод магадгүй ... савааг оночихсон байх ...

- Энэ бол золгүй явдал байсан гэж Харри өөрийн мэдэлгүй хэлээд дотор нь давчдан хоосорлоо.

- Зүгээр дээ ... ямар нэг зүйл өөр зүйл бодож олцгооё.

- Харри түүнийг засаж болно гэж бодохгүй байна. Санаж байна уу ... Роны саваа хугарсныг? Та нар түүнийг машинд хугалсан биз дээ? Түүнийг засаж чадахгүй болохоор ахиад шинийг худалдаж авсан гэж Гермиона нулимс цийлэгнүүлэн хэлэв.

Харри Олливандер Волдемортод олзлогдон, Грегорович алагдсаныг саналаа. Тэр одоо хаанаас шидэт саваа авах хэрэг вэ?

- За яахав. Би чинийхийг түр авъя авъя. Жижүүрлэж байх үедээ гэж хуурамч өөдрөг хоолойгоор хэллээ.

Гермиона нулимс цийлэгнүүлэн шидэт саваагаа өгөөд орон дээр суун үлдэхэд Харри энэ дэлхий дээр түүнээс аль болох хол байхаас өөр юу ч хүсэлгүй гадагш гарлаа.

БҮЛЭГ 18: АЛЬБУС ДАМБЛДОРЫН ХУУРАМЧ АМЬДРАЛ

Нар өндөрт мандахад уудам зэвхий тэнгэр Харрийн зовлон шаналалалд хайхрамжгүй цэлийнэ. Тэр майхнаас гарч суугаад цэвэр агаарт гүнзгий амьсгал авлаа. Тэр амьд үлдээд нар хэрхэн цастай толгодын оройг гялтагнуулан хөөрөхийг харж энэ нь гайхамшигтай үзэгдэл байсан ч одоо түүнийг үнэлж чадахааргүй байлаа. Түүнийг аймшигтай зовлон нэрвэж шидэт саваагаа алджээ. Урд нь цасанд хучигдсан хөндий үргэлжилж алсад сүмийн хонхны дуу гарна.

Харри өөрийн мэдэлгүй хумсаа шигдтэл атгаж гараа өвтгөхийг хичээв. Тэр тоолж баршгүй олон удаа цусаа алдаж, нэг удаа баруун гарын ясгүй болон, цээж, бугуй, духан дээр нь аялалын мөр болох сорви үлдсэн ч хэзээ ч ийм сул дорой хамгаалалтгүй нүцгэн үлдсэнээ мэдэрч байгаагүй бөгөөд шидийн хүчний ихэнхи хэсгээ алджээ. Тэр Гермионагийн үүнд юу гэж хариулахыг мэдэж байлаа. Шидэт саваа шидтэнээс илүү зүйл хийж чадахгүй. Гэхдээ түүний буруу байлаа. Тэр хэзээ ч Харрийн шидэт саваа луужингийн зүү шиг эргэлдэн дайсныхаа эсрэг алтан оч буудахыг хараагүй. Одоо түүнийг ах дүү хоёр нэгдмэл саваа хамгаалахгүй. Тэр өмнө нь энэ хамгаалалт ямар хүчирхэг болохыг ойлгодоггүй байж.

Харри халааснаасаа хугарсан шидэт саваагаа гаргаад хүзүүндээ өлгөсөн Хагридын хүүдийд шургуулав. Хүүдий хэдийн янз бүрийн ашиггүй эвдэрхий зүйлсээр дүүрчээ. Харри хүүдийний гаднаас хуучин снитч байхыг мэдрээд гаргаж барилаа. Гэвч тэр Дамблдорын орхисон бусад зүйлсийн адилаар нууцаа зөрүүдлэн хадгалж ямар ч ашиг тус өгсөнгүй ...

Дамблдорт уурлах уур хилэн Харрийн дотор галт уулын хайлмаг шиг дүрэлзэж бусад мэдрэмжийг нь арчлаа. Тэд цөхөрсөндөө Годрикийн хонхорт бүх асуултын хариу байгаа гэж найдан очсон ч үнэн хэрэгтээ Дамблдорын нууц төлөвлөгөө болон ямар ч газрын зураг байсангүй. Дамблдор түүнийг харанхуйд үл мэдэгдэх айдастай зууралдуулан үлдээгээд ямар ч тусламж үзүүлсэнгүй бөгөөд юу ч тайлбарласангүй. Илд байхгүй байсан харин одоо шидэт саваагүй боллоо. Бас Харри хулгайчийн зургийг унагасан болохоор Волдеморт хэн гэдгийг нь төвөггүйхэн тааварлах болно

...

Одоо Волдемортод хэрэгтэй бүх мэдээлэл нь байгаа ...

- Харри! гээд Гермиона өөрийнх нь саваагаар шившлэг илгээхээс айсан мэт шийдвэргүйхэн дөхөж ирлээ. Тэр нулимс цийлэгнэсэн нүдтэй дэргэд нь ирээд суухдаа чичирсэн гартаа хоёр аяга цай барьжээ.

- Баярлалаа гэж Харри бувтнаад аягыг авлаа.

- Чамтай ярьж болох уу?

- Тиймээ гэж Харри түүнийг гомдоохгүйн тулд хэлэв.

- Зурган дээрх хүн хэн болохыг мэдэхийг хүсч байна уу? Тэгвэл ... энэ ном нь байна ...

Тэр хулчгардуухан өвдгөн дээр нь «Альбус Дамблдорын хуурамч амьдрал» гэсэн цоо шинэ ном тавилаа.

- Яаж? Хаанаас аваа вэ?

- Батильдагийн зочны өрөөнд хэвтэж байсан юм ... Дотроос нь энэ зурвас цухуйж байсан ...

Гермиона дээр нь хортой ногоон бэхээр бичсэн мөрийг чанга уншлаа.

- «Хүндэт Батти тусалсан явдалд баярлалаа. Номын нэг хувийг бэлэглэж чамд таалагдана гэдэгт найдаж байна. Санахгүй байж магадгүй ч чи энэ бүхнийг надад нээсэн билээ. Рита.» Би номыг жинхэнэ Батильда амьд байх үед ирүүлсэн ч уншиж чадаагүй байх гэж бодож байна.

- Тиймээ, тэгсэн байх.

Харри Дамблдорын царай руу уурсан харлаа. Тэр одоо Дамблдорын түүнд хэлэхийг хүсээгүй бүх зүйлийг мэдэх болно.

- Чи надад уурласан хэвээр байна уу? гэж Гермиона асуув.

Түүний нүдэнд ахин нулимс цийлэгнэхэд Харри уур хилэн нь царай дээр нь илрэн гарсныг ойлгов.

- Үгүй. Үгүй Гермиона энэ бүхэн санаандгүй болсон гэдгийг мэдэж байна. Чи гайхамшигтай байж биднийг тэндээс амьд гаргасан. Хэрвээ чи надад туслаагүй бол хэдийн үхсэн байх байлаа.

Тэр нулимстай нүд рүү нь инээмсэглэхийг хичээгээд ном руу харлаа. Хавтас нугалараагүй байхыг бодвол номыг хэзээ ч онгойлгож байгаагүй бололтой. Харри хуудсыг эргүүлэн гэрэл зургийг хайлаа. Тэгээд эрсэн зүйлээ даруйхан олмогц залуу Дамблдор царайлаг найзтайгаа ямар нэг зүйлийн талаар хөгжилтэй ярилцан нөхөрсгөөр инээлдэж байв. Харри түүний дор бичсэн тайлбарыг уншлаа.

Альбус Дамблдор эхийнхээ үхлийн дараа найз Геллерт Гриндевальдын хамт байгаа нь.

Харри сүүлчийн үгийг унших үедээ гайхан алмайрлаа. Тэр хэдэн секунтын турш хуудас руу гөлрөн харав. Гриндевальд. Дамблдорын найз байж! Тэр Гермиона руу хяламхийн харахад нүдэндээ итгэхгүй байгаа мэт харж байв. Дараа нь маш удаанаар Харри руу харлаа.

- Гриндевальд гэнэ үү?

Үлдсэн гэрэл зургуудыг орхиод Харри хуудас эргүүлэн нэрийг хайлаа. Удалгүй эрсэн зүйлээ олсон ч ойлгосонгүй. Учрыг нь олохын тулд урд талын хуудсанд байсан

«Аугаа их сайн сайхан» гэсэн гарчиг руу буцах хэрэг гарав. Тэр Гермионагийн хамт уншлаа.

Арван найман насны босгон дээр Дамблдор Хогвартсыг алдрын дөлөнд төгсжээ. Сургуулийн ахлагч, тэргүүний сурагч, Варнав Финклийн ер бусын шившлэгт олгодог

шагналын ялагч, Визенгамотын Английн хамгийн залуу гишүүн, Кайрт болсон олон улсын алхимичдийн хурлын шинийг санаачлагч алтан медал хүртсэн тэрбээр мэдлэгээ өргөжүүлэхийн тулд сургуулийнхаа дотны анд Элфиас Дожын хамт дэлхийг тойрсон аялалд явахаар төлөвлөжээ.

Залуу хүмүүс Лондонгийн «Цоорхой тогоо»-нд буудаллаад маргааш өглөө нь Грек руу явах ёстой байсан боловч Дамблдорт уулийн шуудангаар эхийнх нь үхлийн тухай мэдээ ирсэн байна. Дож энэ тухай номны зохиолчтой ярилцахаас татгалзсан бөгөөд уншигчдад дараа нь юу болсон талаарх уяхан сэтгэлтэй нийтлэлээ гаргаж Дамблдор Кендрагийн үхэлд эмгэнэсэндээ өөрийгөө хайхралгүй аялалд явахаас татгалзах шийдвэр гаргасан гэж хэлсэн билээ.

Тэгтэл ч үнэхээр Дамблдор тэр даруйхан Годрикийн хонхорт эрэгтэй эмэгтэй бага дүүдээ анхаарал тавихаар иржээ. Гэхдээ үнэн хэрэгтээ ямар анхаарал тавьж байсан бэ?

- Аберфорт бол түүний толгойны өвчин байсан гэж тэр үед Годрикийн хонхорт амьдарч байсан Энид Смик энэ талаар дурсан яриад,

- Ямар ч анхаарал түүнд тавьж байгаагүй. Мэдээж өнчин өрөөсөнд нь өрөвдөх хэрэгтэй байсан ч тэр үргэлж над руу ямааны хорголоор чулуудан тачигнатал инээдэг байв. Би Альбус түүнд санаа зовж байсан гэж бодохгүй байна. Би хэзээ ч тэдний хамт явахыг хараагүй гэжээ.

Альбус бага дүүгээ хардаггүй байсан юм бол юу хийдэг байсан юм бол? Үүний хариулт нь эмэгтэй дүүгээ хяналтнаасаа гаргахгүй байхад оршиж байжээ. Хэдийгээр өмнөх шоронгийн амьдрал нь дууссан ч Ариана Дамблдорын золгүй амьдрал нь сайн тал руугаа эргээгүй байна. Гэр бүлд түүний байгааг цөөн тооны итгэлтэй хүн болох Дож тэргүүтэй хүмүүс мэдэж байсан бөгөөд эрүүл мэнд нь муу байсан талаарх яриаг гаргасан билээ.

Өөр нэг тийм гэр бүлийн итгэлтэй найзын тоонд Годрикийн хонхорт олон жил амьдарсан алдарт «Ид шидийн түүх»-ийн зохиогч Батильда Бэгшот орно. Мэдээж Кендра Батильдагийн найрсаг хөрш болох анхны оролдлогыг няцаасан ч хэдэн жилийн дараа зохиолч Альбусыг Хогвартст байх үед захиа илгээж «Хувиргалын өнөөдөр» сэтгүүлд гаргасан нийтлэлд нь төрсөн сэтгэгдлийнхээ тухай бичиж байжээ. Энэ нь Дамблдорын гэрийнхэнтэй ойртон танилцсан эхний алхам байсан байна. Иймээс Кендрагийн үхлийн дараа бүх тосгоноос зөвхөн Батильда л ганцаараа тусалж дэмжихийг зөвшөөрч байжээ.

Золгүй нь гэвэл Батильдагийн гялалзсан ухаан амьдралынхаа төгсгөл үед мэдэгдэхүйц мууджээ. «Гал асаж байсан ч тогоо нь хоосон» гэж түүний тухай Айвор Диллонсби хэлсэн бөгөөд түүнчлэн Энид Смик «Хөөрхий хөгшин зүгээр л ухаан солиорчихсон» гэжээ. Тэгсэн ч гэсэн би удаан хугацааны сэтгүүлчийн туршлагандаа үндэслэн энэ бүх шуугиант түүхийн үндэс болсон бодит баримтуудыг гарган авч чадсан юм.

Бүхий л шидтэний ертөнцийн адилаар Батильда Кендрагийн цаг бус үхлийг буруу хэрэглэсэн шидтэй холбон тайлбарлаж байсан бөгөөд Альбус, Аберфорт хоёр ч

цаашдын амьдралдаа ингэж ярьж байсан. Батильда Арианагийн сулхан эрүүл мэндийн тухай тоть шиг давтан ярьж байлаа. Тэгсэн ч би багагүй хүч чармайлт гаргаж дээрээс нь Үнэнийг хэлүүлэгч уусмал нэмсэн юм. Батильда Бэгшот Альбус Дамблдорын амьдралын нууцыг мэдэх цор ганц хүн байсан ч одоо манай уншигчид анх удаагаа энэ тухай мэдэх гэж байна. Миний гаргаж тавьсан баримт хар урлагтай эвлэршгүй тэмцэгч болон маглуудыг өмгөөлөгч Альбус Дамблдорын бишрэн шүтэгчдийг гүнээ эргэлзүүлэх болно.

Тэр зун Альбус Годрикийн хонхорт эргэж ирэн өнчин үлдсэн гэр бүлийнхээ тэргүүн болоход Батильда Бэгшот дээр зээ Геллерт Гриндевальд зочлохоор иржээ.

Гриндевальд цаг үеийнхээ хамгийн аюултай шидтэнгүүдийн жагсаалтанд бичигдсэнээрээ алдартай байсан бөгөөд зөвхөн Хэцүү нэрт л түүнийг энэ байрнаас шахан зайлуулж чадахаар эн тэнцүү билээ. Ер нь бол Гриндевальд Англид аюул заналхийлж байгааггүй учир энэ нутагт түүнийг хүчээ авч байсан үеийн тухай сайн мэддэггүй байна.

Гриндевальд Дурмстрангад боловсрол эзэмшсэн бөгөөд энэ сургууль нь хар урлагтай холбоотойгоороо алдартай юм. Тэр Дамблдорын адил гялалзсан авъяасаараа эрт тодрон гарсан байна. Гэсэн ч авъяасаараа тодрон шагнал хүртэхийн оронд Геллерт Гриндевальд өөр зам сонгожээ. Арван зургаан настай байхдаа тэр Дурмстрангад эрсдэлтэй туршилтууд хийснийхээ улмаас сургуулаас хөөгджээ.

Саяхныг хүртэл Гриндевальдын тухай «хэдэн сарын турш хилийн цаана аялсан» гэдгээс өөр юм мэддэггүй байсан бол одоо бид үнэнийг мэдэх боломжтой боллоо. Геллерт хамаатны эмээ болох Годрикийн хонхорт амьдарч байсан авга эгч рүүгээ очоод гайхалтай нь Альбус Дамблдортой бөх холбоо тогтоожээ.

- Минийхээр бол тэр хожим тийм болсон ч гайхамшигтай хүү байсан. Би түүнийг хөөрхий Альбустай танилцуулахад хөвгүүд хоорондоо шууд нөхөрлөж билээ гэж Батильда ярьжээ.

Юу үнэн гэвэл энэ үнэн! Батильда надад Альбус Дамблдорын тэр үед Геллерт

Гриндевальдад бичсэн захиаг үзүүлсэн юм.

- Тиймээ, тэд өдрийн турш хөөрөлдөн хоёулаа их ухаантай байсан! Би заримдаа шөнө Геллертын цонхыг ууль хошуугаараа тогшин Альбусаас захиа авчирахыг сонсдог байлаа. Тэр шинэ санаагаа Геллерттэй ярилцах гээд яарч байсан юм.

Энэ санаа нь юу байв? Энэ нь Альбус Дамблдорын шүтэн бишрэгчдийг гүн цочирдолд оруулахаар зүйл байсан бөгөөд та нарын өмнө арван долоон настай баатар шинэ анддаа илгээсэн захиа байна (463 дугаар хуудсыг үзнэ үү).

Геллерт!

Чиний шидтэнгүүд МАГЛУУДЫГ ӨӨРСДИЙНХӨӨ ТУЛД ТУСЫН АШИГЛАЖ БОЛОХ ЮМ гэсэн санаа миний хувьд шийдвэрлэж болох зүйл байна. Энэ нь бидэнд томоохон эрх мэдэл өгөх бөгөөд эрх мэдэл нь ноёрхлыг өгч, ноёрхол нь эрх мэдлийн

хариуцлагад хүргэх юм. Энэ нь манай барилгын үндсэн суурь болохыг цохон тэмдэглэх байна. Түүнчлэн үүнийг эсэргүүцэгчдийн маргаантай тулгарах нь эргэлзээгүй. Хэрвээ бид гартаа АУГАА ИХ САЙН САЙХНЫГ оруулах юм бол эсэргүүцлийг хүчээр шийдвэрлэх болно. (Үүнд л чиний Дурмстрангийн гол алдаа байгаа юм! Гэхдээ үүний нэг сайн тал нь хэрвээ чи хөөгдөөгүй бол бид уулзахгүй байлаа).

Альбус

Энэ захиа нь Дамблдор тухайн үед олон улсын нууцлалын холбоог түлхэн унагаж маглуудыг ноёрхох гэж байсныг баталж байгаагаараа олон тооны шүтэн бишрэгчдийг нь гайхан цочирдуулж байгаа юм. Дамблдор магл гаралтай хүмүүсийн хамгаалан агуу их тэмцэгч байсныг мэдэх хэн бүхний хувьд энэ нь хүнд цохилт болох бизээ! Альбус Дамблдор тухайн үед нас барсан эхийнхээ араас гашуудаж дүүдээ санаа зовохын оронд дэлхийг эзлэх төлөвлөгөө зохиож байсан нь туйлын жигшүүртэй зүйл юм.

Гэвч төлөвлөгөө биелж амжаагүй байтал ... тэр бодлоо өөрчилсөн бололтой ... Гэвч үнэн таагүй байлаа.

Хоёр сар ч өнгөрөөгүй байтал Дамблдор Гриндевальд хоёрын үнэнч нөхөрлөл салаад домогт тулаанаа хийх хүртлээ ахин уулзсангүй (22-р бүлгийг үзнэ үү). Үүнд гэнэтийн ямар шалтгаан байв. Дамблдор Гриндевальдын төлөвлөгөөнд нь оролцохоо болилоо гэж хэлсэн юм болов уу? Үгүй дээ тийм зүйл болсонгүй.

- Энэ бүхнийг хөөрхий Арианагийн үхлээс болсонгэж бодож байна.

Аймшигтай золгүй явдал бид бүгдийг нэрвэсэн. Геллерт тухайн үйл явдал болсны дараа над руу сандран гүйж ирээд маргааш өглөө нь гэртээ харилаа гэж хэлсэн юм. Сэтгэлээр их унасан байсан даа. Би түүнд зөөвөрлөгч бэлтгэж өгөөд түүнээс цааш уулзаагүй.

- Арианагийн үхэл Альбуст хүнд цохилт болсон. Ах дүүс бүх гэр бүлийнхээ алдаж хорвоо дээр хоёулхнаа үлдсэн. Гэхдээ л тэдний муудалцсан явдалд гайхах хэрэггүй юм. Аберфорт Альбусыг болсон явдалд буруутгаж байсан нь хүнд мөчүүд байлаа. Тиймээ Аберфорт үргэлж ухаангүй хүү байсан Төрсөн ахынхаа хамрыг шууд оршуулган дээр хугалсан. Хэрвээ Кендра хөвгүүд нь охиных нь үхсэн биений хажууд зодолдож байгааг харсан бол тэсэхгүй байсан бизээ. Геллерт оршуулган дээр үлдэж чадаагүй нь харамсалтай ... Тэр Альбусыг сэтгэлээр дэмжих байсан даа ...

Авсны дэргэдэх аймшигтай зодооныг Ариана Дамблдорын оршуулганд оролцсон хэдхэн хүн мэдсэн бөгөөд үүнээс хэдэн асуулт урган гарч байна. Аберфорт яагаад Дамблдорыг дүүгийнхээ үхэлд буруутгасан юм бол? Энэ нь Батильдагийн итгүүлж байгаачилан уй гашууд автсан залуу хүний сэтгэлийн хямрал байв уу? Гриндевальд Дурмстрангаас сурагчид руу дайрсныхаа төлөө хөөгдсөн бөгөөд охины үхлээс хэдхэн цагийн дараа тэр газраас зугтан яваад (айсан юмуу ичсэн юм болов уу?) цаашид түүнтэй уулзаагүй байна.

Түүнчлэн Дамблдор Гриндевальдтай нөхөрлөж байсан залуу насныхаа богинохон үеийн талаар хэзээ ч дурсаж байсангүй бөгөөд золгүй явдлаас хойш таван жилийн турш Геллерт Гриндевальдтай тулгарахаас бүх хүчээ гарган зайлсхийж байжээ. Түүнтэй уулзахад юу саад болов? Өмнөх нөхөрлөл нь үү эсвэл айдас уу? Магадгүй Альбус Дамблдор залуу байхдаа бахдаж байсан хүний эсрэг тэмцэхэд зүрхээ чангалж байсан байж болох юм.

Юутай ч Арианагийн үхэл нууц хэвээр үлджээ? Тэр санаандгүй хар урлагийн ёслолын хохирогч болсон юм болов уу? Эсвэл хоёр залуу найзын эрх мэдэл алдарт хүрэх төлөвлөгөөнөөс мэдэх ёсгүй зүйлээ мэдсэн юм болов уу? Өөрөөр Дамблдорын «аугаа их сайн сайхны» анхны хохирогч болсон юм биш байгаа даа?

Энд бүлэг дуусчээ. Харри толгойгоо өргөхөд, Гермиона хуудсыг түүнээс урьд уншиж дууссан байлаа. Тэр номыг Харрийн гараас аваад царай руу нь айсан байртай харлаа.

- Харри ...

Гэсэн ч тэр толгойгоо сэгсэрлээ. Дотоод сэтгэлд нь ямар нэг зүйл хугарах шиг болов. Роныг явах үед яг л ийм байсан юм.

Тэр Дамблдорт итгэж цэцэн мэргэн сайхан сэтгэлтэй гэж бодож байтал энэ бүхэн хөөс болон замхарлаа. Үүнээс ихийг алдаж болно гэж үү? Рон, Дамблдор, галт шувууны өдтэй шидэт саваа ...

- Харри! Намайг сонс. Энэ ... мэдээж уншихад тийм ч таатай биш зүйл байна ... гэж Гермиона бодлыг нь сонссон аятай хэлэв.

- Тийм шүү хэлэх ч юм биш.

- Гэхдээ үүнийг Рита Скитер бичсэн гэдгийг бүү март, Харри.

- Чи түүний Гриндевальдад бичсэн захиаг уншсан биз дээ?

- Би ... Тиймээ уншсан гээд тэр сэтгэлээр унасан байртай гартаа барьсан хөрсөн цайгаа савчаад,

- Магадгүй энэ бүхнээс дор байх. Батильда зөвхөн тэдний Гриндевальдын уриа болох «аугаа их сайн сайхан» гэсэн үгийг сонссоноо хэлсэн. Тэгээд ... бас ... Дамблдор түүнд санаа төрүүлсэн бололтой. Түүнийг Нурменгардад хүртэл

«аугаа их сайн сайхан» гэж бичсэн байдаг гэж ярьцгаадаг гэв.

- Нурменгард гэдэг чинь юу юм бэ?

- Гриндевальдын өрсөлдөгчдөө хорьдог байсан шорон. Дамблдор эцэст нь түүнийг ялах үед өөрөө дотор нь суусан юм. Ямар ч гэсэн Дамблдор Гриндевальдын эрх мэдэлд хүрэх санааг дэмжиж гэж байсан гэж бодохоос ч аймшигтай юм. Гэхдээ өөр өнцгөөс бол Рита Скитер тэдний хэдхэн сар найз байсныг мэдэж байгаа тэд хоёулаа залуухан ...

- Би чамайг ингэж хэлнэ гэдгийг чинь мэдэж байсан гээд Харри уурласан хоолойгоо нуулгүй,

- Яг «Тэднийг залуу байсан учраас» гэж хэлэхийг чинь мэдэж байсан юм. Тэд бидэн шиг л байсан! Бид амьдралаа эрсдэлт оруулан хар урлагийн эсрэг тэмцэж байхад тэр миний насан дээр сайн найзтайгаа нийлэн маглуудыг ноёрхох төлөвлөгөө зохиож байж! гэв.

Харри цааш тэвчиж чадалгүй үсрэн босоод тойрог дотор цааш явлаа.

- Би Дамблдорыг хамгаалах гээгүй байна. Энэ бүхэн бол «Шидийн хүч» гэдэг шиг дэмий үг. Гэхдээ Харри түүний эх нь үхээд ганцаар үлдсэн болохоор ...

- Ганцаар гэнээ? Тэр ганцаар байгаагүй! Түүнд эрэгтэй дүү бас сангасваа ч гэсэн эмэгтэй дүү байсан ч цоожтой байлган ...

- Би үүнд итгэхгүй байна гээд Гермиона бас бослоо.

- Түүний ямар байсныг мэдэхгүй байгаа ч сангасваа байсан гэж бодохгүй байна. Бид Дамблдорыг хэзээ ч ийм зүйлийг зөвшөөрөхгүй гэдгийг мэдэж байгаа болохоор ...

- Дамблдор маглуудыг ноёрхох гээгүйг бид мэднэ! гэж Харри орилоход дуу нь хоосон толгод дээгүүр цуурайтаж хэдэн хэрээ гуагласаар бүрхэг тэнгэр лүү нислээ.

- Тэр өөрчлөгдсөн, Харри! Зүгээр л өөрчлөгдсөн тэгээд л тэр! Магадгүй арван долоон насандаа энэ бүх дэмий зүйлд итгэж байсан байж болох ч үлдсэн амьдралаа хар урлагийн эсрэг тэмцэхэд зориулсан! Зөвхөн тэр л Гриндевальдыг зогсоож, үргэлж магл болон магл гаралтай шидтэнгүүдийг хамгаалах талаар үг хэлэн, Хэцүү нэрттэй эхнээсээ тэмцээд тулаанд үхсэн!

Газар хэвтэж байсан Рита Скитерийн номны хавтсан дээрээс Дамблдор тэдэн рүү гашуудалтай инээмсэглэв.

- Харри уучлаарай гэхдээ чи Дамблдор энэ бүхнийг өөрөө хэлээгүй учраас л уурлаад байгаа байх!

- Магадгүй л юм! гэж Харри уурсаад уураа хилэнгээ дарахын тулд толгойгоо тэвэрлээ.

- Түүний надаас юу шаардаж байсныг бодоод үз, Гермиона! Амьдралаа эрсдэлд оруул, Харри! Ахин нэг удаа! Тэгээд ахиад дахин! Ямар ч тайлбар хүлээх хэрэггүй сохроор итгэх ёстой. Итгэ би юу хийхийг мэдэж байна хэдийгээр би чамд итгэхгүй байгаа ч гэсэн надад итгэ! Нэг ч удаа бүх үнэнийг хэлээгүй! Нэг ч удаа шүү!

Харрийн хоолой цахиртлаа. Тэд хоосон цагааны дунд зогсоод бие биенийгээ ширтэхэд Харри энэ уужим тэнгэрийн дор хорхой шавьж шиг хичнээн өчүүхэн болохоо мэдэрлээ.

- Тэр чамд хайртай байсан. Хайртай байсныг нь би мэдэж байна гэж Гермиона шивнэлээ.

Харри гараа буулгав.

- Түүнийг зөвхөн надад хайртай байсныг мэдэхгүй байна, Гермиона. Гэхдээ энэ бол хайр биш тэр намайг заваан зүйлд хутгасан. Чөтгөр гэж, тэр Геллерт Гриндевальдтай надаас илүү нээлттэй байсан байх!

Харри цасан дээр унасан Гермионагийн шидэт сабааг аваад ахиад майхны үүдэн дээр суулаа.

- Цай өгсөн явдалд баярлалаа. Би харуулаа дуусгая. Чи дотор ороод дулаахан бай.

Гермиона түүний хөөж байгааг ойлгосон бололтой номоо аваад майхан руу орохдоо толгойны оройг нь хөнгөхөн илбэв. Харри нүдээ аниад Дамблдор түүнд санаа тавьсан гэдэг үгэнд нь итгэхийг хүсч байгаадаа өөрийгөө үзэн ядлаа.

БҮЛЭГ 19: МӨНГӨН СОГОО

Гермиона түүний халааг шөнө дунд авах үед цас орж байлаа. Харри зул сарын цэцгэн хэлхээний оронд Нагайна түүнийг ороож байна гэсэн түгшүүртэй зүүд зүүдэлжээ. Тэр айдаст автан байн байн сэрээд алсад хэн нэгэн дуудаж байгаа юм шиг санагдаж майхан дэрвүүлэн салхи исгэрэхэд хөлийн чимээ хоолой сонсогдох шиг болов.

Эцэст нь харанхуйд босож Гермиона руу гарлаа. Тэр майхны үүдэн дээр суугаад шидэт савааны гэрэлд «Ид шидийн түүх» уншиж байв. Цас лавсан орж байсан тул Гермиона түүний эрт юмаа цуглуулан цааш хөдлөхийг санал болгосон явдалд баярлалаа.

- Явж салхигүй газар олъё гэж тэр зөвшөөрөөд чичирэн хөвөнтэй цамцан дээрээ хүрмээ давхарлан өмсч,

- Надад үргэлж хэн нэгэн тойроод яваад байх шиг санагдлаа. Бүр хоёр ч удаа харагдах шиг болсон гэв.

Харри хөшөөд ширээн дээр хөдөлгөөнгүй чимээгүй байгаа вредноскоп руу харлаа.

- Магадгүй санагдсан ч байж болох юм. Цастай харанхуй байсан болохоор нүд хуурсан байж болзошгүй ... Гэхдээ бид үл үзэгдэх цуван дор шилжсэн нь дээр байх тийм үү? гэж Гермиона түгшсэн янзтай хэлэв.

Хагас цагийн дараа майхан хумхигдаж, Харри хүзүүндээ крестражыг зүүгээд, Гермиона гартаа шүрэн цүнхээ барьж шилжлээ. Тэгтэл дасал болсон дарамттай харанхуйн дараа цастай талбай дээр газардтал хөлдүү газар навчин дунд унав.

- Бид хаа байна? гээд Харри орчин тойрноо хүрээлсэн өтгөн ойг харахад

Гермиона цүнхнээсээ майхны багана гаргаж ирлээ.

- Дин вангийн ойд. Би ийшээ ээж аав хоёртой хамт ирж байсан юм.

Энд модод цасанд хучигдаж аймшигтай хүйтэн байсан ч тийм их салхитай байсангүй. Харри, Гермиона хоёр бараг өдөржингөө майхандаа суулаа. Гермиона дулаацахын тулд цэнхэр дөлтэй гал гаргасан бөгөөд гартаа бариад шилэн савтай нь зөөж болох аж. Харрид түүний халамж анхаарлаас богино хугацаанд хүнд өвдсөний дараа эдгэрсэн юм шиг санагдав. Үдэш болох үед ахиад цас орж тэдний майхан хучигдлаа.

Нойргүй өнгөрөөсөн хоёр шөнийн дараа Харри таагүй сэтгэгдэл төрөв. Тэдний Годрикийн хонхорт болсон зугталтын дараа Волдеморт илүү ойрхон аймшигтай санагдах болжээ. Харанхуй болох үед Гермиона халаа авах гэсэн ч татгалзаад түүнд унтаж амрахыг зөвлөв.

Харри майхны үүдэнд буйдангийн хуучин дэр тавиад суулаа. Тэр бүх цамцаа давхарлаж өмссөн ч даарсандаа чичирч байв. Харанхуй улам өтгөрсөөр цагийн дараа улам нэвтрэшгүй болов. Харри Тэнүүлчний газрын зургаа гаргаж ирээд Жиннигийн

нэрийг хайн харснаа зул сарын баярын амралт болсон болохоор Үүрэнд харьсаныг нь саналаа.

Аврага том ойд өчүүхэн чимээ олон дахин цуурайтан сонсогдоно. Харри ойд янз бүрийн амьтан байдгийг мэдэх хэдий ч дайснаа чимээгүй дөхөхийг нь ялгахын тулд чимээгүй байгаасай гэж хүслээ. Тэгтэл олон жилийн өмнө навчин дээгүүр гулган хөдөлж байсан жанчтай дүрсийг санатал одоо сонсогдох шиг болсонд бодолдоо агзасхийлээ. Хамгаалалтын шившэг хэдэн долоо хоногийн турш бүрэн ажиллаж байгаа ч өнөөдөр нэг л зүйл өөрчлөгдсөн мэт ажээ.

Тэрбээр хэдэн удаа тухгүй байдалд зүүрмэглэн майхны ханыг налснаа толгойгоо өргөж харахад хүзүү нь янгинав. Эргэн тойрон шилжилтийн дунд гацсан юм шиг гүн харанхуйлна. Харри гараа нүүрнийхээ урд өргөөд харах гэсэн ч чадсангүй.

Тэгтэл түүний урд модон дундаас хурц мөнгөлөг гэрэл асан майхан руу чимээгүйхэн ойртон ирлээ.

Харри үсрэн босоод Гермионагийн сабааг дээш өргөхөд хашгиралт хоолойд нь тээглэв. Гэрэл улам хурц болсоор мододын дундаас хар дүрс сүүмэлзэхэд Харри нүдээ онийлгон харлаа ...

Дараа нь гэрлийн эх сурвалж модны араас гарч ирэв. Энэ бол мөнгөлөг цагаан согоо байсан бөгөөд сарны гэрэл шиг нүд гялбам гийж байлаа. Тэр туурайгаа уян налархай зөөн тавьж чимээгүй явахдаа цасан дээр мөр үлдээсэнгүй. Тэгээд Харри руу дөхөж ирснээ үзэсгэлэнтэй толгойгоо өргөн урт сормуустай том нүдээрээ харав.

Харри түүн рүү харахад энэ хачирхалтай амьтан ойр дотно юм шиг мэдрэмж төрлөө. Тэр түүнийг ирэхийг хүлээж байсанаа мартсан байснаа одоо гэнэт санасан мэт болов. Түүнд Гермионаг дуудах хүсэл байсангүй. Гайхамшигтай амьтан зөвхөн түүн рүү ирсэн гэж мөрийцөхөд бэлэн байлаа.

Тэд хэсэг зуур бие биенээ ширтсэний эцэст дараа нь согоо цааш эргэн явлаа.

- Хүлээгээрэй! Эргээд ирээч! гэж Харри удаан хугацаанд чимээгүй байж сөөсөн хоолойгоор хэлэв.

Согоо цаашаа ойн гүн рүү ороход мододын харанхуй их биенүүд гэрэлд зурсхийн үзэгдэв. Харри агшин зуур чичирэн тээнэгэлзлээ. Болгоомжтой байдал энэ занга байж магадгүй гэж шивнэж байсан ч зөн совин нь энд хар шид үгүй гэдгийг хэлж байв. Харри араас нь явлаа.

Согоо чимээгүйхэн явах учир хөлийх нь дор цас чахрахаас ондоо чимээ үл дуулдана. Тэр цаашаа ойн гүн рүү хөтлөн явлаа. Харри удахгүй түүнийг зогсож ойртох боломж өгнө гэдэгт итгэлтэй байсан учир араас нь яаран явлаа. Тэгвэл тэр түүнтэй ярилцаж хэрэгтэй бүх зүйлээ мэдэх болно.

Тэр эцэст нь зогсож үзэсгэлэнтэй толгойгоо эргүүлэв. Харри гүйлээ. Асуулт хэдийн аманд нь эргэлдэж байсан авч амаа нээж амжихаас өмнө алга болов.

Харанхуй түүнийг залгихад гялалзсан толбо нүдний өмнө үзэгдсэн хэвээр харахад нь саад болов. Харри нүдээ анивчихад гэрэл улам хурц боллоо. Согоог байгаа цагт аюулгүй гэдгээ мэдэрч байсан болохоор одоо гэнэтхэн аймшигтай болов.

- Люмос! гэж тэр шивнэлээ. Сабааны үзүүрээс гэрэл асав.

Мөнгөлөг согоо алга болжээ. Харри нүдээ анивчин зогсоод алсад мөчир хугарах цас аяархан хяхтнах чимээ сонслоо. Түүн рүү одоо дайрах юм болов уу? Түүнийг үнэхээр занганд оруулаа гэж үү? Тэнд сабааны гэрэл хүрэхээргүй газар үнэхээр хэн нэгэн зогсоод харж байгаа юм биш байгаа даа?

Тэр саваагаа өндөр өргөлөө. Хэн ч түүн рүү дайрсангүй бөгөөд модны цаанаас ногоон оч гарсангүй. Тэр яах гэж түүнийг ийш нь авчирсан юм бол?

Шидэт сабааны гэрэлд ямар нэг зүйл гялсхийхэд Харри эргэж харсан ч ердөө л жижигхэн хөлдсөн нуур байсан хэрэг байж. Харанхуй мөс гялсхийхэд Харри сайн харахын тулд саваагаа өргөлөө.

Тэр болгоомжтойгоор доош харсаар эрэг рүү дөхөв. Мөсний гадарга дээр сабааны гэрэл тусахад гүнд нь саарал зүйл гялтагнав ... том мөнгөн загалмайтай төстэй юм ...

Харрийн зүрх хэнхдэгээсээ гарах шахам үсчин цохилов. Тэр цасан дээр өвдөглөн унаад ёроолыг гэрэлтүүлэхийн тулд саваагаа мөсөнд тулгалаа. Бараан улаан өнгийн зүйл гялтагнаж харагдана ... Энэ чинь илдний бариулын бадмараг байна шүү дээ ... Ойн нуурын ёроолд Гриффиндорын илд хэвтэж байна.

Харри түүн рүү амьсгаа даран харлаа. Яаж ийм зүйл байж болох юм бэ? Энэ бөглүү ойд майхны хажуухан талд нь илд хаанаас гараад ирэв? Ямар шид Гермионаг энэ газрыг сонгоход хүргэж согоо эхэндээ Патронус шиг санагдсан ч үнэн хэрэгтээ нуурын хамгаалагч байсан гэж үү? Эсвэл илд нууранд тэднийг энд ирсний дараа орсон юм биш байгаа даа? Тэгвэл үүнийг хийсэн хүн одоо хаана байна? Харри ахин саваагаа эргэн тойрны мод бут руу тусган харсан ч тэдний дунд хүний дүрс байсангүй бөгөөд хэнийг ч харсангүй. Түүний айж хөөрсөн сэтгэл нь хөлдүү нуурын ёроол дахь илд рүү буцан ирлээ.

Харри саваагаа мөнгөлөг дүрс рүү чиглүүлээд нам дуугаар,

- Акцио, илд! гэлээ.

Илд хөдөлсөнгүй бөгөөд Харри ч үүнийг хүлээсэнгүй. Тийм амархан байсан бол илд хөлдүү нуурын ёроолд биш зүгээр л газар хэвтэж байх байсан биз. Харри дугуй мөсийг тойрон явахдаа өнгөрсөн удаад илдийг яаж гаргаж ирснээ саналаа. Тэр тэгэхэд аймшигтай аюултай байдалд тусламж гуйсан билээ.

- Туслаач! гэж Харри шивнэсэн ч илд усны ёроолд хөдөлгөөнгүй хайхрамжгүй хэвээр үлдэв.

Харри ахин нуурыг тойрлоо. Дамблдор сүүлийн удаа илдийг гаргахад юу гэж хэллээ? Илдийг малгайнаас зөвхөн жинхэнэ Гриффиндорын хүн л гаргаж чадна гэсэн. Харин жинхэнэ Гриффиндорын хүнд ямар зан чанар байдаг билээ? Харрийн толгойд хуваарилагч бүрх малгайны дууны үг хальт орж ирэв.

Тэр зогсоод уртаар санаа алдахад хүйтэн агаарт уур гарснаа түргэн замхрав. Одоо л юу хийх ёстойгоо мэдлээ. Үнэндээ илдийг анх мөсөн дор харсан цагаас хойш үүнээс болгоомжилж байсан билээ.

Тэр ахин эргэн тойрны мододыг харж хэн ч довтлох гээгүйг шалгав. Хэрвээ мододын дунд дайсан нуугдаж байсан бол Харриг нуурын ёроол шагайж байхад дуусгах цаг хангалттай байсан биз. Үгүй, тэр таагүй ажил хийх мөчөөс зугтахыг хүсч байгаа хэрэг.

Харри хуруугаараа эрэн тэмтчээд олон тооны цамцаа тайлж эхэллээ. Ойлгомжгүй хэдий ч Гермионаг нуур руу хамт авчраагүйдаа талархах сэтгэл төрөв.

Алсад ууль гууглахад Хэдвигийг санаад сэтгэл нь шимширлээ. Тэрбээр хүйтэнд даарсандаа чичирч шүд нь тачигнаж эхэлсэн цааш ч тайлсаар богино өмдтэйгээ үлдэж цасан дээр нүцгэн хөлөөрөө зогслоо. Эцэст нь овоолсон хувцсан дээрээ хугарсан шидэт саваа, ээжийнхээ захиа, Сириусын толины хагархай, хуучин снитчтэй хүүдийг тавилаа. Харри Гермионагийн савааг мөс рүү чиглүүлэн даллав.

- Диффиндо!

Мөс нам гүмийг эвдэн бууны сум шиг тасхийж хагархай нь харанхуй усанд хөвлөө. Харри хэр гүн болохыг мэдсэнгүй ч илдийг авахын тулд усанд бүрэн шумбах хэрэгтэй байлаа.

Энэ нь ус дулаахан байсан ч биелүүлэхэд амаргүй даалгавар байв. Харри усны хөвөө рүү алхаад гэрэлтэй саваагаа газар тавьж хэр хүйтэн байх талаар бодохгүйг хичээн харайлаа.

Усанд мөрөө хүртэл ороход биеийнх нь хэсэг бүр янгинан өвдөж уушгинд нь хүйтэн агаар дүүрлээ. Тэр амьсгалах аргагүй чичирч байсан тул ахин хоёр удаа шумбахгүйн тулд мэдээ алдсан хөлөөрөө илдийг мэдэрлээ.

Тэгээд амьсгаадан чичирсээр сүүлчийн хүчээ гарган шумбалаа.

Хүйтэн аймшигтай байж биеийг нь гал шиг хайран тархи нь хүртэл хөлдөх шиг болов. Тэр харанхуй усны ёроолд хүрч илдний бариулаас атгалаа.

Тэр илдийг дээш нь гаргатал ямар нэг зүйл хүзүүнээс нь чангаав. Харри замаг байх гэж бодсон ч шумбахад юу ч тааралдаагүй тул гараа явуулан суллахыг хичээтэл замаг биш крестражын гинж чангаран хоолойг нь боож байгаа болохыг ойлгов.

Харри хөлөөрөө хүчтэй тийрэн усны гадарга руу гарахыг хичээсэн ч усан дор хадагджээ. Тэр хахаж цацан машгиралдаж боомилсон гинжнээс бээрсэн хуруугаараа зууртал толгойд нь янз бүрийн өнгийн оч гэрэлтэж юу хийж байгаагаа мэдэхээ болиод цээжинд нь үхлийн гар хүрч ...

Тэр ухаан ороход амьдралдаа байгаагүйгээрээ норж дааран хахаж цацан ханиалгаад нүүрээ цасанд наан хэвтэж байлаа. Түүний дэргэд хэн нэгэн амьсгаадан ханиалгаж эрэг дээгүүр явлаа. Гермиона могойтой үеийнх шиг ахиад туслахаар ирж ... Үгүй төсгүй юм ... хэтэрхий сөөнгө ханиалт, хүнд алхаа байна ...

Харрид толгойгоо өргөн аврагчаа харах хүч байсангүй. Тэр чичирсэн гараа өргөн зүүлт байсан газар хүрлээ. Зүүлт алга болжээ ... Хэн нэгэн гинжийг тасалсан байв. Тэгтэл дээр нь хоолой сонсогдож,

- Чи ... чинь ... галзууpаа юу? гэлээ.

Энэ гайхширсан хоолой Харрид хөл дээрээ босох хүчийг өгөв. Тэр бүх бие нь чичирсээр найган зогсож харвал урд нь голдоо хүртэл норсон Рон хувцастайгаа зогсоод үс нь царайдаа наалдсан бөгөөд нэг гартаа Гриффиндорын илд, нөгөө гартаа крестражны тасарсан гинжийг барьсан байлаа.

- Ямар чөтгөрөө хийж үүнийг усанд орохын өмнө тайлаагүй юм бэ? гэж Рон крестражыг урагш хойш ховсдож буй мэт савчин хэлэв.

Харри хариулсангүй үг ч гарсангүй. Роны эргэж ирсэнтэй харьцуулахад мөнгөн согоо юу ч биш байлаа. Тэр үүнд итгэж чадсангүй тул хүйтэнд чичирсээр эрэг рүү очин хувцаслаж эхлэв. Цамцаа ар араас нь ээлжлэн өмсөж байх зууpаа Роны алга болохыг хүлээж байсан ч байрандаа зогссон хэвээр үлдэв. Тэр Харриг аврахын тулд нууранд бас умбажээ.

- Энэ чи юу? гэж Харри эцэст нь боож үхэх гэж байсан хүний хоолойгоор шүдээ хавшин асуулаа.

- Аанхан гээд Рон ичингүйрэн харав.

- Согоог чи гаргасан уу?

- Юу гэнээ? Үгүй дээ! Би чинийх гэж бодсон!

- Миний Патронус буга шүү дээ.

- Аан тийм л дээ надад тэр жаахан өөр юм шиг санагдсан. Эвэргүй байсан.

Харри Хагридын хүүдийг ахин хүзүүндээ зүүгээд сүүлчийн цамцаа өмсөж Гермионагийн шидэт сабаг аван Рон руу эргэлээ.

- Чи хаанаас гараад ирэв?

Рон харваас энэ асуулт хожим тавигдана гэж найдсан ч бүтсэнгүй бололтой.

- Чи ойлгож байгаа биз дээ ... би ... би эргээд ирлээ. Хэрвээ гээд хоолой засан ханиалгаснаа,

- Чи мэднэ дээ. Хэрвээ намайг байлгахыг хүсч байвал гэв.

Нам гүм болов. Роны салж явсан нь тэдний хооронд хана босгожээ. Гэхдээ тэр одоо энд байна. Тэр эргээд ирлээ. Тэр дөнгөж сая Харрийн амьдралыг аварлаа.

Рон гартаа барьж байгаа зүйлээ гайхширан харлаа.

- Аан тийм л дээ би үүнийг гаргасан гээд тэр Харрид илдийг үзүүлж,

- Чи түүний төлөө шумбасан биз дээ? гэв.

- Аанхан. Гэхдээ би чамайг энд яаж ирснийг ойлгохгүй байна? Чи биднийг яаж олсон юм бэ?

- Яривал удаан түүх болно. Би та нарыг хэдэн цагийн өмнөөс хайж байсан ч ой том болохоор амаргүй байлаа. Тэгээд модны дор хоноглодог юмуу гэж бодож байтал буга араас нь чи явж байхыг харсан юм.

- Чи өөр хэнийг ч хараагүй юм уу?

- Үгүй. Би ... гээд тэр тээнэгэлзэн бие биедээ шахцалдан ургасан хоёр мод руу харлаа.

- Надад тэнд юм хөдлөх шиг санагдсан ч чи усан дороос гарч ирээгүй болохоор яарах хэрэгтэй байлаа ... хөөе!

Харри хэдийн Роны заасан газар руу гүйжээ. Ойролцоо ургасан хоёр царс шахцалдан нийлээд дунд нь жижигхэн завсар байлаа. Модны эргэн тойронд цасан дээр мөр байсангүй. Харри гартаа илд, крестраж барьсан хэвээр зогсох Рон руу эргэж ирлээ.

- Ямар нэг зүйл олов уу?

- Үгүй.

- Илд яаж нууранд орсон юм бол?

- Түүнийг Патронусыг илгээсэн хүн хийсэн байх.

Хоёул мөнгөн илд рүү харахад бариулынх нь бадмааараг Гермионагийн сабааны гэрэлд гэрэлтэв.

- Чи үүнийг жинхэнэ гэж бодож байна уу? гэж Рон асуув.

- Шалгах ганцхан л арга байгаа биз дээ?

Крестраж урьдын адил Роны гарт савчина. Зүүлт үл мэдэг чичирлээ. Харрид түүний дотор байгаа амьтан түгшиж байх шиг санагдав. Тэр аюул ослыг мэдрээд Харрид илдийг эзэмдүүлэхгүйн тулд алах гэсэн. Удаан ярих хэрэг байсангүй зүүлтийг үүрд устгах хэрэгтэй байлаа. Харри саваагаа өндөрт өргөн тохиромжтой газар харснаа агч модны сүүдэрт байгаа хавтгай чулууг харлаа.

- Ийшээ явъя! гээд Харри түрүүлж очоод чулууны цасыг нь арилган крестраж руу гар сунгав. Рон эхлээд илдийг өгсөн авч Харри толгой сэгсрээд,

- Үгүй ээ чи үүнийг хийх ёстой гэлээ.

- Би юу? Яагаад? гэж Рон гайхав.

- Чи илдийг нуураас гаргасан болохоор ... тэр чинийх.

Харри өгөөмөр сэтгэлтэй дүр эсгэх гэсэнгүй. Тэр согоог аюулгүй гэж мэдэрч байсан болохоор Рон илдийг нэг удаа эзэмших ёстойг мэдэж байлаа. Энэ шударга байх болно. Дамблдор Харриг үүнд сургасан билээ.

- Би түүнийг онгойлгохоор чи илдээр цавчаарай. Шууд шүү, ойлгов уу? Учир нь энэ зүйл тэмцэх болно. Реддлийн тэмдэглэлийн дэвтэрт амьдарч байсан хэсэг намайг арай л дуусгачихаагүй.

- Чи түүнийг яаж онгойлгох гэж байгаа юм? гэж Рон айн асуулаа.

- Могойн хэлээр гуйх болно.

Хариулт сэтгэлийн гүндээ мэдэж байсан юм шиг аманд нь бэлхэн ороод ирсэнд Нагайнатай уулзсан явдал тусалсныг ойлголоо. Тэр гялалзсан ногоон чулуун дээрх мушгирсан «С» үсэг рүү хараад хүйтэн чулуу ороосон жижигхэн могой гэж төсөөлөхөд төвөггүй байв.

- Зогс! Битгий онгойлго! Би жинхэнээсээ хэлж байна шүү! гэж Рон хашгирав.

- Яагаад? Энэ хараал идсэн зүйлээс салцгаая ...

- Харри, би чадахгүй. Үнэнээсээ хэлж байна шүү ... чи хийсэн нь дээр байх ...

- Яагаад?

- Яагаад гэвэл энэ зүйл надад муугаар нөлөөлдөг юм! гээд Рон зүүлтний хэвтэж байгаа чулуунаас ухраад,

- Би түүнтэй тэмцэж чаддаггүй! Би өөрийгөө цагаатгах гэсэндээ ч юм биш тэр надад Гермиона та хоёроос илүү хүчтэй нөлөөлдөг. Элдэв янзын аймшигтай бодол орж ирдэг. Яагаад гэдгийг нь тайлбарлаж чадахгүй ч түүнийг тайлмагц

... толгой дахь зүйлээ буцаан тавьж байгаа юм шиг болдог ... Би үүнийг хийж

чадахгүй, Харри! гэв.

Тэр цааш илдийг чирэн холдоод нойтон толгойгоо сэгсэрлээ.

- Чи үүнийг хийж чадна! Чи илдийг гаргасан болохоор ашиглах ёстой. Гуйж байна түүнээс салцгаая даа, Рон!

Өөрийнхөө нэрийг сонссон нь Ронд сэргээгч ундаа шиг үйлчлэв бололтой. Тэр шүлсээ залгиад хүндээр амьсгаадсаар ахин чулуу руу очлоо.

- Болохоор нь хэлээрэй гэж тэр сөөнгөтөн гуйв.

- Гурав хүртэл тоолъё гэж Харри хэлэв.

Тэр зүүлт рүү хараад «С» үсэг дээр төвлөрч могой шиг төсөөлөн бодтол санганд орсон жоом шиг татвалзан үсчив. Харри хүзүү халуу оргисон хэвээр байгаа болохоор өрөвдөхгүй байхад амархан байлаа..

- Нэг ... хоёр ... гурав ... Нээгдээрэй!

Сүүлчийн үгийг тэр исгэрэн хэлэхэд гууны алтан хаалт чагхийн нээгдлээ. Тэгтэл дотор нь шилэн дээр амьд нүд эргэлдэж байлаа. Том Реддлийн босоо хүүхэн хараатай улаан өнгөтэй болохоос өмнөх үзэсгэлэнтэй хар нүд.

- Цохь гээд Харри онгойлгосон зүүлтийг чулуун дээр дарлаа.

Рон чичирсэн гараар илдийг өргөхөд нүд галзуурсан мэт эргэлдэв. Харри зүүлтийг чанга бариад хагарсан шилнээс цус гарч байна гэж төсөөлөв.

Тэгтэл крестражаас хоолой сонсогдлоо.

- Би чиний зүрхийг харж байна, тэр минийх!

- Түүнийг бүү сонс! Цохь! гэж Харри сөөнгөтөв.

- Би чиний зүүдийг харсан Рональд Уизли. Би чиний айдсыг харсан. Чиний бүх хүсэл биелэгдэх боломжтой, айж байсан ч биелэгдэх боломжтой ...

- Цохиорой! гэж Харри орилоход хоолой нь мододын дунд цуурайтлаа. Роны илдний үзүүр чичирэн Реддлийн нүднээс харц салгаж чадсангүй.

- Ээжийн хайргүй хүү тэр үргэлж охинтой болохыг мөрөөддөг байсан ... Найз охиноо ч тогтоож чадаагүй тэр чиний найзыг сонгосон ... Үргэлжид хоёрдугаарт байж, үргэлж сүүдэрт байдаг ...

- Рон түргэн цохь! гэж Харри орилоод зүүлт гаран дор нь тохиолдох явдлаас айн цовхчихыг мэдэрлээ. Рон илдийг улам өндөрт өргөхөд Реддлийн нүд улаанаар ярсхийв.

Тэгтэл зүүлтний гуунаас хөөс адил Харри, Гермиона хоёрын муруйсан толгой урган гарч ирэв.

Рон айн хашгираад ухрахад дүрс үргэлжлүүлэн ургасаар цээж, бүсэлхий, хөл гарч ирээд модны их биеэс салаалсан юм шиг Харри, Рон хоёрын урд зогслоо. Зүүлт цайрталаа халахад Харри гараа угз татан авлаа.

- Рон! гэж тэр хашгирсан ч тунгалаг Харри хэдийн Волдемортын хоолойгоор ярьж Рон царай руу нь мэлрэн ширтэнэ.

- Чи яах гэж эргэж ирсэн юм? Бидэнд чамгүйгээр хамаагүй дээр аз жаргалтай байж явсанд чинь баяртай байсан ... Бид чиний аймхай, тэнэг, өөртөө итгэлгүй занг шоолон инээлдэж байлаа ...

- Өөртөө итгэлгүй! гэж тунгалаг Гермиона дэмжив.

Тэд жинхэнээсээ илүү үзэсгэлэнтэй аймшигтай агаад Рон руу харан хөхрөхөд айдаст автан илдийг хүчгүй болгон буулгалаа.

- Харри Поттерын дэргэд чи хэнд хэрэгтэй юм бэ? Чи сонгогдсон хүүтэй харьцуулахад юу хийсэн юм бэ? Чи амьд үлдсэн хүүтэй өрсөлдөж чадна гэж үү?

- Цохь, Рон ЦОХЬ! гэж Харри хашгирсан ч Рон хөдөлгөөнгүй зогсоод томоор нээсэн нүдэнд нь тунгалаг Харри, Гермиона хоёрын дүрс тусав. Тэдний үс гал шиг улалзан, нүд нь улаанаар эргэлдэх агаад муу ёрын хоолойгоор хоршин ярилаа.

- Чиний ээж намайг өөрийнхөө хүү болгохыг хүссэн гэж хэлсэн. Тэр чамайг надаар солихдоо баяртай байна гэж хэлсэн хэмээн хуурамч Харри хэлэв.

- Нэг ч эмэгтэй чамайг сонгохгүй! Чи түүний дэргэд юу ч биш гэж тунгалаг Гермиона хэлээд тунгалаг Харриг могой шиг ороон тэвэрлээ. Тэдний уруул үнсэлдэв.

Рон тэдэн рүү зовж тарчилсан өнгөөр харснаа илдийг чичирсэн гараараа өргөлөө.

- Алив, Рон! гэж Харри орилов.

Рон түүн рүү харахад Харри нүдэнд нь улаан оч харвасныг олж харлаа.

- Рон!

Илд гялсхийн цавчихад Харри хажуу тийш ухасхийгээд төмөр жингэнэх чимээ сонсож дараа нь удаанаар орилох дуу гарав. Харри эргэж хараад тэмцэхэд бэлэн шидэт саваагаа өргөсөн ч юу ч байсангүй.

Гермиона тэр хоёрын аймшигтай хуулбар ул мөргүй алга болжээ. Рон илдийг буулгаад чулуун дээрх эвдэрсэн зүүлтний үлдэгдэл рүү харж байлаа.

Харри удаанаар түүн рүү очихдоо юу хэлэхээ мэдсэнгүй. Рон хүндээр амьсгаадана. Түүний нүд ахин хэвийн цэнхэр өнгөтэй болсон ч нойтон нулимстай байлаа.

Харри юу ч хараагүй дүр эсгэн эвдэрсэн крестраж руу тонгойлоо. Рон шилийг хагалсан болохоор Реддлийн нүд алга болж дотроос нь үл мэдэг утаа уугиж байв. Крестражад амьдарч байсан амьтан устжээ.

Рон илдийг хангинуулан газар унагаад өвдгөн дээрээ лагхийн сууж толгойгоо барилаа. Тэр даарсандаа биш ч чичирч байв. Харри эвдэрсэн зүүлтийг халаасандаа хийгээд дэргэд нь сууж гараа болоомжтой мөрөн дээр нь тавилаа.

- Чамайг явсны дараа тэр бүтэн долоо хоног уйлсан. Магадгүй цаашид уйлсан байж болох ч надад харуулахыг хүсээгүй. Тэр орой бид юу ч ярилцаагүй. Чамайг байхгүйд ...

Тэр үгээ дуусгаж чадсангүй. Одоо Рон эргэж ирсэн болохоор байхгүй байсан нь ямар байсныг жинхэнэ утгаараа ойлголоо.

- Тэр миний дүү шиг байдаг. Би түүнд дүү шигээ хайртай. Түүнийг ч гэсэн надад тэгж ханддаг гэж бодож байна. Үргэлж ийм байсан. Би чамайг үүнийг мэднэ гэж бодож байна.

Рон хариулсангүй цааш эргээд хамраа ханцуйгаараа чимээтэй арчлаа. Харри хөл дээрээ босоод хэдэн алхам холдож Роны ус руу шумбахын өмнө эрэг дээр үлдээсэн том үүргэвчийг харлаа. Харри үүргэвчийг нуруундаа үүрээд буцаж ирэв. Тэр улаан нүдтэй босож ирсэн ч өөрийгөө бүрэн эзэмдсэн байлаа.

- Уучлаарай. Би явсандаа харамсаж байна. Би мэдэж байсан ... Тэр харанхуй руу тохирох хараалын үг олдоно гэж найдсан мэт харав.

- Чи өнөөдөр энэ бүхнийгээ заслаа. Илдийг гаргасан. Крестражыг дуусгалаа.

Миний амьдралыг аварсан.

- Миний байгаагаас илүү янзтай сонсогдож байна гэж тэр бувтналаа.

- Харин энэ үргэлж миний хувьд янзтай сонсогддог. Би чамд олон жилийн өмнөөс энэ тухай хэлэх гэж байсан юм.

Тэд нэгэн зэрэг урагш алхан бие биеэ тэврэхэд Харрийн гарт Роны нойтон хүрэм баригдав.

- Одоо майхнаа хайж олох хэрэгтэй байна гэж Харри бие биеэсээ холдоход хэлэв.

Гэсэн ч майхан түвэггүй олдов. Харрид харанхуй ойд согооны араас удаан явсан шиг санагдсан ч буцах ирэх зам гайхалтай богинохон байлаа. Харри Гермионаг сэрэхийг хүлээлгүй майханд баяртай түргэхэн ороход Рон ард нь хоцров.

Нуур болон цастай ойн дараа энд гайхамшигтай дулаахан байж шалан дээр тавьсан савтай цэнхэр галын дөл улалзана. Гермиона хөнжил дотроо атийн бөх унтаж байсан тул Харри хэдэн удаа нэрийг нь дуудахад сэрсэнгүй.

- Гермиона!

Тэр хөдөлснөө дараа нь огцом өндийн суугаад нүүрнээсээ үсээ холдуулав.

- Юу болсон бэ, Харри? Чи зүгээр үү?

- Бүх зүйл хэвийн маш сайн байна. Тэр ч байтугай гайхамшигтай ч гэж болно.

Бидэн дээр хэн нэгэн ирсэн гээч.

- Чи юуны тухай яриад байна? Хэн гэж?

Тэр гартаа илд бариад элэгдсэн хивсэн дээр ус дуслуулан зогсох Роныг харлаа. Харри харанхуй булан руу очоод Роны үүргэвчийг тавин аль болох ажиглагдахгүй байхыг хичээв.

Гермиона орноос гулган буугаад зүүдэн өвчтэй хүн шиг Рон руу алхлангаа цонхигор царайнаас нь нүд салгасангүй. Тэр урд нь зогсоод уруулаа хагас нээж нүдээ томоор нээн харлаа. Рон сулхан найдангуй инээмсэглээд гараа сунгав.

Тэгтэл Гермиона урагш ухасхийн хүрч болох бүх газраа нүдэж эхлэв.

- Ай, Гермиона ... ёо! Чи чинь яаж байна аа? Гермиона ... Ёо!

- Рональд ... Уизли ... чи ... бол ... өгзөг ... мөн!

Түүний үг бүрийг цохилт дагаж байлаа. Рон толгойгоо хамгаалан хойш ухрав.

- Хичнээн ... хугацаа ... өнгөрсний ... дараа ... мөлхөж ... ирж ... байгаа юм ... өө, миний саваа хаана байна?

Тэр Харрийн гараас саваагаа булаан авахад бэлэн харахад зөнгөөрөө хориглолоо.

- Протего!

Рон, Гермиона хоёрын дунд үл үзэгдэх бамбай бий болов. Гермиона шалан дээр цохиулан унаснаа аманд орсон үсээ нулимаад ахин үсрэн бослоо.

- Гермиона! Тайвшир даа ... гэж Харри хэлэв.

- Тайвширахгүй ээ! гэж тэр хашгирлаа. Харри хэзээ ч түүнийг тийм байдалтай байхыг харж байсангүй. Тэр галзууртлаа уурласан байлаа.

- Миний шидэт савааг өгөөдөх! Өгөөдөх гэж хэлж байна шүү!!!

- Гермиона, зогс ...

- Надад юу хийхийг заах хэрэггүй, Харри Поттер! гэж тэр хашгираад,

- Надад бүү заа! Одоохон өгөөдөх! Аа чи!!! гэв.

Тэр Роны зүг хараал илгээж буй мэт чичилсэн тул Харри түүнийг хэдэн алхам ухарсан явдалд бууруутгасангүй.

- Би чиний араас гүйсэн! Би чамайг дуудсан! Би чамайг эргэж ирэхийг гуйсан!

- Мэднэ! гэж Рон бувтнаснаа,

- Гермиона, уучлаарай. Би явсандаа үнэхээр харамсаж байна ... гэв.

- Аан харамсаж байна гэнээ!

Гермиона цангинатал инээлээ. Рон Харри руу тусламж эрэн харсан ч гараа савчихаас өөр зүйл хийж чадсангүй.

- Хичнээн хугацаагаар хаана байсан нь мэдэгдэхгүй юм байж уучлаарай гэж хэлээд л болчихно гэж бодоо юу ... тэгвэл бүх зүйл засагдах юм биз дээ?!

- Би өөр юу хэлэх байсан гэж? хэмээн Рон орилоход Харри түүний хариу тэмцсэн явдалд нь баяртай байлаа.

- Мэдэхгүй байна! гэж Гермиона даажигнан хэлээд,

- Тархиа ажиллуулаад бодоод үз, Рон ... үүнд их хугацаа хэрэггүй зөвхөн хэдхэн секунт болно ... гэв.

- Гермиона тэр намайг аварсан ... гэж Харри үг хавчуулав.

- Тэр чинь надад хамаагүй! гэж Гермиона орилоод,

- Надад түүний хийсэн зүйл хамаагүй! Хичнээн их хугацаа өнгөрч бид арав дахин үхэж болохыг тэр мэдэж байсан ... гэв.

- Би та нарын үхээгүйг мэдэж байсан! гэж Рон хэдэрлээд анх удаагаа бамбай руу дөхөж очлоо.

- Харриг эцэс төгсгөлгүй «Зөнч» сонинд бичиж, радиогоор ярин хаа сайгүй эрж бүгдийн ухаан солиорсон мэт байхад хэрвээ та нар үхэх юм бол надад ямар байхыг ойлгосон ...

- Чамд тэгээд ямар байх юм дээ?

Гермионагийн түгдрээд ууранда хэлэх үгээ олж ядахад Рон үүнийг ашиглалаа.

- Би шилжингүүтээ шууд харамсаж эргээд ирэх гэсэн ч ойлгож байна уу, бүлэг ангуучдад баригдаад хаашаа ч хөдөлж чадаагүй!

- Бүлэг юу гэнээ? хэмээн Харри асуухад Гермиона буйданд суугаад хэдэн жил хөдлөхгүй юм шиг гар хөлөө шийдэмгий зөрүүлэв.

- Ангуучид гэж Рон давтаад,

- Тэд одоо хаа сайгүй байгаа ... Магл гаралтай хүмүүс болон цэвэр цуснаасаа урвагчдыг барьж өгдөг бүлэг дээрэмчид. Яамнаас барьсан хүн бүрийг шагнаж байгаа юм. Би сургуулийн насны болохоор тэд намайг магл гаралтай нуугдаж байгаа хүн гэж бодоод их баярласан. Би гэр бүлээ нуухаар шийдсэн.

- Чи тэдэнд юу гэж хэлсэн юм?

- Өөрийгөө Стэн Шанпайк гэж хэлсэн. Толгойд орж ирсэн анхны нэр.

- Тэгээд тэд нар итгэсэн үү?

- Тэд нэг их ухаантай биш юм билээ. Тэдний нэг харваас савдаг шиг царайтай нэг нь үнэр нь ч гэсэн ...

Рон Гермиона руу хошин үг нь зөөлрүүлнэ гэж найдсан мэт хяламхийн харсан ч

Гермиона өмнөхийн адил чулуун царайлан гар хөлөө зөрүүлэн суусаар байлаа.

- Ер нь бол тэд намайг Стэн үгүй эсэхэд маргалдсан. Өрөвдөлтэй амьтад тэд тавуулаа байхад би ганцаараа байж саваагаа хураалгасан байсан. Дараа нь тэдний хоёр нь зуураад бусад нь сатаарах үед намайг барьж байсан нэгийнх нь гэдэс рүү цохиод шидэт савааг нь авч зам хаасан нэгийг нь зэвсэггүй болгоод шилжсэн. Нэг их аз тааралгүй л дээ ахиад хуваагдсан ... гээд Рон баруун гараа үзүүлэхэд хоёр хумс нь алга болсон байлаа. Гермиона хүйтнээр хөмсгөө өргөв.

- Дараа нь би та нараас хэдэн милийн алсад газардсан. Та нарын байсан эрэг рүү очсон ч ... тэндээс явсан байсан.

- Бурхан минь ямар сэтгэл хөдлөм түүх вэ гэж Гермиона ихэмсгээр хэлэв. Тэр үргэлж гомдоохыг хүссэн мэт өнгөөр ярих аж.

- Хөөрхий амьтан чи их айсан байх даа! Харин чамайг байхгүйд Харри бид хоёр юу хийсэн гээч? Годрикийн хонхорт очоод тэнд юу болсныг санах ч үгүй байна? ... Аан тийм л дээ Хэцүү нэртийн могой бидэн рүү дайраад арай л алаагүй дараа нь Хэцүү нэрт ирэхэд секунтын зөрөөтэй л зугтсан ...

- Юу? гэж Рон асуугаад гайхширан харсан ч Гермиона түүнийг үл тоомсорлов.

- Харри чи түүнийг хоёр хумсгүй болсон гэж төсөөлөөд үз дээ! Энэ жинхэнэ зовлон шаналал болохыг би ойлгож байна ...

- Гермиона Рон миний амьдралыг аварсан гэж Харри аяархан хэлэв. Тэр үүнийг сонсоогүй дүр үзүүлснээ,

- Би ганц л зүйлийг мэдмээр байна гээд Роны толгой дээгүүр харж,

- Чи өнөөдөр биднийг яаж олов? Энэ их чухал шүү. Хэрвээ бид үүнийг ойлговол цаашид урилгагүй зочдоос өөрсдийгөө сэргийлэх боломжтой гэв.

Рон түүн рүү муухай харснаа өмднийхөө халааснаас жижигхэн мөнгөн эдлэл гаргаж ирэв.

- Үүгээр.

Гермиона түүн рүү харснаа,

- Делюминатор уу? гэж хүйтэн хөндий байдлаа мартан гайхан асуулаа.

- Энэ зүгээр л гэрэл асааж унтраадаг төдий зүйл биш байсан. Би түүний яагаад намайг буцаж ирэхийг хүсэхээс өмнө ажиллаагүйг мэдэхгүй байна. Гэхдээ ер нь бол би зул сарын өглөө радио сонсож байтал гэнэтхэн чамайг ... сонссон гээд Гермиона руу харлаа.

- Чи намайг радиогоор сонссон гэнээ? хэмээн тэр итгэлгүйхэн асуулаа.

- Үгүй, халаасан дотроосоо. Чиний хоолой энэ зүйлээс гарч байсан гээд Делюминаторыг ахин дээш өргөлөө.

- Тэгээд би юу хэлсэн юм? гэж Гермиона үл итгэхийн зэрэгцээ сониучирхан асуув.

- Миний нэрийг хэлсэн ... Рон гэж. Бас ... шидэт сабааны тухай ярьсан.

Гермиона час улайлаа. Харри Роны нэрийг явснаас хойно анхны өдөр чанга дуудсаныг саналаа. Гермиона түүнийг шидэт сабааг засахыг оролдож байхдаа дурссан билээ.

- Ингэж л би түүнийг гаргасан ... гэж Рон үргэлжүүлээд Делюминатор руу харж,

- Энэ үргэлжид байдаг шигээ байсан ч би чиний хоолойг сонсож байлаа. Тэгээд намайг шархийлгэхэд өрөөний чийдэн унтарч цонхны гадаа гэрэл туссан юм.

Рон хуруугаараа Харри, Гермиона хоёрын харж чадахааргүй зүйл рүү заалаа.

- Энэ нь яг л зөөвөрлөгчөөр явах үед эргэн тойронд байдаг шиг шиг цэнхэрдүү бөмбөлөгөн гэрэл шиг байсан?

- Аанхан гэж Харри, Гермиона хоёр зэрэг хэлэв.

- Би энэ л надад хэрэгтэй гэдгийг ойлгосон юм. Үүргэвчээ аваад цэцэрлэгт гарсан.

- Жижигхэн гэрэлтэй бөмбөг намайг хүлээн нисэж байснаа цааш холдоход би түүний араас явсан. Тэр намайг саравч руу аваачаад дараа нь ... миний дотор орсон.

- Өршөөгөөрэй? гэж Харри хэлэхдээ буруу сонссон гэж боджээ.

- Тэр миний дотор хөвж байгаа юм шиг болсон гэж Рон хөдөлгөөнийг нь зүрхэн тушаагаа хуруугаараа зураглан үзүүлээд,

- Миний цээжний баруун талд ... нэвт орчихсон юм шиг болсон. Би түүний халуун илчийг мэдэрч байсан. Тэгээд юу хийх ёстойгоо шууд ойлгосон. Хаашаа явах хэрэгтэйгээ ч мэдэж байсан. Би шилжээд толгод дээр газардахад тэнд цас орж байсан ... гэв.

- Бид тэнд байсан! Хоёр шөнийг өнгөрүүлээд хоёр дахид нь хэн нэгэн харанхуйд нэр дуудан холхиод байх шиг санагдсан гэж Харри дэмжив.

- Аан энэ би л байсан байх. Та нарын хамгаалалтын шившлэг сайн ажиллаж байсан учир харж сонсож чадаагүй ч дэргэд байгаа гэдэгт итгэлтэй байсан болохоороо унтлагын хөнжлөө гаргаад нэг чинь гарч ирэхийг хүлээсэн. Та нарыг майхнаа хураах юм байх гэж бодож байлаа.

- Үгүй дээ, бид тэгэхэд үл үзэгдэх цуван дор шилжсэн. Харри хэн нэгэн эргэн тойронд яваад байх шиг байна гэж хэлсэн болохоор эрт явсан гэж Гермиона хэлэв.

- Тийм байж харин би бүтэн өдөр толгой дээр суусан. Та нарыг гарч ирнэ гэж найдаж байлаа. Тэгээд харанхуй болж эхлэх үед алдсан гэдгээ ойлгоод ахин Делюминатороо шардхийлгэтэл цэнхэр гэрэл дотроос хөтөлж шилжээд эндхийн модон дунд газардсан юм. Та нар ахин үзэгдэхгүй байсан ч хэн нэгэн чинь харагдана гэж найдаж байв ... Тэгтэл Харри гарч ирсэн. Гэхдээ би эхлээд мөнгөн согоо харсан л даа.

- Чи юу харсан гэнээ? хэмээн Гермиона ширүүн асуулаа.

Тэд болсон явдлын тухай тайлбарлаж мөнгөн согоо болон илдийг уснаас хэрхэн авсан тухайгаа ярихад Гермиона хөмсөг зангидан сонсох зуураа хөл гараа зөрүүлэхээ мартсан байлаа.

- Энэ гарцаагүй Патронус байсан байна! гэж тэр дуу алдаад,

- Тэгээд та нар хэн түүнийг гаргасныг харсангүй юу? Хэнийг ч харсангүй гэж үү? Илд рүү аваачсан хэрэг үү? Итгэж ч чадахгүй нь! Тэгээд юу болсон гэнээ? гэв.

Рон Харриг хэрхэн нуур руу үсрэхийг харсан болон гарч ирэхийг нь хүлээсэн ч тэгсэнгүй болохоор ус руу шумбан Харриг гаргаж ирээд дараа нь илдний араас ахин нэг шумбасан тухайгаа ярилаа. Түүнийг зүүлтийг онгойлгосонд хүрээд тээнэгэлзмэгц Харри яриаг нь таслан,

- ... тэгээд Рон түүнийг илдээр цохьсон! гэв.

- Тэгээд тэр ... устсан хэрэг үү? Ингээд л болоо юу? гэж Гермиона шивнэлээ.

- Ер нь бол ... маш сайн орилсон доо гээд Харри Рон руу хяламхийн,

- Энэ байна гэв.

Тэр түүний өвдөг байсан крестражыг заалаа. Гермиона зүүлтийг аваад хагарсан нээлхий рүү нь болгоомжлон харлаа.

Харри эцэст нь аюулгүй боллоо гэж шийдээд бамбайг холдуулж Рон руу эргэлээ.

- Чи сая ангуучдаас өөр саваа авсан гэж хэлсэн үү?

- Юу? гээд Рон зүүлтийг шалгаж байсан Гермиона руу ширтэж байснаа,

- Аан тийм л дээ гэв.

Тэр үүргэвчнийхээ халааснаас бараан модоор хийсэн богинохон саваа гаргалаа.

- Би үүнийг нөөцөнд байлгасан нь дээр гэж бодсон юм.

- Чиний зөв байж! Миний хугарчихсан гээд Харри гараа сунгалаа.

- Чи тоглож байна уу? гэж Рон хэлснээ Гермиона үсрэн босоход айн дальдичлаа.

Гермиона хор хөнөөлгүй болсон крестражыг цүнхэндээ хийгээд ор луу очиж чимээгүйхэн хөнжлөөр хучин хэвтэв.

Рон Харрид шинэ савааг нь өглөө.

- Бодсоноос сайн болсон гэж найдъя хэмээн Харри бувтнав.

- Аанхан. Үүнээс ч дор байж болох байлаа. Тэр над руу шувуу дайруулсныг санаж байна уу?

- Би одоо ч тийм боломжыг алдахгүй шүү гэх Гермионагийн бөглүү хоолой хөнжил дороос гарахад Харри Роны чимээгүйхэн инээмсэглэн үүргэвчнээсээ хүрэн өнгийн хүрмээ гаргаж ирэхийг харлаа.

БҮЛЭГ 20: КСЕНОФИЛИУС ЛАВГУД

Харри Гермионагийн уур хилэн нэг шөнийн дотор намдана гэж хүлээгээгүй болохоор маргааш өглөө нь чимээгүй байж тэдний зүг ууртай харцаар харсан явдалд гайхсангүй. Рон дүнсгэр царайлан түүнээс зай барихыг хичээж байлаа. Харри тэдэнтэй майханд байхдаа муухан оршуулганд ирсэн өөдрөг зочин мэт сэтгэгдэл төрөв. Гэсэн ч Рон хоёулхнаа усанд явах юмуу мөөг түүх үеэр хөгжилтэй болж эхэлдэг байв.

- Хэн нэгэн бидэнд тусалж байна! Хэн нэгэн мөнгөлөг согоо илгээсэн. Бидэнд холбоотон байна. Нэг крестраж устгагдсан, найз минь!

Тэд зүүлтийг устгасан ялалтандаа урамшаад хэдийгээр энэ тухай олон удаа ярьсан ч гэлээ бусад крестраж хаана байж болох талаар ярилцав. Харри анхны амжилт ирсэн болохоор дараагийнх нь ирэх гарцаагүйд урам зоригоор дүүрэн байж Гермионагийн муухай ааш ч үүнийг нь гутааж чадсангүй. Гэнэтийн сайн талын эргэлт, нууцлаг согооны үзэгдэлт, Гриффиндорын илдний олдолт хамгийн гол нь Роны эргэж ирэлт чухал байсан болохоор Харри баярлаж хөөрсөндөө царайны хувирлаа арайхийн төв болгож байв.

Үдээс хойш нь Рон тэр хоёр Гермионагийн уур хилэнгээс зугтан хоосон бутанд жимс хайж буй дүр үзүүлэх зуураа шинэ мэдээллээ үргэлжлүүлэн солилцов. Харри Ронд Гермиона тэр хоёрт тохиолдсон явдал болон Годрикийн хонхорт болсон зүйлийг ярьж, Рон Харрид гадаад ертөнцийн сонинг дуулгав.

Тэр магл гаралтай шидтэнгүүд хэрхэн цөхрөн ид шидийн яамнаас нуугдаж байгаа тухай яриад дараа нь,

- Чи Табугийн тухай мэдсэн үү? гэлээ.

- Юу юм?

- Гермиона та хоёр Хэцүү нэртийг жинхэнэ нэрээр нь дуудахаа болих хэрэгтэй!

- Өө тэгэлгүй яахав таагүй зуршил байгаа юм. Тэгсэн ч би түүнийг ямар ч асуудалгүй нэрлэж чадна В ...

- Чимээгүй! гэж Рон орилоход Харри цочсондоо бут руу унаж, майхны үүдэнд ном уншин сууж байсан Гермиона тэдэн рүү муухай харав.

- Уучлаарай гээд Рон Харриг бөөрөлзгөний бутнаас гаргаж,

- Одоо түүний нэрийг шившсэн болохоор хүмүүсийг мөрдөж байгаа! Хэрвээ түүний нэрийг дурьдвал бүх хамгаалалтын шившлэг эвдэгдэх болно. Тэгж л биднийг Тотнем-Корт-Роудад барьсан юм билээ! гэв.

- Бид түүний нэрийг хэлсний төлөө юу?

- Тийм л дээ! Ер нь энэ бол логик асуудал. Тэднийг тэнэг биш гэдгийг хүлээх зөвшөөрөх хэрэгтэй. Энэ нэрийг зөвхөн Дамблдорын адил хүчтэй өрсөлдөгчид нь хэлэхээс айдаггүй. Одоо Табугийн нэрийг хэлсэн хэнийг ч

хялбархан мөрдөж болно ... Бүлгийн бусад гишүүдийг барих энгийн амжилттай арга болсон доо! Кингсли золтой л баригдаагүй ...

- Чи үнэнээсээ хэлж байна уу?

- Аанхан Үхэл залгигчид түүн рүү бүлгээрээ очсон ч мултраад одоо бидэн шиг зугатаж байгаа гэж Билл хэлсэн гээд Рон бодлогоширонгуй шидэт сабааныхаа үзүүрээр эрүүгээ маажсанаа,

- Сонсооч Кингсли чамд согоо илгээсэн юм болов уу? гэв.

- Түүний Патронус шилүүс болохыг бид хуриман дээр харсан биз дээ?

- Өө тийм л дээ ...

Тэд бутан дундуур цаашлан Гермионагаас холдлоо.

- Харри ... энэ гэнэтхэн Дамблдор байвал яах вэ?

- Юу ... Дамблдор гэнээ?

Рон ичсэн байртай дуугаа намсгаад,

- Дамблдор ... энэ согоо байж магадгүй? Тэр жинхэнэ илдийг гартаа хамгийн сүүлд барьж байсан хүн биз дээ? гээд Харри руу нүднийхээ булангаар хяламхийн харлаа.

Харри Роны үгэнд шоолон инээсэнгүй учир нь энэ асуултын ард гуниг нуугдаж байлаа. Дамблдор эргэж ирсэн гэдэг нь ямар ч үгээр хэлэхийн аргагүй тайвширал өгч байв. Тэр толгой сэгсэрлээ.

- Дамблдор үхсэн. Энэ миний нүдэн дээр болсон. Тэр байхгүй болсон. Тэгээд ч түүний Патронус бол ... галт шувуу болохоос биш согоо биш.

- Тэгсэн ч гэсэн ... Патронус заримдаа өөрчлөгддөг биз дээ? Тонксынх тэгсэн?

гээд Рон салсангүй,

- Хэрвээ Дамблдор амьд байсан бол яагаад үзэгдээгүй гэж? Илдийг бидэнд яагаад гараараа өгөөгүй юм бэ?

- Би хаанаас мэдэх юм. Гэхдээ яагаад үүнийгээ амьд байхдаа хэлээгүй бол. Бас яагаад чамд хуучин снитч, Гермионад хүүхдийн ном үлдээсэн юм бол?

- Харин яагаад юм бол? гээд Харри Рон руу эргэлээ.

- Мэдэхгүй. Би заримдаа түүнийг биднийг элэглэхийн тулд хүнд даалгавар өгсөн гэж бодохоос уурладаг байлаа. Гэвч одоо тэгж бодохоо больсон. Тэр юу хийхээ мэдэж байсан болохоор надад Делюминаторыг орхисон ... Үгүй гэж хэлэх үү? Бас тэр гээд Роны чих улайж гэнэтхэн хөл дороо байгаа өвсийг хөлөөрөө оролдсоноо,

- Тэр намайг хаяж явахыг мэдэж байсан байх гэв.

- Үгүй тэр чамайг заавал эргэж ирнэ гэдгийг мэдэж байсан гэж Харри засан хэллээ.

Рон түүн рүү талархахын зэрэгцээ ичсэн байртай харсанд Харри сэдвийг өөрчлөхөөр яарлаа.

- Ингэхэд чи Рита Скитер Дамблдорын тухай номдоо хэнийг дурьдсаныг мэдэх үү?

- Аан тийм л дээ бүгд түүний тухай ярьж байна. Мэдээж Дамблдор Гриндевальдтай нөхөрлөж байсан явдал ихээхэн шуугиан тарьсан. Гэхдээ минийхээр бол тэнд ямар ч аймшигтай зүйл байхгүй. Тэр тэгэхэд их залуухан байсан биз дээ ...

- Бидэн шиг л гээд Харри Гермионад хариулсан шигээ уцаарлаж амжихаас өмнө царайд нь ямар нэг зүйл илэрсэн бололтой Рон яриагаа яаран өөрчлөв.

Бөөрөлзгөний бутан дээрх хөлдүү аалзны шүлсний голд том аалз байлаа. Харри

Гермионагийн сургууль хийхийг зөвлөсний дагуу Роны өгсөн саваг чиглүүлээ.

- Энгоргио!

Аалз хөнгөхөн чичирснээ торон дотроо харайлаа. Харри ахин оролдов. Энэ удаад аалз үл мэдэг томров.

- Больж үз! гэж Рон хэлээд,

- Дамблдорыг залуу байсан гэж хэлснийг минь уучлаарай ... гэв. Харри Рон аалзнаас айдагийг мартсан байв.

- Өршөөгөөрэй ... Редукто!

Аалз багассангүй. Харри саваа руугаа харлаа. Тэр ахин хэдэн энгийн шившлэг оролдож үзсэн ч бүгд галт шувууны өдтэй хүчирхэг саваанаас нь дор болов. Шинэ саваа нь дасал болоогүй бусдын гарт орсондоо дургүйцэж байгаа мэт байлаа.

- Ахиад жаахан дасгал хийх хэрэгтэй. Хамгийн гол нь өөртөө итгэлтэй байдал гэж чимээгүйхэн дөхөж ирээд Харрийн аалз багасгах оролдлогыг харж байсан Гермиона хэлэв ...

Харри түүний яагаад шинэ саваа нь хэвийн болоосой гэж хүсч байгааг мэдэж байлаа. Гермиона савааг нь хугалсандаа өмнөхийн адил гэмшсэн хэвээр аж. Тэр чимээгүй болсоноо түүнийг өөрт нь саваагаа өгөөд гайхамшигтай савааг авахыг санал болгох гэсэн ч эцэст нь бүгд эвлэрээсэй гэж хүсч байсан тулд маргалгүй тэслээ. Гэсэн хэдий ч Рон Гермиона руу инээмсэглэмэгц холдоод ахин номныхоо ард алга болов.

Харанхуй болох үед бүгд майхандаа эргэж ороод Харри түрүүлж жижүүр хийх үүргийг өөртөө авлаа. Тэр үүдэн дээр суугаад саваагаараа жижигхэн чулууг хөөргөхийг оролдсон ч шид урьдын адил болсонгүй. Гермиона орон дээр хэвтээд ном уншиж, Рон түүн рүү хяламхийн харснаа үүргэвчнээсээ жижигхэн модон радио гаргаж ирээд долгионыг нь тохируулж эхлэв.

- Нэг л програмтай гэж тэр нам дуугаар Харрид тайлбарлаад,

- Үүгээр жинхэнэ мэдээ сонссогддог юм. Үлдсэн станцууд бүгд Хэцүү нэрт болон ид шидийн яамны үгийг давтдаг байхад харин энэ ... Хүлээгээрэй чи өөрөө сонсоно оо сайхан эд байгаа юм. Гэхдээ тэд шөнө болгон нэвтрүүлээд байдаггүй

үргэлж байраа сольж байдаг болохоор долгионд нэвтрэхэд нууц үг хэрэгтэй ... Харамсалтай нь би сүүлчийн нэвтрүүлгийг нь алдчихсан ... гэв.

Тэр шидэт саваагаараа радионы оройг тогшоод ямар нэг үг бувтналаа. Үүнийхээ дараа Гермионаг уурлахаас айсан мэт харсан ч тэрбээр түүнийг энд байхгүй мэт дүр эсгэв. Ийм байдалтай арван хором өнгөрлөө. Рон бувтнан саваагаар тогшиж, Гермиона номны хуудас эргүүлэн, Харри шинэ саваагаараа үргэлжлүүлэн дасгал хийж байлаа.

Эцэст нь Гермиона бослоо. Рон шуудхан тогшихоо болив.

- Хэрвээ энэ чамд саад болж байвал би тэгэхгүй! гэж яаран хэлэв. Гермиона хариулсангүй Харри руу дөхөн ирлээ.

- Бид ярилцах хэрэгтэй байна.

Харри Гермионагийн гартаа барьж байсан «Альбус Дамблдорын хуурамч амьдрал»

ном руу харснаа,

- Яасан? гэж дургүйхэн асуугаад аль нэг бүлэгт нь түүний тухай дурьдсан юм биш байгаа даа гэж бодов. Тэр Ритагийн Дамблдортой нөхөрлөж байсан харьцааны тухай хувилбарыг сонсох эсэхтээ итгэлгүй байлаа. Гэсэн ч Гермиона огт хүлээгээгүй зүйл хэллээ.

- Би Ксенофилиус Лавгудтай ярилцахыг хүсч байна. Харри нүдээ бүлтийлгэв.

- Юу гэнээ?

- Ксенофилиус Лавгуд Полумнагийн эцэг. Би түүнтэй ярилцахыг хүсч байна!

- Яах гэж?

Гермионад харайлтанд бэлтгэх гэж байгаа юм шиг гүнзгий амьсгал авснаа,

- «Бидл Бардын үлгэр» дээрх тэмдэгүүд. Үүнийг хараач! гэв

Тэр Харрид «Альбус Дамблдорын хуурамч амьдрал» номыг сунгахад Дамблдорын Гриндевальдад танил налуу бичгээр бичсэн эх захианы хуулбар зургийг дургүйхэн харлаа. Харри захиаг Рита Скитерийн бодож олсон зүйл биш Дамблдор үнэхээр үүнийг бичсэн гэж баталгаа болсонд нь харахаас дургүй хүрч байв.

- Гарын үсэг. Гарын үсгийг нь хараач, Харри!

Харри харлаа. Тэр эхлээд юу болохыг нь ойлгоогүй ч дараа нь номон дээр шидэт сава аныхаа гэрлийг тусган харахад Дамблдор Альбус гэсэн нэрний «А» үсгийг

«Бидл бардын үлгэр»-үүд номон дээр байсантай ижил гурвалжин булантай тэмдэг

болгон зурсан байлаа.

- Э-э-э ... та нар юуны тухай яриад байна? гэж Рон шийдвэргүйхэн хэлсэн ч

Гермиона үл тоомсорлон Харри руу эргэв.

- Энэ тэмдэг цаг үргэлж тааралдаж байгааг ойлгож байна уу? Мэдээж Виктор Крам үүнийг Гриндевальдын бэлэг тэмдэг гэж хэлсэн ч Годрикийн хонхорт байсан

хуучин булшин дээрх он сар түүнээс хамаагүй дээр үеийнх байсан! Харин одоо бас энэ захиа байна. Бид Дамблдор юмуу Гриндевальдаас юу болохыг нь асууж чадахгүй ... Тэр ч байтугай Гриндевальд амьд хэвээр байгаа эсэхийг ч мэдэхгүй ... гэсэн ч ноён Лавгудаас асууж болно! Тэр хурим дээр ирэхдээ энэ тэмдэгийг хүзүүндээ зүүсэн байсан. Харри, би үүнийг маш чухал гэдэгт итгэлтэй байна!

Харри шууд хариулсангүй. Тэр Гермионагийн эрч хүчтэй царай руу харснаа дараа нь харанхуй майхан руу харан гүнзгий бодлогоширов. Эцэст нь,

- Гермиона бидэнд ахин нэг Годрикийн хонхор хэрэггүй. Бид тэгэхэд бие биендээ явах маш их хэрэгтэй гэж итгүүлж байсан биз дээ? гэв.

- Гэхдээ энэ үргэлж тааралдаад байна, Харри! Дамблдор надад «Бидл бардын үлгэрүүд»-ийг орхихдоо энэ тэмдэгийг үзүүлэх гээгүйг чи хаанаас мэдэх юм?

- Ахиад л эхэллээ! гэж Харри унтууцан хэлээд,

- Бид үргэлж Дамблдорын нууцлаг заавар орхисон тухай ярилцаж байсан ... гэв.

- Гэхдээ Делюминатор хэрэг болсон гэж чимээгүй байсан Рон хэлээд,

- Минийхээр бол Гермионагийн зөв байх. Би үүнийг Лавгудаас асуух хэрэгтэй гэж бодож байна гэв.

Харри түүн рүү баргар харлаа. Тэр Роныг зөвхөн Гермионад тал олохын тулд ингэсэнээс биш гурвалжин тэмдгийн тухай бодоогүй гэдэгт итгэлтэй байлаа.

- Тэгээд ч Годрикийн хонхортой адил биш гэж Рон нэмэрлээд,

- Лавгуд манай талынх, Харри. «Шүүмжлэгч» сэтгүүл анхнаасаа л бүгдийг чамд туслахыг уриалж байсан! гэв.

- Би үүнийг маш чухал гэдэгт итгэлтэй байна! гэж Гермиона батлав.

- Харин та нар энэ үнэхээр чухал байсан бол Дамблдор надад амьд байхдаа хэлэх байсан гэж бодохгүй байна уу?

- Магадгүй чи энэ бүхнийг өөрөө олж мэдэх хэрэгтэй ч байж болох юм гэж

Гермиона хэллээ.

- Тийм шүү. Бүгд логик холбоостой гэж Рон тал засан дуугарлаа.

- Логик холбоостой биш гэж Гермиона зандараад,

- Гэсэн ч бид ноён Лавгудтай ярилцах ёстой гэж бодож байна. Дамблдор, Гриндевальд болон Годрикийн хонхорын тэмдэг хоорондоо холбоотой байгаа биз дээ? Харри бид түүнээс асуух ёстой! гэв.

- Тэгвэл санал хураацгаая. Хэн Лавгудынд очихын төлөө байна ... гээд Рон

Гермионагаас түрүүлж гараа өргөлөө. Тэр бас гараа өргөв.

- Уучлаарай Харри чи цөөнх боллоо гээд Рон нуруун дээр нь алгадав.

- Сайн байна гэж Харри уурлах инээх эсэхээ мэдэхгүй хэлээд,

- Тэгвэл Лавгудынд ахин нэг крестражыг олсны дараа очих уу? Ингэхэд Лавгудынхан хаана амьдардаг юм бол? Мэдэх хүн байна уу? гэв.

- Манайхаас холгүй. Хаана байдгийг нь сайн мэдэхгүй ч ээж аав хоёр тэдний тухай ярихдаа үргэлж толгодын зүг заадаг юм. Олоход амархан байх гэж Рон дуугарлаа.

Гермиона ор луугаа эргэхэд Харри Ронд чимээгүйхэн,

- Чи ердөө түүний өмнө зусардсанаас өөр юу ч биш гэв.

- Хайрын дайнд энэ бол хамгийн сайн арга. Сэргэ л дээ, одоо чинь зул сарын амралт шүү дээ, Полумна лав гэртээ байгаа байх.

Маргааш өглөө нь тэд Оттери-Сент-Кэчпул тосгон маш сайн үзэгдэх салхитай толгод дээр шилжин ирэв. Өндрөөс тосгоны байшингууд тоглоомын юм шиг үзэгдэж нарны цацраг үүлний цаанаас гийгүүлнэ. Тэд хоёр хормын турш Үүрний зүг харж зогссон ч жимсний цэцэрлэгийг хүрээлсэн амьд бургасан хашаа Уизлийн гэрийг маглуудын нүднээс нуужээ.

- Дэргэд нь байгаа хэр нь орж болохгүй гэдэг хачирхалтай хэрэг байна гэж Рон хэлэв.

- Чи хэдийн уйдаж амжсан уу. Зул сараар энд байсан биз дээ хэмээн Гермиона хүйтнээр шилбүүрдэв.

- Байгаагүй! Та нар намайг тэдэнд ойд орхиж явснаа хэлнэ гэж бодоо юу? Тийм шүү Фред, Жорж хоёр үүний төлөө миний толгойг илэх байсан даа. Тэгээд ч Жинни намайг яаж ч ойлгох байсан юм билээ!

- Тэгээд чи хаана байсан юм? гэж Гермиона гайхлаа.

- Билл, Флер хоёрын шинэ хясаан байшинд. Билл үргэлж надтай хэвийн харьцдаг байсан. Тэр мэдээж миний юу хийснийг сонсоод хөөрөөгүй ч үүндээ их харамсаж байгааг минь харсан. Манайхны хэн ч намайг тэнд байгаа гэдгийг мэдээгүй. Билл ээжид тэдний гэрлэснээс дараах хойшхи анхны баяр болохоор зул сарын баяраар Үүрэнд очихгүй хоёулхнаа өнгөрөөхийг хүсэж байна гэж хэлсэн. Флер эсэргүүцээгүй. Тэр Селестина Уорлокийг тэвчиж чаддаггүй юм.

Рон Үүрнээс эргэснээ,

- Явцгаая тэнд байгаа байх гээд толгодын орой луу шидэмгий явлаа.

Тэд хэдэн цагийн турш явахад Гермиона Харриг үл үзэгдэх цуван дор нуугдахыг шаардав. Толгод намхан санагдсан бөгөөд жижигхэн байшинг эс тооцвол хоосон байлаа.

- Магадгүй энэ тэдний байшин байгаад зул сарын баяраар явсан юм болов уу? гээд Гермиона тавцан дээрээ шимтгэлэй цэцэг тарьсан цэмцгэр гал тогооны цонхыг заалаа.

Рон чанга тургилав.

- Хэрвээ тэнд Лавгудынхан амьдарч байсан бол харваас илт байх байсан гэж бодож байна. Толгодын ар луу явцгаая.

Тэд хойд зүг рүү хэдэн мил шилжлээ. Салхи илт ширүүсч үс хувцас хийсгэнэ.

- Аанхан! гэж Рон орилоод толгодын орой дээрх байшинг заав. Тэнгэрийн дор том хар бортого шиг маш хачирхалтай байшин байсан бөгөөд бөхөж буй сарны гэрэлд сүүмийн гялалзана.

- Энэ Полумнагийн байшин байж таарна. Өөр хэн ийм бортогт амьдрах билээ дээ? Аварга том турлиахтай том төстэй байгаа биз?

- Минийхээр бол шувуутай төсгүй байна гэж Гермиона эсэргүүцээд цамхаг руу хөмсөг зангидан харлаа.

Рон урт хөлтэй болохоор толгодын оройд түрүүлж хүрэв. Харри, Гермиона хоёр түүнийг амьсгаадан гүйцээд нүүр дүүрэн инээмсэглэж байхыг нь харлаа.

- Энэ үнэхээр тэдний байшин байна. Хараач.

Тэдний өмнө гараар хийсэн гурван хаяг байв. Эхнийх дээр нь ШҮҮМЖЛЭГЧ СЭТГҮҮЛИЙН ЕРӨНХИЙ ЭХЛЭГЧ К. ЛАВГУД гээд хоёр дахь дээр нь

ЦАГААН БОРЗ БОЛ МАНАЙ СОНГОЛТ Харин гурав дахь дээр нь

ЧАВГАН ДЭЭР ГИШГЭЖ БОЛОХГҮЙ гэжээ.

Хашааны хаалга чахран онгойв. Байшин руу хөтөлсөн зам тахирлан мурийж гадаа нь Полумнагийн заримдаа чихэндээ ээмэгний оронд зүүдэг шаргал өнгийн луувантай төстэй жимс бүхий хачирхалтай бут байлаа. Түүнчлэн Харри хатсан хожуултай адилхан ургамал байхыг таниад түүнээс аль болох холхон явахыг хичээв. Үүдний хаалган дээр ургасан хоёр алимны хөгшин мод салхинд гөвөгдөн нэг ч навчгүй болоод мөчрөөс нь улаан алимны хэмжээтэй үслэг цагаан борзон дундаас сувс шиг цагаан жимс ургажээ. Модны мөчир дээр байсан жижигхэн ууль далавчаа дэвснээ тэднийг ойртоход харцагатай адилхан толгойгоо эргүүлэн харлаа.

- Харри, чи үл үзэгдэх цуваа тайлсан нь дээр байх. Ноён Лавгуд чамд туслахаас биш бидэнд биш гэж Гермиона хэлэв.

Харри цуваа тайлаад Гермионад өгөхөд цүнхэндээ хийснээ гурван удаа бүргэдийн дүрстэй үүдний цохиураар том хар хаалгыг цохив.

Арван секунт ч өнгөрөөгүй байтал хаалга нээгдэж үүдэн дээр Ксенофилиус Лавгуд хөл нүцгэн унтлагын цамцтай төстэй хувцастай зогсож байв. Түүний урт цагаан үс нь чихрийн хөөсөнцөрийг санагдуулах агаад угаагүй бохир ажээ. Одооны үетэйгээ харьцуулахад Билл, Флер хоёрын хурим дээр Ксенофилиус хамаагүй дэгжин харагдаж байсан билээ.

- Юу болоод байна? Та нар хэн бэ? Юу хэрэгтэй юм? гэж тэр чанга дуугаар хашгиран асуугаад эхлээд Гермионаг дараа нь Роныг харж эцэст нь Харри дээр нүд тусахад амаа «О» үсгийг санагдуулам ангайлаа.

- Сайн байна уу, ноён Лавгуд. Би ... Харри. Харри Поттер байна гээд Харри гараа сунгалаа.

Ксенофилиус гар барихыг хүссэнгүй Харрийн духан дээрх сорви руу ширтэв.

- Бид орж болох уу? Бидэнд танаас асуух зүйл байна.

- Би ... тэгээгүй нь дээр гэж бодож байна гэж Ксенфилиус шивнээд чимээтэй шүлсээ залгиснаа цэцэрлэг рүү түргэн харав.

- Энэ гэнэтийн зүйл байлаа ... Миний үг бол ... Би ... Би таныг оруулахаас айж байна ...

- Бид удахгүй гэж Харри тэгж угтсанд нь урам хугаран хэллээ.

- Би ... Тэгвэл ч яахав. Орцгоо түргэн шүү, түргэн!

Тэднийг босго давж амжихтай зэрэг ноён Лавгуд хаалгаа тасхийн хаалаа. Харрид урьд өмнө үзээгүй дэлхий дээрх хамгийн гайхалтай гал зууханд байх шиг санагдав. Өрөө дугариг хэлбэртэй байсан нь аварга том чинжүүний саван дотор байгаа мэт санагдуулна. Өрөөний, хана, зуух, угаалтуур, шүүгээ гээд бүх зүйл дээр цэцэг, шавьж, шувуу зэргийг хурц өнгөөр дүрсэлжээ. Харри үүнээс Полумнагийн хэв маягийг танив.

Өрөөний голд давтмал төмөр эргүүлгэн шат дээд талын давхар руу хөтлөн өгсчээ. Толгой дээр ямар нэг зүйл чанга тас нясхийсэнд Харри Полумна юм хийж байгаа юм болов уу хэмээн гайхлаа.

- Дээшээ гарцгаа гэж ноён Лавгуд эвгүйцсэн янзтай хэлээд түрүүлж шатаар өгсөв.

Дээд талын өрөө нэгэн зэрэг зочны болон уран бүтээлийн өрөө хосолдог бололтой гал зуухнаас илүү хөглөрсөн замбараагүй ажээ. Энэ нь удаан жилийн турш юм нуусан аварга том төөрдөг байшин адил Шаардлагатай өрөөний арай багахан дугуй загварыг санагдуулав. Энд хаа сайгүй янз бүрийн бичиг цаас овооролдоно. Адраас гоёмсог этгээд амьтаны загвар өлгөсөн нь далавчаа дэвж, эрүүгээ хавших аж.

Полумна энд байсангүй бөгөөд нууцлаг чимээ шуугиан шидийн аргаар эргэлдэх хүрдний араа бүхий модон эдлэлээс гарч байв. Энэ нь яг л дарханы ширээн дээр тавьсан хачирхалтай бүтээл шиг харагдаж байсанд Харри «Шүүмжлэгч» сэтгүүлийн хуучин загварын хэвлэлийн машин болохыг ойлгов.

- Өршөөгөөрэй гэж Ксенофилиус хэлээд машины хажуугаар өнгөрч овоолоостой бичиг цаасан дор байсан ширээний бүтээлэгийг угз татан аваад дээрээс нь хаяхад хяхтнах чимээ бүдгэрлээ. Ноён Лавгуд Харри руу эргэлээ.

- Та ийшээ яах гэж ирээ вэ?

Харриг хариулж амжихаас урьд Гермиона гэнэтхэн хашгирлаа.

- Ноён Лавгуд энэ таных уу?

Тэр хуруугаараа хана налуулан тавьсан ганц эвэртийнхтэй төстэй мушгирсан том саарал эвэр рүү зааж байлаа.

- Энэ бол үрчгэр эвэртийн эвэр гэж Ксенофилиус хэлэв.

- Үгүй ээ, тийм биш! гэж Гермиона хэллээ.

- Гермиона одоо маргаж байх цаг биш ... гэж Харри ичингүйрэн бувтнав.

- Харри энэ чинь Эрумпентийн эвэр байна. Худалдахад хориотой зүйлсийн «В» ангилалын жагсаалтанд ордог маш аюултай зүйл. Гэрийн нөхцөлд хадгалах хатуу хориотой!

- Чи хаанаас Эрумпентийн эвэр гэж мэдээ вэ? гээд Рон хөглөрсөн зүйлийн захаар явж эвэр лүү очлоо.

- Энэ тухай «Гайхалтай амьтад ба тэдний оршин байдаг газар» номд бичсэн байдаг! Ноён Лавгуд түүнийг даруйхан эндээс холдуулах хэрэгтэй! Та түүнийг өчүүхэн төдий хүрэхэд дэлбэрдэгийг мэдэхгүй байгаа юм уу?

- Энэ бол үрчгэр эвэртийнх гэж Ксенофилиус тодхон хэлээд зөрүүдлэн харлаа.

- Ноён Лавгуд би үүнийг шинж тэмдгээр нь Эрумпентийн эвэр гэдгийг таньж байна ... таныг хаанаас авсныг мэдэхгүй байгаа ч ...

- Би хоёр долоо хоногийн өмнө гайхамшигтай залуу шидтэнгээс худалдаж авсан юм гэж Ксенофилиус шаардангуй хэлээд,

- Тэр намайг үрчгэр эвэртийг сонирхдогыг мэддэг юм л даа. Полумнад өгч байгаа зул сарын бэлэг минь байгаа юм. Ингэхэд та нар яах гэж ийшээ ирээ вэ, ноён Поттер? гэлээ.

- Бидэнд тусламж хэрэгтэй байна гэж Харри Гермионаг ам нээхээс урьтаж хэлэв.

- Аа! Тусламж гэнээ. Хм-м ... гээд түүний нүд ахин Харрийн сорвин дээр туссанаа айсан ч юм шиг түгшсэн ч юм шиг харагдаж,

- Тиймээ-ээ. .. Харваас ... Харри Поттерт туслах нь ... аюулгүй хэрэг биш гэв.

- Та чинь сэтгүүлдээ бүгдэд Харри Поттерт туслах бол бидний тэргүүн зэргийн үүрэг гээд байгаагүй билүү! гэж Рон хэллээ.

Ксенофилиус ардаа ширээний бүтээлэг дор далдлагдсан хэвлэлийн машин руу харснаа,

- Ээ ... тийм л дээ би тийм бодолтой байсан ч ... гэв.

- Таныхаар бол энэ нь зөвхөн бусдад хамаатай юм биз дээ? гэж Рон асуулаа.

Ксенофилиус хариулсангүй зовж шаналсан янзтай шүлсээ залгиад тэднийг гүйлгэн харахад Харрид дотор нь тэмцэл явагдаж байх шиг санагдав.

- Ингэхэд Полумна хаана байна? Түүнийг юу гэж хэлэхийг харцгаая гэж

Гермиона гэнэт асуув.

Ксенофилиус хахаж цацсанаа биеэ барьж чичирсэн хоолойгоор,

- Полумна гол руу усны шимэгч барихаар явсан. Тэр ... Тэр та нарыг хараад баяртай байх болно. Би түүнийг дуудаадахъя ... Харин дараа нь та нарт туслахыг хичээе гэв.

Тэр доошоо дугуй шатаар уруудан алга болоод үүдний хаалга хаагдах нь сонсогдов. Бие бие рүүгээ харцгаалаа.

- Хулчгар амьтан. Полумна түүнээс арав дахин зоригтой байх! гэж Рон хэлэв.

- Хэрвээ Үхэл залгигчид миний ийшээ ирснийг мэдвэл юу тохиолдохоос айж байгаа байх гэж Харри хэлэв.

- Роны зөв! гэж Гермиона мэдэгдээд,

- Жигшүүртэй хоёр нүүртэн бүгдэд чамд тусал гэж хэлчихээд харин өөрөө болохоор зайлсхийж байдаг. Тэгээд бас энэ эврийг хадгалж байдаг гэв.

Харри цонх руу очлоо. Тэндээс алсад нарийхан гялалзсан тууз шиг гялтганан урсах горхи харагдав. Цамхаг цонхны дэргэдүүр шувуу нисэхээр маш өндөр ажээ. Харри толгодын нугачаанд үзэгдэхгүй байгаа Үүрний зүг харлаа. Тэнд Жинни байгаа ... Тэд Билл, Флер хоёрын хуримнаас хойш нэг ч удаа ийм ойрхон байсангүй бөгөөд одоо түүний зүг харж бодож байна гэж бодоогүй нь лавтай. Магадгүй түүнтэй ойрхон хүн бүр аюулд ордог болохоор үүнд баяртай ч байгаа юм билүү. Ксенофилиус үүний жишээ шүү дээ.

Тэр цонхноос эргэтэл хөглөрсөн зүйлийн дундах хотойсон шүүгээн дээр байгаа зүйл дээр нүд туслаа. Энэ нь толгойдоо хачирхалтай чимэглэл зүүсэн ширүүн шидтэнгийн цээж баримал байв. Чимэглэлийн хоёр талаас сонсголын бүрээ шиг хоёр зүйл ёрдойжээ. Түүнчлэн суран бүснээс нь гялалзсан цэнхэр далавч гарч, духан дахь өөр нэг бүснээс шаргал лууван унжжээ.

- Хөөе, үүнийг хараач! гэж Харри дуудав.

- Гайхамшигтай хэмээн Рон үл тоон хэлээд,

- Тэр үүнийгээ хурим дээр өмсөөгүй нь гайхалтай юм гэв.

Доор хаалга тасхийж хормын дараа Ксенофилиус эргүүлгэн шатаар гарч ирэв. Тэр туранхай хөлдөө резинэн усны гутал углаад уур савссан тавиуртай цай гартаа барьжээ.

- Аан та нар миний бүтээлийг сонирхож байна уу! гээд тавиураа Гермионагийн гарт бариулаад хөшөөний урд байсан Харрийн дэргэд ирж зогслоо.

- Кандида Когтевраны үзэсгэлэнтэй толгойн загвар байгаа юм. Ухаан алтнаас үнэтэй! гээд чихний бүрээ шиг зүйлийг заалаа. - Энэ бол бодол сатааруулагчыг зайлуулах хоолой. Харин энэ бол гээд жижигхэн далавчыг зааж,

- Ухааны цар хүрээг ихэсгэдэг сэнс гэснээ эцэст нь шаргал лууван руу зааж,

- Дирижаблын чавга ер бусын зүйлийг хүлээж авах чадварыг нэмэгдүүлнэ гэв.

Ксенофилиус Гермионагийн ширээний өнцөг дээр хазайлган тавьсан тавиуртай цай руу эргэлээ.

- Та нарт гурдын үндэсний хандыг танилцуулахыг зөвшөөрнө үү? Гэрийн нөхцөлд бэлтгэсэн эд байгаа юм! гээд хүрэн манжингийн шүүс шиг зунгааралдсан зүйлийг аяганд хийж,

- Полумна гүүрний дор байгаа. Тэр та нарыг ирсэнд их баярласан. Одоохон ирэх байх. Суугаад чихэр авцгаа гээд түшлэгтэй сандал дээрх овоолоотой цаасыг холдуулан усны гутлаа зөрүүлэн суугаад,

- Ингэхэд би таньд юугаар туслах вэ, ноён Поттер? гэлээ.

- Юу гэхээр хэмээн Харри Гермиона руу харахад дэмжин толгой дохив.

- Энэ нь таны Билл, Флер хоёры хурим дээр хүзүүндээ зүүсэн байсан бэлэг тэмдгийн тухайд юм. Ноён Лавгуд бид энэ юу болохыг асуухыг хүсч байна?

Ксенофилиус хөмсгөө өргөснөө,

- Та нар үхлийн шүтээнийг мэддэггүй юм уу? гэлээ.

БҮЛЭГ 21: АХ ДҮҮ ГУРВЫН ТУХАЙ ҮЛГЭР

Харри Рон, Гермиона хоёр луу эргэлээ. Харваас тэдний хэн ч Ксенофилиусын хэлсэн зүйлийг ойлгоогүй бололтой,

- Үхлийн шүтээн гэнээ? гэв.

- Яг тийм гэж ноён Лавгуд батлаад,

- Та нар тэдний тухай сонсож байгаагүй юм уу? Үүнд гайхах явдалгүй дээ.

Маш цөөхөн шидтэнгүүд үүнд итгэдэг юм. Үүний гэрч нь гэвэл хурим дээр байсан залуу над руу энэ тэмдэг хар шидтэнийх гэж дайрсан. Ямар бүдүүлэг хэрэг вэ! Үхлийн шүтээнд ямар ч хар талын зүйл байхгүй ... Ердөө энэ тэмдгийг итгэн зүүсэн хэн ч бие биеэ олж эрэхэд нь туслах ёстой юм гэв.

Тэр аягандаа хэдэн халбага чихэр нэмээд гурдын хандаа уулаа.

- Өршөөгөөрэй би юу ч ойлгосонгүй гэж Харри хэлээд эелдэгээр аягатайгаа уутал хахаж цацах шахлаа. Энэ нь яг л нусны амттай Берти Боттс үрэл шингэрүүлчихсан юм шиг таагүй амттай ажээ.

- Харж байна уу үүнд итгэдэг хэн ч үхлийн шүтээнийг хайх ёстой юм гэж ноён

Лавгуд тайлбарлаад уруулаа тамшаалав.

- Энэ үхлийн шүтээн гэдэг чинь юу гэж байгаа юм? гэж Гермиона асуулаа. Ксенофилиус хоосон аягаа тавилаа.

- Та нар бүгд ах дүү гурвын тухай үлгэр уншсан уу?

- Үгүй гэж Харри хэлсэн ч,

- Тиймээ гэж Рон, Рермиона хоёр хэллээ. Ксенфиолиус хөөрөн толгой дохилов.

- Тэгэхээр энэ бүх зүйл ах дүү гурвын үлгэрээс эхэлдэг юм, ноён Поттер. Надад хаа нэгтээ байсан юмсан ...

Тэр овоолоостой бичиг цаас руу цөхрөнгүй харсан ч Гермиона,

- Ноён Лавгуд, надад энд байгаа гээд цүнхнээсээ «Бидл бард үлгэрүүд»-ийг гаргалаа.

- Эх хувь нь уу? гэж Ксенофилиус сонирхоход Гермиона толгой дохив.

- Тэгвэл бидэнд үүнийгээ чанга уншиж өгөхгүй юу? Ингэвэл шууд бүх зүйл ойлгомжтой болно.

- За ... сайн байна гэж Гермиона итгэлгүйхэн зөвшөөрөөд номоо нээхэд Харри хуудасны дээд талд нөгөөх тэмдэг байхыг харлаа. Тэр ханиалгаснаа уншиж эхлэв.

- Ах дүү гурав амьдран суудаг байжээ. Тэд нэг удаа бүрэнхийд алсын замд гарч гэнэ ...

- Харин ээж үргэлж бидэнд шөнө дунд гэж хэлдэг байсан гээд Рон аятайхан сонсохын тулд сандал дээр суниаснаа гараа толгойныхоо ард авлаа. Гермиона түүн рүү уурсан харав.

- Уучлаарай зүгээр л шөнө дунд гэхээр аймшигтай юм шиг санагддаг байсан юм!

- Аанхан яагаад гэвэл биднийг амьдралд илүү их айдас хүлээж байгаа гэж Харри тэсгэлгүй хэлсэн ч Ксенофилиус сонссон шинжгүй цонхны цаадах тэнгэр рүү ширтэн зогсож байв. - Цааш нь унш, Гермиона!

- ... тэгээд ах дүүс гол дээр ирж гэнэ. Гол өргөн байсан болохоор харайх боломжгүй түргэн урсгалд нь сэлэх боломжгүй байв. Гэсэн ч ах дүүс шидийн урлагийг эзэмшсэн байлаа. Тэд шидэт саваагаа даллахад гол дээгүүр гүүр ургаж гэнэ. Ах дүүс гүүрийн дунд хүрсэн хойноо гэнэтхэн замд нь юүдэнтэй дүрс зогсож байхыг харжээ. Тэгээд Үхэл тэдэнтэй ярьсан байна ...

- Уучлаарай тэдэнтэй Үхэл ярьсан гэнээ? хэмээн Харри яриаг нь таслав.

- Энэ чинь үлгэр шүү дээ!

- Аан ойлгомжтой уучлаарай. Цааш нь үргэлжлүүл.

- Ингээд Үхэл тэдэнтэй ярьжээ. Тэр аялагчид ердийнхөөр голд живдэг байтал олз нь мэхэлсэн явдал их уурласан байна. Гэхдээ Үхэл зальтай байлаа. Тэр ах дүү гурвыг шагшин магтсан дүр эсгэж хуурсан явдалд нь тус бүрд нь шагнал сонгож авахыг санал болгосон байна.

- Том ах нь дайнч хүн байсан учир барьсан эзэн нь тулаанд дандаа ялж байдаг дэлхий дээрх хамгийн хүчирхэг шидэт савааг хүсчээ. Тэгтэл Үхэл голын ойролцоо ургасан модны мөчрийг хугалж аваад түүгээр шидэт саваа хийж том ахад нь өгчээ.

- Хоёр дахь ах нь бардам хүн байлаа. Тэр Үхлийг басамжлахын тулд үхсэнийг амилуулах шидийг хүсчээ. Үхэл голын эрэг дээр хэвтэж байсан чулууг аваад дунд ахад нь өгөхдөө энэ нь үхсэнийг буцаах хүчийг агуулдаг гэж хэлжээ.

- Үхэл гурав дахь хүүгээс юу хүсч байгааг нь асуужээ. Бага дүү нь хамгийн даруу, хамгийн цэцэн нь байсан учраас Үхэлд итгэлд итгэсэнгүй. Тэрбээр Үхэл ч түүнийг дагаж чадахааргүй зүйлийг гуйжээ. Үхэл дургүйхэн түүнд үл үзэгдэх цуваа өгсөн байна.

- Үхэлд үл үзэгдэх цув байсан гэнээ? хэмээн Харри ахин асуулаа.

- Хүмүүст ажиглагдахгүй дөхөж очихын тулд гэж Рон тайлбарласнаа,

- Заримдаа үүнээсээ уйдаад тэдэн рүү гараа савчин орилж хашгиран гүйдэг юм

... Уучлаарай Гермиона гэв.

- Тэгээд Үхэл хажуу тийш болон ах дүү гурвыг замаа үргэлжүүлэхийг зөвшөөрчээ. Тэд цааш явах зуураа Үхлийн бэлэглэсэн гайхамшигтай зүйлийг өөр хоорондоо бахдан үзэцгээжээ.

- Ингээд ах дүүс өөр өөрсдийнхөө замаар салсан байна.

- Том ах нь долоо хоног явсны эцэст алсад орших нэг тосгонд очиход хэдэн шидтэнгүүд маргалдаж байлаа. Тэдний тулаанд ороод том ах нь ялсан бөгөөд гарт нь дийлдэшгүй саваа байхад өөр яах билээ. Өрсөлдөгч нь газар унаж үхэхэд том ах нь дэн буудалд ороод Үхэл ямар гайхамшигтай ялагдашгүй саваа өгсөнийг гайхуулан ярьжээ.

- Тэр шөнө нэг шидтэн том ахыг нь согтуу унтаж байхад нь оронд нь дөхөж очжээ. Хулгайч шидэт савааг аваад том ахынх нь хоолойг огтолсон байна.

- Ингэж Үхэл том ахыг нь авчээ.

- Энэ үед дунд ах нь гэртээ эргэж ирээд ганцаар амьдарч байлаа. Тэр үхсэнийг амилуулагч чулууг авч гартаа гурван удаа эргүүлэв. Тэгтэл гаймхамшиг болж урд нь өмнө гэрлэхийг хүсдэг байсан ч өвдөж нас барсан охин зогсож байв.

- Гэсэн ч тэр гунигтай хүйтэн байлаа. Хэдийгээр бодит ертөнцөд эргэн ирсэн ч энд багтах зай байсангүй тул зовж шаналж байв. Эцсийн эцэст дунд ах нь найдлагагүй болж ухаан солиороод хайрттайгаа хамт байхын тулд өөрийгөө алжээ.

- Ингэж Үхэл хоёр дахь ахыг нь авчээ.

- Гурав дахь хүүг нь Үхэл олон жил хайсан ч олсонгүй. Бага дүү хөгширөх үедээ үл үзэгдэх цуваа тайлж хүүдээ өгсөн байна. Тэр Үхэлтэй эртний андын ёсоор уулзсан бөгөөд баяртайгаар хамт явснаар бүгд энэ ертөнцийг орхижээ.

Гермиона номоо хаалаа. Хормын турш Ксенофилус уншиж дууссаныг ажигласангүй бололтой тэгснээ цонхноос харцаа салгаад хэлсэн нь,

- Энэ дээ гэв.

- Өршөөгөөрэй? гэж Гермиона асуулаа.

- Энэ бол Үхлийн шүтээн гэж Ксенофилиус хариулав.

Тэр овоолоостой зүйлээс цаасны өөдөс, галууны өдөн үзэг авлаа.

- Саваа гээд тэр цаасан дээр босоо дүрс зурав. - Үхлийг амилуулагч чулуу гээд гадуур нь дугуй дүрсэлснээ,

- Үл үзэгдэх цув гээд тойрог дотор гурвалжин дүрсэллээ. Ийм бэлэг тэмдэг л Гермионаг тайван байлгаагүй билээ.

- Бүгд хамтдаа Үхлийн шүтээн болно гэж ноён Лавгуд тайлбарлав.

- Гэхдээ үлгэрт Үхлийн шүтээн гэсэн үг дурьдагдаагүй шүү дээ! гэж Гермиона дуу алдав.

- Мэдээж байхгүй гэж Ксенофилиус сэтгэл хангалуун зөвшөөрөөд,

- Энэ бол хүүхдийг сургаж хөгжилтэй байхын тулд ярьдаг үлгэр. Гэхдээ хүмүүс энэ домогт маш эртний шидэт гурван зүйл болох эзэмшигч нь Үхлийг ялагчийн тухай өгүүлдэг гэдгийг ойлгодог юм гэв.

Нам гүм болоход Ксенофилиус ахин цонх руу харлаа. Нар тэнгэрийн хаяанд гудайжээ.

- Полумна одоо ирж байгаа байх гэж тэр аяархан хэлэв.

- Та «Үхлийг ялагч» гэж хэлсэн ... хэмээн Рон дуугарлаа.

- Ялагч. Давагч гээд юу ч гэж нэрлэж болно хэмээн Ксенофилиус хайхрамжгүй гараа савчив.

- Тэгвэл таны бодлоор ... гээд Гермиона шүүмжлэнгүй дуугарахгүй байхыг хичээж,

- Та эдгээр шидэт зүйлс үнэн хэрэгтээ байдаг гэж бодож байна уу? гэв. Ксенофилиус ахин хөмсгөө өргөлөө.

- Тэгэлгүй яахав!

- Гэхдээ энэ чинь ... гэж Гермиона биеэ арай ядан барьж хэлээд,

- Ноён Лавгуд та яаж ийм байж болшгүй зүйлд итгэж чадаж байна аа? ... гэв.

- Полумна надад таны тухай ярьсан залуу хатагтай минь. Миний ойлгож байгаагаар та ухаалаг хэдий ч туйлын хязгаарлагдмал юм. Явцуу. Хаалттай ухаантай гэж Ксенофилиус хэлэв.

- Гермиона магадгүй чи энэ малгайг өмсөөд үзэж болох юм гэж Рон санал болгоод инээдээ барьж ядан далавчтай чимэглэл рүү дохив.

- Ноён Лавгуд үл үзэгдэх цув байдаг гэдгийг бүгд мэднэ. Тэд их ховор ч гэсэн байдаг. Гэсэн ч ... хэмээн Гермиона ахин эхлэв.

- Үгүй үгүй, хатагтай Грейнжер гурав дахь шүтээн бол ердийн үл үзэгдэх цув биш! Энэ бол Хувиргах, Эрээлжлүүлэх зэрэг хагас үзэгдэхгүй болгодог шид хэрэглэхтэй адил биш. Үгүй жинхэнэ гайхамшиг ... цув эзнээ цаг хугацаанд хязгаарлагдалгүй бүрэн үзэгдэхгүй болгож түүнийг ямар ч шидээр илрүүлж чадахгүй! Та тийм зүйлтэй олон тааралдсан уу, хатагтай Грейнжер?

Гермиона амаа нээснээ ахин хаахад гурвуул бие бие рүүгээ харав. Харри тэдний адил зүйл бодож байгааг ойлгож байлаа. Ийм л цув тэдэнд байгаа билээ.

- Яг тийм! гэж Ксенофилиус маргаанд ялагчын дүртэй хэлээд,

- Та нарын хэн ч ийм зүйтэй учраагүй. Түүний эзэн ер бусын баян байх тийм үү? гэв.

Тэр ахин цонх руу харлаа. Үдшийн тэнгэр мэдэгдэм ягаарчээ.

- За яахав гэж Гермиона сэтгэлээр унан хэлээд,

- Цув байдаг гэж бодъё. Тэгвэл чулууны тухайд юу хэлэх гэж байна, ноён Лавгуд? Та түүнийг Үхсэнийг амилуулагч чулуу гэсэн үү? гэв.

- Та юуг нь сонирхоод байгаа юм?

- Тийм зүйл байх боломжгүй!

- Тэгвэл үүнийг батал л даа.

- Энэ чинь ... Уучлаарай ноён Лавгуд энэ чинь инээдтэй байна! Би яаж чулуу байдаггүй гэдгийг батлах юм бэ? Магадгүй та намайг ... дэлхийн бүх чулууг цуглуулаад шалгахыг хүсээ юу? Та үүнийг хэн ч байдаггүй гэдгийг нь баталж чадахгүй болохоор бодит гэж байгаа юмуу! хэмээн Гермиона уурсан хэллээ.

- Яг тийм. Би таныг эцэстээ оюун ухаанаа бага ч гэсэн нээсэн явдалд таатай байна.

- Тэгвэл саваа гэж Харри Гермионад маргах боломж өгөхгүйн тулд түргэн асуугаад,

- Та түүнийг үнэхээр байдаг гэж бодож байна уу? гэв.

- Өө, тэгэлгүй яахав үүнд тоо томшгүй олон гэрч байгаа! Саваа нэг эзэмшигчээс нөгөөд дамжин явдаг болохоор энэ тухай хялбархан олж болно.

- Яагаад тэр вэ? гэж Харри асуулаа.

- Савааны шинэ эзэмшигч өмнөх эзнийг нь хүчээр дийлж байж жинхэнэ эзэн болно. Та Эгберт Эгоист үхлийн тулаанд саваагаа Эмерик Эвилд алагдсан тухай сонссон байлгүй дээ? Ийм байдалтай Годелот зооринд оо төрсөн хүү Херевардад алагдаж саваагаа алдсан. Харин Локсия савааг Варнав Деверилл ийг алж авсан. Шидэт ертөнцийн түүхийн хуудсанд саваа цусан мөр татуулсаар ирсэн юм даа!

Харри Гермиона руу хяламхийлээ. Тэр Ксенофилиус руу хөмсөг зангидан харж байсан ч үгүйсгэсэнгүй.

- Тэгээд таныхаар бол саваа одоо хаана байгаа хэрэг вэ? гэж Рон асуулаа.

- Түүнийг хэн мэдэх билээ? гээд Ксенофилиус цонх руу харж,

- Саваа хаана нуугаастай байгааг хэн мэдэх юм? Мөр нь Аркус, Ливиус хоёр дээр замхарсан. Тэдний хэн нь Локсияг жинхэнээсээ дийлж савааг авсныг хэн мэдэх юм бэ? Бас өөр хэн тэднийг ялсан юм бол? Энэ тухай түүх бидэнд өгүүлээгүй.

Нам гүм болов. Эцэст нь Гермиона хүйтнээр,

- Ноён Лавгуд Певереллын гэр бүл Үхлийн шүтээнд ямар хамаатай юм бэ?

гэлээ.

Ксенофилиус хирдхийсэн байдалтай харагдахад Харрийн толгойд дурсамж зурсхийлээ. Певерелл ... тэр энэ нэрийг урьд нь сонсож байсан юм байна.

- Та яагаад миний толгойг эргүүлээд байна, залуу хатагтай минь! гээд

Ксенофилиус суудлаасаа босож Гермиона руу нүд бүлтийн ширтээд,

- Би таныг эрж байгаа зүйлийнхээ талаар юу ч мэддэггүй гэж бодсон юмсан!

Олонхи эрэгчид Певереллын гэр бүл ... үхлийн шүтээнтэй шууд бүх зүйлээрээ холбоотой байдаг гэдэгт итгэлтэй байдаг! гэв.

- Певерелл гэж хэн бэ? хэмээн Рон асуув.

- Энэ бол Годрикийн хонхорт булшны чулуун дээр байсан нэр! Тэнд тэмдэг байсан гээд Гермиона ноён Лавгуд руу нүд салгалгүй харж,

- Игнотус Певерелл гэж байсан гэв.

- Тиймээ, тийм! гээд Ксенофилиус хуруугаа ёсорхуу өргөж,

- Үхлийн шүтээн Игнотусын булшин дээр байдаг чинь шийдвэрлэх баталгаа биш үү! гэв.

- Юуны тэр вэ? гэж Рон асуулаа.

- Ах дүү гурван Певерелл болох Антиох, Кадмус, Игнотус нар үнэхээр байсан гэдэг! Тэд Үхлийн шүтээний анхны эзэмшигчид байсан юм.

Ксенофилиус ахин цонх руу харснаа бсож тавиур аваад эргүүлгэн шатаар буулаа.

- Хоолонд үлдэх үү? Бид өнөөдөр шөл хийх гэж байгаа! гэж уруудахдаа хашгирав.

- Түүнийг гэгээн Мунгогийн эмнэлэгийн хор хөнөөлтэй тасагт хэвтүүлвэл таарна гэж Рон чимээгүйхэн бувтнав.

Харри ноён Лавгуд гал зууханд орохыг хүлээснээ Гермионагаас,

- Юу хэлмээр байна даа? гэж асуулаа.

- Өө, Харри минь энэ чинь шал утгагүй юм! Бэлэг тэмдэг өөр зүйлийг дүрсэлсэн байх. Зөвхөн цагийн гарз л боллоо.

- Тэгээд ч энэ хүн шидэт ертөнцөд Үүрчгэр эвэртийг бэлэглэсэн! гэж Рон хэлэв.

- Чи бас түүнд итгэхгүй байгаа юм уу? гэж Харри асуулаа.

- Мэдээж үгүй. Ийм түүхийг хүүхүүдэд л хичээл дээр заадаг байх. Таагүй явдалд бүү орооцолд, битгий зодолд. Толгойгоо доошоо харуулаад чимээгүй суу ямар ч гэмтэлгүй сайн байх болно. Гэхдээ эндээс үзэхэд саваа золгүй явдлыг авчирдаг байх.

- Чи юуны тухай яриад байна?

- Мухар сүсэг байгаа юм. Таван сард төрсөн хүн маглтай гэрлэнэ. Бүрэнхийд шившлэг хэрэглэвэл шөнө дунд сүйрэнэ. Саваа гай зовлон авчирна. Ээжээс тийм үг зөндөө сонсож байлаа. Та нар мэдээж зуун удаа сонссон байлгүй.

- Харри бид хоёр маглуудын дунд өссөн шүү дээ. Тэнд өөр зүйл ярьцгаадаг юм гэж Гермиона сануулаад гал зуухнаас ямар нэг зүйл үнэртсэн бололтой гүн амьсгаа авлаа. Түүний уур хилэнд ганц л сайн зүйл байсан нь ноён Лавгудад уурласандаа Ронд уурлахаа мартчихжээ.

- Би чиний зөв гэж бодож байна гэж тэр Ронд хэлээд,

- Энэ бол ердөө л ёс суртахууны үлгэр. Хэрвээ эндээс аль нэгийг нь сонгох хэрэгтэй гэвэл ... гэхэд гурвуул зэрэг дуугарлаа.

- Жанч гэж Гермиона хэлэв.

- Саваа гэж Рон дуугарлаа.

- Чулуу гэж Харри хэллээ.

Тэд бие бие рүүгээ гайхширан харав.

- Чи цувыг сонгох нь тодорхой байсан юм гэж Рон Гермионад хэлээд,

- Үзэгдэхгүй болоход тийм савааны хэрэг байхгүй. Гэхдээ ялагдашгүй саваа гээд бодоод үз дээ! гэв.

- Бидэнд үл үзэгдэх цув байгаа шүү дээ гэж Харри хэлэв.

- Тэгээд ч бидэнд хичнээн их тусалсныг санах аваас! гэж Гермиона дуу алдаад,

- Харин энэ саваа зөвхөн гай зовлон авчирдаг бололтой гэв.

- Түүнийг хаа сайгүй орилох хэрэггүй байсан юм гэж Рон эсэргүүцээд,

- Зөвхөн усан тэнэг хүн л саваагаа толгой дээгүүрээ даллаж «Харж байна уу надад ялагдашгүй саваа байна хүсч байвал хүрээд ир!» гэж хашгирах байх. Хэрвээ чимээгүй байсан бол ... гэв.

- Хэрвээ чимээгүй байсан бол яах юм? гэж Гермиона асуугаад,

- Ксенофилиусын ярьсан зүйлээс зөвхөн ганц л зүйл үнэн байх. Зууны турш хүчирхэг шидэт савааны тухай домог амь дамжин яригдсаар ирсэн гэв.

- Үнэхээр үү? гэж Харри гайхлаа.

Гермиона түүн рүү уцаарлан харав. Энэ нүүрний хувирал хэтэрхий танил байсан болохоор Харри, Рон хоёр бие бие рүүгээ инээмсэглэн харлаа.

- Үхлийн саваа юмуу Хувь заяаны гээд янз бүрийн нэртэй саваа зуун жилийн турш хар шидтэнгүүдийн гар дамжин явж тэд үүгээр бардамнаж байсан. Профессор Бинс тэдний заримаас дурьдаж байсан ч ... Тиймээ энэ бүхэн утгагүй зүйл. Шидэт саваа шидтэнгээсээ хүчирхэг байх боломжгүй. Зүгээр л зарим шидтэн өөрсдийнхөө савааг бусдаас урт илүү сайн гэж гайхуулж байгаа хэрэг.

- Гэхдээ Үхлийн саваа, Хувь заяаны саваа үнэн хэрэгтээ нэг саваа биш гэдгийг яаж мэдэх юм? Зүгээр л янз бүрийн нэртэй явсан болохоос биш гэж Харри хэллээ.

- Тэгээд ч Үхлийн саваа үнэхээр байдаг бол яана? гэж Рон тодруулав.

Харри инээд алдтал толгойд нь гэнэтхэн утгагүй бодол орж ирэв ... Үгүй энэ бол дэмий зүйл. Түүний савааг гандигар биш шивээ навчит модоор Оливандер хийсэн гэж өөртөө сануулсан ч тэрбээр Волдеморт араас нь тэнгэрт хөөх үед хачирхалтай үйлдэл гаргасан билээ. Гэхдээ тэр ялагдашгүй байсан юм бол хугарах байсан гэж үү?

- Харин чи яагаад чулууг сонгож байгаа юм? гэж Рон сониучирхав.

- Хэрвээ үхсэнийг амилуулах боломжтой бол бид Сириус ... Хурц нүдэт ...

Дамблдор болон ... миний эцэг эхийг амилуулж чадах байсан. Рон, Гермиона хоёр инээсэнгүй.

- Гэхдээ Бидл Бардад итгэх аваас тэд эргэж ирэхийг хүсэхгүй биз дээ? гэж

Харри саяхан сонссон үлгэрийнхээ тухай бодон хэлээд,

- Ер нь тийм ч олон үлгэрт үхсэнийг амилуулдаг чулууны тухай гардаггүй биз дээ? гэв.

- Тиймээ гэж Гермиона гунигтайгаар батлаад,

- Би үүнийг зөвхөн ноён Лавгудын төсөөлөл гэж бодож байна. Бидл магадгүй энэ санааг гүн ухааны чулуунаас авсан байх. Та нар үхэшгүй мөнх болгодог чулуу үхлийн эсрэг гэдгийг мэднэ дээ гэв.

Гал зуухнаас түлэгдэж байгаа юм шиг үнэр улам хүчтэй ханхалсанд Харри

Ксенофилиусын хийж буй хоолыг идэж чадах эсэхдээ эргэлзлээ.

- Харин цувны тухайд юу бодож байна? гэж Рон удаанаар хэлээд,

- Түүний зөв гэж бодож байна. Би Харрийн цуванд дассан болохоор ямар гайхамшигтай талаар нь бодож үзэж байсангүй. Бас үүнтэй адил өөр цувны талаар ч сонсож байсангүй. Тэр маш найдвартай үйлчилдэг. Биднийг нэг ч удаа дор нь байхад ...

- Мэдээж шүү дээ ... тэр чинь үл үзэгдэх юм чинь, Рон!

- Үгүй, тэр бусад үл үзэгдэх цувын тухай үнэнийг хэлсэн! Миний толгойд сая л орлоо. Би цув удах тусмаа шид нь муудаж шившлэгэнд цоорон нүх гардаг тухай сонссон. Харин Харрийн цув урьд аавынх нь байсан хэрнээ яг л шинэ юм шиг маш сайн ажилладаг!

- За яахав тэгвэл чулууны тухайд, Рон ...

Тэднийг шивнэн маргалдаж байх зуур Харри өрөөн дундуур явж эргүүлгэн шат руу очоод дээшээ харлаа. Өрөөний адарт түүний нүүр тусч үзэгдэв. Гэсэн ч энэ нь толь биш зураг байлаа. Тэр гайхсандаа шатаар дээш өгсөв.

- Харри чи яаж байна аа? Урилгагүй бол гарч болохгүй!

Гэсэн ч Харри дээд давхарт хүрчээ. Полумна унтлагын өрөөнийхөө таазанд таван гайхамшигтай зураг болох Харри, Рон, Гермиона, Жинни, Невиллийн царайг зурсан байлаа. Хогвартсын хөргүүдээс ялгаатай нь тэд хөдлөхгүй ч ямар нэг шид байлаа. Харрид тэд амьсгалж байх шиг санагдав. Хөргүүдийн хооронд холбон нарийхан алтан гинж хөвөрч байсан нь мянган удаа алтан үсгээр найзууд ... найзууд ... найзууд гэж бичжээ.

Харри сэтгэл хөдлөхөө мэдэрлээ. Орны хажуугын ширээн дээр жижигхэн Полумна өөртэйгээ маш адилхан эмэгтэйтэй тэврэлдэн зогсож байгаа зураг харагдана. Полумна гэрэл зурган дээр амьдрал дээр байдгаасаа илүү сайхан гарчээ. Гэрэл зураг тоостой байлаа. Энэ нь Харрид хачирхалтай санагдсанд эргэн тойрноо анхааралтай харлаа.

Энд нэг л зүйл биш байлаа. Цайвар цэнхэр хивс битүү тоосонд дарагджээ. Шүүгээний хаалга дутуу хаагдсан бөгөөд нэг ч хувцас байсангүй, ор дээр хүйтэн

тухгүй харагдаж эртнээс хэн ч унтаагүй мэт байлаа. Ойролцоох цонхонд аалзны шүлс торлосон харагдана.

- Юу болоо вэ? гэж Гермиона Харриг шатаар уруудахад асуулаа. Гэвч түүнийг хариулж амжихаас өмнө гал зуухнаас Ксенофилиус тавиур дээр шөлтэй таваг барьсаар гарч ирэв.

- Ноён Лавгуд Полумна хаана байна? гэж Харри асуулаа.

- Өршөөгөөрэй?

- Полумна хаана байна?

Ксенофилиус шатны дээд гишгүүр дээр хөшив.

- Би ... би та нарт хэлсэн биз дээ. Гүүрний дор байгаа гэж.

- Тэгвэл та яагаад тавиур дээр дөрвөн аяга авчирсан юм?

Ксенофилиус цааш ярьж чадсангүй. Өрөөнд хэвлэлийн машины түжигнэх болон аяга таваг харжигнах чимээ гарч түүний гар чичирлээ.

- Би энд Полумна байсан гэж бодохгүй байна. Түүний хувцас байхгүй ор дээр нь засагдаагүй байна. Тэр хаана байна? Бас та яагаад үргэлж цонхоор хараад байгаа юм бэ?

Ксенофилиусын гараас тавиур мултрахад шалан дээр таваг унаж хагарлаа. Харри, Рон, Гермиона гурав шидэт саваагаа гаргахад Ксенофилиусын халаас руугаа явсан гар хөшив. Энэ агшинд хэвлэлийн машин хүчтэй чичирснээ бүтээлгэн дороос олон тооны цаас шалан дээр асгараад чимээгүй болов.

Гермиона доош тонгойн шалан дээрээс сэтгүүлийг авахдаа шидэт саваагаа ноён Лавгудаас салгасангүй.

- Харри, хараач!

Тэр дөхөж очоод сэтгүүл рүү хартал хавтсан дээр гарсан өөрийнх нь том зурган дор «Номер нэг сэжигтэн» гэж бичээд шагнал амласан байхыг харав.

- Тэгэхээр «Шүүмжлэгч» сэтгүүл байр сууриа өөрчилсөн хэрэг үү? гэж Харри хүйтнээр асуугаад,

- Ингэхэд та яах гэж цэцэрлэг рүү гарсан юм, ноён Лавгуд? Ид шидийн яам руу ууль илгээгээ юу? гэв.

Ксенофилиус уруулаа жимийлээ.

- Тэд Полумнаг барьсан. Миний нийтлэлээс болоод. Тэд Полумнаг минь барьсан болохоор хаана юу хийж байгааг нь мэдэхгүй байна. Гэхдээ хэрвээ намайг суллана гэсэн ... хэрвээ ...

- Харриг барьж өгвөл үү? гэж Гермиона яриаг нь дуусгав.

- Энэ бүтэхгүй гэж Рон хатуу хэлээд,

- Явцгаая! Зам чөлөөл! гэв.

Ксенофилиус харахаас аймшигтай болов. Тэр зуун жилээр хөгшрөх адил болж уруул дээр нь айдас хүрэм инээмсэглэл тогтжээ.

- Тэд энд одоохон ирнэ. Би Полумнаг аврах ёстой. Би түүнийг алдаж чадахгүй!

Та нар хаашаа ч явахгүй.

Тэр гараа дэлгэн зогсоод шатны хашлагыг хаахад Харри гэнэтхэн ээж нь хүүхдийн орны урд тэгж хааж зогссоныг саналаа.

- Бид таныг гэмтээхийг хүсэхгүй байна. Замаас холд, ноён Лавгуд.

- Харри!!! гэж Гермиона хашгирлаа.

Цонхны цаана шүүртэй хэдэн дүрс зурсхийн өнгөрөв. Тэднийг эргэх агшинд Ксеонофилиус шидэт саваагаа гаргаж ирлээ. Гэсэн ч Харри цагийг нь олж алдаагаа ойлгоод хажуу тийш үсрэн холдохдоо Рон, Гермиона хоёрыг түлхэн холдуулсанд Ксенофилиусын Хөшөөх шид дэргэдүүр нь нисэн өнгөрч Эрумпентийн эврийг онолоо.

Аймшигтай дэлбэрэлт болон өрөө бут үсрэх шиг санагдав. Мод цаасны өөдөс зүг бүр нисэлдэн өтгөн цагаан тоос бужигнав. Харри хажуу тийш үсрээд юу ч харалгүй гараа толгойн дээгүүрээ хамгаалан унав. Гермиона хашгирч, Рон орилон дэлбэрэх чимээ ээлж дараалан гарахад Ксенофилиус цохилтонд өртөн шатны доошоо өнхөрлөө.

Харри хэмхэрхий дундаас босохыг оролдов. Эргэн тойрон тоосноос өөр юу ч харагдахгүй байв. Адрын тал нурж Полумнагийн орны хөл цухуйна. Дэргэд нь Кандида Когтевраны цээж баримал хэвтэж байсан бөгөөд царайных нь тал алга болж, агаарт цаас хаа сайгүй нисэлдэн, хэвлэгч машин харуулдан унаж гал зуухнаас шат руу өгсөх замыг хаажээ. Харрийн дэргэд Гермонагийн тоосонд хучигдсан хөшөө шиг дүрс гарч ирээд хуруугаараа уруулаа дарлаа.

Дор хаалга тасхийн нээгдлээ.

- Би чамд яарах хэрэггүй гэж хэлсэн биз дээ, Трэверс? Үүнийг галзуу амьтан болохоор ердийнхөөрөө дэмийрч байна гэж хэлсэн биз дээ? гэх бүдүүлэг хоолой сонсогдлоо.

Чанга тасхийгээд Ксенофилиус өвдсөндөө хашгирав.

- Үгүй ... үгүй ... дээр ... Поттер!

- Би чамд өнгөрсөн долоо хоногт ийшээгээ хуурамч дуудлагаар ирж чадахгүй анхааруулсан, Лавгуд! Чи үүнийг мартаа юу? Охиноо тэнэг толгойн чимэглэлээр сольж авах гэсэн юм биз дээ? гээд ахин тасхийхэд хашгирах чимээ гарлаа.

- Чи түүнийг эргүүлж авахыг мөрөөдсөндөө бидэнд үрчгэр (тас няс) ... эвэрт ... байдаг ... гэдгийг батлах гэсэн юм уу ...? (тас няс).

- Үгүй! Үгүй! Гуйж байна! гэж Ксенофилиус цурхираад,

- Тэнд үнэхээр Поттер байгаа! Үнэн шүү! гэлээ.

- Харин одоо биднийг дэлбэлэхийг завдаа юу! гэж Үхэл залгигч орилоод ээлжит тас няс хийсэн цохилтын дараа Ксеонфилиусын зовж шаналсандаа өрөвдөлтэй гонгинох дуу гарав.

- Энэ газар одоохон нурах нь, Селвин гэж өөр хүйтэн хоолой хэлэхэд шатны дээш цуурайтав. - Шат хаагдсан байна. Цэвэрлэх гээд үзэх үү? Доош нь буулгаад.

- Чи бол өөдгүй худалч! гэж Селвин нэртэй шидтэн хашгираад,

- Чи ямар ч Поттерыг амьдралдаа хараагүй! Биднийг хуурч алах гээ юу? Ийм аргаар охиноо эргүүлэн авах гэсэн юм биз дээ? гэв.

- Би тангараглаж байна ... Тангараглая ... Поттер дээр байгаа!

- Хоменум ревелио! гэж шатны хөлд зогсож байсан хоёр дахь хоолой хэллээ.

Харри Гермионагийн дуу алдахыг сонстол ямар нэг зүйл толгой дээгүүр нь нисээд сүүдэрт оров.

- Селвин тэнд үнэхээр хэн нэгэн байна гэж хоёр дахь шидтэн ширүүн хэллээ.

- Энэ бол Поттер гэж би хэлсэн биз дээ, энэ бол Поттер! гэж Ксенофилиус уйлагнаад,

- Полумнаг минь өг, зөвхөн Полумнаг минь буцаагаад өг ... гэв.

- Хэрвээ чи дээшээ өгсөөд Харри Поттерыг авчрах юм бол жижигхэн охиноо авах болно, Лавгуд гэж Селвин хэлээд,

- Харин хуурч мэхлэх юмуу хамтрагч чинь тэнд хүлээж байвал охиноос чинь оршуулж болох хэсэг үлдэхийг мэдэхгүй байна гэв.

Ксенофилиус цөхөрч айсандаа хашгирлаа. Дараа нь шат чахрах чимээ гарч

Ксенофилиус эвдэрхий шатаар өгсөхийг оролдож буй бололтой.

- Явъя. Холдох хэрэгтэй байна гэж Харри шивнэлээ.

Тэр дарагдсан хэмхэрхий дороосоо гартал Ксенофилиусын шат хяхтнуулан өгсөх нь сонсогдлоо. Рон бүгдээс илүү булагджээ. Харри, Гермиона хоёр аль болох чимээгүйхэн овоолоостой хогийг зайлуулан цээжин дээр нь дарсан хүнд шүүгээг холдуулахыг оролдов. Ксенофилиус чахруулсаар улам ойртоход Гермиона Роныг тавиад Хөөргөх шид хэрэглэлээ.

Шатны дээд талын хэвлэлийн машин гашуудалтай чахарч тэрбээр хэдхэн алхамын зайд иржээ.

- Харри чи надад итгэж байна уу? гэж тоосонд хучигдсан Гермиона асуулаа. Харри толгой дохив.

- Сайн байна тэгвэл надад үл үзэгдэх цуваа өг. Рон дор нь орог.

- Би юу? Гэхдээ Харри ...

- Маргах хэрэггүй, Рон! Харри миний гараас чанга бариарай. Рон мөрнөөс барь.

Харри зүүн гараа сунгалаа. Рон цуван дор алга болоход хэвлэлийн машин улам хүчтэй чичигнэн Ксенофилиус Хөөргөх шидээр холдуулах гэж буй бололтой. Харри Гермионагийн юу хүлээгээд байгааг ойлгосонгүй.

- Чанга бариарай ... одоохон гэж тэр шивнэлээ.

Ксенофилиусын цаас шиг цонхигор царай шүүгээн дээгүүр гарч ирэв.

- Обиливэйт! гэж Гермиона хашгираад түүний нүүр нүүр лүү шидэт саваагаа чиглүүлснээ дараа нь шал руу чиглүүлж,

- Депримо! гэв.

Тэр зочны өрөөний шаланд дэлбэлэн том нүх гаргахад гурвуул доошоо үхэр чулуу шиг уналаа. Харри Гермионагийн гараас чанга зуурав. Дор хашгиралт сонсогдон гүйлдэж буй хоёр хүн хальт харагдсанаа дээрээс нь эвдэрсэн тавилга хэрэгслийн хэмхэрхий асгарав. Гермиона агаарт атиралдан тасхийхэд Харри байшин нурах нижгэнэсэн чимээн дор харанхуйд татагдан орлоо.

БҮЛЭГ 22: ҮХЛИЙН ШҮТЭЭН

Харри өвсөн дээр унаад амьсгаадан хөл дээрээ үсрэн бослоо. Тэд үдшийн бүрийд ямар нэг талбайн захад газардсан бололтой. Гермиона хэдийн тойрон гүйж шидэт саваагаа даллаж байлаа.

- Протего тоталум ... Сальвио гексиа ...

- Өөдгүй урвагч! гээд Рон үл үзэгдэх цуван дороос гарч Харрид өгөөд,

- Гермона чи агуу, зүгээр л агуу! Одоо хүртэл тэндээс мултарсандаа итгэхгүй нь! гэв.

- Каве инимикум ... Би Крумпентийн дэлбэрдэг эвэр гэж хэлсэн биз дээ! Тийм учраас л сая байшин нь дэлбэрсэн хэрэг.

- Түүнийг тэгэх л хэрэгтэй байсан юм гэж Рон бувтнаад жинс нь урагдан зүсэгдсэн шархаа харж,

- Та нар одоо түүнийг яах бол гэж бодож байна? гэлээ.

- Өө, түүнийг битгий алаасай гэж найдаж байна! гэж Гермиона ёолоод,

- Би Ксенофилиус Үхэл залгигчдыг хуураагүй гэдгийг үзүүлэхийн тулд Харриг харах боломж олгосон юм! гэв.

- Тэгвэл яагаад намайг нуусан юм? гэж Рон асуулаа.

- Чи чинь гэртээ тууралтаар өвдөөд хэвтэж байгаа биз дээ, Рон! Тэд нар Полумнаг эцэг нь сэтгүүлдээ Харриг дэмжсэн нийтлэл бичсэний төлөө барьцаанд авсан байна. Хэрвээ чамайг хамт байхыг харах юм бол гэрийнхэнд чинь юу тохиолдоно гэж бодож байна?

- Харин чиний ээж аав яах болж байна?

- Тэд Австралид сайн байгаа. Бас энэ талаар юу ч мэдэхгүй болохоор ямар ч зүйл тохиолдохгүй.

- Чи агуу гэж Рон давтаад түүнийг бишрэн харав.

- Энэ ч тодорхой, Гермиона. Чамайг байхгүй байсан бол юу хийхээ мэдэхгүй юм гэж Харри дэмжив.

Гермиона баясан инээмсэглэснээ тэр даруй чухал төрхтэй боллоо.

- Полумна яах болж байна?

- Гэхдээ тэд үнэн хэлсэн бол амьд байгаа байх ... хэмээн Рон эхлэв.

- Ингэж бүү хэл, бүү хэл! Тэр үхэж болохгүй! гэж Гермиона хашгирлаа.

- Тэр Азкабанд байгаа байх. Тэнд амьд үлдэж болох ч ... Олон хүмүүс тэсч чаддаггүй ... гэж Рон хэлэв.

- Полумна тэсч чадна гэж Харри хэлэхэд сэтгэл нь тавгүй болов. - Тэр харагдаж байгаагаасаа илүү хамаагүй чанга. Одоо нөхөдтэйгээ өрөөндөө суугаад Наргл болон тархи сатааруулагчын талаар ярилцаж байгаа биз.

- Чиний зөв гэж найдъя. Надад Ксенофилиус өрөвдөлтэй байна ... гээд

Гермиона харц буруулав.

- Хэрвээ тэр биднийг Үхэл залгигчдад барьж өгөх гээгүй бол ч гэж Рон хэллээ.

Тэд майхнаа босгоод дотор нь орж Рон бүгдэд цай аягалав. Тэдний дээсэн дөрөөн дээр аврагдсаны дараа хуучирч сэмэрсэн хүйтэн майхан төрсөн гэр шиг нь найдвартай тохилог санагдах ажээ.

Хэсэг зуур бүгд чимээгүй байсны эцэст Гермиона дуугарлаа.

- Бид тэгээд яах гэж тэнд очсон болж байна? Харри чиний зөв байж. Яг л Годрикийн хонхор шиг цаг үрснээс өөр юм алга! Үхлийн шүтээн гэнэ шүү ... Юун дэмий үг вэ ... ер нь бол гээд толгойд нь өөр юм орж ирсэн бололтой,

- Магадгүй Ксенофилиус энэ бүхнийг өөрөө бодож олсон юм болов уу? Тэр ямар ч үхлийн шүтээнд итгэдэггүй байгаад биднийг Үхэл залгигчид иртэл саатуулахыг хүссэн байх! гэв.

- Би тэгж бодохгүй байна. Сэтгэлийн дарамтанд орсон хүн ямар нэг юм бодож олох нь хараал идсэн хүнд зүйл. Намайг ангуучид барьж авахад өөр хүний тухай бодож байснаас жаахан ч гэсэн мэддэг учир Стэн Шанпайкын дүр эсгэсэн нь дээр байсан. Лавгудын аав бас сэтгэлийн дарамтанд байсан болохоор биднийг саатуулахыг оролдсон. Би түүнийг үнэн хэлсэн гэж бодож байна ... Ямар ч гэсэн тэр ярьж байгаа зүйлдээ итгэдэг нь үнэн шүү гэж Рон дуугарлаа.

- Би үүнийг байх боломжгүй зүйл гэж бодож байна гэж Гермиона хэлээд,

- Хэрвээ тэр худал хэлээгүй юм бол амьдралдаа ийм утгагүй зүйл сонсож байсангүй гэв.

- Хүлээгээрэй. Нууц өрөөг бас бодож олсон зүйл гэж бодож байсан биз дээ?

гэж Рон хэлэв.

- Гэхдээ үхлийн шүтээн бол байх боломжгүй зүйл, Рон!

- Чи үргэлж үүнийгээ давтаж байх юм. Харин тэдний нэг үнэхээр байдаг.

Харрийн үл үзэгдэх цув ...

- Ах дүү гурвын үлгэр бол ердөө домог яриа гэж Гермиона хатуу мэдэгдээд,

- Энэ түүх хүний үхлээс айх айдсаас урган гарсан. Хэрвээ зөвхөн үл үзэгдэх цуван дор нуугдаад амьд үлддэг бол бидэнд хэрэгтэй бүх зүйл маань байна! гэв.

- Мэдэхгүй л юм. Минийхээр бол ялагдашгүй саваа бидэнд саад болохгүй л юмсан гэж Харри үглээд гартаа дургүй саваагаа эргэлдүүлэв.

- Тийм саваа байхгүй, Харри!

- Чи өөрөө Үхлийн гээд янз бүрийн нэртэй ... олон саваа байдаг гэж хэлээ биз дээ ...

- За яахав тэр савааг үнэхээр байдаг гэж төсөөлөөд үзье тэгвэл үхсэнийг амилуулагч чулууны тухай юу хэлэх болж байна? гээд Гермиона хуруугаараа чулууг бэлэгдсэн тойрогыг дурснаа даажигнасан өнгөөр,

- Ямар ч шид үхсэн хүнийг босгохгүй, тэгээд л тэр! гэв.

- Миний саваа Хэцүү нэрттэй холбогдох үед ээж, аав минь гарч ирсэн ... бас

Седрик ...

- Тэгэхдээ тэд жинхэнээсээ эргэж ирээгүй биз дээ! Энэ бол ... төстэй хуулбар нь байсан болохоос жинхэнээсээ амь орсон хэрэг биш.

- Гэхдээ үлгэрийн охин бас жинхэнээсээ эргэж ирсэн биз дээ? Тэнд хэлэхдээ үхсэн хүнд бодит ертөнцөд байр байхгүй гэсэн. Тэгсэн ч гэсэн хоёр дахь ах нь түүнийг харж ярьж байсан ... Тэр ч байтугай түүнтэй хэсэг зуур амьдарсан ...

Харри Гермионагийн нүүрэнд айдас илрэн гарахыг харлаа. Тэр түүнийг үхсэн хүмүүсийн тухай яриагаараа айлгасан бололтой.

- Бас тэр Годрикийн хонхорт оршуулагдсан Певерелл гэж хүн байна хэмээн байгаа утгагүй зүйл ярьж байгаа хүний байртай түргэн хэлээд,

- Чи түүний тухай үнэхээр юу ч мэдэхгүй юу? гэлээ.

- Үгүй гээд Гермиона ярианы сэдэв өөрчлөгдсөнд баярлан,

- Би булшин дээрээс тэмдгийг нь харсны дараа нэрийг нь хайсан. Тэр алдартай байсан бол аль нэг номд гарцаагүй дурьдагдах байсан. Гэсэн ч би Певерелл гэсэн овгийг зөвхөн Кикимерээс түр авсан «Язгууртан шидтэний уг гарал» гэдэг номд харсан юм байна гээд Роны хөмсөг өргөгдөхийг хармагц,

- Энэ бол цэвэр цусны эрэгтэй шидтэнгүүдийн мөхсөн удмын жагсаалт байгаа юм. Миний ойлгосоноор Певереллын гэр бүл тэдний нэг байсан гэв.

- Мөхсөн эрэгтэйчүүдийн жагсаалт гэдэг чинь юу гэж байгаа юм? гэж Рон асуулаа.

- Энэ нь гэр бүлийн овгийг нь өөр хэн ч зүүдэггүй хүмүүсийн тухай ярьж байгаа юм. Хэдийгээр эмэгтэйчүүд нь байж болох ч өөр овогтой гэж Гермиона тайлбарлав.

Тэгтэл Харрийн санаанд нэг зүйл оров. Тэр «Певерелл» гэсэн овгийг хөгшин шидтэн яамны ажилтаны царайд бөгжөө тулгахад нь харснаа санаад,

- Марвало Мракс! гэж чанга хашгирав.

- Юу гэнээ? хэмээн Рон, Гермиона хоёр зэрэг асуулаа.

- Марвало Мракс! Хэцүү нэртийн өвөө! Дамблдорын гүн ухааны цүнхээлд байсан! Марвало Мракс хэлэхдээ Певереллын угсаа гэсэн!

Рон, Гермиона хоёр түүн рүү үл итгэн харлаа.

- Марвало Мракс крестраж болгон хувиргасан бөгжин дээр Певереллийн сүлд байгаа гэсэн! Би түүнийг яамны ажилтны хамрын урд тулган үзүүлэхэд нь харсан юм байна!

- Певереллийн сүлд гэнээ? Юутай адилхан байна? гэж Гермиона асуув.

- Тийм ч сайн биш. Тэнд онцгой зүйл юу ч байгаагүй. Хэдэн сараачсан дүрс байсан. Би түүнийг эвдэрсэн хойно нь ойроос харсан юм.

Гермионагийн нүд гэнэтхэн томорлоо. Рон тэвдэнгүй Харри руу харав.

- Чөтгөр гэж ... Чи ахиад л энэ тэмдэг гэж бодож байна уу? Үхлийн шүтээн үү?

- Яагаад үгүй гэж? хэмээн Харри догдлон хэлээд,

- Марвало Мракс удам угсаанаасаа өөр юу ч сонирхдогүй гахай шиг амьдардаг хөгшин байсан юм. Хэрвээ бөгж зууны өмнөөс түүнд залгамжлагдан ирсэн бол үнэн хэрэгтээ юу гэдгийг нь мэдээгүй байх. Тэдний гэрт ямар ч ном байхгүй гэдэгт надад итгээрэй. Тэр хүүхдийн үлгэр ч уншиж байгаагүй. Түүнд зүгээр л чулуун дээрх хэдэн сүлдний зураас цэвэр цусны угсаа гэдэг дээрхийг нь баталдаг гэж бодохоос аятайхан байдаг юм гэв.

- Тиймээ ... Энэ бүгд их сонирхолтой юм. Гэхдээ Харри чи миний бодож байгааг бодож байна уу ... гэж Гермиона болгоомжтой хэлэв.

- Яагаад үгүй гэж? Яагаад үгүй гэж? хэмээн Харри хашгираад,

- Чулуу мөн байсан уу гэж үү? Хэрвээ үхсэнийг амьдаруулагч чулуу мөн байвал яана? гээд Рон руу дэмжлэг эрэн харлаа.

Тэр амаа ангайжээ.

- Хөөх ... гэдээ Дамблдор түүнийг эвдэлсэн бол ажиллаж байгаа болов уу?

- Ажиллаж байсан уу гэнээ? Рон, тэр хэзээ ч ажиллаж байгаагүй! Ямар ч үхсэнийг амьдруулах чулуу байхгүй! гээд Гермиона уурсаж хилэгнэсэндээ үсрэн бослоо.

- Харри чи Үхлийн шүтээний түүхэнд бүх зүйлийг хамааруулахыг хичээгээд байна ...

- Бүх зүйлийг хамааруулах гэнээ? хэмээн Харри давтаад,

- Тэгвэл бүгдийн учир өөрөө олдлоо! Би чулуун дээр Үхлийн шүтээний тэмдэг байсныг мэдэж байна! Харин Мракс хэлэхдээ түүнийг Певереллээс залгамжлан авсан гэсэн! гэв.

- Чи дөнгөж сая чулуун дээр ямар ч тэмдэг хараагүй гэж хэлээ биз дээ!

- Харри чи одоо бөгжийг хаана байгаа гэж бодож байна? Дамблдор түүнийг эвдэлсний дараа юу хийсэн бол? гэж Рон асуув.

Гэсэн ч Харрийн бодол тэднээс алсад байлаа.

Гурван шидэт зүйл Үхлийн шүтээн болон нэгдэж эзэндээ үхлийг ялахад туслана ... Эзэн ... Ялагч ... Дийлэгч ... Сүүлчийн дайснаа үхэх хүртэл ...

Тэр хэдийн өөрийгөө крестражтай харьцуулахааргүй гурван бэлэг тэмдэгийг эзэмшээд Волдеморттой нүүр тулгарч байгааг харлаа ... Тэдний нэг нь нөгөөгөө амьд байх үед тайван байх боломжгүй ... Магадгүй энэ хариулт юм болов уу? Шүтээн крестражын эсрэг? Хэрвээ тийм бол түүнд ялах боломж байна гэж үү? Хэрвээ түүнд гурван Үхлийн шүтээн байгаа бол хамгаалах болов уу?

- Харри!

Гэхдээ тэр Гермионаг сонссонгүй. Харри үл үзэгдэх цуваа гаргаад хурууныхаа завсраар гүйлгэлээ. Ус шиг уян зөөлөн, агаар шиг хөнгөхөн. Долоон жил шидэт ертөнцөд байхдаа Харри үүнтэй төстэй ямар ч зүйлтэй учирч байсангүй. Ксениофилиус яг л ийм зүйлийг хэлсэн билээ.

Тэгтэл гэнэтхэн саналаа ...

- Миний эцэг эхийг үхдэг шөнө үл үзэгдэх цув Дамблдорт байсан! гэж Харри гэнэтхэн дуу алдав.

Түүний хацар халуу оргиж хоолой нь чичирсэн ч тоосонгүй.

- Ээж Сириуст бичсэн захиандаа Дамблдор цувыг түр авсан гэсэн! Түүгээр юу хийх гэсэн юм бол! Тэр түүнийг судлахыг хүсэж тэр бас үүнийг гурав дахь шүтээн гэж бодож байж! Игнотус Певерелл Годрикийн хонхорт оршуулагдсан ... гээд Харри майхан дотор холхитол итгэмээргүй үнэн урд нь цэлсхийн нээгдлээ.

- Тэр миний өвөг эцэг байж ... Би гурав дахь хүүгийн удам угсаа юм байна!

Бүгдийн учир олдлоо!

Тэр шүтээн хамгаалалт өгөх санаанд зоригжсондоо аз жаргалтайгаар найзууд руугаа эргэв.

- Харри гэж Гермиона ахин хэлсэн ч тэр чичирсэн гараараа Хагридын өгсөн хүүдийг онгойлгох гээд тоосонгүй.

- Унш! гээд Харри Гермионад ээжийнхээ захиаг сунгалаа.

- Унш! Гермиона, Дамблдор түүнийг үл үзэгдэх цувыг авсныг! Түүнд яагаад хэрэг болсон гэж? Тэр Хувирагч шидийг хүчтэй эзэмшсэн болохоор үүний тусламжгүй үл үзэгдэх болж чадна!

Ямар нэг зүйл шалан дээр гялсхийн унаж өнхрөн сандал доогуур оров. Харри захиагаа авахдаа снитчийг санамсаргүй гаргажээ. Тэр жигүүртэй бөмбөгийг авахаар бөхийснөө гэнэтхэн гайхамшигтай санаа орж ирсэнд баярлаж хөөрсөндөө хашгирав.

- Тэр энд байна! Дамблдор надад бөгжийг орхиж! Тэр энд снитчэн дотор байна!

- Чи ... чи тэгж бодож байна уу?

Харри Роны яагаад хирдхийсэн учрыг ойлгосонгүй. Харин түүний хувьд бүх зүйл ойлгомжтой байлаа. Түүний цув гурав дахь шүтээн юм бол снитчийг онгойлгосноор хоёр дахийг нь аваад одоо зөвхөн эхний шүтээнийг олох л үлдлээ, Ялагдашгүй саваа тэгвэл ...

Гэнэтхэн хөшигний цаана туссан гэрэл унтрах адил болж бүхий л баяр хөөр найдлага нь сарнин Харри харанхуйд ганцаар үлдэв. Гайхамшигтай шид бөхлөө.

- Тэр түүнийг эрж байна.

Түүний хоолойны өөрчлөгдсөн өнгө Рон, Гермиона хоёрыг улам их айлгалаа.

- Хэцүү нэрт ялагдашгүй савааг эрж байна.

Харри тэдэн рүү эргээд үл итгэсэн царайтай нүүр туллаа. Тэр үүний үнэн болохыг мэдэж байв. Бүгдийн учир олдлоо! Волдеморт шинэ шидэт саваа эрсэнгүй харин маш хуучин эртний саваа эрж байж. Харри майхны үүдэнд алхан гарахдаа Рон, Гермпона хоёрын байгааг мартаад харанхуй руу харан бодлогоширов ...

Волдеморт маглуудын өнчин хүүхдийн газар өссөн. Түүнд хэн ч Харрийнх шиг

«Бидл Бардын үлгэрүүд»-ийг хэлээгүй. Харин насанд хүрсэн шидтэнгүүдийн ихэнхи нь үхлийн шүтээнд итгэдэггүй. Тэгвэл Волдеморт энэ тухай хаанаас мэдсэн байж болох вэ?

Харри харанхуй руу харлаа ... хэрвээ Волдеморт үхлийн шүтээнийг тухай мэдэж байсан бол гарцаагүй тэднийг аван гурван шидэт зүйлийн эзэн болж Үхлийг ялахыг хүсэх байсан нь эргэлзээгүй ... Хэрвээ тэр үхлийн шүтээний тухай мэдэж байсан бол крестраж шаардагдахгүй байсан. Тэр нэг бэлэг тэмдэгийг крестраж болгон хувиргаснаараа сүүлчийн агуу их шидэт нууцыг мэддэггүй гэдгээ үзүүлж байгаа хэрэг.

Тэгэхээр Волдеморт савааны хүчийг нь ойлголгүй эрж байна ... тэр гурван бэлэг тэмдэг юу болохыг ойлгосонгүй ... Ердөө л савааны түүх илхэн учраас олон хүн мэднэ. Шидэт ертөнцийн түүхийн хуудсанд саваа цусан мөр татуулсаар ирсэн ...

Харри тэнгэр лүү харлаа. Бараан саарал үүлний цаанаас мөнгөлөг сар гялалзав. Олж мэдсэн зүйлдээ болоод түүний толгой эргэлээ.

Тэр майханд эргэж ороод Рон, Гермиона хоёр яг орхисон байдалтай хэвээр зогсохыг хараад цочирдлоо. Гермона гартаа Лилигийн захиаг барьсан хэвээр, Рон үл мэдэг түгшсэн янзтай байв. Тэд түүнийг хэдхэн хоромд ямар агуу их аялал хийснийг мэдсэн болов уу?

- Одоо бүх зүйл ойлгомжтой боллоо гэж Харри тэднийг гайхуулна гэдэгт итгэлтэй хэлээд,

- Энэ бүгдийн учрыг тайлбрлалаа. Үхлийн шүтээн үнэхээр байдаг бөгөөд надад нэг нь байна ... Эсвэл хоёр ч байж болох юм гээд снитчийг өргөлөө.

- Харин Хэцүү нэрт гурав дахийнх нь араас юу болохыг нь ойлголгүй хөөж байна ... Тэр үүнийг ердөө маш хүчирхэг саваа гэж бодож байна ...

- Харри ... намайг уучлаарай гэхдээ чи гүнзгий төөрөлдөж байна гээд Гермиона захиаг нь өгөхөөр ойртлоо.

- Чи ойлгохгүй байгаа юм уу? Бүгдийн учир олдсон!

- Ямар ч тийм биш. Юуны ч учир олдоогүй. Харри чи зүгээр л дур татагдаж байгаа хэрэг. Алив л дээ! гэж тэр дуу алдаад,

- Надад ердөө ганц л асуултанд хариулаад өг. Хэрвээ Үхлийн шүтээн үнэхээр байдаг Дамблдор гурван шүтээнийг цуглуулсан хүн Үхлийг ялахыг мэдэж байсан юм бол ... Харри тэр яагаад энэ тухай чамд хэлээгүй юм бэ? Яагаад?

Хариулт Харрид бэлхэн байлаа.

- Чи өөрөө хэлсэн биз дээ, Гермиона! Учир нь үүнийг өөрөө заавал мэдэх ёстой гэж! Эрэх ёстой!

- Би ердөө чамайг Лавгудынх руу хамт явахаар ятгахын тулд тэгсэн юм гэж

Гермиона тэвчээр алдан хашгираад,

- Үнэн хэрэгтээ ерөөсөө тийм зүйл бодоогүй! гэлээ. Гэсэн ч Харри үүнийг анхаарсангүй.

- Дамблдор үргэлж намайг өөрийн ухаандаа найд гэж хэлдэг байсан. Тэр надад эрсдэлд орон хүчээ турших боломж олгосон. Энэ бол түүний хэв маяг байгаа юм.

- Харри энэ чинь тоглоом биш бүх зүйл жинхэнээсээ байна! Бүгд үнэнээсээ байна! Дамблдор чамд крестражуудыг эрж олоод устга гэсэн тодорхой даалгавар үлдээсэн! Энэ бэлэг тэмдэг юу ч илэрхийлэхгүй болохоор Үхлийн шүтээнийг мартаж үз. Бидэнд сатаарч байх хэрэг байхгүй ...

Гэсэн ч Харри түүнийг сонссонгүй. Тэр гартаа снитчийг эргүүлээд онгойж үхсэнийг амилуулах чулуу гарч ирнэ гэж найдав. Тэгвэл Гермиона түүний үнэн болохыг ойлгох болно.

Тэр Рон руу ухасхийлээ

- Чи энэ бүхэнд итгэж байна уу? Харри бас харсанд Рон тээнэгэлзэн.

- Мэдэхгүй ... Гэхдээ байдаг бол ... Үнэхээр байдаг бол учир нь олдлоо ...

Гэхдээ бүгдийг нь харах хэрэгтэй байх гээд гүнзгий амьсгал авснаа,

- Харри би крестражуудаас салах хэрэгтэй гэж бодож байна. Энэ даалгаварыг бидэнд Дамблдор өгсөн. Магадгүй ... бид үхлийн шүтээний тухай мартах хэрэгтэй байх гэв.

- Баярлалаа, Рон. Би түрүүлж жижүүрлэе гэж Гермиона хэлэв. Тэр Харрийн дэргэдүүр өнгөрөөд майхны үүдэнд ууртайгаар суулаа.

Энэ шөнө Харри бараг унтсангүй. Үхлийн шүтээний тухай бодол түүнийг эзэмдэж тайвширч чадсангүй бөгөөд толгойд нь ганцхан зүйл эргэлдсээр байлаа. Саваа, чулуу, цув хэрвээ бүгд түүнд байсан бол ...

Би төгсгөл нь ирэхээр онгойлгоно ... Төгсгөл нь гэж юу гэж байгаа юм бол? Яагаад чулууг одоо онгойлгож болохгүй гэж? Хэрвээ түүнд чулуу байгаа бол Дамблдороос бүгдийг шууд асууж болох байлаа ... Харри снитчэд харанхуйд боломжтой бүх

үгсийг шивнэн тэр ч байтугай могойн хэлээр ярьсан ч алтан бөмбөлөг зөрүүдлэн нээгдсэнгүй.

Харин саваа? Ялагдашгүй саваа хаана байна? Волдеморт түүнийг хаана эрж байгаа юм бол? Тэрбээр сорви нь өвдөн Волдемортын бодолд нэвтрүүлээсэй гэж хүслээ. Волдеморт тэр хоёр анх удаагаа нэг л зүйлийн араас хөөцөлдөж байна. Гермиона мэдээж тийм бодлыг дэмжихгүй. Ксенофилиусын зөв байсан түүний ухаан явцуу хаалтай. Үнэндээ түүнийг үхлийн шүтээний тухай бодол айлгаж байгаа хэрэг. Ялангуяа Үхсэнийг амилуулдаг чулуу ... ингээд Харри ахин снитчийг уруулдаа хүргээд үнссэн ч хүйтэн төмөр нээгдсэнгүй ...

Үүр гэгээрэх дөхөхөд Харри гэнэтхэн Азкабаны шоронд Дементоруудаар хүрээлүүлэн ганцаар хориотой байгаа Полумнагийн тухай саналаа. Түүнд ичгүүртэй байв. Үхлийн шүтээний тухай мөрөөдөөд түүний тухай мартсан байна шүү дээ! Тэд түүнийг аварч болох хэдий ч тийм их Дементоруудтай тэмцэж дийлэхгүй. Тэр одооны бэлтгэл хийж байгаа саваанаасаа Патронусыг гаргаж чадахгүй байгаа ... Туршиж үзэх хэрэгтэй юм байна.

Хэрвээ илүү сайн ажилладаг саваатай бол ...

Ингээд ахин савааг эзэмдэх тэсгэлгүй хүсэл төрөв ... Үхлийн, ялагдашгүй, дийлдэшгүй ...

Тэд өглөө нь майхнаа хураагаад уйтгартай зүсэр бороон дунд цааш хөдлөв. Бороо тэднийг эрэг хүртэл дагалаа. Тэд бороонд норсон нойтон эрэг дээр майхандаа бүтэн долоо хоног суухад Харри уйтгарласандаа Үхлийн шүтээнээс ондоо юуны ч тухай бодсонгүй. Дотоод сэтгэлд нь гал дүрэлзэж ... Гермионагийн үл итгэл ч тэр, Роны эргэлзээ ч тэр унтрааж чадсангүй. Түүнийг үхлийн шүтээнд автах тусам баяр хөөр нь улам багасч байлаа. Тэр үүнд Рон, Гермиона хоёрын хайхрамжгүй байдал болон эцэст төгсгөлгүй цутгах бороог буруутгасан ч итгэлтэй байдлыг нь юугаар ч эргэлзүүлэхийн аргагүй байв. Түүнчлэн Рон, Гермиона хоёр болон крестражын тухай улигт бодлоос нь тусгаарлагдаж байлаа.

- Улигт бодол гэнээ? хэмээн Гермиона үдэш нь крестражыг хаана эрэх тухай ярианы үеэр Харри энэ үгийг болгоомжгүй хэлэхэд ууртай давтаад.

- Харри бидэнд ямар ч улигт бодол байхгүй! Бид зөвхөн Дамблдорын даалгаварыг биелүүлэхийн төлөө явах ёстой! гэв.

Гэсэн ч Харри зөрүүдлэсэн хэвээр үлдэв. Дамблдор Гермионад шүтээнийг тайлах нууц тэмдэг үлдээн, Харрид үхсэнийг сэргээх чулуу орхиж алтан снитч дотор нуусан. Тэдний нэг нь нөгөөгөө байхад тайван амьдарч чадахгүй ... Үхлийг ялагч ... Яагаад Рон, Гермиона хоёр үүнийг ойлгохгүй байгаа юм бол?

- Сүүлчийн дайснаа устгах хүртэл гэж Харри тайван хэллээ.

- Бид Хэцүү нэртийн эсрэг тэмцэж байгаа гэж бодсон юмсан? хэмээн Гермиона эсэргүүцсэн ч Харри хайхрамжгүй гараа зангав.

Тэр ч байтугай Рон, Гермиона хоёрын эцэс төгсгөлгүй ярих нууцлаг мөнгөн согоо хүртэл Харрийн анхаарлыг татсангүй. Тэр өөр илүү зүйлийг сонирхож байлаа.

Цорын ганц сэтгэлийг нь зовоож байсан зүйл гэвэл сорви нь ахин өвдөж эхэлснийг найзуудаасаа нууж байв. Гэсэн ч Харри харсан зүйлдээ урам хугарчээ. Тэд тодорхойгүй бүдэг хаана байгаа нь ойлгомжгүй байлаа. Харри дүрсийг ялгахыг хичээгээд гавалтай төстэй уул шиг зүйлийн хажууд зогсож байхыг нь хүндхэн харав. Дасал болсон шигээ тод болгохын тулд яахаа мэдэхгүй байж Волдеморт тэр хоёрын хоорондын холбоо сулраагүй байгаа даа гэж түгшиж эхлэв. Заримдаа Харри бүдэг зураг харж байгаа явдалдаа унтууцан үүнд саваа нь буруутай юм шиг санагдах нь бий.

Ахин нэг долоо хоног өнгөрөхөд Харри бодол эрэгцүүлэлд автсаар Рон удирдлагыг гартаа авсныг харлаа. Магадгүй тэр хүссэн үедээ орхиж явж чадах болохоор тэр байж мэднэ, эсвэл Харрийн үлбэгэр хайхрамжгүй байдал нуугдмал удирдагчийн авъяас нь сэргэсэн ч байж мэднэ ямар ч гэсэн Рон урам зоригоор дүүрэн бусдыгаа үйл явдалд уриалж байлаа.

- Гурван крестраж үлдлээ гэж тэр давтаад,

- Алив цаашдын төлөвлөгөөгөө зохиоцгооё! Бид түүнийг эрэхгүй юм уу? Ахин нэг удаад бодоод үзье. Өнчин хүүхдийн асрах газар уу ... гэнэ.

Тахир гудамж, Хогвартс, Реддлийн байшин, «Горбин ба Бэркс» мухлаг, Албани гэж Рон, Гермиона хоёр ахин дахин Том Реддлийн ажиллаж амьдарч байсан газрын тухай ярих болгонд Харри үүнд нь Гермионагийн яршигтай салдаггүй занг болиулахын тулд оролцож байлаа. Тэр ганцаар буланд чимээгүй суугаад Волдемортын бодлыг харахыг хичээхдээ баяртай байсан юм. Магадгүй сабааны тухай шинэ юм мэдэж болох шүү дээ. Гэсэн ч Рон хамгийн итгэмээргүй жирийн газруудад аялахыг шаардах бөгөөд Харри түүнийг нэг газраа тогтохгүйн тулд ингэж байгаа гэдэгт нь итгэлтэй байв.

- Чи түүний Аппер Флежли шидтэнгүүдийн тосгонд амьдрахыг хүсч байсныг хэзээ ч мэдэхгүй! гэж Рон үргэлж батлах бөгөөд,

- Алив тийшээ очиж үзэцгээе гэнэ.

Шидтэнгүүдийн газар нутагт ангуучид явах нь ихссэнийг найзууд алсаас харжээ.

- Тэдний зарим нь Үхэл залгигчдаас дээрдэхгүй. Намайг барих үед өрөвдөлтэй амьтад байсан ч Билл тэдний дунд жинхэнэ аюултай хүмүүс бий гэж үзэж байгаа. «Поттерийн цаг»-аар мэдээлэхдээ ...

- Юу гэнээ? хэмээн Харри асуулаа.

- Поттерийн цаг. Би энэ тухай яриагүй билүү? Миний цаг үргэлж радиогоороо барьж авахыг хичээгээд байгаа радио долгион байгаа юм. Энэ бол үнэнийг хэлдэг ганц станц! «Поттерийн цаг»-аас бусад бүх хөтөлбөрүүд Хэцүү

нэртийн дагалдагчдын гарт орсон. Би та нарыг ч гэсэн сонсоосой гэж хүсч байгаа болохоор жаахан оролдоод үзье ...

Рон оройжингоо шидэт саваагаа зангаж янз бүрийн суваг дээр радио долгионоо тааруулав. Тэнд ихэвчлэн лууны тууралтыг хэрхэн эмчлэх вэ зэрэг зөвлөгөө

сонсогдох агаад, заримдаа «Халуун хайраар дүүрэн тогоо минь» дуу явж байлаа. Рон боломжтой бүх үгсийг бувтнах зууpаа нууц үг нь ямар болохыг тааварлахыг хичээнэ.

- Тэд ер нь бол бүлэгтэй холбоотой зүйлээс сонгож авдаг юм. Билл түүнийг сайн таадаг. Гэхдээ би эрт орой хэзээ нэгэн цагт мэдэх л болно доо ...

Зөвхөн гурван сард л Ронд аз эцэст аз инээмсэглэв. Харри майхны үүдэнд жижүүрлэн суугаад газар ширтэж байтал Рон гэнэтхэн хөөрөн ориллоо.

- Барьчихлаа, барьчихлаа! Нууц үг бол «Альбус»! Харри алив наашаа хүрээд ир дээ.

Харри энэ бүх хугацааны туршид анх удаагаа үхлийн шүтээнээс өөр зүйл сонирхон майханд яаран ороход Рон, Гермиона шалан дээр жижигхэн радионы дэргэд өвдөглөн суугаад жижигхэн чанга яригчаас танил хоолой сонсогдов.

- ... эфирт түр байхгүй байсныг минь өршөөгөөрэй. Энэ бол манай гайхамшигтай Үхэл залгигч нарын айлчлалтай холбоотой зүйл юм ...

- Энэ чинь Ли Жордан байна! гэж Гермиона дуу алдав.

- Аанхан! Янзтай байгаа биз дээ? гээд Рон баясан гийлээ.

- Одоо бид шинэ нууц газар олсон болохоор хоёр туслагчаа та нарт танилцуулахдаа баяртай байна. Оройн мэнд, залуусаа!

- Сайн уу.

- Оройн мэнд, Бруно.

- Бруно гэдэг чинь Ли гэж Рон тайлбарлаад,

- Тэд бүгдээрээ нууц нэртэй болсон ч таахад хэцүү биш ... гэв.

- Чшш! гэж Гермиона хэллээ.

- Бид өмнө нь Ромулус, Равелин хоёрыг сонссон. Одоо Шидтэний радио сүлжээний мэдээгээр «Өдөр тутмын зөнч» сонины дурдаагүй чухал зүйлсийн талаарх мэдээлэлдээ оръё. Ингээд сонсогчиддоо гүнээ харамсалтайгаар Тед Тонкс болон Дирк Кресвелл нарын үхсэнийг мэдэгдэх байна гэв.

Харрийн дотор палхийлээ. Тэд бие бие рүүгээ айдаст автан харав.

- Түүнчлэн бас Горнак нэртэй албин алагдсан. Тэр маглуудын гэр бүлээс гаралтай шидтэн Дин Томас болон бас өөр нэг албин Тонкс, Кресвелл, нартай хамт зугтаж байжээ. Харин одоо Дины хаана байгаа талаар мэдэх хүмүүс биднийг сонсож байвал эцэг, эх, эгч нарт нь энэ тухай мэдэгдэнэ үү.

- Үүний зэрэгцээ Гаддлид маглын гэр бүлийн таван хүн гэртээ үхжээ.

Маглуудын шинжээч нар үхлийн шалтгааныг хий алдагдсан гэж үзэж байгаа ч

Фениксийн бүлгийн гишүүд үхлийн шившлэг байсныг мэдээлж байна. Энэ нь маглуудыг алах нь шинэ дэглэмийн нэг арга барил болохыг баталж байгаа юм.

- Эцэст нь бид радио сонсогчиддоо Годрикийн хонхорт Батильда Бэгшотын биеийг олсныг харамсалтайгаар мэдэгдэх байна. Шинж тэмдгээс үзэхэд тэрбээр хэдэн сарын өмнө үхсэн бололтой. Фениксийн бүлгийн гишүүд түүний биеэс хар шидийн ул мөрийг олсон гэж мэдэгджээ.

- Хүндэт радио сонсогчидоо та бүхнийг бидэнтэй хормын турш нэгдэн чимээгүй байж Тед Тонкс, Дирк Крессвелл, Батильда Бэгшот, Горнак болон нэр нь үл мэдэгдэх Үхэл залгигч нарт алагдсан маглуудын дурсгалыг хүндэтгэхийг хүсч байна.

Нам гүм болоход Харри, Рон, Гермиона гурав юу ч дуугарсангүй. Харри цааш сонсох гэж байгаа зүйлээсээ эмээлээ. Энэ бол удаан хугацааны дараа анх удаагаа гадаад ертөнцтэй холбогдсон хэрэг байв.

- Баярлалаа гэх Ли Жорданы хоолой гарлаа.

- Харин одоо та бүхнийг манай оролцогч болох Равелины сүүлийн үед шидэт ертөнцөд болон маглуудын амьдралд юу болсон тухай мэдээ сонсохыг урьж байна.

- Баярлалаа Бруно гэх эндүүрэхийн аргагүй гүн хоолой гарлаа.

- Кингсли! гэж Рон орилов.

- Мэдэж байна! гэж Гермиона аяархан хэллээ.

- Маглууд урьдын адил зовлон шаналал болон сүйрлийн шалтгаан юу болохыг сэжиглэхгүй хэвээр байна. Гэсэн ч бид зарим шидтэнгүүд амьдралаараа дэнчин тавин магл найз нөхөд болон хөршүүдээ аварч байгаа тухай сайхан мэдээ сонссоор байна. Иймээс бүх сонсогчиддоо тэдний жишээг даган маглууд амьдардаг өөрийнхөө гудамжыг хамгаалалтын шидээр шившихийг уриалж байна. Ийм аргаар бид олон хүний амийг аварч чадах юм.

- Равелин чи радио сонсогчиддоо энэ аюултай цагт «Шидтэнгүүд эхэнд»

зарчмын хувьд юу хэлэх гэж байна?

- Би «Шидтэнгүүд эхэнд», «Цэвэр цустан эхэнд» болон «Үхэл залгигчид» гэсэн үг зарчмын хувьд адил гэж хэлэх байна. Бид бүгд хүмүүс биз дээ? Хүн бүрийн амьдрал үнэтэй.

- Сайхан хэллээ, Равелин! Хэрвээ санал хураасан бол би чамайг ид шидийн яамны сайдаар сонгох байлаа. Харин одоо Ромулус манай «Поттерын найзууд»-ыг хөтлөх болно.

- Баярлалаа, Бруно гэх өөр нэг танил хоолой сонсогдов. Рон амаа нээсэн ч Гермиона урьтан,

- Люпин гэдгийг нь мэдэж байна гэж шивнэлээ.

- Ромулус чи урьдын адил Харри Поттер одоо хүртэл амьд байсаар байгаа гэж баталсаар байна уу?.

- Тиймээ. Би яг одоо түүнийг Үхэл залгигчид алсан гэж хаа сайгүй хашгичиж байгаад эргэлзэхгүй байна. Тэд ийм байдлаар шинэ үлдсэн дэглэмийн эсрэг тэмцэж

буй хүмүүст цохилт өгөх гэж байгаа юм. Амьд үлдсэн хүү бидний тэмцлээ үргэлжлүүлэхэд зайлшгүй хэрэгтэй урам зоригийн биелэл болж байна.

Харрид талархах ичингүйрэх сэтгэл холилдон төрлөө. Люпин түүнийг хэлсэн аймшигт зүйлсийг нь уучилсан юм болов уу?

- Ромулус, чи Харриг одоо биднийг сонсож байгаа гэж бодож байна уу?

- Бид түүнтэй сэтгэл санаагаараа нэг гэж хэлэх байна гэж Люпин хэсэг эргэлзсэнийхээ дараа хэлээд,

- Бас түүнд зөн совингоо дага бараг хэзээ ч алдаж байгаагүй гэж хэлэх байна гэв.

Харри Гермиона руу харахад нүдэнд нь нулимс цийлэгнэжээ.

- Бараг хэзээ ч алдаж байгаагүй гэж тэр шивнэлээ.

- Би та нарт хэлээгүй бил үү? гэж Рон гайхширснаа,

- Билл Люпиныг Тонкс дээр эргэж очсон гэж хэлсэн! Бас түүнийг том гэдэстэй

... гэв.

- Тэгэхээр Харри Поттерын найзууд зовж шаналсан ч үнэнч байгаа хэвээр байна уу? гэж Ли Жордан асуув.

- Манай радио сонсогчид Харри Поттерыг илэн далангүй дэмжигчид баривчлагдсаныг мэдэх билээ. Тэдний дунд «Шүүмжлэгч» сэтгүүлийн эрхлэгч байсан Ксенофилиус Лавгуд орсон гэж Люпин хэлэхэд,

- Амьд л байгаа юм байна гэж Рон бувтналаа.

- Бас хэдхэн цагийн өмнө Рубеус Хагрид ... гэхэд гурвуул дуу алдлаа.

- ... Хогвартсын ойн сахиул сургуулийн нутаг дэвсгэрт «Харри Поттерыг дэмжих» үдэшлэг зохиосоныхоо төлөө баригдах шахжээ. Гэсэн ч түүнийг барьж чадаагүй бөгөөд бидний мэдэж байгаагаар зугтаж яваа юм байна.

- Хэрвээ чамд арван зургаан фут өндөр дүү байгаа бол Үхэл залгигчдаас зугтахад туслах уу?

- Энэ бол эргэлзээгүй томоохон давуу тал гэж Люпин чухалчлан хэлээд,

- Нэмж хэлэхэд Поттерийн цагаар Хагридын бодлыг дэмжиж байгаа ч «Харри Поттерыг дэмжих үдэшлэг» гэдэг нь энэ үед хамгийн ухаалаг бус гэдгийг хэлэх байна гэлээ.

- Тийм шүү, Ромулус гэж Ли Жордан зөвшөөрөв.

- Ингээд «Поттерийн цаг»-ийн хүндэт радио сонсогчидоо та бүхнийг цахилгаан хэлбэртэй сорвитой хүүд үнэнчээ батлан нэвтрүүлгээ цааш үргэлжлүүлэн сонсохыг хүсч байна. Харин одоо Харри Поттер шиг баригдашгүй өөр нэг шидтэний тухай сонсоцгооё. Бид ердийнхөөрөө түүнийг Үхэл залгигчдийн тэргүүн гэж нэрлэдэг бөгөөд түүний талаарх ам дамжсан цуу ярианы талаар манай шинэ туслах Родент танилцуулах болно.

- Родент гэнээ? гэх өөр нэг танил хоолой сонсогдоход Харри, Рон, Гермиона гурав зэрэг дуу алдлаа.

- Фред!

- Үгүй ... Жорж байна.

- Минийхээр бол Фред гээд Рон ойртох агшинд ихрүүдийн нэг уурсангүй,

- Би Родент байхыг хүсэхгүй байна! Би Рапира болно гэж хэлсэн биз дээ! гэв.

- За сайн байна, Рапира чи бидэнд Үхэл залгигчдийн тэргүүний тухай сонссон зүйлээ ярьж өгөхгүй юу?

- Тиймээ, тэгэлгүй яахав, Бруно. Манай радио сонсогчдын мэдэж байгаагаар тэр цэцэрлэгийн цөөрөм юмуу өөр хаа нэгтээ нуугдаагүй. Хэцүү нэрт сүүдэрт үлдэхийг эрхэмлэснээрээ хүмүүсийн дунд сандрал үүсгэж байна. Үнэндээ энэ бүх цуу ярианд итгэх юм бол манай оронд арван есөөс доошгүй Хэцүү нэрт зугаалж яваа юм байх.

- Энэ нь бүрэн биелж байгаа. Нууцлаг байх нь өөрийгөө үзүүлэхээс илүү аймшигтай гэж Кингсли хэлэв.

- Зөвшөөрч байна гэж Фред хэлээд.

- Тэгэхээр хүмүүсээ жаахан тайван байхыг хичээцгээ. Янз бүрийн аймаар зүйл бодолгүйгээр таагүй явдал хангалттай байна. Жишээлбэл Хэцүү нэрт харцаараа алж чаддаг гэсэн санаа байна. Хонгорууд минь дээ, энэ чинь Василиск шүү дээ! Хамгийн энгийн шалгах арга бол тань руу харж буй хүний хөл рүү харах явдал юм. Гэсэн ч та зориглон нүд рүү нь харж болох бөгөөд хэрвээ үнэхээр Хэцүү нэрттэй тулгарсан бол энэ таны амьдралдаа харсан хамгийн сүүлчийн зүйл чинь байх боломжтой.

Харри олон долоо хоногийн туршид анх удаагаа хөхрөөд сэтгэлийн дарамт нь хөнгөрөхийг мэдэрлээ.

- Түүнийг хилийн цаана цөөнгүй харагдсан гэдэг цуу ярианы тухайд юу гэж бодож байна? гэж Ли Жордан асуулаа.

- Хэн хүнд ажлын эцэст багахан амралт авахгүй байхыг хүсэх юм бэ? Хамгийн гол нь хүмүүсээ түүнийг алсад байгаа гэдэг хуурамч аюулгүй байдлын мэдрэмжилд боломж бүү өг. Магадгүй тэр хол байж болох ч Северус Снегг толгойгоо шампунаар угаахаас түргэн ирж чадахыг мартах хэрэггүй. Тиймээс ямар нэг эрсдэл гаргах хэрэггүй юм. Би амьдралдаа ийм зүйл хэлж чадна гэж бодож байгаагүй ч аюулгүй байдал бүхнээс чухал гэх байна!

- Энэ цэцэн үгийн чинь төлөө баярлалаа, Рапира. Хүндэт радио сонсогчидоо ингээд ахин нэг «Поттерын цаг» төгслөө. Бид эфирт ахин хэзээ гарч ирэхээ мэдэхгүй байгаа ч заавал ирнэ гэдэгт эргэлзэх хэрэггүй. Дараагийн нууц үг бол «Хурц нүдэт». Бие биендээ даамжуулаарай! Тавтай нойрсоорой.

Бариул тохируулагч эргээд гэрэл нь унтарлаа. Харри, Рон, Гермиона гурав нүүр дүүрэн инээмсэглэв. Танил нөхөрсөг хоолойнууд итгэмээргүй дотно сонсогдов.

Харри тэднээс тусгаарлагдаад бусад хүмүүс бас Волдемортын эсрэг тэмцэж байгаа гэдгийг мартсан байв. Тэр удаан хугацааны нойрноос сэрсэн мэт боллоо.

- Сайхан байгаа биз тийм үү? гэж Рон баяртай асуулаа.

- Гайхамшигтай гэж Харри хэлэв.

- Тэд их зоригтой юм гэж Гермиона бахдан хэлснээ,

- Хэрвээ тэднийг барьж авбал ... гэв.

- Тэдний үргэлж нүүдгийг сонсоо биз дээ. Яг л бидэн шиг гэж Рон хэлэв.

- Гэхдээ чи Фредийн юу хэлэхийг сонссон уу? гээд Харри нэвтрүүлэг дууссаны дараа сэдэвтээ бодол нь эргэн ирлээ.

- Тэр хилийн цаана байна! Тэр савааг эрсэн хэвээр байна! Би мэдэж байна!

- Харри ...

- Алив л дээ, Гермиона чи яагаад хүлээн зөвшөөрөхгүй байгаа юм бэ? Вол ...

- Харри, Хэрэггүй! ...

- деморт ялагдашгүй савааны араас ангуучилж байна гэдгийг!

- Түүнийг Табу гэж нэрэл! хэмээн Рон орилтол майхны гадаа чанга тасхийх чимээ гарав.

- Харри би чамд хэлсэн биз дээ! Түүний нэрлэж болохгүй гэж! Түргэлээрэй хамгаалалтын шившлэгээ босгохгүй бол ... тэд ...

Рон чимээгүй болоход Харри яагаад гэдгийг нь ойлголоо. Ширээн дээр байсан вредноскол эргэлдэн бүдүүлэг хөөрсөн дуу ойртлоо. Рон халааснаасаа Делюминатор гаргаад шархийлгэхэд майхны гэрэл унтрав.

- Гараа дээшээ өргөөд нэг нэгээрээ гараад ир! Би та нарын тэнд байгаа гэдгийг мэдэж байна шүү! Та нар руу арваад саваа чиглэж байна! Анхааруулгагүй шившлэг илгээх болно шүү! гэх хоолой харанхуйгаас сонсогдов.

БҮЛЭГ 23: МАЛФОЙН ЭДЛЭНД

Харри дэргэдээ байсан найзуудынхаа нь хар дүрс рүү харав. Тэгтэл Гермиона шидэт саваагаа майхны үүд рүү биш түүний нүүр лүү чиглүүлэн аяархан тасхийн гэрэл гялсхийхэд Харри газар унаад өвдсөндөө атиралдав. Тэр юу ч харсангүй бөгөөд нүүр нь хөөхийг мэдэртэл эргэн тойрон хүнд алхаа сонсогдов.

- Бос, шавьж минь гар!

Хэн нэгний гар Харриг угз татан босгоод юу болсныг ойлгож амжихаас өмнө халаасыг нь нэгжин дасгал хийдэг шидэт савааг нь хураан авлаа. Харри хөөн хавдаж харшил туссан юм шиг биржийсэн нүүрээ барихад шархиран өвдөв. Тэр аниастай нүднийхээ завсраар бараг юу ч олж харах боломжгүй байлаа. Нүдний шил нь чирэгдэн гарах үедээ унасан болохоор дөрөв таван бүүдгэр дүрс Рон, Гермиона хоёрыг майхнаас гулдран гаргахыг харав.

- Тавь түүнийг! тавь! гэж Рон орилоход хариу нударганы цохилт сонсогдоод дуу алдан Гермиона,

- Үгүй! Түүнд бүү хүр! Хэрэггүй! гэж хашгирлаа.

- Чиний найз чинь миний жагсаалтан дээрээс олдвол үүнээс ч муу зүйл хүртэх болно доо гэж танил аймшигтай хэржигнэсэн хоолой гараад,

- Гайхамшигтай охин ... амттайхан хэрчим ... би зөөлхөн арьсанд дуртай ... гэв.

Харрийн дотор палхийлээ. Тэр хэрцгий явдлых нь төлөө Үхэл залгигчийн жанчыг өмсөхийг зөвшөөрсөн хүн чоно Фенрир Сивыйн хоолойг таньжээ.

- Майхныг нэгж! гэж өөр хоолой тушаав.

Харри газар доош харуулан хэвтүүлэв. Дэргэд нь түсхийгээд Рон уналаа. Алхах чимээ сонсогдсоноо үл таних хүмүүс майхныг нэгжин сандлыг холдуулав.

- За тэгэхээр хэн бидэнд баригдсаныг харцгаая гэж Фенрир хэлээд Харриг нуруугаар нь эргүүлэв. Савааны гэрэл түүний нүүрэн дээр тусахад Сивый хөхөрлөө.

- Үүнийг ч цөцгийний шар айрагаар даруулан уухгүй бол хоолой давахгүй эд байна даа! Чиний арьс чинь яачихаа вэ?

Харри хариулсангүй.

- Би хэлж байна шүү гэж Сивый давтаад Харрийн элэг рүү цохив.

- Чамд юу тохиолдоо вэ?

- Хатгуулчихсан юм гэж Харри сөөнгөтлөө.

- Тэгсэн бололтой гэж хоёр дахь хоолой хэлэв.

- Нэр? гэж Фенрир архирав.

- Дадли.

- Овог?

- Вернон ... Дадли Вернон.

- Жагсаалтанд шалга, Скабиор гэж Сивый тушаагаад Рон руу очих нь сонсогдов.

- За энэ шаргал чинь хэнсэн билээ?

- Стэн Шанпайк гэж Рон хэлэв.

- Чөтгөр гэж хоёр дахь Стэний нэрийг хэлсэн хүн хэмээн Скабиор нэртэй хүн хэлээд,

- Стэн Шанпайпыг бид мэднэ. Тэр манай ажилд тусалж байсан гэв. Ахин цохилт сонсогдлоо.

- Миний нэр Барди гэж Рон ам дүүрэн цустай хэлэв.

- Барди Уизли.

- Уизли гэнээ? хэмээн Сивый давтаад,

- Тэгвэл чи бохир цустан биш бол цэвэр цуснаасаа урвагч байна даа. За одоо чиний хөөрхөн найз охиныг ...

Түүний хоолойны сэтгэл хангалуун өнгөнөөс Харрийн бие агзасхийлээ.

- Аяархан, Сивый гэж Скабиор найздаа хөхрөн сануулав.

- Би түүнийг шууд хазах гээгүй байна. Эхлээд Барнигийн адил нэрээ санаж эсэхийг харья. Чи хэн бэ, охин минь?

- Пенелопа Кристалл гэж Гермиона айсандаа часхийн дуугарлаа.

- Цусны төрөл?

- Эрлийз.

- Үүнийг амархан шалгаж болно. Тэгээд ч тэд сургуулийн насных юм байна гэж Скабиор хэлэв.

- Бид сургуулиа орхисон гэж Рон хэлэв.

- Орхисон гэнээ, шаргал минь? Тэгээд майхантай зугаалахаар шийдээ юу? Бас

Хар лордын нэрээр даажин хийж зүрхэлнэ гэнээ?

- Даажин хийгээгүй. Санамсаргүй л.

- Санамсаргүй гэнээ? хэмээн ахиад хөхрөх дуу гарлаа.

- Уизли чи хэн Хар лордын нэрийг хэлэх дуртайг мэдэх үү? Фениксийн бүлгийнхэн! Энэ чамд ямар нэг юм сануулахгүй байна уу? гэж Фенрир архирлаа.

- Үгүй.

- Тэд Хар лордод зохих ёсны хүндэтгэл үзүүлдэггүй болохоор түүний нэрийг хориотой болгосон. Үүний тусламжтай бүлгийн хэд хэдэн гишүүдийг барьсан. За харцгаая. Тэднийг нөгөө хоёр луу аваач.

Хэн нэгэн Харрийн үснээс зулгаан хэдэн алхам чирч холдуулаад газар суулгаж ард нь байсан нэгэнтэй нуруугаар хүллээ. Тэр бас л аньсан нүднийхээ завсраар юу ч харахгүй байв. Эцэст нь хүлж дуусаад цааш явмагц Харри,

- Хэн нэгэнд шидэт саваа үлдсэн үү? гэлээ.

- Үгүй гэж хоёр талаас нь Рон, Гермона хоёр хариулав.

- Энэ бүхэн миний буруу. Түүний нэрийг хэлэх хэрэггүй байсан юм ... Намайг уучлаарай.

- Харри?

- Шинэ танил дуу Харрийн нурууны ард сонсогдов. Гермионагийн зүүн талд хүлээстэй хүн ярьж байлаа.

- Дин үү?

- Чи юу! Хэрвээ тэд хэнийг барьснаа мэдэх юм бол ... Эд нар яаманд нуугдсан хүмүүсийг барьж өгөөд мөнгө авдаг ангуучид ...

- Нэг шөнө гэхэд муугүй олз байна! гэж Сивый хэлээд Харрийн дэргэдүүр хадаастай гутал хавиран өнгөрч майхан дотор тар нярхийх чимээ гарлаа.

- Бохир цустан, зугтаж байгаа албин, хуулиас нуугдсан гурван тэнэмэл! Чи тэдний нэрийг шалгав уу, Скабиор?

- Аанхан. Тэнд ямар ч Вернон Дадли гэж алга байна, Сивый.

- Сонирхолтой юм. Маш сонирхолтой гэж Фенрир хэллээ.

Тэр Харрийн дэргэд явган суухад хавдсан нүднийхээ завсраар саарал үс сахалд хучигдсан нүүр, бохир хурц шүд нь харагдав. Сивый цамхагийн орой дээр Дамблдор үхдэг үеийнх шиг хөлс ханхалсан өмхий үнэртэй байлаа.

- Вернон чи үүнийг хүсээгүй биз дээ? Магадгүй чи жагсаалтанд өөр нэрээр байгаа юм уу? Хогварстад ямар тэнхимд сурдаг вэ?

- Слизерин гэж Харри автоматаар хариулав.

- Инээдтэй юм! Яагаад тэд бүгд биднийг энэ нэрийг сонсоод айна гэж боддог юм бол хэмээн Скабиор үл тоомсорлон хэлээд,

- Тэгээд нэг нь ч амралтын өрөө нь хаана байдгийг хэлж чадахгүй шүү гэв.

- Газар дорх хонгилд. Орох гарц нь хананы дэргэд байдаг. Тэнд газар дор нуур байдаг болохоор дүүрэн гавлын дүрстэй ногоон гэрэлтэй байдаг юм.

Богинохон хугацааны турш чимээгүй болов.

- Үгүй ерөө. Харваас бид Слизеринчүүдийн нэгийг барьж авсан бололтой. Чамд аз таарлаа, Вернон. Слизеринд эрлийзүүд тийм ч олон байдаггүй юм. Чиний эцгийг хэн гэдэг вэ? гэж Скабиор хэлэв.

- Тэр ид шидийн яаманд ажилладаг гэж Харри худал хэлсэн ч удахгүй Гермионагийн шившлэг арилахад нүүр нь хэвийн байдалтай болохыг ойлгож байлаа. - Ид шидийн аваар ослын хэлтэст ажилладаг.

- Сивый юу гэдгийг нь мэдэх үү. Тэнд үнэхээр нэг Дадли байдаг шиг санагдаж байна.

Харрийн амьсгал давхацлаа. Үнэхээр тэдэнд аз таарч аюулгүй өнгөрөх нь гэж үү?

- Тийм байж гэж Фенрир хэлэхэд Харри хоолойных нь болгоомжилсон өнгийг сонслоо.

Сивый харваас алдаа гаргаж ид шидийн яамны ажилтны нэгний хүүг барьж авлаа гэсэн таагүй бодол төрсөн бололтой. Харрийн зүрх хавирга дэлдэн маш хүчтэй цохилсон тул хэрвээ үүнийг Фенрир харсан бол гайхахааргүй байв.

- Хэрвээ чи үнэнийг хэлсэн бол юунаас ч айх хэрэггүй. Ид шидийн яам хүртэл зугаалаад болох нь тэр. Танай эцэг чинь чамайг олсны төлөө бидэнд шан хүртээж магад.

Харрийн ам хатлаа.

- Та нар биднийг зүгээр тавьчихаж болохгүй юу?

- Хөөе! Хараач Сивый, энд нэг юм байна! гэж майхнаас хэн нэгэн хашгирлаа.

Тэдний өмнө хар дүрс урган ирэхэд Харри сабааны гэрэлд мөнгө гялсхийхийг харав. Тэд Гриффиндорын илдийг олжээ.

- М-а-а--аш таатай байна гэж Фенрир бахдаад илдийг найзаасаа авч,

- Маш их шүү. Албингуудын хийц биз. Та нар үүнийг хаанаас аваа вэ? гэлээ.

- Энэ аавынх гэж Харри худал хэлэхдээ Фенрир харанхуйд илдний бариул дээр сийлсэн нэрийг харахгүй байх гэж найдав. - Бид түүнийг түлээ хагалахаар авч

...

- Хүлээгээрэй, Сивый! Энд «Зөнч» сонин байна!

Скабиор энэ үгийг хэлмэгц Харрийн сорви төөнөн өвдөж халуу шатлаа. Тэгтэл гэнэтхэн эргэн тойрон юу ч үгүй болж Волдемортын бодолд сахлын хутга шиг зүсэн ороход тэр агаарт баргар цайзын цамхагийн том барилга руу сэтгэл хөөрөн нисэж байлаа.

Ямар ойрхон байна ... бараг л хүрээд ирлээ.

Харри ихээхэн хүч чармайлт гарган байж Волдемортоос ухаанаа хаагаад бодит байдалд эргэн ирэхэд Рон, Гермиона, Дин, Дэгээдэгчтэй харанхуйд хүлээтэй суугаад Фенрир Сивый Скабиортой ярих нь сонсогдов.

- Бохир цустан Гермиона Грейнжер Харри Поттертой хамт аялж байгаа.

Сорви нь ахин халуу шатсан ч Харри хүчлэн Волдемортын бодолд нэвтрэх боломж өөртөө өгсөнгүй. Тэгтэл Фенририйн гутал чахран Гермионагийн өмнө суулаа.

- Юу гэдгийг нь мэдэх үү, охин минь? Энэ зураг чамтай их төстэй юм.

- Үгүй! Энэ би биш!

Гермиона айж цочирдсон хоолойгоороо өөрийгөө бариад өгчих шиг боллоо.

- Харри Поттертэй хамт аялж байгаа гэж Сивый аяархан давтлаа.

Нам гүм болов. Харрийн сорви хүчтэй хатгуулахад бүх хүчээ гарган Волдемортын бодолтой тэмцлээ. Хэзээ ч үүн шиг ухаантай үлдэх нь чухал үе байсангүй.

- Энэ ч олон зүйлийг өөрчилж байна, тийм үү? гэж Фенрир шивнэв.

Бүгд чимээгүй болов. Харри ангуучид зогсоод харахад Гермионагийн гар чичирэхийг мэдрэв. Фенрир босоод Харри руу алхан дэргэд нь суугаад хөөж хавдсан нүүрийг нь харснаа,

- Чиний дух яагаа вэ, Вернон? гэж асуугаад Харри руу ой гутам үнэрээр амьсгалж бохир хуруугаараа сорвийг нь илэв.

- Бүү хүр! гэж Харри орилов. Түүнд өвдөлтийг тэсэх хүч байсангүй.

- Чи шил зүүдэг биз дээ, Поттер?

- Би нүдний шил олсон! гэж ангуучдын нэг орилов.

- Тэнд майханд шил байсан! Хүлээгээрэй, Сивый ...

Хормын дараа Харрийн хамар дээр шил нь тохогдов. Ангуучид ойртон түүн рүү харцгаалаа.

- Тэр мөн байна! Бид Поттерыг барилаа!

Бүгд болсон үйл явдалд гайхаж мэгдсэндээ алхам ухарцгаав. Харри толгойныхоо өвдөлттэй тэмцсээр юу хэлэхээ бодож чадсангүй. Ухааны нэгээхэн хэсэгт дүр зураг харагдаад эхэлжээ ...

... Тэр харанхуй цайзын өндөр ханан дээгүүр орж байна.

Үгүй тэр зэвсэггүй хүлээтэй аймшигтай аюулд байгаа, Харри.

... Түүний харц улам дээшилсээр хамгийн өндөр цамхагийн дээд талын цонх руу харлаа.

Тэр Харри байж тэдний нам дуугаар хувь заяаг нь хэрхэн шийдэхийг сонсов ...

Нисэх цаг боллоо ...

- Ид шидийн яам руу юу?

- Ид шидийн яам там руугаа тонилог. Тэд бүх гавъяаг авч бидэнд юу ч оногдохгүй. Түүнийг шууд Хэцүү нэртэд аваачиж өгье гэж Сивый хэлэв.

- Чи чинь түүнийг дуудах гээд байгаа юм уу? Ийшээ юу? гэж Скабиор айлаа.

- Үгүй гэж Сивый зандраад,

- Надад тийм эрх ... Түүнийг Малфойн эдлэнд байрлаж байгаа гэж ярьж байсан.

Хүүг тийш нь аваачъя.

Харри Сивый яагаад Волдемортыг дуудаж чадахгүй болохыг тааварлав. Хэдийгээр хүн чононд Үхэл залгигчийн жанчыг өмсөхийг зөвшөөрсөн ч гэлээ Хар тамга бол зөвхөн Волдемортын ойр дотны хүмүүст байдаг. Түүнд ийм хүндэтгэл оногдох гавъяагүй билээ.

Сорви нь ахин өвдлөө.

... тэр харанхуйд дээш хөөрөн цамхагийн дээд талын цонх руу нислээ ...

- Түүнийг яг мөн гэдэгт итгэлтэй байна уу? Гэнэтхэн биш байвал бидний төгсгөл ирэх нь тэр.

- Хэн энд гол нь билээ? гэж Фенрир орилоод,

- Би Поттер гэж хэлээд байгаа биз дээ. Шидэт саваа түүнд байсан энэ нь хоёр зуун мянган галлеон болно! Хэрвээ та нар хулчийгаад байвал үлд ... би бүгдийг нь авъя. Хэрвээ аз таарвал охин ч бас оногдох болно! гэв.

... Цонхонд ... нарийхан хар чулуун завсар байлаа. Насанд хүрсэн хүн түүгээр багтахгүй ... нимгэн бүтээлэг дор хүн атиралдан хэвтэнэ ... Унтаж байгаа юм болов уу эсвэл үхсэн юм уу?

- За яахав! гэж Струпъяр шийдлээ.

- За яахав, бид чамтай хамт. Харин бусдыг нь яах вэ, Сивый?

- Магадгүй илүү ихийг ч олж болох юм. Хоёр бохир цустан гэдэг бол арван галлеон. Бас илд байна. Түүнд байгаа бадмааараг бүхэл бүтэн баялаг гэсэн үг.

Олзлогчдыг бүдүүлэгээр гудран босголоо. Харри Гермионагийн айсандаа түргэн амьсгаадахыг сонсов.

- Тэднийг чанга бариарай. Харин би Поттерыг авъя! гээд Сивый Харрийн үснээс зулгаан босгохдоо урт шар хумсаараа хуйхыг нь маажив.

- Гурав хүртэл тоолъё! Нэг ... хоёр ... гурав!

Тэд олзлогдогсдынхоо хамт шилжив. Харри Сивыйн гараас мултрахыг хичээсэн ч амжилтгүй боллоо. Тэр Рон, Гермиона хоёрын дунд шахагдсан болохоор тэднээс салж чадсангүй бөгөөд цээж нь давчдан сорви улам хүчтэй өвдлөө ...

... тэр нарийхан цонхоор ууршх адил могой шиг хөнгөхөн гулган ороод гяндангийн шалан дээр газардлаа.

Олзлогдогсод зам дээр газардахдаа нэг нэгнийхээ дээрээс дарж унав. Харри хавдсан нүдээрээ замын төгсгөлд байгаа давтмал төмөр хаалгыг хараад бага зэрэг санаа амарлаа. Ямар ч муу зүйл болсонгүй бөгөөд Волдеморт энд байсангүй. Тэр түүнийг харалттайгаа тэмцэн мултрах үед хачирхалтай өндөр цамхагтай газарт байсан. Түүнд Харриг баригдсан гэдгийг ойлгомогц тэндээс ирэхэд их хугацаа шаардагдах болно ... энэ бол өөр хэрэг байлаа ...

Ангуучдын нэг хаалга руу очоод торыг нь сэгсчив.

- Бид түүгээр яаж орох вэ? Цоожтой байна, Сивый! Би онгойлгож ... Түй чөтгөр гэж!

Тэр айдаст автан гараа угз татлаа. Төмөр тахийснаа хуйлран айдас хүрэм хоншоортой царай болж хангинасан дуугаар,

- Ирсэн зорилго? гэлээ.

- Бид Поттерыг барьсан! Бид Харри Поттерыг барьсан! гэж Сивый ялгуусан хоолойгоор хашгирав.

Хаалга нээгдлээ.

- Орцгооё! гэж Сивый өөрийн хүмүүстээ тушаав.

Олзлогдогсдыг хаалгаар түлхэн оруулаад амьд бургасан хашаагаар хүрээлэгдсэн замаар явахад алхаа нь бөглүү цуурайтана. Харри дээрээ тунгалаг цагаан дүрс хараад альбинос тогос болохыг нь ойлгов. Түүнийг бүдрэхэд Фенрир угз татан босгоод бусад олзлогдогч нарын хамт хүлээтэй ганхсаар явахад хавдсан нүдээ аниад сорвиныхоо өвдөлтийг зөвшөөрч Волдеморт юу хийж буйг мэдэхийг хүслээ ...

... Хөнжлөн дор байсан эцэнхий дүрс түүн рүү хажуулдан эргэж гавлыг санагдуулам царайныхаа нүдийг нээлээ ... Тэрбээр арай ядан өндийн суугаад хөнхөр нүдээрээ. Волдеморт руу харав. Хоригдол инээмсэглэхэд бараг ч нэг ч шүд байсангүй.

- Тэгэхээр чи ирээ юу. Би чамайг хэзээ нэгэн цагт ... ирнэ гэж боддог байсан ...

Гэхдээ аялал чинь утгагүй юм болж. Надад тэр хэзээ ч байгаагүй.

- Худалч!

Волдемортын уур хилэн Харрийн дотор дүрсхийхэд толгой нь өвдсөндөө арай салж унасангүй. Тэр огцом биедээ буцан бодит байдалдаа эргэн ирлээ. Олзлогсдыг довжооны урд түлхэн зогсоов.

Үүд нээгдэхэд гэрэл тусав.

- Юу болоо вэ? гэх эмэгтэй хүний хүйтэн хоолой гарлаа.

- Бид Хэцүү нэртийг дуудахаар ирсэн! гэж Фенрир хэржигнэн хэлэв.

- Та нар хэн юм бэ?

- Та намайг мэднэ шүү дээ! гэж хүн чоно гомдолтой хэлээд,

- Би ... Фенрир Сивый! Бид Харри Поттерыг барьсан гэв.

Сивый Харриг гэрэлд чирэн гаргахад бусад олзлогдогчид хөлөө зөөн эргэлдлээ.

- Тэр бага зэрэг хавдсан ч гэсэн яг мөн! гэж Скабиор хэлээд,

- Та жаахан ойртвол сорвийг нь харах болно. Бас энэ охиныг харж байна уу?

Түүнтэй хамт аялж байсан бохир цустан, хатагтай! Тэднийг мөн гэдэгт нь эргэлзэх хэрэггүй шидэт савааг нь бид хураасан. Энэ байна ... гэв.

Харри аньсан нүднийхаа завсраар Нарцисса Малфой хөөсөн нүүрийг нь шинжихийг харлаа. Скабиор түүнд дасгал хийж байсан саваг нь өгөв. Тэр хөмсгөө өргөснөө,

- Тэднийг гэрт оруул! гэж тушаав.

Олзлогсдыг өшиглөн чулуун гишгүүрээр өгсүүлэн хөөгөөд ханандаа эгнэсэн хөрөгтэй үүдний танхимд орууллаа.

- Миний араас яваарай! Миний хүү Драко улаан өндөгний баяраар гэртээ ирээд байгаа. Хэрвээ энэ Харри Поттер мөн бол тэр мэдэх ёстой гээд Нарцисса танхим дундуур хөтлөн явлаа.

Шөнийн харанхуйн дараа зочны өрөө нүд гялбам хурц гэрэлтэй санагдав. Харри бараг аньсан нүднийхээ цаанаас өрөө уужим болохыг ажиглав. Адраас болор бүрхүүл өлгөсөн нь бараан ягаан хананд өлгөөтэй олон тооны хөргүүдийг гэрэлтүүлэх аж. Гантиг зуухны урд талын сандлаас хоёр хүн өндийв.

- Юу болоод байна?

Танил үгээ сунгасан хоолой Люфиус Малфойн хоолой сонсогдоход Харри жинхэнэ аймшиг мэдэрч юу хийхээ мэдсэнгүй. Айдас түүнийг Волдемортын бодлоос салахад тусалсан ч сорви нь чинэрэн өвдсөөр байв.

- Тэд Поттерыг барьсан гэж хэллээ. Драко, наашаа ир гэх Нарциссагийн хүйтэн хоолой гарлаа.

Харри Дракогын нүүр лүү эгц харж зүрхэлсэнгүй. Тэр нүднийхээ булангаар цайвар үстэй өндөр цонхигор дүрс сандлаас өндийхийг харав.

Сивый Харриг түлхэн бүрхүүлийн дор аваачив.

- За юу хэлмээр байна даа, хүү минь? гэж хүн чоно хэллээ.

Харрийн эсрэг талд ханан зуухны дээр хээ угалзтай хүрээ бүхий том толь өлгөөтэй байсанд Гриммогийн байшинг орхисноос хойш анх удаагаа өөрийн тусгалаа харлаа.

Түүний царай итгэмээргүй хөөн томорч гялалзсан ягаан өнгөтэй болсон байв. Гермионагийн шившлэг нүүрнийх нь хэлбэрийг өөрчилсөн бололтой. Хар үс нь мөрөө хүртэл уртасч, эрүүн дээр нь хар сүүдэр тусна. Хэрвээ энд хэн зогсч байгааг мэдээгүйсэн бол хэн шилийг нь зүүсэнд ихэд гайхах байлаа. Гэсэн ч дуу хоолойных нь өнгө барьж өгөх байсан тул чимээгүй байхаар шийдээд Драког ойртоход нүд рүү нь харахгүй байхыг хичээв.

- За яасан, Драко? Тэр мөн үү? Харри Поттер мөн үү? гэж Люциус Малфой шунахайран сониучирхав.

- М-мэдэхгүй ... Итгэлтэй биш байна гээд Драко Сивыйгээс аль болох хол байхыг хичээнгээ Харри руу түүний адил айн харлаа.

- Чи сайн хараарай! Түүнд ойртож оч!

Харри хэзээ ч Люциус Малфой ингэж хөөрсөн байхыг сонсож байсангүй.

- Драко хэрвээ бид Поттерыг Хар лордын гарт өгвөл биднийг бүх юмыг ууч ...

- Алив ээ түүнийг хэн барьсан гэдгийг мартахгүй байгаа юм биз дээ, ноён Малфой? гэж Фенрир сүрдүүлэн хэлэв.

- Тэгэлгүй яахав! гэж Люцуис тэсч ядан дуугараад Харрид ойртон хайхрамжгүй цонхигор царайгаараа харснаа,

- Та нар түүнийг яагаа вэ? Тэр яагаад ийм байдалтай байгаа юм? гэж асуув.

- Энэ бид биш.

- Минийхээр бол Түлдэг шившлэгтэй төстэй юм байна гээд түүний саарал нүд Харрийн дух руу харлаа.

- Энд ямар нэг зүйл харагдаж байна. Магадгүй сорви ч байж болох юм ... Драко нааш ирээд хараач! Чи юу гэж бодож байна?

Дракогын царай Харрийн урд ирэхэд эцэгтэйгээ гайхам адил харагдав. Эцэг Малфой хөөрөн догдолсон байсан бол Драко Харри руу дургүйхэн айсан ч гэмээр харснаа,

- Мэдэхгүй байна гэж бувтнаад зуухны дэргэд зогсож байсан Нарцисса руу очив.

- Бид тодорхой мэдэх ёстой, Люциус! гэж Нарцисса нөхөр рүүгээ хүйтнээр хашгичив.

- Хар лордыг дуудахаас өмнө Поттер мөн гэдэгт бүрэн итгэлтэй болсон байх хэрэгтэй ... Эдгээр хүмүүс шидэт савааг нь авсан гэж хэлсэн ч Олливандерийн хэлсэнтэй адилгүй юм гээд бэлтгэл хийж байсан савааг нь харж,

- Хэрвээ бид алдаа гаргаж Хар лордыг дуудвал ... тэр Долохов, Роул хоёрыг яасныг санаж байгаа биз дээ? гэв.

- Тэгвэл бохир цустанг яах вэ? гэж Фенрир архирлаа.

Харри хүлээтэй олзлогсдыг эргүүлэн Гермионаг гэрэлд гаргахад золтой л унасангүй.

- Хүлээгээрэй гэж Нарцисса ширүүн өнгөөр хэлээд,

- Тиймээ, тийм! Тэр Поттертой хатагтай Малкины дэлгүүрт байсан! Би түүний «Зөнч» сонинд гарсан зургийг харсан юм байна! Хараач Драко энэ Грэйнжер мөн үү? гэлээ.

- Мэдэхгүй ... болох л юм ...

- Харин энэ нь бол Уизли байна! гэж Роны эсрэг талд зогсч байсан эцэг Малфой хашгираад,

- Тэд Поттерын найзууд байна! Драко алив хардаа энэ Артур Уизлийн хүү мөн биз дээ? гэв.

- Тийм шүү. Болох л юм гэж Драко давтлаа.

Харрийн ард зочны өрөөний хаалга нээгдэн эмэгтэй хүний хоолой сонсогдоход айдас нь туйлдаа хүрэв.

- Энд юу болоод байна? Яагаа вэ, Цисси?

Беллатриса Лейстрейнж хоригдлуудыг удаанаар тойроод Харрийн баруун талд зогсон Гермиона руу хүнд зовхин дороосоо харлаа.

- Энэ хамгийн бохир цустан байна даа! Грейнжер үү? гэж тэр нам дуугаар хэлэв.

- Тиймээ, тийм Грейнжер! Харин дэргэд нь Поттертой төстэй хүн зогсч байна!

Поттер болон түүний найзууд эцэстээ баригдлаа! гэж Люциус хашгирлаа.

- Поттер гэнээ? хэмээн Беллатриса дуу алдаад Харриг сайн харахын тулд ойртож ирэв. - Чи итгэлтэй байна уу? Тэгвэл Хар лордод түргэн дуулгах хэрэгтэй!

Тэр зүүн ханцуйгаа шуулаа. Харри түүний арьсан дээрх Хар тамгыг хараад одоохон

Беллатриса түүнд хүрэх юм бол эзнээ дуудах болно гэдгийг ойлгож байв ...

- Би өөрөө түүнийг дуудах болно! гээд Люциус Беллатрисаг Хар тамганд хүргэхгүйн тулд бугуйнаас нь зууралдаж,

- Би түүнийг дуудна, Белла! Поттерыг гэрт авчирсан болохоор миний мэдлээр

... гэв.

- Чиний мэдлээр гэнээ! хэмээн Беллатриса хөхрөөд гараа мулталж авахыг хичээн,

- Чи бүх эрх мэдлээ сабааныхаа хамт алдсан, Люциус! Чи яаж зүрхэлж байна!

Надад бүү хүр! гэв.

- Чи энд ямар ч хамаагүй хүүг бариагүй ...

- Өршөөнө үү, ноён Малфой. Поттерыг бид барьсан болохоор алтаа авмаар байна ... гэж Сивый хажуугаас нь оролцов.

- Алт гэнээ! хэмээн Беллатриса хөхрөөд ханцуйгаа сугалж авахыг хичээнгээ нөгөө гараараа халаасан дахь шидэт саваагаа тэмтэрлээ.

- Май энэ алтаа ав бузар хогийн амьтан минь, намайг алт хүссэн гэнээ? Би зөвхөн эзнийхээ хүндэтгэл ... түүний ...

Тэр гэнэтхэн тэмцэлдэхээ болиод хар нүдээрээ Харрийн чадахгүй зүйлийг харлаа. Люциус түүний бууж өгсөн явдалд баярлан ханцуйгаа шуутал ...

- Зогс! Бүү хүр! Хэрвээ Хар лорд одоо ирвэл бид бүгд үхнэ! гэж Беллатриса муухай хашгирав.

Люциусын хуруу Хар тамганы дээр хөшив. Беллатриса хажуу тийшээ холдоод,

- Энэ юу вэ? гэлээ.

- Илд гэж ангуучдын нэг бувтнав.

- Надад өг!

- Энэ таных биш, хатагтай минийх! Би түүнийг олсон.

Тас хийх чимээ гараад улаан оч гялсхийхэд Харри Беллатриса Хөшөөх шившлэг илгээснийг ойлголоо. Түүний найз уурсан орилоход Скабиор шидэт саваагаа гаргалаа.

- Энэ чинь тоглоом уу, хатагтай?

- Остолбеней! Отсолбеней! гэж тэр хашгирав.

Тэр дөрвийн эсрэг байсан болохоор хүч нь харьцангуй байсан ч Харри шидийн томоохон урлаг эзэмшсэнийг нь мэдэж байв. Өрсөлдөгчид нь зогсч байсан газартаа ээлж дараалан унахад зөвхөн Сивый үлдээд өвдөглөн сууж гараа сунгав. Харри нүднийхээ булангаар Беллатриса хүн чонын гартаа барьсан Гриффиндорын илдийг авахыг харав. Түүний царай цонхийн цайлаа.

- Та нар илдийг хаанаас аваа вэ? гэж тэр шивнээд Фенрирын гарт байсан шидэт сабааг булааж авлаа.

- Яаж зүрхэлж байна? гэж тэр хариу архирсан ч шүдээ ярзайлган уруулаа хөдөлгөхөөс хэтэрсэнгүй.

- Намайг тавь, эмэгтэй минь!

- Та нар илдийг хаанаас олсон? гэж тэр давтаад,

- Снегг түүнийг миний Гринготтсын шүүгээнд хадгалуулахаар өгсөн! гэв.

- Тэр майханд байсан. Намайг тавь гэж хэлж байна шүү!

Беллатриса шидэт саваагаа даллахад хүн чоно хөл дээрээ үсрэн боссон ч ойртож зүрхэлсэнгүй. Тэр сандлын ард ороод бохир хумсаараа түшлэгийг нь базлаа.

- Драко энэ новшнуудыг зайлуул гэж Беллатриса шалан дээр ухаангүй хэвтэж байгаа хүмүүс рүү занган тушаагаад,

- Хэрвээ чамд тэднийг дуусгах зориг байхгүй бол хашаанд үлдээчих би дараа нь учрыг нь олно гэлээ.

- Дракотой тэгж ярьж бүү зүрхэл! гэж Нарцисса хилэгнэсэн ч Беллатриса,

- Чимээгүй, Цисси! Үйл явдал чиний бодсоноос ч илүү ноцтой байна! гэж хашгирлаа.

Тэрбээр үл мэдэг амьсгаадан зогсоод илдний бариул руу ширтсэнээ чимээгүй зогсох олзлогдогсод руу эргэлээ.

- Хэрвээ энэ үнэхээр Поттер мөн бол ямар нэг хор учруулах хэрэггүй гэж өөрөөсөө илүү бусаддаа бувтнаад,

- Хар лорд Поттертой учраа өөрөө олохыг хүсдэг ... Гэхдээ тэр мэдэх юм бол ...

Би мэдэх ... ёстой! гээд дүү рүүгээ эргэж,

- Намайг юу хийхээ шийдэх хүртэл олзлогсдыг зооринд цоожил! гэлээ.

- Энэ бол миний гэр Белла, чамд тушаах эрх байхгүй!

- Биелүүл! Чи бидэнд ямар аюул заналхийлж байгааг төсөөлөх ч үгүй байна!

гэж Беллатриса хашгирав.

Тэр үхтлээ айсан харагдаж савааны үзүүрээс нь нарийхан оч гараад хивсийг цоолон шатаав.

Нарцисса хормын зуур тээнэгэлзсэнээ хүн чононд хандан,

- Олзлогдогчдыг зооринд оруул, Фенрир гэв.

- Хүлээгээрэй! Бүгдийг нь биш ... Бохир цустангаас бусдыг нь гэж Беллатриса хэлэв.

Сивый баяртай хуухирлаа.

- Үгүй! Оронд нь намайг үлдээ! гэж Рон хашгирав.

Белларисса түүний царай луу цохиход түсхийх чимээ өрөөнд хадав.

- Хэрвээ тэр байцаалтыг даалгүй үхвэл чи дараагийнх нь болно. Миний хувьд цэвэр цуснаасаа урвагч бохир цустангийн дараа ордог. Тэднийг зооринд оруул, Сивый. Сайн түгжээрэй шүдээ хүргэж болохгүй шүү.

Тэр хүн чонын савааг буцааж өгөөд жанчныхаа халааснаас мөнгөн чинжаал гаргаж ирэн Гермионагийн уяаг огтлон бусад олзлогсдоос салгаад өрөөний дунд үснээс нь чирэн аваачив. Сивый үлдсэн дөрвийг хаалга руу хөөн харанхуй хонгилоор туун явахдаа шидэт саваагаа урдаа өргөн үл үзэгдэх шидийн даралт учруулж эсэргүүцэх боломж өгсөнгүй.

- Түүнийг ажлаа дууссан хойно охиныг надад өгнө гэж найдаж байна! хэмээн

Фенрир тэднийг хөөх зуураа мөрөөдөнгүй хэлээд,

- Хоёрхон хазахад болно байх, шаргал минь? гэв.

Харри Роны чичирэхийг мэдрлээ. Олзлогсод нуруугаараа хүлээтэй байсан учир огцом эргүүлгэн шат хүзүүгээ хугалах шахам уруудав. Дор хүнд модон хаалга байлаа. Сивый саваагаараа тогшин үүдийг нээгээд чийгтэй өрөөнд түлхэн оруулж харанхуйд орхилоо. Тэгтэл зоорины хаалга хаагдах чимээ намдахтай зэрэгцэн дэргэд нь аймшигтай хашгиралт гарлаа.

- Гермиона! Гермиона! гэж Рон орилоод мултрахыг хичээхэд Харри арай ядан хөл дээрээ тогтлоо.

- Чимээгүй! Рон, бид яаж мултрахаа болох хэрэгтэй байна ...

- Гермиона! Гермиона!

- Орилохоо больж үз төлөвлөгөө зохиох хэрэгтэй байна ... Уяагаа яаж суллах вэ

...

- Харри? Рон? Энэ та хоёр уу? гэх хоолой харанхуйд сонсогдов.

Рон чимээгүй боллоо. Дэргэд нь ямар нэг юм шар шурхийв. Харри түүн рүү бараан дүрс ойртож ирэхийг харлаа.

- Харри? Рон?

- Полумна юу?

- Тиймээ, би байна! Өө, үгүй дээ би та нарыг баригдахыг хүсээгүй!

- Полумна чи бидэнд уяанаас мултрахад тусалж чадах уу? гэж Харри асуув.

- Тиймээ, магадгүй л юм ... Энд нэг хуучин хадаас байгаа бид түүнийг хааяа ашигладаг юм ... Одоохон жаахан хүлээгээрэй ...

Дээр Гермона ахиад л хашгирлаа. Беллатриса бас хашгирч байгаа сонсогдсон ч Рон үүнтэй зэрэгцэн орилсон учир үг нь ялгагдсангүй.

- Гермиона! Гермиона!

- Ноён Олливандер? гэх Полумнагийн дуу Харрид сонсогдов.

- Ноён Олливандер хадаас таньд байна уу? Жаахан хөдөл дөө ... Хувингийн хажууд байсан шиг санагдаж байна ...

Тэр төдхөн эргэж ирээд,

- Тайван зогсож бай гэж гуйлаа.

Харри түүнийг хадаасаар зузаан олсыг үрэхийг мэдрээд суллаж өгөхийг хичээлээ. Тэгтэл дээр Беллатрисагийн хоолой сонсогдов.

- Ахиад асууя! Та нар илдийг хаанаас авсан бэ? Хаанаас?

- Олсон юм ... Бид түүнийг олсон ... Гуйж байна, хэрэггүй!

Гермиона ахиад хашгирлаа. Рон хүчтэй мурилзахад зэвтэй хадаас Харрийн бугуй руу унав.

- Рон чимээгүй зогс! Би юу ч харахгүй байна ... гэж Полумна шивнэлээ.

- Халаасанд байгаа! Миний халаасанд Делюминатор байгаа түүгээр гэрэл гаргаж болно.

Хормын дараа шархийхэд Делюминатороос гэрэл гарч майханд байгаа юм шиг болов. Гэрэл агаарт хөөрөн туяарч жижигхэн нар шиг хонгилыг гийгүүллээ. Харри

Полумнагийн цонхигор царай болон Олливандерын хөдөлгөөнгүй дүрс хананы дэргэд шалан дээр хөдөлгөөнгүй атиралдан хэвтэхийг харав. Тэр хүзүүгээ эргүүлэн бусад олзлогдогч болох Дин болон Дэгээдэгч хоёрыг харлаа. Албин хүмүүстэй холбоотой уяандаа бараг ухаангүй өлгөгджээ.

- Өө, баярлалаа Рон илүү эвтэйхэн боллоо! гэж Полумна баярлаад хүлээсийг ахин үрэнгээ,

- Сайн уу, Дин! гэв.

Дээр Беллатрисагийн хоолой ахин сонсогдов.

- Чи худал хэлж байна бузар бохир цустан минь! Та нар миний банкны шүүгээг ухсан! Үнэнээ хэл, үнэнээ хэл!

Ахин нэг аймшигтай орилолт ...

- Гермиона!

- Та нар тэндээс өөр юу авсан бэ? Та нар өөр юу авсан юм? Үнэнийг хэлэхгүй бол чамайг энэ чинжаалаар дүрнэ гэдгээ тангараглая!

- Болчихлоо!

Олс унахад Харри бугуйгаа үрэн эргээд Рон өрөөн дундуур гүйж намхан адар луу ширтэн гарах нүх эрэхийг харлаа. Дины царай хөхөрч цус болсон агаад Полумнад

«баярлалаа» гэж хэлээд чичирэн зогсож, Дэгээдэгч хагас ухаантай шалан дээр лагхийн суулаа. Түүний бор царайд олон тооны шархны сорви үлджээ.

Рон шидэт саваагүй шилжихийг оролдов.

- Эндээс гарах арга байхгүй, Рон. Би ч гэсэн оролдсон. Ноён Олливандер энд эртнээс байсан болохоор бүгдийг туршиж үзсэн гэж Полумна түүний бүтэлгүй оролдлогыг харан хэлэв.

Гермиона ахин хашгирахад чимээ Харриг хутга шиг зүслээ. Тэр сорвиныхоо төөнөн өвдөхийг тоолгүй сэтгэлийн гүндээ ашиггүй гэж мэдсэн хэр нь зоориор гүйж хана тэмтэрч үзэв.

- Та нар тэндээс өөр юу авсан бэ? Хариул! Круцио!

Гермионагийн хашгиралтанд хана цуурайтав. Рон орилон нударгаараа хана нүдлээ. Харри цөхрөн хүзүүндээ зүүсэн Хагридын хүүдийг тэмтрэв. Тэр снитчийг гаргаад найдан сэгсэрсэн ч юу ч болсонгүй ... хугарсан галт шувууны өдтэй саваагаа даллаж үзсэн ч ид шидийн оч гарсангүй ... тэгтэл хагарсан толины хэлтэрхий шалан дээр хангинан унаж хурц цэнхэр нүд үзэгдэв ...

Толиноос түүн рүү Дамблдорын нүд харж байлаа.

- Туслаарай! Бид Малфойн гэрийн зооринд байна, бидэнд туслаарай! гэж

Харри ухаангүй хашгирлаа. Нүд ирмэснээ алга болов.

Харри саяны болсон явдалд итгэсэнгүй. Тэр бөхийн хагархайг аваад эргүүлэхэд хана адраас өөр юу ч туссангүй тэгтэл дээр Гермиона илүү аймшигтай хашгирахад Рон ахиад л хамаг хүчээрээ орилов.

- Гермиона! Гермиона!

- Та нар миний шүүгээнд яаж нэвтэрсэн? Тэр зэвүүн албин тусласан уу? гэж

Беллатриса хашгирав.

- Бид түүнтэй зөвхөн өнөөдөр тааралдсан! Бид таны шүүгэнд ороогүй ... Энэ илд бол жинхэн биш! Дуураймал ердөө л дуураймал! гэж Гермиона мэгшив.

- Дуураймал гэнээ? хэмээн Беллатриса хашгираад,

- Маш үнэмшилтэй байлаа гэв.

- Үүнийг хялбар шалгаж болно! Драко яваад албинг аваад ир. Тэр жинхэнэ илд мөн бишийг хэлэг! гэх Люциусын хоолой гарлаа.

Харри шалан дээр эвхрэлдсэн Дэгээдэгч рүү ухасхийлээ.

- Дэгээдэгч гуйж байна тэдэнд илдийг хуурамч гэж хэлээч! Тэд жинхэнэ гэдгийг нь мэдэх ёсгүй! гэж шовх үзүүртэй чихэнд нь шивнэв.

Зоорины шатан дээр яарсан хөлийн чимээ сонсогдоод дараагийн агшинд хаалган дээр Дракогын чичирсэн хоолой гарч,

- Хойшоо ухар. Хана налаад зогсоорой! Ямар нэг тэнэг юм хийхийг оролдвол ална шүү! гэлээ.

Бүгд хана руу ухарлаа. Цоож шаржигнахад Рон Делюминаторoo унтрааж халаасандаа хийв. Зооринд ахин харанхуй боллоо. Хаалга нээгдэв. Малфой саваагаа өмнөө барьсаар цонхийн цайсан ч шийдэмгий орж ирлээ. Тэр жижигхэн албингийн гараас бариад чирэн гаргахад хаалга тасхийн хаагдаж зооринд чанга цуурайтлаа.

Рон Делюминаторoo шархийлгэв. Адрын дор гурван гэрэлт бөмбөлөг хөвөхөд бүгд гэрийн үйлчлэгч Доббиг харлаа.

- Доб ...

Харри Роны гар луу цохин хашгирахыг нь болиулав. Рон түүн рүү айдаст автан харлаа. Тэгтэл толгой дээр нь банз чахрах чимээ гарч Драко Дэгээдэгчийг Беллатриса руу аваачив.

Добби одон бөмбөг шиг нүдээ бүлтийлгэн хөлөөсөө толгой хүртэл чичирч байлаа. Тэр хуучин эзнийхээ гэрт ирсэндээ эмээхгүй байж чадаагүй бололтой.

- Харри Поттер! Добби таныг аврахаар ирлээ! гэж тэр жингэнэсэн хоолойгоор хэлэв.

- Чи хаанаас ...

Харрийн үг аймшигтай хашгиралтанд дарагдан дээр ахиад л Гермионаг тамлав. Иймээс хэрэггүй асуултаа орхиж гол асуудалдаа төвлөрөөд,

- Чи эндээс шилжиж чадах уу? гэж Доббигоос асуув.

Тэр чихээ хөдөлгөн толгой дохив.

- Хүмүүсийг өөртэйгээ гаргаж чадах уу? Добби ахин толгой дохив.

- Сайн байна! Добби Полумна, Дин, ноён Олливандер нараас бариарай ... тэднийг гарга ... Хааш нь аваачих вэ?

- Билл, Флер хоёрын байшин руу! Тинвортын зах дахь хясаан байшин гэж Рон хэлэв

Үйлчлэгч гурав дахь удаагаа толгой дохилоо.

- Дараа нь эргээд ирээрэй! Чи үүнийг чадах уу? гэж Харри хэллээ.

- Тэгэлгүй яахав, Харри Поттер! гэж Добби шивнэв.

Үйлчлэгч юу болсныг мууxан ойлгож байгаа ноён Олливандер руу гүйгээд гараас нь барьж сул гараа Полумна, Дин хоёрт сунгалаа. Тэд хөдөлсөнгүй.

- Харри бид чамд туслахыг хүсч байна! гэж Полумна шивнэв.

- Бид чамгүй эндээс явахгүй гэж Дин хэллээ.

- Алив түргэл! Билл, Флер хоёрынд уулзацгаая.

Тэгтэл Харрийн сорви өмнөхөөсөө долоон дор өвдөж урд нь ноён Олливандер биш өөр хөгшин гарч ирлээ. Тэр хэрзгэр туранхай агаад чих дөжрөм инээж байв.

- Тэгвэл намайг ал, Волдеморт! Би үхлийг баяртайгаар угтах болно! Гэхдээ миний үхэл чамайг эрж байгаа зүйлээ олоход туслахгүй ... Чи олон зүйлийг ойлгосонгүй ... маш олон зүйлийг ...

Харри Волдемортын уур хилэнг мэдэртэл Гермиона ахин хашгирсан учир зоорин дахь аймшигтай үйл явдалд эргэн ирлээ.

- Алив түргэл гэж Полумна, Дин хоёрыг яаруулав.

- Бид та нарын араас шууд явна.

Полумна, Дин хоёр үйлчлэгчийн сунгасан гараас барив. Чанга тасхийгээд Добби, Полумна, Дин, Олливандер нар алга боллоо.

- Энэ юу вэ? Та нар сонссон уу? Зооринд юу дуугарсан бэ? гэж дээр Люциус

Малфой хашгирлаа.

Харри, Рон хоёр бие бие рүүгээ харан хөшлөө.

- Драко ... Үгүй ээ Сүүлтийг дууд! Явж шалгаад ирэг!

Хөлийн чимээ дээр гараад нам гүм болов. Зочны өрөөнийхөн дор ямар нэг чимээ шуугиан сонсогдох эсэхийг анирдаж буй бололтой.

- Бид түүнийг барьж авах хэрэгтэй гэж Харри Роны чихэнд шивнэв.

Тэдэнд өөр сонголт үлдсэнгүй. Энэ агшинд гурван олзлогдогч зугтаад байгаа билээ.

- Гэрлээ үлдээ гэж Харри нэмэрлэв.

Шатаар хэн нэгэн уруудлаа. Тэд ханын баруун зүүн талд наалдан хүлээлээ.

- Холдоорой! Хаалганаас ухарцгаа. Би орлоо шүү! гэх Сүүлтийн хоолой сонсогдов.

Хаалга цэлсхийн онгойлоо. Агшин зуур Сүүлт гурван жижигхэн нар шиг хурц гэрэл гийгүүлж буй хоосон зоорийг мэгдэн харав. Тэд түүн рүү ухасхийв. Рон гараас нь шидэт сабаг булаахад, Харри Сүүлтийн амыг дарлаа. Тэднийг чимээгүйхэн ноцолдох зуур Сүүлтийн шидэт саваанаас оч гарч мөнгөн гар Харрийн хоолойноос багалзуурдав.

- Тэнд юу байна, Сүүлтээ? гэх Люциус Малфойн дуу дээр сонсогдов.

- Юу ч биш! Бүх зүйл хэвийн гэж Рон Сүүлтийн сөөнгө хоолойтой адилхан дуугаар ориллоо.

Харри арай ядан амьсгалж байв.

- Намайг алахыг хүсч байна уу? Би чиний амьдралыг аварсан! Чи надад өртэй, Сүүлтээ! гэж төмөр хуруунаас мултархыг хичээн шивнэлээ.

Сүүлтийн мөнгөн гар гэнэт суларсанд Харри гайхан мултрав. Жижигхэн ус гүйсэн нүдтэй хархтай төстэй хүний нүд айсандаа томорчээ. Тэр харваас Харригаас дутуугүй гэнэтийн уяхан сэтгэлдээ гайхсан бололтой тэгснээ үргэлжлүүлэн сарвалзав.

- Алив ийшээ гэж Рон бувтнаад Сүүлтийн шидэт сабаг гартаа барив.

Зэвсэггүй тусламжгүй болсон Петтигрюгийн нүдэнд айдас дүүрчээ. Түүний харц Харрийн нүүр лүү биш өөр хаа нэг тийш туссанаа мөнгөлөг гарын хуруу хоолой руугаа ойртов.

- Үгүй ээ ...

Харри удаан бодолгүй төмөр гарнаас зуурсан ч зогсоож чадсангүй. Волдемортын хамгийн хулчгар зарцдаа бэлэглэсэн мөнгөн зэвсэг эзнийхээ эсрэг үйлчлэв. Петтигрю хормын зуур найгаснаа өрөвдөлтэй нэг агшины турш хоёр найзын нүдэн дээр амьсгаа нь давхцав.

- Үгүй!

Рон бас Харрийн хамт Сүүлтийн мөнгөлөг хурууг суллахыг оролдсон ч ашиггүй боллоо. Петтигрю хэдийн хөхөрчээ.

- Релашио! гээд Рон шидэт саваагаа мөнгөн гар луу чиглүүлсэн ч юу ч болсонгүй.

Петтигрю өвдөглөн унахтай зэрэгцэн дээр Гермиона аймшигтай хашгирав. Сүүлтийн нүд эргэлдсэнээ сүүлчийн удаа татганан чимээгүй боллоо.

Харри, Рон хоёр бие бие рүүгээ харснаа Петтигрюгийн үхсэн биеийг шалан дээр орхиод зоорины шат руу ухасхийв. Хонгилд гараад үүд нь хагас нээлттэй зочны өрөө лүү очлоо. Эндээс гартаа Гриффиндорын илдийг бариад Дэгээдэгчийн дээрээс ширтэж байгаа Беллатриса сайн харагдаж байлаа. Гермиона хөдөлгөөнгүй Беллатрисагийн хөлд хэвтэнэ.

- За? Жинхэнэ илд мөн үү үй юу? гэж Беллатриса Дэгээдэгчээс асуулаа. Харри сорвиныхоо янгиналттай тэмцэн амьсгал даран хүлээлээ.

- Үгүй. Хуурамч гэж Дэгээдэгч хэлэв.

- Чи итгэлтэй байна уу? Яг итгэлтэй байна уу?

- Тиймээ гэж албин хариулав.

Беллатриса сэтгэл амран санаа алдсанаа бие нь суларлаа.

- Сайн байна!

Тэр саваагаа хайхрамжгүй шавхуурдахад албингийн нүүрэн дээр гүн шарх үүсч хашгираад хөлд нь уналаа. Беллатриса түүнийг холдуулан өшиглөөд,

- Харин одоо Хар лордыг дуудъя! гэж ялан дийлсэн хоолойгоор хэлэв. Тэр ханцуйгаа шамлаад хуруугаараа Хар тамганд хүрлээ.

Харрийн сорви ахин төөнөн өвдлөө. Бодит байдал алга болж тэр Волдеморт болон хувираад эцэнхий шидтэн урдаас нь шүдгүй амаараа шоолон инээж байв. Гэнэтийн дуудлага түүний уур хилэнг хөдөлгөв. Тэр тэдэнд анхааруулж Поттертэй хамаагүй дэмий хоосон зүйлд дуудахыг хориглосон! Хэрвээ тэд ахин алдаа гаргасан байвал ...

- Тэгвэл намайг ал л даа! Чи хэзээ ч ялахгүй, ялах ч боломж байхгүй! Шидэт саваа хэзээ ч чинийх болохгүй ...

Волдемортын уур хилэн эцэстээ хүрэв. Ногоон гэрэл шоронгийн өрөөг дүрсхийн гэрэлтүүлэхэд хэврэгхэн бие овсхийснээ төмөр орон дээр амьгүй уналаа. Волдеморт цонх руу эргэхдээ уур хилэнгээ арай ядан барьж байв. Хэрвээ тэд шалтгаангүй түүнийг түгшээсэн бол хариуг нь хүртээх болно ...

- Боллоо бохир цустан бидэнд хэрэггүй. Хэрвээ хүсч байвал түүнийг ав, Сивый гэх

Беллатрисагийн хоолой гарав.

- Үгүйййййййййййййй ээ!

Рон зочны өрөөнд ухасхийн орлоо. Беллатриса эргэн тойрноо гайхан харснаа шидэт саваагаа Рон руу чиглүүлэв.

- Экспеллиармус! гэж тэр орилоод Сүүлтийн савааг зангахад түүний шидэт саваа үсрэн Харри барьж авлаа.

Люциус, Нарцисса, Драко, Сивый нар эргэн харахтай зэрэгцэн Харри «Остолбеней!» гэж хашгиртал Люциус ханан зуух мөргөн уналаа. Драко, Нарцисса, Фенрир нарын шившлэг Харрийн дэргэдүүр өнгөрөхөд булган буйдангийн цаагуур оров.

- Зогс, эсвэл тэр үхнэ шүү!

Харри амьсгаадан буйдангийн цаанаас өндийлөө. Беллатриса ухаангүй болсон

Гермионаг гартаа бариад хоолойд нь мөнгөн хутга тулгасан байв.

- Шидэт саваагаа хая. Хая эсвэл бид түүний бохир цусыг харах болно шүү!

Рон гартаа Петтигрюгийн савааг атган хөшлөө. Харри Беллатрисагийн савааг барин өндийн зогслоо.

- Би хая гэж хэлсэн шүү! гэж Беллатриса хашгираад хутгаа Гермионагийн хоолойд чанга тулгахад арьс нь зүсэгдэн цус гарав.

- За яахав! гээд Харри Беллатрисагийн шидэт савааг газар хаялаа. Рон ч гэсэн Сүүлтийн савааг хаяв. Хоёулаа гараа өргөлөө.

- Сайн байна! Драко савааг цуглуул! Хар лорд удахгүй энд ирнэ, Харри

Поттер! Чиний үхэл ойртож байна! гээд Беллатриса хорсолтой инээмсэглэв.

Харри өөрөө ч үүнийг ойлгож байлаа. Сорви нь янгинан өвдөж Волдеморт тэнгэрт хаа нэгтээ алсад харанхуй шууран буй тэнгисийн дээгүүр нисэхийг мэдэрлээ. Тэр

удахгүй шилжиж болох газар хүрэх нь байна. Үүнээс гарах ямар ч арга зам байсангүй.

- Цисси би энэ жижигхэн баатрыг хүлэх хэрэгтэй гэж бодож байна. Сивый хатагтай бохир цустанд санаа тавих болно. Тэгээд ч Хар лорд чиний охинд өнөө шөнө хийсэн зүйлийн төлөө харамсахгүй гэдэгт итгэлтэй байна, Сивый хэмээн Беллатриса Драко шалан дээрээс савааг яаран цуглуулахыг хараад хэлэв.

Сүүлчийн үгийн дараа дээр хачирхалтай хяхарсан чимээ гарав. Бүгд дээшээ хартал таазнаас өлгөөтэй аварга том болор бүрхүүл чичигнэснээ гэнэтхэн мултарч жингэнэн доошоо нислээ. Беллатриса түүний дор зогсож байсан болохоор хашгираад хажуу тийш үсрэхдээ Гермионаг унагав. Бүрхүүл шалан дээр унаад болор унжуурга нь бут үсрэн Гермиона, Гриффиндорын илдээс зуурсан албин хоёрыг хучив. Хагархай зүг бүр цацагдахад Драко алгаараа цустай нүүрээ дарав.

Рон Гермионаг хагархайнаас холдуулахыг хичээхэд Харри боломжыг ашиглахаар шийдээд буйдан даван үсэрч Дракогын гарт байсан гурван шидэт савааг аван бүгдийг нь Сивый рүү чиглүүлээд,

- Остолбеней! гэж хашгирлаа.

Гурван шившлэг маш хүчирхэг байсан болохоор хүн чоно адар мөргөөд шалан дээр түсхийн унав.

Нарцисса Драког чирэн гай зовлонгоос холдуулахад, Беллатриса хөл дээрээ үсрэн босоод үсээ хийсгэн мөнгөн хутгаа даллалаа. Нарцисса шидэт саваагаа хаалга руу чиглүүлэв.

- Добби! Чи! Чи бүрхүүл унагасан уу? гэж тэр хашгирахад Беллатриса хөшлөө. Жижигхэн гэрийн үйлчлэгч өрөөн дундуур гүйгээд чичирсэн хуруугаа хуучин

эзэгтэй рүүгээ чиглүүллээ.

- Харри Поттерт бүү хүр!

- Түүнийг ал, Цисси! гэж Беллатриса орилоход ахин нэг тас няс хийх чимээ гаран Нарциссагийн саваа нисээд хана цохин уналаа.

- Аа чи муу зэвүүн жижигхэн сармагчин! Яаж шидтэнгийн савааг холдуулж зүрхлэв? Яаж эзнийхээ үгийг сонсохгүй байж зүрхлэв? гэж Беллатриса хашгирлаа.

- Доббид эзэн байхгүй! Добби чөлөөтэй гэрийн үйлчлэгч. Тэр Харри Поттерыг найзуудтай нь аврахаар ирсэн!

Харрийн сорви халуу шатан өвдлөө. Тэр бүүр түүр ухаандаа Волдеморт ирэхэд хэдхэн секунт үлдсэнийг ойлгов.

- Рон бариарай ... явцгаая! гэж хашгираад Ронд нэг шидэт савааг шидлээ.

Дараа нь бөхийн бүрхүүлийн дороос Дэгээдэгчийг аван гартаа илдийг зууран ёолж буй албинг мөрөн дээгүүрээ тохоод Доббийн гараас барьж шилжихээр эргэлдлээ.

Харанхуй болоход тэр сүүлчийн удаа зочны өрөөнд байгаа цонхийн цайсан Нарцисса, Драко хоёрыг харж Роны шаргал үс судалтан мөнгөлөг цэнхэр зүйл гялсхийхэд Беллатрисагийн хутга өрөөн дундуур алга болж буй Харриг чиглэн нисэв

...

Билл Флерийнд ... Хясаан байшин ... Билл, Флерийнд ...

Тэр үл мэдэгдэх газар руу алга болохдоо чадахаараа зорьсон газрын нэрийг давтаад тэнд хүрэхэд хангалттай байх гэж найдав. Толгой нь хагарах шахан өвдөж албингийн жин мөрөн дээр нь хүндээр даран Гриффиндорын илд нурууг нь балбана. Доббийн гар огцом хөдлөхөд үйлчлэгч хэрэгтэй газар луу нь чиглүүлэх гэж байна гэж бодоод хуруунаас нь арай ядан зуурлаа ...

Ингээд тэд давсны үнэр ханхалсан хатуу газар газардав. Харри өвдгөн дээрээ унаад

Доббийн гарыг тавьж Дэгээдэгчийг газар аяархан буулгахыг хичээв.

- Чи зүгээр үү? гэж асуусан ч албин хөдлөөд ойлгомжгүй үг бувтнав.

Харри харанхуйд нүдээ анивчин харлаа. Түүнд одот тэнгэрийн дор холгүй орших байшингаас хүмүүс гарч ирж байгаа юм шиг санагджээ.

- Добби энэ хясаан байшин мөн үү? гэж шивнээд Малфойн гэрээс авсан хоёр шидэт сабааг шаардлага гарвал тэмцэхэд бэлдэв.

- Бид хэрэгтэй газраа ирсэн үү? Добби?

Харри эргэн харлаа. Жижигхэн гэрийн үйлчлэгч түүнээс хэдхэн алхамын зайд зогсож байв.

- Добби!

Үйлчлэгч үл мэдэг найгахад гялалзсан том нүдэнд нь одод тусан үзэгдэв. Тэгтэл Харри мөнгөн хутга хүндээр амьсгаадах цээжинд нь бариулаа хүртэл зоогдсоныг харлаа.

- Добби ... үгүй ... Туслаарай! Туслаарай! гэж Харри орилоод байшингийн зүгээс гүйн ирж буй хүмүүс руу харлаа.

Тэр шидтэн, магл, нөхөр дайсан эсэхийг мэдээгүй ч энэ чухал биш байв. Зөвхөн харанхуйд өмнөө толботон харагдах Доббийн урдаас гүйхэд тэр өмнөөс нь гуйх мэт гараа сунгав. Харри түүнийг бариад хүйтэн ногоон дээр хэвтүүлэв.

- Добби үгүй ээ битгий үхээрэй, зөвхөн битгий үхээрэй ... Үйлчлэгчийн нүд түүн рүү харж уруул нь чичигнэснээ,

- Харри ... Поттер ... гэлээ.

Дараа нь гэрийн үйлчлэгч татвалзсанаа чимээгүй болоход шилэн бөмбөг шиг хөдөлгөөнгүй нүдэнд нь ододын гэрэл гялалзсан ч харж чадахааргүй болжээ.

БҮЛЭГ 24: ШИДЭТ САВААНЫ МАСТЕР

Харри ахин Хогвартсын хамгийн өндөр цамхагийн дэргэд Дамблдорын үхсэн биений өмнө өвдөглөн сууж байгаа хар дарсан зүүдэнд автах мэт болсон ч үнэн хэрэгтээ урд нь Беллатрисагийн мөнгөн хутга зоогдсон жижигхэн бие ногоон дээр хэвтэж байлаа. Тэр ахин дахин «Добби ... Добби» гэж давтаж байсан ч үйлчлэгч эргэж ирэхээргүй газар луу явжээ.

Тэр нэг юмуу хоёр хормын дараа дэргэд нь Билл, Флер, Дин, Полумна нар ирээд тойрон зогссоныг мэдэв.

- Гермиона? Тэр хаана байна? гэж Харри гэнэтхэн хэлэв.

- Рон түүнийг байшин руу авч явсан. Түүний бүх зүйл хэвийн гэж Билл хариуллаа.

Харри ахин үйлчлэгч руу хараад хурц хутгыг биеэс нь болгоомжтой авч хүрмэндээ хөнжил шиг ороолоо.

Хаа нэгтээ ойрхон тэнгисийн ус давалгаална. Харри түүний хэрхэн шуугихыг сонсох зуур бусад нь юу хийхээ ярилцав. Дин байшин руу шархадсан Дэгээдэгчийг авч явахад, Флер яаран түүн рүү гүйж очив. Билл үйлчлэгчийг оршуулах хэрэгтэй гэж хэллээ. Харри түүнийг зөвшөөрч байсан ч ярьж чадсангүй. Тэр жижигхэн үхсэн бие рүү хараад сорви нь лугшин өвдөж ухааныхаа нэг хэсэгт Волдеморт хэрхэн Малфойн гэрт үлдсэн хүмүүсийг шийтгэж байхыг харлаа. Хар лордын уур хилэн аймшигтай байсан ч гашуудлын дэргэд хүчгүй болжээ.

- Би үүнийг зүй ёсоор нь хийхийг хүсч байна. Ид шидгүй. Та нарт хүрз олдох уу? гэж Харри сэхээ ороод хэлэв.

Хэсэг хугацаа өнгөрсний дараа тэр Биллийн заасан газар болох цэцэрлэгийн өнцөгт бутан дунд булшны нүх малтав. Түүний шидгүй биеийн хүчний хүнд ажил хийхдээ дуслуулсан хөлс, алган дахь цэврүү болгон нь гэрийн үйлчлэгчид тэднийг аварсны бэлэг болох байлаа.

Сорви нь өвдөх хэдий ч тэр өвдөлтөндөө захирагдалгүй өөр өнцгөөс мэдэрч байлаа. Тэр эцэст нь Дамблдорын Снеггээс сурахыг хүсч байснаар холбоосыг хянан өөрийн ухаанаа Волдемортоос хааж сурчээ. Яг л Волдеморт Сириусын үхлийн гашуудлын дараа түүний бодолд нэвтэрч чадахгүй байсантай адил одоо Доббийн араас гашуудаж байгаа болохоор ухаанд нь нэвтэрч чадсангүй. Харваас гашуудал түүнийг Волдемортоос холдуулдаг бололтой ... Хэдийгээр Дамблдор хайр гэж хэлсэн ч гэсэн

...

Харри ухаад ухаад л хөлдүү газрыг улам гүн ухлаа. Тэр хөлсөө арчаад сорвиныхоо өвдөлтийг тоохгүй байхыг хичээв. Харанхуйд тэнгис шуугих болон өөрийнх нь амьсгалахаас ондоо чимээгүй агаад Малфойн гэрт юу ярьж байсныг саналаа ...

Тэр гар дахь хүрзнийхээ нэгэн хэмээр цохилох чимээнд бодолд автав ... Үхлийн шүтээн ... Крестражууд ... Үхлийн шүтээн ... Крестражууд ... хачирхалтай нь энэ нь

одоо түүнд эзэмдэх хүслийг төрүүлсэнгүй. Гашуудал айдас түүнийг хөөжээ. Тэр яг л алгадуулаад сэхээ орсон мэт болов.

Тэрбээр булшны нүхийг улам гүн болгон ухахдаа Волдеморт өнөөдөр хаана байсан болон Нурменгардын шоронд хэнийг яагаад алсныг мэдэж байлаа ...

Түүнчлэн өчүүхэн энэрэнгүй сэтгэл гаргаад үхсэн Сүүлтийг саналаа ... Дамблдор үүнийг урьдчилан харсан. Дамблдор өөр хичнээн зүйл урьдчилан харсан бол?

Харри цаг хугацааны баримжаагаа алджээ. Эргэн тойрон бага зэрэг гэгээ орсныг зөвхөн Рон, Дин хоёр ирэх үед л мэдэрлээ.

- Гермиона хэр байна?

- Дээрдсэн. Флер түүнд санаа тавьж байгаа гэж Рон хэлэв.

Харри булшны нүхийг яагаад шидэт савааны тусламжтай биш энгийнээр ухаж байгаад хариулахад бэлэн байсан авч үүний хэрэг гарсангүй. Тэд чимээгүйхэн нүх рүү харайгаад тус бүрдээ хүрзтэй байж гурвуулаа хамтдаа ажилласан ч нүх хангалттай гүн болсонгүй санагдав.

Харри үйлчлэгчийг хүрэмдээ аятайхан хучив. Рон нүхний ирмэг дээр суугаад гутлаа тайлан оймсоо үйлчлэгчид өглөө. Дин ноосон малгайгаа өгөхөд, Харри Доббийн толгойд болгоомжтой өмсгөөд сарьсан багваахай шиг дэлдэн чихийг нь цухуйлгав.

- Нүдийг нь аниулах хэрэгтэй.

Харри харанхуйд бусад нь ирэхийг сонссонгүй. Билл аян замын дээлтэй, Флер том цагаан хормогч өмсөөд халааснаасаа Яс ургуулагчтай лонх цухуйлгажээ. Гермиона Флерийн халатыг өмсөөд цонхийн цайж хөл дээрээ тогтож ядан зогсоход Рон мөрөөр нь тэвэрлээ. Полумна Флерийн хүрмийг өмсөөд явган сууж хуруугаараа гэрийн үйлчлэгчийн нүдийг зөөлхөн аниулснаа,

- Боллоо тэр одоо яг унтаж байгаа юм шиг байна гэж аяархан хэлэв.

Харри эльфийг булшны нүхэнд хийгээд хөл гарыг нь аятайхан тавин амарч буй мэт болгов. Дараа нь дээшээ гараад сүүлчийн удаа жижигхэн бие рүү харлаа. Тэр уйлсангүй. Тэгтэл Дамблдорын оршуулган дээр алтан сандал ирийтэл тавьж ид шидийн яамны сайд эхний эгнээнд нь суугаад, гавъяа зүтгэлийг нь урнаар уншиж, цагаан гантигаар бунхан барьсныг санав. Добби үүнээс дутуугүй гавъяатай ч бутан дунд өө сэвтэй нүхэнд оршууллаа.

- Ямар нэг зүйл хэлэх хэрэгтэй байх. Би түрүүлж хэлье за юу? гэх Полумнагийн хоолой гарав.

Бүгдийн харц түүн рүү чиглэхэд босоод нүхний ёроолд байгаа үхсэн үйлчлэгчид хандан,

- Намайг зооринооос аварсанд чинь их баярлалаа, Добби. Хэдийгээр чи шударга бусаар аймшигтай үхсэн ч гэсэн ч зоригтой сайн байсан. Би үргэлж чиний хийсэн зүйлийг санаж байх болно. Одоо чамайг аз жаргалтай байгаа гэж найдна гэв.

Тэр хүлээсэн байртай Рон руу харлаа. Рон хоолой засан ханиалгаад сөөнгөтөн,

- Тиймээ ... баярлалаа, Добби ... гэв.

- Баярлалаа гэж Дин бувтналаа. Харрийн хоолойд бөөн юм тээглэхэд,

- Баяртай Добби гэж шивнэлээ.

Тэр өөр үг хэлж чадсангүй бөгөөд Полумна хэдийн өмнөөс нь бүгдийг хэлсэн билээ. Билл шидэт саваагаа даллахад булшны хажуугын овоолсон шороо агаарт хөөрч нямбай хучигдаж багахан улаан толгод үүсэв.

- Би энд жаахан үлдвэл зүгээр биз дээ? гэж Харри асуулаа.

Тэд ямар нэг учир нь ойлгогдохгүй зүйл бувтнаад хэн нэгэн нуруун дээр нь алгадаж, бүгд байшин руу буцахдаа түүнийг оршуулгын дэргэд ганцааранг нь үлдээлээ.

Тэр эргэн тойрноо харав. Цэцгийн мандлыг тэнгисийн усанд мөлийсөн сайхан цагаан чулуугаар хүрээлжээ. Харри арай томхоныг сонгож аваад Доббийн толгойн тушаа газар дэр шиг тавилаа. Дараа нь халааснаасаа шидэт саваагаа гаргав.

Саваа хоёр байлаа. Тэр хэний саваа гэдгийг нь мартсан ч зөвхөн хэн нэгнээс булааж авснаа санаж байв. Иймээс арай аятайхан санагдсан богинохныг нь сонгож аваад чулуу руу чиглүүлэв.

Түүний удаанаар шивнэхийг даган чулуун дээр үг бичигдэв. Тэр Гермионагийн хамаагүй дээр түргэн бичихийг мэдэж байсан ч булшны нүх ухсан шигээ үүнийг өөрөө хийхийг хүслээ. Тэгээд ахин цэхлэн зогсох үед чулуун дээр дараах үг бичигдсэн байлаа.

ЭНД ЧӨЛӨӨТЭЙ ҮЙЛЧЛЭГЧ ДОББИ ХЭВТЭЖ БАЙНА.

Тэр хэдэн хормын турш хийсэн ажил руугаа хараад дараа нь явлаа. Сорви хатгуулсан ч толгой нь харанхуйд бараа нь харагдах булшны тухай бодлоор дүүрч аймшигтай санагдав.

Түүнийг гэрт орох үед бүгд зочны өрөөнд суугаад Биллийн ярихыг сонсож байлаа. Өрөө маш сайхан гэгээлэг бөгөөд жижигхэн ханан зууханд гал асна. Харри хивсэн дээр шороо тарихыг хүсээгүй тул үүдэнд зогсоод сонсов.

- Аз болоход Жинни амралтаараа гэртээ ирчихсэн байсан. Тэр Хогвартст байсан бол биднийг хүрч амжихаас өмнө барих байсан юм. Харин одоо бол аюулгүй болсон гээд Билл Харрийн зогсож байхыг ажиглалаа.

- Би Үүрнээс бүгдийг цуглуулаад нагац эгч Мюриэлийнд аваачсан. Үхэл залгигчид Роныг чамтай байсан гэж мэдэх болохоор гарцаагүй тийшээ очих байсан ... Үгүй дээ, уучлал гуйх хэрэггүй гэж Харрийн царайг ажиглан хэлээд,

- Үүнийг эрт орой хэдий ч тохиолдоно гэж аав бидэнд эртнээс анхааруулж байсан юм. Манай гэр бүл бол хамгийн том цэвэр цуснаасаа урвагч гэлээ.

- Тэднийг юу хамгаалж байгаа юм? гэж Харри асуулаа.

- Итгэлцлийн шид. Нууц хадгалагч нь аав. Манай байшинд ч гэсэн тийм шид бий. Би нууц хадгалагч нь. Одоо бид ажилдаа явж болохгүй болсон ч энэ чухал биш.

Олливандер, Дэгээдэгч хоёрыг бас нагац эгч Мюриэлийнх рүү илгээе. Манайд өрөө хангалтгүй ч тэнд хангалттай зай бий. Флер түүнийг яс ургуулагчаар эмчилсэн болохоор Дэгээдэгчийн хөл эдгэрсэн. Цагийн дараа хөдөлж чадна байх ...

- Үгүй гэж Харри хэлэхэд Билл гайхан түүнийг харлаа.

- Тэр хоёулаа надад хэрэгтэй. Би тэдэнтэй ярихыг хүсч байна. Энэ маш чухал шүү.

Харри хоолойныхоо гэнэтийн захирангуй өнгийг сонсоод Доббийн үхлээс өөртөө итгэлтэй болсноо мэдэв. Бүгд түүний зүг гайхширан харав.

- Би явж гараа угаалаа. Дараа нь тэдэнтэй түргэн ярих хэрэгтэй байна гээд

Харри цус шаварт будагдсан гараа харлаа.

Тэр жижигхэн гал зууханд ороод цонхны дэргэдэх угаагуур руу очиход тэнгис харагдаж байв. Тэнгэрийн хаяанд үүр гэгээрч алтлаг ягаан туяа татна. Харри нүүрээ угаах зуураа бодол нь ахин харанхуй цэцэрлэг рүү очлоо.

Добби хэн зоорь луу илгээснийг хэлж чадахгүй болсон ч Харри түүнийг харсан болохоо мэдэж байв. Хурц цэнхэр нүд толины хэлтэрхийнээс харахад тусламж ирсэн. Хогвартсад тусламж гуйсан хүн хэзээд авдаг.

Харри цонхны гадаах үзэмжийг тоолгүй гараа арчихад зочны өрөөнд яриа дүнгэнэж сонсогдов. Тэр тэнгис рүү хараад хэзээ ч байгаагүйгээрээ зорилгодоо ойртсоноо мэдэрлээ.

Сорви нь өвдсөн хэвээр Волдеморт бас байндаа ойртжээ. Харри урьд нь ойлгохгүй байсан зүйлээ ойлголоо ... Яг л зөн совин нь нэг зүйл хэлэхэд тархи нь өөр зүйл хэлээд байгаа юм шиг. Дамблдор Харрийн толгойд инээмсэглэн хурууныхаа үзүүрээр адислаж байгаа юм шиг.

Чи Ронд Делюминаторыг орхисон ... Чи түүнийг ойлгосон ... Тэгээд түүнд эргэж ирэх боломж өгсөн.

Чи Сүүлтийг бас ойлгосон ... Чи түүний сэтгэлийн гүндээ харамсаж байгаа гэдгийг мэдэж байсан ...

Хэрвээ чи тэднийг тийм сайн мэдэж байсан юм бол ... Миний тухайд юу мэдсэн юм, Дамблдор?

Үнэхээр би Үхлийн шүтээнийг мэдсэн ч хайхгүй байх ёстой байсан гэж үү? Чи үүнийг хичнээн хүнд болохыг төсөөлж байна уу? Тэгвэл яагаад даалгаварыг ийм хэцүү болгосон юм бэ? Надад бодож олох хугацаа байсан уу?

Харри байрандаа зогссон хэвээр алсад тэнгэрийн хаяанд нарны алтан цацраг тусахыг харлаа. Дараа нь цэвэрхэн гар луугаа хараад гар нүүрийн алчуур барьж байсан явдалдаа гайхлаа. Түүнийг хажуу тийш нь тавиад зочны өрөө рүү ахин эргэтэл сорви нь янгинан хатгуулж ой ухаанд нь тэмээлзгэнэ усны гадарга дээгүүр нисэх адил дүрс тусаж танил барилгын дүрс тодров.

Шатны хөлд Билл, Флер хоёр зогсож байв.

- Би Дэгээдэгч, Олливандер хоёртой ярилцах хэрэгтэй байна гэж Харри хэллээ.

- Үгүй. Х`лээх хэрэгтэй, `Арри. Тэд их ядарсан гэж Флер хэлэв.

- Надад их харамсалтай байгаа ч хүлээж чадахгүй нь. Би тэдэнтэй одоо л ярих ёстой. Тус бүртэй нь ... ганцаарчилан. Энэ маш яаралтай.

- Хараал ид, Харри юу болоод байна? гэж Билл тэссэнгүй хэлээд,

- Чи бидэн дээр үхсэн гэрийн үйлчлэгч, хагас ухаантай албин, Гермионаг тамлагдсан төрхтэй авчирсан дээрээс нь бас Рон ямар нэг зүйл хэлэхээс татгалзаад байдаг ... гэв.

- Бид юу хийж байгаагаа хэлж болохгүй. Билл чи бүлэгт байдаг болохоор

Дамблдор бидэнд хэнд ч хэлж болохгүй даалгавар өгснийг мэдэж байгаа.

Флер ямар нэг зүйл тэвчээргүйхэн бувтнасан ч Билл түүн рүү харсангүй Харри руу ширтлээ. Түүний гүн сорвитой царайг ойлгоход амаргүй байв. Тэр эцэст нь,

- За яахав. Чи хэнтэй нь түрүүлж ярихыг хүсч байна? гэв.

Харри тээнэгэлзлээ. Тэр шийдвэр гаргах нь чухал болохыг мэдэж байв. Цаг бараг үлдсэнгүй сонгох хэрэгтэй байлаа. Үхлийн шүтээн үү крестраж уу?

- Дэгээдэгч. Би эхлээд Дэгээдэгчтэй ярилцъя.

Түүний зүрх саяхан итгэмээргүй саадыг гүйн туулсан мэт цохилов.

- Тэгвэл миний араас гээд Билл түрүүлж шатаар өгслөө. Харри хэдэн гишгүүр өгссөн хойноо зогсоод эргэж хараад,

- Надад та хоёр хэрэгтэй байна! гэж зочны өрөөнд хаалганы сүүдэрт нуугдсан

Рон, Гермиона хоёр луу хашгирав.

Тэд гэрэлд гарахдаа санаа амарсан төрхтэй боллоо.

- Бие чинь хэр байна? Чи гайхамшигтай байж ... тэгж их зовсон ч түүх зохиож ярьсан гэж Харри Гермионагаас асуув.

Гермиона сулхан инээмсэглэхэд Рон түүний мөрөөр чанга тэвэрлээ.

- Бид одоо юу хийх вэ, Харри?

- Хараарай. Явцгаая.

Билл Харри, Рон, Гермиона гурвыг хоёр давхарт гаргав. Давчуу шатны талбай дээр гурван хаалга байлаа.

- Ийшээ.

Билл Флерийн өрөөний хаалгыг онгойлгов. Цонхны цаадах тэнгис нарны алтлаг туяанд гялбана. Харри цонх руу очоод цээжиндээ гараа зөрүүлэн эргэхэд сорви нь төөнөн өвдлөө. Гермиона гоёлын ширээний хажуугийн сандал дээр сууж, Рон түшлэгэн дээр нь суув.

Билл эргэж ирэхдээ гартаа жижигхэн албинг барьжээ. Тэр Дэгээдэгчийг орон дээр болгоомжтой тавихад талархсан үг бувтсан ч гараад хаалга хаалаа.

- Таныг орноос босгосонд уучлаарай. Хөл чинь яаж байна? гэж Харри асуулаа.

- Өвдөж байна. Гэхдээ эдгэрч байгаа гэж албин хариулав.

Тэр гартаа Гриффиндорын илдийг барьсан хэвээр царайд нь хэрцгий догшин сониучирхсан өнгө холилдон үзэгдэв. Харри албингийн шарангуй арьс, урт нарийхан хуруу, хар нүд рүү харлаа. Флер түүний шаахайг тайлсан учир урт бохир тавхай нь ил гарчээ. Тэр үйлчлэгчээс арай биерхүү бөгөөд толгой нь хүнийх шиг том байлаа.

- Та санахгүй байгаа байх ... гэж Харри эхлэв.

- Би таныг анх Гринготтсод ирэх үед шүүгээ рүү чинь дагуулан явснаа санаж байна? Би санаж байна, Харри Хоттер. Та албингуудын дунд ч гэсэн их алдартай хэмээн Дэгээдэгч хэлэв.

Харри албин хоёр бие биесээ цэгнэн харлаа. Харрийн сорви улам өвдлөө. Тэр Дэгээдэгчтэй яриагаа түргэхэн дуусгахыг хүч байсан ч итгэлгүй алхам хийхээс айж байлаа. Түүнийг юу гэж хэлэхээ бодож амжихаас өмнө албин нам гүмийг эвдэв.

- Та үйлчлэгчийг оршууллаа. Би хөрш унтлагын өрөөний цонхоор харсан гэж огцом хэлэв.

- Тиймээ.

Дэгээдэгч түүн рүү хар нүдээрээ хяламхийн харлаа.

- Та ер бусын шидтэн юм, Харри Поттер.

- Яагаад тэр вэ? гэж Харри асуугаад сорвио үрлээ.

- Та булшны нүх ухсан.

- Тэгээд юу гэж?

Дэгээдэгч хариулсангүй. Харри албин магл шиг гараараа ажилласаныг нь хэлж байна гэж бодсон ч түүний дэмжих эсэх нь хамаагүй байлаа! Тэр дайралтыг өөр дээрээ авлаа.

- Дэгээдэгч, би асуух гэсэн ...

- Та бас албинг аварсан.

- Юу?

- Та намайг ийшээ авчирсан. Үхлээс аварсан.

- Таныг үүнд харамсаагүй байх гэж найдана? хэмээн Харри тэвчээр алдан хэлэв.

- Үгүй, харамсаагүй Харри Поттер. Гэхдээ та ер бусын шидтэн юм гээд

Дэгээдэгч хуруугаараа хар сахлаа ороолоо.

- За яахав тийм байж. Гэхдээ надад тусламж хэрэгтэй байна, Дэгээдэгч. Та л надад тусалж чадна.

Албин үүнийг дэмжсэн тэмдэг үзүүлсэнгүй бөгөөд Харри руу баргар харсан хэвээр байлаа.

- Би Гринготтс банкны шүүгээг дээрэмдэх хэрэгтэй байна.

Харри ингэж хэлэхийг хүсээгүй ч сорви нь өвдөж нүдний өмнө Хогвартсын дүрс сүүмэлзэн үзэгдэхэд үг өөрийн мэдэлгүй гарчээ. Тэр ахин харалтыг хаав. Одоо Дэгээдэгчтэй ярих нь юунаас илүү чухал бай.

Рон, Гермона хоёр түүн рүү галзуурсан аятай ширтлээ.

- Харри ... гэж Гермиона хэлсэн ч Дэгээдэгч үгийг нь таслав.

- Гринготтсын шүүгээг дээрэмдэх гэнээ? хэмээн давтсанаа үрчийж орон дээр аятайхан хэвтлээ. - Боломжгүй хэрэг.

- Боломжгүй биш. Дээрэмдэж байсан удаа бий гэж Рон эсэргүүцэв.

- Тийм шүү гэж Харри дэмжээд,

- Биднийг анх танилцдаг өдөр болсон, Дэгээдэгч. Долоон жилийн өмнө миний төрсөн өдрөөр гэв.

- Тэгэхэд шүүгээ хоосон байсан. Түүнийг тийм ч хатуу хамгаалаагүй гэж албин зандрахад Харри түүний Гринготтс банкинд ажиллахаа больсон ч сэтгэл зүрхээ зориулсан хэвээр байгааг ойлголоо.

- Харин бид хоосон биш хүчирхэг хамгаалттай шүүгээнд нэвтрэх хэрэгтэй байна. Лестрейнжийн шүүгээнд.

Рон, Гермиона хоёр гайхширан бие бие лүүгээ харсан ч Дэгээдэгчтэй ярилцсаны дараа тэдэнд тайлбарлах хугацаа хангалттай байлаа.

- Ямар ч боломж байхгүй гэж Дэгээдэгч хатуу хэлээд,

- Юу ч бүтэхгүй. Хэрвээ чи бусдын эрдэнэсийг авахаар ирсэн бол ...

- Буцаж гарахгүй үүрд үлдэнэ гэдгийг санаж байна. Би тийшээ эд баялагийн төлөө орох гээгүй. Энэ шүүгээнээс хувьдаа юу ч авах гээгүй. Та надад итгэж байна уу?

Албин Харри руу хяламхийн харахад духан дээрх цахилгаан хэлбэртэй сорви нь хатгуулан өвдсөн ч үл тоомсорлон нэвтрэх боломж өгсөнгүй.

- Хэрвээ энэ дэлхий дээр эд баялаг хайгаагүй шидтэн бий гэвэл Харри Поттер таныг гэдэгт итгэж байна. Албин, гэрийн үйлчлэгч нар хүндлэл хамгаалалт үзүүлэхэд дасал болоогүй байдаг ч та энэ шөнө хийлээ. Бидэнд саваа зүүхийг ч зөвшөөрдөггүй гэж Дэгээдэгч эцэст нь хэлэв.

- Шидэт саваа зүүх гэнээ хэмээн Харри давтав.

Энэ үг түүнд хачирхалтай сэтгэгдэл төрүүлэхэд сорви нь ахин өвдөж Волдеморт умард зүгийг чиглэж байлаа. Харри зэргэлдээ өрөөнд хэвтэж буй Олливандераас асуулт асуухсан гэхээс байж ядлаа.

- Шидэт саваа зүүх эрхийн талаар албин шидтэнгүүд удаан жилийн өмнөөс маргалдаж байгаа гэж албин чимээгүйхэн өгүүлэв.

- Албингууд саваагүй илбэдэж чадна шүү дээ гэж Рон хэллээ.

- Энэ хамаагүй! Шидтэнгүүд шидээ савааны мэдлэгийн нууцаа өөр бусад шидийн ард түмэнтэй хуваалцахыг хүсэхгүй байгаа юм. Тэд бидэнд боломжоосоо хуваалцахыг хүсэхгүй байна!

- Албингууд ч гэсэн шидийн нууцаасаа хуваалцдаггүй. Та нар хэзээ ч илд блон дуулга яаж хийдгээ хэлээгүй. Албингууд шидтэнгүүдийн хэзээ ч хийж байгаагүй аргаар төмөр эдлэлийг боловсруулдаг ...

- Энэ чухал биш гэж Харри Дэгээдэгчийн царай барайхыг харан яаран хэлээд,

- Шидтэнгүүд албин болон бусад шидийн амьтдын эсрэг маргаан ... гэв.

- Гэхдээ энэ тийм шүү дээ! гээд Дэгээдэгч таагүйхэн инээд алдаж,

- Хар лордыг хүчирхэг болох тусам танай ард түмэн манайхыг хавчин хяхаж байна! Гринготтс банк шидтэнгүүдийн захиргаанд орж, үйлчлэгч алагдаж байхад хэн шидэт саваа зүүхгүй байхыг эсэргүүцэх юм бэ? гэв.

- Бид! Бид үүнийг эсэргүүцэж байна! Жишээлбэл би дурын албин гэрийн үйлчлэгчийн адил хөөгдөж байна. Би бол бохир цустан! гэж Гермиона цэхлэн зогсоод нүдээ гялалзуулан хэлэв.

- Өөрийгөө тэгж битгий нэрлэ! гэж Рон хашгирлаа.

- Яагаад үгүй гэж? хэмээн Гермона эсэргүүцээд,

- Тиймээ би бохир цустан үүгээрээ бахархаж байна! Шинэ дэглэмд миний байр суурь таныхаас дээргүй, Дэгээдэгч! Ийм учраас намайг Малфойнд тамлахаар сонгосон юм! гэв.

Тэр ингэж хэлээд халатныхаа захыг яран Беллатрисагийн хутганы улаан зүссэн ормыг харуулснаа,

- Ингэхэд та Харри Доббиг чөлөөлснийг мэдэх үү? Бид олон жилийн турш гэрийн үйлчлэгчийг чөлөөлөхөөр тэмцэж байгааг мэдэх үү? гэхэд Рон ичсэндээ сандлын түшлэгэн дээр хавчганалаа.

- Та биднийг Хэцүү нэртийг ялахыг хүсэхгүй байна гэж үү, Дэгээдэгч! Албин Гермиона руу Харрийн адил сониучирхан харлаа.

- Таньд Лестрейнжийн шүүгээнээс юу хэрэгтэй юм бэ? Дотор нь хадгалаатай байгаа илд хуурамч. Жинхэнэ нь энэ байна. Би та нарыг мэдэж байгаа гэж бодож байна. Та надаас түүнд худал хэлэхийг гуйсан биз дээ.

- Гэхдээ шүүгээнд зөвхөн илд байгаа хэрэг биш тийм үү? Та түүнд юу хадгалагдаж байгааг харсан уу? гэж Харри асуулаа.

Түүний зүрх хүчтэй цохилоход сорвиныхоо өвдөлттэй бүх хүчээ гарган тэмцлээ. Албин ахиад л хуруугаараа сахлаа ороолоо.

- Гринготтсын дүрэмд банкны шүүгээнд хадгалаастай байгаа зүйлийн талаар ярих ёсгүй. Бид гайхамшигтай эрдэнэс баялаг хадгалж байдаг. Бидний үүрэг бол тэнд байгаа зүйлд санаа тавьж сахин хамгаалах явдал юм.

Албин илдийг илснээ Рон, Гермиона хоёрыг гүйлгэн харж тэгснээ ахиад л Харри руу харлаа.

- Та залуу ч гэсэн олон дайсны эсрэг тэмцэж байна.

- Та бидэнд туслах уу? Бид таны тусламжгүй банкны шүүгээнд нэвтрэх найдлага байхгүй. Та бидний цорын ганц найдлага.

- Би ... энэ тухай бодож үзье гээд Дэгээдэгч ахин тэдний тэвчээрийг барлаа.

- Гэхдээ ... гэж Рон ууртай хэлсэн ч Гермиона хавирга руу нь тохойгоороо нударлаа.

- Баярлалаа гэж Харри хэлэв.

Албин том толгойгоо хариу бөхийлгөснөө Билл, Флер хоёрын орон дээр байгаа жижигхэн хөлөө харав.

- Яс ургуулагчын үйлчлэл гарч байх шиг байна. Би одоо унтаж чадах боллоо.

Намайг өршөөгөөрэй ...

- Тиймээ, мэдээж!

Өрөөнөөс гарахдаа Харри Дэгээдэгчийн хажууд байсан Гриффиндорын илдийг авлаа. Албин эсэргүүцээгүй хэдий ч нүдэнд нь эгдүүцэл гялсхийх шиг санагджээ.

- Жижигхэн жигшүүртэй амьтан. Тэр биднээр тоглож байна! гэж Рон хаалга хаамагц уурсав.

- Харри чи миний бодож байгааг хэлсэн үү? Лейстренжийн шүүгээнд крестраж байгаа гэж бодоо юу? хэмээн Гермиона шатны харанхуй талбайд хүрэхдээ асуулаа.

- Тиймээ. Блелатриса биднийг тийшээ орсон гэж бодмогц яаж айхыг нь харсан биз дээ? Яагаад юм бол? Бид тэндээс өөр юу авч болох вэ? Тэр Хэцүү нэртийг энэ тухай мэдэхээс үхтлээ айсан.

- Гэхдээ бид Хэцүү нэртийн хувьд чухал газар хайж байгаа гэж бодсон юмсан.

Гэтэл Лейстрейнжийн шүүгээнд байх гэж үү? хэмээн Рон бодлогоширонгуй хэлэв.

- Би түүнийг Гринготтсод орж байсан эсэхийг мэдэхгүй байна. Тэр залуудаа ямар ч алт залгамжилж аваагүй болохоор Танхир гудамжинд анх очихдоо гаднаас нь л харсан байх.

Сорви нь янгинан өвдсөн ч Харри тоохгүй байхыг хичээв. Тэр Рон, Гермиона хоёртой Гринготтсын тухай ярихаас урьд Олливандертай ярих хэрэгтэй байлаа.

- Тэр Гринготтсын шүүгээний түлхүүртэй хүнд атаархдаг байсан гэж бодож байна. Энэ түүний шидэт ертөнцөд харсан жинхэнэ бэлэг тэмдэг байсан. Бас түүний Беллатриса нөхөр хоёрт нь итгэдгийг бүү март. Тэд түүнийг унахаас өмнө хамгийн үнэнч зарц нь байсан. Би түүнийг эргэж ирсэн шөнө тэгж хэлэхийг сонссон гээд Харри духаа үрлээ.

- Гэхдээ түүнийг Беллатрисад крестраж юу болохыг хэлсэн байх гэж бодохгүй байна. Тэр Люциус Малфойд тэмдэглэлийн дэвтрийн тухай үнэнийг хэлээгүй. Түүнийг шүүгээндээ үнэт зүйлийнхээ хамт хадгал гэсэн байх. Хагрид хэрвээ ямар нэг юм нуухыг хүсвэл Хогвартсаас гадна ... Гринготтс дэлхий дээр хамгийн аюулгүй газар гэсэн.

Харриг яриагаа дуусгамагц Рон толгой сэгсэрлээ.

- Чи түүнийг сайн ойлгосон байна!

- Жаахан л. Хэрвээ би Дамблдорыг арай илүү сайн ойлгосон бол ... За яахав, бид үүнийг харах болно. Харин одоо Олливандер руу явцгаая.

Рон, Гермиона хоёр биширсэн янзтай харлаа. Тэд хамтдаа шатны талбайн эсрэг талын хаалга руу очиж цохилоо. «Ороорой» гэх хариу дуулдав.

Шидэт сабааны дархан цонхон талын орон дээр хэвтэж байв. Тэр зооринд жилээс илүү хугацаанд хоригдож тамлагдсаныхаа улмаас аймшигтай турж яс арьс болоод царай нь шарангуй өнгөтэй болжээ. Том мөнгөлөг нүд нь аягандаа хөнхийн, хөнжил дээр тавьсан гар нь ясан хэдрэг болсон байв.

Харри хоосон орон дээр суухад дэргэд нь Рон, Гермиона хоёр суув. Энд нар тусахгүй хэдий ч цонхоор хясааны орой болон шинэхэн булшны шороо харагдаж байлаа.

- Ноён Олливандер таныг түгшээсэн явдалд өршөөгөөрэй гэж Харри хэлэв.

- Хонгор хүү минь чи биднийг аварсан. Би бүгд зооринд үхэх нь гэж бодож байлаа ... Чамд яаж талархахаа ч мэдэхгүй байна гэж Олливандер сулхан хоолойгоор хэлэв.

- Бид үүнийг хийсэндээ баяртай байна.

Сорви улам хүчтэй өвдөхөд Харри Волдемортыг байндаа хүрэхэд ойртсон болохыг ойлголоо. Түүнд айдас төрөв ... Тэр хэдийн сонголт хийж Дэгээдэгчтэй эхэлж

ярихаар шийдсэн. Харри тайван байхыг хичээгээд хүзүүндээ зүүсэн хүүдийнээс хугарсан шидэт саваагаа гаргаж ирлээ.

- Ноён Олливандер надад тусламж хэрэгтэй байна.

- Хүссэнээр чинь болъё! гэж тэр сонсдох төдий хэлэв.

- Та үүнийг засч чадах уу? Түүнийг засаж болох болов уу?

Олливандер чичирсэн гараа сунгахад Харри алган дээр нь шидэт саваагаа тавилаа.

- Шивээ навчит мод галт шувууны өд. Арван нэгэн дюйм. Туяхан сайхан саваа гэж Олливандер чичирхийлсэн хоолойгоор хэлэв.

- Тиймээ. Та чадах уу?

- Үгүй. Надад их харамсалтай байгаа ч ийм гэмтэл учирсан үед засах боломжгүй.

Харри эртнээс ийм хариулт сонсоход бэлэн байсан ч энэ нь хүнд цохилт боллоо. Тэр саваагаа хүүдийд ахин буцааж хийв. Олливандер хугарсан саваа алга болохыг харж байснаа Харри халааснаасаа Малфойн гэрээс авсан хоёр саваа гаргаж ирлээ.

- Та үүнийг хэнийх болохыг таних уу?

Мастер эхний савааг аваад мойног хуруундаа эргэлдүүлэн ойртуулж шинжин харлаа.

- Хушганы мод лууны хатаасан зүрх. Арван хоёр дөрөвний гурван дюйм. Нугарашгүй хатуу. Энэ саваа Беллатриса Лестрейнжийнх.

- Харин энэ нь?

Олливандер хоёр дахь савааг мөн адил анхааралтай харлаа.

- Долоогоны мод ганц эвэртийн хялгас. Арван дюйм. Энэ саваа Драко Малфойнх байсан.

- Байсан гэнээ? хэмээн Харри давтаад,

- Одоо биш болсон юмуу? гэлээ.

- Тэгж бодохгүй байна. Хэрвээ та түүнийг тэмцлийн дүнд авсан бол ...

- Тэгсэн.

- Тэгвэл тэр одоо таных. Яг л гараас гар дамжин явдаг саваа шиг. Саваанаас олон зүйл хамаарна. Гэхдээ түүнийг тэмцэлд авсан бол шинэ эзэндээ үнэнч зүтгэх болно.

Өрөөнд нам гүм болж зөвхөн алсад тэнгис давалгаалах сонсогдоно.

- Та шидэт саваа амьд гэж хэлсэн шүү дээ. Яг л өөрсдөө бодож чаддаг юм шиг гэж.

- Шидэт саваа эзнээ сонгодог болохыг саваа судлаач хүн бүр мэднэ.

- Тэгвэл сонгоогүй савааг ашиглаж болох уу?

- Тийм л дээ хэрвээ чи жинхэнэ шидтэн бол шидийн суваг чинь ямар ч зүйлийг эзэмшиж чадна. Хамгийн үр дүнтэй арга гэвэл шидтэн саваа хоёрын хоорондын нөхөрлөл юм. Энэ бол маш ярвигтай холбоос. Эхлээд харилцан бие биендээ татагдсанаа туршлага солилцоно ... саваа шидтэнгээс сурч шидтэн саваанаас сурдаг юм.

Давалгаа эрэг мөргөн буцах чимээ гашуудалтай дуулдав.

- Би энэ савааг Драко Малфойгоос авсан. Тэр намайг сонгсож байгаа болов уу?

- Тийм гэж бодож байна. Шидэт саваа төвөгтэй нарийн шидийн хуулийн дагуу ялсан шинэ эзэндээ харъяалагдах ёстой.

- Харин би үүнийг ашиглаж болох уу? гээд Рон халааснаасаа Сүүлтийн савааг гарган сунгав.

- Туулайн бөөр мод лууны хатсан зүрх. Есөн дюйм. Хэврэгхэн. Намайг барьсаны дараа Питер Петтигрю үүнийг хүчээр авсан юм. Тиймээ хэрвээ та түүнийг тэмцлийн дүнд авсан бол дургүй ч гэсэн сонсох болно.

- Бүх саваанууд тийм үү? гэж Харри асуулаа.

- Тийм гэж бодож байна гээд Олливандер Харри руу том нүдээрээ харж,

- Та гүн гүнзгий асуулт тавилаа, ноён Поттер. Шидэт савааны ухаан бол ярвигтай хэцүү дүүрэн шидийн нууц агуулсан зүйл юм гэв.

- Өмнөх эзнийг заавал алалгүйгээр шидэт савааг эзэмшиж болох уу? Олливандер хирдхийлээ.

- Өмнөх эзнийг нь алах гэнээ? Би заавал тэгэх хэрэгтэй гэж хэлээгүй биз дээ.

- Домогт өгүүлснээр бол гээд Харрийн зүрх хурдтай цохилоход сорви нь хүчтэй хатгуулав. - Шидэт савааны тухай домогт эзнийг нь алснаар гар дамжин явдаг хэдэн савааны тухай гардаг.

Олливандер цонхийн цайж том нүд нь айдаст автан томорлоо.

- Би ердөө ингэдэг ганц саваа байдаг гэж бодож байна.

- Хэцүү нэрт энэ савааг сонирхож байгаа биз дээ? гэж Харри асуув.

- Би ... яаж? Та хаанаас мэдээ вэ? гэж Олливандер сөөнгөтөөд Рон, Гермиона хоёр луу тусламж гуйн харлаа.

- Тэр танаас шидэт савааны хоорондын холбоосыг яаж дийлэхийг хэлэхийг хүссэн.

Олливандер айдаст автлаа.

- Тэр намайг тамласан, ойлгож байна уу! Круциатус шидээр! Би ... би түүнд мэдэж байгаа зүйлээ хэлэхээс өөр сонголт байгаагүй ... үнэндээ таамагласан юм.

- Би ойлгож байна. Та түүнд нэг зүрхтэй ихэр савааны тухай хэлээ биз дээ?

Бусдын савааг авахыг зөвлөө биз дээ?

Олливандер түүн рүү эмээнгүй харснаа удаанаар толгой дохилоо.

- Гэхдээ энэ бүтээгүй гэж Харри үргэлжлүүлээд,

- Миний саваа бусдын савааг нь ч гэсэн дийлсэн. Та үүнийг яагаад гэдгийг тайлбарлаж чадахгүй биз? гэв.

Олливандер толгой дохисон шигээ удаанаар сэгсрэв.

- Би ... би хэзээ ч тийм зүйлийн тухай сонсож байгаагүй. Тэр шөнө таны саваа ер бусын үйлдэл гаргасан. Нэг зүрхтэй сабааны холбоос ховорхон тохиолддог хэдий ч яагаад таны саваа бусдын сабааг хугалж чадсаныг төсөөлж чадахгүй нь ...

- Бид одоо өөр сабааны тухай ярьж байна ... аллагын үндсэн дээр нэгнээс нөгөөд дамжин явдаг. Хэцүү нэрт миний сабаанд ямар нэг хачирхалтай зүйл байгааг ойлгоод танаас өөр сабааны тухай асуусан биз дээ?

- Та энэ тухай хаанаас мэдээ вэ? Харри хариулсангүй.

- Тиймээ тэр асуусан. Тэр намайг Үхлийн болон Хувь заяаны сабааны тухай мэдэх бүхнээ ярь гэж шаардсан гэж Олливандер шивнэлээ.

Харри гайхан мэгдсэн Гермиона руу хяламхийлээ.

- Хар лорд үргэлж миний өгсөн галт шувууны өд арван гурав хагас инч саваанд сэтгэл хангалуун байдаг байсан ... нэг зүрхтэй сабааны тухай мэдэхгүй байх хүртлээ. Тэр одоо өөр илүү хүчирхэг саваа хайж таныг дийлэх ганц арга гэж бодож байгаа юм.

- Гэхдээ тэр удахгүй миний саваа найдлагагүй хугарсныг мэдэх болно. Эсвэл мэдсэн ч байж магадгүй гэж Харри аяархан хэлэв.

- Үгүй ээ! Тэр хаанаас энэ тухай мэдэх вэ? гэж Гермиона айн дуу алдлаа.

- Эртний шид. Миний бэлтгэл хийж байсан саваа Малфойнд үлдсэн, Гермиона.

Хэрвээ тэд түүнийг олоод сүүлд хийсэн шидийг нь шалгаж үзвэл миний саваа хугаран засахыг оролдсоныг мэдэх болно. Бас сабааг намайг зөвхөн бэлтгэл хийх зорилгоор ашиглаж байсныг ойлгох болно.

Гермиона ягаарснаа ахин цонхийлоо. Рон Харри руу зэмлэнгүй харав.

- Одоо энэ тухай ярихаа ...

Гэсэн ч түүнийг үгийг ноён Олливандер тасаллаа.

- Хар лорд сабааг зөвхөн таныг устгахын төлөө эрээгүй, ноён Поттер. Тэр түүнийг эзэмснээр халдашгүй болно гэж бодож байгаа юм.

- Энэ үнэн гэж үү?

- Ялагдашгүй сабааны эзэн үргэлж дайралтаас айж явдаг. Гэхдээ Хар лордын сабааг эзэмших санаа ... үнэхээр гайхамшигтай гэж хэлмээр байна.

Харри гэнэтхэн анхны уулзалтаар ноён Олливандер түүнд таалагдаагүйг саналаа. Тэр одоо хүртэл удаан хугацаанд олзлогдож тамлагдсаны дараа ч Хар лорд сабааг эзэмшихийг бахдаж байна.

- Тэгэхээр та энэ саваа үнэнэхээр байдаг гэж боддог юм биз дээ, ноён

Олливандер? хэмээн Гермиона асуув.

- Тиймээ, тэгэлгүй яахав. Түүний хувь заяаг хөөх боломжтой. Цаг хугацааны явцад алга болох юмуу түр нуугдсанаа ахин гарч ирдэг юм. Шинж чанараар нь таних боломжтой.

- Харин та ... үүнийг зөвхөн үлгэр домог гэж бодохгүй байна уу? гэж Гермиона найдангуй асуулаа.

- Үгүй дээ. Гэхдээ өмнөх эзнийг нь заавал алах ёстойг мэдэхгүй юм байна. Энэ саваа түүхэнд цусан мөр татуулсаар ирсэнийг хүний шунахай зантай холбон үзэж болох юм ...

- Ноён Олливандер та Хэцүү нэртэд ялагдашгүй саваа Грегоровичэд байгаа гэж хэлсэн биз дээ?

Олливандер улам цонхийн хий үзэгдэлтэй төстэй болов.

- Та хаанаас ... хаанаас ...

- Би хаанаас мэдсэн нь чухал биш гээд Харри нүдээ анихад сорви нь гал шиг төөнөн харанхуй Хогсмидын төв гудамжыг харагдсанаа цааш умард зүг рүү алслан явлаа.

- Та Хэцүү нэртэд яагаад Грегоровичэд байгаа гэж хэлсэн юм бэ?

- Тийм цуу яриа байсан юм. Таныг төрөхөөс олон жилийн өмнө. Минийхээр бол Грегорович өөрөө түүнийг гаргасан байх. Та үүний ажил хэрэгт ямар ашигтайг ойлгож байна уу. Тэр ялагдашгүй сабааны шинж чанарыг судлан хуулбарыг нь хийж чадна гэсэн үг.

- Тиймээ ойлгож байна гээд Харри боссоноо,

- Ноён Олливандер ахин нэг асуулт үлдлээ. Үүний дараа бид таныг тайван орхиё. Та Үхлийн шүтээний тухай юу мэдэх вэ? гэлээ.

- Юуны тухай гэнээ? хэмээн Олливандер гайхширан асуув.

- Үхлийн шүтээн.

- Би таныг юун тухай яриад байгааг ойлгосонгүй гэж айж байна. Энэ шидэт саваатай холбоотой зүйл үү?

Харри түүний турж эцсэн царай руу хараад тоглоогүй гэдгийг нь ойлгов. Тэр үнэхээр юу ч мэдэхгүй байлаа.

- Баярлалаа. Маш их баярлалаа. Харин одоо бид явлаа та амар. Олливандер түүн рүү өрөвдөлтэй харлаа.

- Тэр намайг тамласан! Круциатус шидээр ... Та үүнийг ямар болохыг нь төсөөлөхгүй байна ...

- Чадна. Жинхэнээсээ шүү. Гуйя амрахыг хичээгээрэй. Бидэнд хэлсэн бүх зүйлд чинь баярлалаа.

Харри шат руу гарахад Рон, Гермиона хоёр даган уруудав. Гал зууханд Билл, Флер, Полумна, Дин нар суугаад цай ууж байв. Бүгд эргээд Харри руу харахад толгой дохиод цэцэрлэг рүү Рон, Гермиона хоёрын хамтаар гарлаа.

Доббийн нойрсож байгаа улаан толгод өмнө нь гарч ирэхэд Харри буцаж алхахдаа толгой нь улам өвдлөө. Тэр асар их хүч чармайлт гарган байж харалтаа хаасан ч энэ

нь удаан үргэлжлэхгүй гэдгийг мэдэж байв. Онолоо шалгахын тулд харалтанд нэвтрэх хэрэгтэй байлаа. Гэвч одоо ахин нэг хүч гаргаж Рон, Гермиона хоёрт тайлбарлах шаардлагатай байв.

- Ялагдашгүй саваа Грегоровичэд дээр үед байсан. Би Хэцүү нэрт түүнийг эрж байхыг харсан. Түүнийг мөрдөж Грегоровичийг олсон ч саваа байхгүй болоод Гриндевальд хулгайлсан байсан. Гриндевальд саваа хаана байгааг яаж мэдсэнийг ойлгохгүй байгаа ч ... Грегоровичэд энэ тухай тараахгүй байх хангалттай ухаан байгаагүй бол ойлгомжтой гэж бодож байна.

Волдеморт Хогвартсын хаалганд хүрлээ. Харри зогсоод шилтгээний замаар гартаа дэнлүүтэй хүн угтан ирэхийг харлаа.

- Гриндевальд эрх мэдэлд хүрэхдээ савааг ашиглажээ. Түүнийг хүч чадлын оргилд байхад Дамблдор өөр хэн ч зогсоох аргагүйг ойлгоод Гриндевальдыг тулаанд дуудан дийлж савааг авсан байна.

- Саваа Дамблдорт байсан гэж үү? Харин одоо хаана байна? гэж Рон гайхан асуулаа.

- Хогвартсад гээд Харри эцсийн хүчээ шавхан бодит байдалд эргэн ирлээ.

- Тэгвэл гүйцгээе! Харри, түүнийг очихоос урьд авъя гэж Рон шаардлаа.

- Хэтэрхий оройтсон. Тэр саваа хаана байгааг мэдсэн. Одоо тэнд байна гэж

Харри арай ядан харалттайгаа тэмцэж хэллээ.

- Харри! Чи энэ тухай эртнээс мэдэж байсан уу? Тэгвэл бид яагаад хугацаа гарзадсан юм? Яагаад эхлээд Дэгээдэгчтэй ярилцсан юм? Бид амжих байсан! Авч амжих байсан ... гэж Рон уурсан хашгирлаа.

- Үгүй гээд Харри өвдөглөн унав. - Гермионагийн зөв Дамблдор намайг энэ савааны араас явахыг хүсээгүй. Тэр намайг крестражыг устгахыг хүссэн.

- Ялагдашгүй саваа шүү дээ, Харри! гэж Рон ёолов.

- Би тэгэх ёсгүй ... миний ажил бол крестражыг олох ...

Эргэн тойрон хүйтэрч харанхуйлав. Нар тэнгэрийн хаяанд дөнгөж жарган тэр

Снеггийн хамт нуурын зүг явж байлаа.

- Би удахгүй чиний араас шилтгээн рүү явна. Намайг орхи гэж тэр өндөр хүйтэн хоолойгоор хэлэв.

Снегг бөхийн ёслоод шилтгээн рүү хар жанчаа намируулан алхав. Харри алхаагаа удаашруулан Снеггийн дүрс алга болохыг хүлээлээ. Снегг ч байж өөр хэн ч гэсэн түүний хаашаа явахыг харах ёсгүй. Сургуулийн цонхонд гэрэл асаагүй байсан ч тэр нууцлагдах ёстой. Секунтын дараа тэр Хувиргах шидээр өөрийгөө далдлан бусдын нүдэнд үзэгдэхгүй болов.

Тэр нуурын эрэг рүү очоод анхны ноёрхолоо олсон газар болох шилтгээний дүрсийг харж баярлан ...

Тэгтэл тусгал нь харанхуй усанд үзэгдэв. Цагаан гантиг бунхан эрэг дээр цайвалзан харагдана. Тэр ахин баяр хөөрийг мэдрэхэд толгой нь хүч чадалдаа эргэв. Тэр хуучин улаан модон саваагаа өргөлөө. Хамгийн сүүлчийн үйлдэл нь ямар агуу юм бэ!

Бунхан цэлсхийн нээгдэж өмнө нь даавуунд хучигдсан амьгүй туранхай өндөр дүрс харагдав. Тэр ахин саваагаа өргөлөө.

Оршуулгын боолт задарлаа. Үхлийн царай тунгалаг цонхигор бараг даршлагдсан гэмээр ажээ. Нүдний шил нь махигар хамар дээрээ инээдтэй хэлтийжээ! Дамблдорын гар цээжин дэрээ зөрүүлээстэй ... харин саваа гарт нь байлаа ... хамт оршуулагджээ.

Үнэхээр хөгшин тэнэг гантиг бунхан сабааг хамгаална гэж бодсон юм болов уу? Хар лорд бунханыг дээрэмдэж зүрхлэхгүй гэж бодсон юм болов уу? Аалз шиг цагаан гар ухасхийн олзоо шүүрэн авахад өмнөх эзний үхсэн бие дээр оч асгаран шидэт саваа шинэ эзэндээ зүтгэхэд бэлэн боллоо.

БҮЛЭГ 25: ХЯСААН БАЙШИН

Билл, Флер хоёрын байшин бусдаас зайтай хясааны ирмэг дээр сүндэрлэх бөгөөд шохойдсон ханаа тэнгисийн хясаагаар чимэглэжээ. Энэ нь үзэсгэлэнтэй сайхан газар байлаа. Байшин цэцэрлэгт тэнгисийн давалгаа сонсогдож аварга том амьтан амьсгалж буй мэт түрлэг нь эрэг мөргөн буцна. Харри хэдэн өдрийг дүүрэн хүнтэй байшингаас зугтан хясаан дээрээс уудам тэнгэр, өргөн тэнгис ширтэн өнгөрүүлсэн бөгөөд давстай хүйтэн салхи нүүрийг нь илбэнэ.

Тэр одоо хүртэл өөрийнхөө Волдеморт болон ялагдашгүй савааны араас хөөцөлдөхгүй байх шийдвэр гаргасандаа эмээх сэтгэл төрж байв. Үүний дээрээс Рон эргэлзээгээ нэмэрлэхгүй байж чадахгүй аж.

- Хэрвээ Дамблдор биднийг нууцалсан тэмдгийг тайлан савааг авахыг хүссэн бол яах вэ? Хэрвээ энэ чамайг Үхлийн шүтээнийг эзэмшиж чадах эсэхийг шалгасан шалгуур байсан бол яана? Харри ялагдашгүй саваа үнэхээр байдаг бол бид Хэцүү нэртийн эсрэг яаж тэмцэх болж байна?

Харри үүнд хариулсангүй. Тэр Волдемортод бунханг саадгүй дээрэмдэх боломж олгосон талаараа бодсон ч яагаад ингэж шийдсэнээ тайлбарлаж чадсангүй. Түүнийг энэ талаар өөртэйгээ маргах болгонд улам сул сонсогдож байлаа.

Хамгийн хачирхалтай нь гэвэл Гермионагийн дэмжлэг түүнийг Роны тээнэгэлзлээс дутуугүй эргэлзүүлж байв. Ялагдашгүй саваа байдаг нь батлагдсан тул тэр үүнийг хар шидийн зүйл гэж нотолж Волдеморт түүнийг авсан нь туйлын жигшүүртэй зүйл гэж хэлж байлаа.

- Чи тэгж хийх ёсгүй байсан, Харри. Чи Дамблдорын бунхныг тонож болохгүй байсан! хэмээн эцэст төгсгөлгүй давтаж байв.

Гэвч үхсэн биед хүндэтгэл үзүүлэхээс илүү Харри Дамблдорын санааг буруу таасан гэсэн айдас төрж байв. Тэр урьдын адил харанхуйд төөрч бэдэрсэн хэвээр байсан тул сонгож авсан замаа эргэж харан тэмдгийг зөв уншаагүй байгаа даа гэж эргэлзлээ. Гэнэтхэн өөр зам сонгох хэрэгтэй байсан бол яана? Цаг хугацаа өнгөрөх тусам түүнийг ахин Дамблдорт уурлах уур хилэн цохио мөргөх хүчирхэг давалгаа адил хаман авлаа. Тэр яагаад амьд байхдаа бүгдийг тайлбарлаагүй юм бол?

- Ингэхэд тэр үнэхээр үхсэн болов уу? гэж Рон тэднийг байшинд ирснээс гурав хоногийн дараа асуулаа.

Харриг цэцэрлэг цохио хоёрыг тусгаарласан хашаа ширтэж байхад нь Гермиона тэр хоёр олжээ. Түүнд ахин маргах хүсэл байсангүй тул найзууд нь олсон явдалд бараг харамслаа.

- Тиймээ, Рон үхсэн алив энэ тухай ахиж ярихаа больцгооё!

- Бүх баримтыг аваад үз л дээ, Гермиона. Мөнгөн согоо, Гриффиндорын илд, Харри толинд нүд харсан ... хэмээн Рон Харрийн толгой дээгүүр ширтэн зөрүүдлэн давтав.

- Харри нүдийг төсөөлсөн гэж хэлсэн шүү дээ! Үнэн биз дээ, Харри?

- Магадгүй л юм гээд Харри түүний зүг харсангүй.

- Гэхдээ чи төсөөлсөн гэж бодохгүй байгаа биз дээ? гэж Рон асуулаа.

- Үгүй тэгж бодохгүй байна.

- Харж байна уу! гээд Рон Гермионаг эсэргүүцэж амжихаас өмнө,

- Хэрвээ энэ Дамблдор байгаагүй юм бол Добби хаанаас бидний зооринд байгаа гэдгийг мэдсэн хэрэг байх вэ? гэв.

- Мэдэхгүй ... Тэгээд чинийхээр бол Дамблдор Хогвартсад бунханд хэвтэж байж түүнийг бидэн рүү илгээсэн байх нь уу?

- Мэдэхгүй ... хий үзэгдэл болсон ч юм билүү!

- Дамблдор хий үзэгдэл болоогүй цаашаа явсан гэж Харри хэллээ. Тэр сүүлийн үед үүнд улам итгэлтэй байлаа.

- Цаашаа гэдэг чинь юу гэж байгаа юм? гэж Рон гайхлаа. Гэвч Харриг дуугарч амжихаас өмнө ард нь хоолой сонсогдов.

- `Арри? гээд тэдэн рүү Флер дөхөж ирэв. Түүний урт мөнгөлөг үс сэвшээ салхинд намирна.

- `Арри, Дэгээдэгч чамтай ярихыг хүсч байна. Тэр жижигхэн унтлагын өрөөнд байгаа. Та нартай гадны хүнгүй ярилцахыг хүсч байна гэж хэлсэн.

Түүнд албингийн зараалд гүйх нь таалагдахгүй байгаа нь илт байсан бөгөөд ингэж хэлмэгц ууртайгаар эргэн гэр лүү явлаа.

Флерийн хэлсэнчлэн Дэгээдэгч тэднийг гурван унтлагын өрөөний хамгийн жижигхэн нь болох Полумна, Гермиона хоёрын унтдаг өрөөнд хүлээж байв. Албин улаан хөшгийг нээхэд цэлмэг үүлтэй тэнгэр харагдан өрөөний бүүдгэр байдалтай хачирхалтай зохилдов.

- Би шийдвэр гаргалаа, Харри Поттер гэж албин намхан сандал дээр хөлөө зөрүүлэн суугаад урт нарийхан хуруугаараа түгшлэгийг нь бөмбөрдөнгөө хэлэв.

- Албингуудын Гринготтс банкинд нэвтрэхийг хүсч байвал туслахад бэлэн байгаа бөгөөд ...

- Ашгүй дээ! Баярлалаа, Дэгээдэгч, бид таньд их ...

- ... хариуд нь хөлс төлөхийг хүсч байна гэж яриагаа дуусгав. Харри гайхан тээнэгэлзлээ.

- Таньд хэд хэрэгтэй юм бэ? Надад алт байгаа.

- Үгүй хэрэггүй. Надад алт байгаа. Би илдийг авахыг хүсч байна. Годрик Гриффиндорын илдийг гээд албингийн хар нүд гялсхийлээ. Харри сэтгэлээр уналаа.

- Бид үүнийг таньд өгч чадахгүй. Уучлаарай.

- Тийм тохиолдолд бидэнд асуудал үүсэх болно.

- Бид тэндээс ямар нэг зүйл авааД таньд өгч болно шүү дээ. Лестрейнжийн шүүгээнд зөндөө олон зүйл байгаа болохоор биднийг тийш ормогц та хүссэнээ сонгож авч болно гэж Рон хажуугаас нь хэлэв.

Түүнийг ингэж хэлмэгц Дэгээдэгч уурласандаа хүрэнтлээ.

- Хүү минь, би хулгайч биш! Надад бусдын эд зүйл хэрэггүй!

- Гэхдээ илд биднийх ...

- Та нарынх биш гэж тэр эсэргүүцлээ.

- Бид Гриффиндорынх, харин тэр Годрик Гриффиндорт харъяалагддаг ...

- Гриффиндороос өмнө хэнийх байсан юм? гэж албин шаардаад суудал дээрээ өнгийлөө.

- Хэнийх ч биш. Түүнийг Гриффиндор хийсэн! гэж Рон хэлэв.

- Үгүй! гэж албин хашгираад Рон руу урт хуруугаараа чичлэн,

- Ахиад л шидтэний ихэмсэг зан! Илд Годрик Гриффиндорыг авахаас өмнө Рагнукад хамаарагдаж байсан! Энэ бол ... албингийн хийцийн гайхамшигтай бүтээл! Тиймээс албинд залгамжлагдах ёстой! Ийм үнэхээр миний тусламж ирнэ, хэрвээ хүсэхгүй бол дураараа болцгоо гэв.

Дэгээдэгчийн нүдэнд уур хилэн дүрэлзэв. Харри Рон, Гермиона хоёр руу харснаа,

- Бид энэ тухай зөвлөлдөх хэрэгтэй байна. Түр гарч болох уу? гэж асуув. Албин гашуунаар толгой дохив.

Харри нэг давхарын хоосон өрөөнд ороод ханан зуух руу очиж юу хийх талаар хөмсөг зангидан бодлогоширов. Тэгтэл ард нь Роны дуу гарч,

- Тэр зүгээр л тоглож байгаа юм! Бид түүнд илдийг өгч болохгүй гэлээ.

- Энэ үнэн үү? Гриффиндор үнэхээр илдийг хулгайлсан юм болов уу? гэж

Харри Гермионагаас асуулаа.

- Мэдэхгүй. Шидтэнгүүдийн түүхэнд шидтэн аль нэг өөр ард түмний хийсэн зүйлд хохирол учруулсан тухай үргэлж чимээгүй байдаг юм ... Гэхдээ би ямар ч тохиолдолд Гриффиндор илдээ цэвэр бус замаар олж авсан гэж дуулаагүй.

- Албингийн бас нэг ээлжит түүх. Тэд үргэлж шидтэнгүүд гомдоож байна гэж ярьдаг юм. Түүнийг бас бидний шидэт савааг нэхээгүйд баярлах хэрэгтэй!

- Албингуудад шидтэнд дургүй байх шалтгаан бий, Рон. Бид өнгөрсөн үед тэдэнтэй итгэмээргүй хэрцгий харьцаж байсан гэж Гермиона хэллээ.

- Гэхдээ албингууд өөрсдөө ч энхийн цагаан тагтаа биш шүү дээ. Биднээс хичнээн их хүн алсныг мэдэх үү? Тэд бохир тоглодог.

- Гэхдээ одоо аль ард түмэн нь илүү хуурамчаас илүү Дэгээдэгчийг нууц ажиллагаанд оролцуулж туслуулах нь чухал байгаа биз дээ?

Нам гүм болоход бүгд мухардлаас гарах арга замын тухай бодлоо. Харри цонхоор Доббийн оршуулгыг харав. Полумна булшны чулууны дэргэд шилэн савтай лаванда цэцэг тавьж байлаа.

- За яахав гээд Рон Харри руу эргэж,

- Ингэвэл ямар вэ? Дэгээдэгчид бид илдийг шүүгээнд орсон хойноо өгнө гэж хэлье. Илд бидэнд хэрэгтэй. Тэнд хуурамч нь байгаа биз дээ? Бид түүнийг аваад хуурамчыг нь өгөх болно гэв.

- Рон тэр биднээс хамаагүй дээр ялгана! Тэр ганцаараа хуурамч гэдгийг нь мэдсэн! гэж Гермиона дуу алдав.

- Тийм л дээ гэхдээ түүнийг анзаарахаас нь өмнө ... гээд Рон Гермиона руу эмээнгүй харлаа.

- Жигшмээр юм. Түүнээс тусламж гуйчихаад дараа нь хуурах гэж байна уу?

Бас албингууд шидтэнгүүдэд дургүй гэдэгт гайхаад байгаа юмаа. Роны чих улайлаа.

- За яахав, яахав! Би зүгээр л өөр зүйл бодож олж чадсангүй. Харин чи юу зөвлөмөөр байна?

- Бид түүнд өөр дутуугүй үнэ цэнэтэй юм санал болгоё.

- Гайхамшигтай! Явж албингийн хийцийн өөр нэг илд авчраад түүнийг илүү сайхан гэж хэлээрэй.

Тэд ахин чимээгүй болов. Харри өөр юм санал болгосон ч албин илднээс өөр зүйлийг зөвшөөрөхгүй гэдэгт итгэлтэй байлаа. Гэтэл тэд илдгүй бол крестражын эсрэг тэмцэж чадахгүй.

Харри нүдээ аниад тэнгис хэрхэн шуугихыг сонсов. Грифиндор илдийг хулгайлсан гэж бодох нь аягүй байлаа. Тэр үргэлж Гриффиндорых гэдгээрээ бахархаж ирсэн. Гриффиндор магл гаралтай хүмүүсийг хамгаалан цэвэр цусанд дуртай Слизеринтэй сөргөлдсөн ...

- Дэгээдэгч худал хэлсэн байж магадгүй. Гриффиндор түүнийг хэнээс ч хулгайлаагүй байх. Ингэхэд албин үнэн ярьж байгааг гэдгийг бид хаанаас мэдэх юм бэ? гээд Харри нүдээ нээлээ.

- Үүнд ямар ялгаа байна? гэж Гермиона асуув.

- Ялгаа гэвэл миний мэдэрч байгаа зүйлд байна гээд Харри гүн амьсгал авснаа,

- Түүнд илдийг шүүгээнд нэвтрэхэд тусалсны дараа өгье гэж хэлье. Гэхдээ бид үүнийг заавал хийнэ гэж хэлэх албагүй гэв.

Роны нүүрэнд алгуур инээмсэглэл тодроход, Гермиона эсрэгээрээ түгшсэн шинжтэй болов.

- Харри, тэгж болохгүй ...

- Бид түүнийг үнэхээр өгөх болно. Бүх крестражыг устгасны дараа. Би өөрийн биеэр Дэгээдэгчид аваачиж өгнө. Хэнийг ч хуурах гээгүй байна.

- Гэхдээ энэ хооронд чинь жил өнгөрч болно шүү дээ! гэж Гермиона хашгирав.

- Тиймээ гэхдээ тэр мэдэхгүй. Энэ худал хэлсэн хэрэг биш ... үнэн шүү

Харри Гермионагийн унтууцсан царай луу харлаа. Тэр Нурменгардын хаалган дээр сийлсэн «АУГАА ИХ САЙН САЙХАН» гэсэн үгийг санаснаа энэ бодлоо үлдэн хөөв. Тэдэнд сонголт байгаа билүү?

- Надад энэ таалагдахгүй байна гэж Гермиона хэлэв.

- Надад ч гэсэн гэж Харри хэллээ.

- Минийхээр бол агуу санаа байна! Явж түүнд хэлье гээд Рон үсрэн босов.

Тэд жижигхэн унтлагын өрөөнд эргэж орлоо. Харри илдийг өгөх цаг хугацааг хэлэхгүй байхаар үгээ нямбайлан боловсруулав. Түүнийг ярьж байх үед Гермиона барайн шал ширтэхэд бүтэхгүй байх гэж айсан ч Дэгээдэгч зөвхөн түүнийг харж байлаа.

- Хэрвээ би тусалвал Гриффиндорын илдийг өгнө гэсэн ам өгч байна уу, Харри

Поттер?

- Тиймээ.

- Тэгвэл гар барьцгаая гээд албин гараа сунгав.

Харри түүнийг атгахдаа энэ итгэлгүй хар нүднээс эвгүйцэхээ мэдрэв. Дараа нь

Дэгээдэгч гарыг нь тавиад алгаа хавсран,

- За, эхэлцгээе! гэв.

Яг л ид шидийн яам руу нэвтрэх гэж байсан үеийн түүх эргэн давтагдав. Дэгээдэгч харанхуйд дуртай учир тэд жижигхэн унтлагын өрөөнд ажиллаж байв.

- Би Лейстрейнжийн шүүгээнд нэг л удаа орсон. Тэгэхэд надад хуурамч илдийг аваачиж тавих үүрэг оногдсон юм. Энэ бол маш эртний өрөө. Эртний шидтэний гэр бүлүүд эрдэнээсээ хамгийн гүн, хамгийн том, хамгийн найдвартай хамгаалттай шүүгээнд хадгалдаг юм ...

Тэд цаг үргэлж бяцхан өрөөнд түгжин суусаар байв. Өдөр хоног удаанаар өнгөрч долоо хоног боллоо. Нэг асуудлыг шийдэхэд нөгөө нь урган гарах аж. Тэднийг ээлжит түгшээсэн зүйл гэвэл Хувиргагч уусмалын нөөц бараг дуусч байгаа явдал байлаа.

- Зөвхөн ганц хувь хэмжээтэй үлдэж гээд Гермиона өтгөн шавар шиг шингэнийг гэрэлд дэнлүүний гэрэлд өргөн харлаа.

- Энэ хангалттай гээд Харри Дэгээдэгчийн зурсан гүний хонгилын бүтэц зургийг харав.

Хясаан байшингийн бусад оршин суугчид Харри, Рон, Гермиона гурав өдөржин цоожтой суугаад зөвхөн хоол идэхээр гарч ирж байгааг анзаарахгүй байхын аргагүй аж. Гэхдээ хэн нь ч энэ талаар асуусангүй бөгөөд Харри ширээнд суух үедээ Биллийн сэтгэл түгшсэн харцыг мэдэрлээ.

Түүнчлэн хамтдаа их хугацааг өнгөрүүлэх тусам Харри албин таалагдахгүй байгааг ойлгов. Дэгээдэгч гэнэтхэн улай үзэхээр шунан Лестрейнжийн шүүгээнд орохдоо хэн нэг шидтэнийг шархдуулах санаа гаргахдаа ихээхэн баярлаж байв. Харри бусад нь ч гэсэн үүнд зэвүүцэхийг мэдэрсэн ч дэргэд нь энэ тухай ярьсангүй. Албин тэдэнд хэрэгтэй байлаа.

Дэгээдэгч дургүйхэн бүгдтэй хамт байхыг зөвшөөрч байв. Түүний хөл нь эдгэрсэн ч өмнөх шигээ Олливандерын адил өрөөнд нь хоол авчирч өгөхийг шаардаж байсан бөгөөд эцэст нь Флерийн тэвчээр барагдах үед Билл дээшээ гарч албинд энэ бүтэхгүй гэдгийг ойлгуулав. Үүний дараа Дэгээдэгч бүгдийн хамт ширээнд суусан ч ердийн хоолноос татгалзаж түүхий мах, үндэс, янз бүрийн мөөг өгөхийг шаардаж байлаа.

Харри үүнд гэм буруутайгаа мэдрэв. Эцсийн эцэст тэр л албинг хясаан байшинд үлдээн, Уизлийн гэр бүлийнхэн нуугдаж байгаа байшин руу явуулахаас татгалзсан билээ. Билл, Жорж, Фред, ноён Уизли нар удтал ажилдаа явсангүй.

- Намайг уучлаарай гэж тэр дөрвөн сарын салхитай нэг үдэш Флерт оройн хоол бэлтгэхэд тусалж байхдаа хэлээд,

- Би та нарыг энэ бүхэнд хутгахыг хүсээгүй гэлээ.

Флер хутгаар Дэгээдэгч болон Биллд зориулан мах хэрчиж байх зуураа (Билл Фенриртэй учирсныхаа дараагаар шүүрхий маханд дуртай болжээ) Харри руу сүүлийн үед ямагт уурлаж байсан ч тайвширсан царайгаар харав.

- ‘Арри, чи миний дүүг аварсныг би мартаагүй!

Шуудхан хэлэхэд Харри Габриэлийн амьдралыг авраагүй бөгөөд үнэн хэрэгтээ ямар ч аюул заналхийлээгүй билээ.

- Ютай ч н`ён Олливанд`р өнөө орой Мюриэлийнд очих болохоор байдал арай дээрдэх болно. Албинг гээд Флер хамраа үрчийлгэн зуухан дээр буцалж байгаа сав руу саваагаа зангаж,

- Нэг давхарт оруулах болохоор Дин та хоёр түүний өрөөнд ороорой гэв.

- Бидэнд зочны өрөө хангалттай гэж Харри түргэхэн хэлэв.

Тэдний хувьд Дэгээдэгч сэтгэл хангалуун байх хэрэгтэй байсан тул буйдан дээр унтахаа хүрвэл баярлахгүйг нь мэдэж байлаа.

Флер шаардсан ч Харри,

- Рон, Гермиона бид гурав энд удаан саатахгүй гэлээ.

- Удахгүй гэдэг чинь юу гэж байгаа юм? гээд Флер суулга руу саваагаа чиглүүлэнгээ,

- Та нар хаашаа ч явах хэрэггүй, энд аюулгүй байна! гэв.

Тэр гэнэтхэн хатагтай Уизлитай маш төстэй боллоо. Гэвч аз болж энэ үед үүдний хаалга онгойн Полумна, Дин хоёр бороонд норсон үстэй гартаа эрэг дээр хаягдсан мод барин орж ирэв.

- ... жижигхэн чихтэй. Аав түүнийг үслэг ягаан өнгөтэй болохоор усны үхэртэй төстэй гэж хэлдэг юм. Хэрвээ тэднийг дуудахыг хүсвэл вальс эргэх хэрэгтэй гэхдээ маш хурдан шүү ... гэж Полумна дуржигнуулав.

Дин ичсэн байртай мөрөө хавчаад Харри руу харлаа. Полумна тэр хоёр Рон, Гермиона хоёр оройн хоолны ширээ засч байсан зочны өрөө рүү оров. Харри Флерийн асуултнаас зайлсхийхийн тулд завшааныг ашиглан хоёр савтай хулууны шүүс аваад араас нь явлаа.

- Хэрвээ чи манай гэрт очвол би чамд эврийг нь үзүүлнэ ээ. Аав түүний тухай бичсэн ч Үхэл залгигчид намайг «Хогвартс экспресс»-ээс буулгаад зул сараас хойш хариагүй байгаа болохоор хараагүй л байна гээд Полумна түлээгээ галд хийв.

- Полумна бид чамд хэлсэн биз дээ. Эвэр дэлбэрсэн. Тэгээд ч энэ бол

Эрумпентийн болохоос Үрчгэр эвэртийнх биш гэж Гермиона хашгирав.

- Үгүй, энэ гарцаагүй үрчгэр эвэртийнх байсан. Аав түүнийг тодорхой бичсэн.

Одоо хэдийн засварлаад сэргээн босгосон биз. Гермиона толгой сэгсэрснээ сэрээгээ үргэлжлүүлэн тавилаа.

Билл ноён Олливандерыг авчрав. Шидэт савааны мастер ихэд суларч доройтон гартаа том чемодан барьсан Биллийн гараас зуурчээ.

Полумна хөгшин рүү очив.

- Би таныг их санана даа!

- Би ч гэсэн, хонгор минь. Та намайг аймшигтай газар байхад ихэд тайвшируулж байлаа гээд Олливандер мөрийг нь илэв.

Флер түүний хоёр хацар дээр үнсээд,

- Баяртай, ноён Олливандер! Таныг Биллийн нагац эгчийнх рүү явуулж байгаад өршөөгөөрэй. Та титмийг түүнд аваачаад өгч чадахгүйсэн болов уу? гэв.

- Би үүнийг хүндэтгэл гэж үзэх байна гээд Олливандер үл мэдэг бөхийн ёслов. - Энэ бол та нарын сайхан сэтгэл зочломтгой занд миний хийж чадах хамгийн өчүүхэн зүйл.

Флер гандсан хилэн хайрцаг онгойлгон ноён Олливандерт титмийг үзүүлэхэд намхан адарт өлгөсөн гэрэлд туяаран гялалзав.

- Алмаз болон сарны чулуу. Хэрвээ эндүүрээгүй бол албингийн хийц үү? гэж өрөөнд чимээгүйхэн орж ирсэн Дэгээдэгч хэлэв.

- Шидтэнгийн төлсөн гэж Билл аяархан хэлэхэд албин түүн рүү эмээнгүй харлаа.

Байшингийн гадаа хүчтэй салхи дэгдэхэд Билл ноён Олливандерын хамт гарч шөнийн харанхуйд алга болов. Үлдсэн хүмүүс ширээнд тохой нийлүүлэн суугаад хоолоо идлээ. Ханан зууханд гал тас нясхийн дүрэлзэнэ. Харри Флер сэрээгээрээ

хоолоо хатгах зууpаа цонх руу дахин дахин харахыг ажиглажээ. Гэсэн ч Билл оройн хоол дууссаны дараа салхинд арзайсан үстэй орж ирэв.

- Бүх зүйл хэвийн. Олливандер шинэ газартаа очсон. Ээж, аав хоёр мэнд дамжуулсан. Жинни ч гэсэн. Фред, Жорж хоёр арын өрөөнд нь уулийн шуудангаар захиалга аваад Мюриэлийг галзууруулах шахаж байгаа юм байх. Гэхдээ нагац эгч титмийг нь эргүүлэн өгсөн явдалд их баярласан шүү. Биднийг алдсан гэж бодож байсан юм билээ.

- Ай, чиний нагац эгч үү гэж Флер ууртай хэлээд саваагаа даллахад бохир тавгууд агаарт хөөрөн хураагдав. Дараа нь бүгдийг гал зуух руу орууллаа.

- Аав ч гэсэн титэм хийсэн. Жинхэнэ венец титэм гэж Полумна хэлэв.

Рон мушийн Харри руу харахад Ксенофлиусынд харсан толгойн хөгийн чимэглэлийг санасан болохыг нь мэдэж байлаа.

- Тиймээ тэр Кандида Когтевраны алдагдсан титмийг сэргээн босгохыг хичээж байгаа юм. Ихэнхи хэсгийг нь хийчихсэн байгаа. Далавч нэмснээрээ маш их ялгаатай болсон ...

Үүдний хаалга чанга тасхийхэд бүгдийн толгой тэр зүг рүү эргэлээ. Гал зуухнаас айсан Флер гүйн орж ирэв. Билл үсрэн босоод саваагаа хаалга руу чиглүүлэхэд Харри, Рон, Гермиона нар түүний жишээг дагалдав. Дэгээдэгч чимээгүйхэн ширээн дор гулган орлоо.

- Тэнд хэн байна? гэж Билл хашгирлаа.

- Би, Римус Люпин! гэх дуу салхины исгэрэх чимээн дундаас гарахад Харрийн зүрх палхийлээ. Юу болсон юм бол?

- Би хүн чоно, Нимфадор Тонкстой гэрлэсэн, Хясаан байшингийн нууц хадгалагч нь болох чи хаягаа хэлж онцгой тохиолдолд ирэхийг урьсан!

- Люпин! гээд Билл хаалга руу гүйн очиж нээлээ.

Люпин аян замын дээл өмсөж цонхийн цайсан бөгөөд босго даван орж ирэхдээ буурал үс нь салхинд өрвийжээ. Тэр өрөөнд байгаа хүмүүсийг тойруулан хараад чангаар,

- Би хүүтэй болсон! Доригийн эцгийг хүндэтгэж Тед гэж нэрлэсэн! хэмээн хашгирлаа.

Гермиона хөөрөн хашгирав.

- Юу? Тонкс! Тонкс хүүхэдтэй болоо юу?

- Тиймээ тийм болсон! гэж Люпин орилов.

Ширээнд байгсад баярлан дуу алдаж санаа амарлаа. Гермиона Флер хоёр,

- Баяр хүргэе! гэж хэлсэн бол Рон,

- Чөтгөр гэж, хүүхэд! хэмээн амьдралдаа хэзээ ч тийм зүйл сонсоогүй мэт хэлэв.

- Тиймээ, тийм! Хүү ! гэж Люпин аз жаргалд автан давтав.

Тэр ширээг тойрон яваад Гриммогийн байшингийн хонгилд ямар ч зүйл болоогүй мэт Харриг чанга тэвэрснээ,

- Загалмайлсан эцэг болмоор байна уу? гэж Харриг тавиад асуув.

- Б-би юу? гэж Харри ээрлээ.

- Мэдээж чи өөр хэн байх вэ дээ? Дора ч гэсэн тэгж бодож байгаа.

- Б ... аан ... хөөх ...

Харри мэгдсэн ч баяр хөөртэй байлаа. Билл лонхтой дарс авчирч, Флер Люпиныг тэдэнтэй суухыг урив.

- Би удаж болохгүй гэртээ харих хэрэгтэй байна гэж Люпин гийн хэлээд эргэн тойрноо харахдаа хэдэн насаар залуужсан юм шиг харагдав.

- Баярлалаа! Баярлалаа, Билл.

Билл дарс хундагалан цом дүүргэхэд бүгд хундагатайгаа өргөн босож Люпин хундаганы үг хэлэв.

- Тедди Римус Люпин агуу их шидтэн болохын төлөө!

- Тэр хэнтэй адилхан байна? гэж Флер асуулаа.

- Минийхээр бол Доратай адилхан ч тэр болохоор надтай адил гэж хэлсэн.

Бараг халзан юм билээ. Хар үстэй төрсөн ч цагийн дараа шаргал болсон гэж тангарагласан ч болж байна! Намайг буцаж очихд лав цайвар болсон байна байх. Андромеда Тонксын үс төрсөн цагаасаа өөрчлөгдөж эхэлсэн гэж хэлсэн гээд Люпин хундагтайгаа хоосолж,

- За яахав, ердөө ганц гэж Билл ахин дүүргэхэд хэлэв.

Салхи жижигхэн байшингийн ханыг нижигнүүлэхэд ханан зуухан дахь гал тас нясхийн дүрэлзэв. Билл ахин нэг лонх авчирлаа. Тэд Люпинээс сонссон мэдээндээ болоод нуугдаж байгаагаа ч мартжээ. Шинэ амьдрал ямар гайхалтай хэрэг вэ! Зөвхөн албинд баярын уур амьсгал хамаагүй санагдсан бололтой унтлагын өрөө лүүгээ ганцаар явлаа. Харри үүнийг хэн ч ажиглаагүй гэж бодсон ч Билл Дэгээдэгчийн араас дагуулан харж байв.

- Үгүй ... үгүй! Би үнэхээр явах хэрэгтэй! гээд Люпин ээлжит хундаганаас шийдэмгий татгалзан босч дээлээ өмслөө.

- Баяртай, баяртай! Хэдэн өдрийн дараа зургийг нь авчирч үзүүлнэ ээ. Тэд бүгд чиний тухай сонин сонсохдоо баяртай байгаа ...

Тэр ээлж дараалан бүгдтэй гар барьсанаа гийсэн хэвээр гарч одлоо.

- Загалмайлсан эцэг, Харри! Ямар их хүндэтгэл вэ! Баяр хүргэе! гэж Билл гал зуух руу ширээ цэвэрлэхэд туслахаар явж байхдаа дуу алдав.

Харри ширээн дээр хоосон хундагануудаа тавилаа. Билл хаалга хаасан ч Люпиныг явсны дараа үргэлжлүүлэн баярлаж байгаа бусдынх нь дуу сонсогдсон хэвээр байв.

- Би чамтай нүүр тулан ярилцах гэсэн юм. Байшинд дүүрэн хүн байгаа болохоор амаргүй байлаа гээд Билл тээнэгэлзсэнээ,

- Харри чи Дэгээдэгчтэй ямар нэг зүйл хийхээр төлөвлөж байгаа юмуу даа гэлээ.

Энэ бол асуулт биш баталгаа байсан тул Харри няцааж чадсангүй Биллийн цааш яахыг хүлээв.

- Би Хогвартсыг төгссөнөөс хойш Гринготтсд ажиллаж байсан болохоор албингуудыг сайн мэднэ. Хэрвээ шидтэн албингийн хоорондхөхөрлөл байх боломжтой гэвэл надад найз албингууд бий. Ийм учраас би албингуудыг сайн мэднэ гээд ахиад л тээнэгэлзсэнээ,

- Харри Дэгээдэгч чамд тусалсны төлөө юу амалсан бэ? гэв.

- Би үүнийг хэлж чадахгүй нь, Билл. Уучлаарай.

Гал зуухны хаалга онгойн Флер гараараа дүүрэн хоосон хундагатай ирлээ.

- Түр хүлээгээрэй гэж Билл хэлэв. Тэр буцаж гараад хаалга хаалаа.

- Тэгвэл би хэлье. Хэрвээ чи Дэгэдээгчтэй наймаа ялангуяа эрдэнэстэй холбоотой зүйл хийх гэж байгаа бол болгоомжтой байгаарай. Албингууд өмчлөх эрх болон хөлсний талаар өөр ойлголттой байдаг юм. Хүмүүсийнхтэй адил биш.

Харрийн дотор жижигхэн могой мушгирах мэт эвгүй болов.

- Энэ чинь юу гэж байгаа юм?

- Манай ард түмэн олон янз. Олон зууны турш шидтэн албингуудын харьцаа хэцүү байснаар ирснийг чи ид шидийн түүхээс мэдэж байгаа. Үүнд хоёр талын аль алиных нь буруу бий. Түүнлчлэн Гринготтс банкинд ажилладаг олонхи албин шидтэнгүүдэд итгэж болохгүй тэд өмчлөх эрхэд нь хүндэтгэлгүй хандаж байна гэж үздэг юм.

- Би хүндэтгэж байна гэж Харри хэлсэн ч Билл толгой сэгсэрлээ.

- Чи ойлгосонгүй, Харри. Энэ нь хэрвээ чи албинтай зэрэгцэн ажиллаагүй бол ойлгохын аргагүй зүйл. Албингийн үүднээс бол бүтээсэн эзэн нь түүний жинхэнэ эзэмшигч болохоос биш худалдан авагч нь биш. Тэд албингийн урласан зүйл болгон тэдэнд харъяалагдах ёстой гэж боддог юм.

- Хэрвээ түүнийг худалдаж авсан бол ...

- Энэ ч гэсэн тэдний зүгээс бол хүн мөнгөө төлснөөрөө зээлээр хэрэглэж байгаа хэрэг. Тэд албингийн урласан зүйл шидтэнгээс шидтэнд дамжих санааг дэмждэггүй. Чи Дэгээдэгч титмийг яаж харж байхыг харсан уу? Тэр гарцаагүй эхний эзэмшигч нь үхсэний дараа албингуудад буцах ёстой гэж бодож байгаа. Тэд албингийн хийцийн эд шидтэнд залгамжлагдах нь хулгай гэж үздэг юм.

Харрийн дотор таагүй болов. Билл үнэхээр ийм их зүйл тааварласан гэж үү?

- Би чамаас ганц л зүйл гуйх гэсэн юм. Албинд амлахдаа болгоомжтой байгаарай гээд Билл хаалганы бариулаас барьж,

- Гринготтсыг дээрэмдэхээс илүү албин хэлсэн амнаасаа буцах нь илүү аюултай шүү гэлээ.

- Ойлгомжтой. Баярлалаа. Би үүнийг анхааралдаа авна гэж Харри Биллийг хаалга онгойлгоход хэллээ ...

Тэр араас нь даган гал зуухнаас гарахад толгойд нь хүндхэн бодол эргэлдэж Тедди Люпин Сириусын адил хариуцлагагүй загалмайлсан эцэгтэй болоогүй байгаа даа гэж эргэлзлээ.

БҮЛЭГ 26: ГРИНГОТТС

Бүх зүйл төлөвлөгдөж бэлтгэл ажил дуусчээ. Жижигхэн унтлагын өрөөний ханан зуухны тавиур дээрх шилэн саван дотор (Гермиона Малфойн гэрт байхад цамцан дээр нь үлдсэн) ганц ширхэг ширүүн хар үс хэвтэж байлаа.

- Бас чамд шидэт саваа нь байгаа болохоор илүү итгэлтэй болно гээд Харри хушганы модон саваа руу толгой дохилоо.

Гермиона савааг хазахаас айсан мэт гартаа барив.

- Би үүнийг үзэн ядаж байна. Ямар их үзэн ядаж байна гээч! Яг л түүний нэг хэсэг байгаа юм шиг ...

Харри түүнийг урьд нь саваа болохгүй байна гэхэд зүгээр л тэгж төсөөлж байгаа юм гээд дасгал хийхэд болно гэснийг санав. Гэсэн ч маргааш банк дээрэмдэх гэж байсан болохоор бухимдуулахгүйн тулд үүнийг сануулж зүрхэлсэнгүй.

- Саваа чамд түүний байдлыг тодруулахад туслана! хэмээн Рон тайвшируулав.

- Гэхдээ энэ саваа Невиллийн ээж аав болон өөр хүмүүсийг тамлаж байсан. Тэр

Сириусыг алсан! гэж Гермиона дуу алдав.

Харри энэ тухай бодсонгүй. Түүнд савааг хартал дэргэдээ хана түшүүлэн тавьсан

Гриффиндорын илдээр хуга цавчих хэрцгий хүсэл төрлөө.

- Би саваагаа алдсан болохоор ноён Олливандер шинийг хийж өгнө байх гэж найдаж байна!

Тэр өглөө ноён Олливандер Полумнад шинэ саваа явуулжээ. Тэр одоо арын хашаанд гараад нарны гэрэлд туршиж үзэж байлаа. Саваагаа ангуучдад алдсан Дин түүнийг баргар харна.

Харри Драко Малфойд харъяалагдаж байсан долоогоны саваагаа харлаа. Гайхалтай нь саваа түүнийг Гермионагийнхаас доргүй сонсож байв. Тэр ноён Олливандерын хэлсэн үгийг санаад Гермионагийн асуудал юундаа байгаа болохыг тааварлав. Тэр Беллатрисагийн савааг барихыг хүсэхгүй байв.

Унтлагын өрөөний хаалга нээгдэж Дэгээдэгч орж ирэв. Харри өөрийн мэдэлгүй илдийг татан ойртуулснаа албин үүнийг нь ажигласанд харамслаа. Тэгээд эвгүй байдлаас гарахыг хичээн,

- Бид юмаа сүүлчийн удаа шалгаж байна, Дэгээдэгч. Билл, Флер хоёрт маргааш өглөө эрт явах учир үдэх хэрэггүй гэж хэлсэн гэв.

Тэд үүнийг шаргуу гуйсны учир нь Гермиона явахынхаа урьд Беллатриса болж хувирах гэж байгаа болохоор Билл, Флер хоёр юу хийх гэж байгааг нь тааварлахад хялбархан болох байв. Бас эргэж ирэхгүй гэдгээ хэлжээ. Түүнчлэн Перкинсийн хуучин майханг ангуучдад баригддаг шөнөө алдсан болохоор Билл тэдэнд өөрийнхийгөө өгчээ. Одоо майхан баглагдан Гермионагийн шүрэн цүнхэнд орсон байлаа.

Харри энэ ая тухтай байшинд хэдэн долоо хоногийн турш байсан болохоор салахад хэцүү байсан бөгөөд Билл, Флер, Полумна, Дин нарыг санахаа мэдэж байв. Тэр харанхуй жижигхэн өрөөнд түгжин сууж хэн нэгэн сонсож байгаа эсэхийг үргэлж шалгасаар эцэж ядарчээ. Хамгийн гол нь Дэгээдэгчээс салж амрах байлаа. Гэсэн ч албинд хэрхэн илдийг өгөлгүй салах нь шийдэгдээгүй асуудал хэвээр үлдэв. Дэгээдэгч тэднийг таван хором ч тайван орхихгүй тул үүнийг шийдэх боломжгүй байсан бөгөөд эргэж харахын зуургүй цоожны нүхэнд түүний урт хуруу шургалж байдаг байв.

- Миний ээж түүнийг сургаад өгөх байсан даа гэж Рон үглэжээ.

Түүнчлэн Гермиона Харрийн хууран мэхлэх төлөвлөгөөг дургүйхэн дэмжиж, Рон Дэгээдэгч тэднийг тайван орхих ховорхон олдох мөчид өөр юу ч бодож олж чадалгүй,

- Илдийг аваад түргэн сална шүү гэнэ.

Харри тэр шөнө муу унтлаа. Удтал нойргүй хэвтээд ид шидийн яам руу орохын шөнө ийм зүйл мэдэрч байснаа санав. Тэгэхэд шийдвэр дүүрэн байсан бол одоо эргэлзээ түгшүүрт автсан байлаа. Ямар нэг зүйл санаснаар болохгүй мэт сэтгэгдэл төрөх аж. Тэр өөртөө Дэгээдэгч юу тулгарахыг мэдэж байгаа учир төлөвлөгөө маш сайн болсон гэж итгүүлж байсан ч дотор нь амаргүй хэвээр байв. Тэр хоёр гурван удаа Рон хэрхэн оронд оо хөрвөөхийг сонссон ч унтлагын өрөөндөө Динтэй байсан болохоор ярилцаж чадсангүй.

Эцэст нь зургаан цаг болоход Рон, Харри хоёр унтлагын хөнжлөөс сугараад харанхуйд хувцаслаж Гермиона, Дэгээдэгч хоёртой уулзахаар тохиролцсон цэцэрлэг рүү чимээгүйхэн гарав. Үүрээр жихүүн байж таван сарын сэвшээ салхи салхилан, харанхуй тэнгэрт цайвар од гялалзаж, тэнгис хад мөргөн давалгаалах чимээ сонсогдоно.

Доббийн булшинд хүрэх замд нялх ногоо соёолжээ. Жилийн дараа толгод цэцгээр хучигдах болно. Үйлчлэгчийн нэртэй цагаан чулуу нар салхинд гандан өгөршөөд энд эртнээс байсан мэт болжээ. Харри Доббид хамаагүй сайхан газар олж чадахыг мэдэж байсан ч болохоор энд орхиход гунигтай санагдлаа. Тэр булшны дэргэд зогсоод үйлчлэгч хаанаас тэднийг аврахаа мэдсэн болох талаар толгойгоо гашилгав. Тэгтэл байшингийн хаалга онгойх чимээ гарахад эргэж харлаа.

Зүлгэн дээгүүр тэдэн рүү Беллатриса Лестрейнж Дэгээдэгчийн хамт алхан ирж байв. Тэр явах зуураа жижигхэн шүрэн цүнхээ Гриммогийн байшингаас авсан хуучин жанчныхаа дотор талын халаасанд хийлээ. Харри түүний жинхэнэ Гермиона болохыг мэдэж байсан ч дотор нь зарсхийхгүй байж чадсангүй. Тэрбээр түүнээс өндөр бөгөөд урт хар үс нь нуруугаа даган унжиж хүнд зовхитой нүдээрээ ихэмсгээр харснаа Беллатриса Лестрейнжийн хоолойгоор намуухан ярилаа.

- Тэр гурдын үндсээс ч хамаагүй дор амттай юм! Рон нааш ир би чамайг хувиргая ...

- За яахав гэхдээ намайг хэтэрхий урт сахалд дургүй гэдгийг санаарай ...

- Бурхан минь, одоо чинь гадаад үзэмжийнхээ талаар бодож цаг билүү!

- Энд гадаад үзэмж ямар хамаатай гэж? Гэхдээ чиний өнгөрсөн удаад хийж өгсөн богинохон хамар надад таалагдсан.

Гермиона санаа алдсанаа ажилдаа орж ямар нэг зүйл бувтнан Роны гадаад төрхийг өөрчиллөө. Харри, Дэгээдэгч хоёр төлөвлөгөө ёсоор үл үзэгдэх жанчин дор нуугдах ёстой байв.

- Болчихлоо. Ямар харагдаж байна, Харри? гэж Гермиона хэлэв.

Роны зүсээ хувиргасан байдал үл мэдэгдэм ялгагдаж байсан нь Харри түүнийг сайн мэддэгийнх байлаа. Роны үс уртсаж, өтгөн хүрэн үс сахалтай болж, сэвх нь алга болоод, богинохон том хамар, өтгөн хөмсөгтэй болжээ.

- Тийм ч сайхан биш. Явцгаах уу? гэж Харри хэлэв.

Гурван найз харанхуй чимээгүй ододын дор сүндэрлэх хясаан байшин руу харснаа эргэж Итгэлцлийн шидээс гаран шилжиж болох газар луу явлаа.

Тэднийг хаалгаар гармагц Дэгээдэгч,

- Намайг дээш нь гаргах уу, Харри Поттер? гэлээ.

Харри бөхийхөд албин түүний мөрөн дээр гараад хүзүүнээс нь барив. Тэр хүнд биш байсан ч хүзүүнээс нь чанга зуурахад эвгүй санагдлаа. Гермиона цүнхнээсээ үл үзэгдэх цув гаргаад тэднийг нөмөргөлөө.

- Зүйтэй! гээд тэр бөхийн Харрийн хөл далдлагдсан эсэхийг шалгаж,

- Юу ч харагдахгүй байна, явцгаая! гэлээ.

Харри байрандаа эргэхэд Дэгээдэгч мөрөн дээр нь хамт эргэлээ. Тэр бүх хүчээ гарган бодолдоо Тахир гудамж руу орох гарц болох «Цоорхой тогоо» руу төвлөрлөө. Албин эргэн тойрон харанхуйлах үеэр хоолойноос нь улам чанга зуурсан ч дараагийн агшинд газардахаа мэдрээд нүдээ нээвэл Чаринг-Кросс-Роудын зам дээр өглөө эрт юу ч сэжиглээгүй маглуудын дунд зогсож байв.

«Цоорхой тогоо» бараг хоосон байлаа. Баарны эзэн шүдгүй Том лангууны ард шилэн аяга зүлгэн хоёр шидтэнтэй шивнэлдэж байснаа Гермионагийн сүүдрээс гарч ирэхийг хараад холдож,

- Хатагтай Лестрейнж гэж бувтнаад бөхийн ёслов.

- Өглөөний мэнд гэж Гермиона хэллээ. Том түүн рүү гайхсан харцаар ажиглав.

Харри албинг мөрөн дээр суулгасан хэвээр Гермионаг арын хашаанд гарахад гүйцээд чихэнд нь,

- Хэтэрхий эелдэг байна! Чи эргэн тойрны хүмүүсээ новшнууд байгаа юм шиг бодож ярих ёстой гэлээ.

- За за, ойлголоо!

Гермиона жанчин дороосоо Беллатрисагийн шидэт савааг гаргаж тоосгон хана тогшив. Тэгтэл тоосгонууд хөдлөн хананд нүх гарснаа томорч улам өргөссөөр Тахир гудамжинд орох нуман хаалга боллоо.

Энд дэлгүүр дөнгөж нээгдэж байгаа өглөө эртийн цаг тул нам гүмхэн байж худалдан авагчид ирээгүй байлаа. Тахир гудамж Харрийн Хогвартсад орох анхны жилээ харсан үймээн шуугиантай үеэс хойш их өөрчлөгджээ. Ихэнхи мухлаг дэлгүүрийн цонх хаалттай байж өнгөрсөн жилтэй харьцуулахад хар урлагийн дэлгүүрүүд ихээр нэмэгджээ. Харри лангуунд наалттай байгаа өөрийнхөө «НОМЕР НЭГ СЭЖИГТЭН» гэж бичсэн зурагт хуудсыг харлаа.

Дэлгүүрийн гадаа хаалган дээр ноорхой хүмүүс сууж байв. Тэд өрөвдөлтэй гонгиносон хоолойгоор хажуугаараа өнгөрөх хүмүүсээс мөнгө гуйх хэдий ч үнэн хэрэгтээ жинхэнэ шидтэн ажээ. Нэг нь нүдээ цус болсон алчууураар ороосон харагдана.

Гермионаг ажиглангуут гуйлгачид салхинд хөөгдсөн мэт алга болов. Тэд зүг бүр тийш таран гүйлдэхдээ юүдэнгээ буулган царайгаа нуулаа. Гермиона тэдэн рүү сонирхон хартал замыг нь цустай боолттой хүн хаав.

- Миний хүүхдүүд! Миний хүүхдүүд хаа байна? Чи тэднийг яасан бэ? Чи хаана байгааг нь мэдэж байгаа! гэж хахир дуугаар хуруугаараа чичлэн орилов.

- Би юу? Би ... үнэндээ ... хэмээн Гермиона ээрлээ.

Эрэгтэй түүн рүү ухасхийн хоолойноос нь зуурлаа. Чанга тасхийх чимээ гараад улаан оч гялсхийхэд үл таних хүн газар ухаангүй болон уналаа. Рон сунгасан гартаа шидэт саваа бариад сахалтай царай нь цочирдсон өнгө шинжтэй зогсож байв. Бүхий л цонхноос сониучирсан царай үзэгдэж дэргэдүүр өнгөрч байсан хүмүүс жанчаа хумиад эсрэг талын зүг рүү гүйлдлээ.

Энэ нь тэднийг Тахир гудамжинд улам анхаарал татам болгосон тул Харри төлөвлөгөөгөө өөрчилсөн нь дээр гэж бодсон ч хэлж амжихаас урьд ард нь хашгиралт сонсогдов.

- Та юу хатагтай Лейстрейнж!

Харри огцом эргэж харахад Дэгээдэгч хүзүүнээс нь чанга зуурлаа. Тэдэн рүү өндөр туранхай бие өтгөн буурал үс, шовх хамартай шидтэн ойртож байв.

- Энэ бол Трэверс гэж албин Харрийн чихэнд шивнэв.

Харри Трэверс гэж хэн болохыг шуудхан санаж чадсангүй. Гермиона тэр агшинд цэхлэн зогсоод,

- Таньд юу хэрэгтэй вэ? гэлээ. Трэверс гомдсон байртай зогсов.

- Тэр бас Үхэл залгигч! гэж Дэгээдэгч хэлэхэд Харри Гермиона руу очоод чихэнд нь шивнэн мэдээллийг дамжууллаа.

- Зүгээр л мэндлэхийг хүссэн юм гэхдээ миний мэндчилгээ таньд таагүй байгаа бол ... гэж Трэверс хүйтнээр хэлэв.

Харри одоо л түүний хоолойг танилаа. Трэверс Ксенофилиусын гэрт ирсэн хоёр Үхэл залгигчын нэг байсан билээ.

- Үгүй дээ яалаа гэж, Трэеверс! хэмээн Гермиона түргэхэн алдаагаа засаад,

- Юу байна даа? гэлээ.

- Беллатриса би таны гадуур явж байгааг хараад гайхаж байна.

- Үнэхээр гэж үү? Яагаад? гэж Гермиона асуув.

- Юу гэхээр гээд Трэверс ханиалгаснаа,

- Би Малфойн гэрт юу болсон тухай сонссон ... хм-м ... зугталтын дараа гэв.

Харри, Гермиона хоёр гайхширлаа. Хэрвээ энэ үнэн байвал Беллатриса гэрээсээ гарч чадахгүй болсон байх нь ...

- Хар лорд түүнд үнэнч зүтгэдэг хүмүүсийг үргэлж уучилдаг гэж Гермиона Беллатрисагийн тоомсоргүй байдлыг дууриан хэлээд,

- Магадгүй Трэверс та түүний талаар сайнгүй бодол өвөрлөж байдаг бололтой гэв.

Үхэл залгигч сэжиглэгдсэн явдалдаа улам гомдонгуй болов. Тэр Роны хөшөөсөн ухаангүй хэвтэж байгаа хүн рүү харлаа.

- Энэ таныг доромжлоо юу?

- Үүнийг ахиж хэлэх нь чухал биш гэж Гермиона хүйтнээр хэллээ.

- Саваагүй болсон хүмүүс их төвөг удаж байна. Тэдний нэг нь өнгөрсөн долоо хоногт намайг ид шидийн яаманд дамжуулж хэлэхийг гуйсан! «Би шидтэн, Би шидтэн эрхэмээ үүнийгээ таньд баталж байна!» гэж тэр даажигнан хэлээд,

- Би яг л түүнд саваагаа өгөх юм шиг! Ингэхэд та хэний савааг ашиглаж байгаа вэ, Беллатриса? Би таных ... гэв.

- Миний саваа байгаа гэж Гермиона тайван хариулаад Беллатрисагийн савааг үзүүлж,

- Би таныг хаанаас энэ цуу яриаг сонссоныг мэдэхгүй байгаа ч ташаа мэдээлэл гэж хэлэх байна гэв.

Трэверс сэтгэлээр унан Рон руу эргэлээ.

- Таны найз хэн бэ? Би түүнийг мэдэхгүй юм байна.

- Энэ бол Драгомир Деспард гэж Гермиона хэлэв. Тэд эртнээс Роныг гадаадын шидтэн болгох нь аюулгүй хэрэг гэж шийдсэн байлаа.

- Тэр англиар бараг ярьдаггүй ч Хар лордын талыг дэмждэг. Трансильванаас манай шинэ дэглэмтэй танилцахаар ирсэн юм.

- Та юу хэлнэ вэ? Өдрийн мэнд, Драгомир!

- Дрийнмнд гэж Рон бувтнаад гараа сунгав.

Трэверс бохир зүйлд хүрэхээс айсан мэт Роны гарыг хоёр хуруугаараа барилаа.

- Таныг юу ийш нь найзтай чинь ... хм-м ... ийм өглөө эрт авчраа вэ?

- Гринготтс орох хэрэг байна гэж Гермиона хэлэв.

- Өө, надад ч гэсэн! гэж Трэверс дуу алдаад,

- Алт, бохир алт! Түүнгүй бол амьдрах аргагүй ч манай урт хуруутай найз нар үүнийг эрхэлдэгт харамсал төрдгөө хэлэх байна гэв.

Харри Дэгээдэгчийн гар хоолойд нь чангарахыг мэдэрлээ.

- За явцгаах уу? гээд Трэверс Гермионаг занган урдаа гаргав.

Тэд түүнтэй хамт явахаас өөр сонголтгүй болсон тул жижигхэн мухлагууд дээгүүр сүндэрлэх Гринготтс банкны цасан цагаан барилга руу тахир гудамжаар явлаа. Рон дэргэд нь явахад Харри, Дэгээдэгч хоёр араас нь дагалдав.

Тэд энэ хийх ажилгүй Үхэл залгигчаас болж ихээхэн төвөгтэй байдалд оржээ. Түүнийг Белтарисагийн дэргэд явж байхад Харри Гермиона, Рон хоёртой үг солих ямар ч боломж байсангүй. Удалгүй гантиг шатаар өгсөн хүрэл хаалга руу очих үед Дэгээдэгчийн анхааруулсан ёсоор урт хуруутай албин солигдон хаалганы хоёр талд гартаа урт алтан заагуур барьсан шидтэн зогсож байлаа.

- Аа, худал зүйлийг илрүүлэгч! Энэ бүдүүлэг хэдий ч үр дүнтэй ... ! гэж

Трэверс дуу алдав.

Тэр гишгүүрээр өгсөж хаалганы баруун зүүн талд байсан шидтэн рүү толгой дохиход алтан илрүүлэгчээр биеийг нь шалгав.

Харри илрүүлэгч зүсээ хувиргах болон нуусан зүйлийг илрүүлдэгийг мэдэж байв. Түүнд ердөө секунтын хугацаа байсан тул Драко Малфойн шидэт савааг хамгаалагчид руу чиглүүлээд,

- Конфундо! гэлээ.

Трэверс танхим руу харж байсан тул тэдний хэрхэн давхийхийг ажигласангүй. Гермиона гишгүүрээр урт хар үсээ намируулан өгсөв.

- Ганцхан хором, хатагтай гээд хамгаалагч илрүүлэгчээ өргөлөө.

- Гэхдээ чи саяхан намайг шалгаа биз дээ! гэж Гермиона Беллатрисагийн ихэмсэг хоолойгоор захирангуй хэлэв.

Трэверс эргээд хөмсгөө асуунгүй өргөлөө. Хамгаалагч тэвдсэн байртай нарийхан алтан илрүүлэгч рүү хартал хажуудах нь гайхширсан хоолойгоор,

- Тийм шүү, Мариус чи дөнгөж сая тэднийг шалгасан гэлээ.

Гермиона хаалга руу явахад Рон түүнээс хоцорсонгүй бөгөөд Харри Дэгээдэгчийн хамт араас нь өгсөв. Түүнийг босгон дээр очоод эргэж харахад шидтэнгүүд гайхширан толгойгоо маажиж байв.

Дараагийн мөнгөн хаалган дээр хоёр албин зогсоод хулгай хийвэл цээрлүүлэх тухай шүлэг сийлсэн харагдана. Харри гэнэтхэн арван нэгэн насны гайхамшигтай төрсөн өдрөөр нь Хагрид «Зөвхөн галзуурсан хүн л банкыг дээрэмдэхийг оролдоно гэдгийг хэлэх байна» гэснийг саналаа. Тэгэхэд Гринготтс түүнд шидэт алт агуулсан гайхамшигтай газар санагдаж байсан бөгөөд толгойд нь хэзээ ч ийшээ тонуулчнаар ирнэ гэж орж байсангүй ... Энэ агшинд тэд уужим гантиг танхим руу орлоо.

Урт лангууны ард албингууд өндөр сандал дээр суугаад өглөө эртийн зочидод үйлчилж байв. Гермиона, Рон, Трэверс нар томруулдаг шилээр алтан зоос шинжиж байгаа хөгшин албин руу очив. Гермиона Ронд эргэн тойрныг тайлбарлаж буй дүр эсгэн Трэверсийг урдаа гаргалаа.

Албин зоосоо хауу тийш тавин хэнд ч хандсан юмгүй «лепрекон» гэж хэлснээ

Трэверсийн сунгасан жижигхэн алтан түлхүүрийг авч хараад эзэнд нь эргүүлж өглөө. Гермиона лангуу руу алхав.

- Хатагтай Лейстренж! Юугаар туслах вэ? гэж албин гайхлаа.

- Би шүүгээндээ орохыг хүсч байна гэж Гермиона хэлэв.

Хөгшин албин үл мэдэг хирдхийхэд Харри эргэн тойрноо харав. Трэверс тэдний яриаг сонсон лангуунд саатаж бусад албингууд Гермиона руу нүд бүлтийн ширтэв.

- Таньд өөрийгөө гэж батлах зүйл байна уу? гэж албин асуув.

- Батлах гэнээ? Надад хэзээ ч өөрийгөө батлах хэрэг гарч байгаагүй! гэж

Гермиона уурсав.

- Тэд мэдэж байна! Тэдэнд нэр барьж болзошгүй гэж анхааруулсан байна!

хэмээн Дэгээдэгч Харрийн чихэнд шивнэв.

- Шидэт саваагаа үзүүлэхэд хангалттай гэж албин хэлээд чичирсэн гараа сунгав.

Харрид гэнэтхэн Гринготтсын албингууд Беллатрисагийн саваа алдагдсаныг мэдэж байна гэсэн сэтгэгдэл төрлөө.

- Түргэл түргэл! Империус шид хэрэглэ! гэж Дэгээдэгч чихэнд нь шивнэв. Харри жанчин дороосоо саваагаа гаргаад хөгшин албин руу чиглүүлэн амьдралдаа

анх удаа,

- Империо! гэлээ.

Саваанаас гарсан шид судастай нь холбогдон тархинд нь халуун урсгал цутгахад хөөрөх сэтгэл төрөв. Албин Беллатрисагийн савааг авч анхааралтай харснаа,

- Аан та шинэ саваатай болоо юу, хатагтай Лестрейнж! гэлээ.

- Юу гэнээ? хэмээн Гермиона гайхсанаа,

- Үгүй дээ энэ минийх гэлээ.

- Шинэ саваа гэнээ? хэмээн Трэверс ойртож ирэхэд албингууд харсаар байлаа.

- Юу гэсэн үг вэ? Та ямар мастрераар захиалан хийлгэсэн юм? Харри тэр даруй саваагаа Трэверс рүү чиглүүлээд,

- Империо! гэлээ.

- Аан тийм ба харж байна гээд Трэверс Беллатрисагийн савааг харан,

- Маш сайхан саваа байна. Сайн ажилладаг биз тийм үү? Би үргэлж шинэ савааг жаахан дасгал хийх хэрэгтэй гэж боддог байсан харин та юу гэж бодож байна? гэлээ.

Гермиона энэ бүх хачирхалтай явдалд гайхсан ч аз болж үг дуугарсангүй. Хөгшин албин алгаа ташихад өөр жижигхэн албин ирэв.

- Надад Хангинуур хэрэгтэй байна.

Залуу албин ухасхийн алга болсноо хормын дараа эргэж ирэхэдээ дотроо дүүрэн төмөр харжигнасан жижигхэн арьсан хүүдий авчрав. Тэр хүүдийг хөгшин албинд өглөө.

- Сайн байна! Миний араас яваарай, хатагтай Лейстрейнж! Би таныг шүүгээнд чинь хүргээд өгье гээд хөгшин албин сандалаас үсрэн буугаад лангууны ард үзэгдэхгүй болов.

Тэр лангууны үзүүрээс гарч ирээд тэдний зүг баяртайгаар гүйхэд хүүдий дахь зүйл харжигнав. Трэверс хөдөлгөөнгүй зогсоод амаа ангайжээ. Рон түүн рүү гайхан харна.

- Хүлээгээрэй ... Богрод!

Өөр нэг албин лангууны цаанаас яаран гарч ирлээ.

- Бидэнд заавар байгаа. Намайг уучлаарай хатагтай гэхдээ Лестрейнжийн шүүгээний талаар бидэнд онцгой заавар өгсөн.

Тэр ямар нэг зүйл түгшсэн шинжтэй Богродын чихэнд шивнэсэн ч Империус шидээр удирдуулсан албин сэгсрэн холдлоо.

- Би онцгой зааврыг мэдэж байна. Хатагтай Лестрейнж өөрийнхөө шүүгээг эргэхийг хүсч байна. Эртний гэр бүл ... эртний үйлчлүүлэгч ... ийшээ явна уу

...

Тэрбээр харжигнуулсан хэвээр танхимаас гарах олон хаалганы нэг рүү явлаа. Харри байрандаа гөлийн зогссон Трэверс рүү харснаа шидэт саваагаа даллан хамт авч явахад Үхэл залгигч тэднийг хүлцэнгүй дагалдан бамбарын гэрэлтэй хонгилд гарлаа.

- Ажил муугаар эргэлээ тэд сэжиглэж байна! гээд Харри хаалга хаагдмагц үл үзэгдэх цуваа тайллаа.

Дэгээдэгч түүний нуруун дээрээс үсрэн буув. Трэверс, Богрод хоёр урд нь Харри

Поттер гэнэтхэн гарч ирсэн явдалд огтхон ч гайхсангүй.

- Тэд Империус шидийн нөлөөн дор байгаа. Гэхдээ би үүнийг сайн хийсэн эсэхээ мэдэхгүй байна гэж Харри Рон, Гермиона хоёрын мэлрэн зогсохыг хараад тайлбарлав.

Тэгтэл ой ухаанд нь Беллатрис Лестрейнжэд анх Уучлашгүй шид хэрэглэхийг оролдох үеэр «Чи түүний үйлчлэхийг жинхэнээсээ хүсэх ёстой, Поттер!» гэж хашгирсаныг саналаа.

- Одоо бид юу хийх вэ? Зугтах уу? гэж Рон асуув.

- Боломжтой бол тэгэх болно гээд Гермиона гол танхимаас гарч ирсэн хаалга руу харлаа.

- Нэгэнт ийм хол явсан хойно цааш явах хэрэгтэй гэж Харри шийдлээ.

- Сайн байна! Тэгвэл бидэнд тэргэнцэрийг залахад Богрод хэрэгтэй. Надад эрх нь байхгүй. Гэхдээ шидтэн тэнд багтахгүй гэж Дэгээдэгч хэлэв.

Харри Трэверс рүү шидэт саваагаа чиглүүлээд,

- Империо! гэв.

Шидтэн огцом эргээд харанхуй хонгилоор гүйн одлоо.

- Чи түүнийг хааш нь явуулчихав?

- Нуугдахаар гээд Харри шидэт саваагаа Богродын зүг рүү зангалаа.

Хөгшин албин исгэрэхэд харанхуйгаас жижигхэн тэрэг чахран өнхөрч ирэв. Бүгд түүнд орж суухад Богрод тэдний урд орон бусад нь ард суув. Харрид гол танхимаас хашгиралт сонсогдох шиг санагджээ.

Тэргэнцэр урагш хөдлөснөө хурдаа авч эхлэв. Тэд ханын ангархайд наалдан зогсох Трэверсийн хажуугаар өнгөрч төөрдөг байшин шиг тахиралдан мурийсан замаар доош уруудлаа. Тэргэнцэрийн чахрах чимээнд юу ч сонсогдохгүй байв. Харийн үс салхинд хийсэн дэргэдүүр нь хагд өнгөрч тэргэнцэр улам газрын гүн рүү явахад байнга эргэж харж байв. Тэд ардаа томоохон ул мөр үлдээсэн болохоор Гермионагийн Беллатриса болж зүсээ хувиргах болон савааг нь авч явсан нь тэнэг санагдлаа. Үхэл залгигчдад хэн түүний савааг авсан нь илт билээ ...

Тэднийг Гринготтсын гүн рүү улам хурдлан орох үед тэргэнцэр булан эргэтэл тахирласан замын төгсгөлд устай цөөрөм байлаа.

Дэгээдэгч «Үгүй!» гэж хашгирсан ч тоормослож амжсангүй бөгөөд тэргэнцэр хурдтайгаар ус руу шуугин оров. Харрийн ам нүдэнд ус дүүрч амьсгалах боломжгүй болов. Тэргэнцэр хөмөрч бүгд зам дээр шидэгджээ. Харри түүний хэрхэн хонгилын

хана мөргөн хэмхрэх чимээ болон Гермиона хашгирахыг сонсоод агаарт жингүйдэн чулуун шалан дээр хөнгөхөн газардав.

- З-Зөөлрүүлэх шид гэж Гермиона хахаж цацан тайлбарлав.

Рон түүнд өндийхөд туслахад Харри түүний Беллатриса биш болсныг айдаст автан харлаа. Тэр нэвт нороод ердийн төрхөндөө орж өмссөн жанч нь томдсон байв. Рон ч гэсэн шаргал үстэй болон сахалгүй болжээ. Тэд бие бие лүүгээ хараад юу болсныг ойлгов.

- Хулгайчын занга! гэж Дэгээдэгч хяхтнаад хөл дээрээ өндийн ус руу харлаа.

Харри түүний жирийн ус биш болохыг тааварлав.

- Энэ шидийн бүх хувиргалтыг арилгадаг юм байна. Тэд биднийг ийшээ нэвтэрч болзошгүй гэж арга хэмжээ авсан байна!

Тэгтэл Гермиона цүнхээ ухаж хүрмээ гарган өмсөв. Богрод усанд ороод Империус шид тайлагдсан бололтой толгойгоо итгэлгүйхэн сэгсэрлээ.

- Бидэнд тэр хэрэгтэй. Гринготтсын албингүй банкны шүүгээнд орж чадахгүй.

Бас хангинуур хэрэгтэй! гэж Дэгээдэгч хэлэв.

- Империо! гэж Харри давтлаа.

Түүний хоолой чулуун хананд бөглүү цуурайтахад ахиад л шидэт саваанаас тархинд нь хяналт цутгахыг мэдэрлээ. Богрод шившлэгэнд мансууран царайны өнгө нь өөрчлөгдөж эелдэг хайхрамжгүй болов. Рон арьсан хүүдийд төмөр эдлэлүүдийг яаран хийлээ.

- Харри хэн нэгэн ирж байна! гээд Гермиона Беллатрисагийн сабааг уснаас авч сунгаад,

- Протего! гэж хашгирлаа.

Бамбай шид шившлэгтэй усыг яаран хонгил үүсгэв.

- Сайн бодож! гэж Харри бахдаад,

- Дэгээдэгч цаашаа явцгаая! гэв.

Бүгд албингийн араас гүйхэд Богрод тэдний хамт хөгшин нохой шиг шогшуулав.

- Бид эндээс яаж гарах болж байна? гэж Рон асуув.

- Энэ тухай дараа санаа зовцгооё гээд Харри чимээ анирдахад ойрхон хангинах чимээ гарах шиг болов.

- Цаашаа хол явах уу, Дэгээдэгч?

- Холгүй, Харри Поттер холгүй.

Тэд булан тойроод харсан зүйл нь гэнэтийн байлаа.

Газрын гүн дэх дөрөв юмуу таван шүүгээ хүрэх замд аварга том луу гинжилжээ. Тэр удаан хугацааны турш газар дор байсаар хайрс нь цайрч гуужин нүд нь сүүн ягаан

өнгөтэй болжээ. Лууны арын хөлийг чулуун шаланд бат бэх зоосон гадаснаас гинжээр бэхэлсэн байлаа. Биедээ наасан аварга том далавчаа дэлгэхэд ойролцоох орчныг дүүргэв. Луу толгойгоо эргүүлэн хана чичиртэл хүрхэрснээ галаар тургилаа. Найзууд булан руу зугтав.

- Тэр бараг сохорсон ч үүндээ улам хэрцгий болгосон. Гэсэн ч бидэнд түүнийг хянаж чадах зүйл бий. Тэр хангинуур ойртохыг мэднэ. Алив тэднийг нааш нь өг гэж Дэгээдэгч хэлэв.

Рон албинд хүүдий өгөхөд Дэгээдэгч жижигхэн төмөр эдлэл гаргаад сэгсэрч жижигхэн алхаар дөш нүдэх мэт хангинасан чимээ гарав. Дэгээдэгч бүгдэд тийм зүйл өглөө. Богрод өөрийнхийгөө аваад хүлцэнгүй сонсов.

- Та нар юу хийх хэрэгтэйгээ мэдэж байгаа. Тэр чимээ шуугиан сонсоод өвддөг юм. Түүнийг холдмогц Богрод алгаа шүүгээний хаалганд шургуулах болно.

Тэд ийш тийшээ болгоомжтой хараад хангинуурыг сэгсчин урагш хөдлөв. Чимээ хадан хананд цуурайтан өсөхөд Харрийн толгой бүхэлдээ хөрвөх шиг боллоо. Луу ахин хүржигнэснээ үл мэдэг чичирэн ухрав. Харри түүний хоншоор дээрх ташуу цавчсан сорвийг хараад луу хангинуурыг сонсоод илднээс айж байгааг ойлголоо.

- Түүний алгыг хаалганд дар! гэж Дэгээдэгч хашгирав.

Харри саваагаа Богрод руу чиглүүллээ. Хөгшин албин дуулгавартай гараа модон хавтан дээр дарахад шүүгээний үүд хайлж тэдний өмнө шалнаасаа адар хүртэл дүүрэн эд зүйлс бүхий агуй шиг уужим нүх нээгдэв. Тэнд алтан зоос, цом, мөнгөн дуулга, амьтны үнэт арьс үс болон сээр нуруу, далавч, үнэт чулуун дашмагтай ханд, гавлын толгойд угласан титэм зэрэг зүйлс байлаа.

- Түргэн хайгаарай! гэж Харри хэлэхэд бүгд агуй руу ухасхийн орлоо.

Тэр Рон, Гермиона хоёрт Пенелопа Пуффендуйн аягыг зураглан хэлсэн ч шүүгээнд крестраж өөр хэлбэртэй байвал яахыг хэн ч мэдсэнгүй. Харри эргэн тойрноо зэрвэс хартал ард нь хаалга тасхийн хаагдаж шүүгээний дотор харанхуй боллоо. Рон орилов.

- Ямар ч аймшигтай зүйл алга гэж Дэгээдэгч тайвшируулаад,

- Богрод дараа нь биднийг гаргана! Шидэт саваагаараа гэрэлтүүлээрэй.

Яараарай цаг бага үлдсэн шүү! гэв.

- Люмос!

Харри саваагаараа эргэн тойрныг гэрэлтүүлэхэд дээд талын тавиур дээр Гриффиндорын хуурамч илд гинжтэй хэвтэж байлаа. Рон, Рермиона хоёр бас саваагаараа гэрэлтүүлэн үнэт эдлэлийн цуглуулгыг харав.

- Харри энэ юм болов уу? А-а-а!

Гермиона өвдсөндөө хашгирахад Харри тийш нь гэрэлтүүлээд үнэт чулуун цом гараас нь мултарч унахыг харлаа. Түүнийг шалан дээр унан хуваагдахад цомны

бороо орон агшин зуур агуйд адилхан зүйлс дүүрч жинхэнийг нь ялгах боломжгүй болов.

- Би түлэгдчихлээ! гэж Гермиона ёолоод цэврүүтсэн хуруугаа харлаа.

- Гар хүрэхээр түлж олшруулдаг шившлэг! Хүрсэн зүйл болгон чинь түлж олон тоогоор хуулбар нь үүсэх болно! Хэрвээ тэд хэт ихэсвэл дарж алах аюултай гэж Дэгээдэгч хэлэв.

- Тэгвэл юунд ч хүрэх хэрэггүй! гэж Харри цөхрөн хашгирсан ч Рон санаандгүй унасан цомонд хүрэхэд дэлбэрэн хорь дахин олширч халуун хайлмаг гутлыг нь нэвт түлэхэд үсрэн холдлоо.

- Зогс, бүү хөдөл! гээд Гермиона Роны гараас барилаа.

- Зүгээр л харцгаая! Хоёр талдаа бариултай доргоны дүрс сийлсэн жижигхэн алтан аяга болохыг нь мартаж болохгүй шүү. Хэрвээ олохгүй бол Когтевраны сүлдтэй ямар нэг хайж олоорой ... бүргэдийн дүрс ч юмуу ...

Тэд болгоомжтой эргэн тойрныхоо өнцөг булан бүрийг гэрэлтүүлсэн ч юунд ч шүргэхгүй байх нь боломжгүй зүйл байлаа. Харрийн хүрэлтээр хуурамч галлеоны хүрхрээ үүсэн шалан дээр буй цомны овоотой нэгдэж улайссан алт пийшэнд байгаа мэт төөнөн хаашаа ч явах аргагүй болов. Сабааны гэрэлд хананаас адар хүртэл овоолсон албингийн хийцийн бамбай, дуулга гялсхийн өнгөрнө. Харри саваагаа улам өндөр өргөтөл гэнэтхэн харанхуй зүйл дээр тусахад зүрх нь зогсох шиг болж гар нь чичирлээ.

- Тэр байна ... дээр!

Рон, Гермиона хоёр саваагаа бас тэр зүг өргөхөд гурван сабааны гэрэлд Хэпзиб Смитын Том Редллд хулгайд алдсан Пенелопа Пуффендуйн жижигхэн алтан аяга гялтагнан үзэгдэв.

- Түүнийг бид яаж юунд ч хүрэхгүй авах болж байна? гэж Рон сонирхов.

- Акцио, аяга! гэж Гермиона Дэгээдэгчийн анхааруулсныг мартан хашгирлаа.

- Ашиггүй, үйлчлэхгүй! гэж албин зандрав.

- Тэгвэл юу хийх болж байна? гэж Харри ууртай асуугаад,

- Хэрвээ илдийг авахыг хүсч байвал Дэгээдэгч бидэнд тусал ... Хүлээгээрэй!

Илдээр хүрч болох уу? Гермиона надад түүнийг өгдөө гэв.

Гермиона жанчныхаа халаасыг ухан сувдан цүнх гаргаж ирээд дотроос нь гялалзсан илд гаргаж ирлээ. Харри бадмараг шигтгээтэй бариулаас нь бариад ойролцоох мөнгөн домбонд хүрэв. Домбо олширсонгүй.

- Илдний үзүүрээр авч чадах юм шиг байна ... Гэхдээ би яаж тийшээ хүрэх вэ? Тавиур дээрх аяганд тэдний хэн нь ч байтугай хамгийн өндөр Рон хүртэл хүрч

чадахгүй ажээ. Илбэлдүүлсэн эрдэнэсийн хайлмаг халуу шатаахад Харри нүүр нуруу

хөлрөв. Тэр нүүрээ үрчийлгэн аяганд яаж хүрэх вэ гэж бодлогоширтол хаалганы цаана луу хүрхэрч хангинах чимээ гарлаа.

Одоо тэд жинхэнээсээ занганд орж хэрвээ шүүгээнээс гарах юм бол бүлэг албингууд хүлээж байх болно. Харри Рон, Гермиона хоёрын царайд айдас тодрохыг харав. Хангинах чимээ улам чанга боллоо.

- Гермиона би дээд талын тавиурт заавал хүрэх хэрэгтэй байна гэж Харри хэлэв.

Тэр саваагаа даллаад,

- Левикорпус! гэж шивнэлээ.

Харри агаарт шагайнаасаа өргөгдөн дуулга цохин унахад хуулбар нь ихсэж цайртал улайсан шингэн шалаар урсан агуй улам давчуу болов. Рон, Гермиона болон албингууд өвдсөндөө эд зүйлс дамжин үсрэхэд хувилж эхлэв. Хайлсан эрдэнэсийн давалгаанд тэднийг хашгиран дэвхцэх зуур Харри илдийг аяганы бариул руу сунган дэгээдлээ.

- Импервиус! гэж Гермиона цөхөрсөндөө өөрийгөө хамгаалахыг оролдон хашгирахад Рон албингуудтай цуг төмөр эдлэлд түлэгджээ.

Тэгтэл өмнөхөөсөө аймшигтай хашгиралт гарахад Харри доош харлаа. Рон, Гермиона хоёр бүсэлхийгээ хүртэл эрдэнэсийн гүнд дарагдаад Богродыг гартаа барьж, Дэгээдэгч үзэгдэхгүй болоод урт хурууны үзүүр нь цухуйж байлаа.

Харри Дэгээдэгчийн хуруунаас татан гаргахад түлэгдсэн албин орилов.

- Либеракорпус! гэж Харри орилоод Дэгээдэгчийн хамт эрдэнэсийн овоо дээр унахад илд гараас нь мулт үсэрлээ.

- Бариарай! гэж Харри өвдөлтийг арай ядан тэсч орилоход Дэгээдэгч мөрөн дээр нь авиран гарч хайлсан төмрөөс аврагдав.

- Илд хаана байна? Түүгээр аягыг авъя!

Хаалганы гадаа хангинах чимээ улам чанга боллоо. Хожигдож хэтэрхий хожигдож ...

- Тэнд байна!

Дэгээдэгч илдийг түрүүлж хараад үсрэх агшинд Харри албин эхнээсээ л тэдний үгэнд итгээгүй болохыг ойлгов. Тэрбээр хайлмаг алтны тэнгист унахгүйн тулд нэг гараараа Харрийн үснээс зуурч илдний бариулаас атгаад дээш өргөхөд үзүүрт нь торгоогдсон жижигхэн алтан аяга агаарт нисэв. Харри аягыг гараа махандаа хүртэл түлэгдэхийг тоолгүй барьж автал тоолохын аргагүй хувилан асгарлаа. Шүүгээний үүд нээгдэхэд халуун алт галт уулын хайлмаг шиг урсав.

Харри өвдөлтөө тоолгүй аягыг халаасандаа хийгээд илдийг авах гэсэн ч Дэгээдэгч хэдийн алга болжээ. Тэр Харрийн мөрөн дээрээс үсрэн буумагц «Хулгайч! Хулгайч! Туслаарай! Хулгайч!» гэж орилоод чичлүүр хутгаар зэвсэглэсэн төрлийнхөн дундаа уусан алга болов.

Хайлсан алт түүний хөлд хүрэхэд өргөөд эндээс яаж мултрахаа ойлголоо.

- Остолбеней! гэж тэр орилоход Рон, Гермиона хоёр дэмжлээ.

Улаан оч албингуудын зүг харвахад хэдэн албин шалан дээр унасан ч бусад нь урагш ухасхийлээ. Булангаас шидтэнгүүд гүйн гарч ирэв.

Аргамжаатай луу хүрхэрэхэд албингуудын толгой дээгүүр галт хуй буудлаа. Шидтэнгүүд ирсэн зүг рүүгээ ум хумгүй зугтав. Энэ нь түүнд нэг санаа төрүүлэхэд шидэт саваагаа гадаснаас дөнгөлөөтэй луу руу чиглүүлээд,

- Релашио! гэж хашгирлаа. Гинж хангинан уналаа.

- Ийшээ! гээд Харри сохорсон луу руу ухасхийх замдаа албингууд руу Хөшөөх шившлэг илгээлээ.

- Харри ... Харри ... чи юу хийж байна? гэж Гермиона хашгирав.

- Алив түргэн авираарай!

Луу чөлөөлөгдсөнөө ойлгосонгүй. Харри түүний нугалсан хойд сарвуугаар дамжин нуруун дээр нь гарав. Луу Гермиона Харрийн араас авирч гарахыг мэдсэнгүй. Түүний араас Рон гарч ирлээ. Ахин нэг агшин болоход луу хүлээсгүй болсон гэдгээ ойлгов.

Тэр хүрхрэн босч сэрвээгээ өндийлгөв. Луу далавчаа дэлгэхэд албингууд орилон зугтаж Харри бүх хүчээ гарган өвдгөөрөө хавчиж овон товон хайрснаас нь зуурлаа. Луу агаарт хөөрөхөд Харри, Рон, Гермиона нар адар мөргөхгүйн тулд нуруунд нь наалдан бөхийв. Түүнийг хонгилын гарц руу нисэхэд албингууд орилон хутга шидсэн ч нэмэр болсонгүй.

- Ашиггүй дээ тэр хэтэрхий том! гэж Гермиона хашгирахад луу галаар тургилан хонгилын хананд цууралт үүсгээд сарвуугаараа маажин нүхийг томсголоо.

Харри тоос шороо халуунд нүдээ чанга анив. Түүнийг чулууны нурах болон лууны хүрхрэх чимээ дөжрөөх шахсан ч Гермионагийн хашгирах дуу сонсогдов.

- Дефодио!

Гермиона луунд хонгилыг томсгоход тусалж орилолдон хангинуулан гүйх албингуудаас холдов. Харри, Рон хоёр түүнийг дуурайн адрыг нураалаа. Тэд харанхуй нуурыг өнгөрөхөд том амьтан эрх чөлөөтэй болсноо мэджээ. Тэр хурц үзүүртэй сүүлээрээ ардаа байсан том хадыг шарван нураахад албингуудын хашгиралт хангинах чимээ алсад хоцров. Луу өөртөө галаар зам гаргалаа.

Эцэст нь тэд шившлэг болон лууны хүчээр хонгилоос гантиг танхимд гарахад шидтэн болон албингууд зүг бүр тийш таран зугтав. Энд луу далавчаа бүрэн тэнийлгэж чадах болжээ. Тэр эвэртэй толгойгоо гарц руу чиглүүлэн цэвэр агаар үнэрлээд нислээ. Түүний нуруун дээр Харри, Рон, Гермиона гурав зуурсан хэвээр төмөр хаалгыг нугасаар нь эвдэж Тахир гудамжинд гарснаа тэнгэрт хөөрлөө.

БҮЛЭГ 27: СҮҮЛЧИЙН НУУЦ ГАЗАР

Лууг залах боломжгүй байлаа. Тэр хаашаа нисэж байгаагаа харахгүй байсан ч агаарт гэнэтхэн хөрвөвөл тэд өргөн нуруун дээр нь тогтож чадахгүйд хүрэх байв. Гэсэн ч Харри төгсгөлгүй гайхамшигтай аврагдсаар байлаа.

Луу улам өндөрт нисэхэд Лондон дор саарал ногоон зураг болон бүртэлзэв. Харри лууны хүзүү руу урагш бөхийж төмөр шиг хатуу хайрснаас зуурлаа. Салхи үсийг нь таатай хийсгэж лууны далавч салхин тээрмийн сэнс адил дэвнэ. Рон хөөрсөндөө чанга хараахад, Гермиона аяархан дуу алдав.

Таван хормын дараа Харри луу тэднийг унагах вий гэж айхаа болилоо. Амьтан харваас газар дорхи шоронгоос аль болох хол зугтах гэсэн ганцхан зүйлийг хүсэж буй бололтой. Гэвч газар яаж буух вэ гэдэг асуудал хэвээр үлдэв. Харри луу агаарт хэр удаан нисэж чадах болон газардах аятайхан газраа харж чадах эсэхийг нь мэдсэнгүй. Тэр эргэн тойрноо хартал сорви нь ахиад л хатгуулан өвдөв.

Волдеморт тэдний Лестрейнжийн шүүгээг дээрэмдсэнийг мэдэх хүртэл хичнээн хугацаа өнгөрөх бол? Гринготтсын албингууд Беллатрисад энэ тухай хэр түргэн мэдэгдэх бол? Харин алтан аяга алга болсон гэдгийг мэдмэгц Волдеморт эцэстээ тэдний крестражын араас хөөцөлдөж байгааг ойлгох болно ...

Луу харваас хүйтэн цэвэр агаарын хүслэн болж байсан бололтой. Тэр дээш хөөрөн чийгтэй хүйтэн үүлний дунд ороход Харри зам дээр явах машины жижигхэн дүрсийг ялгаж чадахаа болив. Тэд хөдөө нутгийн хүрэн ногоон толгод, гялалзсан тууз адил хөврөх гол горхи зам дээгүүр нислээ.

- Чи түүнийг юу эрж байгаа гэж бодож байна? гэж Рон хойд зүг рүү улам алслан нисэх үед хашгирлаа.

- Мэдэх юм алга! гэж Харри хариу хашгирав.

Түүний гар хүйтэнд бээрсэн ч барилтаа сулруулж зүрхэлсэнгүй. Хэсэг хугацааны дараа луу тэнгис рүү зүглэж байвал яах вэ гэсэн эмээнгүй бодол төрөв. Харрийн гар хөл даарсандаа бээрч өлсөж цангаж байв. Ингэхэд луу хэзээ сүүлчийн удаа хооллосон нь сонирхолтой? Түүнд хэр хугацааны дараа идэх юм шаардагдах бол? Хэрвээ гэнэтхэн эргэж хараад нуруун дээр нь гурван хүн сууж байгааг харвал яах болж байна?

Гүн хөх тэнгэрт наран гудайсан ч луу ниссээр байв. Дор том бага хотууд жирэлзэн өнгөрч газарт хар үүл мэт сүүдэр татав. Харри өвдсөндөө лууны хайрснаас арай ядан зуурч байв.

- Надад санагдсан уу эсвэл бид доошилж байна уу? гэж Рон хэсэг хугацааны дараа хашгирав.

Харри доош хараад жаргаж буй нарны гэрэлд хүрэнтсэн ногоон уул толгод, нуур харлаа. Газар улам тодорч байв. Луу гялалзсан зүйлээс энд ус байна гэдгийг мэдсэн бололтой.

Тэр доошлон томоохон тойрог эргэлдсэнээ арай багахан нуур луу чиглэв.

- Намайг хэлэхээр үсрээрэй! Биднийг шууд ус руу үсэрвэл ажиглахгүй! гэж хашгирлаа.

Найзууд нь зөвшөөрсөн хариу хэлэхэд Гермиона сулхан дуугарлаа. Харри усны мандалд лууны шар хэвлий тусахыг харав.

- Үсрээрэй!

Харри нурууны хажуугаар гулсан үсрээд хөлөөрөө нуур луу пүлхийн ороход бодсоноос ч өндрөөс үсэрсэн шиг санагдав. Тэр ногоон зэгстэй усанд чулуу шиг живэн ороод хөлөөрөө тийрэн усны мандалд гарч Рон, Гермиона хоёрын унасан том цагариг руу амьсгаадан харлаа. Луу юу ч ажигласангүй бололтой тавин футын зайд холджээ. Рон, Гермиона хоёр хахаж цацан уснаас гарахад луу хүнд далавчаа дэвэн эсрэг талын эрэг дээр газардав.

Харри, Рон, Гермиона гурав ойролцоох эрэг рүү чиглэлээ. Нуур ус санаснаас гүехэн ажээ. Эцэст нь норж ядарсан тэд зэгс шавар туучсаар гулгамтай өвсөн дээр гаран унав.

Гермиона ханиалган бүх бие нь чичирч байлаа. Харри баярласандаа гайхалтай хөнгөн байсан болохоор босож шидэт саваагаа гаргаад хамгаалалтын шившлэг босгож эхлэв.

Үүнийгээ хийж дуусаад Рон, Гермиона хоёр луу очин банк дээрэмдсэнээс хойш анх удаагаа сайтар харлаа. Хоёулангийх нь нүүр болон гар улаан хүрэнтэн түлэгдэж цэврүүтэн хувцас нь нэвт норжээ. Тэд ярвайн олон тооны шархандаа бадъяны ханд түрхэж байлаа. Гермиона Харрид шилтэй эмийг сунгаад цүнхнээсээ гурван лонх хулууны шүүс болон хясаан байшингаас авсан цэвэр хуурай хувцас гаргалаа. Тэд хувцаслаад шүүсээ ууцгаав.

- Юу гээч бидэн дээр нэмэх нь крестраж. Харин хасах нь ... гээд Рон эдгэрсэн гарынхаа арьсыг харлаа.

- Илдгүй үлдлээ гэж Харри шүдэн завсраар сийгүүлээд бадъян жинсэн өмднийхөө цоорхойн түлэгдсэн хэсэгт түрхлээ.

- Илдгүй үлдсэн гэж Рон давтснаа,

- Зальтай жижигхэн новш гэв.

Харри крестражыг норж нэвтэрсэн хүрэмнийхээ халааснаас гаргаад урдаа ногоон дээр тавилаа. Аяга нарны гэрэлд гялтагнахад гурвуул суугаад хулууны шүүс уунгаа түүн рүү харлаа.

- Ямар ч гэсэн үүнийг хүзүүндээ зүүхгүй боллоо гээд Рон гарынхаа араар амаа арчив.

Гермиона нуур луу харав. Луу нөгөө талын эрэг дээр ус уусан хэвээр байв.

- Түүний бүх зүйл хэвийн гэж та нар бодож байна уу?

- Чи яг л Хагрид шиг ярих юм! гэж Рон тургилаад,

- Энэ чинь луу шүү дээ Гермиона! Тэр өөртөө санаа тавьж чадна. Харин чи бидэнд санаа зовсон нь дээр юм биш үү гэв.

- Чи юуны тухай яриад байна?

- Чамд юу гэж хэлэхээ ч мэдэхгүй байгаа ч хэн нэгэн биднийг Гринготтс дээрэмдсэн гэдгийг анзаарсан байх!

Гурвуулаа инээд алдаж эхэлснээ зогсож чадсангүй. Харрийн хавирга хатгуулан өлссөндөө толгой нь эргэж байсан ч улайрч буй тэнгэр рүү харан хэвтээд хөхөрлөө.

- Бид одоо юу хийх вэ? Тэр одоо бүгдийг ойлгосон болов уу? Хэцүү нэрт биднийг крестражын араас хөөцөлдөж байсан гэдгийг ойлгосон байх даа! гэж Гермиона зогьсуулан хэллээ.

- Магадгүй тэд түүнд хэлэхээс айсан биз! Өөр ямар нэг зүйл хэлсэн байх ... гэж

Рон найдангуй хэлэв.

Агаарт нуурын усны үнэр ханхийн Роны хоолой бөхлөө. Харрийн толгой илдээр цавчиулсан аятай янгинан өвдлөө. Тэр сулхан гэрэлтэй өрөөнд зогсоод эсрэг талд нь хагас дугуйрсан шидтэнгүүд байж шалан дээр өрөвдөлтэй чичирсэн дүрс өвдөг сөгдсөн байлаа.

- Чи юу хэлсэн бэ? гэж өндөр хүйтэн хоолой уур хилэндээ шатан асуулаа. Тэр зөвхөн үүнээс л айж байсан билээ ... Гэхдээ ийм зүйл байж болно гэж үү? Тэр яагаад ингэснийг ойлгосонгүй.

Албин чичирээд түүний улаан нүд рүү харж зүрхэлсэнгүй.

- Давт! Давтаад хэл! гэж Волдеморт шивнэв.

- Э-эээнтээн ... э-зэнтээн ... бид т-тэднийг з-зогсоохыг о-оролдсон ч ... л-луйварчид ... Лейстренжийн ... шүүгээг ... дээрэмдсэн гэж албин хар нүдээ айдаст автан бүлтийлгэн ээрэн хэлэв.

- Луйварчид гэнээ? Ямар луйварчид? Би Гринготтсыг луйварчин дээрэмдэж чаддаг гэж бодоогүй юмсан! Энэ хэн байсан бэ?

- Энэ бол ... Поттер ... хоёр ... хоёр туслагчынхаа хамт байсан ...

- Тэгээд тэд юу авсан бэ? Тэд юу авсан юм? Хэл! гэж хоолой уур хилэндээ автан асуулаа.

- Ж-жижигхэн ... а-алтан аяга ... э-эээнтээн ...

Тэр өөрийнхөө уурсан хашгирахыг сонслоо ... Тэр галзууртлаа уурсаж хилэгнэн ... худал хэн ч үүний тухай мэдэх боломжгүй! Хүү яаж нууцыг нь тайлж чадсан юм бол?

Гандигарын саваа агаарт шавхуурдахад өрөөнд ногоон гэрэл гялсхийн өвдөглөсөн албин хажуу тийш үхэдхийн уналаа. Шидтэнгүүд айдаст автан зугтав. Беллатриса, Люциус Малфой хоёр бүхнээс урд хаалга руу ухасхийлээ. Ялагдашгүй саваа ахин

дахин гялсхийхэд зугтаж амжаагүй хэн бүхэн энэ алтан аяганы тухай аймшигт мэдээнээс болж үхэв ...

Тэр үхэгсдийн дундуур нааш цааш холхин явлаа. Түүнийг үхэшгүй мөнх болгосон хосгүй үнэт эрдэнэс хамгаалалтанд байгаа ... Тэмдэглэлийн дэвтэр устгагдсан, аяга хулгайлагдсан. Хэрвээ ... Хэрвээ хүү бусдынх нь талаар мэдэж байвал яах вэ? Тэр үнэхээр мэдэж хэдийн бусдыг нь илрүүлсэн хэрэг биш биз дээ? Үүнд Дамблдор оролцсон байвал яана? Дамблдор үргэлж түүнийг сэжиглэж байсан ч тушаалаар нь үхэж саваа нь түүнийх болсон ...

Гэхдээ үнэхээр хүү нэг крестражыг нь устгасан бол лорд Волдеморт эргэлзээгүй энэ тухай мэдэх болно! Тэр бүхнээс илүү хүчирхэг аугаа их шидтэн бөгөөд Дамблдорыг олон тооны үнэ цэнэгүй хүмүүсийнх нь хамт алсан. Лорд Волдеморт яаж чухал эрдэнэсийг нь сөнөөн устгасан байхад мэдэхгүй байх билээ?

Гэсэн ч үнэндээ тэмдэглэлийн дэвтэр устгагдахад тэр юу ч мэдрээгүй. Тэр үүнийг тэгэхэд хий үзэгдлээс дутуугүй биетэй байснаар тайлбарласан ... Үгүй үлдсэн крестражууд аюулгүй байдалд байгаа ... Тэдэнд хэн ч хүрээгүй ...

Гэхдээ тэр үүнд итгэлтэй байхын тулд шалгах ёстой. Тэр өрөөнөөс гарахдаа албингийн хүүрийг холдуулан өшиглөхөд тархинд нь нуур, оромж, Хогвартс гэсэн дүр зураг зурсхийв ...

Уур хилэн нь ялыгүй намдлаа. Хүү хаанаас Мраксын байшинд бөгж нуусныг мэднэ гэж? Хэн ч түүнийг тэдэнтэй хамаатан гэдгийг сэжиглэхгүй бөгөөд холбоогоо нууцлахын тулд бүх ул мөрөө арилгаж устгасан. Бөгж эргэлзээгүй аюулгүй байдалд байгаа.

Түүний дээр хүү юмуу өөр хэн нэгэн агуйн хамгаалалтыг яаж давахыг мэдэх болж байна? Зүүлтийг хулгайлна гэж бодох нь утгагүй зүйл юм!

Сургуулийн тухайд гэвэл ... зөвхөн тэр л ганцаараа л Хогварстын хаана крестраж нуугаастай байгааг мэднэ. Учир нь тэр ганцаараа шилтгээний хамгийн гүн нууцад нэвтэрч чадсан ...

Бас Нагайна байна. Түүнийг одооноос ийш тийш нь илгээлгүй хамгаалалтанд байлгахын тулд ойрхон байлгах хэрэгтэй ...

Гэсэн ч бүрэн итгэлтэй байхын тул нууц газрынхаа хамгаалалтын шившлэгийг шалгах хэрэгтэй ... Үүнийг яг л гандигарын савааг олсон шиг ганцаараа хийх ёстой.

Харин ямар нууцаа түрүүлж шалгах вэ? Алинд нь илүү аюул заналхийлж байгаа бол? Тэгтэл дотор нь эвгүй болж айдас төрөв. Дамблдор түүний хоёр дахь нэрийг мэднэ ...

Дамблдор түүнийг Мраксын гэр бүлтэй хамаатан гэдгийг тааварласан байж болох юм ... Тэдний хаягдсан оромж хамгийн найдлагагүй газар болохоор тийшээ бүхнээс урьд очих хэрэгтэй ...

Нуурын тухайд гэвэл? Үгүй ээ, боломжгүй! Гэсэн ч Дамблдор түүний асрах газарт өнгөрүүлсэн өнгөрсөн үеийн нүглийн тухай ямар нэг зүйл шиншилсэн байж болох юм.

Эцэст нь Хогвартс ... Гэсэн ч крестраж тэнд аюулгүй байгаа бөгөөд Поттер Хогсмидэд анзаарагдахгүй ойртож чадахгүй. Тэр Снеггэд хүүг ахин шилтгээнд нэвтрэхийг оролдож болзошгүй гэж анхааруулсан ... Гэхдээ Снеггэд шалтгааныг нь хэлэх тэнэг хэрэг байлаа. Беллатриса, Малфой хоёрт итгэсэн нь ноцтой алдаа байсан. Тэд хөнгөмсөг тэнэг байдлаараа итгэсэн нь ямар бодлогогүй хэрэг байсныг харуулсан.

Юунаас урьд Мраксын байшинг эргэхдээ Нагайнаг өөртэйгээ хамт авч явах болно. Тэр одооноос түүнтэй салахгүй ...

Тэр танхимаас гараад үүдний өрөөнд орж дэнлүүний гэрэл ассан харанхуй цэцэрлэгт гарлаа. Тэр могойн хэлээр дуудахад Нагайна урт нарийхан сүүдэр шиг ногоон дээгүүр мөлхөн ирэв ...

Харри нүдээ нээгээд бодит байдалд буцан ирлээ. Тэр нуурын эрэг дээр хэвтээд тэнгэрт нар гудайж Рон, Гермиона хоёр дээрээс нь харж байв. Тэдний түгшсэн царай болон сорвиных нь өвдөлт Волдемортын ой ухаанд нэвтэрсэн нь ажиглагдахгүй өнгөрснийг илтгэх аж. Харри суугаад чичирч нэвт хөлөрсөн байсандаа гайхлаа. Түүний өмнөх ногоон дээр аяга гэмгүйхэн хэвтэж байсан бөгөөд гүн цэнхэр усанд жаргаж буй нарны туяа алтрана.

- Тэр мэдэж байна гэж Харри хэлэхэд Волдемортын чих дөжрөм хашгиралтын хажууд хоолой нь хачирхалтай аяархан санагдлаа.

- Тэр үлдсэн крестражуудаа шалгахыг хүсээд хамгийн сүүлчийнх нь ...

Хогвартсад байсан. Би мэдэж байж. Би үүнийг мэдэж байж.

- Юу гэнээ?

Рон түүн рүү алмайран харахад, айсан Гермона өвдөглөн суулаа.

- Чи юу хараа вэ? Чи яаж мэдэв?

- Би түүнийг аяганы тухай мэдсэнийг харсан. Би ... би түүнийг толгойд байсан харин тэр гээд Харри аллагын тухай саналаа.

- Тэр үүнд маш их уурлаж биднийг хаанаас мэдсэнийг ойлгоогүй ч бусад крестражуудыг бүрэн бүтэн эсэхийг шалгахаар шийдээд эхний ээлжинд бөгж лүү очих гэж байна. Тэр Хогвартсад Снегг байхад ажиглагдахгүй нэвтрэх нь боломжгүй хэрэг учир тэндхийн нууц хамгийн найдвартай гэж бодож байна. Түүнийг сүүлчийн нууцаа шалгах хооронд хэдэн цаг өнгөрөх байх.

- Харин чи Хогварстын нууц нь юу болохыг харсан уу? гээд Рон бас өвдөглөн суулаа.

- Үгүй тэр Снеггэд анхааруулах тухай бодсоноос биш хаана байгаа тухай бодоогүй ...

- Хүлээгээрэй, хүлээгээрэй! Шууд явж болохгүй төлөвлөгөө зохиох хэрэгтэй гэж Гермиона Рон крестражыг аваад, Харри үл үзэгдэх цуваа гаргахыг харан хашгирав.

- Тийшээ түргэн явах хэрэгтэй гэж Харри хатуу хэлэхэд шинэ майхандаа орон унтахыг мөрөөдөж байсан нь өнгөрсөн хэрэг болжээ.

- Чи түүнийг бөгж зүүлт хоёр нь алдагдсаныг мэдвэл яахыг төсөөлж байна уу?

Тэр гэнэтхэн Хогвартсын крестражыг нуувал яана? Тэнд хадгалах нь найдлагагүй гэж бодвол яах болж байна!

- Бид тийшээ яаж орох болж байна?

- Эхлээд Хогсмид рүү очино. Тэнд очоод ямар нэг зүйл бодож олцгооё.

Сургуулийн эргэн тойрны хамгаалалт ямар болохыг харах хэрэгтэй. Алив нөмрөгөн дор ор, Гермиона! Энэ удаад бүгд хамт байх хэрэгтэй.

- Гэхдээ бид бүрэн багтахгүй ...

- Тэнд харанхуй байх юм чинь хэн ч бидний хөлийг ажиглахгүй.

Харанхуй усан дээгүүр том далавч алгадах чимээ гарч луу эцэст нь нислээ. Гурван найз бэлтгэх зууraa хар дүрс нуурын дээгүүр харанхуй тэнгэрт хөөрөн ойролцоох уулын зүг хөөрөн алга болохыг харав.

Гермиона тэдний дунд зогсоход Харри бүгдийг цуваар хучаад зэрэг байран дээрээ эргэлдэн харанхуйд умбалаа.

БҮЛЭГ 28: АЛГА БОЛСОН ТОЛЬ

Харрийн хөл зам дээр хүрэхэд харанхуй дэлгүүрийн лангуу болон тосгоны эгнэсэн байшингийн дүрс бүхий Хогсмидын танил төв гудамж харагдав. Харин урд нь Хогвартс хүрэх замын эргэлт байж, «Гурван шүүр»-ийн цонхны гэрэл асаатай байлаа. Тэр гэнэтхэн жилийн өмнө суларч доройтсон Дамблдорыг түшээд энд газардсанаа санатал сэтгэл нь шимшрэн Рон, Гермиона хоёрын гарыг тавихаас урьд

...

Агаарт Волдеморт аяга хулгайлагдсаныг мэдсэн үеийнх шиг хашгиралт сонсогдов. Харри хашгиралт тэднийг ирсэнтэй холбогдуулан гарсныг ойлгоод бүх бие нь хөвчирлөө. Тэднийг эргэн тойрноо харах мөчид «Гурван шүүр»-ийн хаалга нээгдэж гудамжинд арваад юүдэнтэй цув бүхий Үхэл залгигч саваагаа барьсаар гүйн гарч ирэв.

Рон саваагаа өргөсөн ч Харри хориглож амжлаа. Дайсан Хөшөөх шившлэг хэрэглэхэд хэтэрхий олон байсны дээр байршил нь шууд илрэх байв. Нэг Үхэл залгигч саваагаа занган орилоход хашгиралт нь алсын ууланд цуурайтав.

- Акцио цув! гэж өөр нэг нь хүнгэнүүлэв.

Харрийн цувныхаа нугалааснаас зуурч чанга үлдээхэд Татдаг шид үйлчилсэнгүй.

- Поттер цуван дор нуугдаж байна уу? гэж тэр шидийг үргэлжлүүлэн оролдох зуур хашгираад дэргэдэх хүндээ хандан,

- Урагшаа! Тэр энд байна гэлээ.

Зургаан Үхэл залгигч тэдний урдаас гүйж ирэхэд Харри, Рон, Гермиона гурав ойролцоох гудамж руу түргэн ороод араас нь хоёр алхамын шахуу зайд дагалдав. Гурван найз харанхуйд ойртож буй хөлийн чимээ анирдан хүлээхэд Үхэл залгигчид шидэт саваагаа тусган орж ирэв.

- Эндээс холдоё! Шилжицгээе! гэж Гермиона шивнэлээ.

- Сайхан санаа байна гэж Рон зөвшөөрөв.

Гэвч Харрийг хариу хэлж амжихаас урьд Үхэл залгигчдын нэг,

- Бид чамайг энд байгаа гэдгийг мэдэж байна шүү, Поттер. Чи эндээс зугтаж чадахгүй! Заавал олох болно! гэв.

- Тэд биднийг ирэхэд бэлтгэлтэй байжээ. Биднийг ирэхэд зориулан шид босгосон байна. Тэгэхээр явахгүй байхад ч гэсэн санаа тавьсан байх гэж Харри шивнэлээ.

- Дементоруудыг яах вэ? Тэднийг ийш нь дуудъя хүүг дор нь олно гэж нэг

Үхэл залгигч хэлэв.

- Хар лорд үргэлж хүүг өөрийн гараар алахыг хүсдэг ...

- Дементорууд түүнийг алахгүй! Хар лордод Поттерийн амь хэрэгтэй болохоос биш сэтгэл санаа нь биш. Харин ч үнссэний дараа алахад хялбар болно!

Дэмжсэн дуу сонсогдов. Харри Дементоруудыг хөөхөд Патронусаа дуудах хэрэгтэй болохоор дотор нь хүйт даалаа. Энэ нь тэднийг агшин зуур барьж өгөх билээ.

- Бид шилжих гээд оролдож үзэх хэрэгтэй байна, Харри! гэж Гермиона шивнэв. Түүнийг ингэж хэлэх агшинд гудамж ер бусын хүйтэн болоод эргэн тойрон харанхуйлж одод хүртэл алга болов. Харанхуйд Гермионагийн гараас зуурах нь мэдэгдэв. Тэд хамтдаа эргэсэн ч агаар нягтарч хүндрэн шилжих боломжгүй болжээ.

Үхэл залгигчид шидээ сайн тавьсан бололтой. Хүйтэн Харрийг дагжуулахад Рон, Гермиона хоёрын хамт хана даган чимээ гаргахгүйг хичээн явлаа. Тэгтэл булангаас арваад Дементорууд чимээн шуугиангүй хөвөн гарч ирээд урт нөмрөгөө намируулан яртай гар сунгалаа. Тэд хохирогчынхоо айдсыг үнэртэж байгаа болов уу? Харри тийм гэдэгт итгэлтэй байсан бөгөөд тэд түргэн хөдлөхдөө чимээтэй амьсгалахад агаарт цөхрөл айдас тархаж ...

Тэр Дементорын үнсэлт хүртэхгүйн тулд саваагаа өргөөд Рон, Гермиона хоёрын тухай бодсоноо,

- Экспекто патронум! гэж шивнэв.

Сабааны үзүүрээс мөнгөн буга гарч хөөрөв. Дементорууд сарнин алга болоход хаа нэгтээгээс хөөрсөн хашгиралт сонсогдож,

- Тэр тэнд байна, би түүний Патронусыг харсан. Буга байсан! гэлээ. Дементорууд ухран алга болоход тэнгэрт ахин од түгэж Үхэл залгигчдийн хөлийн чимээ пижигнэв. Харри балмагдсандаа яахаа мэдсэнгүй ч гэнэтхэн ард нь үүд чахарч зүүн талын давчуу гудамжны хаалга нээгдэн бүдүүлэг хоолой,

- Поттер ийшээ түргэл! гэв.

Харри тэнэгэлзэлгүй ухасхийхэд тэд хамтдаа нээлттэй үүдээр орлоо.

- Дээшээ гараад цуваа битгий тайлаарай! гэж өндөр хүн хэлээд дэргэдүүр нь өнгөрч хаалга хаалаа.

Харри хаашаа орсоноо мэдсэнгүй ч лааны бүдэг гэрэлд «Гахайн толгой» баарны борогдуухан танхимыг харав. Хүүхдүүдэд лангуу руу ухасхийн дээшээ гардаг эргүүлгэн шатаар өгсөөд ханан зуухан дээр цайвар үстэй охин хоосон зай руу амирлангуй ширтэх цорын ганц тосон зураг өлгөсөн элэгдсэн хивс бүхий зочны өрөөнд оров.

Дор гудамжинд хашгиралт сонсогдов. Тэд үл үзэгдэх цуваа тайлалгүй цонх руу очиж доош харлаа. Харри аврагч болох «Гахайн толгой»-н эзэн цорын ганц юүдэнгүй дүрсийг танив.

- Тэгээд юу гэж? хэмээн тэр юүдэнгээр нүүрээ хаасан Үхэл залгигч руу хашгирч,

- Яасан гэж? Та нар Дементоруудыг миний гудамж руу илгээсэн. Би Патронусаа дуудаж тэднийг хөөлөө! Тэднийг дэргэдээ байхыг тэвчиж чаддаггүй юм, сонсов уу? Тэвчих ч үгүй! гэв.

- Энэ чиний Патронус биш! Тэр бол буга байсан ... Поттерын Патронус гэж

Үхэл залгигч хэлэв.

- Буга гэнээ! хэмээн баарны эзэн орилоод шидэт саваагаа гарган,

- Буга гэнээ! Чи ч тэнэг амьтан юм даа ... Экспекто патронум! гэв.

Савааны үзүүрээс том эвэртэй амьтан гараад толгойгоо сэжин төв гудамж руу давхиж үзэгдэхгүй болов.

- Үгүй өөр байсан ... гэж Үхэл залгигч итгэлгүйхэн хэллээ.

- Хөл хорионы цаг эвдэхэд гарсан дохиог чи сонссон биз дээ. Хэн нэгэн журам зөрчин гудамжинд гарсан ... гэж тэдний нэг эзэнд хандан хэллээ.

- Хэрвээ надад гудамжинд мууpаа гаргах хэрэг гарвал би гаргаж л орхино. Тэр хөл хорионы цаг чинь надад хамаагүй.

- Тэгэхээр чи аваарын шидийг эвдсэн байх нь ээ?

- Хэрвээ тэгсэн бол юу гэж? Намайг Азкабанд илгээх нь үү? Хаалганаасаа хамраа цухуйлгасан гэж шийтгэх юм биз дээ? Алив учраа олцгооё. Гэхдээ би та нарыг Хар тамганд хүрч түүнийг дуудахгүй байх гэж найдаж байна. Түүнд ийшээ миний хөгшин муурны төлөө дуудсан нь таалагдана гэж бодохгүй л байна шүү.

- Бидэнд санаа зовох хэрэггүй! Өөртөө л санаа тавь хөл хорионы цаг зөрчигч минь! гэж нэг Үхэл залгигч хэлэв.

- Хэрвээ миний баар хаагдах юм бол та нар хаанаас хууль бус ундаа хороо авах болж байна? Та нар ажлынхаа хажуугаар хийдэг зүйлээ яах болж байна?

- Чи биднийг сүрдүүлж байна уу?

- Би чамайг ийшээ ирсэнд амаа хамхих ёстой юу?

- Би буган Патронус харсан л юм даа! гэж эхний Үхэл залгигч чанга хэлэв.

- Буга гэнээ? Тэнэг минь, тэр чинь ямаа!

- За яахав бид эндүүрсэн юм байж гэж хоёр дахь Үхэл залгигч хэлээд,

- Ахиад хөл хорионы цаг зөрчих юм бол тийм ч амархан мултрахгүй байх шүү!

гэв.

Үхэл залгигчид төв гудамж руу буцав. Гермиона санаа амран дуу алдаад цуван дороос гарч ганхдаг сандал дээр суулаа. Харри хөшиг татсанаа цуваа тайлав. Дор баарны эзэн хаалганы түгжээ оньслох чимээ дуулдсанаа дараа нь шат чахарлаа.

Харри гэнэтхэн ханан зуухны тавиур дээр байгаа охины хөргөн дорх дөрвөлжин хүрээтэй толийг харлаа.

Эзэн өрөөнд орж ирэв.

- Ухаангүй тэнэгүүд! Юугаа бодож ийшээ ирээ вэ? гэж ууртай хэлээд тэднийг гүйлгэн харав.

- Баярлалаа. Ямар их баярласанаа хэлж ч чадахгүй нь. Та бидний амийг аварлаа гэж гэж Харри хэлэв.

Баарны эзэн тургилаа. Харри түүн рүү очоод урт буурал үс сахалтай нүүр лүү нь харлаа. Бохир нүдний шилний цаана хурц цэнхэр нүдтэй юм.

- Би таны нүдийг толинд харсан.

Өрөөнд чимээгүй болов. Харри баарны эзэн хоёр бие бие рүүгээ харлаа.

- Та над руу Доббийг илгээсэн.

Эзэн толгой дохиод үйлчлэгчийг нүдээрээ хайлаа.

- Би түүнийг та нартай байгаа гэж бодсон юмсан. Та нар түүнийг хаана орхио вэ?

- Тэр үхсэн. Беллатриса Лестрейнж алсан гэж Харри хэлэв.

Баарны эзний царай тоомсоргүй харагдсанаа хэдэн хормын дараа,

- Харамсалтай байна. Надад тэр үйлчлэгч таалагддаг байсан юм гэв. Тэр зочид руугаа харалгүй эргээд саваагаа даллан дэнлүү асаав.

- Та бол Аберфорт гэж Харри араас нь хэллээ. Эзэн хариулсангүй бөхийн ханан зууханд гал асаав.

- Та үүнийг хаанаас аваа вэ? гэж Харри асуугаад хоёр жилийн өмнө хагалсан

Сириусын толь руу очлоо.

- Наземникусаас жилийн өмнө худалдаж авсан юм. Альбус надад яаж ажилладагийг нь тайлбарласан. Би чамайг харахыг хичээж байсан.

Рон дуу алдсанаа,

- Мөнгөн согоо! Үүнийг та явуулсан уу? гэж хөөрөн хэлэв.

- Чи юуны тухай яриад байна? гэж Аберфорт асуулаа.

- Хэн нэгэн бидэн рүү Патронус согоо явуулсан байсан!

- Чиний тархи чинь яг л Үхэл залгигчийнхаас дутах юм алга, хүү минь. Би дөнгөж таван хормын өмнө Патронусаа ямаа гэдгийг үзүүлээ биз дээ?

- Өө ... тийм л дэ э... Ингэхэд өлсөж байх чинь гэж Рон гомдонгуй хэлэхэд гэдэс нь чанга хүржигнэлээ.

- Надад хоол байгаа гээд Аберфорт өрөөнөөс гарч хормын дараа эргэн ирэхдээ том талх, бяслаг, хувинтай балын ундаа авчрав. Тэр энэ бүхнээ зуухны өмнөх жижигхэн ширээн дээр өрж тавилаа. Өлссөн хүүхдүүдийг хоолож байх зуур зууханд түлээ тас няс хийх болон юм ууж, зажлах чимээ гарна.

- За тэгэхээр хэмээн Аберфорт бүгд цадан Харри, Рон хоёр сандлын түшлэгээ налан нойрмоглоход хэлээд,

- Та нарыг эндээс яаж гаргахаа бодох хэрэгтэй байна. Шөнө үүнийг хийх боломжгүй ... гэдгийг хараа биз дээ. Хэрвээ хэн нэгэн гудамжинд гарах л юм бол аваарын шид ажиллаж саяны залуус та нарыг лукотрус ... доксины өндөг шиг няцлах болно. Хоёр дахь удаагаа ямар ч буга, ямаа үйлчлэхгүй гэж айж байна. Тиймээс гэгээ орж хөл хорионы цаг тайлагдмагц цуван дор чимээгүй явцгаа. Хогсмидээс аль болох түргэн гарч уул өөд гарвал шилжих боломжтой болно. Бас тэнд Хагридтай уулзах боломжтой. Баривчлагдах шахсаныхаа дараа агуйд Грохтой цуг нуугдаж байгаа гэв.

- Бид явахгүй Хогвартст нэвтрэх хэрэгтэй байна гэж Харри хэллээ.

- Тэнэг юм бүү ярь, хүү минь гэж Аберфорт уурслаа.

- Бид үүнийг заавал хийх ёстой.

- Та нарын хийх ёстой зүйл бол эндээс аль болох түргэн холдох гээд Аберфорт түшлэгээ наллаа.

- Та ойлгосонгүй. Цаг байхгүй болсон. Бид даруйхан шилтгээнд нэвтрэх хэрэгтэй байна. Таны ах Дамблдор биднийг ...

Галын гэрэлд Аберфортын нүдний шил агшин зуур гялсхийхэд Харри аварга том аалз Арагогын сохор нүдийг саналаа.

- Миний ах Альбус олон зүйлийг хүсч байсан. Тэгээд ч түүний агуу далгаварыг биелүүлэх гэж хүмүүс зовж шаналж байна. Энэ сургуулиас хол бай, Поттер боломжтой бол хилийн цаашаа яв. Миний ах болон ухаалаг төлөвлөгөөнийх нь талаар март. Тэр эндээс явсан болохоор гомдох зүйл үгүй бөгөөд чи үүнийг заавал хийх албагүй.

- Та ойлгохгүй байна гэж Харри давтлаа.

- Тийм үү гэж хэмээн Аберфорт чимээгүйхэн асуугаад,

- Чи намайг төрсөн ахаа ойлгодоггүй гэж бодож байна уу? Альбусыг надаас илүү дээр гэж бодож байна уу? гэв.

- Үгүй л дээ. Зүгээр л ... тэр надад нэг зүйл даалгасан гээд Харри цадтал хооллосондоо бие нь нозоорч суларлаа.

- Үнэхээр тийм гэж үү? Сайхан ажил байна гэж найдъя? Таатай юу? Амархан уу? Сургуулиа төгсөөгүй хүүхдүүд хийчихээр хялбархан юм биз дээ?

Рон баргар инээхэд, Гермиона хэрсүү төрхтэй болов.

- Би ... үгүй ээ, амархан биш. Гэхдээ би заавал хийх ёстой ...

- Ёстой гэнээ? Яагаад ёстой гэж? Ингэхэд тэр үхсэн биз дээ? Түүний араас одохоос өмнө үүнийгээ орхиж үз хүү минь! Өөрийгөө авар!

- Чадахгүй.

- Яагаад чадахгүй гэж?

- Би ... гээд Харри сэтгэлээр унан тайлбарлаж чадсангүй.

- Гэхдээ та өөрөө тэмцэлд оролцож Фениксийн бүлгийн гишүүн байсан биз дээ

...

- Би түүнд байсан. Гэвч Фениксийн бүлгэм байхгүй болсон. Хэцүү нэрт ялж тэмцэл дуусан хэнд ч өөрийгөө хуурах хэрэг байхгүй болсон. Чи хэзээ ч энд аюулгүй байж чадахгүй, Поттер тэр чамд хүрэхийг хэтэрхий их хүсч байгаа. Иймээс явж хилийн цаана нуугд аврагд! Энэ хоёрыг өөртэйгээ аваад яваарай. Тэд чамтай яваа нь мэдэгдсэн болохор энд аюулгүй байж чадахгүй гээд Рон, Гермиона хоёрыг заалаа.

- Чадахгүй нь. Надад хийх ажил бий ...

- Түүнийгээ өөр хүнд даалга!

- Үгүй. Үүнийг зөвхөн намайг хийх ёстой гэж Дамблдор хэлсэн ...

- Өө тэгсэн гэж үү? Тэр чамд үнэхээр бүх зүйлээ шударгаар хэлсэн юм биз дээ?

Харри бүхий л сэтгэл зүрхээрээ тийм гэж хэлэхийг хүссэн ч үг хоолойд нь тээглэв. Аберфорт харваас түүний бодлыг таасан бололтой.

- Би өөрийнхөө ахыг сайн мэднэ, Поттер. Тэр ээжийн гар дээр нууж нууцалж сурсан юм. Нууцалж худал хэлэх дунд бид өссөн Альбу с... үүнд төрөлхийн авъяастай гэв.

Эзний нүд ханан зуухны тавиур дээрх зурган дээр туслаа. Харри сая л өрөөнд буй цорын ганц хөрөг болохыг нь ажиглажээ. Альбусын зураг энд байсангүй.

- Ноён Дамблдор энэ таны дүү юу? Ариана юу? гэж Гермиона хулчгардуухан асуулаа.

- Тиймээ. Та нар харваас Рита Скитерын уншигчид бололтой тийм үү хатагтай? Гермиона галын гэрэлд час улайлаа.

- Бид түүний тухай Элфиас Дожоос сонссон гэж Харри түүнийг өмгөөлөх санаатай хэлэв.

- Хөгшин тэнэг! Миний ахыг хорвоо дээрх ганц нар гээд итгэчихсэн! Зөвхөн тэр ч биш та гурав хүртэл үүнд итгэсэн бололтой гэж Аберфорт бувтнаад балын ундаа залгилав.

Харри чимээгүй байлаа. Тэр Дамблдорын талаар төрсөн эргэлзээтэй бодлоо илэрхийлэхгүй хүсээгүй бөгөөд Доббийн булшны нүхийг малтах үедээ сонголтоо хэдийн хийсэн билээ. Тэр Альбус Дамблдорын заасан осолтой замаар явахаар шийдэж хэлсэн бүх зүйлд нь зүгээр л сохроор итгэхийг хүслээ. Гэсэн ч ахин нэг

шинэ эргэлзээ хэрэггүй байсан тул зорилгоосоо хазайхгүйн тулд цааш сонсохыг хүссэнгүй. Гэвч түүнийг Аберфортын харцтай тулгармагц хурц цэнхэр нүд нь ахынхаа адил хэт ягаан туяа шиг төөнөн бодлыг нь унших шиг санагдлаа.

- Профессор Дамблдор Харрид их хайртай байсан гэж Гермиона аяархан хэлэв.

- Өөр яах гэж? Хөгжилтэй нь миний ах хайртай хайрласан маш олон хүмүүс муугаар дуусдагт байгаа юм.

- Та үүгээрээ юу хэлэхийг хүсээ вэ? гэж Гермиона дуу алдав.

- Тоох хэрэггүй гэж Аберфорт хэллээ.

- Гэхдээ та маш ноцтой зүйлийн тухай хэлсэн! Та дүүгийнхээ тухай ярьсан уу?

Аберфорт түүн рүү харлаа. Хэдэн секунтын турш түүний уруул үгээ зажлах гэж буй аятай хөдөлснөө дараа нь урсгаж эхлэв.

- Миний дүүг зургаан настай байхад нь гурван магл хүү дайрсан юм. Тэд түүнийг цэцэрлэгт шид үзүүлж байхыг нь нууцаар харсан юм билээ. Тэр хүүхэд байсан болохоор үүнийгээ хянаж чаддаггүй байсан юм ... Ер нь ямар ч шидтэн түүний насан дээр чадахгүй. Тэд харсан зүйлдээ айсан бололтой. Тиймээс хүчээр хашаа даваад жижигхэн шулмыг ямар ч илбэ үзүүлж чадахгүй болгожээ.

Гермионагийн нүд томроход, Роны дотор муухайрлаа. Абефорт Альбусын адил цэхлэн өндийж зогслоо. Тэр гэнэтхэн дүрэлзсэн уур хилэндээ зовж шаналж буй мэт төрхтэй болов.

- Тэд түүнийг хэзээ ч босч ирэхээргүй болтол нь хугалсан. Тэр шид ашиглаж чадахгүй ч түүнээсээ салж чадахгүй болохоор энэ нь дотор ухаан руу нь эргэн нөлөөлж дэлбэрэх үедээ өөрийгөө хянаж чадахгүй хачирхалтай ... аюултай болдог байсан. Гэхдээ ихэнхи цагтаа гэмгүй эелдэг аймхай охин хэвээр байв.

- Миний эцэг үүнийг хийсэн хөвгүүдийг хөөж Арианаг гэмтээсний төлөө шийтгэсэн. Тэгэхэд түүнийг Азкабан руу илгээсэн. Тэр ямар учраас үүнийг хийснээ хэлээгүй болохоор ид шидийн яам Арианад юу тохилдсоныг мэдээгүй. Хэрвээ тэгсэн бол түүнийг бол гэгээн Мунгогын эмнэлэгт үүрд хорих байлаа. Тэр үүнийгээ барьж чадахаа болиод ид шид дэлбэрэн гарах үеэр өөрийгөө хянаж чаддаггүй байсан учир олон улсын шидтэнгүүдийн нууцлалыг зөрчсөн ноцтой аюул заналхийлж байсан юм.

- Бид түүнийг аврахын тулд нуух хэрэгтэй байлаа. Иймээс өвдсөн гэсэн цуу тараасан юм. Ээж охиноо тайван амьдруулахын тулд тэндээс явсан.

- Ариана надад бүхнээс илүү хайртай байсан гээд Аберфортын үрчгэр сахалтай царайд өсвөр насны хүүгийн дүр тодорч,

- Альбусд биш ... тэр гэртээ байх үедээ үргэлж өрөөндөө сууж ном уншиж шагналаа тоолон цаг үеийнхээ хамгийн алдартай шидтэнгүүдтэй захидлаар харилцдаг байсан гээд тургилав.

- Тэр түүн рүү хэзээ ч очиж байгаагүй. Харин би түүний хайртай ах байсан.

Ээжийг чаддаггүй байхад зөвхөн би л түүнийг хоол идүүлэхээр ятгаж чаддаг байлаа. Би түүнийг уурсан хилэгнэсэн үед нь тайвшруулж дараа нь надад ямаа тэжээхэд тусалдаг байв.

- Харин дараа нь арван дөрвөн нас хүрэх үед нь ... Ойлгож байна уу, би гэртээ байгаагүй. Би тэнд байсан бол түүнийг тайвшируулж чадах байсан. Түүний ээлжит уур хилэн дэгдэх үеэр ээж тийм ч залуу биш болсон болохоор ... золгүй явдал тохилдсон юм. Ариана үүнийг санаатай хийгээгүй. Гэхдээ ээж нас барсан даа.

Харрид өрөвдөх жигших сэтгэл холилдон төрөв. Тэр цааш яриаг сонсохыг хүссэнгүй ч Абефорт үргэлжлүүлэн ярьсар байсан тул хөгшин сүүлийн удаа энэ тухай хэзээ ярьсан бол гэж өөрөөсөө асуулаа.

- Тиймээс Альбус Элфиас Дожтой дэлхийг тойрсон аялал хийж чадаагүй. Тэд хамтдаа ээжийн оршуулга дээр хамт ирээд Дож явсан хойно Альбус гэрийнхээ гол хүн болон үлдсэн юм. Ха! гээд Аберфорт гал руу нулимлаа.

- Би түүнд надад сургууль хамаагүй гэртээ үлдэнэ гэж хэлсэн юм. Гэтэл тэр ээжийг орлож байгаа болохоор намайг заавал сургуулиа төгсөх ёстой гэсэн. Мэдээж манай гоц авъяастаны хувьд хагас галзуу дүүгээ өдөр бүр гэр дэлбэлчих вий гэж харж байхад шагналын тухай бодолтгүй байлаа. Гэхдээ үүнээс хэдхэн долоо хоногийн дараа ... тэр ирсэн гээд Аберфортын нүүр аймшигтай болов.

- Гриндевальд. Ингэж л эцэст нь миний ах өөртэйгээ эн тэнцүү хөршийн гялалзсан авъяастай хүүтэй уулзсан юм даа. Тэд Арианаг ардаа суулгаад шидтэнгүүдийн бүлэг байгуулах төлөвлөгөө зохиож, Үхлийн шүтээн болон өөр бусад сонирхолтой зүйлсийг эрэн хайдаг байлаа. Бүх шидтэнгүүдийн сайн сайхны төлөө агуу төлөвлөгөө байсан! Ганц дүү охиноо харж чаддаггүй Альбус аугаа их сайн сайхны төлөө хөдөлмөрлөх юм гэнэ?

- Гэвч хэдэн долоо хоногийн дараа би үүнийг хангалттай гэж үзсэн юм. Би Хогвартс руу буцах болсон болохоор яг л чам шиг нүүр тулан харж байгаад түүнд хэлсэн гээд Аберфорт Харри руу ахдаа хандаж байснан өсвөр насны хүүгийн хилэнтэй царайгаар харлаа.

- Би түүнд энэ бүхнийгээ дуусга гэж хэлсэн. Би түүнийг гэрээс гаргаж болохгүй хийхээр төлөвлөж байгаа ухаалаг яриандаа бүү орооцолдуул гэсэн. Гэтэл түүнд энэ таалагдаагүй гээд Аберфортын нүдний шил галын дөлөнд гялалзсанаа ахин сохор мэт цагаан болов.

- Гриндевальдад ч гэсэн энэ таалагдаагүй. Тэр уурласан. Тэр намайг гялалзсан ахынхаа зам дээр тээг болсон тэнэг хүү гэж хэлсэн ... Гэсэн ч би тэд ертөнцийг өөрчилж шидтэнгүүдийг тэргүүлэн маглуудыг байх ёстой байранд нь тавихад миний хөөрхий дүү цаашид нуугдсан хэвээр байх эсэхийг ойлгоогүй.

- Дараа нь тэр өөр зүйл хэлэхэд ... би саваагаа авахад тэр өөрийнхийгөө авч ахын минь хамгийн сайн найз надад Круциатус шившлэг илгээсэн юм. Альбус

түүнийг зогсоохыг оролдон бид гурвыг тэмцэлдэж байх зуур гэрэл гялсхийн Арианаг оноход үүнийг тэсэн гарч чадаагүй гээд Аберфортын нүүр үхлийн шарх олсон мэт зовж шаналсан төрхтэй болов.

- Тэр магадгүй туслахыг хүсээд юу хийж байгаагаа ойлгоогүй байх. Бидний хэн байсныг мэдээгүй ч энэ хэн нь ч байж болох байлаа ... тэр унаад үхсэн.

Түүний сүүлчийн үг хоолойн дээр нь тээглэн цахиртсанаа ойролцоох сандал дээр лагхийн суув. Гермионагийн нүүр нулимсанд норж, Рон Аберфорт шиг зэвхий царайлжээ. Харри жигшиж зэвүүцсэндээ үүнийг толгойноосоо гарган хаяж хэзээ ч сонсоогүй байгаасай гэж хүслээ.

- Надад ... их харамсалтай байна гэж Гермиона шивнэлээ.

- Тэр үүрд явсан гэж Абефрорт сөөнгөтөөд хамраа ханцуйгаараа арчин хоолой засан ханиалгав.

- Мэдээж Гриндевальд зугтахаар яарсан. Тэр хэдийн төрсөн нутаг руугаа яваад Арианад юу тохиолдсоныг мэдэхийг хүсээгүй. Альбус хүсч байсан эрх чөлөөгөө авсан, тийм биз дээ? Хүзүүнээсээ чулуу шиг зүүгдэж байсан дүүгээсээ чөлөөлөгдөж агуу их шидтэний бүгийн сайн сайхны төлөө зам нь чөлөөтэй болсон юм даа ...

- Тэр хэзээ ч чөлөөтэй болоогүй гэж Харри хэллээ.

- Чи юу хэлэв? гэж Аберфорт асуулаа.

- Хэзээ ч. Таны ах үхдэг шөнөө ой ухаанд нөлөөлдөг шингэн уусан юм. Тэгээд хашгиран ёолж дэргэдээ хэн нэгэн байгаа юм шиг маргаж байсан. Тэдэнд бүү хүр, чамаас гуйя ... Оронд нь намайг цохьсон нь дээр.

Рон, Гермиона хоёр Харри руу нүдээ томруулан ширлээ. Тэр хэзээ ч нуурын дундах арал дээр болсон зүйлийн тухай тодорхой ярьж байсангүй. Дамблдорын хамт Хогвартсад буцаж ирсний дараа болсон явдал нам гүм болсон билээ.

- Түүнд ахин Гриндевальд болон та нартай хамт байгаа юм шиг санагдсаныг мэдэж байна гээд Харри ахин Дамблдорын цөхөрсөн гуйлтыг сонслоо.

- Түүнд Гриндевальд Арианаг гэмтээхийг харж байгаа юм шиг санагдсан ... Энэ түүний хувьд тамлал байсан. Хэрвээ та түүнийг тэр үед харсан бол чөлөөлөгдсөн гэж хэлэхгүй л байсан даа.

Аберфорт судас нь гүрийсэн гараа бодлогоширон харав. Тэгснээ удаан хугацааны дараа,

- Поттер хаанаас миний ах чамд бүх нийтийн их сайн сайхнаас анхаарал хандуулаагүй гэдэгт итгэлтэй байгаа юм бэ? Чи хаанаас түүнд миний жижигхэн дүү шиг онцын хэрэггүй биш байсан гэдгээ мэдэж байгаа юм бэ? гэлээ.

Харрийн зүрхийг мөсөн зүүгээр хатгуулах мэт болов.

- Би үүнд итгэхгүй байна. Дамблдор Харрид хайртай байсан гэж Гермиона хэллээ.

- Тэгвэл яагаад нуугдахыг тушаагаагүй юм бэ? Яагаад амьд үлдэхийн тулд аврагд гэж хэлээгүй юм бэ? хэмээн Аберфорт палхийтэл хэлэв.

- Яагаад гэвэл заримдаа зөвхөн аврагдах тухай бодох хэрэггүй байдаг юм! Заримдаа бусдын сайн сайхны төлөө бодох хэрэгтэй байдаг юм! Бид дайнд байна гэж Харри Гермионагаас урьтаж дуугарав.

- Чи арван долоон настай, хүү минь!

- Бид насанд хүрсэн болохоор таныг бууж өгсөн ч цаашид тэмцэх болно.

- Хэн чамд намайг бууж өгсөн гэж хэлсэн юм?

- Би түүнд байсан. Гэвч Фениксийн бүлгэм байхгүй болсон. Хэцүү нэрт ялж тэмцэл дуусан хэнд ч өөрийгөө хуурах хэрэг байхгүй болсон гэж Харри давтлаа.

- Би таалагдаж байна гэж хэлээгүй ч энэ бол үнэн.

- Үгүй ээ, энэ худал. Таны ах Хэцүү нэртийг яаж дуусгахаа мэдэж байсан болохоор надад үүнийг хэлсэн юм. Би амжилтанд хүрэх юмуу үхэх хүртлээ цаашид тэмцэх болно. Энэ бүхэн яаж дуусахыг мэдэхгүй ч тэр талаар бодохыг хүсэхгүй байна. Би олон жил үүнийг мэдэж байсан.

Тэр Аберфорт инээх юмуу маргахыг хүлээсэн ч чимээгүй болоод ууртай хөмсгөө өргөв.

- Бид Хогвартс руу нэвтрэх хэрэгтэй байна. Хэрвээ та бидэнд тусалж чадахгүй бол гэгээ орохоор яваад өөрсдөө замаа эрж олох болно. Хэрвээ та туслаж чадах бол одоо яг л үүнийг хэлэх мөч ирээд байна.

Аберфорт хөдөлгөөнгүй суусан хэвээр Харри руу ширтэхэд ахтайгаа туйлын адилхан харагдав. Тэр эцэст нь ханиалгаад босож ширээ тойрон явснаа Арианагийн хөргийн өмнө зогсоод,

- Чи юу хийхээ мэдэж байгаа гэж хэлэв.

Ариана инээмсэглээд цааш эргэхдээ ердийн хөргөнүүдийн адилаар жаазнаасаа гарах биш урт сунасан хонгилоор зурагны гүн руу явлаа. Тэд зогсоод харанхуй хэрхэн дүрсийг залгихыг харав.

- М-м ... юу ... гэж Рон хэлэв.

- Шилтгээн рүү орох ганц л арга бий. Та нар мэдээж бүх нууц хонгил гарцууд хаалттай үүдэн дээр нь Дементоруудыг тавьж сургуулийн дотор жижүүрүүд холхиж байгаа гэдгийг мэднэ. Хогвартс хэзээ ч ийм хамгаалалттай байсангүй. Бас захирал ... Снегг орлогч нь Кэрроу нар байгаа ... За яахав энэ ч таны нарын хэрэг л дээ. Чи үхэхэд бэлэн гэж хэлсэн биз дээ.

- Гэхдээ ... гээд Гермиона Арианагийн хөрөг рүү харлаа.

Зурагны үзүүрийн хонгилоос жижигхэн цагаан цэг гарч ирэн Ариана буцаж ирэв. Тэр одоо ганцаараа биш хэн нэгэн доголон өндөр хүнтэй ирж байсан бөгөөд ойртох тусам улам өсөн томорч байлаа. Харри хэзээ ч тийм урт үс харж байсангүй. Хоёр дүрс томрох тусам жаазанд нүүр мөр дүүрэн гарч ирэв. Тэгтэл зураг ханан дахь хаалга мэт нээгдэж жинхэнэ хонгил гарч ирлээ. Тэндээс үс нь урт ургасан шархтай царай, урагдсан хувцастай жинхэнэ Невилл Долгопупс хөөрөн гарч ирээд Харри руу ухасхийн,

- Би чамайг ирнэ гэдгийг мэдэж байсан юмаа! Би мэдэж байсан, Харри! гэж хашгирлаа.

БҮЛЭГ 29: АЛДАГДСАН ТИТЭМ

- Невилл ... хаанаас ... яаж ...

Гэвч Невилл Рон, Гермиона хоёрыг хараад баяртайгаар уулга алдан тэврэхээр ухасхийв. Түүний төрх байдал аймшигтай байлаа. Нэг нүд нь том хөхөрч шарлан, нүүр нь битүү сорви болж бүхий л төрх байдлаараа гай зовлонгоос гарч ирснийг илтгэнэ. Гэсэн ч түүний царайны өнгө жаргалтайгаар гийж Гермионаг тэвэрснээ ахин,

- Би чамайг ирнэ гэдгийг мэдэж байсан юм. Үргэлж Симусд хүлээх хэрэгтэй гэж баталдаг байлаа! гэв.

- Невилл чамд юу тохиолдоо вэ?

- Юу? Аан энэ үү? гээд Невилл шархтай толгойгоо хайхрамжгүй савчив.

- Энэ юу ч биш! Симус үүнээс долоон дор харагдаж байгаа. Та нар харна аа. За явцгаах уу гэснээ Аберфорт руу эргэж,

- Өө, ийшээ өөр хоёр гурван хүн ирнэ шүү гэлээ.

- Хоёр гурав гэнээ? хэмээн Аберфорт унтуулан давтсанаа,

- Хоёр гурав гэдэг чинь юу гэж байгаа юм, Долгопупс? Энд одоо хөл хорионы цагаас болоод аваарын шившлэг тосгон даяар тавиастай байна гэв.

- Би мэднэ. Ийм болохоор тэднийг шууд танай баарны урд шилж гэж хэлсэн юм. Тэднийг шууд хонгил руу явуулаарай за юу? Их баярлалаа.

Невилл Гермионагийн гараас барин ханан зуухан дээр гарч хонгил руу авирахад туслав. Түүнээс араас Рон ороход, Невилл дагалдав. Харри Аберфорт руу эргэлээ.

- Таньд яаж талархахаа ч мэдэхгүй байна. Та бидний амийг хоёр удаа аварлаа.

- Тэгвэл ирээдүйд болгоомжтой байгаарай. Гурав дахь удаагаа бүтэхгүй байх шүү гэж Аберфорт бувтнав.

Харри ханан зуухан дээр авиран гараад Арианагийн хөрөгний нүх рүү ороход нөгөө талд гөлгөр чулуун гишгүүр байв. Харваас гарц энд олон жилийн өмнөөс байсан бололтой хананд зэс лааны тосгуур суурилуулж, шороотой шал нь мөлийн дагтаршчээ. Тэд сүүдэрт хана даган явлаа.

- Энэ гарц хэдийнээс байсан юм бол? Тэнүүлчний газрын зураг дээр байхгүй биз дээ, Харри? Би ердөө сургуулиас гарах долоон нууц гарц байдаг гэж бодсон юмсан хэмээн Рон хэлэв.

- Тэд бүгдийг нь хичээлийн жил эхлэхээс өмнө хаасан болохоор одоо тэднээр нэвтрэх боломжгүй болсон. Гарцыг шившлэгээр хамгаалж үүдэн дээр нь Үхэл залгигч болон Дементорууд байгаа гээд Невилл баясан гийсэн царайгаар эргэж харснаа,

- Гэхдээ энэ чухал биш ... Та нар Гринготтсыг дээрэмдсэн гэсэн үнэн үү?

Тэндээс луугаар зугтсан юм уу? Одоо хаа сайгүй бүгд энэ тухай ярьж байна. Кэрроу Терри Бутыг Их танхимд оройн хоолны үеэр энэ тухай хашгирсаных нь төлөө шийтгэсэн! гэв.

- Тиймээ энэ үнэн гэж Харри хэллээ. Невилл баярлан инээмсэглэв.

- Та нар луугаа яасан юм?

- Гермиона түүнийг тэжээхийг хүссэн ч сул тавьсан гэж Рон хэлэв.

- Хэтрүүлэх хэрэггүй дээ, Рон ...

- Харин та нар энэ хугацаанд юу хийж байв даа? Та нарыг зүгээр л нуугдаж байсан гэж ярьцгааж байгаа ч би тэгж бодохгүй байна, Харри. Та нарт төлөвлөгөө байсан байх.

- Чиний зөв. Гэхдээ эхлээд Хогвартсын тухай ярианч, Невилл. Бид энэ талаар мэдэх юм юу ч алга.

- Хогвартс ... Урьдын Хогвартстай төсгүй болсон гээд Невиллийн нүүрэн дээрх инээмсэглэл алга боллоо.

- Та нар Кэрроугын тухай сонссон уу?

- Энд багшилж байгаа хоёр Үхэл залгигч биз дээ?

- Тэд зөвхөн багшилдаггүй юм. Тэд бүхий л шийтгэлийг оноодог. Эдгээр

Кэрроунууд шийтгэлд дуртай.

- Амбриж шиг үү?

- Амбриж тэдний дэргэд тэжээвэр хонь л гэсэн үг. Үлдсэн багш нар Кэрроуд бидний алхам бүрийн талаар илтгэж байх ёстой. Гэхдээ тэд үүнийг хийхээс зайлсхийж байгаа. Харваас тэднийг бидэн шиг л үзэн ядаж байгаа биз.

- Харин Амикус урьд нь Хар урлагаас хамгаалах хичээлийг зааж байсан болохоор одоо зөвхөн хар урлагаас хамгаалах хичээл ордог юм. Биднийг хичээлээс хоцорсон хүнд Круциатус шид хэрэглэн сургуулилахыг ...

- Юу?

Харри, Рон, Гермиона гурвын хоолой хонгилд цуурайтав.

- Тиймээ. Ийм учраас л би үүнийг хүртсэн юм гээд хацар дээрх гүн шархаа харуулав.

- Би үүнийг хийхээс татгалзсан. Тэгсэн ч зарим хүмүүс болон Крэбб, Гойл хоёрт их таалагдаж байгаа ... Эцэст нь тэд анх удаагаа бүхнээс түрүүнд орлоо! Амикусын дүү Алекто магл судлалын хичээл зааж одоо заавал орох хичээлийн нэг болсон. Бид маглуудыг амьтан шиг тэнэг бохир болох тухай сонсож шидтэнгүүд удахгүй цаг нь ирэхээр тэднээс нуугдаж байсныхаа хариуг хэрцгийгээр авах тухай сонсдог юм. Харин үүнийг түүнээс ахтайгаа

хичнээн маглын цус урсгасныг асуусныхаа төлөө хүртсэн юм гээд нүүрэн дээрх зүсэгдсэн шархыг заалаа.

- Чөтгөр ав, Невилл! Чи үнэхээр энд хэлээ хазаж байх ёстой гэдгийг ойлгохгүй байна уу? гэж Рон дуу алдав.

- Чи өөрөө түүний яриаг сонссон бол бас тэсэхгүй байсан даа. Гэхдээ тэдэнтэй зөрчилдөх нь ашигтай. Энэ нь бүгдэд найдлага төрүүлдэг. Би чамайг ийм алхам хийдэгийг ажигласан, Харри.

- Гэхдээ тэд чамайг хутга ирлэгч билүү шиг болгож! гэж Рон эсэргүүцээд хурц гэрлийн дор өнгөрөхдөө гэмтлийг нь хараад цочлоо.

Невилл мөрөө хавчив.

- Хамаагүй ээ. Гэсэн ч тэд цэвэр цусны хүмүүсийн цусыг урсгахыг хүсдэггүй болохоор биднийг ам нээсний төлөө багахан тамалж арай алчихгүй байдаг юм.

Харри Невиллийн өөр бусад ямар аймшигтай зүйлс ярихыг мэдсэнгүй.

- Жинхэнэ аюул гэвэл шилтгээний гадаа байгаа найз нөхөд хамаатнуудад нь таагүй явдал тохиолдож байгаа. Тэд барьцааны хүн авдаг болсон. Хөгшин Ксено Лавгуд «Шүүмжлэгч» сэтгүүлд хэтэрхий их зүйл бичсэний төлөө Полумнаг галт тэрэгнээс авч яваад зул сараас хойш ирээгүй байгаа.

- Түүний бүх зүйл хэвийн, Невилл. Бид түүнийг харсан.

- Би мэднэ тэр надад дохио илгээсэн.

Тэр халааснаасаа алтан зоос гарган үзүүлэхэд Харри Дамблдорын армийн мэдээ дамжуулдаг хуурамч алтан зоосыг танилаа.

- Гайхамшигтай эд байгаа юм гээд Невилл Гермиона руу баяртай инээмсэглэж,

- Кэрроу биднийг бие биетэйгээ яаж харьцдагыг хэзээ ч мэдээгүй. Тэд үүний учрыг л олохгүй байгаа юм. Бид шөнөөр ханан дээр «Дамблдорын арми гишүүн элсүүлж байна» гэх мэт бичиг үлдээдэг байсан. Снегг үүнд үхтлээ уурласан даа гэв.

- Байсан гэнэ ээ? хэмээн Харри өнгөрсөн цагт анхаарлаа хандуулан асуулаа.

- Гэсэн ч энэ хүндхэн болж байна. Зул сарын дараа бид Полумнагүй үлдсэн.

Харин улаан өндөгний баярын дараа Жинни эргэж ирээгүй болохоор Кэрроу харваас намайг үүний ард байгааг тааварласан бололтой сүүл даган мөшгөж эхэлсэн. Бас Майкл Корнерыг нэгдүгээр дамжааны сурагчийг гинжнээс сулласаны төлөө барьсан. Түүнийг хүмүүсийг айлгахын тулд их хэрцгий тамласан даа.

- Үгүй ер хэмээн Рон хэвгий газар өгсөж эхлэхдээ бувтналаа.

- Би хүмүүсийг Майкл шиг болгохыг хүсээгүй болохоор энэ зүйлээ хаясан.

Гэсэн ч бид тэмцлээ үргэлжүүлсээр хоёр долоо хоногийн өмнө нууц байдалд

шилжсэн. Тэгэхэд л тэд намайг зогсоох цорын ганц арга бол эмээ рүү очих явдал гэж шийдсэн юм билээ.

- Тэд яасан гэнээ хэмээн? гэж Рон, Харри, Гермиона гурав зэрэг асуулаа.

- Тиймээ гээд Невилл хонгил огцом өгсөхөд үл мэдэг амьсгаадаж,

- Гэхдээ тэдний бодлыг хялбархан ойлгож болно. Хамаатнуудыг нь барьцаалах нь маш сайн үйлчилэх юм шиг санагдсан ч эсрэгээрээ эргэсэн дээ. Тэд эмээг дутуу тооцоолсон. Хөгшин шидтэн ганцаар амьдарч байсан болохоор ... тэд харваас онцгой хүч хэрэггүй гэж бодсон юм билээ. Тэгсэн ч гээд тэдэн рүү эргэхэд Харри царай дээрх инээмсэглэлийг нь хараад гайхлаа.

- Долиш одоо гэгээн Мунгогын эмнэлэгт хэвтэж байгаа харин эмээ зугтсан. Тэр надад захиа илгээж эцэг эхийнхээ жинхэнэ хүү болоход минь бахархаж байна гэсэн! гээд түнтгэр халаасаа алгадлаа.

- Янзтай гэж Рон хэлэв.

- Тиймээ гэж Невилл хөгжилтэй хэлээд,

- Тиймээс тэд намайг дарах цорын ганц арга бол Хогвартсыг надгүй болгох явдал гэдгийг ойлгосон юм билээ. Тэд намайг Азкабан руу илгээх юмуу эсвэл алах байсныг мэдэхгүй байгаа ч би тухайн үед нь ойлгоод зугтчихсан гэв.

- Гэхдээ бид одоо Хогвартс руу яваа биш юм уу? гэж Рон гайхширан асуулаа.

- Тэгэлгүй яахав. Одоохон харна. Бараг ирчихлээ.

Тэд булан тойроод хонгилын төгсгөл рүү эргэв. Үүдэн дээр Арианагийн хөргөнд байсны адил богино хэдэн гишгүүр байлаа. Невилл хаалгыг гадагш нээв. Харри түүний араас өгсөхдөө хэн нэгэнд,

- Хэн ирснийг хараач! Би та нарт хэлсэн биз дээ! гэж хашгирахыг сонслоо.

Харри өгсөөд онгорхой үүдээр ороход баярлаж хөөрсөн хоолой угтав.

- Харри!

- Энэ бол Поттер, Поттер!

- Рон!

- Гермиона!

Түүний өмнө дэнлүүний гэрэлд олон тооны царай жирсхийн үзэгдэв. Дараагийн агшинд хориос доошгүй хүмүүс тэднийг бүчин тэвэрч, нурууг нь алгадан, үсийг нь сөргүүлэн илж, гар барьж байлаа. Энэ нь тэд яг л квиддичийн аварга шалгаруулах тэмцээнд ялаад ирсэн мэт санагдуулна.

- Хөөе хүүхдүүдээ, чимээгүй! гэж Невилл хашгирахад хүүхдүүд ухран Харрид эргэн тойрноо харах боломж олгов.

Өрөө үл таних бөгөөд аварга том байдлаараа гоёмсог модон урц юмуу хөлөг онгоцны бүхээгийг санагдуулах аж. Адраас өнгө бүрийн дүүжин ор дүүжилж, цонхгүй хар модоор доторлосон хананд тод өнгийн зураг өлгөжээ. Харри улаан

өнгийн дэвсгэр дээр Гриффиндорын сүлд болох алтан арслан, шаргал дэвсгэр дээр Пуффендуйн хар дорго, цэнхэр дэвсгэр дээрх Когтевраны хүрэл бүргэд нарыг харлаа. Энд Слизерины мөнгөлөг ногоон өнгө байсангүй. Бас битүү номын тавиур

байрлуулан, хэдэн шүүр хана түшүүлэн тавиад, буланд том модон хайрцагтай радио байлаа.

- Бид хаана байна?

- Мэдээж Шаардлагатай өрөөнд! Хэтрүүлсэн биш байгаа биз дээ? Кэрроу намайг ангуучилж эхлэхэд би аврагдах цорын ганц арга байгааг ойлгосон юм. Би ийшээ ирээд хаалга руу орсон! Мэдээж намайг ороход одооных шигээ биш хамаагүй жижигхэн ердөө ганц дүүжин ор, Гриффиндорын сүлд байсан юм. Гэсэн ч одоо Дамблдорын армид шинэ гишүүд нэмэгдсэн болохоор улам том болсон доо.

- Кэрроу ийшээ орж чадахгүй юу? гээд Харри үүд рүү харлаа.

- Үгүй гэж Симус Финниган хэлэхэд Харри түүний хавдаж хөхөрсөн царайнаас уруул нь хөдөлж байгааг ялган харж чадсангүй.

- Энэ бол жинхэнэ нуугдах газар байгаа юм. Зөвхөн биднийг дотогш нь оруулдаг өөр хэнийг ч нэвтрүүлдэггүй. Бүгдэд нь Невиллд баярлалаа. Тэр энэ өрөөг жинхэнэ утгаар нь ойлгодог юм. Энд хэрэгтэй зүйлээ тодорхой гуйхад л болно. Жишээлбэл «Кэррог дэмждэг хэнийг ч оруулахыг хүсэхгүй байна» гэх мэт хүссэнээр чинь хийх болно. Хамгийн гол нь ямар ч нэг нүх сүв үлдээж болохгүй! Невилл сайн байна!

- Үүнд ямар онцгой зүйл байхгүй гэж Невилл даруухан хэлээд,

- Би энд хагас өдөр байсан болохоор аймшигтай өлсөөд хаа нэгтээгээс идэх юм олохыг хүссэн юм. Тэгтэл «Гахайн толгой» орох гарц нээгдэн би түүгээр яваад Аберфорттой уулзсан. Тэр биднийг хоолоор хангадаг яагаад гэвэл энэ өрөөний цорын ганц хийж чадахгүй зүйл учир гэв.

- Яагаад гэвэл хоол хүнс Гэмпийн хувиргалын үндсэн таван хуулийн нэгд багтдаг болохоор гэж Рон бүгдийг мэл гайхуулан хэлэв.

- Иймээс л бид энд хоёр долоо хоног нуугдаж байгаа юм. Хэрвээ бидэнд шинэ дүүжин ор хэрэг болвол тэнд бий болно гэнэтхэн жорлон юмуу халуун усанд ормоор санагдвал ...

- Бас зүгээр л угаахыг хүсвэл зөвхөн бодоход л болно! гэж Лаванда Браун дэмжихэд Харри түүний байгааг сая л анзаарлаа.

Тэр одоо л эргэн тойрноо хараад олон танил царайгаа олж харлаа. Энд ихэр хоёр

Патил, Терри Бут, Эрни Макмиллан, Энтони Голдстейн, Майкл Корнер нар байв.

- За юу тохиолдсоноо яриад байгаарай. Та нарын тухай олон цуу яриа дэгдсэн болохоор бид «Поттерийн цаг»-ийг сонсохыг хичээж байлаа. Та нар Гринготтсыг дээрэмдээгүй биз дээ? гэж Эрни хэлээд радио руу заалаа.

- Дээрэмдсэн. Бас лууны хувьд үнэн! гэж Невилл хашгирлаа.

Чанга алга таших болон «ура!» хашгирах чимээ гарахад Рон бөхийн ёслов.

- Та нар тэндээс юугаа авааа вэ? гэж Симус сониучирхан асуулаа.

Гэвч тэднийг асуултанд хариулж амжихаас урьд Харрийн сорви аймшигтай өвдлөө. Тэр хөгжилтэй сонирхсон царайнуудаас яаран эргэтэл Шаардлагатай өрөө алга болж нурсан оромжин дотор зогсоод өмхөрсөн тоостой шалан дээр хоосон алтан хайрцаг таг нь онгорхой хэвтэхийг харж Волдемортын уур хилэнтэй хоолой толгойд нь цуурайтав.

Тэр ихээхэн хүч чармайлт гарган байж Волдемортын бодлоос гараад Шаардлагатай өрөөнд эргэн ирэхэд Роноор дэмжүүлэн зогсоод ганхаж байлаа.

- Чи зүгээр үү, Харри? Суух уу? Ядарсан байх тийм үү? гэж Невилл асуулаа.

- Үгүй гээд Харри Рон, Гермиона хоёр руу харж чимээгүйхэн Волдеморт ээлжит крестражаа алга болсныг мэдсэнийг ойлгуулахыг мэрийв. Цаг тун бага үлджээ. Хэрвээ Волдеморт одоо Хогвартс руу ирэхээр шийдвэл тэдэнд боломж байхгүй болно.

- Бид явах хэрэгтэй байна гэж найзуудынхаа ойлгосон царайг хараад хэллээ.

- Бид юу хийх ёстой вэ, Харри? Чамд төлөвлөгөө байна уу? гэж Симус асуулаа.

- Төлөвлөгөө гэнээ? хэмээн Харри өөрийн мэдэлгүй давтаад Волдемортын уур хилэнд ахин автахгүйг хичээхэд духан дээрх сорви нь халуун шатан өвдлөө.

- Ер бол Рон, Гермиона бид гурав нэг зүйл хийх хэрэгтэй байгаа болохоор явах хэрэгтэй байна.

Одоо хэн ч ура хашгирсангүй. Невилл будилсан шинжтэй харагдав.

- Явах хэрэгтэй гэдэг чинь юу гэж байгаа юм?

- Бид энд үлдэхийн тулд эргэж ирээгүй. Бидэнд хийх өөр чухал ажил бий ... гээд Харри сорвиныхоо өвдөлтийг намдаахын тулд илэв.

- Ямар?

- Би ... би та нарт хэлж чадахгүй.

Чанга гүнгэнэх чимээ гарав. Невилл хөмсгөө өргөлөө.

- Яагаад бидэнд хэлж чадахгүй гэж? Хэцүү нэртийн эсрэг тэмцлийн зүйл биз дээ?

- Тийм л дээ ...

- Тэгвэл бид чамд туслая.

Дамблдорын армийн зарим нэг гишүүд толгой дохиход үлдсэн нь урам зоригтойгоор хөөрөн догдлов. Тэдний хоёр нь даруйхан үйл явдалд оролцоход бэлнээр сандал дээр үсрэн гарлаа.

- Чи ойлгосонгүй гэж Харри сүүлийн үед энэ үгийг хэтэрхий олон давтан хэлээд,

- Бид ... бид та нарт хэлж чадахгүй. Бид үүнийг ... өөрсдөө биелүүлэх ёстой гэв.

- Яагаад? гэж Невилл асуув.

- Яагаад гэвэл ... гээд Харри цөхрөн хараад Рон, Гермиона хоёртой крестражыг хаанаас эрэх талаараа тусдаа ярихыг хүслээ. Сорви төөнөн өвдөж байсан учир бодлоо төвлөрүүлэхэд амаргүй байв.

- Дамблдор бид гуравт нэг ажил үлдээсэн. Тэгээд хэнд ч хэлэхгүй байхыг хүссэн юм ... Түүнийг зөвхөн бидэнд даалгасан гэж болгоомжтой хэлэв.

- Бид бол Дамблдорын арми. Бид бүгд хамтдаа байж та нартай цуг явна.

- Энэ бол ердийн нэг зугаалга биш гэж Рон хэлэв.

- Би ерөөсөө тэгж хэлээгүй байна. Бас яагаад бидэнд итгэхгүй байгааг чинь ойлгохгүй байна. Энэ өрөөнд байгаа хүн бүр Кэрроугын эсрэг тэмцэж буй учир байгаа. Бидний хэн ч Дамблдорт үнэнчээ баталсны адил ... чамд үнэнч зүтгэх болно, Харри.

- Бодоод үз л дээ гэж Харри эхэлсэн ч юу хэлэхээ мэдсэнгүй. Гэсэн ч энэ чухал биш байлаа. Хонгилын хаалга ард нь нээгдэв.

- Бид чиний дохиог авсан, Невилл! Сайн уу би та гурвыг энд байгаа гэж бодож байлаа!

Энэ бол Полумна, Дин хоёр байв. Симус баяртай хашгиран сайн андаа тэвэрлээ.

- Бүгдээрээ сайн байцгаана уу! Эргэж ирэх чинь ямар сайхан юм бэ! гэж

Полумна хөгжилтэй хэлэв.

- Полумна чи энд юу хийж байгаа юм? Чи яаж ... гэж Харри түгшин асуулаа.

- Би түүнд мэдээ илгээсэн юм гээд Невилл хуурамч зоосыг өндөр өргөж,

- Бас Жиннид чамайг ирэх юм бол дуудна гээд амалчихсан. Бид нар бүгд чамайг ирэхэд томоохон хувьсгал болно гэж бодож байлаа. Тэр үед бид Снегг, Кэрроу хоёрыг түлхэн унагах болно гэв.

- Мэдээж тийм шүү дээ. Тийм биз дээ, Харри? Бид одоо тэднийг Хогвартсаас хөөх үү? гэж Полумна хөөрцөглөн хэлэв.

- Сонсоцгоо ... гээд Харри улам бухимдлаа.

- Надад их харамсалтай байгаа ч бид үүний төлөө ирээгүй. Бид хийх ёстой ажлаа гүйцээгээд дараа нь ...

- Та нар биднийг энд хаяад явах нь уу? гэж Майкл Корнер шаардав.

- Үгүй! Бидний хийхийг хүсэж байгаа ажлын эцэст Хэцүү нэртээс салах болохоор бүгдэд ашигтай ... гэж Рон дуу алдлаа.

- Тэгвэл чи биднийг туслуулахаар ав! Бид ч гэсэн оролцохыг хүсэж байна! гэж

Невилл ууртай хашгирав.

Ард нь шинэ шуугиан дэгдэхэд Харрийн зүрх палхийв. Одоо ханын нүхээр Жинни болон Фред, Жорж, Ли Жордан нар орж ирлээ. Жинни Харри руу нүд гялбам

инээмсэглэлээ. Тэр түүний ийм үзэсгэлэнтэй гэдгийг урьд нь анзаараагүй юмуу эсвэл мартсан бололтой гэсэн ч хэзээ ч харахад ийм таатай байсангүй.

- Аберфорт уурлаж эхлэж байна. Тэр унтахыг хүсэж байхад баарыг нь төмөр замын буудал болгон хувиргалаа гэсэн хэмээн Фред хэлээд мэндэлсэн дунд хариулан гараа даллалаа.

Тэгтэл Ли Жорданы араас түүний найз охин байсан Чжоу Чанг гарч ирээд инээмсэглэхэд Харри амаа ангайлаа.

- Би мэдээг авсан гээд тэр хуурамч зоосоо үзүүлэн Майкл Корнерийн дэргэд суулаа.

- За ямар төлөвлөгөөтэй байна, Харри? гэж Жорж асуув.

- Үгүй дээ, ямар ч төлөвлөгөө байхгүй гэж Харри энэ бүх хүмүүсийн гэнэтийн ирэлт хөл үймээн болон сорвиныхоо өвдөлтийг тэвчих хүчгүй болоод хэллээ.

- Тэгвэл бид төлөвлөгөө боловсруулах уу? Би үүнд ямар дуртай гээч! хэмээн

Фред хэлэв.

- Сонс энэ бүхнээ зогсоо! Чи яах гэж тэднийг ийш нь дуудаа вэ? Энэ чинь ухаангүй хэрэг гэж Харри Невиллд хэллээ.

- Бид одоо дайтна биз дээ? гээд Дин хуурамч зоосоо гаргаад,

- Харри ирсэн мэдээ ирмэгц л бид тэмцэхээр гарсан! Би шидэт саваагаа авах гэсэн ч ...

- Чиний саваа байхгүй болоо юу? гэж Симус гайхав. Рон гэнэтхэн Харри руу эргэлээ.

- Тэд яагаад тусалж чадахгүй гэж?

- Юу?

- Тэд бидэнд тусалж чадна гээд тэр дуугаа намсгаад,

- Бид түүнийг хаана байгаа гэдгийг мэдэхгүй ч түргэн олох хэрэгтэй байна.

Гэхдээ бүгдэд крестраж гэдгийг нь заавал хэлэх албагүй гэв. Харри Гермиона руу хартал,

- Би Роны зөв гэж бодож байна. Бид эрж байгаа зүйлээ ямар болохыг нь ч мэдэхгүй байгаа болохоор тусламж хэрэгтэй. Чи заавал бүх зүйлийг ганцаараа хийх албагүй, Харри гэж түүний дурамжхан өнгийг хараад нэмэрлэв.

Харри толгой ангалзан сорви нь хатгуулан өвдөж байсан ч хүчлэн бодлоо. Дамблдор түүнд крестражын тухай Рон, Гермиона хоёроос өөр хүнд хэлж болохгүй гэж анхааруулсан. Нууцлах болон хууран мэхлэлт дунд бид өссөн. Альбус үүнд төрөлхийн авъяастай. Тэр Дамблдор шиг бусдад итгэхээс айгаад цээжиндээ нууцаа хадгалах

гэж үү? Гэсэн ч Дамблдор Снеггэд итгээд юу боллоо доо? Хамгийн өндөр цамхагийн орой дээр алагдсан биз дээ ...

- За яахав. Сайн байна гээд Харри өрөөнд байсан хүмүүс рүү хандахад чимээгүй боллоо. Фред, Жорж хоёр ойролцоох хүмүүстэйгээ тоглон наргиж байснаа болиод бүгд догдлон харлаа.

- Бид нэг зүйлийг олох хэрэгтэй байна. Хэцүү нэртийг ялахад туслах ... нэг зүйл байгаа юм. Тэр энд Хогвартсад байгаа ч хаана байгааг нь мэдэхгүй байна. Тэр Кандида Когтеврантай холбоотой байх боломжтой. Түүнтэй холбоотой зүйлийн тухай сонссон хүн үү? Жишээлбэл бүргэдийн дүрстэй зүйл ч юмуу?

Тэр Когтеварчуудын жижигхэн бүлэг болох Падма, Майкл, Терри, Чжоу нар руу найдангуй харсан ч зөвхөн Жиннигийн сандлын бариул дээр сууж байсан Полумна хариулав.

- Түүний титэм алдагдсан. Би түүний тухай чамд ярьж байсаныг санаж байна уу, Харри? Кандида Когтевраны титэм алдагдсан. Аав түүний хуулбарыг нь хийх гэж байсан юм.

- Тиймээ гэхдээ титэм алга болсон, Полумна ... тэр алга болсон. Үүнд л учир нь байгаа юм гээд Майкл Корнер нүдээ эргэлдүүлэв.

- Тэр хэзээ алга болсон юм? гэж Харри асуулаа.

- Олон зууны өмнө гэж Чжоу хариулахад Харри сэтгэлээр уналаа.

- Профессор Флитвик түүнийг Кандидатай цуг алга болсон гэж ярьдаг юм.

Титэм алга болоод ямар ч ул мөр үлдээгүй. Эсвэл би эндүүрээд байна уу? гээд

Когтевранчууд руу харлаа. Бүгд толгойгоо сэгсрэв.

- Уучлаарай ямархуу титэм юм дээ? гэж Рон асуув.

- Титэм шиг л титэм. Кандида Когтевраны титэм шидийн хүчийг агуулдаг болохоор түүнийг өмссөн хүн цэцэн мэргэн болдог гэж ярьцгаадаг гэж Терри Бут хэлэв.

- Тиймээ. Тархи сатааруулагчыг гаргах хоолойг аав ... Гэсэн ч Харри Полумнад ярих боломж өгсөнгүй.

- Та нарын хэн нэг чинь түүнтэй төстэй зүйл харж байсан уу?

Бүгд ахин толгой сэгсэрлээ. Харри Рон, Гермиона хоёрын харцанд цөхрөл илрэхийг харав. Титэм эрт цагт ул мөргүй алга болсон болохоор шилтгээнд крестражаар нуусан байх магадлал бага байлаа ... Гэсэн ч түүнийг дараагийн асуултаа бодож амжихаас урьд ахин Чжоугын хоолой сонсогдов.

- Хэрвээ энэ ямар болохыг харахыг хүсч байвал би чамайг зочны өрөөндөө аваачиж үзүүлье, Харри. Тэнд Кандидагийн хөшөөний толгой дээр титэм байдаг юм.

Харрийн сорви ахин өвдөхөд Шаардлагатай өрөө нүдний өмнө агшин зуур алга болж алсад харанхуй газар жирэлзэн мөрөн дээр нь том могой цагарigласан байлаа. Волдеморт ахин нисэж байсан ч газар дорхи нуур луу юмуу шилтгээн рүү ирж байгаа эсэх нь мэдэгдсэнгүй. Гэсэн хэдий ч хугацаа тун бага үлджээ.

- Тэр замдаа гарсан байна гэж Рон, Гермиона хоёрт аяархан хэлээд Чжоу болон бусад руу харав.

- Сонсоцгоо би титэм ямар болохыг мэдэхийн тулд хөшөөг очиж харах хэрэгтэй байна. Энд намайг хүлээж байгаарай ... ойлгож байгаа биз дээ ... аюулгүй байдлын тулд.

Чжоу явахаар өндийсөн ч Жинни огцом дуугаар,

- Үгүй ээ, Полумна Харриг хүргэж өгнө. Тийм биз дээ, Полумна? гэлээ.

- Өө, тэгэлгүй яахав дуртайяа! гэж Полумна баяртай дуу алдахад Чжоу урам хугаран буцаж суулаа.

- Бид өрөөнөөс яаж гарах вэ? гэж Харри Невиллээс асуув.

- Ийшээ гээд тэр Харри, Полумна хоёрыг булан руу аваачаад огцом шаттай жижигхэн өрөө нээн,

- Асуудал гэвэл гарц дандаа өөр газар нээгддэг болохоор бид байнга олоод байж чаддаггүй. Болгоомжтой байгаарай Харри хонгилд шөнө жижүүрлэж байгаа шүү гэлээ.

- Зүгээр дээ. Удахгүй уулзая, Невилл.

Полумна тэр хоёр яаран бамбарын гэрэлтэй урт шатаар өгсөөд буланд гарч ирэв. Эцэст нь тэд хатуу хананд хүрлээ.

- Ийшээ ор гэж Харри Полумнад хэлээд үл үзэгдэх цуваа гарган хоёулаа нөмөрлөө. Дараа нь ханыг хөнгөхөн түлхэв.

Тэднийг хүрмэгц хана хайлан алга болоход гадагш гарав. Харри хана буцан байрандаа орохыг харлаа. Тэд харанхуй хонгид зогсож байв. Харри хүзүүндээ зүүсэн хүүдий дотроосоо Тэнүүлчний газрын зургийг гарган авч хараад хаана байгаагаа оллоо.

- Бид тавдугаар давхарт байна. Ийшээ явцгаая гэж Филчийн дүрс өмнө талын хонгилд явахыг хараад хэллээ.

Тэд хонгилоор явав.

Харри урд нь шилтгээнд шөнийн цагаар маш олон удаа явж байсан хэр нь хэзээ ч ингэж зүрх нь галзуурсан мэт цохилон байндаа аюулгүй хүрэх нь чухал байсангүй. Полумна тэр хоёр зургаа шалган явсаар сарны гэрэл туссан талбай болон хангинан чахрах рыцарын хуяг дуулганы дэргэдүүр өнгөрч эргэлт болгон дээр болгоомжтой байж, хоёр ч удаа зогсон хий үзэгдлийг анхаарлыг таталгүй өнгөрүүлэв. Харри хором бүр саад бэрхшээлтэй тулгарахад бэлтгэн юуны урд Пивзийн ирэх чимээг анирдаж байлаа.

- Ийшээ, Харри гэж Полумна аяархан хэлээд ханцуйнаас нь татан шат руу өгсөв.

Тэд толгой эргэм дугуй шатаар өгслөө. Харри урьд нь хэзээ ч ийшээ ирж байсангүй. Эцэст нь бүргэдийн дүрс бүхий хүрэл цохиуртай хаалганд хүрэхэд бариул цоожны нүх байсангүй.

Полумна цагаан гараа сунган хаалга тогшиход бүрэнхийд биенээсээ тусгаарлагдсан хий үзэгдэл мэт аймшигтай харагдав. Гэсэн ч энэ аяархан цохилт Харрийн чихэнд их бууны дуу мэт сонсогдлоо. Бүргэдийн хошуу нээгдсэн ч шувууны дууны оронд уянгалаг аялгуутай хоолой,

- Галт шувуу гал хоёрын хэн нь урьд байсан бэ? гэлээ.

- М-м ... Чи юу гэж бодож байна, Харри? гэж Полумна асуув.

- Юу? Үүнд нууц үг хэрэггүй юм уу?

- Үгүй. Асуултанд хариулах хэрэгтэй.

- Хэрвээ буруу хариулвал яах вэ?

- Тэгвэл зогсоод хэн нэгэн зөв хариулж чадах хүн ирэхийг хүлээх хэрэг гарна.

Ингэж байж сурдаг юм ойлгож байна уу?

- М-м тийм л дээ ... Гэхдээ асуудал гэвэл бидэнд одоо бусдыг хүлээх цаг байхгүй, Полумна.

- Би ойлгож байна гэж Полумна чухалчлан хэлээд,

- Би хариултыг мөчлөг эхлээгүй байсан гэж бодож байна гэлээ.

- Зөв байна гэж хоолой хэлээд хаалга нээгдлээ.

Когтевраны зочны өрөө томхон дугариг агаад маш уужим ажээ. Ханан дахь цонхнуудад цэнхэр хүрэл өнгийн торгон хөшиг өлгөжээ. Когтевранчууд эндээс өдрийн цагаар тойрон хүрээлсэн уулсын гайхамшигтай үзэсгэлэнг хардаг байж. Пөмбөгөр адрыг ододоор хээлж чимэглэн шалан дээр цэнхэр хивс дэвсчээ. Эндхийн ширээ, сандал, номын шүүгээ эсрэг талын үүдэн дээр байгаа хөшөө гээд л бүх зүйл цагаан гантигаар хийгдсэн байлаа.

Харри Полумнагийн гэрт харсан Кандида Когтеварны цээж баримлыг танилаа. Хөшөө дээшээ унтлагын өрөө рүү өгсдөг хаалганы дэргэд байв. Тэр гантиг эмэгтэй рүү очоод хартал нууцлаг инээмсэглэл нь үзэсгэлэн гоо гэхээсээ илүү аймшигтай юм шиг ч санагдав. Хөшөөний толгой дээр Флерийн хуримын өдөр өмссөн титмийг санагдуулам гантиг титэм харагдана. Түүн дээр жижигхэн үсэг байлаа. Харри цуваа сөхөн бичгийг уншихаар суурин дээр гарав.

Ухаан алтнаас үнэтэй.

- Чи ч хөөрхийлөлтэй усан тэнэг юм даа гэж шоолонгуй хэлэх сөөнгө дуу гарлаа.

Харри огцом эргээд шалан дээр хальтирч унав. Түүний өмнө Алекто Керроугийн дүрс гарч ирээд Харрийн шидэт саваагаа чиглүүлж амжихаас урьтаж махлаг хуруугаараа бугуйн дээрх амнаас нь могой цухуйсан гавлын дүрсээ дарлаа.

БҮЛЭГ 30: СЕВЕРУС СНЕГГ ОГЦОРСОН НЬ

Түүний хуруу тамганд хүрэх агшинд Харрийн сорви аймшигтай төөнөн өвдөж одод бүхий өрөө хараанаас алга болоод хясааны дэргэдэх тэнгисийн усанд мөлийсөн хадан дээр зогсож байхдаа зүрх нь хөөрөн догдов. Тэд хүүг барьжээ.

Чанга тасхийх чимээ гараад Харри бодит байдалд эргэн ирлээ. Тэр саваагаа өргөсөн ч урд нь зогсож байсан шидтэн нүүрээрээ газар падхийн унаад номын тавиурын шил жингэнэв.

- Би өмнө нь Хөшөөх шившлэгийг ДА-гийн бэлтгэлээс өөр газар хийж байгаагүй. Ийм шуугиан гардаг гэж мэдсэнгүй шүү гэж Полумна гайхлаа.

Тэгтэл толгой дээрх адар чичирч унтлагын өрөөний хаалга нээгдэн яаран гүйлдэх хөлийн чимээ сонсогдов. Полумнагийн шившлэг дээр унтаж байсан Когтевранчуудыг сэрээжээ.

- Полумна чи хаана байна? Бид цуван дор нуугдах хэрэгтэй байна!

Тэгтэл хаа нэгтээгээс шалан дээр хөл гарч ирэв. Тэр ухасхийн үл үзэгдэх цуваа нөмөргөж амжтал зочны өрөөний хаалга нээгдэн унтлагын хувцастай айсан Когтевранчууд орж ирснээ Алекто шалан дээр ухаангүй хэвтэж байсанд дуу алдан гайхлаа. Дараа нь тэд дурын агшинд дайрах зэрлэг араатан руу дөхөж байгаа юм шиг удаанаар тойроод эцэст нь хамгийн зоригтой нэгдүгээр дамжааны сурагч Алектогийн нурууг хөлөөрөө түлхлээ.

- Тэр үхсэн бололтой! гэж тэр баяртай хашгирав.

- Хөөх хараач! Тэд баярлаж байна! гэж Полумна Алектог тойрон зогссон Когтевранчуудыг хараад хөөрөн шивнэв.

- Тийм шүү ... сайхан хэрэг ...

Харри сорви нь янгинан өвдөхөд ахин Волдемортын бодолд нэвтрэхээр шийдээд нүдээ анилаа ... Тэр эхний агуйн хонгилоор явж байв ... Эндээс явахын өмнө итгэлтэй байхын тулд зүүлтийг шалгахаар шийджээ ... Тэгээд ч үүнд их хугацаа орохгүй ...

Зочны өрөөний хаалга нүдэхэд Когтевранчууд байрандаа хөшлөө. Харри хаалганы цохиурын уянгалаг хоолой,

- Алга болсон эд зүйлс хаачдаг вэ? гэхийг сонслоо.

- Би хаанаас мэдэх юм. Амаа тат! гэж бүдүүлэг хоолой зандрахад Харри Кэрроугын ах болох Амикусыг танилаа.

- Алекто! Алекто! Чи энд байна уу? Чи түүнийг барьсан уу? Хаалгаа онгойлго!

Когтевранчууд айдаст автан шивнэлдэхэд ээлж дараалан чанга тасхийх чимээ гарч хэн нэгэн хаалга руу гал нээж буй мэт болов.

- Алекто! Хэрвээ түүнийг ирэхэд Поттер бидэнд байхгүй байвал ... Чи бидэнд Малфойнход тохиолдсон шиг зүйл болохыг хүсээ юу? Хариулаач! гэж Амикус орилоход хаалга хүчтэй чичирсэн ч нээгдсэнгүй.

Когтевранчууд хойш ухран хамгийн хулчгар нь нэг нь унтлагын өрөө лүү явдаг шат руу өгсөж эхлэв. Харри үүд нээгдэхэд Амикусыг хөшөөх талаар бодсон ч гэнэтхэн өөр нэг сайн танил хоолой сонсогдлоо.

- Танаас юу хийж байгааг чинь асууж болох уу, профессор Кэрроу?

- Энэ чөтгөрийн ... хаалгыг ... нээхийг ... оролдож байна! Явж Флитвикийг дууд! Даруйхан онгойлгох хэрэгтэй байна! гэж Амикус орилов.

- Гэхдээ тэнд таны дүү тэнд байхгүй хэрэг үү? Профессор Флитвик өнөө үдэш таны гуйлтанд нээж өгсөн биз дээ? Магадгүй тэр таньд хаалга онгойлгоход тусалж болох байх? Тэгвэл таньд шилтгээний хагасыг сэрээх хэрэг байхгүй болно! гэж профессор МакГонагалл хэлэв.

- Тэр хариулахгүй байна хөгшин туужуу минь! Тэгвэл чи өөрөө онгойлго!

Одоохон түргэл!

- Хэрвээ хүсч байгаа бол тэгье л дээ гэж профессор МакГонагалл мөс шиг хүйтэн хоолойгоор хэлэв.

Аяархан цохих чимээ гарахад уянгалаг хоолой ахин,

- Алга болсон эд зүйлс хаачдаг вэ? гэж асуулаа.

- Хоосон ахуйд байгаа болохоор хэлэх боломжгүй гэж профессор МакГонагалл хариулав.

- Сайхан хариулт байна гэж бүргэдийн хошуу хэлээд хаалга нээгдлээ.

Босгоор Амикусын саваа цухуйхад зочны өрөөнд үлдсэн Когтевранчууд шатаар гүйн гарлаа. Тэр дүү шигээ бөгтгөр зэвхий царайтай агаад жижигхэн нүд нь шалан дээр хөдөлгөөнгүй хэвтэж байгаа Алектог хараад уур хилэнд автав.

- Жижигхэн гөлөгнүүд минь юу хийчих нь энэ вэ? Хэн хийснийг нь хэлэх хүртэл бүгдийг нь Круциатусаар тамлах болно доо ... Хар лордод одоо юугаа хэлэх болж байна? гэж нударгаараа духаа цохин орилоод,

- Энэ гахайнууд Алектог алсан болохоор барьж чадсангүй гэж хэлэхээс! гэв.

- Таны дүү ердөө Хөшөөх шившлэгэнд өртсөн байна. Түүний бүх зүйл хэвийн гэж Алекто руу бөхийн зогссон профессор МакГонагалл уурсангүй хэллээ.

- Чамайг аянга ниргээсэй билээ! Хэрвээ ийшээ Хар лорд ирэх юм бол түүний бүх зүйл хэвийн биш байхаа болно! Тэр түүнийг дуудсан болохоор би Хар тамганы төөнөхийг мэдэрсэн. Тэр одоо биднийг Поттерыг барьсан гэж бодож байгаа!

- Поттерыг барьсан гэнээ? Поттерыг барьсан гэдэг чинь юу гэж байгаа юм?

хэмээн профессор МакГонагалл огцом асуув.

- Тэр бидэнд Поттер Когтевраны цамхаг руу нэвтрэхийг оролдоно гэж хэлээд хэрвээ хүүг баривал дуудаарай гэсэн юм!

- Поттер ямар учраас Когтевраны цамхагт нэвтрэнэ гэж? Тэр миний тэнхимд сурдаг!

Түүний хоолойд уур хилэнгийн зэрэгцээ бардам өнгө тодроход Харри Минерва МакГонагаллд талархах сэтгэл төрөхөө мэдэрлээ.

- Бидэнд түүнийг зөвхөн ийшээ ирнэ л гэсэн! Би яахаараа мэдэх ёстой юм! Профессор МакГонагалл цэхлэн зогсоод өрөөг гялалзсан харцаар нэгжихэд хоёр ч удаа Харри, Полумнагийн зогсож байгаа газар туслаа.

- Бид хүүхдүүдэд энэ хэргийг тохож болох юм гээд Амикиусын дүйнгэ царайд гэнэтхэн зальжин өнгө тодорч,

- Тиймээ бид тэгж хийх болно. Алектог хүүхдүүд дайрахдаа Тамганд хүрсэн учраас хуурамч түгшүүр зарлагдсан гэж хэлнэ ... Тэр тэдэнтэй өөрөө учраа олог. Хоёр гурван хүүхэд байхгүй болох ямар ялгаа байна? гээд ододтой адрын дээр байгаа унтлагын өрөө лүү харлаа.

- Ялгаа гэвэл зөвхөн үнэн болон худал, хулчгар болон зоригтой хоёрын хооронд байна гэж цонхийн цайсан профессор МакГонагалл хэлээд,

- Ер бол ийм ялгааг та дүүтэйгээ ойлгож чадахгүй. Гэхдээ нэг л зүйл маш тодорхой байна. Та мунхаг байдлаа Хогвартсын сурагчдад тохож чадахгүй. Би таньд үүнийг зөвшөөрөхгүй! гэв.

- Юу гэнээ?

Амикус профессор МакГонагалл руу заналхийлэн нүүр тулан очив. Тэр зайлсхийсэнгүй зөвхөн түүнийг дээрээс доош нь жорлонгийн бохир суултуур аятай жигшин харлаа.

- Хэн ч таны зөвшөөрлийг асуух гээгүй байна, Минерва МакГонагалл! Таны үе өнгөрсөн. Энд бид ноёрхож байгаа болохоор хэрвээ та намайг дэмжихгүй бол үүнийгээ хүндхэн төлөх болно шүү!

Ингээд тэр нүүр лүү нь нулимлаа.

Харри жанчаа сөхөөд шидэт саваагаа өргөн,

- Чи ингэх ёсгүй байсан юм! гээд Амикусыг эргэхэд,

- Круцио! гэж хашгирлаа.

Үхэл залгигчийн хөл өргөгдөв. Тэр агаарт живж буй хүн шиг атиралдаж өвдсөндөө орилон ёолсоноо номын шүүгээний урд талын шилийг хагалахад шалан дээр жингэнэн уналаа.

- Одоо л би Беллатрисагийн юу хэлснийг ойлгож байна. Үүнийг үнэхээр хүсэх хэрэгтэй юм байна гэж Харри тархинд нь цус буцлахыг мэдрэн хэлэв.

- Поттер! Поттер ... та ... энд байгаа хэрэг үү! Гэхдээ яаж ... гэж профессор

МакГонагалл зүрхээ даран шивнээд,

- Поттер энэ чинь тэнэг хэрэг шүү дээ! гэлээ.

- Тэр тань руу нулимсан.

- Поттер би ... үүнийг маш их ... таны зүгээс маш уужим хэрэг гэдгийг ойлгож байна л даа ... Гэхдээ та ойлгосонгүй ...

- Ойлгож байна гэж Харри итгүүлэв. Минервагийн айдас яагаад ч юм түүнд хүч өгчээ.

- Профессор МакГонагалл ийшээ Волдеморт ирж байгаа.

- Түүнийг одоо нэрээр нь хэлж болох уу? гэж Полумна сониучирхаад үл үзэгдэх цуван дороос гарав.

Хоёр дахь оргодлыг хараад профессор МакГонагалл тэссэнгүй бололтой хэдэн алхам ухран ойролцоох сандал дээр унаад гараараа хуучин халатныхаа захыг дарлаа.

- Одоо түүнийг яаж дуудах нь хамаагүй болсон. Тэр намайг хаана байгаа гэдгийг мэднэ гэж Харри хэллээ.

Түүний тархины нэгээхэн хэсэг халуу шатсан сорвиор уур хилэнтэй холбогдон Волдеморт хэрхэн сүүмгэр ногоон завиар харанхуй нууран дээгүүр түргэн хөвөхийг харлаа ... Тэр одоохон чулуун аягатай аралд хүрэх нь байна ...

- Та зугтах хэрэгтэй. Түргэл Поттер даруйхан! гэж профессор МакГонагалл шивнэв.

- Чадахгүй нь. Би энд нэг зүйл хийх ёстой. Профессор та Кандида Когтевраны титэм хаана байгааг мэдэхгүй биз?

- Кандида Когтевраны титэм гэнээ? Мэдээж үгүй ... тэр олон зууны өмнө алга болсон биз дээ? гээд тэр өндийн сууснаа,

- Поттер таны шилтгээнд ирсэн чинь ухаангүй, цэвэр ухаангүй хэрэг ... гэлээ.

- Өөрөөр болохгүй байсан юм. Профессор би энд нуусан нэг зүйлийг олох ёстой бөгөөд титэм байж болзошгүй ... Би профессор Флитвиктэй ярилцах хэрэгтэй байна ...

Хөдлөх чимээ гарч шил жингэнэлээ. Амикус өндийж эхэлж байв. Харри, Полумна хоёрыг ямар нэг зүйл хийж амжихаас урьтаж профессор МакГонагалл суудлаасаа үсрэн босоод саваагаа Үхэл залгигч руу чиглүүлэн,

- Империо! гэв.

Амикус хөл дээрээ босоод ухаангүй хэвтэх дүү рүүгээ очиж гарт нь байсан савааг аван профессор МакГонагаллд өөрийнхөө саваатай хамт сунгаад Алектогийн хажууд хэвтлээ. Профессор МакГонагалл саваагаа ахин өргөхөд агаарт гялалзсан мөнгөлөг олс гарч хоёр Кэрроуг бие биетэй нь бөх хүлэв.

- Поттер хэрвээ Хэцүү нэрт таны энд байгаа гэдгийг үнэхээр мэдэх юм бол хэмээн профессор МакГонаглл шалан дээр хэвтэх Кэрроуд санаа тавиад хэлэв.

Түүнийг ингэж хэлмэгц Харриг өвдөлт хаман авч сорви хатгуулан агшин зуур тэр чулуун аяганы тунгалаг шингэн хоосон ёроолд нь алтан зүүлт байхгүй болсныг харлаа ...

- Поттер чи зүгээр үү? гэх хэн нэгний хоолой сонсогдон Харри эргэн ирэхэд

Полумнагийн мөрөн дээр дараад зогсож байлаа.

- Цаг яваад байна Волдеморт ойртож байна. Профессор би Дамблдорын тушаалыг гүйцэтгэж байгаа болохоор түүний даалгасан зүйлийг хайх ёстой. Гэхдээ намайг эрлээ хийж байх хооронд Хогвартсын сурагчдыг нүүлгэн шилжүүлэх хэрэгтэй байна. Волдеморт намайг эрж байгаа болохоор замд нь тааралдсан бүхнээ алах болно ялангуяа одоо ... гээд золтой л «Тэр одоо миний крестражыг устгасныг мэдэж байгаа» гээд хэлчихсэнгүй.

- Та Дамблдорын тушаалыг гүйцэтгэж байгаа юм уу? гэж Минерва

МакГонагалл давтаад гайхан харснаа босож,

- Тийм бол бид таныг энэ зүйлээ эрж байх хооронд чинь ... Хэцүү нэртийг сургууль руу нэвтрүүлэхгүй байх арга хэмжээ авъя гэв.

- Энэ боломжтой гэж үү?

- Тийм гэж бодож байна гэж профессор МакГонагалл хөндий өгүүлээд,

- Таны багш нар муугүй шид эзэмшдэг юм шүү. Хэрвээ бид хамтдаа хичээх юм бол түүнийг хэсэг зуур тогтоож чадах байх. Мэдээж профессор Снеггийн тухайд ямар нэг зүйл хийх хэрэгтэй л дээ ... гэв.

- Хүлээгээрэй ...

- Хэрвээ Хогвартс бүслэлтэнд орж Хар лорд хаалган дээр ирэх юм бол аль болох олон гэмгүй хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх шаардлагатай. Гэтэл нисдэг дарины сараалж хяналтанд байгаа болон сургуулийн нутаг дэвсгэрт шилжих боломжгүй байдаг ...

- Үүнээс гарах гарц бий гэж Харри «Гахайн толгой» руу хөтөлдөг хонгилыг санаад яаран хэллээ.

- Поттер энд зуугаад сурагчдын тухай ярьж байна ...

- Би мэднэ профессор гэхдээ Волдеморт болон Үхэл залгигчид сургуулийн хил хязгаарт л анхаарлаа төвлөрүүлэхээс биш «Гахайн толгой»-ноос хэн гарч байгааг сонирхохгүй.

- Тэр ч тийм шүү гэж МакГонагалл зөвшөөрөөд саваагаа ахин Кэрроунууд руу чиглүүлэхэд мөнгөн торонд агаарт өлгөгдөн хөөрөөд алтлаг цэнхэр адрын дорх тэнгисийн хоёр том мангас шиг харагдав.

- Явцгаая. Бусад тэнхимийн эрхлэгчдэд анхааруулах хэрэгтэй байна. Та цуваа ахин нөмөрсөн нь дээр байх.

Тэр хаалгаар гарахдаа саваагаа өргөхөд үзүүрээс нь гурван нүдээ тойрсон шилний тэмдэгтэй мөнгөлөг муур гараад харанхуй эргүүлгэн шатыг мөнгөлөг гэрлээр дүүргэв. Профессор МакГоанаглл Харри, Полумна гурав тэдний араас яаран уруудлаа.

Тэднийг хонгилд гүйн гарах үед Патронусууд нэг нэгнийхээ араас алга болов. Профессор МакГонагалл дөрвөлжин хээтэй халатаа шар шурхийлгэн явах зуур Харри, Полумна хоёр үл үзэгдэх цуван дор нуугдан дагаж байлаа.

Тэд ахин хоёр давхар уруудахад чимээгүй алхаа сонсогдов. Харри сорви нь өвдөж байсан ч түрүүлж сонслоо. Гэсэн ч түүнийг хүзүүндээ зүүсэн Тэнүүлчний газрын зургийг гаргаж амжихаас өмнө МакГонагалл өөр хүн байгааг анзааран зогсоод шидэт саваагаа авч,

- Энд хэн байна? гэв.

- Би гэх намуухан хоолой гараад рыцарын хуяг дуулганы араас Северус Снегг гарч ирлээ.

Түүнийг хараад Харрийн үзэн ядалт буцлав. Тэр Снеггийн хийсэн гэмт хэрэг болон тослог хар үс эмжсэн туранхай царай, үхлийн хүйтэн харцтай нүдийг бараг мартсан байлаа. Тэр унтлагын хувцасгүй ердийн хар жанчтай байсан бөгөөд мөн шидэт саваагаа бэлхэн барьжээ.

- Кэрроу хаана байна? гэж тайван асуув.

- Би түүнийг хэлсэн газар чинь байгаа гэж бодсон юмсан гэж профессор

МакГонагалл хариу хэлэв.

Снегг улам ойртсоноо Харрийн энд байгааг мэдсэн мэт профессор МакГонагаллын ойр орчныг харлаа. Харри бас саваагаа өргөв.

- Надад Алекто сургуульд хууль бусаар нэвтэрсэн хүнийг барьж авсан гэсэн сэтгэгдэл төрсөн юмсан.

- Тийм гэж үү? Таньд яагаад тийм сэтгэгдэл төрөө вэ? гэж профессор

МакГонагалл гайхав.

Снегг Хар тамга бүхий зүүн гарын бугуйгаа үл мэдэг сөхлөө.

- Аан тийм л дээ! гэж профессор МакГонагалл тургилаад,

- Таныг Үхэл залгигчидтай хувийн онцгой сувгаараа холбоотой гэдгийг мартчихаж! гэв.

Снегг сонсоогүй дүр эсгэн ар талыг нь харсаар алгуур ойртлоо.

- Би өнөөдөр таны хонгилд жижүүрлэх ээлж гэж мэдсэнгүй, Минерва.

- Таньд татгалзах зүйл байгаа юм уу?

- Би таныг юу ийм орой болсон хойно орноос чинь босгосныг мэдэхийг хүсч байна.

- Надад сэжигтэй чимээ сонсогдох шиг санагдсан.

- Тийм гэж үү? Гэхдээ энд нам гүм байна гээд Снегг түүн рүү цоо ширтлээ.

- Та Харри Поттерыг харсан уу, Минерва? Хэрвээ харсан бол би шаардаж ...

Профессор Макгонагалл итгэмээргүй түргэн хөдлөв. Түүний шидэт саваа агаарт шавхуурдахад Харри Снеггийн ухаангүй газар унахыг хүлээсэн ч түүний Бамбай шид маш хурдтай байж МакГонагалл тэнцвэр алдан найгалаа. Тэр саваагаа хананд байгаа бамбар руу чиглүүлэхэд мулт үсрэв. Харри Снеггийн илгээсэн шившлэгээс Полумнаг түлхэн холдуулан түлхэхэд галт цагариг хонгил дундуур бугуйл мэт нисэв

...

Одоо энэ гал биш том хар могой болоод МакГонагалл түүнийг утаа болгон дэлбэлснээ агшин зуур чичлүүр хутга болон буцлаа. Снегг түүнээс зугтан дуулганы цаагуур ороход хутганууд хуяган дээр нэг нэгнийхээ араас хангинан зоогдов.

- Минерва! гэх часхийсэн хоолой гарахад Харри Полумнаг шившлэгээс хамгаалсан хэвээр эргээд профессор Флитвик, Стебль нар унтлагын хувцастай гүйлдэхийг харлаа. Араас нь махлаг биетэй профессор Слизнорт амьсгаадан ирж байв.

- Үгүй! Та Хогвартсад хэнийг ч алахгүй! гэж Флитвик хашгираад шидэт саваагаа өргөлөө.

Флитвикийн шид Снеггийн ард нь нуугдсан хуяг дуулгыг цохиход хангинан амь орлоо. Снегг хуягны төмөр тэврэлтээс мултраад дуулгыг өрсөлдөгчид рүүгээ илгээхэд Харри, Полумна хоёр арай ядан булташ амжтал хана цохин бутрав. Харри ахин харах үед Снегг аврагдахаар зугтан гүйж МакГонагалл, Флитвик, Стебль нар араас нь аянга илгээж байлаа. Түүнийг ангийн хаалгаар гүйн орсноос хормын дараа МакГонагалл,

- Хулчгар! Хулчгар! гэж хашгирав.

- Тэнд юу болоод байна? Юу болсон юм бол? гэж Полумна санаа зовлоо.

Харри түүнийг хөл дээрээ босоход туслаад үл үзэгдэх цуваа тайлан хоосон ангид гүйж ороход профессор МакГоанаглл, Флитвик, Стебль нар хагарсан цонхны дэргэд зогсож байлаа.

- Тэр үсэрчихсэн! гэж профессор МакГонагалл Харри, Полумна хоёрыг хараад хэлэв.

- Тэр үхчихээ юу? гээд Харри Флитвик, Стебль нарын гайхсан харцыг үл тоомсорлон цонх руу гүйн очлоо.

- Үгүй ээ үхээгүй. Дамблдороос ялгаатай нь гэвэл тэр шидэт саваатай байсан ... бас эзнээсээ хэдэн мэх сурсан бололтой гэж МакГонагалл гашуунаар хэлэв.

Харри алсад сарьсан багваахай адил нэвсгэр дүрс шилтгээний хаалга руу гүйхийг хараад дотор нь зарсхийлээ.

Тэгтэл ард нь хүнд алхаа амьсгаадах чимээ сонсогдож Слизнорт эцэст нь гүйцэж ирэв.

- Харри! гэж тэр маргад ногоон халаттай өргөн цээжээ илэх зуураа хашгираад,

- Хүндэт хүү минь ... ямар гэнэтийн бэлэг вэ ... Минерва тайлбарлаач ... Северус ... юу ... гэлээ.

- Манай захирал богино хугацааны амралт авсан гээд профессор МакГонагалл хагархай цонхоор Снеггийн дүрс рүү заав.

- Профессор! гэж Харри хашгираад гараараа духаа барин дүүрэн инерналтай нууранд цайвар ногоон завь эрэг мөргөн газардахад Волдеморт аллага хийх хүслээр дүүрэн үсрэн гарахыг харлаа.

- Профессор сургуулийг даруйхан хамгаалах хэрэгтэй. Тэр ийшээ ирж байна!

- Сайн байна! Ийшээ Хэцүү нэрт ирж байна гэж МакГонагалл бусад багш нарт мэдэгдэхэд Стебль, Флитвик хоёр дуу алдаж, Слизнорт аяархан ёоллоо.

- Поттер шилтгээнд Дамблдорын тушаалаар ямар нэг зүйл хийх ёстой. Бид Поттерыг хэрэгтэй зүйлээ хийх хүртэл бүх чадлаараа хамгаалах хэрэгтэй байна.

- Та харваас бидний ямар ч хүчин чармайлт Хэцүү нэрийг тэсгээхгүй гэдгийг ойлгож байгаа биз дээ? гэж Флитвик хэлэв.

- Гэхдээ бид түүнийг саатуулж чадна гэж професор Стебль хэллээ.

- Баярлалаа, Помоно гээд профессор МакГонагалл тэднийг баргар ойлгосон харцаар харж,

- Би шилтгээний үндсэн хамгаалалтыг босгож тэнхимийнхээ сурагчдыг Их танхимд цуглуулахыг хүсч байна. Тэднийг нүүлгэн шилжүүлэх хэрэгтэй ч насанд хүрсэн нэг нь бидэнтэй тэмцэхээр үлдвэл боломж олгох хэрэгтэй гэв.

- Зөвшөөрч байна гээд профессор Стебль түргэн алхан гарахдаа,

- Тентакула. Чөтгөрийн ургамал ... Тиймээ би Үхэл залгигчидтай тэмцэж чадна гэдгээ харж байна гэв.

- Би эндээс шууд хийе гээд Флитвик шидэт саваагаа хагарсан цонх руу чиглүүлж төвөгтэй нарийн шившлэг бувтнахад Харрид хачирхалтай шуугих чимээ сонсогдон сургуулийн нутаг дэвсгэрт хуй хөөрөх шиг болов.

- Профессор таныг сатааруулсанд өршөөгөөрэй. Гэхдээ энэ их чухал шүү. Та Кандида Когтевраны титэм хаана байгааг мэдэх үү? гэж Харри жижигхэн шившлэгийн багш руу очоод хэлэв.

- Протего хоррибилис ... Кандида Когтевраны титэм гэнээ? Мэдээж бага зэрэг ухаан хэзээ ч илүүдэхгүй ч энэ үйл явдалд түүнгүй болно байх гэж айж байна.

- Би зөвхөн ... түүний хаана байгааг мэдэх гэсэн юм? Та урьд нь харж байсан уу?

- Харж байсан уу гэнээ? Нэг ч амьд амьтан түүнийг харж байгаагүй. Тэр урт хугацааны өмнө алга болсон, хүү минь.

Харри урам хугаран цөхрөхөө мэдрэв. Тэгэхээр крестражыг яаж олох болж байна?

- Би та болон Когтевранчуудтай чинь Их танхимд уулзая, Филиус! гээд профессор МакГонагалл Харри, Полумна хоёрыг араасаа дагахыг зангав.

Тэднийг хаалганд хүрсэн хойно норж цонхийн сахлын үзүүр нь чичирсэн Слизнорт,

- Үнэнийг хэлэхэд энэ чинь галзуурсан хэрэг! Минерва үүнийг ухаантай санаа гэдэгт чинь итгэлгүй байна. Түүнийг сургууль руу ороход саатуулахыг оролдсон бүхэнд аймшигтай аюул заналхийлнэ гэдгийг санаарай гэв.

- Би таныг хорин хормын дараа Слизеринчүүдтэй чинь Их танхимд хүлээж байна. Хэрвээ та сурагчдын хамт явахыг хүсвэл бид саатуулахгүй ч шилтгээнийг хамгаалах тэмцэлд нэгдвэл сайн байна, Гораций. Бид үхлийн тулаан хийх гэж байна.

- Минерва! гэж тэр айдаст автан дуу алдав.

- Слизерин тэнхим хэний талд орохоо шийдэх цаг ирлээ. Явж сурагчдаа сэрээ, Гораций.

Харри цааш нь Слизнортын бувтнахыг сонсолгүй хонгилын дунд саваагаа өргөн зогссон профессор МакГонагалл руу гүйн очлоо.

- Пиертотум ... өө бурхан минь Филч, одоо л биш шүү ... Хөгшин харуул хонгилд гүйн гарч ирээд,

- Сурагчид орондоо биш байна! Сурагчид хонгилд байна! гэж хаширлаа.

- Яагаад гэвэл тэдэнд тэгж тушаасан учраас, тэнэг минь! гэж МакГонагалл зандраад,

- Одоохон явж ямар нэг ашигтай хий! Пивзийг ол! гэв.

- П-Пивз гэнээ? хэмээн Филч энэ нэрийг хэзээ ч сонсож байгаагүй мэт ээрэн хэллээ.

- Тиймээ, Пивз тэнэг минь Пивз! Та түүний тухай үргэлж гомдолдоггүйсэн билүү! Явж түүнийг авчир!

Филч харваас профессор МакГонагаллыг ухаан солиорсон гэж бодсон бололтой бувтнасаар цааш холдлоо.

- Харин одоо ... Пиертотум Локомтор! гэж профессор МакГонагалл хашгирав.

Тэгтэл бүх хонгилын хөшөө, хуяг дуулгууд сууринаасаа тар нярхийтэл үсрэн буугаад гүйж ирэв.

- Хогвартс аюулд орлоо! Нутаг дэвсгэрээ хамгаал, биднийг хамгаал, сургуулийн өмнө хүлээсэн үүргээ биелүүл! гэж профессор МакГонагалл тушаав.

Чанга чахрах чимээ гараад хэсэг том жижиг хөшөөнүүд Харрийн дэргэдүүр хөлөө дэвслэн алхаж өнгөрлөө. Тэдний дунд бас амьтад байсан бөгөөд хуяг дуулгануул чахран илд, хадаастай мунаа өргөлөө.

- Харин одоо, Поттер та хатагтай Лавгудтай найзууд дээрээ очоод Их танхимд авчир. Би бусад Гриффиндорынхныг аваад очъё.

Тэд дараагийн шатны талбай дээр салахад Харри, Полумнагийн хамт Шаардлагатай өрөөний хонгил руу явлаа. Замд нь унтлагын хувцсан дээрээ жанчаа өмссөн сурагчдыг Их танхим руу авч яваа багш нар болон ахлагчид тааралдав.

- Поттер байна!

- Харри Поттер!

- Тэр байсан үнэн шүү би харсан!

Гэсэн ч Харри эргэж харалгүй явсаар эцэст нь Шаардлагатай өрөөнд хүрч шидэт хананд хүрэхэд нээгдэж оруулав. Харри Полумна хоёр шатаар түргэн уруудлаа.

- Ямар ...

Харри Шаардлагатай өрөөнд юу болсныг хараад гайхан алмайрав. Түүнийг явснаас хойш олон хүн цугларсан бололтой өрөө дүүрэн хүнтэй болжээ. Түүн рүү Кингсли, Люпин, Оливер Вуд, Кэти Белл, Анжелина Жонсон, Алисия Спиннет, Билл, Флер ноён ба хатагтай Уизли харж байв.

- Тэнд юу болоод байна, Харри? гээд Люпин түүнийг угтан алхлаа.

- Волдеморт ийшээ нисэж ирж, багш нар сургуулийн хамгаалалт босгож байна

... Снегг зугтсан ... Харин та нар энд юу хийж байгаа юм бэ? Яаж мэдсэн юм?

- Бид Дамблдорын армийн бүх гишүүдэд мэдээлэл илгээсэн. Хэн тийм боломжыг алдахыг зөвшөөрөх билээ дээ, Харри. Харин Фениксийн бүлгэмийн хувьд цасан уруй шиг зүйл болсон гэж Фред тайлбарлав.

- Юунаас эхлэх үү, Харри? Юу болсон бэ? гэж Жорж оролцов.

- Насанд хүрээгүй хүүхдүүдийг нүүлгэн шилжүүлэхийн тулд тулд бүгдийг нь

Их танхимд цуглуулж байна. Дайн эхэлсэн.

Бөөн хөл үймээн дэгдэн бүгд шат руу ухасхийлээ. Харри хана налан зогсоод дэргэдүүрээ Фениксийн бүлгэмийн гишүүд, Дамблдорын армийнхан болон урьд нь квиддичийн багт хамт байсан тоглогчид саваагаа бэлхэн барин гүйлдэн өнгөрөхийг харлаа.

- Явъя Полумна гэж Дин дуудаад гараа сунгав. Полумна түүнээс бариад араас нь яаран өгслөө.

Шаардлагатай өрөөнд байсан хүмүүс цөөрч ердөө хэдхэн хүн үлджээ. Харри тэдэн рүү очлоо. Хатагтай Уизли Жинниг бариад Люпин, Фред, Жорж, Билл, Флер нар тойрон зогсож байв.

- Чи насанд хүрээгүй шүү дээ! Би үүнийг зөвшөөрөхгүй! Хөвгүүд болох ч харин чи ... гэртээ эргэж очих ёстой гэж хатагтай Уизли охин руугаа хашгирав.

- Явахгүй! Би ч гэсэн Дамблдорын армийн гишүүн! хэмээн үс нь сэгсийсэн

Жинни эхийнхээ гараас мултраад хэлэв.

- Өсвөр насны хүүхдийн бүлэг.

- Хэн ч үүнийг зүрхлэхгүй байгаа бол өсвөр насны хүүхдийн бүлэг түүнийг авъя! гэж Фред хэлэв.

- Тэр арван зургаан настай! Бас л жижигхэн байна! Та хоёр юугаа бодож түүнийг авчирсан юм ... гэж хатагтай Уизли хашгирав.

Фред, Жорж хоёр ичингүйрсэн төрхтэй боллоо.

- Ээжийн зөв, Жинни. Чи энд үлдэж болохгүй. Насанд хүрээгүй хүүхдүүдийг явуулах нь зөв гэж Билл аяархан хэллээ.

- Би гэр лүүгээ явахгүй гээд Жиннигийн нүдэнд уур хилэн дүрсхийлээ. Энд миний бүх гэр бүл байхад тэнд ганцаар суугаад юу ч мэдэхгүй хүлээж чадахгүй ... гээд Харри руу гуйн харсан ч толгой сэгсэрсэнд «Гахайн толгой» руу явдаг хонгил руу гашуунаар эргэж,

- Сайн байна. Тэгвэл бүгд баяртай шив ... гэлээ.

Яаран алхах хөлийн чимээ сонсогдоод хэн нэгэн хонгилоос гарч ирэхдээ бүдэрч уналаа. Тэр ойролцоох сандал дээр даран босч ирснээ эргэн тойрноо харж эвэр хүрээтэй шилээ засаад,

- Би хоцорсон уу? Эхэлчихсэн үү? Би сая л энэ тухай мэдлээ гэв.

Перси чимээгүй боллоо. Тэр харваас шууд гэр бүлийнхэнтэйгээ тулгарна гэж бодоогүй бололтой. Хэсэг хугацааны турш бүгд тэвдэцгээв. Эцэст нь Флер Люпин рүү эргээд амаргүй нам гүм байдлыг эвдэн,

- Жаал хүү Тедди хэр байна даа? гэлээ.

Люпин түүн рүү гайхан харлаа. Уизлийн гэр бүлийн чимээгүй байдал мөс шиг хүйтэн болов.

- Тэр ... сайн байгаа, баярлалаа! Тонкс одоо түүнтэй цуг эхийндээ байгаа гэж

Люпин чанга хэлэв.

Перси болон бусад Уизлийнхан хөдөлгөөнгүй бие биенээ харсаар байлаа.

- Надад зураг нь байгаа! гэж Люпин хашгираад хүрэмнийхээ халааснаасаа зураг гаргаж ирэн Флер, Харри хоёрт сунгахад тод ногоон өнгийн үстэй хүү булцгар гараа савчиж байхыг олж харлаа.

- Би тэнэг байсан! гэж Перси гэнэт чанга орилоход Люпин цочсондоо золтой л зургаа унагачихсангүй.

- Би хамгийн тэнэг, сүржин усан тэнэг бас ...

- Ид шидийн яамыг дэмжиж гэр бүлээ эрх мэдлийн төлөө орхисон гэж Фред яриаг нь төгсгөв.

Перси хүндээр санаа алдлаа.

- Тиймээ тэгсэн.

- Үүнээс үнэн үг сонсож байсангүй гээд Фред Персийн гарыг барилаа.

Хатагтай Уизли эхэр татан уйлав. Тэр урагш ухасхийгээд Фредийг хажуу тийш түлхэн Персиг амьсгаа авахын аргагүй болтол тэврэв. Перси нурууг нь илэнгээ аав луугаа харлаа.

- Аваа, уучлаарай!

Ноён Уизли нүдээ түргэн анивчсанаа очиж хүүгээ тэврэв.

- Юу чамайг ингэж бодоход хүргэв, Перси? гэж Жорж сониучирхав.

- Энэ ч эртний хэрэг дээ гээд Перси жанчаараа нүдний шилээ арчиж,

- Гэсэн ч ид шидийн яам урвагчдыг шоронд хийж байгаа болохоор мултрахад амаргүй байлаа. Би Аберфорттой холбоо тогтоосон болохоор арван минутын өмнө тэр надад Хогвартс тэмцэлд бэлтгэж байна гэж хэлсэн. Иймээс би ирлээ гэв.

- Бид одооных шиг энэ хүнд бэрх цагт ахлагчид үйл хэргийг гартаа авахыг харж байна! гэж Жорж Персийн байдлыг ихэмсэг байдлыг дуурайн даажигнан хэлээд,

- Одоо Үхэл залгигчид үзүүлээд өгөхийн тулд дээшээ өгсөцгөөх үү гэв.

- Тэгэхээр чи миний эгч болсон уу? гээд Перси Флертэй гар бариад Билл, Фред, Жорж нарын хамт яаран дээшээ өгсөв.

- Жинни! гэж хатагтай Уизли хашгирав.

Жинни гэр бүлийн үймээн шуугианыг далимдуулан бүгдийн хамт дээшээ гарч байлаа.

- Молли надад нэг санал байна. Жинниг энд үлдээчих. Тэгвэл тэр тэмцлийн үед бидний ямар байгааг мэдэх болно гэж Люпин хэлэв.

- Би ...

- Сайхан санаа байна. Жинни чи энэ өрөөнд үлдэнэ сонсов уу? гэж ноён Уизли хатуу хэлэв.

Жинни харваас үүнд хөөрсөнгүй бололтой эцэг рүүгээ ширүүн харж толгой дохив. Хатагтай Уизли Люпины хамт бас шат руу очлоо.

- Рон, Гермиона хоёр хаа байна? гэж Харри асуув.

- Их танхимд очсон байх гээд ноён Уизли мөрөө хавчлаа.

- Би дэргэдүүрээ өнгөрөхийг хараагүй шүү дээ.

- Тэд ямар нэг жорлонгийн тухай ярьж байгаад чиний явсны дараа явсан гэж

Жинни хэлэв.

- Жорлонгийн тухай гэнээ?

Харри өрөөн дундуур алхан хаалга онгойлгоод жорлон руу шагайхад хэн ч байсангүй.

- Чи тэднийг жорлонгийн тухай ярьсан гэдэгт итгэл ...

Тэгтэл сорви нь тэсэхийн аргагүй өвдөж Шаардлагатай өрөө алга болоод тэр далавчтай гахайн дүрс бүхий давтмал төмөр хаалганы завсраар харанхуйд сүүмэлзэх шилтгээний гэрэл рүү харлаа. Нагайна түүний мөрөн дээр эвхрэлдэнэ. Түүнийг алуурчны хүйтэн хэрцгий хүсэл эзэмдлээ.

БҮЛЭГ 31: ХОГВАРТСЫН ТЭМЦЭЛ

Их танхимын шидэт адар харанхуйлан одод түжээ. Түүний дор дөрвөн тэнхимийн урт ширээнд унтлагын хувцастай, жанчтай сурагчид сууцгаажээ. Тэдний дунд сургуулийн хий үзэгдлүүдийн мөнгөлөг дүрс зурсхийн үзэгдэж бүгдийн харц Их танхимын тавцан дээр ярьж байгаа профессор МакГонагалл руу чиглэсэн байлаа. Түүний ард цайвар үстэй хүн морь Флоренц тэргүүтэй бусад багш нар зогсоод, тулалдахаар ирсэн Фениксийн бүлгэмийн гишүүд харагдана.

- ... нүүлгэн шилжүүлэлтийг ноён Филч, хатагтай Помфри хоёр удирдан явуулах болно. Ахлагчид миний дохиогоор шилжүүлэлт хийгдэх газар луу тэнхимийнхнийгээ хүргэхээр зохион байгуулаарай.

Олонхи сурагчид айн тэвджээ. Харри хана налан зогсоод Гриффиндорын ширээнд Рон, Гермиона хоёрыг хайн хартал Пуффендуйн ширээнд сууж байсан Эрни Макмиллан өндийгөөд чангаар,

- Хэрвээ бид үлдэж тулаанд оролцохыг хүсвэл яах вэ? гэв. Дэмжин алга таших чимээ гарав.

- Насанд хүрсэн нь үлдэж болно гэж профессор МакГонагалл хэлэв.

- Бид нар эд зүйлээ яах вэ? Тээш болон уулиа? гэж Когтевраны ширээнээс нэг охин асуув.

- Бидэнд боож баглаж байх хугацаа байхгүй. Одоо хамгийн чухал зүйл бол та бүхнийг эндээс аюулгүй гаргах явдал.

- Профессор Снегг хаана байна? гэж Слизериний ширээнээс нэг охин хашгирав.

- Өө, уучлаарай нэг үгээр хэлвэл дүрвэн зугтсан гэж профессор МакГонагалл хэлэхэд Гриффиндор, Пуффендуй, Когтевраны ширээнд нирхийтэл инээд хадав.

Харри Рон, Гермиона хоёрыг хайсан хэвээр танхим дундуур Гриффиндорын ширээ рүү явахад бүгдийн толгой түүний зүг эргэн ард нь шивнэлдэх дуу гарав.

- Бид нар шилтгээний нутаг дэвсгэрт хамгаалалтын шившлэг босгосон ч хэр удаан тэсэхийг нь мэдэхгүй байна. Иймээс та бүхнийг түргэн хөдөлж зохион байгуулж буй ахлагч нарынхаа үгийг сонсохыг ...

Түүний сүүлчийн үгийг даран өөр хоолой Их танхимд цуурайтав. Хоолой өндөр хүйтэн аймшигтай ажээ. Хаанаас гарч байгаа нь ойлгомжгүй байсан нь хана өөрөө ярьж буй мэт санагдана. Яг л зууны өмнө хананд зүүрмэглэж байсан мангас сэрсэн мэт.

- Би та нарын тулаанд бэлтгэж байгааг мэдэж байна.

Ширээнд хашгиралт сонсогдон айсан сурагчид бие биеэ тэвэрч хоолойны эзнийг хайн эргэн тойрноо харлаа.

- Та нарын хүчин чармайлт ашиггүй. Миний эсрэг тэмцэж чадахгүй. Би хэнийг ч алахыг хүсэхгүй байна. Би Хогвартсын багш нарт хүндэтгэлтэй ханддаг. Би цэвэр цусны шидтэнгүүдийн цусыг урсгахыг хүсэхгүй байна.

Танхимд нам гүм болоод зөвхөн хананаас дуу нүргэлэх чимээ гарч байлаа.

- Надад Харри Поттерыг өгвөл та нарын хэн ч зовохгүй. Надад Харри Поттерыг өгвөл сургуульд гар хүрэхгүй үлдээнэ. Надад Харри Поттерыг өвөл та нар шагнал хүртэх болно. Та нарт шөнө дунд хүртэл бодох хугацаа өгье гэж Волдемортын хоолой хэлэв.

Танхимд ахин нам гүм болоход бүгдийн толгой Харрийн зүг эргэн мянга мянган үл үзэгдэх туяагаар сүлбэх мэт болов. Дараа нь Слизериний ширээнээс Пэнси Паркинсон өндийгөөд гараа чичилэн хашгирав.

- Тиймээ тэр энд байна! Поттер энд байна! Хэн нэгэн түүнийг бариарай!

Харри үг хэлж амжаагүй байтал хөдөлгөөн гарч эхлэв. Гриффиндорынхон түүний урд нэг хүн шиг үсрэн босоод Слизеринийхэн рүү эргэлээ. Тэдний араас Пуффендуйнхан өндийж үүнтэй зэрэгцэн Когтевранчууд босцгоов. Бүгд цаашаа харан зогсоод Пэнси руу харахад шидэт саваагаа жанчныхаа ханцуйд хийлээ.

- Баярлалаа таньд, хатагтай Паркинсон. Та ноён Филчийн харгалзаан дор хамгийн түрүүнд энэ танхимыг орхих болно. Тэнхимийн үлдсэн сурагчид араас нь яваарай гэж профессор МакГонагалл хэлэв.

Сандал хөдлөх чимээ шуугиан гарснаа Слизерийнхэн бөөгнөрөн танхимын эсрэг талын үүд рүү явлаа.

- Когтевранчууд араас нь! гэж профессор МакГонагалл тушаав.

Дөрвөн ширээний сандал ээлж дараалан хоосров. Слизериний ширээнд хэн ч үлдээгүй бол хэдэн ахлах ангийн Когтевранчууд сууж үлдээд гарч буй нөхдөө харлаа. Түүнээс арай илүүтэй Пуффендуйчууд үлдэхэд, Гриффиндорын ширээнд урьдын адил тэнхимийн хагас суусан хэвээр байсан тул профессор МакГонагалл очиж насанд хүрээгүй нэгнийг нь босгов.

- Криви үлдэж болохгүй, яв! Та гэсэн, Пикс!

Харри яаран Уизлийнхан руу очоод Гриффиндорын ширээнд хамт суулаа.

- Рон, Гермиона хоёр хаана байна?

- Чи тэднийг олоогүй ...? гэж ноён Уизли сэтгэл түгшин хэлсэн ч Кингсли тавцан дээр гараад үлдсэн хүмүүс хандан үг хэлэхэд чимээгүй боллоо.

- Шөнө дунд болоход ердөө хагас цаг үлджээ. Иймээс түргэн хөдлөх хэрэгтэй байна! Хогвартсын багш нар болон Фениксийн бүлгийнхэн тулааны төлөвлөгөө гаргасан. Профессор Флитвик, Стебль, МакГонагалл нар хамгийн

өндөр гурван цамхаг болох Когтевран, одон орон, Гриффиндорын бүлгүүдийг ахлах болно. Тэндээс гадаад байдал сайн үзэгдэх болохоор шившлэг илгээхэд сайхан

боломжтой. Харин Римус, Артур хоёр надтай шилтгээний газар нутгийг хянах бүлэгт орно. Бидэнд сургуулийн гарц хонгилыг хамгаалах хүмүүс хэрэгтэй байна ...

- Энэ харваас бидний ажил бололтой гээд Фред Жорж руу зангахад Кингсли зөвшөөрсний тэмдэг болгон толгой дохив.

- Маш сайн байна ахлагч нар нь ийшээ ирцгээ хүмүүсээ хуваая!

- Поттер, та ямар нэг юм хайгаад байгаа билүү? гэж профессор МакГонагалл сурагчид тавцан руу бөөгнөрөхөд яаран ирээд хэлэв.

- Юу? Аан тийм л дээ! Тэгэлгүй яахав!

Тэр Рон, Гермиона хоёрын тайлбарлаж боломгүй алга бололт болон өөр бусад бодлууд толгойг нь эзлээд крестражыг хайх тухайгаа бараг мартсан байлаа.

- Тэгвэл яв, Поттер! Ажилдаа ор!

- Тиймээ, би явлаа ...

Тэр Их танхимаас сурагчдыг нүүлгэн шилжүүлж буй үүдний танхим руу гүйн гарахдаа араасаа олон хүний харцыг мэдрэв. Харри сурагчдын дундуур гантиг шатаар гүйн гараад хоосон хонгил руу эргэв. Айдас сандрал хамаг бодлыг нь эзлээд төвлөрч чадахгүй байсан тул тайвширахыг хичээн крестражын тухай бодохыг оролдсон ч толгой нь шилэн саванд байгаа шар зөгий шиг дүнгэнээд болсонгүй. Харваас Рон, Гермона хоёрын тусламжгүй учрыг нь олох чадваргүй бололтой. Харри алхаагаа удаашруулаад хоосон хонгилын голд зогсож дайнд мордсон хөшөөний суурин дээр суугаад хүүдийнээсээ Тэнүүлчний газрын зургийг гарган Рон, Гермиона хоёрын нэртэй цэг хайсан ч олдсонгүй. Тэр зургаа хумиад нүдээ анин гараараа нүүрээ дараад төвлөрөхийг хичээлээ.

Волдеморт намайг Когтевраны цамхаг руу очино гэж бодсон.

Үүнд л эргэлзээгүй тодорхой хариулт байна. Волдеморт Алектод Когтевраны зочны өрөөнд хүлээхийг даалгасанд зөвхөн ганц тайлбар байв. Волдеморт Харри энэ тэнхимийн крестражтай холбоотой зүйлийг мэдэхээс айсан хэрэг.

Тэгээд ч алга болсон титмээс ондоо Когтеврантай холбоотой өөр зүйл байхгүй бололтой ... Титэм крестраж байж болох уу? Когтевраныхан үе удмаараа хайгаад олоогүй зүйлийг Волдеморт олсон байж болох уу? Хэрвээ нэг ч амьд амьтан түүнийг хараагүй юм бол хэн түүний байж болох газрыг мэдэх вэ?

Нэг ч амьд амьтан ...

Харри нүдээ томоор нээлээ. Тэр суурин дээрээс үсрэн босоод сүүлчийн найдлага өвөрлөн буцаж гүйлээ. Түүнийг гантиг шат руу гүйн ирэхэд Шаардлагатай өрөө рүү чиглэж буй зуугаад хөлийн чимээ улам чангарав ... Ахлагчид хашгиран тушаал өгч хашгиралдан түлхэлцэх тэнхимийнхээ сурагчдыг хараанаасаа алдчихгүйг хичээнэ.

Харри Захария Смит дарааллын урд орох гэсэн нэгдүгээр дамжааныхныг тараахыг харав. Бага сурагчид уйлж, томууд нь найз нөхөд болон ах эгчээ цөхрөн дуудна.

Харри сувдан цагаан дүрс үүдний танхимд явахыг хараад чимээ шуугианыг давахын тулд чанга хашгирлаа.

- Ник! Ник! Би чамтай ярилцах хэрэгтэй байна!

Тэр сурагчдийн дундуур чихэлдсээр эцэст нь Гриффиндор цамхагын хий үзэгдэл бараг толгойгүй Никийн хүлээн зогсож буй шатны талбайд хүрлээ.

- Харри! Хонгор хүү минь!

Ник баяртайгаар түүний гарыг атгахад цэв хүйтэн усанд дүрсэн юм шиг эвгүй санагдав.

- Ник надад туслаач. Когтевран цамхагийн хий үзэгдэл хэн юм бэ? Бараг толгойгүй Ник түүн рүү гоморхсон байртай гайхан харлаа.

- Мэдээж Саарал хатагтай. Хэрвээ чамд хий үзэгдлийн туслалцаа хэрэгтэй бол

...

- Надад тэр л хэрэгтэй байна. Чи түүний хаа байгааг мэдэх үү?

- Хараадахъя.

Никийн толгойгоо ганхуулан эргээд сурагчдын зүг харлаа.

- Тэр байна, Харри. Урт үстэй залуухан эмэгтэй.

Харри түүний тунгалаг хуруу дагуулан хараад өндөр тунгалаг дүрс хана нэвтлэн одохыг харлаа.

Тэр түүний араас ухасхийн явсан зүг рүү нь хонгилоор гүйгээд Саарал хатагтай хонгилын нөгөө өнцөгт чимээгүй гулган явахыг харав.

- Хөөе ... хүлээгээрэй ... битгий яваач!

Хий үзэгдэл газраас хэдэн инчийн зайд дүүжигнэн зогсов. Тэрбээр бүсэлхий хүрсэн үс, шал шүргэсэн цувтай үзэсгэлэнтэй хэдий ч ихэмсэг бардам ажээ. Харри дөхөж очихдоо түүнтэй хэдэн удаа тааралдаж байсан ч ярьж байгаагүй болохоо мэдэв.

- Та Саарал хатагтай юу? Тэр чимээгүй толгой дохив.

- Когтевран цамхагын хий үзэгдэл үү?

- Тиймээ.

- Танаас гуйя ... надад тусламж хэрэгтэй байна. Алга болсон титмийн тухай мэдэх бүхнээ надад яриач.

Түүний уруул дээр хүйтэн инээмсэглэл тодорсноо,

- Таньд юугаар ч тусалж чадахгүй гэж айж байна гээд явахаар эргэв.

- Хүлээгээрэй!

Харриг уур хилэн сандрал бүчсэн ч хашгирсангүй. Саарал хатагтай түүний өмнө ахин зогсох үед шөнө дунд болоход арван таван хором үлдээд байв.

- Энэ маш яаралтай. Хэрвээ титэм Хогварсад байгаа бол би түргэн олох хэрэгтэй байна.

- Та титэмний тухай мөрөөдсөн анхны сурагч биш. Эндхийн олон сурагч надад тайван байх боломж өгдөггүй юм гэж Саарал хатагтай зэвүүцэнгүй хэлэв.

- Энэ сайн дүн авахын тулд биш! Волдемортыг ялах тухай ярьж байна. Эвсэл энэ таны сонирхлыг татахгүй байна уу? гэж Харри хашгирлаа.

Тэр улайгаагүй хэдий ч тунгалаг хацар нь бараантсанаа ууртай хоолойгоор,

- Мэдээж ... та яаж зүрхэлж ...

- Тэгвэл надад тусал!

Түүний өөртөө итгэлтэй байдал алга боллоо.

- Учир нь ... асуудал түүнд биш. Титэм миний ээжийнх байсан ... гэж хий үзэгдэл бувтнав.

- Таны ээжийнх гэнээ?

Тэр харваас өөртөө уурссан бололтой,

- Өмнөх амьдралдаа би Хелена Когтевран байсан гэж хүйтнээр хэллээ.

- Та түүний охин юмуу? Тэгвэл титэмд юу тохиолдсоныг мэдэх ёстой доо!

- Титэм ухаан нэмдэг хэдий ч гэж хий үзэгдэл хүчлэн хэлээд,

- Лорд гэдэг нэртэй шидтэнг ялахад чинь хэрэг болно гэж бодохгүй байна гэв.

- Би түүнийг зүүх гээгүй гэж хэлээ биз дээ! Одоо энэ тухай тайлбарлах цаг алга. Хэрвээ таньд Хогвартс үнэтэй бол, хэрвээ та Волдемортыг хэрхэн дуусгахыг харахыг хүсч байгаа бол титэмний тухай юу мэдэхээ надад хэлж өг!

Саарал хатагтай агаарт чимээгүйхэн хөвөн түүн рүү харахад Харри гүнзгий цөхрөлд автлаа. Хэрвээ тэр ямар нэг зүйл мэдэж байсан бол энэ тухай Флитвик юмуу Дамблдорт хэлэх л байсан. Түүнийг толгой сэгсрээд явах гэтэл хий үзэгдэл гэнэт аяархан,

- Би ээжийнхээ титмийг хулгайлсан гэв.

- Та ... юу хийсэн гэнээ?

- Би титмийг хулгайлсан гэж Хелена Когтевран шивнэн давтаад,

- Би ээжээсээ илүү ухаантай болохыг хүсээд авааД зугтчихсан гэв.

Харри итгэлийг нь олохын тулд цашид юу асуухаа мэдсэнгүй ч тэрээр үргэлжлүүлэн,

- Миний ээж титэм алга болсон хойно ч бүгдэд урьдын адил түүнд байгаа гэж итгүүлж байсан гэж ярьцгаадаг. Тэр миний хийсэн аймшигтай урвалтыг Хогвартсын бусад үндэслэгчдээс нуусан юм. Харин дараа нь ээж өвдсөн ... маш хүнд өвдсөн. Хэдийгээр би урвасан ч гэлээ тэр надтай ахин уулзахыг хүсэж байсан юм. Тэр надад их хайртай байсан болохоор эрж олохоор хүн явуулсан. Ээж түүнийг тушаалыг нь биелүүлэхээс наана тайвширахгүй гэдгийг мэдэж байсан гэв.

Харри хүлээхэд Саарал хатагтай гүн санаа алдсанаа толгойоо унжуулав.

- Тэр миний нуугдаж байсан ойд мөрдөж ирсэн. Тэгээд намайг түүнтэй явахаас татгалзахад аймшигтай уурласан юм. Барон үргэлж цочмог ууртай байдаг байсан. Тэр миний татгалзал болон чөлөөтэй байдалд минь атаархаад уурандаа хутгаар дүрчихсэн юм.

- Барон гэнээ? Та хэлэх гээ юу ...?

- Тиймээ Цуст барон гээд Саарал хатагтай жанчаа сөхөн цагаан цээжин дээрх бараан шархаа харууллаа.

- Тэр юу хийснээ харах үедээ харуусалд автан зэвсгээ аваад өөрийгөө алсан юм.

Түнээс хойш олон зууны турш нүглээ наминчилахаар гинжтэй яваа ... гэж гашуунаар хэлэв.

- Харин ... титэм яасан бэ?

- Тэр бароныг ирэхэд миний нуусан газар хэвээр үлдсэн. Хөгшин модны хонгилд.

- Хөгшин мод хонгилд гэнээ? Ямар мод? Хаана байдаг юм?

- Албанийн ойд. Миний эхийн хүрч чадахааргүй хүнгүй газарт.

- Албанид гэж Харри давтлаа.

Түүнд гайхамшигтай санаа төрөхөд яагаад Дамблдор, Флитвик хоёрт нууцаа хэлээгүй болохыг нь ойлголоо.

- Та нэг удаа энэ түүхийг ярьсан тийм үү? Сургуулийн сурагчид. Тэр нүдээ анин толгой дохилоо.

- Би ... мэдээгүй ... тэр их ... элдэг байсан. Намайг ойлгож ... өрөвдөж байх шиг санагдсан.

«Тиймээ. Том Реддл Хелена Когтевраны эрдэнэсийг эзэмшихийн тулд үнэхээр ойлгож байсан» гэж Харри бодов.

- Та Реддэлд залилуулсан анхны хүн биш. Тэр хүссэн үедээ сэтгэл татам байж чаддаг юм гэж Харри бувтналаа.

Тэгэхээр Волдеморт Саарал хатагтайн алга болсон титэм нуусан газар луу явжээ. Тэр алс холын ойд очоод нуусан эрдэнэсийг авсан. Магадгүй «Горбин ба Бэркс»-т ажиллахын өмнө Хогвартсыг төгссөний дараа ингэсэн байх боломжтой.

Энэхүү Албаны бөглүү ой юм нуухад маш тохиромжтой газар болохоор Волдемортод ойг гүнд нь хүртэл самнахын тулд арваас доошгүй жил орсон болов уу?

Гэсэн ч ч титэм модонд үлдсэнгүй үнэт крестраж болон хувирчээ ... Үгүй ээ, титэм төрсөн газартаа эргэн ирсэн. Волдеморт түүнийг ийш нь ...

- Ажил асуудаг шөнөө авчирсан байх! гэж Харри бодлоо чанга дуусгав.

- Өршөөгөөрэй?

- Тэр титмийг Дамблдороос багшлах зөвшөөрөл гухай гэж ирэхдээ шилтгээнд нуужээ! гээд Харри гэнэтхэн бүгдийг ойлголоо.

- Харваас титмийг нуугаад Дамблдорын өрөө лүү өгссөн байх ... эсвэл уруудсан хойноо ч юмуу! Мэдээж ажилд орж байж л Гриффиндорын илдийг авч чадах байсан ... Баярлалаа таньд, баярлалаа!

Харри гайхширсан хий үзэгдлийг үлдээгээд үүдний танхим руу буцах замдаа ахин цаг руугаа харлаа. Шөнө дунд болоход таван хором үлдээд хэдийгээр тэр сүүлчийн крестраж ямар болохыг мэдэж байсан ч хаана байгааг нь мэдсэнгүй ...

Олон сургуулийн сурагчид титмийг уйгагүй эрсээр ирсэн ч Когтевраны цамхагт байгаагүй. Тэгэхээр хаана гэж? Том Реддл Хогвартсад мөнх нууж чадахаар ямар нууц газар байх вэ.

Тэр цөхрөлд автан булан тойртол зүүн талд нь цонх тар нярхийн хагарч нүсэр бие нисэн орж ирэхэд арай ядан булташ амжтал эсрэг талын хана мөргөв. Тэндээс том үстэй амьтан чулуудагдан гасаллаа.

- Хагрид! Ямар ... гэж Харри Соётыг холдуулахыг оролдон хашгирахад том сахалтай дүрс шалан дээрээс өндийлөө.

- Харри чи энд байна! Чи энд байна!

Тэр бөхийн Харрийн хавиргыг шажигнатал тэврээд хагарсан цонх руу эргэснээ,

- Сайн байна, Грошик! Би одоохон чам дээр эргээд ирнэ ээ ухаалаг байгаарай!

гэж нүхээр хашгирав.

Хагридын толгойны ард харанхуй цонхоор алсад гэрэл гялсхийн орилж хашгирах чимээ сонсогдов. Тэр цагаа харахад шөнө дунд болжээ. Дайн эхэллээ.

- Чөтгөр гэж, Харри. Энэ тэр үү? Тэмцэл эхэлсэн үү? гэж Хагрид уулга алдав.

- Хагрид чи хаанаас гараад ирэв?

- Бид Хэцүү нэртийг агуйнаасаа сонссон юм. Хоолойг нь ойлгож байна уу?

Шөнө дунд болохоос өмнө Поттерыг авчирч өг гэж. Би чамайг нэг зүйл хийж

байна гэж ойлголоо. Доошоо суу, Соёот. Тэгээд л бид чамд туслахаар ирсэн юм. Грошик ой дундуур Соёот бид хоёрыг гаргасан. Би түүнд шилтгээнд орох хэрэгтэй байна гэхэд цонхоор оруулсан. Гэхдээ би яг ингэхийг хүсээгүй ч ... Ингэхэд Рон, Гермиона хоёр хаана байна?

- Сайхан асуулт байна. Явцгаая.

Тэд хамтдаа яаран хонгилоор явахад Соёот хэлээ унжуулан дагалдав. Харри эргэн тойрон гүйлдэх чимээ болон, хашгиралт сонсож харанхуй цонхоор шилтгээний нутаг дэвсгэрт гэрэл гялсхийхийг харлаа.

- Бид хаашаа явж байгаа юм? гэж Хагрид хүндээр амьсгаадан явахдаа асуув.

- Сайн мэдэхгүй байна. Гэхдээ Рон, Гермиона хоёр хаа нэгтээ байх ёстой гээд

Харри ахин нэг булангаар эргэлээ.

Хонгилын эцэст тулааны анхны хохирогч болох багш нарын өрөөний үүдийг хамгаалдаг хоёр чулуун луу шившлэгэнд өртөн хагараад шалан дээр сулхан хөдөлж хэвтэнэ. Харри нэгнийнх нь толгой дээрээс бөхийхөд,

- Надад анхаарал хандуулах хэрэггүй ... Би сүйрээд хэвтэж байна гэв.

Түүний чулуун царайг хараад Харри гэнэтхэн Ксенофилиусын байшинд байсан Кандида Когтевраны гантиг цээж баримлын толгойн чимэг болон Когтевраны цамхагын чулууны хөшөөний буржгар цагаан үсэн дээр зүүсэн титмийг саналаа ...

Тэгээд хонгилын эцэст хүрэх үед хөгшин чулуун шидтэний толгой дээр байсан хиймэл үсэнд титэм угласан нь санаанд оров. Тэгтэл галт шарз уусан мэт чих нь шуугиад явчихад гуйвлаа.

Тэр одоо л сүүлчийн крестраж хаана байгааг мэдлээ.

Том Реддл хэнд ч итгэлгүй үргэлж ганцаар ажиллан Хогвартс шилтгээний гүн нууцуудыг мэддэг байсан. Түүнчлэн Дамблдор, Флитвик болон үлгэр жишээ сурагчид хэзээ ч энэ газар орохгүй ч Харри сургуульд сурч байх үедээ дардан бус замаар явж байсан. Түүнийг эцэстээ Волдемортын нууц газрыг мэдэж байсан гэж Дамблдорын санаанд ороогүй байх.

Түүний замд профессор Стебль, Невилл хоёр хэдэн сурагчдын хамт чихэвч өмсөөд гартаа том цэцгийн сав авч явж байгаа нь тааралдав.

- Мандрагорууд! Бид тэднийг хана давуулан хаяад Волдемортын талынханд яаж таалагдахыг харах болно гэж Невилл дэргэдүүр нь өнгөрөхдөө хашгирлаа.

Харри одоо хааш явахаа мэдэж байв. Тэр алхаагаа хурдасгахад Хагрид, Соёот хоёр дагалдав. Тэд хөргийн урт эгнээг явж өнгөрөхөд дугуй эргэдэг захтай, дуулга, жанчтай шидтэнгүүд зурагнаас зурагны хооронд гүйлдэн шилтгээний бусад хэсэгт болсон үйл явдлын сонинг бие биедээ дуулгаж байв. Тэгээд хонгилын эцэст хүрэх үед гэнэтхэн шилтгээн чичирлээ.

- Соёот минь айх хэрэггүй! гээд Хагрид орилсон ч том анч нохой агаарт шаазангийн хэлтэрхий шиг үсрэхэд айсан нохойныхоо араас хөөгөөд Харриг ганцаар үлдээв.

Харри чичирсэн гарцаар гарахдаа саваагаа бэлхэн барилаа. Нэг хонгилд дэргэд нь жижигхэн хүлэг баатар ноён Кэдоган дуулгаа хангиуулан гүйж урмын үг хашгирахад жижигхэн одой морь ард нь шогшуулж байлаа.

- Сагсуу луйварчин, галзуу амьтад! Тэдэнд үзүүлээд өг, Харри Поттер. Бүгдийг нь хөө!

Харри яаран булан эргээд Фред Ли Жордан, Ханна Аббот тэргүүтэй хэсэг сурагчдын хамт нууц гарцыг халхалж байсан хөшөөний хоосон суурины дэргэд зогсож байхыг харлаа. Хүүхдүүд гарцыг анирдан саваагаа бэлхэн барьжээ.

- Хөгжилтэй шөнө байна! гэж Фред хашгирахад шилтгээн ахин чичирч Харри цааш гүйлээ. Тэр дараагийн хонгилд хүрээд хаа сайгүй ууль харав. Хатагтай Норрис цөхрөн мяулж сарвуугаараа хүрэхийг хичээнэ ...

- Поттер!

Түүний замыг саваагаа бэлхэн барьсан Аберфорт Дамблдор хаан зогсов.

- Миний бааранд зуугаад хүүхдүүд байна, Поттер!

- Бид тэднийг явуулсан болохоор мэднэ. Волдеморт ...

- ... чамайг барьж өгөхийг татгалзсан учраас сургууль руу дайрч байгаа биз дээ.

Би тэнэг биш Хогсмидэд түүний хоолой сонсогдсон. Үнэхээр хэний ч толгойд Слизеринийхнийг барьцааны хүнээр үлдээх санаа орсонгүй гэж үү? Тэнд байсан Үхэл залгигчидийн хүүхдүүд аюулгүй газар луу илгээгдсэн. Тэднийг энд үлдээгээгүй чинь ухаалаг санаа биш байлаа.

- Волдемортыг энэ зогсоохгүй. Таны ах хэзээ ч ийм алхам хийхгүй байсан гэж

Харри хэлэв.

Аберфорт тургилаад эргэж нөгөө тийш явлаа.

Таны ах хэзээ ч ийм алхам хийхгүй байсан ... Юу үнэн гэвэл энэ үнэн. Дамблдор олон жил Снеггийг хамгаалж байсан болохоор хэзээ ч сурагчдыг барьцааны хүнээр ашиглахыг зөвшөөрөхгүй байсан ...

Харри эцэст нь сүүлчийн хонгил руу гулсан эргээд харсан зүйлдээ уур нь хүрсэн ч санаа амарлаа. Түүний өмнө Рон, Гермиона хоёр гартаа том махигар бохир шар зүйл бариад зогсож байв. Рон гартаа шүүр барьжээ.

- Та хоёр хаанаас гараад ирэв? гэж Харри ориллоо.

- Нууц өрөөнөөс гэж Рон хэлэв.

- Ямар ... өрөө? гээд Харри огцом зогслоо.

- Энэ бол Роны санаа байсан! Гайхамшигтай байгаа биз, тийм үү? Чамайг явсны дараахан би Роноос хэрвээ дараагийн зүйлийг бид олох юм бол түүнээс

яаж салахыг асуусан юм? Бид одоо хүртэл аяганаас салаагүй байгаа. Тэгтэл нэг санаа орж ирсэн! Василиск!

- Юу ...

- Крестражыг устгах чадвартай зүйл гэж Рон энгийнээр хэлэв.

Харри ахин том махигар соёо руу хараад үхсэн василискаас салган авсан болохыг нь ойлголоо.

- Гэхдээ та хоёр тийшээ яаж орсон юм? Үүний тулд могойн хэлээр ярих ёстой шүү дээ! гэж Роны соёог харан асуулаа.

- Тэр ярьсан! Түүнд үзүүл, Рон! гэж Гермиона шивнэв. Рон боож үхэх гэж байгаа хүн шиг исгэрлээ.

- Би чиний зүүлтийг яаж онгойлгож байхыг сонссон юм. Эхний удаагаа болоогүй ч эцэст нь бид тийшээ орсон гэж ичингүйрсэн шинжтэй мөрөө хавчин хэлэв.

- Тэр гайхалтай! Гайхалтай! гэж Гермиона дуу алдав.

- Тэгэхээр та нар ... хэмээн Харри бүх хүчээ гарган ойлгохыг хичээн дуугарлаа.

- Бид ээлжит крестражыг устгасан. Гермиона түүнийг василискийн соёогоор зоосон. Би түүнд боломж өгөх ёстой гэж үзсэн ч ... таатай санагдаагүй байх гээд Рон хүрмэн дороосоо Пуффендуйн аяганы хэмхэрсэн үлдэгдлийг гарган ирэв.

- Чи агуу! гэж Харри хашгирлаа.

- Дэмий яриа гэж Рон сэтгэл хангалуун хэлээд,

- Харин чамаар сонин юу байна? гэв.

Энэ үед дээр дэлбэрэлт сонсогдон адраас тоос бужигнав. Гурвуул дээшээ харахад алсад хашгиралт сонсогдлоо.

- Би титмийг ямар харагддаг болон хаана байгааг нь мэднэ. Тэр намайг уусмалын хичээлийн хуучин сурах бичгээ нууж байхад зууны турш нуусан зүйл дунд байсан. Тэр түүнийг хэн ч олж чадахгүй гэж бодож. Явцгаая.

Хана ахин чичирлээ. Тэр Рон, Гермиона хоёрыг дагуулан Шаардлагатай өрөөний шатаар уруудлаа. Энд Жинни, Тонкс болон цагаан эрвээхэйд идэгдсэн малгайтай настай шидтэн гурваас өөр хэн байсангүй. Харри Невиллийн эмээг танилаа.

- Аан Поттер. Бидэнд юу болоод байгаа тухай ярич гэж тэр ирэхийг нь хүлээж байсан мэт хэлэв.

- Бүгд бүтэн үү? гэж Жинни, Тонкс хоёр зэрэг асуулаа.

- Ер нь бол тийм. «Гахайн толгой»-н гарцан дээр өөр хүн үлдсэн үү? Тэр өрөөнд хүмүүс байхад өөрчлөгдөхгүйг мэдэж байв.

- Би хамгийн сүүлд түүгээр ирсэн. Аберфорт бараа орхисон болохоор аюулгүй биш санагдаад лацадсан. Чи миний ач хүүг харав уу? гэж хатагтай Долгопупс хэлэв.

- Тэр тэмцэж байгаа гэж Харри хэллээ.

- Тэгэлгүй яахав. Уучлаарай биш явж туслах ёстой гэж хөгшин хатагтай бардам хэлээд шатаар түргэн өгслөө.

- Би чамайг хүүтэйгээ эхийндээ байгаа гэж бодсон юмсан гээд Харри Тонкс руу харлаа.

- Юу ч мэдэхгүй суугаад байж тэвчсэнгүй. Чи Римусыг харав уу? гэж Тонкс шаналангуй хэлэв.

- Тэр сургуулийн нутаг дэвсгэрийг хамгаалах бүлгийг тэргүүлж ... Тонкс цаашдын үгийг сонсолгүй орхин явлаа.

- Жинни. Уучлаарай чамайг эндээс гарахыг гуйх гэсэн юм. Тийм ч удаан биш.

Дараа нь буцаж орж болно.

Жинни харваас орогнох газраас мултарсандаа аймшигтай баярлав бололтой.

- Дараа нь Шаардлагатай өрөөнд эргэж ирнэ шүү! Чи заавал буцаж орох ёстой!

гэж Харри түүнийг Тонксын араас шатаар гүйн өгсөхөд нь хашгирав.

- Хүлээгээрй. Бид хэн нэгнийг мартсан шиг байна! гэж Рон огцом хэлэв.

- Хэнийг? гэж Гермиона асуулаа.

- Гэрийн үйлчилэгчид тэд бүгдээрээ гал зууханд байгаа биз дээ?

- Чи тэднийг тэмцэлд оруулахыг хүсээ юу? гэж Харри хэлэв.

- Үгүй. Би тэднийг бас нүүлгэх хэрэгтэй гэж бодож байна. Бид Доббид тохиолдсон явдал давтагдахыг хүсэхгүй байгаа биз дээ? Тэднийг биднээс болж үх гэж тушааж болохгүй.

Чанга нүргэлэх чимээ гарахад Гермиона василискийн соёог унагаад Рон руу гүйн очиж хүзүүгээр нь тэврэн үнслээ. Рон шалан дээр соёо, шүүрээ унагаад хариу тэврэн үнсэхэд Гермионагийн хөл шалнаас хөндийрөв.

- Цагаа олж дээ! гэж Харри аяархан хэлсэн ч тэд хэрэгссэнгүй бие биетэйгээ тэврэлдэн ганхан зогссон хэвээр байв.

- Хөөе. Бид чинь дайнд байна! гэж Харри чанга хэллээ. Тэд хөтөлцөөтэй хэвээр бие биенээсээ холдлоо.

- Би мэднэ найз минь гэж Рон шилэн хүзүү рүүгээ блажераар цохиулсан аятай хэлээд,

- Иймээс одоо эсвэл хэзээ ч үгүй гэдгийг ойлгож байна уу? гэв.

- Сайн байна тэгвэл крестражын тухайд яах болж байна? Та нар ... титмийг олтол жаахан хүлээж болохгүй байна уу.

- Тиймээ ... чиний зөв уучлаарай гээд Гермиона тэр хоёр Василискийн соёог авснаа час улайлаа.

Тэднийг хэдхэн хормын өмнө Шаардлагатай өрөөнд нэвтэрсэн ханаар гарахад шилтгээний байдал муудсан байлаа. Хана адар улам аймшигтай чичирч агаарт дүүрэн тоос бужигнаад цонхны цаана улаан ногоон өнгийн оч гялсхийн ниснэ. Үхэл залгигчид одоохон нэвтрэх нь бололтой. Харри доор аварга биет Грохх уурсан чангаар хашгирч чулуун луугаар даллахыг харлаа.

- Тэдний хэн нэгийг онох байх гэж найдъя! гэж Рон хашгиралтыг сонсоод хэлэв.

- Хэрвээ энэ бидний хэн нэгэн биш бол ч гэх хоолой ард нь гарахад Харри эргэж хараад Жинни, Тонкс хоёр саваагаа цонх руу чиглүүлэн шилийг нь алга болгохыг харав. Жинни дор байгаа Үхэл залгигч руу шившлэг илгээлээ.

- Сайн байна! гэж хэн нэгэн хашгираад тоосон дундаас дүрс урган гарч ирэхэд Харри буурал үс нь өрвийсөн Аберфорт хонгилоор бүлэг хүүхэд дагуулан явахыг харлаа.

- Тэд хойд ханыг нэвтлэх нь байна. Аварга биетүүдийг авчирч!

- Та Римусыг хараагүй биз? гэж Тонкс араас нь хашгирав.

- Тэр Долоховтой тэмцэж байсан түүнээс хойш би хараагүй.

- Тонкс түүний бүх зүйл хэвийн гэж Жинни хэлсэн ч Тонкс хэдийн тоосон дундуур Аберфортын араас гүйжээ.

Жинни тэдэн рүү эргэв.

- Бүх зүйл сайхан болно гэж Харри хэдийгээр энэ нь хоосон үг болохыг нь мэдэж байсан ч хэлээд,

- Жинни бид одоохон эргээд ирнэ ... хаа нэгтээ буланд нуугд хаашаа ч битгий яваарай ... гэв.

Тэгснээ «явцгаая» хэмээн Рон, Гермиона хоёрт хандав. Тэд хана даган буцаж гүйгээд

Шаардлагатай өрөөний үүдэнд хүрлээ.

«Надад бүх зүйл нуудаг газар хэрэгтэй байна» гэж Харри дотроо гуйгаад хананы дэргэдүүр гурван удаа өнгөрөхөд хаалга бий боллоо.

Тэднийг босго давмагц хаалга хаагдан тулааны чимээ шуугиан намдаж нам гүм болов. Сүм шиг уужим өрөөнд Хогвартсын сурагчдын мянган жилийн өмнөөс нуусан ханан хот шиг эгнэсэн эд зүйлсийн цамхаг өндөрт сүндэрлэнэ.

- Тэр үнэхээр ийшээ хэн ч орж ирнэ гэдгийг ойлгоогүй юм болов уу? гэж Рон хэлэхэд бөглүү цуурайтав.

- Тэр ганцаараа л чадна гэж бодсон. Гэхдээ би ийшээ юм нуухаар орж ирсэн болохоор түүнд аз таарсангүй ... Ийшээ. Би тэнд байгаа гэж бодож байна гэж Харри хэлэв.

Тэр чихмэл савдаг болон Драко Малфойн өнгөрсөн жил зассан алга болдог шүүгээний дэргэдүүр өнгөрөөд хаашаа явахаа санаж чадсангүй ...

- Акцио, титэм! гэж Гермиона цөхрөн хашгирсан ч юу ч болсонгүй.

Харваас Шаардлагатай өрөө Гринготтсын шүүгээний адил шидийн хамгаалалттай бололтой.

- Алив хуваагдъя. Хиймэл үсэн дээр титэм зүүсэн цээж баримал эрж олоорой!

Тэр шүүгээний дэргэд байсан гэж Харри хэлэв.

Тэд эгнээ дундуур явлаа. Харри найзуудынхаа хөлийн чимээг сонсож лонх, малгай, тор, хайрцаг, ном, зэвсэг, шүүр, квиддчийн цохиур харсаар явлаа.

- Хаа нэгтээ байсан л юмсан. Энүүхэн энд гэж өөртөө бувтнав.

Тэр төөрдөг байшингийн гүнд улам алсан холдтол урьд нь ирж байсан газрынхаа зүйлийг танилаа. Баруун талд нь уусмалын хичээлийн хуучин сурах бичгээ нууж байсан орой дээрээ тоосонд дарагдсан хиймэл үс, өнгөө алдсан титэм бүхий сэвхтэй шидтэний цээж баримал тавьсан шүүгээ харагдахад зүрх нь булгилан цохилж амьсгал давхцав.

Тэр гараа сунган ойртоод хэдэн алхам үлдээд байтал ард нь нэг хоолой,

- Поттер, зогс! гэлээ.

Харри огцом эргэж харахад ард нь Крэбб, Гойл хоёр мөр мөрөө түшин зогсоод шидэт саваагаа чиглүүлсэн байлаа. Тэдний дундах жижигхэн зайд Драко Малфойн доогтой царай харагдав.

- Чиний гарт миний саваа байна, Поттер! гээд Малфой Крэбб, Гойл хоёрын завсраар заалаа.

- Үгүй чинийх биш болсон. Би үүнийг тэмцлийн дүнд авсан, Малфой. Харин чи үүнийг хэнээс авсан юм? гээд Харри долоогоны модон саваагаа чанга атгалаа.

- Ээжээсээ.

Хэдийгээр үйл явдал хөгжилгүй байсан ч гэлээ Харри инээд алдав. Рон, Гермиона хоёр хаа нэгтээ хол байгаа бололтой.

- Харин та гурав яагаад Волдемортой биш байгаа юм? гэж Харри асуулаа.

- Шагнал авахыг хүссэн юм гэж Крэбб нүсэр биедээ багадсан жингэнэсэн хоолойгоор хэлээд хүүдий чихэр өгөхөөр амласан жижигхэн хүүхэд шиг баясан инээмсэглэхэд Харрид түүний ам нээхээс урьд сонсогдох шиг санагдав.

- Бид буцаж үлдсэн, Поттер. Явахгүй байхаар шийдсэн юм. Чамайг түүнд хүргэж өгөхөөр шийдсэн.

- Сайхан төлөвлөгөө байна! гэж Харри шоолонгуй хэлэв.

Тэр Малфой, Крэбб, Гойл гурав ийм зайнаас саад болно итгэсэнгүй тул удаанаар крестражын байгаа цээж баримал руу ухран алхав. Хэрвээ түүнийг тэмцэл эхлэхээс өмнө авч амжвал ...

- Ингэхэд та нар наашаа яаж орж ирсэн юм бэ? гэж тэднийг сатааруулахын тулд сонирхов.

- Би өнгөрсөн жил нуудаг зүйлсийн өрөөнд арай л хоноглоогүй. Би ийшээ орж ирэхийг сайн мэднэ гэж Малфой хэлэв.

- Бид гадаа хонгилд нуугдаж байлаа. Одоо бид Далдлагддаг шид хэрэглэж чаддаг болсон. Тэгтэл чи булангаас бидний өмнө үсрэн гарч ирээд тидэм хэрэгтэй гэж хэлсэн. Юун тидэм вэ? гэж Гойл тэнэгдүүхэн инээмсэглэн хэллээ.

- Харри? Чи тэнд хэнтэй яриад байна? гэх Роны хоолой баруун талд нь сонсогдов.

Крэбб саваагаа шавхуурдах адил түргэн хөдөлгөж тавин футын зайд байгаа эвдэрхий тээш, хуучин ном, жанч зэрэг хуучин эд зүйлсийн дэлгүүр ч голоод авахгүй эд зүйлс рүү чиглүүлээд,

- Дисцендо! гэв.

Хана доргисноо гэнэтхэн Роны хажуугийн эгнээ нурлаа.

- Рон! гэж Харри Гермионагийн хашгирахыг сонсоод орилов. Харри хэрхэн тоолж баршгүй эд зүйлийн овоолго бие биенээ даран унахыг хараад саваагаа жигүүр хооронд чиглүүлэн,

- Фините! гэж хашгирахад зогсов.

- Үгүй ээ! Хэрвээ чи бүх өрөөг сүйрүүлэх бид титмийн хэлтэрхийг ч олж чадахгүй! гэж Малфой шившлэгээ давтах гэж байсан Крэббийн гараас зууран орилов.

- Тэгээд юу гэж? Хар лорд Поттерыг хүссэн болохоос биш титмийг биш! гээд

Крэбб түүнийг түлхлээ.

- Поттер ийшээ түүний төлөө ирсэн. Харин тэр ... гэж Малфой уцаарлан дуугарав.

- Юу байх ёстой гэж? гээд Крэбб Малфойн зүг хэрцгийгээр эргэж,

- Хэн чиний бодлыг сонирхох юм бэ? Би чамаас тушаал сонсохгүй, Драко. Чи аавтайгаа дууссан хүмүүс гэв.

- Харри! Юу болоод байна? гэж Рон ахин хашгирав.

- Харри! гэж Крэбб даажигнан хэлээд,

- Юу болоод байна гэнэ шүү ... Үгүй, Поттер! Круцио!

Харри титэм рүү гар сунгасан ч Крэббийн шившлэг түүнийг онолгүй чулуун баримлыг цохиход агаарт мулт үсрээд титэм толгой дээрээс нь унаж овоолсон эд зүйлсийн дунд далд оров.

- Зогс! Хар лорд түүнийг амьдаар нь хүсч байгаа ... гэж Малфой Крэбб рүү хашгирав.

- Тэгээд юу гэж? Би түүнийг алах гээд байна уу? гэж Крэбб Малфойн гарыг сэгсэрснээ зандраад,

- Гэхдээ болох юм бол би түүнийг алах болно. Хар лорд түүнийг үхлийг л хүссэн биз дээ? гэв.

Харрийн дэргэдүүр улаан оч гялсхийн өнгөрөхөд Гермиона булангийн цаанаас гүйн гарч ирээд Крэббийн толгой руу Хөшөөх шившлэг илгээлээ. Гэвч Малфой Крэббийг түлхэж амжсан учир оносонгүй.

- Бохир цустан! Авада Кедавра!

Харри Гермиона хэрхэн Крэббийн үхлийн шившлэгээс хажуу тийш булталхыг хараад уур хилэн нь дүрэлзэн бусад зүйлс хамаагүй болов. Тэр Крэбб рүү Хөшөөх шившлэг илгээхэд үсрэн холдохдоо Малфойн гарт байсан шидэт сабаг цохиод унагачихлаа.

- Түүнийг битгий ал! Түүнийг битгий ал! гэж Малфой Харри руу саваагаа чиглүүлсэн Крэбб, Гойл хоёрт хандан хашгирав. Тэдний түр зуурын эргэлзээ Харрид тус боллоо.

- Экспеллиармус!

Гойлын саваа мулт үсрэн ханан хэрмийн дунд алга болов. Гойл дүйнгэтэн эргэлдэж саваагаа олохыг хичээнэ. Малфой Гермионагийн илгээсэн хоёр дахь Хөшөөх шившлэгээс булталхад, Рон гэнэтхэн жигүүрийн төгсгөлөөс гарч ирээд Саажуулах шившлэг илгээсэн ч оносонгүй.

Крэбб огцом эргээд ахин,

- Авада Кедавра! гэж хашгирлаа.

Рон бөхийн ногоон очноос булталв. Саваагүй үлдсэн Малфой гурван хөлтэй хувцасны шүүгээний ард нуугдахыг хичээхэд, Гермиона Гойлыг Хөшөөх шившлэгээр онов.

- Тэр энд хаа нэгтээ байгаа! Эрж бай би Ронд туслая ... гэж Харри хашгираад титмийн унасан овоолго руу заалаа.

- Харри! гэж тэр хашгирав.

Түүний ард давалгаалах мэт чимээ гарахад эргэж хараад Рон, Крэбб хоёр хамаг хурдаараа гүйлдэн ирэхийг харлаа.

- Дулаацмаар байна уу, новш оо? гэж Крэбб гүйх зууpаа хашгирав.

Гэсэн ч тэр шидийн хяналтаа алдсан бололтой. Итгэмээргүй том хэмжээтэй дөл тэдний араас хөөн хүрсэн бүх зүйлээ үнсэн товрог болгож байлаа.

- Агуаменти! гэж Харри орилоход сабааныхаа үзүүрээс ус шүршсэн ч агаарт ууршин алга болов.

- Зугтаарай!

Малфой хөшөөх шивлэгт өртсөн Гойлыг ардаа чирэв. Крэбб бүгдийн түрүүнд айсан шинжтэй хурдлан гүйлээ. Харри, Рон, Гермиона гурав зугтахад араас нь гал хөөв. Энэ бол жирийн нэг гал байсангүй. Крэбб Харрийн мэдэхгүй шидийг хэрэглэсэн бололтой тэднийг булан эргэхэд галын дөл амьд байгааг нь мэдсэн юм шиг алахаар хөөв. Тэгснээ гал хэлбэр дүрсээ өөрчилөн асар том галт амьтдын цуглуулга болох дөлт могой, химер, луу болоод агаарт хөөрөн соёотой амаа ярзайлган, эврээрээ мөргөж, ясархаг сарвуугаараа маажлан хүрэхийг хичээв.

Малфой, Крэбб, Гойл гурав хараанаас алга болов. Харри, Рон, Гермиона гурав байрандаа хөшлөө. Аймшигт хэрцгий мангас тэднийг дугуйран бүсэлж улам ойртон ирэхдээ эврээ сэжин, сүүлээ шавхуурдав.

- Одоо яах вэ? Юу хийх болж байна? гэж Гермиона дөл дунд хашгирав.

- Ааарай!

Харри ойролцоох овоолгоос хоёр хүнд шүүр аваад нэгийг нь Рон руу шидлээ. Тэр түүнийг унаад Гермионаг ардаа суулгав. Харри хоёр дахид нь суугаад газар хүчтэй түлхэн хөөрөхөд эвэр хошуутай галт химер эрүүгээ тас нясхийлгэн дайрсан ч тэдэнд хүрсэнгүй. Халуун болон утаа тэсэхийн аргагүй байлаа. Тэдний дор шидэт гал сурагчдын хууль бусаар нуусан олон тооны эд зүйлсийг дүрэлзүүлэн шатаав. Харри доош харахад Малфой, Крэбб, Гойл нар хаа ч байсангүй. Тэр дор нисэж байсан учир галт мангасын дөл барьж авахыг хичээсэн ч бүтсэнгүй. Ямар аймшигт үхэл вэ ... тэр үүнийг хүсэхгүй байна ...

- Харри эндээс гарцгаая! гэж Рон хашгирсан ч өтгөн хар утаан дунд хаалгыг олох боломжгүй байлаа.

Тэгтэл Харри бүхнийг залгиж буй галын тас нясхийх дуун дундаас аяархан өрөвдөлтэй гонгинох дуу сонсов.

- Энэ хэтэрхий аюултай! гэж Рон хашгирсан ч Харри хэдийн эргэжээ. Түүний нүдний шил утаанд тортоглосон ч галын тэнгис рүү доошлоод гар хөл юмуу нүүр царай зэрэг амьд хүний шинж тэмдэг ялган харахыг хичээлээ ...

Тэгтэл тэднийг харлаа. Малфой шатсан ширээний овоолго болох хэврэгхэн пирамидын орой дээр зогсоод гартаа ухаан алдсан Гойлыг барьсан байв. Харри доош шумбалаа. Малфой түүнийг хараад гараа сунгахад Харри барьсан ч энэ нь бүтсэнгүй. Гойл хэтэрхий хүнд байсан тул Малфойн норж хөлсөнд нэвтэрсэн гар Харрийн алгаас мултрав.

- Хэрвээ бид нар тэднээс болж үхэх юм бол би чамайг ална шүү, Харри! гэх Роны хоолой дэргэд нь сонсогдов. Галт химер харайн ирэхэд Рон, Гермиона хоёр хэдийн Гойлыг шүүрэндээ тэгнээд дээш хөөрч, Малфой Харрийн ард суув.

- Хаалга руу! Түргэн хаалга руу! гэж Малфой чихэнд нь гонгинолоо.

Харри шүүрээ залан Рон, Гермиона, Гойл нарын араас дагахад баагисан хар утаа дунд амьсгал авах боломжгүй байлаа. Тэднийг галт мангаст өртөөгүй сүүлчийн эд зүйлс болох аяга, бамбай, гялалзсан зүүлт, өнгөө алдсан титмийн дээгүүр хөөрөхөд

...

- Чи юу хийж байна? Юу хийж байна, хаалга тэнд байна! гэж Малфой Харри огцом эргээд доошилоход хашгирлаа. Титэм галт могойн ам руу удаанаар эргэлдэн гялсхийн унахад амжин барьж аваад бугуйдаа углав ...

Могой түүний зүг ухасхийсэн ч зайлсхийн эргээд шүүрээ дээшээ чиглүүлж хаалга олохыг хичээв. Рон, Гермиона, Гойл нар алга болж Малфой Харригаас өвдтөл зуурч байлаа. Харри эцэст нь утаан дунд хананд байгаа дөрвөлжин булантай дүрс олж хараад шүүрээ тийш чиглүүлэв. Хормын дараа тэр цэвэр агаар амьсгалж Малфойн хамт хонгилд гарлаа.

Малфой шүүрнээс буугаад нүүрээ доош харуулан хахаж цацан хэвтэв. Харри нуруугаараа хана налан суулаа. Шаардлагатай өрөөний хаалга алга болж шалан дээр Рон, Гермиона хоёр хүндээр амьсгаадан суугаад дэргэд нь Гойл ухаангүй хэвээр байв.

- К-крэбб ... К-крэбб ... гэж Малфой эцэст нь үг хэлэх чадвартай болоод хэлэв.

- Тэр үхсэн гэж Рон хэрцгий хэллээ.

Нам гүм болоход зөвхөн амьсгаадах ханиалгах чимээ дуулдана.

Дараа нь шилтгээн аймшигтай нижигнэн чичрэхэд толгойгоо гартаа барьсан тунгалаг морьтонгуудын урт цуваа хашгиран өнгөрөв. Харри хөл дээрээ гуйвлан босоод толгойгүй анчдын клубыг дагуулан харлаа. Эргэн тойрон урьдын адил тэмцэл үргэлжилсээр байв. Айдас түүнийг бүчин авлаа.

- Жинни хаана байна? Тэр энд байсан. Би түүнд Шаардлагатай өрөөнд буцаж орохыг тушаасан гэж огцом хэлэв.

- Чөтгөр гэж чи Шаардлагатай өрөө ийм түймрийн дараа хэн нэгэнд онгойно гэж бодож байна уу? гээд Рон бас үсэрч босоод цээжээ илэн хонгил руу харлаа.

- Хуваагдаад өөр газар хайх уу?

- Үгүй гээд Гермона бас босоход саваагүй болсон Малфой, Гойл хоёр шалан дээр тэрийн хэвтэнэ.

- Алив хамтдаа явцгаая. Ийшээ явах хэрэгтэй байх ... Харри чиний гарт юу байгаа юм?

- Юу? Аан тийм л дээ.

Тэр титмийг бугуйнаасаа тайлаад өргөн харлаа. Тэр харлаж халуу шатсан хэвээр байсан ч дээр нь бичигдсэн «УХААН АЛТНААС ҮНЭТЭЙ» гэсэн бичгийг уншиж болохоор байлаа.

Титмээс цусыг санагдуулам бараан өнгийн шингэн дуслав. Тэгтэл Харрид гэнэтхэн гартаа барьсан төмрийн хэлтэрхий чичигнэн алсад өвдсөн хашгиралт гарах шиг санагдав.

- Энэ харваас чөтгөрийн гал байсан бололтой гэж Гермиона титмийн үлдэгдлийг харан хэлэв.

- Юу?

- Чөтгөрийн гал ... шидэт гал болохоор бүх зүйлийг тэр дундаа крестражыг ч гэсэн устгах чадалтай. Гэхдээ би үүнийг хэзээ ч ашиглаж байгаагүй маш аюултай. Крэббийг хаанаас мэдсэнийг мэдэхгүй ч ...

- Кэрроугаас сурсан байх гэж Харри баргар хэлэв.

- Тэр түүнийг яаж зогсоох талаар муу сонссон нь харамсалтай. Хэрвээ тэр биднийг алахыг оролдоогүй бол би үхэлд нь их гомдох байлаа гэж Гермионагийн адил үс нь түлэгдэн царай нь хөө тортог болсон Рон хэлэв.

- Гэхдээ та нар ойлгохгүй байна уу? Энэ чинь бид зөвхөн могойд хүрэх үлдлээ гэсэн үг ... гэж Гермиона шивнэв.

Гэвч түүний үгийг тулалдааны чимээ шуугиан тасалж орилох, ёолох чимээ хонгилд дүүргэв. Харри эргэж харахад зүрх нь палхийлээ. Үхэл залгигчид Хогвартст орж иржээ. Гарцан дээр Фред, Перси хоёр юүдэнтэй өрсөлдөгч лүүгээ шившлэг илгээж байлаа.

Харри, Рон, Гермиона гурав туслахаар ухасхийв. Эргэн тойрон шившлэгийн оч нисэлдэн Персигийн үзэлцэж байсан хүн огцом ухархад юүдэн нь гулган унаж хөнхөр дух, буурал үс гарав ...

- Өдрийн мэнд, ноён сайдаа! гэж Перси Тикнесс рүү шившлэг илгээгээд хашгирлаа. Сайд шидэт саваагаа унагаад дотор нь муухайрсан аятай цээжээ маажлав.

- Миний огцрох өргөдлийг санаж байна уу?

- Перси чи тоглож байна уу! гэж Фред хашгирахад түүний үзэлцэж байсан

Үхэл залгигч гурван тийшээ бутарсан Хөшөөх шивлэгт өртөн унав.

Битүү жижигхэн хадаас шигдсэн Тикнесс шалан дээр унаад тэнгисийн зараа шиг эргэлдэв. Фред Перси рүү хөөрөн харлаа.

- Чи үнэхээр тоглосон байна, Перси ... Би чамайг хэзээ ч тоглоом хийхийг сонсож байсангүй ...

Тэгтэл дэлбэрэлт үүсэх үед Харри, Рон, Гермиона, Фред, Перси болон хоёр Үхэл залгигч тэдний хөлд нэг нь Хөшөөх, нөгөө нь Хувиргах шившлэгт өртөөд хэвтэж байв. Энэ агшинд ертөнц гэнэтхэн хэдэн хэсэг болон хуваагдах шиг санагдан Харри агаарт цорын ганц зэвсэг болох нарийхан модон саваагаа чанга атгаад нисэхдээ толгойгоороо гараа хаалаа. Тэр найзуудынхаа хашгиралтыг сонссон ч тэдэнд юу тохиолдсоныг мэдсэнгүй.

Харин дараа нь ертөнц өөрчлөгдөн бүрэнхий боллоо. Тэр хонгилд аймшигт дайралтын ул мөр болох эд зүйлсийн хэлтэрхийд дарагдаад хэвтэж байв. Агаар хүйтэрч шилтгээний ханын нэг хэсэг дэлбэрэн алга болоод хацрыг нь даган халуун шингэн урсав. Дараа нь аймшигтай хашгиралт сонсогдоход дотор нь бүх зүйл хөрвөх шиг болов. Тэр найган босоод энэ өдөр тэр ч байтугай амьдралдаа хэзээ ч амсаагүй аймшигт автлаа ...

Гермиона бас хэмхэрхий дундаас өндийхөд хана дэлбэрсэн хэсэгт гурван шаргал үс харагдав. Харри Гермионагийн гараас бариад чулуу модон дундуур бүдчин гүйлээ.

- Үгүй! Үгүй! Үгүй! гэж хэн нэгний хоолой хашгирав. Үгүй! Фред! Үгүй!

Тэгтэл Перси дүүгийнхээ мөрнөөс сэгсрэн, Рон хажууд нь өвдөглөн суугаад Фред нүд нь, хөдөлгөөнгүй хараастай, уруул дээр нь саяхны бөхөж амжаагүй инээмсэглэл тодорсон байлаа.

БҮЛЭГ 32: ГАНДИГАРЫН САВАА

Ертөнц төгссөн байтал яагаад тулаан дуусч шилтгээн чимээгүй айдаст автан бүх дайчид зэвсэгээ хаяхгүй байгаа юм бол? Харри бодлоо хянаж чадахаа болиод хий хоосонд автан юу болсныг ойлгохоо болив. Фред Уизли үхэж болохгүй ...

Тэгтэл биений хажуугийн хананд гарсан нүхнээс харанхуйд шившлэг нисэн толгой дээрх ханыг онов.

- Доошоо! гэж Харри өөр шившлэг нисэн ирэхэд хашгирлаа. Тэр Роны хамт Гермионагийн хоёр талаас барин шалан дээр дарахад, Перси Фредийн биеийг цаашдын хор хөнөөлөөс хамгаалан хэвтлээ.

- Перси эндээс явцгаая. Бид явах хэрэгтэй! гэж Харри хашгирав. Перси толгой сэгсэрлээ.

- Перси!

Роны тортог болсон нүүр дээгүүр нулимс зам татуулан урсав. Тэр том ахынхаа мөрнөөс татан чангаасан ч Перси байрнаасаа хөдөлсөнгүй.

- Перси чи түүнд юугаар ч тусалж чадахгүй! Бид эндээс явах хэрэгтэй.

Гермиона часхийн хашгирахад Харри эргэж харсан ч юу болсныг асуух хэрэг байсангүй. Хананд гарсан нүхээр багахан машинаас дутуугүй том аалз орж ирэв. Тэмцэлд Арагогын хүүхдүүд нэгджээ.

Рон, Харри хоёр зэрэг шившлэг илгээхэд амьтан хөлөө сарвалзуулан харанхуйд далд орлоо.

- Тэр бусдыгаа авчирсан байна! гэж Харри хашгираад ханын цоорхойгоор харахад олон тооны аварга аалзууд Хориотой ойгоос гарч Үхэл залгигчдийн сэтэлсэн газраар гүйлдэн шилтгээний хана руу авирч байв. Харри Хөшөөх шившлэгээр эхний мангасыг оноход хана дагуу өнхрөн алга болов. Түүний толгой дээгүүр хэдэн шившлэг гэрэлтүүлэн нисэж үс нь хийслээ.

- Явцгаая, Түргэлээрэй!

Тэр урдаасаа Рон, Гермиона хоёрыг холдуулан түлхээд Фредийн суганаас барилаа. Перси Харрийн юу хийх гэж байгааг ойлгосон бололтой дүүгийнхээ биенээс барин туслав. Тэд шившлэгээс булган бөхийн явж Фредийн биеийг замаас холдуулав.

- Ийшээ гээд Харри түүнийг урд нь хуяг дуулга зогсож байсан хөндий рүү авчрав. Харри Фред руу харж чадаагүй хэдий ч биеийг нь сайн нуусан гэдэгт итгэлтэй болсон хойно Рон, Гермиона хоёрын хамт ухасхийлээ. Малфой, Гойл хоёр хаа нэг тийш алга болоод хонгилын эцсийн нурсан хэсэгт битүү тоос бужигнан, цонхны шил хагарч, урд нь гүйж яваа олон дүрс харагдсан ч ... нөхөр дайсан эсэх нь ялгагдсангүй. Перси булан эргэмэгц,

- Руквуд! гэж орилоод хоёр сурагчтай тулалдаж байгаа өндөр хүний зүг гүйж одлоо.

- Харри, ийшээ! гэж Гермиона хашгирав.

Тэр Роныг гарц руу түлхэхэд Харрид хэсэгхэн хугацааны ухаангүй мөчид тэд ахин тэврэлдэх шиг санагджээ. Гэвч дараагийн агшинд Гермиона Ронд Персигийн араас гүйх боломж өгөхгүйн тулд тэвэрч байгааг ойлголоо.

- Сонс, Намайг сонс, Рон!

- Би тулалдахыг хүсч байна ... Үхэл залгигчдыг алахыг хүсч банйа ... Түүний тоос шороонд хучигдсан царай мурийж ууранда чичирч байлаа.

- Рон бид түүнийг дуусгах боломжтой цорын ганц хүмүүс! Рон чамаас гуйя ...

Бидэнд могой хэрэгтэй. Бид могойг алах ёстой! гэж Гермиона гуйлаа.

Харри Роны юу мэдэрч байгааг ойлгож байв. Ээлжит крестражын араас хөөцөлдөх нь өс хонзонгийн дэргэд юу ч биш. Тэр ч гэсэн тэмцэлд оролцон Фредийн алуурчинг шийтгэж, Уизлийн гэр бүлийн бусад хүмүүсийг олон хамгийн гол нь Жинниг зүгээр эсэхийг шалгахыг хүсч байлаа ... Үгүй, энэ тухай бодож болохгүй ...

- Бид тэмцэлд байна! Бид могойд хүрэх ёстой! Бид яагаад энд байгаа гэдгээ мартаж болохгүй! Зөвхөн бид л түүнийг дуусгаж чадна! гэж Гермиона хэлэв.

Тэр бас уйлж байсан бөгөөд урагдаж тортог болсон ханцуйгаар нүүрээ арчаад тайвширахын тулд хэдэн удаа гүнзгий амьсгал авч Роныг тавилгүй Харри руу эргэлээ.

- Чи одоо Волдеморт могойтойгоо хаана байгаа гэдгийг мэдэх ёстой. Алив

Харри түүний бодлыг унш! гэв.

Энэ яагаад амархан санагдана вэ? Яагаад сорви нь олон цагийн өмнөөс халуу төөнөн Волдемортын бодлыг үзүүлэхийг хүссэн юм бол? Тэр Гермионагийн тушаалын дагуу нүдээ анихад дэлбэрэлт, орилж хашгирах зэрэг тулааны чимээ шуугиан намдан эндээс алсад очих шиг болов ...

Тэр ханын цаас нь хуурч ойчин, нэгээс бусад цонхыг нь модон самбараар хаасан хачирхалтай танил өрөөнд зогсож байлаа. Тулааны чимээ эндээс алсад байгаа юм шиг сонсогдоно. Хаалтгүй цонхоор шилтгээний зүг галт оч гялсхийж байсан ч өрөөнд бүүдгэр харанхуй агаад тосон дэнлүү гэрэлтүүлж байлаа.

Тэр саваагаа хуруундаа эргэлдүүлэн ширтэнгээ бодол санаа нь шилтгээний цорын ганц түүний мэдэх нууц өрөөнд байлаа ... Тэр хүү титмийг олохгүй гэдэгт итгэлтэй байв ... гэсэн ч Дамблдорын утсан хүүхэлдэй түүний бодсоноос ч хол явсан ... хэтэрхий хол явсан ...

- Эзэнтээн! гэх цөхрөнгүй сөөнгө хоолой гарав.

Тэр эргэхэд өрөөний харанхуй буланд Люциус Малфой навсайсан төрхтэй сууж байлаа. Тэрбээр хүүгийн сүүлчийн зугталтын дараа аймшигт шийтгэлийн ул мөртэй үлдэж нэг нүд нь хавдаж нээгдэхгүй болжээ.

- Эзэнтээн! Гуйж байна ... Миний хүү ...

- Хэрвээ чиний хүү үхвэл би үүнд буруугүй, Люциус. Тэр бусад Слизеринчүүдтэй хамт над руу ирээгүй. Магадгүй Харри Поттерын талд орсон юм болов уу?

- Үгүй ... хэзээ ч тэгэхгүй ... гэж Малфой шивнэлээ.

- Тэгээгүй нь ч чиний хувьд дээр.

- Харин та ... эзэнтээн Поттер таны гарт биш өөр хүний гарт үхэж магадгүй гэж айхгүй байна уу? Магадгүй ... намайг өршөөгөөрэй ... магадгүй тулааныг зогсоогоод ... та өөрөө шилтгээнд орж түүнийг хайхгүй юм уу? гээд Малфойн хоолой чичирлээ.

- Намайг мэхлэх гэж бүү оролд, Люциус. Чи хүүдээ юу тохиолдсоныг мэдэхийн тулд тулааныг зогсоохыг хүсч байна. Тэгээд ч надад Поттерыг эрэх хэрэг байхгүй. Үүр гэгээрэхээс өмнө тэр өөрөө над руу ирнэ.

Волдеморт ахин гартаа эргүүлж буй саваа руу харав. Түүнд нэг л зүйл таалагдахгүй байлаа. Хэрвээ лорд Волдемортод ямар нэг зүйл таалагдахгүй байгаа бол тэр даруйхан учрыг нь олох болно ...

- Явж Снеггийг авчир.

- Снеггийг гэнээ, эзэнтээн?

- Снеггийг. Яг одоо. Тэр надад хэрэгтэй байна. Би түүнийг ... надад нэг зүйл хийж өгөхийг хүсч байна. Яв.

Айсан Малфой өрөөнөөс гараад харанхуйд алга боллоо. Волдеморт урьдын адил саваагаа хуруундаа эргэлдүүлэн хөдөлгөөнгүй зогсохдоо нүд салгахгүй харна.

- Ганц л арга байна, Нагайна гэж шивнэлээ.

Агаарт гялалзсан тор юмуу шилэн хоргыг санагдуулах түүний хийсэн шидийн хамгаалалтын бөмбөлөгт аварга могой цагариглан хөвж байлаа.

Харри гүн амьсгаа аваад нүдээ нээлээ. Энэ агшинд орилж хашгирах болон дэлбэрэх чимээ ахин сонсогдов.

- Тэр Орилоо овоохойд байна. Могой түүнтэй хамт шидийн хамгаалалтан дотор байсан. Тэр саяхан Люциус Малфойг Снеггийн араас явууллаа.

- Волдеморт Орилоо овоохойд байна гэнээ? Тэр ... тэр тэмцэлд оролцоогүй юм уу? гэж Гермиона уурсангүй хэлэв.

- Тэр тэмцэлд оролцох хэрэггүй гэж бодож байна. Тэр намайг өөрөө түүн дээр очино гэж бодож байна.

- Яагаад?

- Тэр намайг крестражын араас явааг мэдэж байгаа. Тиймээс өөр лүүгээ очуулахын тулд ... Нагайнаг дэргэдээ байлгаж байна.

- Зүйтэй гээд Рон мөрөө цэхлэн,

- Тэгэхээр чи тийшээ явж болохгүй. Яагаад гэвэл тэр үүнийг л хүлээж байгаа.

Чи энд үлдээд Гермионад санаа тавьж бай харин би яваад түүнийг ... гэв. Гэсэн ч Харри Роны үгийг таслав.

- Та хоёр хоёулаа энд үлд харин би үл үзэгдэх цувтай яваад буцаад ...

- Үгүй ээ, цувыг би өмссөн нь дээр байх гэж Гермиона хэлэхэд,

- Ингэж бодох ч хэрэггүй! гэж Рон зандарлаа.

- Рон би чамаас дутуугүй чадна гэж Гермиона хэлэхэд тэдний зогсож байсан хөргөн гарцны үүд нээгдэв.

- Поттер!

Түүний өмнө багтай хоёр Үхэл залгигч зогсож байлаа. Гэсэн ч тэднийг шидэт саваагаа өргөж амжихаас урьтаж Гермиона,

- Глиссео! гэж хашгирав.

Тэдний хөл дорх гишгүүр налуу болон хатуурахад түүгээр хурдтай доош гулгаад Үхэл залгигчдийн илгээсэн Хөшөөх шившлэг толгой дээгүүр нь нисэн өнгөрөв. Тэд доод давхарын хөргөн гарцыг нэвтлэн гарахдаа эсрэг талын хана мөргөлөө.

- Дуро! гэж Гермиона хашгираад саваагаа хөрөг рүү чиглүүлэхэд чанга чахрах чимээ гарч гарч чулуу болон хувиран араас нь хөөж байсан Үхэл залгигч мөргөн уналаа.

- Хойшоо! гэж Рон хашгирахад гурвуул хана налахад тэдний дэргэдүүр амь орсон ширээнүүдийг хариулж яваа профессор МакГонагалл гүйн өнгөрөв. Тэр харваас тэднийг ажигласангүй бололтой үс нь сэгсийж, хацар нь зүсэгджээ. Булан эргээд гэж «Хамгаал» хашгирах нь сонсогдов.

- Харри цуваа өмс. Биднийг тоох хэрэггүй гэж Гермиона хэлэв.

Гэсэн ч тэр гурвуулангаа хучлаа. Агаарт тоос бужигнан, чулуу нурж шившлэгийн гэрэл гялсхийж байхад хэн тэдний биенээсээ салсан хөлийг анзаарах билээ дээ.

Тэд доошоо гүйж халз тулааны төвд оров. Тулааны талбарын хоёр талын хөргүүд багтай баггүй Үхэл залгигчидтай тулалдаж байгаа багш нар сурагчдыг хөхүүлэн дэмжинэ. Дин саваа олоод Долоховтой тулалдаж, Парвати Трэверстэй үзэлцэж байлаа. Харри, Рон, Гермона гурав цохилт өгөхийн тулд саваагаа зэрэг өргөсөн ч халз тулаанчид нь хэтэрхий түргэн хөдөлж байсан болохоор шившлэг хэнийг ч онож болохоор байлаа. Тэд шахцалдан зогсоод боломжыг хүлээхэд толгой дээгүүр нь

«Үүүү!» гэж орилох чимээ гарлаа. Харри харцаа өргөөд адрын дор байгаа Пивзийг олж харав. Хий үзэгдэл Үхэл залгигчидийн толгой дээрээс булцуутай вандуй асгахад үс нь өт шиг оволзон хүзүү рүүгээ орж хурц үзүүртэй болов.

Пял!

Роны толгой дээрх цуван дээр нойтон булцуу ойчиход сэгсрэн унагахыг хичээлээ.

- Энд үл үзэгдэх хүн байна! гэж багаар нүүрээ хаасан Үхэл залгигч хашгираад хачирхалтай үзэгдлийг заахад Дин боломжыг агшиглан өрсөлдөгчөө Хөшөөх

шившлэгээр унагалаа. Долохов нөхөртөө туслахаар ухасхийхэд Парвати түүн рүү Петрификус тоталус илгээв.

- Гүйгээрэй! гэж Харри хашгираад Рон, Гермиона хоёрын хамт цувнаасаа зууран тулаанчдын дундуур цуваа толгой бөхийн гүйхдээ болцууны шүүсэнд хальтирлаа.

- Би ... Драко Малфой. Драко, танай тал байна!

Драко шатны дээр хар багтай хүнээс гуйж байлаа. Харри дэргэдүүр нь гүйн өнгөрөхдөө Үхэл залгигчид Хөшөөх шившлэг илгээв. Малфой аварагчаа эрэн баясан харсан ч Рон жанчин дороос цохиход Үхэл залгигчийн дээрээс унаад мэгдсэн байртай язарсан уруулынхаа цусыг арчлаа.

- Бид энэ шөнө хоёр дахь удаагаа чиний амьдралыг аварлаа хоёр нүүртэй хөгийн амьтан минь! гэж Рон зандрав.

Тулаанчид шатны талбай үүдний танхим гээд хаа сайгүй байлаа. Үхэл залгигчид шилтгээнийг бүхэлд нь дүүргэжээ. Үүдний хаалган дээр Яксли Флитвиктэй тулалдаж, баруун талд нь багтай Үхэл залгигч Кингслитэй тэмцэлдэнэ. Сурагчид зүг бүр тийш гүйлдэн зарим нь шархадсан найз нөхдөө түшин явж байлаа. Харри багтай Үхэл залгигч руу Хөшөөх шившлэг илгээхдээ хортой Тентакула чулуудаж байсан Невиллийг золтой л оночихсонгүй. Хортой ургамал ойролцоох Үхэл залгигчийг баяртайгаар ороолоо.

Харри, Рон, Гермиона гурав шат уруудан гүйв. Зүүн талд нь Слизериний элсэн цагны шил хагарч тэнхимийн маргад оноо шалан дээр асгаран дээгүүр нь гүйсэн хүн гулган ойчихоор болжээ. Найзуудыг үүдний танхимд гүйн гарах үед дээд талын тагтнаас хоёр бие унав. Гэтэл газар тодорхойгүй саарал амьтан шиг дүрс дөрвөн хөллөн гүйж унасан хүний нэгийг хазахаар ухасхийв.

- Үгүй! гэж Гермиона хашгираад сабааны үзүүрээс чих дөжрөм чимээ гарахад Лаванда Брауны биен дээрээс тонгойсон Фенрир Сивый гэдрэг үсрэн гантиг шатны бариул мөргөн унаад өндийхийг хичээв. Тэгтэл толгойны орой дээр нь хурц гэрэл ярсхийж тас хийх чимээ гаран болор бөмбөлөг уналаа. Фенрир шалан дээр унаад хөдөлсөнгүй.

- Надад өөр олон байгаа! гэж профессор Трелони гантиг шатны орой дээрээс хашгираад,

- Хэдийг хүсч байна! Май ... гэв.

Тэрбээр теннисний тамирчны туслагч шиг цүнхнээсээ том болор бөмбөлөг гаргаад доошоо чулуудав. Тэр агшинд хүнд модон хаалга нээгдэж үүдний танхимд аварга том аалзууд хүч түрэн орж ирлээ.

Аймшигтай хашгиралт дэгдэн тулалдаж байсан Үхэл залгигчид болон Хогвартсыг хамгаалагчид сарнин зугтахад айсуй буй мангас руу улаан ногоон оч ярсхийн нисэлдэв.

- Эндээс яаж гарах вэ? гэж Рон орилоон дундуур хашгирсан ч Харри, Гермиона хоёрын үг хэлж амжихаас урьд Хагрид шатны доошоо ягаан шүхрээ илд шиг эргүүлэн нижигнэн бууж ирлээ.

- Тэдэнд бүү хүр, бүү хүр! гэж хашгирав.

- Үгүй, Хагрид!

Харри ертөнц дээр бүхнийг мартаад цуван дороос шургалан гарч танхимын дундуур шившлэгээс булган гүйв.

- Хагрид, буцаад ирээч!

Гэсэн ч түүнийг замын талдаа орохоос урьтаж Хагрид яралзан гүйсэн аалзан дунд орон алга болоод аймшигт сүрэг шившлэгийн дайралтаас ухран Хагридыг гүндээ оруулав.

- Хагрид!

Харри түүний нэрийг хэн нэгэн дуудахыг сонссон ч нөхөр дайсан эсэхийг нь мэдсэнгүй. Тэр үүдний шат уруудан харанхуйд гүйн гараад аалзнууд олзоо авч явж байгаа зүг харсан ч Хагрид ялгагдсангүй.

- Хагрид!

Тэгтэл тэдний дунд сарвалзах гар харах шиг санагдав. Тэр араас нь гүйсэн ч урд нь гэнэтхэн нүсэр хөл бий болоод газар чичирлээ. Тэр нүдээ өргөхөд хорин футын өндөртэй аварга биет зогсож байлаа.

Толгой нь харанхуйд үзэгдэхгүй байсан ч бүдүүн мод шиг үсэрхэг нүцгэн хөл нь шилтгээний хаалганаас тусах гэрэлд гялалзав. Тэр гэнэтхэн нударга зангидан дээд давхрын цонхыг хүчтэй цохиход Харри асгарсан шилний хагархайнаас булган буцаж довжоо руу гүйн гарав.

- Өө бурхан минь! гэж Гермиона хашгирав. Харри, Рон хоёр дээшээ хартал аварга биет цонхны дотор байгаа хүмүүсийг барьж авахыг хичээж байлаа.

- Зогс! Хэрвээ чи түүнийг хөшөөвөл шилтгээний талыг нураана гэж Рон

Гермионагийн саваа өргөсөн гарыг хориглон хэллээ.

- Хаггер?

Шилтгээний булангаас Грохх гарч ирэхэд Харри анх удаагаа түүний аварга биетний хажууд хичнээн жижигхэн болохыг мэдлээ. Дээд давхарын хүмүүсийг барьж авахыг оролдож байсан хэрцгий аварга биет эргэн чулуун гишгүүр чичигнэтэл хүрхрээд төрлийнхөө жижиг биет рүү алхав. Грохх амаа том нээж тоосгоны хэмжээтэй шар шүдээ гарган чих дөжиртөл орилоод тэд хоёул ууртай арслан шиг ноцолдов.

- Гүйцгээе! гэж Харри хашгирав.

Харанхуй орчин аварга биетнүүдийн аймшигт тулааны хашгиралт цохилтын чимээгээр дүүрлээ. Харри Гермионагийн гараас бариад довжооноос гүйхэд Рон араас

нь дагалдав. Харри Хагридыг аврах найдлагаа бас л орхиогүй байв. Тэр түргэн гүйж Хориотой ой хүрэх замын хагаст орсон ч шинэ саад гарч ирлээ.

Орчины агаар гэнэтхэн хүйтэрлээ. Харрийн амьсгал давхцав. Харанхуй сүүдрээс юүдэнтэй бараан дүрсүүд гулган гарч ирээд шилтгээний зүг давалгаалан ойртож чимээтэй амьсгалав ...

Рон, Гермиона хоёр дэргэд нь шахан зогсоход тулааны дуу чимээ гэнэтхэн намдаж эргэн тойрон зөвхөн Дементоруудын үүсгэсэн гүн харанхуй ноёрхов.

- Алив, Харри! Патронусаа гарга! Харри алив л дээ! гэх Гермионагийн хоолой алсаас сонсогдов.

Тэр саваагаа өргөсөн ч цөхрөл найдваргүй байдал хаман авлаа. Фред байхгүй болсон, Хагрид үхсэн юмуу эсвэл үхэж байгаа бас өөр хичнээн хүн үхсэнийг тэр мэдэхгүй. Түүнд сэтгэл санаа нь хүртэл биеэ орхин одсон юм шиг санагдав.

- Харри, Түргэлээрэй! гэж Гермиона хашгирав.

Зуугаад Дементоруудад Харрийн цөхрөл найр шиг санагдсан бололтой тэдний зүг гулсан хөвж байлаа ...

Тэгтэл Роны мөнгөн нохой сулхан гялсхийгээд бөхөн, Гермионагийн халиу агшин зуур агаарт хайлан алга болох нь үзэгдээд саваа барьсан гар нь чичирч ямар ч мэдрэмжгүй болов.

Гэнэтхэн тэдний толгой дээгүүр мөнгөн туулай, бодон, үнэг нисэв. Дементорууд тэднийг хараад хойш ухарлаа. Харанхуйгаас гурван шинэ дүрс гарч ирээд Патронусаа үргэлжлүүлэн илгээв. Энэ бол Полумна, Эрни, Симус нар байв.

- Бүх зүйл хэвийн хэмээн Полумна Шаардлагатай өрөөнд ДА-гийн бэлтгэл сургуулилж байгаа юм шиг урамтай хэлээд,

- Бүгд хэвийн, Харри ... Алив өөр ямар нэг баяртай юмны тухай бод ... гэв ...

- Баяртай юмны тухай гэнээ? хэмээн тэр сөөнгөтөн асуулаа.

- Бид энд байсан хэвээр байна. Тэмцэл үргэлжилж байна ... Алив л дээ ...

Харри маш их хүчин чармайлт гаргасны эцэст сабааны үзүүрээс мөнгөн оч цацран буга гарлаа. Тэр урагш давхихад Дементорууд сарнин зугтаж шөнийн агаар ахин дулаан болоод тулааны чимээ шуугиан чангарлаа.

- Биднийг аварсанд чинь та нарт яаж талархаа ч мэдэхгүй байна гэж Рон чичирсэн хоолойгоор тэдэнд хэлэв.

Чанга нүргэлэх чимээ гараад газар чичирэхэд ойн зүгээс царсан бороохой далласан өөр нэг аварга биет гарч ирэв.

- Гүйгээрэй! гэж Харри ахин хашгирсан ч үүний хэрэг байсангүй бүгд бутран зугтах агшинд мангасын хөл тэдний зогсож байсан газар буулаа. Харри эргэн тойрноо харав. Рон, Гермиона хоёр дэргэд нь гүйж нөгөө гурав ахин тэмцэл рүү явжээ.

- Түүнээс холдох хэрэгтэй байна! гэж Рон аварга биет ахин царсан бороохойгоо эргүүлж чих дөжиртөл орилоход хашгирав. Энэ чимээ шилтгээний нутаг дэвсгэрт цуурайтан шөнийн харанхуйд улаан ногоон очис нисэлдэнэ.

- Шажигнуур уд! Гүйгээрэй! гэж Харри хэлэв.

Тэр агшинд тархинд хашигдсан бүх бодол нь хамаагүй болжээ. Фред, Хагрид болон бүх хайртай хүмүүсийнхээ үхэхээс айх айдас, шилтгээний гадна дотно өрнөж байгаа тулаан бүгд түүнийг хүлээж байгаа учраас одоо л гүйж Волдемортын могойд хүрэх хэрэгтэй. Яагаад гэвэл Гермионагийн хэлснээр үүнийг дуусгах өөр ямар ч арга байхгүй ...

Тэр урагшаа бөхийн харанхуйд гялсхийх очисыг тоолгүй гүйхэд нуурын ус давалгаалах чимээ тэнгис шиг сонсогдож, Хориотой ойн модод салхигүй байтлаа шуугиж, шилтгээнд гарсан тэмцэл бослого шиг санагдан амьдралдаа хэзээ ч байгаагүй хурдан гүйхдээ ташуур шиг шавхуурддаг мөчрөөр их биеэ хамгаалсан уд модыг харлаа.

Харри амьсгаадан алхаагаа удаашруулан зогсоод хөгшин удны шавхуурдах мөчир харанхуйд сүүмэлзэх бүдүүн их биеийг харж яаж хүрэн хөдөлгөөнгүй болгох эсэхээ бодлоо. Тэд араас нь гүйж ирэхэд Гермиона ярьж чадахааргүй болтол амьсгаадаж байв.

- Бид ... тийшээ ... яаж хүрэх юм? Би ямар ч боломжыг харахгүй байна ...

Хэрвээ Живоглот энд байсан бол гэж Рон хэлэв.

- Живоглот гэнээ? Чи чинь ингэхэд шидтэн биш юмуу? гэж Гермиона хүндээр амьсгаадан хэлээд зүрхээ дарлаа.

- Өө, тийм л дээ ...

Рон эргэн тойрноо харснаа газар хэвтэж байсан мөчир лүү саваагаа чиглүүлэн,

- Вингардиум левиоса! гэв.

Мөчир газраас хөөрч салхинд хөөгдсөн мэт эргэлдэн нисээд ууртай шавхуурдаж буй мөчрийн завсраар оров. Тэр их биеийн ойролцоо цохьсон ч мод агшин зуур зогслоо.

- Сайн байна! гэж Гермиона дуу алдав.

- Хүлээгээрэй.

Харри эргэлзсэн нэг мөчийн турш тулааны чимээ шуугианыг сонсон тээнэгэлзлээ. Волдеморт түүнийг ирэхийг хүссэн. Хэрвээ тэр Рон, Гермиона хоёрыг занганд оруулвал яах вэ?

Гэтэл тэдний өмнө энгийн атлаа хэрцгий бодит байдал урган гарч ирэхэд дараагийн хийх алхам нь ... Волдемортын хамт байгааг могойг алах болон Волдеморт тэднийг хонгилын төгсгөлд хүлээж байгаа явдал байлаа ...

- Харри бид чамтай хамт явна урагшаа! гээд Рон түүнийг түлхэв.

Харри модны үндсэн дор нуугдсан хонгил руу ороход түүгээр явахад өнгөрсөн удаагынхаас илүү хэцүү байв. Тэд дөрвөн жилийн өмнөхөөс хоёр дахин өссөн болохоор намхан адар тулж мөлхөхөөс өөр аргагүй болжээ. Харри дурын агшинд саадтай тулахыг хүлээн саваагаараа алхам тутамдаа гэрэлтүүлж байсан ч юу ч болсонгүй. Тэд дуу шуугүй явцгаахад Харри савааны үзүүрээс гарсан сулхан чичигнэх гэрлээс харцаа салгасангүй.

Эцэст нь хонгил дээш өгсөхөд дээр гэрэл харагдав. Гермиона шагайнаас нь зулгаалаа.

- Үл үзэгдэх цув! Үл үзэгдэх цуваа өмс! гэж шивнэв.

Тэр сул гараа сунгахад Гермиона хуйлаастай зүйл өгөв. Харри түүнийг арай ядан нөмрөөд «Нокс!» гэж шивнэн савааныхаа гэрлийг унтрааж цааш дөрвөн хөллөж аль болох чимээ шуугиан гаргахгүйг хичээн явахдаа агшин бүр түүнийг илрүүлэн хүйтэн хоолой сонсогдож ногоон гэрэл гялсхийхийг хүлээж байлаа.

Тэгтэл урд нь овоохойноос хоолой сонсогдон хонгилын гарцыг хаан хуучин хайрцаг тавьсан байв. Харри амьсгаа ч авч зүрхлэлгүй хана хайрцаг хоёрын хоорондын нарийхан завсраар шагайв.

Өрөөнд бүүдгэр байсан ч агаарт шидийн гялалзсан бөмбөлөгт усан дор байгаа мэт эвхрэлдэн хөвж буй Нагайна харагдав. Бас булангийн ширээн дээр урт хуруутай цагаан гар шидэт саваагаар тоглож үзэгдэнэ.

Тэгтэл Снеггийн хоолой гарахад Харрийн зүрх палхийлээ. Снегг түүний нуугдсан хайрцагнаас алхамын зайд зогсож байв.

- Эзэнтээн тэдний эсэргүүцэл суларсан ...

- Чиний тусламжгүй. Северус чи авъяаслаг шидтэн хэдий ч одоо бидэнд хэрэгтэй гэж бодохгүй байна ... Бид байндаа бараг л хүрсэн ... бараг л гэж Волдеморт өндөр хүйтэн хоолойгоор хэлэв.

- Таньд хүүг авчрахыг зөвшөөрнө үү. Таньд Харри Поттерыг авчрахыг зөвшөөрнө үү. Би түүнийг яаж хайхаа мэднэ, эзэнтээн. Танаас гуйж байна.

Снегг нүхний дэргэдүүр өнгөрөхөд Харри арагш болохдоо Нагайнагаас нүд салгасангүй ямар шидээр хамгаалалтын бөмбөлөгийг эвдлэх билээ гэж бодлоо. Нэг л бүтэлгүй оролдого ... түүний байрлалыг илрүүлэх болно ...

Волдеморт босоход түүний могойтой адилхан хамар, улаан нүд үзэгдэн бүрэнхийд цонхигор царай нь туяарав.

- Надад асуудал тулгараад байна, Северус гэж тэр аяархан хэллээ.

- Юу тэр вэ, эзэнтээн?

Волдеморт гандигарын саваагаа өргөлөө.

- Тэр яагаад намайг сонсохгүй байна, Северус?

Нам гүмд цагариглан буй могой аяархан исгэрэх нь сонсогдов. Эсвэл Волдеморт исгэрсэн юм болов уу?

- Эзэнтээн? Би ойлгохгүй байна. Та энэ саваа ер бусын шид агуулж байгаа гэж хэлсэн.

- Үгүй энэ саваа ердийн шидийг үзүүлж байна. Би ер бусын шидтэн байтал харин саваа бол ... үгүй. Тэр миний хүлээж байсан шиг байсангүй. Олливандераас олон жилийн өмнө авч байснаас огт ялгаагүй юм.

Хар лорд бодлогоширон тайван ярихад Харрийн сорви төөнөн өвдөж дух нь янгинан

Волдемортын уур хилэн хэрхэн дүрэлзэхийг мэдэрлээ.

- Ямар ч ялгаагүй гэж Волдеморт давтав.

Снегг чимээгүй байсан бөгөөд Харрид царай нь харагдсангүй. Магадгүй тэр аюул ослыг мэдрээд эзнээ тайвшируулах хэрэгтэй үг хайж байгаа юм болов уу.

Волдеморт өрөөн дундуур явахад Харри хэдэн секунтын турш түүний зөвхөн хянамгай хоолойг л сонсож байв.

- Би удаан бодсон, Северус ... Би чамайг яагаад тулааны талбараас дуудсаныг мэдэх үү?

Энэ агшинд Харри илбийн бөмбөлөг дотор эвхрэлдсэн могойг харж байгаа Снеггийн дүр зургийг харлаа.

- Үгүй эзэнтээн би мэдэхгүй гэхдээ танаас намайг буцаахыг гуйж байна.

Намайг тийшээ эргэж очихыг зөвшөөрнө үү. Надад Поттерыг олох боломж олгооч.

- Чи яг л Люциус шиг ярьж байна. Та хоёр надаас ялгаатай нь гэвэл Поттерыг ойлгодоггүй. Түүнийг эрэх хэрэг байхгүй. Поттер өөрөө над дээр ирэх болно. Би түүний дутагдал болох сул талыг мэднэ. Тэр нөхөд нь тэмцэлд өөрөөс нь болоод үхэхийг хараад зогсож чадахгүй. Тэр үүнийг ямар ч үнээр хамаагүй зогсоохыг хүсч байгаа. Тэр ирэх болно.

- Гэхдээ эзэнтээн түүнийг өөр хэн нэгэн санаандгүй алж болзошгүй ...

- Би Үхэл залгигчдад тодорхой заавар өгсөн. Поттерыг барь харин нөхдийг нь аль болох ихээр ал гэж. Гэхдээ миний чамтай ярихыг хүссэн зүйл бол Харри Поттерын тухай биш. Чи надад үнэтэй. Маш их шүү.

- Эзэнтээн би түүнийг олж чадах цорын ганц хүн. Надад эргэж очоод хүүг хайхыг зөвшөөрөөч. Би чадна гэдэгтээ итгэлтэй байна ...

- Би үгүй гэж хэлсэн биз дээ! гээд Волдемортын улаан нүдний хүүхэн хараа ярсхийн цааш жанчаа шар шурхийлгэн эргэхэд уур хилэн нь Харрийн сорвийг тэсэхийн аргагүй болол төөнөв.

- Би хүүтэй сүүлд тулгарахад юу болсон бэ гэдэг ганц л зүйлд сэтгэл зовж байна!

- Ямар асуулт эзэнтээн та ...

- Энд л асуулт байгаа юм, Северус. Байгаа.

Волдеморт зогсоход Харри ахин түүнийг бүтнээр нь харлаа. Хар лорд цагаан хуруундаа саваагаар тоглонгоо Снегг рүү ширтэв.

- Яагаад надад байсан хоёр саваа Харри Поттер луу чиглүүлэх үед зүтгэхээс татгалзсан юм бол?

- Би ... би энэ асуултын хариуг мэдэхгүй, эзэнтээн.

- Үнэхээр гэж үү?

Волдемортын уур хилэн Харрийн тархинд хатгуулахад өвдсөндөө хашгирахгүйн тулд шүд зуун нудрага зангидан тэслээ. Тэр нүдээ аниад гэнэтхэн Волдеморт болж Снеггийн цонхигор царай луу харж байв.

- Миний улаан модон саваа Харри Поттерыг алахаас бусад бүхий л тушаалыг биелүүлсэн. Тэр хоёр ч удаа үүнийг хийж чадаагүй. Олливандер надад нэг зүрхтэй савааны тухай яриад өөрийг хэргэл гэсэн. Би тэгж хийсэн ч Люциусын саваа Харри Поттертой тулгарахад хугарсан.

- Би ... би үүнийг яаж тайлбарлахыг мэдэхгүй, эзэнтээн.

Снегг Волдеморт луу харсангүй. Түүний хар нүд урьдын адил шидийн бөмбөлөгт байгаа могой руу харлаа.

- Би гурав дахь савааг олсон, Северус. Гандигарын саваа, Үхлийн саваа, Хувь заяаны саваа. Би түүнийг өмнөх эзнээс нь авсан. Би үүнийг Альбус Дамблдорын бунхнаас авсан.

Снегг одоо л Волдемортын нүд рүү ширтсэн ч царай нь үхлийн баг өмсчихсөн аятай харагдав. Тэр гантиг шиг цагаан хөдөлгөөнгүй байсан тул Харри хооосн харцны араас дуу гарахад цочлоо.

- Эзэнтээн, надад хүүг авчрахыг зөвшөөрөөч ...

- Би ялалтын ирмэг дээр урт шөнийн турш энд суугаад гандигарын саваа яагаад тушаал биелүүлэхийг татгалзсан талаар бодож үзлээ. Домогт өгүүлснээр бол хууль ёсны эзэн нь болохын тулд нэг зүйл хийх ёстой гэсэн ... надад асуултын хариулт олдох шиг санагдсан.

Снегг чимээгүй байлаа.

- Магадгүй чи хэдийн тааварласан байх тийм үү? Чи ухаалаг хүн, Северус. Чи миний үнэнч сайн туслах байсан болохоор одоо болох үйл явдалд би харамсаж байна.

- Эзэнтээн ...

- Гандигарын саваа надад үнэнчээр зүтгэхгүй байгаагын учир нь би түүний хууль ёсны эзэн биш, Северус. Гандигарын саваа өмнөх эзнийг нь алсан шидтэнд харъяалагдах ёстой. Чи Альбус Дамблдорыг алсан. Чамайг амьд байхад гандигарын саваа надад жинхэнээсээ хамаарагдахгүй.

- Эзэнтээн! гэж Снегг хашгираад саваагаа хамгаалан өргөлөө.

- Өөр арга байхгүй. Би энэ сабааг эзэмших ёстой, Северус. Сабааг эзэмдэж байж Харри Поттерыг эзэмдэнэ.

Ингээд Волдеморт гандигарын сабаагаа даллав. Юу ч болсонгүй ч тул Снегг харваас хоромхон зуур өршөөгдлөө гэж бодсон байх. Гэсэн ч Волдемортын санаа тодорхой боллоо. Могойн эвхрэлдэж байсан бөмбөгөлөг агаарт эргэлдэн хөөрөөд Снегг хашгирч амжилгүй толгой мөр нь бөмбөлөг дотор далд орж Волдеморт могойн хэлээр,

- Түүнийг ал! гэв.

Аймшигтай хашгиралт гарлаа. Харри Снеггийн царайнаас хэрхэн сүүлчийн өнгө алга болж цайран, нүд нь томорч, могойн соёо хүзүүнд нь шигдэхэд бөмбөлөгийг түлхэхийг хичээн өвдөглөн унахыг харлаа.

- Харамсалтай байна гэж Волдеморт хүйтнээр хэлээд эргэв.

Тэр цааш явахад гашуудал харамсал огтхон ч байсангүй. Тэр энэ овоохойг орхин сабаа нь түүнд үнэнээсээ зүтгэх болсон болохоор ажил хэргээ хөөцөлдөх цаг болж. Тэр гялалзсан бөмбөглөгтэй могойг Снеггээс холдуулан дээш хөөргөөд хажуудаа буулгахад хүзүүний шархнаас цус дуслав. Волдеморт өрөөнөөс эргэж харалгүй гарахад могой хамгаалалтын бөмбөлөгтэйгээ агаарт хөөрөн дагалдав.

Харри хонгилд өөрийн бодолдоо ирээд нүдээ нээж хашгирахгүйн тулд гараа хазан тэслээ. Тэр хайрцагны нарийхан завсраар шагайхад шалан дээр чичирсэн хар гутал харагдав.

- Харри! гэж ард нь Гермиона шивнэсэн ч хайрцагийг чимээгүйхэн холдуулан түлхээд бүхий л эр зоригоо хөвчлөн овоохой руу оров.

Тэрээр яагаад үхэж буй хүнд дөхөж очин хуруугаараа хүзүүнийхээ шархны цусыг тогтоохыг оролдож буй Снеггийн зэвхий даасан царайг харснаа ч мэдсэнгүй. Харри үл үзэгдэх цуваа тайлж үзэн яддаг хүнийхээ дээрээс харлаа. Снеггийн томорсон нүд Харри дээр тогтоход ямар нэг зүйл хэлэхийг хичээв. Харри түүн лүү бөхийхөд Снегг жанчнаас нь зууран ойртуулан татаад аймшигтай хэржигнэсэн хоолойгоор,

- Үүнийг ав ... ав ... гэв.

Түүний ам, чих, нүднээс мөнгөлөг цэнхэр шингэн шиг зүйл гарахад Харри юу болохыг нь ойлгосон ч яахаа мэдсэнгүй ...

Гермиона түүнд чичирсэн гараар агаараас шил гаргаж өгөв. Харри сабаагаа хоолойноос гарсан мөнгөлөг зүйл рүү чиглүүлэв. Шил дүүрэх үед Снеггийн судас цохилохоо зогсон цус гарахаа болиод атгалт нь суларлаа.

- Намайг ... хараарай ... гэж шивнэв.

Ногоон нүд хартай харц тулгарахад агшины дараа харын гүнд нэг зүйл унтарч хоосон хөдөлгөөнгүй болон Харрийн хувцаснаас барьж байсан гар шалан дээр унаад Снегг хөдөлсөнгүй.

БҮЛЭГ 33: ПРИНЦИЙН ТҮҮХ

Харри Снеггийн хажууд өвдөглөн суугаад харж байтал гэнэтхэн өндөр хүйтэн хоолой гарахад гар дахь шилэн саваа атгаад үсрэн босохдоо Волдеморт овоохойд эргэн ирсэн гэдэгт эргэлзсэнгүй.

Гэсэн ч Волдемортын хоолой хана шаланд цуурайтан Хар лорд Хогвартс, Хогсмидын оршин суугчид, болон шилтгээнийг хамгаалж буй хэн бүхний дэргэд зогсоод хүзүү рүү нь амьсгалан үхлийн цохилт өгөхөд бэлэн байгаа юм шиг тод ярилаа.

- Та нар зоригтой тэмцлээ. Лорд Волдеморт эр зоригийг үнэлж чаддаг юм. Гэвч та нар хүнд хохирол амссан. Хэрвээ цаашид үргэлжлүүлэн тэмцэх юм бол бүгд нэг нэгнийхээ араас үхэх болно. Би үүнийг хүсэхгүй байна. Шидтэний дусал цус болгон үнэтэй. Лорд Волдеморт энэрэнгүй сэтгэл гаргаж байна. Би дайчдаа даруйхан буцахыг тушаасан. Би та нарт нэг цагийн хугацаа өгч байна. Та нар үхэгсдээ татаж болно. Шархдагсдадаа тусал.

- Харин одоо би чамд хандаж байна, Харри Поттер. Чи надтай нүүр тулгарахаас зайлсхийснаараа найз нөхдөө үхүүлж байна. Энэ цагийн хугацаанд би чамайг Хориотой ойд хүлээж байх болно. Хэрвээ чи цагийн дотор над руу ирэхгүй өөрийгөө тушаахгүй байх юм бол тэмцэл ахин эхлэн харин энэ удаад би өөрөө тулаанд оролцох бөгөөд Харри Поттер чамайг хайж надаас зугтахад тусалсан эрэгтэй, эмэгтэй хүн, хүүхэд хэнийг ч бай бүгдийг нь шийтгэх болно. Ингээд нэг цаг шүү.

Рон, Гермиона хоёр Харри руу харан толгойгоо сэгсэрлээ.

- Түүнийг битгий сонс гэж Рон дуугарахад,

- Бүгдийн учир олдох болно. Алив ... алив эргээд шилтгээн рүү явцгаая. Тэр ой руу явсан болохоор бид шинэ төлөвлөгөө бодож олох хэрэгтэй байна гэж Гермиона хэллээ.

Тэр Снеггийн бие рүү хяламхийснээ яаран хонгил руу эргэлээ. Рон түүний араас дагалдав. Харри үл үзэгдэх цуваа аваад ахин Снегг рүү харлаа. Тэр Снеггийг алахыг хүсч байсан хэр нь одоо айдсаас гадна юу мэдэрч байгаагаа ойлгосонгүй ...

Тэд хонгилоор чимээгүйхэн мөлхөн буцлаа. Гэсэн ч Харрийн толгойд Волдемортын үг хангинасаар байв.

Чи надтай нүүр тулгарахаас зайлсхийснаараа найз нөхдөө үхүүлж байна. Энэ цагийн хугацаанд би чамайг Хориотой ойд хүлээж байх болно. Нэг л цаг.

Шилтгээний өмнөх нуга дээр томгүй хуйлаастай зүйл байв. Цагийн дараа гэгээ орох хэр нь харанхуй хэвээр ажээ. Харри, Рон, Гермиона гурав чулуун гишгүүрээр яаран өгслөө. Замд нь багахан завины хэмжээтэй өрөөсөн шаахай байсан бөгөөд ... Грохх болон өрсөлдөгчийнх нь сураг байсангүй.

Шилтгээнд ер бусын чимээгүй байлаа. Гялсхийх гэрэл байхгүй, ёолох, орилж хашгирах, тас нясхийх чимээ байхгүй. Үүдний чулуун шал хоосорч цусны толбо

тогтжээ. Гантигийн хэлтэрхий, модны зомгол дунд шалаар нэг тарсан маргад өнхөрнө.

- Бүгд хаачаа вэ? гэж Гермиона шивнэлээ.

Тэд Их танхим руу хөдлөхөд Рон урд нь явлаа. Харри хаалган дээр зогсов.

Тэнхимийн ширээнүүд алга болж танхим дүүрэн хүнтэй байлаа. Амьд үлдэгсэд бөөгнөрөн зогсоод бие биенээ тэврэнэ. Шархдагсдыг бүлэг туслах дагуулсан хатагтай Помфри эмчилнэ. Тэдний дунд Флоренцийн хажуу тал шархдан хөл дээрээ зогсох хүчгүй болоод хэвтэж байв.

Амь үрэгдэгсдийг танхимын голд эгнүүлэн тавьжээ. Фредийн бие дээр гэр бүлийнхэн нь тойрон цугласан учир үзэгдсэнгүй. Жорж толгойных нь хажууд өвдөглөн суугаад, хатагтай Уизли цээжин дээр нь хэвтэж чичирэн уйлна. Ноён Уизли үсийг нь илбэхэд хацрыг нь даган нулимс урсаж байлаа.

Харри Рон, Гермиона хоёрыг салан явахад нэг ч үг хэлсэнгүй. Тэр Гермиона хэрхэн царай нь хавдаж толботсон Жинни рүү дөхөж очоод тэврэхийг харав. Рон Билл, Флер, Перси нар руу очлоо. Перси түүний мөрөөр тэврэв. Жинни, Гермиона хоёр бусад руугаа ойртоход Харри сая л Фредийн дэргэд хэвтэж байсан биеийг харлаа. Энэ бол харанхуй шидэт адрын дор цонхийн цайсан ч амгалан унтаж байгаа мэт царайтай хэвтэж буй Римус, Тонкс хоёр байлаа.

Их танхим нүдний өмнө хөвөн алга болоод улам багасан агшлаа ... Харри гуйвлан үүд рүү явав. Тэр амьсгаа авч чадсангүй. Түүнд бусад биеийг харж өөр хэн үхсэнийг мэдэх хүч ч байсангүй. Тэр Уизлийнхан руу харж чадсангүй бөгөөд ... хэрвээ Волдеморт руу шууд очсон бол Фред үхэхгүй байсан билээ ...

Тэр дээш эргээд гантиг шатаар өгслөө. Люпин, Тонкс хоёр ... Энэ бүх мэдрэмжээ авч хаяхыг хичнээн их хүснэ вэ ... Хэрвээ зүрхээ суга татан гарган ирж чаддагсан бол түүний дотор байгаа бүхэн цурхиран уйлах байсан бизээ ...

Шилтгээн тэр чигтээ хоосорчээ. Хий үзэгдлүүд хүртэл Их танхимд цугларч үхэгсдийн араас гашуудаж буй бололтой. Харри гартаа Снеггийн сүүлчийн дурсамж бүхий болор шилийг барьж зогсолтгүй гүйгээд захирлын өрөө рүү орох үүдийг хамгаалсан чулуун лууны өмнө алхаагаа удаашруулав.

- Нууц үг?

- Дамблдор! хэмээн Харри түүнтэй уулзахын хүслэн болж байсан учир юу ч бодолгүй хэлэв. Тэгтэл түүний гайхлыг төрүүлэн чулуун луу үсрэн холдоод эргүүлгэн шат нээгдлээ.

Гэвч түүнийг дугуй өрөөнд гүйн ороход бүгд өөрчлөгдсөн байв. Хананд өлгөөстэй хөргүүд хоосорчээ. Нэг ч захирал тэнд байсангүй. Тэд харваас болсон үйл явдлыг харахаар хөргүүдийн хооронд дамжин шилтгээнээр гүйж байгаа бололтой.

Харри захирлын сандлын ард өлгөсөн Дамблдорын хоосон хөрөг рүү гунигтай хараад цааш эргэв. Гүн ухааны цүнхээл ердийн байрандаа байлаа. Харри түүнийг бичгийн ширээн дээр тавиад Снеггийн дурсамжыг эртний дүрс тэмдэг бүхий

эмжээртэй чулуун суулганд хийв. Бусдын ой санамжид орж байж л ... сэтгэл нь амрах шиг ... Снегг түүнд бодлоос өөр юу ч үлдээсэнгүй. Дурсамж хачирхалтай мөнгөлөг цагаан өнгөөр хуйлран эргэлдэхэд Харри гашуун зовлонгоо мартахын тулд огт эргэлзэлгүй толгойгоо чулуун суулганд дүрлээ.

Тэр хурц нарны гэрэлтэй дулаахан газар унав. Тэгээд өндийн босох үедээ бараг хоосон хүүхдийн тоглоомын талбайг олж харлаа. Алсад тэнгэрийн хаяанд том яндан ёрдойно. Хоёр охин савлуур дээр тоглож бутны цаанаас туранхай хүү харж байлаа. Түүний урт хар үс өмссөн хувцастайгаа муухан зохилдох агаад өмд нь хэт богинохон, насанд хүрсэн хүний нэвсгэр хүрэмтэй, ажлын хувцас шиг хачин цамцтай байлаа.

Харри хүүд ойртон очив. Снегг ес юмуу арван наснаас хэтрээгүй харагдаж байсан бөгөөд цонхигор, жижигхэн, туранхай байлаа. Тэр эгчээсээ арай өндөр жижигхэн охин руу шунамхайран харж байв.

- Лили, боль! гэж том нь хашгирав.

Гэвч охин агаарт маш өндөр савлан үсрэхдээ хашгирч инээд алдаад тоглоомын талбай дээр гимнастикчин шиг итгэмээргүй хөнгөхөн уян хөдөлгөөнөөр газардав.

- Ээж чамд ингэж болохгүй гэж хэлсэн! гээд Петунья дүүжингээ чахруулан зогсоод үсрэн бууж ташаагаа тулав.

- Ээж чамайг ингэж болохгүй гэж хэлсэн, Лили!

- Гэхдээ юу ч тохиолдоогүй шүү дээ. Тунья, үүнийг хараач. Миний юу чаддагыг хараач гэж Лили инээд алдав.

Петунья харлаа. Тоглоомын талбай дээр тэднээс гадна Снегг байсныг охид мэдсэнгүй. Лили Снеггийн ард нь нуугдсан бутнаас унасан цэцгийг авав. Петунья удаанаар түүн рүү очихдоо сониучирхсан болон дургүйцсэн янзтай байлаа. Лили эгчийгээ ойртож ирэхийг хүлээж байгаад алгаа нээхэд цэцэг дэлбээлсэн байв.

- Үүнийгээ боль! гэж Петунья хашгирав.

- Чамайг энэ яагаа ч үгүй биз дээ! гээд Лили алгаа тэнийлгэн цэцгийг газар унагав.

- Тэгж болохгүй гээд Петунья газар унаж байгаа цэцгийг нүд салгахгүй дагуулан харснаа,

- Чи үүнийг яаж хийв? гэж атаархангуй асуулаа.

- Энэ ойлгомжтой биш үү? гээд Снегг удаан тэссэнгүй бутны араас үсрэн гарлаа.

Петунья хашгираад савлуур луу ухрахад, Лили айсан ч зогссон хэвээр үлдэв. Снегг харваас гэнэтийн гарч ирэлтэндээ харамссан бололтой Лили рүү хараад туранхай хацар нь ягаарлаа.

- Юу ойлгомжтой гэж? хэмээн Лили асуув.

Снегг хөөрөн догдолсноо савлуурын дэргэд зайтай зогсож байгаа Петунья руу харж дуугаа намсган,

- Би чиний хэн гэдгийг мэднэ гэв.

- Чи юуны тухай яриад байна?

- Чи ... чи шидтэн гэж Снегг шивнэлээ. Охин гомдсон төрхтэй болов.

- Энэ чинь тийм ч сайнгүй үг байна! гээд тэр бардмаар эргээд хамраа өргөн эгч рүүгээ явлаа.

- Үгүй дээ! гэж Снегг араас нь хашгирав. Тэр час улайхад Харри яагаад тэнэг нэвсгэр хүрмээ тайлахгүй байгааг нь гайхсан ч өмссөн цамцнаасаа ичсэн юм болов уу гэж бодлоо. Тэр охидын араас сарьсан багваахай шиг эв хавгүйхэн явахдаа наснаасаа хамаагүй ахмад харагдав.

Эгч дүүс түүн рүү дургүйцэн хараад хоёул савлуурын шонгоос зуурлаа.

- Чи үнэхээр шидтэн. Үнэн шүү. Би чамайг эртнээс харж байгаа юм. Гэхдээ үүнд ямар ч муу юм байхгүй. Миний ээж бас шидтэн, би өөрөө ч гэсэн шидтэн.

Петунья хүйтнээр инээд алдав.

- Шидтэн гэнээ! хэмээн тэр гэнэт гарч ирэлтнээс нь хойш зориг зүрх орон хашгираад,

- Би чамайг хэн гэдгийг мэднэ. Чи бол Снеггийнхний хүү. Тэд голын эрэг дээр Ээрүүлийн мухар гудамжинд амьдардаг юм. Ингэхэд чи яах гэж биднийг тагнаад байгаа юм бэ? гэлээ.

- Би тагнаагүй! гэж Снегг хурц нарны гэрэлд зогсож байгаадаа аягүйцэн халууцаж хэлээд,

- Чамайг би хэзээ ч тагнахгүй. Чи чинь магл шүү дээ гэж хорсолтой хэлэв.

Хэдийгээр Петунья юу хэлснийг нь мэдээгүй ч гэлээ дууны өнгөнөөс нь гадарлав бололтой.

- Лили явцгаая! гэж огцом хэлэв.

Лили эгчийнхээ үгэнд орон явахдаа Снегг рүү муухай харав. Тэр зогсоод хүүхдийн тоглоомын талбайгаас гарахыг нь харан үлдэхэд Харри цорын ганц түүнийг ширтэж байсан хүн болохоор гашуун урам хугарлыг нь ойлгож Снегг эртнээс энэ яриаг бэлтгэсэн ч санаснаар нь бүтээгүй болохыг ойлгов.

Үйл явдал Харрийн эргэж харахын зуургүй өөрчлөгдөж өөр газар бий болов. Тэр бяцхан төгөл дунд зогсож байлаа. Нарны туяа мододын хоорондтусаж титмүүд нь сэрүүхэн ногоон сүүдэр үүсгэжээ. Хоёр хүүхэд урд урдаасаа хараад газар сууж байв. Энэ удаад Снегг хүрмээ тайлсан ч бүрэнхийд хачирхалтай цамц нь нүдэнд туссангүй.

- Хэрвээ чи сургуулиас гадуур шид хэрэглэх юм бол ид шидийн яамнаас шийтгэж захиа ирдэг юм.

- Гэхдээ би сургуулиас гадуур шид хэрэглээгүй шүү дээ!

- Бидний хувьд болно. Гэхдээ бидэнд шидэт саваа байхгүй. Бид үүнгүйгээр юу ч хийж чаддаггүй болохоор хүүхдүүд үүнийг сонирхдоггүй юм. Гэсэн ч чи арван нэгэн нас хүрээд суралцаж эхлэхдээ болгоомжтой байх хэрэгтэй гээд толгойгоо учиртай дохилоо.

Тэд чимээгүй болцгоов. Лили газар унасан мөчир авч агаарт эргэлдүүлэхэд Харри түүний үзүүрээс нь оч цацарч байна гэж төсөөлсөн болохыг ойлголоо. Дараа нь тэр мөчрөө хаяаад хүү рүү эргэн,

- Энэ бүхэн үнэн гэж үү? Чи тоглоогүй биз дээ? Петунья ямар ч Хогвартс байхгүй чамайг худал хэлж байна гэсэн. Тэр үнэхээр байдаг юм уу? гэв.

- Бидний хувьд бий харин түүний хувьд байхгүй. Бид хоёулаа захиа авна.

- Үнэхээр үү? хэмээн Лили шивнэлээ.

- Тиймээ гээд Снегг муухан зассан үс, олиггүй хувцастай байсан ч хүчтэй сэтгэгдэл төрүүлсэндээ өөртөө итгэлтэй болов.

- Захиаг үнэхээр ууль хүргэж ирдэг юм уу? гэж Лили аяархан асуув.

- Ихэнхидээ уулиуд авчирдаг юм. Гэхдээ магл гэр бүлээс гаралтай хүний хувьд сургуулиас хэн нэгэн ирж эцэг эхтэй нь ярилцдаг юм.

- Магл гаралтай байх нь ялгаатай юу? Снегг тээнэгэлзлээ.

- Үгүй. Энэ ялгаатай биш.

- Сайн байна гээд Лилийн санаа амарлаа. Тэр харваас үүнд түгшсэн бололтой.

- Чамд шидийн чадвар байгаа. Би үүнийг харсан. Би чамайг үргэлж хардаг байсан ... гээд түүний хоолой бөхлөө.

Гэсэн ч Лили түүнийг сонсолгүй газар сунан хэвтээд толгой дээрх сүүдэрлэсэн навч руу харж байв. Снегг түүн рүү хүүхдийн тоглоомын талбайд харж байсан үеийнх шигээ шунахайран харна.

- Чиний гэрийн бүх зүйл хэвийн үү? гэж Лили асуулаа.

- Зүгээр гээд тэр үл мэдэг хөмсөг зангидав.

- Тэд маргалдахгүй байна уу?

- Өө, бүр яаж маргалдаж байгаа гээч! Гэхдээ би удахгүй явах болохоор удаан байхгүй гээд Снегг юу хийж байгаагүй анзааралгүй навч зулгаан авч тасчиж эхлэв.

- Чиний аав ид шидэд дургүй юу?

- Тэр юунд ч дургүй.

- Северус ...

Снегг нэрийг нь дуудсанд баясан инээмсэглээд,

- Аан? гэлээ.

- Надад Дементоруудын тухай ярiач.

- Чи тэдний тухай юу мэдмээр байгаа юм?

- Хэрвээ би сургуулиас гадуур ид шид хэрэглэвэл ...

- Хэн ч чамайг Дементорт өгөхгүй! Дементорууд жинхэнэ гэмт хэрэг хийсэн хүмүүсийг барьдаг юм. Тэд шидтэнгүүдийн Азкабан шоронг харгалздаг. Харин чи Азкабанд ороход хэтэрхий ...

Тэр ахин улайгаад хэдэн навч тасдав. Тэгтэл ард нь тасхийх чимээ гарахад Харри эргэж харвал Петунья модны ард нуугджээ.

- Тунья! гэж Лили гайхан хэлэхэд, Снегг үсрэн босоод,

- Хэнийг тагнаад байгаа юм? Чамд юу хэрэгтэй юм? гэж хашгирлаа. Петунья баригдсандаа айсан ч ямар нэг гомдоох зүйл хэлэхээр хүчлэн бодлоо.

- Чи юугаа өмсчихөө вэ, аан? Ээжийнхээ цамцыг уу? гээд Снеггийн цээж рүү хуруугаараа заав.

Тасхийх чимээ гараад түүний толгой дээр байсан мөчир хугарахад Лили хашгирав. Мөчир Петуньягийн мөрийг нь цохиход хойшоо найгаснаа нулимс цийлэгнүүлэв.

- Тунья!

Гэвч Петунья хэдийн гүйжээ.

- Чи үүнийг хийсэн үү? гээд Лили Снегг рүү эргэхэд,

- Үгүй! гэж айсан байртай хэлэв.

- Чи үүнийг хийсэн! Чи хийсэн! Чи түүнийг өвтгөсөн! гээд тэр ухарлаа.

- Үгүй, би биш.

Гэвч Лили энэ худал үгэнд итгэсэнгүй. Тэр түүнийг сүүлчийн зэвүүрхэн хармагцаа эгчийнхээ араас гүйхэд Снегг золгүй ичингүйрсэн байдалтай үлдэв.

Үйл явдал ахин өөрчлөгдөв. Харри эргэн тойрноо харлаа. Тэр есөн бүхэл дөрөвний гуравдугаар тавцан дээр Снеггээс холгүйхэн зогсоод дэргэд нь үл ялиг бөгтөр, шаргалдуу царай, туранхай гашуун төрхтэй түүнтэй маш адилхан эмэгтэй зогсож

байлаа. Снеггийн нүд буудал дээр зогсож байгаа гэр бүлийн дөрвөн хүн рүү чиглэжээ. Хоёрр охин эцэг эхийнхээ хамт зогсож байв. Лили эгчийгээ ятгахыг оролдож байгаа бололтой. Харри ойртож очоод сонсов.

- Уурлах хэрэггүй, Тунья намайг уучлаарай! Сонсооч ... гээд эгчийнхээ гараас барьсан ч Петунья угз татан авахыг хичээв.

- Магадгүй би тэнд очихоороо ... үгүй ээ сонсооч, Тунъя! Магадгүй би тэнд очихоороо профессор Дамблдорын шийдвэрийг өөрчилөхөөр ятгаж чадах байх!

- Би ... тийшээ ... явахыг ... хүсэхгүй ... байна! Чи намайг тэнэг шилтгээнд суралцахаар ... гээд түүний нүд тавцан дээр эзнийхээ гарт дуугарч байгаа муур, далавчаа дэвэн гуугчих тортой ууль, зарим нь урт хар хувцас өмсөн чемодан чирсэн

хүүхдүүд болон уурын улаан галт тэргэнд зуны удаан хугацааны амралтын дараа бие биетэйгээ баяртай мэндлэн уулзах сурагчдыг гүйлгэн харлаа.

- Намайг ... гаж зүйл сурна гэж бодоо юу?

Лилигийн нүдэнд нулимс цийлэгнэхэд Петунъя эцэст нь гараа сугалан авлаа.

- Энэ бол гаж биш. Энэ чинь муухай үг байна!

- Гаж зүйлийн тусгай сургууль учраас чи явж байгаа гэж Петнуья сэтгэл хангалуун хэлээд,

- Снеггийн хүү та хоёр ... хоёулаа төрөлхийн гаж амьтад. Та хоёрыг жирийн хүмүүсээс хол байлгах хэрэгтэй. Энэ нь бидний хувьд аюулгүй байх болно гэв.

Лили тавцан дээгүүр болж буй үйл явдлыг сонирхож буй эцэг эх лүүгээ харлаа. Дараа нь тэр эгч рүүгээ эргээд аяархан ууртайгаар хоолойгоор,

- Чи энэ сургуулийг муухай гэж бодож байгаагийн учир нь захиралд өөрийгөө авахыг гуйсан захиа илгээсэнд байгаа юм гэв.

Петунья час улайлаа.

- Гуйсан гэнээ? Би гуйгаагүй!

- Би түүний хариуг харсан ... Маш эелдэг байсан.

- Хэн чамд уншихыг зөвшөөрсөн юм. Энэ чинь миний хувийн юм ... чи яаж чадав аа? гэж Петунья шивнэлээ.

Лили холгүй зогсох Снеггийн зүг хяламхийхэд Петунья дуу алдав.

- Энэ хүү үзсэн юм уу? Чи миний өрөөнд энэ хүүтэй хулгайгаар ороо юу!

- Үгүй, бид хулгайгаар ороогүй ... Северус дугтуйг нь л харсан. Тэр магл Хогвартсаас захиа авч чадна гэдэгт итгэхгүй байсан юм! Тэр шидтэнгүүдийн шуудангийн үйлчилгээ нууцаар ажилладаг болохоор ...

- Шидтэнгүүд хамраа хаа сайгүй дүрж явах юм! гэж Петунья дүрсхийн хэлээд, гаж амьтад! гэснээ дүүгээсээ нүүр буруулан эцэг эх рүүгээ эргэлээ ...

Үйл явдал ахин өөрчлөгдөхөд Снегг «Хогвартс экспресс»-ийн хонгилоор яаран явж байлаа. Тэр сургуулийн дүрэмт хувцасаа өмсөөд анх удаагаа маглуудын муухай хувцаснаасаа салав бололтой. Эцэст нь хэдэн хөвгүүд шуугилдан ярьж буй өрөөний үүдэнд зогсов. Цонхны буланд Лили суугаад нүүрээ шилэнд наажээ.

Снегг тасалгаанд орж эсрэг талд нь суув. Тэр түүн рүү харснаа ахин цонх руу эргээд уйлан,

- Би чамтай ярихгүй гэж хүчилсэн хоолойгоор хэлэв.

- Яагаад?

- Тунья намайг үзэн ядаж байна. Дамблдорын захиаг уншсаны төлөө.

- Тэгээд юу гэж?

Тэр түүн рүү жигшин харлаа.

- Тэр чинь миний эгч шүү дээ!

- Тэр бол ердөө гээд Снегг чимээгүй болов. Лили нулимсаа арчиж байсан тул түүний үгийг сонссонгүй.

- Гэхдээ бид явж байна! Бид Хогвартс руу явж байна! гээд тэр хоолойны хөөрсөн өнгөө нууж чадсангүй.

Лили нойтон нүдтэй толгой дохиод инээмсэглэв.

- Чи Слизеринд орсон нь дээр байх гэж Снегг урамшуулан хэллээ.

- Слизеринд гэнээ?

Тасалгаанд сууж байсан хөвгүүдийн нэг одоог хүртэл Лили, Снегг хоёрт анхаарал хандуулаагүй байснаа тэдэн рүү харлаа. Харри саяхныг хүртэл эцгийгээ анзаарсангүй. Туранхай яг л Снегг шиг хар үстэй гэсэн ч өөр байлаа.

- Хэн Слизеринд орохыг хүснэ гэж? Тэгвэл би шууд сургуулиас гарна харин чи? гэж Жеймс эсрэг талдаа сууж байсан хүүгээс асуухад Харри Сириусыг хөөрөн танилаа. Тэр инээмсэглэсэнгүй.

- Манай гэр бүлийнхэн бүгдээрээ Слизеринд сурдаг.

- Чөтгөр гэж! Харин чи надад дажгүй санагдсан юмсан! гэж Жеймс дуу алдав.

Сириус инээлээ.

- Магадгүй би гэр бүлийнхээ уламжлалыг зөрчих байх. Харин чамайг сонго гэх юм бол аль тэнхимд орох вэ?

Жеймс үл үзэгдэх илд өргөлөө.

- Эрэлхэг зоригтой хүмүүс суралцдаг Гриффиндорт. Яг л эцэг шигээ. Снегг зэвүүцэнгүй тургилав. Жеймс түүн рүү эргэлээ.

- Чамд энэ таалагдахгүй байна уу?

- Үгүй дээ. Хэрвээ ухаантай байхаас зоригтой байхыг эрхэмлэж байгаа бол ... гэж Снегг тургилтаа инээмсэглэл болгохыг оролдон хэлэв.

- Харин чи хаашаа орно гэж найдаж байна? гэж Сириус оролцов. Жеймс инээд алдахад Лили улайн суугаад тэднийг таагүй харцаар ажиглав.

- Северус явж өөр тасалгаа эрж ольё.

- Оооо ...

Тэд түүний ихэмсэг хоолойн өнгийг дуурайн даажигнаад, Жеймс Снеггийг хажуугаараа өнгөрөх үед дэгээдлээ.

- Удахгүй уулзъя, Нюниус! гэж тасалгааны хаалга хаагдахад хашгирав. Ингээд үйл явдал ахин өөрчлөгдлөө ...

Харри асан буй олон лааны гэрэл гэрэлтүүлсэн тэнхимйн ширээний урд Снеггийн баруун талд зогсоод анхаарал хандуулсан царайнуудыг харж байв. Тэгтэл профессор МакГонагалл,

- Лили, Эванс! гэж дуудав.

Тэр хэрхэн ээжийнхээ чичирсэн хөлтэй урагш гарч ирээд сандал дээр суухыг харлаа. Профессор МакГонагалл түүний толгойд хуваарилагч бүрх малгайг өмсгөхөд хар үсэнд нь дөнгөж хүрэв үү үгүй юу,

- Гриффиндор! гэж хашгирав.

Харри хэрхэн Снеггийн аяархан дуу алдахыг сонслоо. Лили малгайгаа тайлаад профессор МакГонагаллд буцаан өгч хөгжилтэй алга ташиж буй Гриффиндорынхон руу алхахдаа Снегг рүү гунигтай инээмсэглэв. Харри Сириус түүнд хажуудаа зай тавьж өгөхийг харлаа. Тэр түүн рүү харснаа тасалгааны хөршөө танив бололтой шийдэмгий эргэлээ.

Жагсаалт дуудах үргэлжилсээр. Харри Люпин, Петтигрю болон түүний эцэг Гриффиндорын ширээнд сууж байгаа Лили, Сириус хоёртой нэгдэхийг харлаа. Эцэст нь хуваарилалтанд багахан хүмүүс үлдэхэд профессор МакГонагалл Снеггийн нэрийг дуудав.

Харри түүний хамт сандал руу очиж малгайг толгойдоо өмсөхийг нь харав.

- Слизерин! гэж малгай хашгирлаа.

Ингээд Северус Снегг Их танхимын нөгөө өнцөг рүү зүглэн Лилигээс холдоход Слизеринчүүд хөөрөн мэндчилж, ахлагчын тэмдэг энгэртээ гялалзуулсан Люциус Малфой нуруун дээр нь алгадаад дэргэдээ хамт суулгав ...

Үйл явдал өөрчлөгдлөө ...

Лили, Снегг хоёр шилтгээний хашаанд гараад ямар нэг юмны талаар маргалдаж байсанд Харри сонсохоор яаран дөхөж очив. Тэд өндөр болсныг бодвол харваас хуваарилалт өнгөрснөөс хойш хэдэн жил болсон бололтой.

- ... бид найзууд гэж бодсон юмсан. Сайн найзууд гэж Снегг хэлэв.

- Бид найзууд хэвээрээ, Сев гэхдээ надад чиний холбоотой хүмүүс таалагдахгүй байна! Өршөөгөөрэй би Эйвери, Мальсибер хоёрыг тэвчиж чаддаггүй юм. Мальсибер шүү! Чи түүнээс юугаа олох гээ вэ, Сев? Тэр чинь аймшигтай! Чи түүний Мэри Макдональдад юу хийхийг завдсаныг мэдэх үү? гээд Лили багана налан зогсоод туранхай шарангуй царай луу нь харлаа.

- Энэ чинь юу ч биш. Тэр зөвхөн инээхийг хүсээд л ...

- Энэ чинь хар шид хэрвээ чи үүнийг инээдтэй гэж бодож байгаа бол ...

- Тэгвэл Поттер болон түүний нөхдийн хувьд юу хэлэх гэж байна? гэж Снегг зэвүүцэнгүй хэллээ.

- Поттер энд ямар хамаатай юм бэ?

- Тэд шөнөөр хаа нэг тийш яваад байгаа. Тэр Люпинд нэг л хачин зүйл бий.

Ингэхэд тэр хаашаа явсан юм бол?

- Тэр өвдсөн. Маш хүнд өвдсөн гэсэн.

- Сар бүрийн арван таванд уу?

- Би чиний онолыг мэднэ. Гэхдээ энэ чамайг яагаад зовоогоод байгаа юм бэ?

Чамд тэдний шөнө юу хийх нь ямар хамаа байна? гэж Лили хүйтнээр асуув.

- Би зөвхөн тэд бүгдийн боддог шиг гайхамшигтай биш гэдгийг чамд үзүүлэхийг хүссэн юм.

Лили түүний шаардангуй харцанд улайв.

- Ямар ч гэсэн тэд хар шид хэрэглэдэггүй. Харин чи бол талархал мэддэггүй амьтан. Би өнгөрсөн шөнө юу болсон тухай сонссон. Чи шажигнуур удны доод талын хонгил руу ороход Жеймс Поттер чамайг аварсан ...

Снеггийн нүүр мурийлаа.

- Аварсан гэнээ? Аварсан юм биз дээ? Чи түүнийг баатар гэж бодож байна уу?

Тэр өөрийнхөө арьсыг найзынхтайгаа хамт аварсан юм! Чи тэгж болохгүй ... би чамд зөвшөөрөхгүй ...

- Зөвшөөрөхгүй гэнээ? Надад уу?

Лилигийн хурц ногоон нүд нарийсахад Снегг дорхноо үгнээсээ буцлаа.

- Би тэгж хэлэхийг хүсээгүй ... зүгээр л чамайг мунхруулахыг хүсээгүй юм ... тэр чамайг сонирхдог, Жеймс Поттер чамайг сонирхдог! Харин тэр ... бүгд түүнийг ... квиддичийн аварга гэж боддог ... гэж гашуунаар уялдаа холбоогүй үг хэлэхэд Лили хөмсгөө улам өргөв.

- Би Жеймс Поттерын их зантай биеэ тоосныг мэднэ. Иймээс чи надад тайлбарлахгүй байж болно. Гэхдээ Мальсибер, Эйвери хоёрын хувьд бол өөр хэрэг. Өөр хэрэг, Сев. Чи тэдэнтэй яаж нөхөрлөж чаддагийг ойлгохгүй юм.

Харри Снегг Мальсбер, Эйвери хоёрын тухай шүүмжлэлийг сонсож чадах эсэхэд эргэлзлээ. Тэр Жеймс Поттерыг доромжлох агшинд бие нь тайвширсан бол эргээд Снеггийн алхамын тухай ярихад ...

Ингээд үйл явдал өөрчлөгдөв ...

Харри ахин Снегг Их танхимд С.И.Ш-ийн хар урлагаас хамгаалах хичээлийн шалгалт өгсөний дараа шилтгээнээс гараад санамсаргүй Жеймс, Сириус, Люпин, Петтигрю нараас холгүй газар суухыг харлаа. Гэвч энэ удаад Харри ойртсонгүй. Тэр юу болсныг мэдэж байгаа болохоор ахин сонсохыг хүссэнгүй. Тэр Лили хүмүүсийн дунд Снеггийг хамгаалахаар ойртохыг харав. Тэгтэл алсад Снеггийн уур хилэнтэй хоолой сонсогдож,

- Бохир цустан! гэсэн үг цуурайтлаа. Үйл явдал өөрчлөгдлөө.

- Намайг уучлаарай.

- Би үүнийг сонирхохгүй байна.

- Намайг уучлаарай!

- Ингэхгүй байж болно.

Энэ бол шөнө байлаа. Лили халаттай энгэртээ гараа зөрүүлэн Гриффиндор цахмагийн үүдэн дэх тарган хатагтай хөргийн өмнө зогсож байв.

- Би зөвхөн Мэри чамайг шөнөжингөө энд зогссон гэж хэлсэн болохоор гарч ирсэн юм ...

- Тиймээ. Би тэгсэн. Би чамайг бохир цустан гэж дуудахыг хүсээгүй зүгээр л ...

- Санамсаргүй хэлчихсэн гэх нь үү? гэж Лили өрөвдөх сэтгэлгүй хэлээд,

- Хэтэрхий хоцорсон. Би чамайг олон жилийн өмнө уучилсан. Миний найз нөхдийн хэн нь ч чамтай яагаад ярьдагийг ойлгодогүй. Чи болон чиний найзууд ... Үхэл залгигчид ... аанхан чи үүнийг үгүйсгэхгүй байгаа юм биз дээ! Чи өөрийгөө ч тийм гэдгийг үгүйсгэж чадахгүй! Чи Хэцүү нэрттэй нэгдэх гээд тэсч ядаж байна уу? гэв.

Тэр амаа нээсэн ч юу ч хэлсэнгүй.

- Би цаашид дүр үзүүлж чадахгүй. Чи өөрийн замаа сонгосон би өөрийнхөөрөө явлаа.

- Үгүй ... сонсооч би хүсээгүй ...

- Намайг бохир цустан гэж дуудахыг үү? Гэхдээ чи тийм гэр бүлтэй бүх хүмүүсийг тэгж дууддаг биз дээ, Северус. Би яагаад өөр байх ёстой гэж?

Тэр тайлбарлахыг хичээсэн ч Лили зэвүүцэнгүй эргээд хөргөн гарцаар алга болов. Гриффиндорын цамхагын үүд уусан алга болсон ч шинэ үйл явдал шууд эхэлсэнгүй.

Харри үйл явдал өөрчлөгдөх дүрсэн дунд нисэхэд хүрээлэн буй орчин ахин бэхжин

харанхуй хүйтэн хоосон толгодын орой дээр зогсоод салхинд модолдын мөчир шуугиж байлаа. Насанд хүрсэн Снегг шидэт саваагаа чанга атгаад хүндээр амьсгаадан байрандаа сэтгэл зовон эргэлдэхдээ гарцаагүй хэн нэгнийг хүлээж байлаа. Түүний айдас Харрид халдахад айх зүйл юу ч байхгүй гэдгийг мэдэж байсан хэр нь хэнийг хүлээж байгаа болохыг нь тааварлан хойшоо эргэж харав ...

Агаарт нүд гялбам хурц цагаан гэрэл гялсхийв. Харри аянга байх гэж бодсон ч Снегг өвдөглөн унаад саваа нь гараасаа мултарлаа.

- Намайг битгий алаач!

- Би тэгэх гээгүй байна.

Дамблдор ой шуугих чимээнд анзаарагдалгүй шилжин иржээ. Тэр Снеггийн өмнө хийссэн жанчтай зогсоход царай дээр нь гартаа барьсан сабааны гэрэл тусав.

- За Северус? Лорд Волдеморт надад ямар үг дамжуулаа вэ?

- Үгүй ... ямар ч үг дамжуулаагүй ... Би ийшээ өөрөө ирсэн юм! гээд Снегг гараа базлав. Түүний хар үс салхинд хийсэж ухаан солиорсон аятай харагдав.

- Би анхааруулахаар ирсэн юм ... үгүй хүсэхээр ... гуйж байна ...

Дамблдор саваагаа даллахад модны навчис урьдын адил салхинд хийссээр байсан хэр нь тэдний зогсож байсан газар нам гүм болов.

- Үхэл залгигчид надаас хүсэх ямар гуйлт байх билээ дээ?

- Энэ бол зөгнөл ... Трелонигийн хэлсэн ... зөгнөлийн тухай ...

- Аан тийм л дээ. Чиний лорд Волдемортод уламжилсан уу?

- Бүгд ... миний сонссон бүхэн! Ийм учраас ... үүнээс болоод ... тэр зөгнөлийг

Лили Эванст хамаатай гэж бодож байгаа юм!

- Зөгнөл эмэгтэй хүний тухай хэлээгүй. Тэнд долоон сарын сүүлчээр төрөх хүүгийн тухай байсан.

- Та миний юу ярьж байгааг ойлгож байна уу? Тэр түүний хүүгийн тухай бодож байна ... Тэр түүн рүү араас очих гэж байна ... бүгдийг нь алах болно ...

- Хэрвээ тэр таны хувьд чухал юм бол лорд Волдеморт эргэлзээгүй түүнийг өршөөх байлгүй. Та түүнээс эхийг нь өршөөхийг гуйж болсонгүй юу?

- Би тэгсэн ... би түүнээс гуйсан.

- Та надад жигшүүртэй санагдаж байна гэж Дамблдор Харрийн хэзээ ч сонсож байгаагүй зэвүүцсэн хоолойгоор хэлэхэд Снегг үл мэдэг атийлаа.

- Тэгэхээр таньд нөхөр хүү хоёр нь үхэх нь хамаагүй байх нь ээ? Зөвхөн тэд үхэж байж та хүссэндээ хүрэх юм биз дээ?

Снегг юу ч хэлсэнгүй Дамблдор луу харлаа.

- Тэгвэл бүгдийг нь нуу ... түүнийг авар ... тэднийг ... аюулгүй болго. Танаас гуйя гэж сөөнгөтөв.

- Тэгвэл та оронд нь юу өгөх юм дээ, Северус?

- Өг ... өгөх гэнээ? хэмээн Снегг Дамблдор руу мэгдэн харахад Харрид агшин зуур эсэргүүцэх гэж байгаа юм шиг санагдсан ч хэсэг хугацааны дараа,

- Бүгдийг гэв.

Толгодын орой алга болж Харри Дамблдорын өрөөнд зогсоод шархадсан амьтан гинших лугаа адил аймшигтай чимээ гарав. Снегг баргар царайлсан Дамблдорын урд талын сандал дээр бөхийн сууж байлаа. Хормын дараа Снегг нүүрээ өргөхөд толгодын орой дээр зогсож байснаасаа хойш зуун жилээр хөгширсэн юм шиг санагдав.

- Би таныг ... түүнийг ... аварсан ... гэж бодсон.

- Жеймс тэр хоёр хүнд буруу хүндээ итгэсэн. Яг л тань шиг, Северус. Та лорд

Волдеморт түүнийг өршөөнө гэж найдаж байсан биз дээ? Снеггийн амьсгаа давхцав.

- Тэдний хүү амьд үлдсэн.

Снегг толгойгоо салж өгдөггүй ялаа хөөж байгаа аятай сэгсэрлээ.

- Түүний хүү амьд байгаа. Нүд нь яг л түүнийх шиг. Та Лили Эвансын нүдийг санаж байгаа биз дээ?

- Боль! Үхсэн ... үүрд явсан ... гэж Снегг хашгирав.

- Таныг гэмшил зовоож байна уу, Северус?

- Би үүний оронд ... үхсэн нь дээр байсан юм.

- Одоо энэ хэнд ашигтай гэж? хэмээн Дамблдор хүйтнээр асуугаад,

- Хэрвээ та Лили Эванст хайртай байсан бол үнэн сэтгэлээсээ хайрладаг байсан бол цаашдын зам чинь тодорхой байна гэв.

Снеггийн зовлон шаналалд бүрхэгдсэн нүд Дамблдорын үгийг даруй ойлгосонгүй.

- Та ... үүгээрээ юу хэлэхийг хүсээ вэ?

- Чи түүнийг яагаад үхсэн болохыг мэднэ. Үүнийг хоосон гарзадахгүйн тулд хий. Лилигийн хүүг хамгаал.

- Түүнд хамгаалалт хэрэггүй. Хар лорд явсан ...

- Хар лорд эргэж ирэхэд Харри Поттерд аймшигтай аюул заналийлэх болно. Удтал нам гүм болов. Снегг биеэ бариад амьсгаа нь жигдэрлээ. Тэр эцэст нь,

- Сайн байна. За яахав. Гэхдээ энэ тухай хэнд ч битгий хэлээрэй, Дамблдор!

Энэ бидний хооронд үлдэх ёстой! Тангарагла! Би үүнийг тэвчихгүй ... ялангуяа Поттерын хүү ... надад амла! гэв.

- Би хэзээ ч энэ тухай хэлэхгүй гэдгээ амлаж байна, Северус? гээд Дамблдор Снеггийн зовж шаналсан хэрцгий царай луу хараад санаа алдлаа. Хэрвээ та шаардаж ...

Өрөө алга болоод ахин эргэж ирэхэд Снегг Дамблдорын урдуур холхиж байлаа.

- Авъяасгүй, яг л эцэг шигээ биеэ тоосон, дүрэм журам зөрчих дуртай, алдар гавъяанд шунагч бүдүүлэг ...

- Та түүнээс өөр юу харахыг хүсээ вэ, Северус гэж Дамблдор «Өнөөдрийн хувиргал» сэтгүүлээс нүд салгалгүй хэлээд,

- Бусад багш нар хүүг даруухан, аятайхан ухаалаг авъяастай гэж хэлсэн. Тэгээд ч миний хувьд хүмүүжилтэй хүү шиг санагдсан гээд сэтүүлийн хуудсаа эргүүлэнгээ,

- Квиреллийг харж байгаарай, за юу? гэлээ.

Эргэн тойрны өнгө өөрчлөгдөн харанхуйлахад Снегг, Дамблдор хоёр үүдний танхимаас арай зайтай зогсоод дэргэдүүр нь бүжигт үдэшлэгийн сүүлчийн оролцогчид унтлагын өрөө лүүгээ явж байлаа.

- Юу болсон бэ? гэж Дамблдор аяархан асуув.

- Каркаровын тамга бас харласан. Тэр сандралд орон шийтгэгдэхээс айж байгаа. Та түүнийг Хар лордын уналтын дараа ид шидийн яаманд ямаршуу туслалцаа үзүүлснийг мэднэ биз дээ. Каркаров хэрвээ тамга төөнөхийг мэдрэх л юм бол зугтах болно.

- Өөр яана гэж? Та харин түүнтэй нэгдэхийг хүсэхгүй байна уу? гэж Дамблдор аяархан хэлэхэд дэргэдүүр нь Флер Делакур, Рожер Дэвисийн хамт явж өнгөрлөө.

- Үгүй. Би тийм хулчгар биш гэж Снегг Рожер, Флер хоёрын араас хараад хэлэв.

- Тийм л дээ гэж Дамблдор зөвшөөрөөд,

- Та Игорь Каркаровтой харьцуулахад хамаагүй зоригтой. Та миний заримдаа хэтэрхий эрт хийсэн сонголтын тухайгаа боддогыг мэдэх үү ... гээд цаашаа мэгдсэн Снеггийг орхин явлаа.

Ингээд Харри ахин захирлын өрөөнд зогсож байлаа. Шөнө болжээ. Дамблдор бичгийн ширээний ардах өндөр түшлэгтэй сандал дээрээ хажуулдан хэвтэнэ. Тэр харваас хагас ухаантай байгаа бололтой түлэгдэж харласан баруун гар нь унжжээ. Снегг шившлэг бувтнан саваагаа Дамблдорын бугуй руу чиглүүлснээ, зүүн гараараа өтгөн алтаг шингэнтэй ханд уулгалаа. Хэдэн хормын дараа Дамблдорын зовхи чичигнэн нээгдэв.

- Яах гэж? Та яах гэж энэ бөгжийг зүүсэн юм бэ? Түүнд хараал агуулагдаж байсныг та мэдэж байгаа шүү дээ. Та яагаад түүнд хүрсэн юм бэ?

Дамблдорын урд талын ширээн дээр Марвало Мраксын эвдэрсэн бөгж хэвтэж байв. Дэргэд нь Гриффиндорын илд хэвтэнэ.

Дамблдор үрчийлээ.

- Би ... тэнэг зүйл хийсэн. Татагдахгүй байж чадсангүй ...

- Юунд татагдсан гэж? Дамблдор хариулсангүй.

- Та гайхамшигаар ийшээ эргэж ирсэн байна! гэж Снегг уурсангуй хэлээд,

- Энэ бөгж бидний бодсоноос ч илүү ер бусын хүчтэй хараалыг агуулж байгаа.

Би хараалыг ердөө түр тогтоон барьж чадна ... гэв. Дамблдор харласан гараа өргөөд сониучирхан харав.

- Та маш сайн ажиллажээ, Северус. Надад хэр хугацаа үлдсэн гэж бодож байна? гэж цаг агаарын тухай асууж байгаа аятай ердийн дуугаар хэлэв. Снегг хэсэг зуур тээнэгэлзсэнээ,

- Хэлж чадахгүй нь. Магадгүй жил байх. Ийм шидийг үүрд зогсоох боломжгүй.

Цаг хугацааны явцад улам газар аван хүчтэй болно гэв.

Дамблдор инээмсэглэв. Харваас түүнийг амьдрахад жилээс илүүгүй хугацаа үлдсэн гэдэг нь ер санаа зовсонгүй бололтой.

- Та надад байсан нь ямар азтай, ямар итгэмээргүй азтай хэрэг вэ, Северус.

- Хэрвээ та намайг арай эрт дуудсан бол би таньд арай илүү хугацаа олгох зүйл хийж чадах байлаа гэж Снегг уцаарлан хэлээд хэмхэрсэн бөгж рүү харж,

- Та бөгжийг эвдлэхэд хараал тайлагдсан гэж бодож байна уу? гэв.

- Сүнсэнд ямар нэг зүйл ... болсон нь эргэлзээгүй гээд Дамблдор хүчлэн өндийж сандалдаа суув.

- Гэхдээ энэ ч ажил хэргийг хөнгөлж байна шүү. Снегг түүн рүү гайхширан харахад Дамблдор инээмсэглэв.

- Би лорд Волдемортын миний тухайд зохиосон төлөвлөгөөний тухай ярьж байна. Төлөвлөгөө ёсоор хөөрхий хүү Малфой намайг алах ёстой юм.

Снегг Харрийн ихэнхидээ суудаг Дамблдорын эсрэг талын сандалд суулаа. Харри түүний Дамблдорын гарын хараалын тухуй ярилцахыг хүссэнийг ойлгож байсан ч элдэгээр энэ сэдвийг үргэлжлүүлэхээс татгалзав. Снегг баргар царайлан,

- Хар лорд Драког амжилтанд хүрнэ гэж хүлээгээгүй. Энэ бол Люциусын саяхны алдааны шийтгэл юм. Дракогын эцэг эхийг удаанаар тамлах замаар тэд алдааныхаа үнийг төлж байгаа гэв.

- Товчхон хэлэхэд хүүтэй үхлийн хэлэлцээр хийжээ. Миний ойлгосноор бол

Драко бүтэлгүйтвэл даалгаварыг та өвлөн авах ёстой биз дээ?

Хэсэг зуур чимээгүй болов.

- Тиймээ хар лордод тийм төлөвлөгөө байсан гэж бодож байна.

- Лорд Волдеморт ойрын ирээдүйд Хогвартсад тагнуул хэрэггүйг мэдэж байгаа биз дээ?

- Тиймээ, тэр сургууль мөдхөн гарт нь орно гэж бодож байгаа.

- Хэрвээ тэр үнэхээр гартаа оруулах юм бол та Хогвартсын сурагчдыг хамгаалахын тулд бүх зүйлээ хийнэ гэдгээ амлах уу?

Снегг удаанаар толгой дохив.

- Сайн байна. Одоо тэгвэл таны эхний даалгавар бол Дракогын юу хийж буйг илрүүлэх явдал. Өсвөр насны айж эмээсэн хүү эргэн тойрондоо байтугай өөртөө ч аюултай. Түүнд тусламж зөвөлгөө санал болго ... та түүнд таалагддаг болохоор зөвшөөрөх ...

- ... хэрвээ тэр эцгийгээ алдаагүй байсан бол болох байсан. Драко намайг

Люциусын байрыг эзлэхийг оролдож байгаа гэж бодож байгаа юм.

- Ямар ч гэсэн оролдоод үз. Би өөрөөсөө илүү хүүгийн толгойд орж ирэх төлөвлөгөөний санамсаргүй хохирогчид санаа зовж байна. Эцсийн дүндээ түүнийг лорд Волдемортын уур хилэнгээс ганц л зүйл аварна.

Снегг хөмсгөө өргөн даажигнасан байртай,

- Та түүнд өөрийгөө алахыг зөвшөөрөх гээ юу? гэв.

- Мэдээж үгүй. Намайг та алах ёстой.

Удтал чимээгүй болоход галт шувуу Фоукс юм тонших чимээ гарав.

- Та намайг үүнийг шууд одоо хийхийг хүсч байна уу? Эсвэл гэрээсээ бичсэнээс хэдэн хормын дараа юу? гэж Снегг хүйтнээр асуулаа.

- Өө, үгүй дээ тийм хурдан биш гээд Дамблдор инээмсэглэв.

- Би цаг нь ирэхээр мэдэгдэх болно. Гэвч өнөө шөнө тохиолдсон явдлаас үзэх юм бол жилийн дараа гэдэгт эргэлзээгүй гэж хатсан гараа харан хэлэв.

- Хэрвээ та үхэхийг эсэргүүцээгүй юм бол яагаад Дракод үүнийг хийх боломж олгож болдоггүй юм бэ? гэж Снегг ширүүн хэллээ.

- Хүүгийн сэтгэл санаа сэвтээгүй. Би түүнийг надаас болж зовохыг хүсэхгүй байна.

- Харин миний сэтгэл санаа, Дамблдор? Минийх?

- Зөвхөн та ганцаараа л сэтгэл санаагаа зовоох нь хөгшин хүнийг өвдөлт доромжлолоос зайлсхийхэд туслахыг мэднэ. Би танаас үүнийг хичээнгүйлэн гуйж байна, Северус. Яагаад гэвэл миний үхэл «Педдлийн их буунууд» баг улирлын тоглолтонд сүүлчийн байр эзэлсэнтэй адил шийдэгдсэн зүйл байх ёстой юм. Би үүнийг удаан хугацаанд зоволгүй түргэн хийхийг эрхэмлэж байгаа ч хэрвээ жишээлбэл, Сивыйн тухайд бол ... Би түүнийг Волдеморт

элсүүлсэн гэж сонссон? Эсвэл манай идэхээсээ өмнө хоолоороо тоглох дуртай хонгор Белляриса ч юмуу.

Тэр хөнгөн ярих агаад цэнхэр нүдээрээ Харри руу олонтоо харж байсны адил

Снеггийг цоо ширтэхэд толгой дохив. Дамблдорын царай сэтгэл ханамжтай боллоо.

- Баярлалаа, Северус ...

Өрөө алга боллоо. Харин одоо Снегг, Дамблдор хоёр бүрэнхийд сургуулийн хоосон нутаг дэвсгэрээр зугаалж байв.

- Та үдэш бүр Поттертой юу хийгээд байгаа юм бэ? гэж Снегг гэнэтхэн асуув.

Дамблдор түүн рүү ядрангуй харлаа.

- Яагаад? Та яагаад түүнийг цаг үргэлж шийтгэхийг оролддог юм бэ, Северус?

Хүү хамаг цагаа шийтгэл дунд өнгөрүүлж байна.

- Тэр эцэгтэйгээ адилхан ...

- Тийм байж болох ч сэтгэл зүрхнийхээ гүнд ээжтэйгээ адилхан. Би Харритай хэтэрхий ойртоогүй дээр нь мэдээлэл өгөхийн тулд олон цагийг өнгөрүүлж ярилцах хэрэгтэй байна.

- Мэдээлэл гэнээ. Та түүнд итгэдэг атал ... харин надад бол үгүй.

- Асуудал итгэлд байгаа юм биш. Бид хоёул хугацаа хязгаартайг мэднэ.

Ялангуяа би хүүд даалгавараа биелүүлэхэд нь хангалттай мэдээлэл өгөх хэрэгтэй байна.

- Тэгвэл яагаад надад адилхан мэдээлэл өгч болдоггүй юм?

- Би бүх нууцаа нэг л сагсанд хийхийг эрхэмлэж байгаа ... ялангуяа ихэнхи цагтаа лорд Волдемортын гарт өлгөгдөхгүй сагсанд.

- Гэхдээ би таны тушаалаар хийж байгаа!

- Тиймээ та үүнийг маш сайн хийж байгаа. Гэхдээ намайг таны биелүүлж байгаа ажлын аюул ослыг дутуу үнэлсэн гэж бүү бод, Северус. Волдемортод үнэтэй мэдээлэл дамжуулах ажлыг ялангуяа ийм ажлыг би танаас өөр хүнд итгэн даатгаж чадахгүй.

- Та Хар лордын бодолтой шууд холбоотой окклюменций ч эзэмших чадваргүй тааруухан хүүд илүү итгэж байна!

- Волдеморт энэ холбооноос айж байнаа. Тэр саяхан ... Харрийн бодлоос бага зэрэг амталж үзсэн. Энэ бол түүний амьдралдаа хэзээ ч амсаж байгаагүй өвдөлт байсан. Тэр Харриг цаашид эзэмдэхийг оролдохгүй гэдэгт би итгэлтэй байна. Ямар ч гэсэн тийм аргаар биш.

- Би ойлгосонгүй.

- Лорд Волдемортын зэрэмдэглэгдсэн сүнс Харрийнх шиг сэтгэл санааг тэвчдэггүй юм. Яг л хэлээрээ хөлдүү төмөр юмуу дөл мэдрэхтэй адилхан зүйл

...

- Сүнс гэнээ? Бид бодлын тухай ярьж байгаагүй билүү!

- Харрийн хувьд ярих нь лорд Волдемортын хувьд адилхан.

Дамблдор эргэн тойрондоо хүн байгаа эсэхийг шалган харав. Тэд Хориотой ойн дэргэд байсан ч ойр хавьд хэн ч байсангүй.

- Та намайг алсны дараа, Северус ...

- Та надад бүгдийг хэлэхээс татгалзаж байгаа мөртлөө надаас багагүй зүйл шаардаж байна! гээд Снеггийн туранхай царайд уур хилэн хуралдав.

- Та надад том ажил даалгасан, Дамблдор! Гэсэн ч би бодлоо өөрчилж болох юм!

- Та надад ам өг, Северус. Бид таны надад хийж өгөх ёстой зүйлийн тухай олон удаа ярилцсан. Та манай Слизериний залуу найзыг харахаа зөвшөөрснөө санаж байгаа биз дээ?

Снегг түүн рүү ууртай харлаа. Дамблдор санаа алдав.

- Северус өнөө орой арван нэгэн цагаас миний өрөөнд ирээрэй ... тэгвэл та итгэсэнгүй гэж гомдоллохгүй болно ...

Ингээд тэд ахин Дамблдорын өрөөнд байлаа. Цонхны цаана харанхуйлжээ. Фоукс чимээгүй суугаад Снегг ч гэсэн хөдөлгөөнгүй суух агаад Дамблдор өрөөн дундуур холхих зууpаа ярилаа.

- Харри үүнийг хүч хүрэх бүхнээ хийж дуусах хамгийн сүүлчийн хором хүртэл мэдэх ёсгүй шүү?

- Тэр юу хийх ёстой гэж?

- Энэ бол Харри бид хоёрын нууц. Одоо анхааралтай сонс, Северус. Цаг нь болохоор ... миний үхлийн дараа ... маргах хэрэггүй дээ, миний яриаг бүү тасал! Цаг нь болохоор лорд Волдеморт могойныхоо амины төлөө санаа зовж эхлэнэ.

- Нагайнагын төлөө юу? хэмээн Снегг гайхан асуулаа.

- Яг тийм. Цаг нь болохоор лорд Волдеморт могойгоо тушаал биелүүлэхээр илгээхээ болиод дэргэдээ аюулгүй байлган шидийн хамгаалалтаар хамгаалах болно. Тэгэхэд л Харрид хэлж болно гэж бодож байна.

- Харрид юу хэлнэ гэж?

Дамблдор гүн амьсгаа авснаа нүдээ анилаа.

- Түүнд лорд Волдеморт алахыг оролдон Лили өөрийн амьдралаараа тэдний дунд бамбай болж хамгаалан үхлийн хараал эргэн ойход сүснийх нь нэг хэсэг дэлбэрч нурсан байшинд байсан цорын ганц амьд хүнд орсон гэж хэл.

Лорд Волдемортын нэгээхэн хэсэг Харрийн дотор байгаа учраас тэр хүүд могойн хэлээр ярих болон бодолтойгоо холбогдох боломж өгсөнөө өөр ч сайн ойлгоогүй. Хэдийгээр сүнсний тэр хэсгийг Волдеморт тааварлаагүй ч Харрийн дотор хамгаалагдаж байгаа үед үхэх боломжгүй.

Харрид урт хонгилын үзүүрээс хоёр хүнийг харж байгаа юм шиг санагдан хоолой нь алсад дүнгэнэлээ.

- Тэгэхээр хүү ... хүү үхэх ёстой юу? гэж Снегг тайван асуув.

- Волдеморт түүнийг өөрөө алах ёстой, Северус. Энэ хамгийн чухал. Ахиад л удаан хугацаанд чимээгүй болов. Дараа нь Снегг,

- Энэ бүх жилүүдэд ... бид түүнийг хамгаалахын төлөө хийж байгаа гэж бодсон юмсан. Лилигийн төлөө гэв.

- Бид түүнийг хамгаалж байсны учир нь түүнийг сургаж өсөж өндийгөөд хүчээ туршиж үзэх боломж өгөх нь чухал байсан юм гээд Дамблдор зовхио өргөсөнгүй.

- Тэр үед тэдний хоорондын холбоо улам бат бэх болж хүчирхэгжин шимэгч маягийн болсон. Заримдаа надад Харри өөрөө үүнийгээ сэжиглэж эхлэх шиг санагддаг. Хэрвээ би эндүүрээгүй бол түүний үхлээ угтан алхах үе нь Волдемортын жинхэнэ төгсгөл болно гэж бодож байна.

- Та түүний амьдралыг хэрэгтэй үедээ үхүүлэхээр хадгалж байсан хэрэг үү? Дамблдор нүдээ нээхэд Снегг айдаст автсан харагдав.

- Энэ таныг цочирдуулж байна уу, Северус. Хичнээн эрэгтэй эмэгтэй хүмүүс таны нүдэн дээр үхэж байсан билээ?

- Хамгийн сүүлчийнхийг нь би аварч чадаагүй. Харин та намайг ашигласан байна гээд Снегг өндийлөө.

- Чи тэгж бодож байна уу?

- Би таны төлөө тагнуул хийж, худал хэлэн, таны төлөө өөрийгөө үхлийн аюулд оруулж байлаа. Ингээд энэ бүхнээ Лилигийн хүүгийн амьдралыг хамгаалахын тулд хийсэн гэж бодсон юм. Харин одоо та надад түүнийг төхөөрөх гэж байгаа гахай шиг тэжээсэн гэж хэлж байна ...

- Гэхдээ үүнд л сэтгэл хөдөлмөөр зүйл байгаа юм, Северус. Та эцсийн эцэст хүүтэй дасал болоогүй биз дээ?

- Хүүд гэнээ? Экспекто патронум! гэж Снегг хашгирав.

Сабааны үзүүрээс мөнгөн согоо гарч ирж шалан дээр газардаад цонхоор хөөрөн алга болоход Дамблдор түүнийг дагуулан харав. Мөнгөлөг гэрэл бөхөх үед тэр Снегг рүү нүд дүүрэн нулимстай эргэв.

- Хичнээн хугацааны дараа вэ?

- Үргэлж гэж Снегг хариулав.

Ингээд үйл явдал ахин өөрчлөгдөхөд Харри Снегг хэрхэн бичгийн ширээн ард өлгөөтэй Дамблдорын хөрөгтэй ярьж байхыг харлаа.

- Та Волдемортод Харрийн нагац ах эгчийнхээ гэрээс явах зөв өдрийг хэлэх хэрэгтэй. Гэхдээ Волдеморт таныг маш сайн мэдээлэгч гэж боддог учир үүнд сэжиг төрүүлж болохгүй. Үүнд хоёр санаа байгаа юм ... Харрийн аюулгүй байдал. Наземникус Флетчерт Конфундус шид хэрэглэхийг оролд. Тэгээд ч танаас гуйя Северус хэрвээ ангуучлах явдалд оролцох юм бол дүрдээ үнэмшилтэй тоглоорой ... Би таныг лорд Волдемортын итгэлийг удаан хугацаанд алдалгүй үлдэхгүй бол Хогвартс Кэрроугийнхний гарт орно гэж айж байна.

Одоо Снегг Наземникустай үл таних бааранд сууж байлаа. Тэд толгой бөхийлгөн ярилцана. Наземникусын царай сониучирхсан хоосон байсан бол Снегг хөмсөг зангидан анхаарлаа төвлөрүүлжээ.

- Чи энэ санааг Феникийн бүлэгт ашигла гэж хэл. Хувиргагч уусмал. Адилхан Поттерууд. Энэ бол бүтэх цорын ганц арга. Харин намайг чамд зөвлөсөн гэдгийг мартаарай. Тэдэнд чиний өөрийн санаа гэж хэл ойлгосон уу?

- Ойлголоо гэж харц нь төвлөрөөгүй Наземникус бувтнав.

Тэгтэл Харри шүүрэн дээр байгаа Снеггийн хажууд нисэж харанхуй шөнө байлаа. Дэргэд нь бусад юүдэнтэй Үхэл залгигчид нисэлдэн урд нь Люпин, Харритай үнэн хэрэгтээ Жоржтой байлаа ... Нэг Үхэл залгигч Снеггийг гүйцээд шидэт саваагаа Люпины нуруу луу чиглүүлэв.

- Сектусемпра! гэж Снегг хашгирав.

Гэвч Үхэл залгигчийн саваатай гар луу чиглүүлсэн шившлэг Жоржыг онолоо. Дараагийн үйл явдал. Снегг Сириусын унтлагын өрөөнд өвдөглөн сууж байв. Тэр

Лилигийн хуучин захиаг уншихад унжуу хамрыг нь даган нулимс дуслана. Хоёр

дахь хуудсанд ердөө хэдхэн үг байсан нь.

Геллерт Гриндевальдтай нөхөрлөж байсан гэж хэлсэн. Би хувьдаа Батильдаг зөнөсөн гэж бодож байна!

Хайрлан хүндэтгэсэн, Лили

Снегг Лилигийн гарын үсэгтэй хуудсыг уран аваад жанчныхаа дотор халаасанд хийв. Дараа нь тэр гэрэл зургийг хоёр хувааж инээж байгаа Лилиг үлдээгээд нөгөө тал болох Жеймс, Харри хоёрыг шүүгээний доод тал руу хийлээ ...

Ингээд Снегг ахин захирлын өрөөнд зогсоод Финеас Найжелус хөргөндөө яаран ирээд байв.

- Захирлаа! Тэд Дины ойд майхнаа барьж! Бохир цустан ...
- Би энэ үгийг чинь сонсмооргүй байна!
- ... Грейнжэр охин цүнхээ онгойглох үедээ энэ тухай дурсахыг нь би сонссон юм!
- Сайн байна. Маш сайн байна! гэж захирлын сандлын дээр байсан

Дамблдорын хөрөг дуу алдаад,

- Одоо илдийг аваачиж өг, Северус! Гэхдээ эр зориг шаардагдах нөхцөлд ... харин хэн өгч байгааг нь мэдэх ёсгүй гэдгийг бүү мартаарай! Хэрвээ Волдеморт Харрийн бодлыг уншаад таныг хүүгийн төлөө ажиллаж байгаа гэдгийг мэдэх юм бол ... гэв.
- Мэднэ гэж Снегг товчхон хэлээд Дамблдорын хөрөг рүү очиж хажуу талаас нь татлаа. Хөрөг онгойход ард нь Гриффиндорын илдийг нуусан нууц хөндий нээгдэв.
- Та урьдын адил Харри яагаад илдийг өгөх нь чухал болохыг хэлэхгүй юм уу?

гэж Снегг замын дээлээ өмсөх зууpаа асуулаа.

- Үгүй, гэж бодож байна. Тэр өөрөө түүгээр юу хийхээ олно. Болгоомжтой байгаарай, Северус. Тэгэхгүй бол тэд таньд Жорж Уизлитай тохиолдсон явдлын дараа аятай хандахгүй гэж айж байна.

Снегг босго руу эргээд,

- Санаа зовох хэрэггүй дээ, Дамблдор. Надад төлөвлөгөө бий гэж хүйтнээр хэлэв.

Ингээд өрөөнөөс гарах үед Харри гүн ухааны цүнхэлээс мултран гараад өрөөний хивсэн дээр зогсохдоо Снегг саяхан хаалга хаагаад явсан мэт санагдав.

БҮЛЭГ 34: АХИН ОЙД

Эцсийн үнэн энэ л байж. Тэр тоостой хивсэн дээр доош харан хэвтэхдээ ялахад сурсан тухайгаа бодсон ч эцэст нь амьд үлдэхгүй гэдгээ ойлгов. Түүний даалгавар бол үхлийг тайвнаар угтах явдал. Ийм аргаар Волдемортоос сүүлчийн холбоосоо салгах ёстой болохоор тэдний зам ахин тулгарах үед саваагаа өөрийгөө хамгаалахаар өргөлгүй Годрикийн хонхорт дуусаагүй ажлын үлдэгдэл биелэгдэх юм. Тэдний нэг нь нөгөөгөө амьд байгаа үед тайван байх боломжгүй.

Тэр зүрх нь хавирга дэлсэн цохилохыг мэдэрлээ. Хачирхалтай нь үхлээс айх айдас ихсэх тусам улам ихээр амьд үлдэхийг хүсэх аж. Гэхдээ энэ бүхэн удахгүй дуусах болно. Цохилт төлөвлөгдсөн. Түүнийг сүүлчийн удаагаа шилтгээний нутаг дэвсгэрээр Хориотой ой руу явах үед хичнээн хугацаа үлдсэн бол?

Айдас түүнийг нөмрөн авахад зүрх нь хүчтэй цохилов. Сонирхолтой нь үхэхэд өвдөх болов уу? Тэр хичнээн удаа үхлээс дээсэн дөрөөн дээр мултарч байсан ч нэг ч удаа энэ тухай бодож байсангүй. Амьд үлдэхийн төлөө хүсэл үргэлж үхлийн айдсаас илүү хүчтэй байдаг байсан бөгөөд Волдемортоос зугтаж байхад толгойд нь хэзээ ч энэ тухай орж байсангүй.

Түүнд зуны нэгэн шөнө сүүлчийн удаа Улаан модон гудамжны дөрөвдүгээр байшингаас явж байхад галт шувууны өдтэй саваа нь амийг нь аварч байсан удаа санагдав. Хэрвээ тэр Хэдвиг шиг юу болохыг мэдэлгүй түргэхэн үхсэн бол. Эсвэл хэн нэгэн хайртай хүнээ аврахын тулд үхлийн шившлэгийг угтан урдуур нь ухасхийсэн бол ... Тэр одоо нас барсан эцэг эхдээ атаархаж байлаа. Түүнд өөрийгөө устгах үхлийг угтан явахын тулд өөр төрлийн эр зориг шаардагдах болно. Харри хуруугаа чичирэхэд хэдийгээр энд хэн ч байхгүй хөргүүд хоосон байсан ч хүчлэн атгахыг оролдлоо.

Тэр удаанаар өндийн суугаад өөрийгөө амьдралдаа хэзээ ч байгаагүйгээр амьд биет гэдгээ мэдрэв. Тэр яагаад өмнө нь тархи, булчин цээжинд цохилох зүрхээ ийм гайхамшигтай гэдгийг ажиглаагүй юм бол ... Энэ бүхнээс юу ч үлдэхгүй ... тэднээс юу ч үлдэхгүй байх болно. Тэр удаан бөгөөд гүнзгий амьсгал авахад ам хоолой нь хуурай байлаа нүд нь ч гэсэн адил.

Дамблдорын гэрээслэл хоосон зүйл байж. Мэдээж түүний төлөвлөгөө том байсан даа. Харри ердөө л үүнийг олж харахад хэтэрхий тэнэг байсан болохоор одоо л бүх зүйлийг ойлголоо. Тэр нэг ч удаа Дамблдор түүнийг амьд үлдээхийг хүсч байсан шалтгааныг сэжиглэсэнгүй. Одоо л амьдрал нь бүх крестажыг устгахад чиглэж байсан болохыг олж харж байна. Дамблдор түүнд тэднийг устгах даалгавар өгөхөд дуулгавартайгаар зөвхөн Волдемортын амьдралын холбоосыг ч биш өөрийнхөө холбоосыг устгах ажлыг үргэлжлүүлж байж. Ямар нарийн няхуур төлөвлөгөө вэ ... илүү амь үрэгдэлгүй устгагдахаар тэмдэг тавигдсан хүү аюултай даалгаварыг биелүүлэхээр явж Волдемортоос ахин нэг цохилт авах нь байна.

Дамблдор Харрийг зайлсхийлгүй эцсээ хүртэл хүртэл явахыг мэдэж байсан болохоор энэхүү төгсгөл гэгчийн төлөө хүүтэй ойртон танилцсан биз. Тэр Волдемортоос

дутуугүй Харри хэнийг ч өөрийнхөө өмнөөс үхүүлэхгүйн тулд хүч хүрэх бүх зүйлээ хийх байсныг мэдэж байсан. Тэгтэл Фред, Люпин, Тонкс болон их танхимд амь үрэгдэн хэвтэж буй бүхэн ахин түүний нүдний өмнө босож ирэхэд агшин зуур амьсгал нь давхацлаа. Үхэл тэвчиж боломжгүй байлаа ...

Гэвч Дамблдор түүнийг хэтрүүлэн үнэлжээ. Харри даалгавараа биелүүлээгүй могой амьд хэвээр байгаа болохоор Волдеморт Харрийн үхлийн дараа ч ахин нэг крестражаар газар дэлхийтэй холбоотой үлдэх болно. Мэдээж тэр даалгавраа өөр хүнд өгч болно. Харри хэн үүнийг хийж чадах эсэх талаар бодлогоширов. Рон, Гермиона хоёр юу хийх ёстойгоо мэднэ. Дамблдор ийм учраас түүнийг найзууддаа итгэхийг хүссэн биз ... хэрвээ тэр арай эрт үнэн хувь заяатайгаа тулгарвал хэн түүний хэргийг үргэлжлүүлэх байсан бол ...

Энэ бүхэн хүйтэн цонхны гадаргуун дээр бороо шиг дуслах шиг маргашгүй үнэн бөгөөд тэр үхэх ёстой. Би үхэх ёстой. Тэр төгсөх ёстой.

Хэдийгээр тэднээс хэсэгхэн хугацааны өмнө салсан ч гэлээ Рон, Гермиона хоёр одоо түүнд алс хол байгаа юм шиг санагдав. Ямар ч салах ёс тайлбар хэрэггүй гэж шийдлээ. Энэ замд тэд түүний хамт явж чадахгүй болохоор зогсоох оролдлого нь үнэт хугацааг алдуулж болно. Тэр арван долоон насны төрсөн өдрөөр нь бэлэглэсэн алтан цаг руу харлаа. Волдемортын өгсөн цагийн хугацаанаас хэдийн хагас нь өнгөрөөд байв.

Харри босоход зүрх нь үргэсэн шувуу адил хавирга дэлдэн цохилов. Тэр эргэж харалгүй өрөөний хаалга хааж гарлаа.

Шилтгээн хоосон байв. Тэр ганцаар явахдаа өөрийгөө хэдийн үхсэн хий үзэгдэл адил мэдэрлээ. Хөргүүд урьдын адил хоосон хэвээр. Эргэн тойрон аймшигтай нам гүм ноёрхож энд үлдсэн бүхэн Их танхимд үхэгсдийнхээ араас гашуудаж байлаа.

Харри үл үзэгдэх цуваа нөмрөн доош яваад гантиг шатаар уруудан үүдний танхимд гарлаа. Магадгүй тэр бодлынхоо нэгээхэн хэсэгт хэн нэгэн түүнийг хараад зогсоогоосой гэж хүссэн ч үл үзэгдэх цув үргэлжид төгс нэвтрэшгүй байдаг болохоор довжоо руу гарлаа.

Тэгтэл тэнд Невиллтэй золтой мөргөлдчихсөнгүй. Тэр хэн нэгэнтэй шилтгээн рүү бие оруулж байв. Харри Малфой, Крэбб, Гойл нарын адил сэмхэн буцаж ирсэн Колин Кривиг хараад зүрх нь шимширлээ. Тэр хэтэрхий залуудаа үхжээ.

- Невилл юу гэдгийг нь мэдэх үү? Би түүнийг ганцаар аваад явъя гэж Оливер

Вуд хэлэв. Тэр Колиныг мөрөн дээрээ тохоод Их танхим руу явлаа.

Невилл агшин хэртэй хаалганы хүрээ налаад тоостой гарынхаа араар духаа арчив. Тэр яг л хөгшин хүн шиг адил харагдана. Тэр хэсэг амраад шатаар ахин харанхуйд гаран бусад нөхдөө эрэхээр шатаар буув.

Харри Их танхим руу харлаа. Тэнд хүмүүс цуглараад бие биеэ тайвшируулахыг хичээн уух юм өгч, хайртай нас барсан нэгнийхээ хажууд өвдөглөн сууж байсан ч Рон, Гермиона, Жинни юмуу Уизлийн хэн нэгэн түүнчлэн Полумна ч харагдсангүй.

Тэр тэднийг сүүлчийн удаа харахын тулд юугаа ч өгөхөд бэлэн байв. Гэсэн ч тэгвэл салж чадах хүч байгаа болов уу? Үгүй ээ ингэсэн нь дээр.

Тэр харанхуйд довжоо уруудан гарлаа. Ойролцоогоор өглөөний дөрвөн цаг болж шилтгээний газар нутагт нам гүм ноёрхож түүнийг даалгавараа биелүүлэхийг амьсгаа даран хүлээж байх шиг санагдана.

Харри дараагийн бие рүү тонгойж буй Невилл рүү очлоо.

- Невилл ...

- Бурхан минь Харри миний зүрх золтой л зогсчихсонгүй!

Харри үл үзэгдэх цуваа сөхөв. Түүнд гэнэтхэн нэг санаа төрсөн тул итгэлтэй байхыг хүслээ ...

- Чи хаашаа ганцаараа явж байгаа юм? гэж Невилл сэжигтэй асуув.

- Энэ төлөвлөгөөнд хэрэгтэй байгаа юм. Би нэг зүйл хийх ёстой. Сонсооч, Невилл ...

- Харри! Харри чи бууж өгөх гэж байгаа юм биш биз дээ? гэж Невилл гэнэтхэн айлаа.

- Үгүй гэж Харри хөнгөхөн худал хэлээд,

- Мэдээж үгүй ... би үүний төлөө яваагүй. Ингэхэд Невилл чи Волдемортын могойг мэдэх үү? Түүнд аварга могой байгаа ... Нагайна гэж дууддаг ... гэв.

- Тиймээ би энэ тухай сонсож байсан ... Тэгээд юу гэж?

- Түүнийг алах хэрэгтэй байгаа юм. Рон, Гермиона хоёр энэ тухай мэдэх ч гэнэтхэн ... гээд айдас зүрхийг нь базлахад цааш ярьж чадсангүй.

Гэсэн ч хэн нэгэн үргэлжлүүлэх нь чухал болохоор Харри биеэ барилаа. Дамблдор крестражуудын тухай мэдэх гурван хүн үлдэхийг мэдэж байсан. Одоо Невилл Харрийн байрыг эзэлж урьдын адил гурвуул үлдлээ.

- Хэрвээ тэд гэнэтхэн ... чадахгүй бол ... чамд боломж гарвал ...

- Могойг алах уу?

- Могойг ална гэж Харри давтлаа.

- За ойлголоо, Харри. Харин чи зүгээр үү?

- Зүгээр дээ. баярлалаа, Невилл.

Гэсэн ч тэр Харриг цааш явахад гараас нь зуураад,

- Бид нар цаашид тэмцэх болно ойлгож байгаа биз дээ, Харри? гэв.

- Тиймээ, би ... гээд дотор нь багтарахад үгээ дуусгаж чадсангүй ч Невиллийг энэ гайхуулсангүй. Тэр Харрийн мөрөн дээр алгадаад гараа авч цааш бие эрхээр одлоо.

Харри ахин цуваа нөмрөөд түргэн явав. Тэгтэл холгүйхэн газар хэвтэж байгаа бие рүү тонгойсон дүрс тааралдахад алхамын зайд очсон хойно Жинни болохыг нь танилаа.

Тэр ээжийгээ дуудан уйлах охин руу тонгойж байв.

- Зүгээр дээ бүх зүйл сайхан болно. Бид чамайг одоохон шилтгээн рүү аваачна гэж Жинни хэлэв.

- Би гэр лүүгээ явахыг хүсч байна. Би цаашид тэмцэхийг хүсэхгүй байна гэж охин шивнэлээ.

- Би мэднэ гэж Жинни шивнээд,

- Бүх зүйл сайхан болно гэв.

Харрийн хамаг бие хүйт даалаа. Тэр Жиннид энд байгаа гэдгээ хашгиран мэдэгдэж одоо хаашаа явж байгаагаа хэлэхийг хүсэв. Тэр түүнийг цааш явахыг зогсоогоод буцаж гэр лүүгээ харихыг хүсэв ...

Гэсэн ч тэр гэртээ байна. Хогвартс түүний анхны хамгийн сайхан гэр нь байлаа. Тэр

Волдеморт, Снегг болон өөр бусад хөвгүүдийн төрсөн гэр нь байсан ...

Жинни шархадсан охины дэргэд өвдөглөөд гараас нь барилаа. Харри асар их хүч чармайлт гарган цаашаа явав. Түүнд Жинни дэргэдүүр нь өнгөрөхөд эргэж харах шиг санагдсан ч нэг ч үг дуугаралгүй явлаа.

Харанхуйд Хагридын овоохой гарч ирэв. Цонхондоо гэрэлгүй байсан бөгөөд Соёот хаалганы цаана угтан чанга хуцах дуу гарсангүй. Үдэш Хагридынд зочлоход гялалзсан зэс данх зуухан дээр тавьж, аварга биетийн хоол болох жигнэмэг таваглан, том сахалтай нүүр, нялцгай өтөөр бөөлжиж буй Рон, Норбертыг аврахад тусалж буй Гермиона ...

Харри цааш хөдөлж ойн захад хүрээд зогслоо.

Мододын хоорондуур бүлэг Дементорууд байв. Тэр эндээс хүйтэн мэдрээд аюулгүй нэвтэрч чадна гэдэгтээ итгэсэнгүйн дээр Патронусаа дуудах ч хүч байсангүй. Тэр чичирэлтээ удаан тэсч чадахгүй. Энэ бол ердийн бус үхэл. Амьсгалах болгонд ногооны үнэр ханхлан хүйтэн агаар нүүр илбэх ямар гайхамшигтай юм бэ! Хүмүүс удаан жилийн турш амьдран цаг хугацаа үргүй өнгөрөөж байхад харин тэр агшин бүрээс зууралдаж байна. Тэр цааш явах ёстойгоо мэдэж байсан ч ингэх хүчгүй болжээ. Удаан хугацааны тоглоом дуусч снитч баригдан талбайг орхих цаг болж ...

Снитч ... Харри бээрсэн хуруугаараа хүзүүндээ зүүсэн хүүдийг ухан гаргалаа.

Би төгсгөл нь ирэхээр онгойлгоно.

Тэр снитчийг хараад хүндээр түргэн амьсгаадав. Одоо л удаанаар өнгөрүүлэхийг хүсч байсан цаг хугацаа хүчээ авах шиг санагдаж бүхнийг ойлголоо. Энэ бол төгсгөл нь байж. Цаг нь ирлээ.

Тэр алтан бөмбөлөгийг уруулдаа хүргээд,

- Би удахгүй үхнэ гэж шивнэлээ.

Төмөр хавхлаг нээгдэв. Харри чичирсэн гараараа жанчин дороосоо Дракогийн сабааг гаргаад,

- Люмос! гэлээ.

Снитчийн хуваагдсан төв дунд хурц ирмэгтэй хар чулуу байв. Дээр нь гандигарын саваа хөндлөн зурсан байдаг Үхсэнийг амьдруулагч чулуу. Гурвалжинг тойроод жанчыг бэлэгдсэн дүрс дугуйрана.

Ингээд л ахин Харри удаан бодолгүй бүхнийг ойлголоо. Учир нь тэднийг эргүүлэн авчрахдаа биш ... тэр удахгүй өөрөө нэгдэх гэж байна. Тэр тэднийг дуудаагүй ... тэд түүнийг дуудаж байна.

Тэр нүдээ аниаад чулууг алган дээрээ гурван удаа эргүүллээ.

Шид болсны тэмдэг болон аяархан хөдлөх хөнгөн хөлийн чимээ Хориотой ойн захад дүүрэв. Харри нүдээ нээгээд эргэн тойроноо харлаа.

Тэд хий үзэгдэл шиг ч байсангүй амьд бие шиг нягт байсангүй ч харагдаж байсан бөгөөд урьд нь тэмдэглэлийн дэвтрээс гарч байсан Реддлийг санагдуулна ... тэр ой санамжаас гаран биежсэн билээ. Тэд амьд юм шиг түүний зүг яаран ирэхдээ бүгд нөхөрсгөөр инээмсэглэж байв.

Жеймс Харрийн адил өндөртэй ажээ. Тэр нас барсан өдрийнхөө хувцастай байсан бөгөөд жигд бус арзгар үстэй, нүдний шилээ ноён Уизлийн адил хэлтгийдүүхэн тавьжээ.

Сириус өндөр үзэсгэлэнтэй Харрийн урьд харж байснаас хамаагүй залуу харагдана. Тэр уян налархай хөдөлгөөнөөр алхан ирээд гараа халаасандаа хийн инээмсэглэв.

Люпин ч гэсэн залуужин тийм ноорхой биш болоод үс нь өтгөн хар өнгөтэй болжээ. Тэр баяртайгаар байраа эзлэн зогсов.

Лилигийн инээмсэглэл бусдаас илүү тод байлаа. Тэр түүн рүү урт үсээ хаялан дөхөж очоод ногоон нүдээрээ царайг нь ахин хэзээ ч харж чадахгүй юм шиг ширтлээ.

- Чи маш зоригтой байна!

Харри үг хэлж чадсангүй. Тэр ээжийгээ нүд салгалгүй ширтэж байвал үүрд зогссон ч хамаагүй өөр юу ч хэрэггүй байлаа.

- Чи бараг байндаа хүрлээ. Жаахан л үлдэж. Бид ... бид чамаар их бахархаж байна! гэж Жеймс хэлэв.

- Энэ өвдөх үү?

Хүүхдийн гэмээр асуулт Харрийн амнаас өөрийн мэдэлгүй гарчээ.

- Үхэх үү? Үгүй огтхон ч үгүй. Түргэн хурдан унтаж байгаа юм шиг гэж Сириус хэлэв.

- Тэр ч гэсэн түргэн хийж бүхнийг дуусгахыг хүсч байгаа гэж Люпин хэлэв.

- Би та нарыг үхэхийг хүсээгүй. Та нарын хэнийг ч. Надад их харамсалтай байна ... гэж Харри хэллээ.

Тэр бусдаас илүү Люпинд хандаж гуйсан хоолойгоор ярилаа.

- Та дөнгөж сая хүүтэй болсон ... Римус надад их харамсалтай байна ...

- Надад ч гэсэн. Түүнтэй сайн танилцаж чадаагүй нь харамсалтай ... Гэхдээ тэр намайг үхсэнийг мэдэх үед ойлгоно гэж бодож байна. Би түүнд амьдрахад илүү аз жаргалтай ертөнц босгож өгөхийг хичээсэн юм.

Сэрүүхэн сэвшээ салхих ойн гүнээс салхилан Харрийн духны үсийг илбэв. Тэд түүнийг яв гэж хэлээгүй ч өөрөө шийдвэр гаргах ёстойгоо ойлголоо.

- Та нар надтай явах уу?

- Эцсээ хүртэл гэж Жеймс хэлэв.

- Тэд та нарыг харах уу?

- Бид чиний нэг хэсэг. Иймээс зөвхөн чамд л харагдана гэж Сириус хэлэв. Харри эх рүүгээ хараад,

- Надаас битгий холдоорой гэж аяархан хэлэв.

Ингээд цааш явахад Дементоруудын хүйтэн түүнд ямар ч аюул учруулсангүй бөгөөд дагалдагсдынхаа хамт Патронустай байгаа юм шиг нэвтрэн гарлаа. Тэд хамтдаа ойролцоо шахан ургаж мөчир нь сарвайсан хөгшин мододын дундуур явлаа. Харри харанхуйд цуваа чанга бариад ойн гүн рүү улам алслан одохдоо Волдемортын хаана байгааг мэдэхгүй байсан ч олно гэдэгтээ эргэлзсэнгүй. Дэргэд нь Жеймс, Сириус, Люпин, Лили нар чимээ шуугиангүй явах нь түүнд зориг зүрх нэмж хөлөө зөөн цааш явсаар байлаа.

Тэгтэл биетэйгээ хачирхалтай холбоогүй болсон шиг санагдаж гар хөл нь захирагдахаа болиод жолооч биш зорчигч болсон шиг санагдав. Үхэгсэд түүний хамтаар ой дундуур яваа нь амьд юм шиг бодит болж Рон, Гермиона, Жинни нар болон шилтгээнд бусад үлдсэн хүмүүс хий үзэгдэл шиг санагдахад амьдралынхаа төгсгөл рүү Волдемортыг угтан бүдчин алхлав ...

Пад хийх чимээ гараад шивнэлт сонсогдон хэн нэгэн дэргэд байлаа. Харри цуван дороо хөшөөд харанхуйг анирдан сонсоход эцэг, эх, Люпин, Сириус нар дэргэд нь зогслоо.

- Энд хэн нэгэн байна. Үл үзэгдэх цувтай. Гэнэтхэн байвал яана ...? гэж дэргэд нь бүдүүлэг хоолой гарав.

Ойролцоох модны дэргэд хоёр дүрс байлаа. Харри сава аных нь гэрэлд Яксли, Долохов хоёрыг танив. Тэд Харри болон эцэг эх, Сириус, Люпин нарын зүг харж байсан ч юу ч олж харсангүй.

- Би гарцаагүй сонссон доо. Амьтан юм болов уу? гэж Яксли хэлэв.

- Мулгуу Хагридын тэжээсэн зүйл биз гэж Долохов мөрөн дээгүүрээ харан хэлэв.

Яксли цагаа харлаа.

- Цаг бараг болж. Поттерт цагийн хугацаа өгсөн. Тэр ирсэнгүй.

- Харин тэр хүүг ирнэ гэдэгт итгэлтэй байсан. Уурлаж байгаа байх.

- Тэгвэл буцсан нь дээр. Цаашдын төлөвлөгөө ямар болохыг мэдье гэж Яксли хэлэв.

Тэр Долоховын хамт эргээд ойн гүн рүү буцаж явлаа. Харри тэднийг хэрэгтэй газар нь хүргэхийг ойлгоод дагалдахдаа эргэж харахад эх нь инээмсэглэж, эцэг нь урамшуулан толгой дохив.

Тэд хэдэн хормын турш явсны эцэст Харри урдаа гэрэл гарахыг гарлаа. Яксли, Долохов хоёр урьд нь аварга том аалз Арагогын амьдарч байсан ойн цоорхойд гарчээ. Түүний асар том торны үлдэгдэл модноос дүүжлээстэй хэвээр үр хүүхэд нь Үхэл залгигч нарын талд тэмцэхээр явжээ.

Талбайн голд асч буй түүдгийн гэрэл чимээгүй болгоомжтой зогсож буй Үхэл залгигчдыг гийгүүлэв. Тэдний зарим нь юүдэн, багтай байсан ч бусдынх нь царай нээлттэй байлаа. Жаахан цаахан талд нь хоёр аварга биет суугаад арсгар бул чулуу шиг хэрцгий царайтай толгойгоо хөдөлгөнө. Харри урт хумсаа хэмлэн буй Фенрир болон, уруулынхаа цусыг арчиж буй өндөр цайвар үстэй Роулыг харлаа. Люциус Малфой айсан янзтай Нарциссагийн таагүй харц руу ширтэж байв.

Бүгдийн харц бөхийн зогсоод гартаа гандигарын саваа барьсан Волдеморт руу чиглэжээ. Тэр залбирч байсан уу эсвэл бодлогоширч байсан уу ч гэлээ талбайн захад зогсоод үйл явдлыг харж буй Харрид нуугдаж тоглохоор тоолж буй хүүхэд шиг санагдав. Толгойны ард нь аварга могой Нагайна гялалзсан шидэт торонд хөөрөн эргэлдэнэ.

Долохов, Яксли хоёр тойрогт ороход Волдеморт харцаа өргөв.

- Тэр хаа ч алга эзэнтээн гэж Долохов хэлэв.

Волдемортын царайны хувирал өөрчлөгдсөнгүй ч улаан нүд нь түүдгийн гэрэлд гялсхийв. Тэр урт хуруундаа гандигарын савааг удаанаар эргүүллээ.

- Эзэнтээн гэж Беллатриса хэлэв. Тэр Волдемортын дэргэд сэгсийж маажуулсан нүүртэй зогсож байсан ч гэмтэлгүй бүтэн байлаа.

Волдеморт түүний яриаг гар өргөн зогсоохоод өөр үг хэлэлгүй хүндэтгэлтэй бишрэнгүй харав.

- Би түүнийг ирнэ гэж бодсон. Би түүнийг ирэхийг хүлээж байсан гэж

Волдеморт өндөр хүйтэн хоолойгоор хэлээд түүдгийн дөл рүү харлаа.

Бүгд чимээгүй болов. Тэд Харригаас дутуугүй айсан бололтой зүрх нь хажуугийн хүндээ дуулдахаар хүчтэй цохилж байлаа. Харри хөлөрсөн гараараа үл үзэгдэх цуван дор байгаа шидэт саваагаа тэмтэрлээ.

- Би харваас ... алдсан бололтой гэж Волдеморт хэлэв.

- Үгүй, алдаагүй.

Харри хоолойгоо айсан сонсогдуулахгүйн тулд энэ үгийг бүх хүчээ гарган аль болох чанга хэлээд түүдэг рүү урагш алхахад Үхсэнийг амьдруулагч чулуу хөшсөн гараас нь мултарч нүдний буланд эцэг эх болон, Сириус, Люпин замхран одох нь үзэгдэв. Энэ агшинд түүнд Волдемортоос өөр хэн ч чухал байсангүй. Тэд энд зөвхөн хоёулаа байлаа.

Энэ үзэгдэл гарч ирсэн шигээ түргэн алга болов. Аварга биетүүд архирч, Үхэл залгигчид үсрэн босож хашгирч, дуу алдан, инээлдэв. Волдеморт хөдөлгөөнгүй зогсоод улаан нь нүд нь ойртон ирж буй Харри руу чиглэв.

Тэгтэл хоолой сонсогдож,

- Үгүй, Харри! Үгүй! гэлээ.

Тэр эргэж харахад Хагрид ойролцоох модноос хүлээтэй байлаа. Түүний нүсэр бие найдлагагүй суллагдах оролдлого хийхэд модны орой чичирэн ганхав.

- Үгүй! Үгүй! Харри чи яагаад ...

- Чимээгүй! гэж Роул зандраад саваагаа даллан Хагридыг дуугүй болгов.

Беллатриса үсрэн босоод Волдеморт, Харри хоёр луу тэсч ядан ширтэв. Бүгд хөшөөд зөвхөн Волдемортын толгойн ар дахь могой гялалзсан дөлөнд цагираглан эргэлдэнэ.

Харри цээжиндээ цамцны дор шидэт саваагаа мэдэрсэн ч гаргах оролдого хийсэнгүй. Тэр Нагайнаг хүчирхэг шид хүрээлж байгаа болохоор саваагаа чиглүүлж амжихаас урьд арваад шившлэг ирэхийг мэдэж байв. Волдеморт, Харри хоёр хөдөлгөөнгүй зогссон хэвээр бие биенээ харснаа дараа нь тэр толгойгоо үл мэдэг гилжийлгэхэд хачирхалтай баяр хөөргүй инээмсэглэл уруулгүй аманд нь тодров.

- Харри Поттер. Амьд үлдсэн хүү гэж аяархан хэлэхэд галын дүрэлзэх чимээнд шивнэлт адил сонсогдлоо.

Үхэл залгигчид хөдөлсөнгүй. Тэд төдийгүй эргэн тойрны бүх хүн хөшин хүлээв. Хагрид мултрахыг оролдсоор, Беллатриса хүндээр амьсгалан харин Харри Жиннигийн гялалзсан нүд, уруулын амтын тухай бодлоо ...

Волдеморт цаашид юу болохыг хүлээж буй сониуч хүүхэд адил толгойгоо гилжийлгэсэн хэвээр саваагаа өргөв. Харри улаан нүд рүү харахдаа зөвхөн ганц л зүйл болох биеэ барих чадвараа алдаж айдаст дийлдэхээс өмнө бүх зүйл түргэн болохыг хүслээ ...

Тэр нимгэхэн уруул хөдлөхөд ногоон гэрэл гялсхийхийг хараад ... бүх зүйл бөхлөө.

БҮЛЭГ 35: КИНГС КРОСС

Тэр доошоо хараад нам гүмд хэвтэж байв. Гав ганцаараа байж хэн ч түүнийг харсангүй бөгөөд өөрийгөө ч тэнд байгаа гэдэгт итгэсэнгүй.

Хангалттай хугацаа өнгөрсний дараа... эсвэл ямар ч хугацаа өнгөрөөгүй юм болов уу

... түүний толгойд амьд байна гэсэн бодол орж ирэв. Учир нь тэр ямар нэг зүйлийн гадаргуу дээр хэвтэж доор нь байгаа зүйлээ мэдэрч байв.

Энэ дүгнэлтийг хийсэн даруйдаа Харри нүцгэн байна гэдгээ ухаарлаа. Тэр энд хэн ч байхгүй ичих зүйлгүй гэдэгт итгэлтэй байсан ч эвгүйцлээ. Иймээс харах чадвар нь хэвээр байгаа эсэхийг шалгахын тулд нүдээ нээгээд урьдын адил байгааг ойлгов.

Тэр урьд өмнө харж байгаагүй цайвар манан дунд хэвтэн хоосон зайд униар суунаглана. Түүний дээр нь хэвтэж байсан зүйл цагаан дулаахан хоосон байсан ч явж болохоор хатуу ажээ.

Харри өндийн суухад биед нь ямар нэг гэмтэл учраагүй байв. Тэр нүүрэндээ хүрч үзэхэд шил нь байсангүй.

Тэгтэл эргэн тойрон хүрээлсэн хоосон ахуйд ямар нэг зүйл атиралдан газар нүдэж буй мэт аяархан чимээ гарав. Чимээ өрөвдөлтэй үл мэдэг таагүй байсанд Харрид ямар нэг нууц ичгүүртэй зүйл сонсож байгаа мэт эвгүй мэдрэмж төрөв.

Тэр гэнэтхэн хувцаслахыг хүслээ.

Гэвч энэ хүслээ бодож ч амжаагүй байхад дэргэд нь хувцас гарч ирэхэд авч өмслөө. Хувцас зөөлөн цэвэр дулаахан байсан бөгөөд хамгийн ер бусын нь гэвэл энэ тухай бодох мөчид гарч иржээ ...

Харри босож эргэн тойрноо харав. Тэр магадгүй аварга том Шаардлагатай өрөөнд байгаа юм болов уу? Тэр цааш нь илүү олон зүйл олж харлаа. Дээр нарны гэрэлд бөмбөгөр шилэн адартай дээвэр гялалзана. Магадгүй энэ ордон юм болов уу? Гэвч ойролцоох манангаас дуулдах хачирхалтай нүдэх гонгинох чимээнээс бусад бүх зүйл тайван амгалан ажээ ...

Харри удаанаар эргэж харахад Хогвартсын Их танхимыг санагдуулам бөмбөгөр шилэн дээвэртэй уужим гэрэлтэй цэвэрхэн танхимд зогсч байв. Энд хов хоосон байлаа. Тэр зүйлийг эс тооцвол цор ганцаараа байна ...

Тэр одоо л чимээ шуугианы эх үүсвэрийг хараад зэвүүцэх сэтгэл төрөв. Шалан дээр сандлын доор жижигхэн нүцгэн хүүхэдтэй төстэй зулмарсан шиг шүүрхий арьстай амьтан дагжин хэвтээд хүндээр амьсгалж байв.

Харри түүнээс айлаа. Амьтан жижигхэн эмзэг байсан ч тэр дурын агшинд үсрэн холдоход бэлэн удаанаар ойртлоо. Төдхөн амьтанд гар сунган хүрч чадах болсон ч үүнийг хийх хүч хүрсэнгүйд хулчгар болохоо мэдэрлээ. Амьтаныг тайвшируулах хэрэгтэй байсан ч зэвүүцэх сэтгэл төрөв.

- Чи түүнд тусалж чадахгүй.

Тэр огцом эргэж харлаа. Түүн рүү өндөр бараан цэнхэр өнгийн хувцастай Альбус Дамблдор явж байв.

- Харри! гээд Дамблдор түүнийг эрүүл ямар ч гэмтэлгүй гараараа тэврэв.

- Гайхамшигтай хүү! Чи зоригтой, маш зоригтой эр хүн! Явцгаая.

Харри дөжирсөн юм шиг Дамблдорын араас явж гонгинож буй хүүхдээс холдон гялалзсан өндөр адрын дорх өмнө нь ажиглаагүй хоёр сандал руу очлоо. Дамблдор тэдний нэг дээр суухад Харри нөгөө дээр нь суугаад хуучин захирлынхаа нүүр лүү ширтэв. Урт мөнгөлөг үс сахал, хурц цэнхэр нүд, хагас саран нүдний шил, махигар хамар гээд л юм бүхэн түүний санаж байснаар байлаа. Ингээд ...

- Гэхдээ та чинь үхсэн шүү дээ гэж Харри хэлэв.

- Эргэлзээгүй гэж Дамблдор ажил хэрэгчээр батлав.

- Тэгвэл ... тэгвэл би ч гэсэн үхсэн гэсэн үг үү?

- Аан ... гээд Дамблор нүүр дүүрэн инээмсэглэв.

- Тиймээ энэ асуулт хэвээрээ үлдэнэ ... Ер нь бол бүхэлдээ хонгор хүү минь үгүй гэж санагдаж байна.

Тэд бие биеэ лүүгээ харахад хөгшин нүд гялбам инээмсэглэв.

- Үгүй гэнээ? хэмээн Харри асуулаа.

- Үгүй.

- Гэхдээ ... гээд Харри зөнгөөрөө духан дээрх сорвио гараараа тэмтэрч үзэхэд байсангүй. Гэхдээ би үхсэн байх ёстой ... би өөрийгөө хамгаалаагүй! Би түүнийг намайг алахыг хүссэн!

- Энэ л байхгүй юу бүх зүйл өөрчлөгдсөн гээд Дамблдор баяртайгаар гэгээ татуулан инээмсэглэхэд Харри хэзээ ч ийм жаргалтай хүн харж байсангүй.

- Тайлбарлаач гэж Харри гуйлаа.

- Гэхдээ чи хэдийн мэднэ гэж Дамблдор хуруугаа тэнийлгэн хэлэв.

- Би түүнд өөрийгөө алах боломж олгосон. Тийм биз дээ?

- Тиймээ, тэгсэн! гээд Дамблдор толгой дохив.

- Тэгэхээр түүний сүнсний надтай байсан хэсэг ...

Дамблдор эрчтэйгээр толгой дохиод цааш ярихыг урамшуулан инээмсэглэв.

- Үхсэн үү?

- Эргэлзээгүй! Тиймээ, тэр устгагдсан. Чиний сүнс одоо чамд бүрэн дүүрэн харъяалагдах болсон, Харри.

- Гэсэн ч ... гээд Харри сандал дор чичирч байгаа зэрэмдэг амьтан руу харлаа.

- Энэ юу вэ, профессор?

- Үүнд бидний хэн ч тусалж чадахгүй.

- Гэхдээ хэрвээ Волдеморт үхлийн хараал хэрэглэхэд хэн ч миний орноос үхээгүй бол би яаж амьд байх юм?

- Би чамайг мэднэ гэж бодож байна. Эргээд бод. Тэр шунахай хэрцгий сэтгэлдээ автан юу хийснийг сана.

Харри бодлогоширон эргэн тойрны орон зайг нүдээрээ гүйлгэн харав. Хэрвээ тэд үнэхээр энэ хачирхалтай ордонд суугаад дэргэд нь сандал дор амьтан атиралдаж байгаа бол. Тэгтэл хариулт дорхноо урган гарч ирлээ.

- Тэр миний цусыг авсан.

- Яг тийм! Тэр чиний цусны тусламжтай өөрийн биеэ эргэн босгосон! Чиний цус түүний судсанд байгаа, Харри. Лилигийн хамгаалалт та хоёр хоёуланд чинь байгаа! Тэр чамайг амьд байлгаж байж өөрөө амьд байна!

- Намайг амьд байхад ... тэр амьд байна гэнээ? Гэхдээ би бодохдоо ... бүх зүйл эсрэгээрээ гэж бодсон юмсан! Би бид хоёулаа үхэх ёстой гэж бодсон. Эсвэл энэ адилхан юм уу?

Түүний анхаарлыг ахин золгүй амьтны ёолох дуу татахад хяламхийн харлаа.

- Та биднийг түүнд юу ч хийж чадахгүй гэдэгт итгэлтэй байна уу?

- Энд юугаар ч тусалж чадахгүй.

- Тэгвэл илүү ихийг ... тайлбарлаач. Дамблдор инээмсэглэв.

- Чи бол түүний санаандгүй үүсгэсэн долоо дахь крестраж байсан, Харри.

Волдеморт сүнсээ тогтворгүй эмзэг болгосон болохоор ... хүүхдийг нь алахын тулд чиний эцэг эхийг алсан хэрцгийллийн үед бут үсрэн хуваагдсан. Ингээд тэр танай гэрээс бодсоноосоо ч долоон дор байдалд зугтан гарсан юм. Тэр ардаа зөвхөн биеэ орхиогүй. Тэр өөрийнхөө нэг хэсгийг амьд үлдсэн хохирогч болох чиний дотор орхисон.

- Бас түүний мэдлэг аймшигтай дутуу дулимаг гэдгээрээ ялгаатай! Тэр үнэт зүйлсийн талаар ямар ч ойлголтгүй. Гэрийн үйлчлэгч, хүүхдийн үлгэр, хайр, үнэнч сэтгэл, гэм хоргүй байдал гээд зүйлсийн талаар Волдеморт өчүүхэн төдий ч ойлголтгүй. Өчүүхэн төдий ч шүү! Тэр энэ бүхэн ямар ч шидтэй эгнэшгүй хүчийг агуулж байдгийг ойлгоогүй.

- Тэр чиний цусыг хүчирхэг болохын тулд авсан. Тэр эхийн чинь чамайг хамгаалахын төлөө үхсэн шидийн нэг хэсгийг биедээ авсан. Түүний бие амь хайрлахгүй энхүү хүчийг хадгалснаараа чиний амьд байгаа нь Волдемортын аврагдах сүүлчийн найдлага болоод байлаа гээд Дамблдор Харри руу инээмсэглэн ширтлээ.

- Та үүнийг мэдэж байсан хэрэг үү? Энэ бүх хугацаанд мэдэж байсан юм уу?

- Би зөвхөн тааварласан юм. Гэвч миний таавар ихэнхидээ таавар баталгааждаг юм гэж Дамблдор хөгжилтэй хэлэв.

Тэднийг удтал чимээгүй суухад амьтан ард нь чичигнэн гонгиносон хэвээр байлаа.

- Өөр зүйл байна. Ахин нэг асуулт. Миний саваа яагаад түүний бусдаас авсан савааг хугалсан юм бол?

- Үүнийг ч гэсэн би мэдэхгүй.

- Тэгвэл тааварла! гэж Харри гуйхад Дамблдор инээмсэглэв.

- Чи ойлгох ёстой, Харри. Лорд Волдеморт одоог хүртэл судлагдаагүй шидийн гүнд нэвтрэн орсон. Гэхдээ энэ тохиолдолд бол нэг ч саваа үйлдвэрлэгч Волдемортод тайлбар хэлж чадахгүй байсан гэж бодож байна ...

- Чиний мэдэж байгаачлан лорд Волдеморт хүний биед ороход та хоёрын дундах холбооны хүч хоёр дахин нэмэгдсэн. Гэхдээ түүний сүнсний хэсэг чиний дотор агуулагдан буй үед тэр хүч чадалтай болохыг хүсээд эхийн чинь амиа өгсөн хамгаалалтыг авсан. Гэхдээ тэр энэ шид ямар аймшигтай хүч агуулдагыг ойлгосон бол хэзээ ч чиний цусыг авч зүрхлэхгүй байлаа... Хэрвээ тэр энэ хүчийг ойлгосон бол хэзээ ч лорд Волдеморт байхгүй байж аллага хийхгүй байсан.

- Ингээд та хоёрын дунд түүхэнд ч хэзээ байгаагүй хувь заяаны холбоос үүссэн үед Волдеморт чамайг ижил зүрхтэй савааны тусламжтай довтолсон. Үүнээс ямар хачирхалтай зүйл болсны бид мэднэ. Хоёр зүрхтэй саваа Волдемортын хэзээ ч бодож байгаагүйгээр үйлчлэл үзүүлсэн ч саваа ихрүүд гэдгийг мэдээгүй.

- Тэр шөнө Волдеморт чамаас илүү их айсан, Харри. Чи үхлийг тайвнаар хүлээж үүнд бэлэн байхад түүнд хэзээ ч үүнийг хийх чадвар байгаагүй. Чамайг эр зориг ялсан учир саваа чинь улам хүчтэй болсон. Ийм учраас хоёр шидэт савааны хооронд эздийнхээ харилцааг дуурайсан зүйл болсон юм.

- Бас тэр шөнө чиний саваа Волдемортын саваанаас түүний хэсгийг агуулсан хүчний хэсгийг шингээн авсан гэж бодож байна. Иймээс саваа чамайг мөрдөн хөөх үед нэгэн зэрэг хамаатан үхлийн дайсан болгосон хүнээ таниад Люциусын саваанд хэзээ ч байгаагүй шидийн хүчийг оргилуулан гаргажээ. Чиний саваа эр зоригийг чинь болон Волдемортын үхлийн чадварыг нэгэн зэрэг багтаан агуулсан болохоор хөөрхий Люциус Малфойн саваа үүнийг яаж тэсч дийлэх билээ?

- Гэхдээ хэрвээ миний саваа тийм хүчирхэг юм бол Гермиона түүнийг яаж хугалсан болж байна?

- Хүндэт хүү минь түүний гайхамшигтай чадвар зөвхөн лорд Волдеморт шидийн гүн нууцын дагуу хор хөнөөл учруулах гэж оролдоход илэрдэг гэж бодож байна. Зөвхөн түүний эсрэг тохиолдолд ер бусын хүчийг агуулах болно. Өөр бусад үед бол энэ хамгийн жирийн саваа хэдий ч ... эргэлзээгүй маш сайн саваа хэмээн Дамблдор яриагаа элдэгээр төгсгөв.

Харри удаан хугацааны турш бодлогширон суулаа. Эсвэл магадгүй секунт юм болов уу. Ийм нөхцөлд цаг хугацаа баримжаалах гэдэг тун бэрх ажээ.

- Тэр намайг таны саваагаар алсан.

- Тэр чамайг миний саваагаар алах гээд чадаагүй гэж Дамблдор засаад,

- Бид чиний үхээгүй гэдгийг зөвшөөрсөн шиг санагдаж байна ... гэв.

- Одоо би өөрийгөө маш сайн гэж мэдэрч байна. Ингэхэд бид хаана байгаа юм бол? гээд Харри эрүүл цэвэрхэн гар луу нь харлаа.

- Тиймээ би энэ тухай чамаас асуух гэж байсан юм. Чи биднийг хаана байгаа гэж бодож байна?

Дамблдор өмнө энэ тухай асуусан бол Харри үүнийг мэдэхгүй байлаа. Гэсэн ч одоо хариулт толгойд нь бэлхэн байв.

- Харваас Кингс Кросс буудал дээр байгаа бололтой. Зөвхөн хүнгүй хоосон галт тэрэг байхгүй.

- Кингс Кросс буудал гэнээ! Бурхан минь үнэхээр гэж үү? гэж Дамблдор хөхрөв.

- Харин та биднийг хаана байна гэж бодож байна? гэж Харри яльгүй гомдон асуулаа.

- Мэдэх юм алга хүү минь. Энэ чамд тавьсан асуулт шиг санагдаж байна.

Харри юу ч ойлгосонгүй. Дамблдор ухаан солиорсон юм болов уу. Тэр түүн рүү хараад оршин буй газраасаа илүү чухал зүйлийг саналаа.

- Үхлийн шүтээн гэж Харри хэлэхэд Дамблдорын царай дахь инээмсэглэл алга болов.

- Аан тийм л дээ гэж захирал сэтгэл түгшсэн янзтай хэлэв.

- Тэгээд?

Харри түүнтэй уулзсанаас хойш энэ бүх хугацаанд анх удаагаа тайван байдлаа алдахыг харлаа. Тэр хэсэг зуур буруу хэрэг хийсэн жижигхэн хүү шиг болов.

- Чи намайг уучлана биз дээ? Намайг чамд итгээгүй явдалд уучлах уу? Чамд хэлээгүйд минь? Харри би чамайг над шиг алхам хийх вий гэхээс айсан юм. Би чамайг алдааг минь давтахаас айсан. Би чамаас өршөөл гуйж байна, Харри. Гэвч би эртнээс чамайг хамаагүй дээр гэдгийг ойлгосон л доо.

- Та юуны тухай яриад байна? гэж Харри гайхан асуухад Дамблдорын нүдэнд нулимс цийлэгнэв.

- Шүтээн, энэ шүтээнүүд. Цөхөрсөн хүний хүслэн! гэж тэр бувтнав.

- Гэхдээ тэд үнэн хэрэгтээ байдаг биз дээ!

- Тэд байдаг ч тэнэгүүдийг урхиддаг гэдгээрээ маш аюултай. Би тэдний нэг тэнэг байсан юм. Гэхдээ чи үнэнийг ойлгосон биз дээ? Надад чамаас нуух нууц үгүй болсон. Чи ойлгосон байх.

- Би юу ойлгосон гэж?

Дамблдор Харри руу эргэхэд цэнхэр нүдэнд нь нулимс гялтагнаж байлаа.

- Үхлийг эзэгнэгч Харри, үхлийг эзэгнэгч! Би эцэст нь Волдемортоос дээрдэх юм алга байгаа биз дээ?

- Мэдээж та хамаагүй илүү. Яаж ингэж хэлж болох юм бэ? Та хэзээ ч аллага хийхгүй зайлсхийх байсан!

- Энэ үнэн. Гэхдээ би үхлийг яалах арга хайсан, Харри гэж Дамблдор тайвширах арга хайж байгаа хүүхэд адил хэлэв.

- Гэхдээ Волдеморт шиг биш шүү дээ гээд Харри Дамблдорт удаан хугацааны турш уурлаж байсан ч одоо өндөр хөнхөр адрын дор сууж байхдаа хамгаалах сэтгэл төрөв.

- Шүтээн болохоос крестраж биш.

- Шүтээн. Крестраж биш. Яг тийм гэж Дамблдор бувтнав.

Нам гүм болоход тэдний ард амьтан гонгиносон хэвээр байсан ч энэ удаад Харри эргэж харсангүй.

- Гриндевальд тэднийг бас эрсэн үү? Дамблдор нүдээ буруулснаа толгой дохив.

- Энэ л биднийг бие биедээ татагдахад хүргэсэн юм. Хоёр ухаантай омог бардам хөвгүүд нэг л зүйлийн хүслэн болж байлаа. Годрикийн хонхорт түүнийг Игнотоус Певераллыг булшаас болоод ирсэн байх гэж бодож байна Тэр гурав дахь дүүгийн нас барсан газрыг судлахыг хүсч байж.

- Тэгэхээр энэ бүхэн үнэн үү? Бүгд үнэн гэж үү? Ах дүү Певералл ... гэж Харри хэлэв.

- Энэ бол ах дүү гурвын үлгэр. Тиймээ би тэднийг үхэлтэй зэлүүд зам дээр таарсан гэдэгт ... итгэдэг байсан. Гэсэн ч удалгүй ах дүү гурван Певералл онцгой авъяастай аюултай шидтэнгүүд байж эдгээр хүчирхэг зүйлийг бүтээсэн гэж бодох болсон. Харин шүтээний түүхэнд гардаг Үхэл бол зүгээр л домог юм.

- Чиний мэдэж байгаачилан үл үзэгдэх цув зууны туршид эцгээс хүүд, эхээс охинд дамжсаар эцэст нь Игнотусын адил Годрикийн хонхорт төрсөн хүнд залгамжлагдан ирсэн юм гээд Дамблдор Харри руу инээмсэглэв.

- Энэ би юу?

- Чи. Би чамайг цув яагаад эцэг эхийг чинь үхдэг шөнө надад байсныг хэдийн тааварласан гэж бодож байна. Жеймс надад үүнийг хэдхэн өдрийн өмнө үзүүлсэн. Энэ түүний сургуулийн дүрэм журмаас гадуур баригдалгүй явдгийн

учир байж! Би анх түүнийг хараад нүдэндээ ч итгээгүй Жеймсээс судлахын тулд түр өгөхийг гуйсан. Би удаан хугацааны өмнө Үхлийн шүтээнээс татгалзсан ч цув ойрхон байхад биеэ барьж чадаагүй ... Би хэзээ ч үүнтэй төстэй цув харж байгаагүй ... Маш эртний бүхий л талаараа төгс ... иймээс л би чиний эцэг үхэхэд Үхлийн хоёр шүтээний цорны ганц эзэмшигч болон үлдсэн юм даа гэж гашуудалтай хоолойгоор хэлэв.

- Цув байсан ч тэднийг аврахгүй байсан. Волдеморт ээж аав хаана нуугдаж байгааг мэдэж байсан. Цув тэднийг хараалаас хамгаалахгүй байсан.

- Юу үнэн гэвэл энэ үнэн.

Харри үргэлжлэлийг хүлээсэн ч Дамблдор чимээгүй байсан тул яаруулан,

- Тэгэхээр та цувыг харах үедээ Үхлийн шүтээнийг хайхаа больсон байсан хэрэг үү? гэв.

- Больсон байсан гэж Дамблдор сулхан хэлээд. Харрийн нүд рүү хүчлэн харж,

- Чи юу болсныг мэднэ. Гэсэн ч намайг өөрийгөө үзэн ядсанаас илүү үзэн ядаж чадахгүй гэв.

- Гэхдээ би таныг үзэн ядаагүй ...

- Тэгэх ёстой гээд Дамблдор цээж дүүрэн амьсгал авлаа.

- Чи миний дүүгийн маглуудаас болж өвдсөн нууцыг мэднэ. Бас миний хөөрхий эцэг өс хонзонгоо авсныхаа хариуд Азкабанд нас барж, эх минь Арианаг асрамжлахын тулд амьдралаа зориулсаныг мэднэ.

- Намайг энэ уурлуулсан, Харри гэж Дамблдор хэрцгий хүйтнээр хэлээд

Харрийн толгой дээгүүр хоосон орон зай руу ширтлээ.

- Би авъяаслаг хүү байж эрх чөлөө хүсч байлаа. Би гялалзахыг хүссэн. Алдар нэр гавъяа хүссэн. Гэсэн ч намайг буруугаар битгий ойлгоорой гээд царай нь ахин нас дарсан хөгшин болж,

- Би тэдэнд хайртай байсан. Би эцэг эх, эрэгтэй эмэгтэй хоёр дүүгээ хайрладаг байсан ч амиа бодсон хичнээн амиа бодсон хүн байсан болохыг минь чи төсөөлж ч чадахгүй гэв.

- Иймээс эх маань нас барж өвчтэй охин дүү болон үг сонсдоггүй эрэгтэй дүүгийнхээ хариуцлагыг аван тосгонд эргэн ирэх үед сэтгэл минь уур хилэн ганслалд автсан юм. Тэд намайг занганд оруулж амьдралыг минь сүйтгэж байх шиг санагдаж байв! Тэгтэл тэр ирсэн гээд Дамблдор ахин Харрийн нүд рүү эгцлэн ширтлээ.

- Гриндевальд. Чи түүний санаа миний урам зоригийг хичнээн хурцалсныг төсөөлж чадахгүй дээ, Харри. Маглуудыг хүчээр захирах. Шидтэнгүүдийн тусын тулд. Гриндевальд бид хоёр гялалзсан залуу хувьсгалын удирдагчид байлаа. Мэдээж надад хэдэн эргэлзэл байсан ч хоосон үгээр өөрийгөө тайвшируулсан. Энэ бүхэн аугаа их сайн сайхны төлөө бөгөөд шидтэнгүүдэд учруулсан хохирлоо зуу дахин эргүүлж төлж байгаа хэрэг байлаа. Гэхдээ би сэтгэлийн гүндээ Геллерт Гриндевальд гэж хэн болохыг ойлгож байсан уу?

Тийм гэж бодож байгаа ч би үүнийг нүдээ аниад өнгөрөөсөн. Хэрвээ бидний төлөвлөгөө бүтсэн бол бүх мөрөөдөл минь биелэх байлаа.

- Бидний бодол төлөвлөгөө Үхлийн шүтээнд чиглэж байв! Тэр бидний сэтгэл зүрхийг хэрхэн эзэмдсэн гэж бодож байна! Ялагдашгүй саваа эрх мэдэлд хүргэх

байсан! Үхсэнийг амилуулдаг чулуу ... инферналын арми үүсгэх байсан! Харин миний хувьд гэвэл үнэнээ хэлэхэд ... эцэг эхээ буцаан ирүүлж мөрөн дээр үүрсэн ачаанаасаа хөнгөрөх гэсэн юм.

- Цувны тухайд ... яагаад ч юм бид цувны тухай бараг ярилцаагүй, Харри. Бид хоёул цувгүйгээр муугүй үл үзэгдэх болж чаддаг болохоор хэн нэгнийг нуух юмуу хамгаалахад хэрэглэх байсан байх. Би хэрвээ түүнийг олдог юм бол Арианаг нуухад хэрэг болох байх гэж бодож байсан. Гэсэн ч цув биднийг анхаарлыг татсаны учир нь цуглуулыг бүрэн болгоход зайшгүй шаардлагатай байж домогт өгүүлснээр гурван зүйлийг эзэмшсэн хүн үхлийг эзэмдэн ялагдашгүй болох байлаа

- Үхлийн эзэмдэгч ялагдашгүй Гриндевальд, Дамблдор хоёр! Хоёр сарын турш ухаангүй хэрцгий мөрөөдөлдөө улайран гэр бүлээс үлдсэн хоёр дүүгээ үл хайхран орхисон.

- Харин дараа нь ... юу болсныг чи мэднэ. Бодит байдал миний бүдүүлэг бичиг үсэггүй мөртлөө гайхамшигтай дүүгээр минь дамжин ирсэн юм. Би үнэнийг нүүр лүү хэлэхэд сонсохыг хүсээгүй. Би Үхлийн шүтээнийг хайхаа больж эмзэгхэн өвчтэй дүүгээ араасаа чирэн явахыг хүсээгүй. Маргаан тэмцэлд хүрэхэд Гриндевальд өөрийгөө хянаж чадахаа больсон. Тэгтэл миний эхийн тэгж их анхаарал халамж тавьдаг байсан ... Ариана шалан дээр үхсэн хэвтэж байлаа.

Дамблдор чимээтэй санаа алдсанаа уйлав.

Харри түүн рүү гар сунгаад баяртайгаар хүрч байгаагаа мэдэрлээ. Тэр Дамблдорын гараас чанга атгахад алгуур биеэ барилаа.

- Гриндевальд юу болсныг хараад зугтсан. Тэр өөрийн эрх мэдэлд хүрч, маглуудыг тамлах төлөвлөгөө болон миний дэмжиж байсан Үхлийн шүтээний мөрөөдлөө хэрэгжүүлэхээр алга болсон. Түүнийг зугтсан хойно би дүүгээ оршуулахаар үлдээж цаашид ичгүүрийнхээ үнийг төлөхөөр уй гашуудалтай амьдарсан.

- Цаг хугацаа өнгөрсөөр. Түүний талаар янз бүрийн цуу тархан ер бусын хүчтэй саваа олж авсан гэж ярьцгааж байлаа. Тэр үед надад ид шидийн яамны сайдын суудал хэдэн удаа санал болгосон ч татгалзсан. Би эрх мэдэлд хүрч болохгүй гэдгээ мэдэж байсан.

- Гэхдээ та Фаж, Скримжер хоёроос хамаагүй дээр байна шүү дээ! гэж Харри дуу алдав.

- Чи тэгж бодож байна уу? гэж Дамблдор удаанаар хэлээд,

- Би үүнд итгэлгүй байсан. Би хар залуу байхдаа л эрх мэдэл бол миний сул тал гэдгийг ойлгосон. Энэ хэдийгээр хачирхалтай санагдаж болох ч Харри эрх

мэдэлд илүү тохирох хүн хэзээ ч түүний араас хөөцөлдөггүй юм. Надад Хогвартсад үлдсэн нь дээр байсан. Тэгээд ч муугүй багш байсан шиг санагдаж байна ...

- Та хамгийн шилдэг нь байсан!

- Чи их сайхан сэтгэлтэй юм, Харри. Гэвч намайг залуу шидтэнгүүдийг сургаж байх зуур Гриндевальд арми цуглуулж байлаа. Түүнийг надаас айж байгаа гэж ярьцгааж байв. Тийм байж болох ч би түүнээс илүү айж байсан юм.

- Үгүй дээ үхлээс биш гэж Дамблдор Харрийн асуусан харцны хариуд хэлээд,

- Түүний надад хийж чадах шидийн зүйлд биш. Бидний хүч эн тэнцүү бөгөөд магадгүй би түүнээс илүү болохоо мэдэж байсан. Би үнэнээс айсан юм. Ойлгож байна уу тэр аймшигт шөнө бидний хэн шившлэгээр дүүг минь алсныг мэдэхгүй байсан юм. Намайг хулчгар гэж нэрлэж болно ... чиний зөв, Харри. Энэ дэлхий дээр би юунаас илүү түүнийг алсан гэдгээ мэдэхээс айсан

... их зантай тэнэг байдал минь түүний амьдралыг бөхөөснийг мэдэхээс айсан юм гэв.

- Гриндевальд намайг юунаас айсныг мэдэж байсан гэж бодож байна. Би ичгүүрээс зайлсхийн түүнтэй уулзахаас дөлж байлаа. Гэсэн ч хүмүүс үхэж түүнийг даван дийлэх аргагүй болох үед эцэст нь хүч хүрэх зүйлээ хийсэн.

- Цааш нь юу болсныг чи мэднэ. Би халз тулаанд ялж саваа надад оногдсон юм.

Ингээд ахин чимээгүй боллоо. Харри Дамблдороос Арианаг хэн алсныг асуусангүй. Тэр Дамблдор энэ тухай хэлэхийг хүссэн ч мэдэхийг хүсэхгүй байв. Гэсэн ч одоо Дамблдор хэрвээ Ейналежын толинд харвал юу харагдах нь илт болов.

Тэд удтал чимээгүй суухад нурууны ард гонгинох амьтан Харрийн сэтгэлийг зовоосонгүй. Дараа нь тэр,

- Гриндевальд Водемортын савааг олоход саад болохыг оролдсон. Тэр түүнд хэзээ ч байгаагүй гэж худал хэлсэн гэв.

Дамблдор толгой дохиод өвдгөө ширтэхэд махигар хамрынх нь үзүүрт нулимс гялтагнав.

- Түүнийг сүүлчийн жилүүдээ Нурменгардын өрөөнд харуусал дунд өнгөрүүлсэн гэж ярьцгааж байсан. Үүнийг үнэн байгаасай гэж найдаж байна. Би түүнийг хийсэн зүйлдээ ичгүүр айдас мэдэрсэн гэдэгт итгэхийг хүсч байна. Гэвч магадгүй энэ худал байгаад тэр Волдемортод ... Үхлийн шүтээнийг түрүүлж эзмшихэд саад хийх гэж байсан болох юм ...

- Иймээс таны бунханг дээрэмдсэн гэж үү? Дамблдор нүдээ арчлаа.

Ахин хэсэг зуур чимээгүй байсны дараа Харри,

- Та Үхсэнийг сэргээгч чулууг ашиглахыг оролдсон гэхэд Дамблдор толгой дохилоо.

- Олон жилийн дараа би Мраксын сүйрсэн байшинд ... шүтээнийг залуу байсан үеийнхээсээ өөр шалтгаанаар хүссэн юм ... би толгойгоо гээсэн, Харри. Би түүнийг крестраж болохыг бөгжинд хараал шингэсэн байж болохыг мартсан байлаа. Би түүнийг авч хуруундаа хийхдээ одоохон Ариана, ээж, аавыгаа харж эцэст нь тэднээс уучлал гуйж чадна гэж бодсон ...

- Би ийм л тэнэг байлаа, Харри! Энэ бүх жилийн дараа юунд ч суралцсангүй.

Би Үхлийн шүтээнийг эзэмших гавъяагүй гэдгээ нэг бус удаа баталсан ч энэ сүүлчийн баталгаа нь боллоо.

- Яагаад? Энэ чинь хүний төрөлхийн зүйл шүү дээ! Та тэднийг харахыг хүссэн байна. Юу нь муу байна? гэж Харри асуулаа.

- Магадгүй саяас нэг хүн л Үхлийн шүтээнийг эзэмших чадвартай байж болох юм, Харри. Би тэднийг эзэмшиж байгаадаа өчүүхэн төдий ч бардаж гандигарын саваагаар аллага хийгээгүйгээрээ гайхуулаагүй. Би түүнийг эрх мэдэлд хүрэхийн төлөө биш бусдыг аврахын тулд ашиглаж байсан юм.

- Бас цувны тухайд бол цэвэр сонирхлоор авсан болохоор хэзээ ч надад чамд буюу эзэндээ зүтгэж байсан шиг зүтгээгүй. Харин чулууны тухайд гэвэл аль эрт ертөнцөөс одсон хүмүүсийг чиний өөрийгөө золиослохын тулд хийсэн шиг биш буцааж авчрах гэсэн юм. Чи үнэхээр Үхлийн шүтээнийг эзэмших гавъяатай.

Дамблдор Харрийн гарыг зөөлөн алгадаад инээмсэглэв. Тэр юу хийх ёстой вэ? Дамблдорт уурлах хэрэг үү?

- Тэгвэл яагаад бүгдийг ийм хэцүү болгосон юм? Дамблдор ичингүйрэн инээмсэглэв.

- Би хатагтай Грейнжер чамайг тогтоон барина гэж найдаж байлаа. Би чиний халуун толгой сэтгэл зүрхээ хөтлөх байх гэж айсан юм. Хэрвээ бүгдийг зүгээр хэлсэн бол над шиг эдгээр зүйлд буруу цагтаа буруу шалтгааны улмаас татагдах вий гэж айсан юм. Би тэд чамд жинхэнэ ёсоороо олдохыг хүссэн. Чи бол жинхэнэ үхлийг эзэмдэгч яагаад гэвэл жинхэнэ эзэмдэгч үхлээс зугтдаггүй. Тэр үхэх ёстойгоо хүлээн зөвшөөрч амьдрал үхлээс доргүй ойлгох ёстой.

- Волдеморт хэзээ ч Үхлийн шүтээний тухай мэдэж байгаагүй юу?

- Үгүй гэж бодож байна. Учир нь тэр чулууны юу болохыг крестраж болгон хувиргасан. Гэхдээ мэдсэн ч түүний сонирхлыг саваанаас бусад нь татна гэж бодохгүй байна. Түүнд үл үзэгдэх цув хэрэггүй, чулууны хувьд гэвэл хэнийг эргүүлэн авчрахыг хүсэх юм бэ? Тэр үхэгсдээс айдаг. Тэр хэнд ч хайртай байгаагүй.

- Гэхдээ та түүнийг гандигарын савааны араас хөөцөлдөж байсныг мэднэ биз дээ?

- Би түүнийг бага Литл Хэнглтонд чиний саваанд ялагдсаны дараагаас эрж эхэлсэн гэдэгт итгэлтэй байна. Тэр эхэндээ чамайг хүчтэй шид эзэмшиж гэж

айсан боловч Олливандераас хос зүрхтэй савааны тухай сонсоод бүгдийн тайлбарыг олсон шиг санагджээ. Гэсэн ч түүний бусдаас авсан саваа чинийхтэй тэмцэж чадаагүй. Тэр үед л Волдеморт чиний саваа ямар хүчтэй болон чиний ямар авъяас эзэмшсэнийг өөрөөсөө асуухын оронд юунд ч ялагдашгүй хүчтэй шидэт саваа хайж эхэлсэн юм. Гандигарын савааг эзэмшиж байж чамаас дутуугүй болох байлаа. Тэр гандигарын саваа сул талыг нь нөхөн жинхэнэ ялагдашгүй болгоно гэдэгт итгэлтэй байсан. Хөөрхий Северус ...

- Та Снеггтэй үхлээ төлөвлөж байхдаа гандигарын савааг түүнд оногдуулахыг хүссэн үү?

- Тийм бодолтой байснаа хүлээн зөвшөөрөх байна. Гэсэн ч минийхээр болсонгүй бололтой.

- Тиймээ. Таныхаар болсонгүй.

Тэдний ар дахь амьтан гонгинон ёолж байсан ч Харри, Дамблдор хоёр удтал чимээгүй суулаа. Энэ бүх хугацаанд Харри алгуур лавсан орох цас адил цаашдын алхам бүрээ төлөвлөж бодлоо.

- Харин одоо би эргэж очих ёстой юу?

- Чинийхээр л болно.

- Надад сонголт бий гэж үү?

- Мэдээж. Бид Кингс Кросс буудал дээр байгаа би дээ? Би чамайг буцаж очихыг хүсэхгүй бол галт тэргэнд сууж болно гэж хэлэх гэсэн юм.

- Тэгвэл би хаашаа очих вэ?

- Урагшаа.

Ахин чимээгүй болов.

- Гандигарын саваа Волдемортод байгаа.

- Тиймээ. Гандигарын савааг Волдеморт авсан.

- Гэхдээ та намайг буцахыг хүсч байна уу?

- Би бодохдоо хэрвээ чи буцахыг сонговол түүнийг үүрд дуусгах боломж бий гэж бодож байгаа ч амалж чадахгүй нь. Гэхдээ зөвхөн чамайг энд ирснээс илүү бага айдастай буцна гэдгийг мэдэж байна.

Харри ахин сандлын дор чичирч хахаж цацан буй улаан нялцгай амьтан руу харлаа.

- Үхсэн хүнийг өрөвдөх хэрэггүй, Харри. Хэн ч хайрладаггүй өрөвдөлтэй амьдрал. Гэхдээ чамайг буцаж очиход илүү бага сэтгэл санаа өвдөж, илүү цөөн гэр бүл хагацах болно гэдгийг итгүүлэх байна. Хэрвээ энэ чамд хангалттай санагдвал одоо бидний салах цаг болж.

Харри толгой дохисноо санаа алдав. Мэдээж эндээс Хориотой ойд буцах нь хэцүү байсан бөгөөд дулаахан гэгээлэг тухтай газраас гараад өвдөлт айдас хүлээж байлаа. Тэр босоход Дамблдор ч гэсэн босож бие биенээ удтал ширтэв.

- Надад сүүлчийн зүйлийг хэлээч. Энэ бүхэн үнэн үү? Эсвэл миний толгойд болж байна уу?

Дамблдор түүн рүү баясан инээмсэглэхэд хоолой чихэнд нь чангаран сонсогдоод дүрс нь цайвар манан дунд алга болов.

- Мэдээж энэ бүхэн чиний толгойд болж байгаа, Харри. Гэхдээ энэ бүхнийг бодит биш гэж хэн хэлэх юм бэ?

БҮЛЭГ 36: ӨӨТЭЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тэр ахин газар нүүрээ доош харуулан хэвтээд хамарт нь ойн үнэр ханхлав. Хацрынх нь дор хүйтэн хатуу газар мэдрэгдэн нүдний шил нь хэлтийж чамархай дээрээ гарчээ. Бүх бие нь янгинан өвдөж үхлийн шившлэг оносон газар төмрөөр цохиулсан мэт хөхөрсөн бололтой. Тэр унасан газраа зүүн гараа эвгүй нугалан амаа ангайстай хэвээр хөдөлгөөнгүй хэвтэв.

Тэр Үхэл залгигчдын хөөрөн хашгирах чимээ сонсогдохыг хүлээсэн ч үүний оронд яарсан алхаа түгшсэн шивнэлт сонслоо.

- Эзэнтээн ... эзэнтээн ...

Беллатрисагийн хоолой хайртдаа хандаж байгаа юм шиг сонсогдлоо. Харри нүдээ нээж зүрхэлсэнгүй байдлыг бусад мэдрэмжийнхээ тусламжтай цэгнэхийг оролдов. Саваа урьдын адил хувцсан дор нь байсан бөгөөд цээжинд нь мэдрэгдэн, гэдсэндээ хөнгөн жинтүү хийсэн мэт зөөлөн санагдах нь бусдын нүднээс нуусан үл үзэгдэх цув нь байлаа

- Эзэнтээн ...

- Хангалттай гэх Волдемортын хоолой гарлаа.

Ахин хөлийн чимээ гарч хэдэн хүн нэг зүг ухасхийв. Харри юу болсныг мэдэхийн тулд нүдээ үл мэдэг нээлээ.

Волдеморт харваас хөл дээрээ дэмнүүлэн боссон бололтой хэдэн Үхэл залгигчид яаран холдоод тойрогт нэгдэв. Зөвхөн Беллатриса явсангүй урьдын адил өвдөглөсөн хэвээр байв.

Харри ахин нүдээ аниад харсан зүйлийнхээ тухай бодлоо. Үхэл залгигчид унасан Волдемортын эргэн тойронд цугласан бололтой. Тэр Харри руу үхлийн хараал илгээхэд ямар нэг зүйл болж. Магадгүй бас Волдеморт газар унасан юм болов уу? Тэд хэсэг хугацааны турш ухаангүй хэвтэж байгаад одоо хоёул ирж ...

- Эзэнтээн, надад зөвшөөрөөч ...

- Надад тусламж хэрэггүй гэж Волдеморт хүйтнээр хэлэхэд Харри хэдийгээр хараагүй ч гэлээ Беллатриса хэрхэн тусламжын гараа сунгасныг төсөөлөн бодлоо.

- Хүү ... үхсэн үү?

Ойн цоорхойд нам гүм ноёрхов. Хэн ч түүн рүү ойртсонгүй ч олон арван нүд ширтэх нь мэдрэгдэхэд хуруу юмуу зовхи нь хөдлөхөөс айлаа.

- Чи гэж Волдеморт хэлэхэд тасхийх чимээ гарч өвдсөн хашгиралт гарав.

Түүнийг шалгаад надад үхсэн эсэхийг нь хэл.

Харри түүн рүү хэнийг илгээснийг мэдээгүй ч хөдөлгөөнгүй хэвтэхээс ондоо зам үлдсэнгүйд зүрхнийхээ цохилох чимээг сонсон хүлээв. Гэхдээ Волдеморт түүнд ойртохоос айж төлөвлөгөө бүтсэнгүй гэж сэжиглэж байгаа нь сулхан ч гэсэн тайвширал байлаа.

Харрийн нүүрэнд зөөлхөн гар хүрээд цамцан доогуур нь зүрхийг нь дарж үзэв. Тэгтэл эмэгтэй хүний түргэн амьсгал сонсогдон урт үс хацар шүргэхийг мэдэрлээ ...

- Драко амьд уу? Тэр шилтгээнд байгаа юу? гэж тэр чихэнд нь сонсдох төдий шивнэхэд урт үс нүүрэн дээр нь нөмрөн буугаад үзэгдэх орчныг хаав.

- Тиймээ гэж аяархан хэлэхэд цээжин дээр байсан гар чангаран хумсаа арьсанд нь шигтгэв. Дараа нь гар холдож эмэгтэй өндийгөөд,

- Тэр үхсэн байна! гэж Нарцисса Малфой чанга мэдэгдлээ.

Одоо л бүгд шуугьж, хөөрсөн хашгиралт гараад хөлийн чимээ түжигнэн хагас аньсан зовхин завсраар нь агаарт ёслолын улаан мөнгөлөг оч гялсхийн буудах нь үзэгдэв.

Харри урьдын адил үхсэн дүр үзүүлэн хэвтэхдээ юу болсныг ойлголоо. Нарцисса армийн тусламжтай шилтгээнд орж хүүгээ эрэхийг хүсчээ. Түүнд Волдеморт ялах эсэх нь хамаагүй байлаа.

- Та нар харсан уу? гэж Волдеморт олны чимээ шуугиан дунд хашгирав.

- Харри Поттер миний гарт үхлээ. Одоо надад аюул заналхийлэх хүн байхгүй болсон! Харцгаа! Круцио!

Харри үүнийг л хүлээж байлаа. Тэр Хориотой ойд газар хэвтэхдээ Волдеморт ялалтаа тунхаглан доромжлохыг мэдэж байв. Тэр агаарт овсхийн хөөрөөд унасан ч бодсон шиг нь өвдсөнгүй. Түүнийг хоёр гурван ч удаа агаарт хөөргөлөө. Нүдний шил нь үсрэн унаж, саваа нь хувцсан дор өнхөрсөн ч үнгэгдсэн хүүхэлдэй мэт нэвсийн унаад нэг ч булчингаа хөдөлгөсөнгүй. Түүнийг гурав дахь удаагаа газар унах үед ойн цоорхойд хөгжилтэй хашгиралт инээд цуурайтав.

- Харин одоо бид шилтгээн рүү явж баатраас нь үлдсэн зүйлийг үзүүлье. Хэн биеийг авч явах вэ? Үгүй ... Хүлээж бай ...

Шинэ хөхрөлт дэгдээд дараа нь Харри газар түсхийн чичирэхийг мэдрэв.

- Тэр чиний гарт байвал холоос үзэгдэх болохоор чи түүнийг авч яваарай. Алив жижигхэн найзыгаа ав, Хагрид. Бас шилийг нь зүүгээрэй хүү бүгдэд танигдах ёстой шүү гэж Волдеморт хэлэв.

Хэн нэгэн Харрийн шилийг хүчтэй зүүгээд том гар агаарт гайхалтай хөнгөнөөр өргөв. Тэр ойн сахиул гартаа тэврэх үед мөр нь чичигнэн уйлахыг мэдэрсэн ч ... илрэхгүйн тулд ямар нэг дохио зангаа үг хэлсэнгүй.

- Урагшаа! гэж Волдеморт тушаахад Хагрид хоорондоо шахалдан ургасан мододын дундах замаар бүдчин буцаж явлаа. Мөчир үс хувцсанд нь орооцолдон хатгуулах хэдий ч Харри нүдээ анин амаа нээлттэй хөдөлгөөнгүй

хэвтээд, эргэн тойрон Үхэл залгигчид бөөгнөрөн явж, гашуудан мэгших

Хагрид түүний гүрээний судас хэрхэн цохилохыг анзаарсангүй.

Үхэл залгигчдын араас хоёр аварга биет хөдлөхөд Харри тэдний замдаа хэрхэн мод бут хугачин явахыг сонслоо. Тэдний гаргасан чимээ шуугианаар шувууд тэнгэрт дэрхийн нисэх нь хүртэл Үхэл залгигчидыг баясан хашгиралдахад хүргэж байв. Ялан

дийлсэн жагсаал ойн зах руу чиглэхэд удалгүй Харрийн аниастай нүдний завсраар гэгээ татаж модод сийрэгжэв.

- Бейн!

Хагридын гэнэт хашгирсан явдалд Харри бараг нүдээ нээх шахлаа.

- За яасан тэмцээгүйдээ баяртай байна уу, хулчгар сүрэг морьд минь? Харри

Поттерыг а-алсанд сэтгэл хангалуун ...?

Хагрид цааш үргэлжлүүлж чадсангүй ахин нулимсандаа хутгалдахад Харри цувааг хичнээн хүн морьд харж байгааг гайхсан ч нүдээ нээж зүрхэлсэнгүй. Үхэл залгигчид хүн морьдыг ардаа орхихдоо хашгиралдаж бүдүүлэг хараал урсгаж байлаа. Удалгүй Харри цэвэр агаар мэдрэхэд ойн захад хүрснийг мэдлээ.

- Зогс!

Тэр Хагридыг тушаал биелүүлэхийн тулд ганхан зогслоо гэж бодсон ч хүйтэн агаар сэнгэнэн ойн захад харуулдаж байсан Дементоруудын сөөнгө амьсгалах нь сонсогдов. Гэсэн энэ нь одоо түүнд нөлөөлөхгүй болжээ. Түүний амьд үлдсэн явдал дотроос нь халуу шатааж сахиус шиг үйлчилж байсан болохоор эцгийнх нь мөнгөн буга зүрхэнд байгаа юм шиг байлаа.

Харрийн дэргэдүүр хэн нэгэн өнгөрөхөд хормын дараа Волдемортын шидийн чанга хоолой шилтгээний газар нутагт цуурайтан хэнгэрэгийг нь балбав.

- Харри Поттер үхсэн. Тэр зугтах оролдлогынхоо үеэр алагдсан. Та нар түүний төлөө үхэж байхад зугтаж тэр амиа аврахыг хичээж байлаа. Бид баатрыг чинь үхсэн гэдгийг итгүүлэхийн тулд биеийг нь авчирлаа. Тулаан шийдвэрлэгдсэн. Та нар дайчдынхаа хагасыг алдсан. Миний Үхэл залгигчид та нараас тоогоор илүүгийн дээр амьд үлдсэн хүү байхгүй болсон. Цаашид дайтах нь утгагүй явдал. Хэрвээ үргэлжлүүлэн тэмцэх аваас эрэгтэй, эмэгтэй хүүхэд хэн ч бай гэр бүлийнх нь гишүүдийнх нь хамтаар хүйс тэмтрэх болно. Шилтгээнээс гарч ирээд миний өмнө сөхөрвөл би та нарыг уучлая. Та нар эцэг эх, хүүхэд, ах дүүсийнхээ хамт өршөөгдөн бидний босгосон шинэ ертөнцөд хамтдаа амьдрах болно.

Шилтгээний зүг нам гүм байлаа. Волдеморт Харрид ойрхон зогсож байсан тул нүдээ нээхийг зүрхэлсэнгүй.

- Миний араас гэж Волдеморт хэлээд түрүүлж явах нь онсогдоход Хагрид араас нь дагалаа.

Харри одоо л хагас аньсан зовхиныхоо завсар Волдеморт урд нь шидийн хамгаалалтгүй болсон Нагайнаг мөрөн дээрээ тавин алхахыг харав. Гэсэн ч үүрийн харанхуйд хоёр талд нь Үхэл залгигчид алхаж байсан тул хувцсан дороос саваагаа гаргаж чадсангүй ...

- Харри ... Өө, Харри минь дээ ... Харри гэж Хагрид мэгшив.

Харри ахин нүдээ аниад шилтгээнд ойртож байгаагын тэмдэг болох Үхэл залгигчидын баясан хашгиралт дундаас Хогвартсын зүгээс ямар нэг чимээ сонсохыг хичээв.

- Зогс!

Үхэл залгигчид зогсоход Харри тэднийг хэрхэн сургуулийн нээлттэй хаалганы урд эгнэн зогсохыг сонслоо. Үүрийн ягаан гэгээ туссан болохоор зовхи нэвтлэн үүдний танхимын гэрэл харагдаж байв. Тэр хүлээлээ. Одоо л Хагридын гар дээр хэвтэж байх нь харагдсанаас үхсэн нь дээр биз.

- Үгүй!

Энэ бол цөхөрч шаналсан Харрийн зүүдэндээ ч үзэж байгаагүй аймшигт хашгиралт байсан бөгөөд профессор МакГонагалл л ийм дуу гаргах чадвартай билээ. Тэр дэргэдээ эмэгтэй хүний инээд сонсогдоход Беллатриса МакГонагаллын уй гашууд баясаж буйг ойлгов. Тэр ахин нүдээ хагас нээгээд нээлттэй хаалгаар хүмүүс гарч үүдний довжоог дүүргэн шилтгээнийг хамгаалагчид өөрийн нүдээр Харрийн үхлийг харахаар ухасхийхийг харлаа. Урд нь Нагайнагын толгойг цагаан хуруугаараа илж буй Волдеморт үзэгдэв. Тэр ахин нүдээ анив.

- Үгүй!

- Үгүй!

- Харри! Харри!

Рон, Гермиона, Жиннигийн хоолой профессор МакГонагаллын хоолойноос долоон дор байлаа. Харри хариу дуугарахыг хүссэн ч биеэ барьж хөдөлгөөнгүй хэвтлээ. Тэгтэл тэдний хашгиралт дохио мэт үйлчилж цугласан олон хашгирч Үхэл залгигчдын хараан ...

- Чимээгүй! гэж Волдеморт хашгирахад тасхийх чимээ гаран хурц гэрэл ярсхийж бүгдийг чимээгүй болов.

- Тоглоом дууссан. Түүнийг миний хөлд авчир Хагрид ... энд л түүний байх ёстой газар!

Харри ногоон дээр тавихыг нь мэдэрлээ.

- Харж байна уу? Харри Поттер үхсэн! Та нар мэхлэгдсэнээ ойлгож байна уу?

Тэр ердөө бусдыг өөрийнхөө төлөө үхэхийг шаарддаг хүү байж! гээд

Волдеморт түүний биений ардуур нь холхилоо.

- Тэр чамайг олон удаа дийлсэн! гэж Рон хашгирахад Хогвартсыг хамгаалагчид ахин түрхрэн шуугьсан ч хоёр дахь илүү хүчирхэг тасхийлт тэдний хоолойг дарлаа.

- Тэр шилтгээний нутаг дэвсгэрээс сэмхэн зугтах оролдлого хийгээд алагдсан.

Өөрийгөө аврах гээд үхсэн ... гэж Волдеморт энэ үгийн хуурамчид цэнгэн хэлсэн ч үг нь таслагдлаа.

Харри тэмцлийн чимээ хашгиралт сонсоод дараа нь ахин нэг тасхийх чимээ гарч гэрэл гялсхийхэд өвдсөндөө хашгирах дуу гарав. Тэр нүдээ үл мэдэг нээв. Хэн нэгнийг олны дундаас гаргаж Волдемортын өмнө авчрав. Харри газар дүрс унахад Волдеморт өрсөлдөгчөө зэвсэггүй болгон инээхийг харав.

- Энэ чинь хэн бэ? Хэн миний урдаас ялагдсан тэмцлээ үргэлжлүүлэхийг зүрхэлдэг билээ? аяархан могойн хоолойгоор исгэрэн асуулаа.

Беллатриса аз жаргалтайгаар инээд алдав.

- Энэ бол Невилл Долгопупс, эзэнтээн! Кэрроуд өчнөөн их төвөг удсан хүү!

Мракобореций хүү болохыг нь санаж байна уу?

- Аан тийм л дээ санаж байна гээд Волдеморт шилтгээнийг хамгаалагчид болон Үхэл залгигчдын дунд хөл дээрээ цөхрөн босохыг оролдож буй зэвсэггүй хамгаалалтгүй болсон Невиллийн дээрээс харснаа,

- Гэхдээ чи цэвэр цустай биз дээ зоригтой хүү минь? гэж урдаас нь нударга зангидан зогссон хүүд хандан хэлэв.

- Хэрвээ тийм бол юу гэж? хэмээн Невилл чанга хэлэв.

- Чи эр зоригоороо судсанд чинь нэр төртэй цус урсаж байгаа гэдгийг харууллаа. Чи үнэтэй Үхэл залгигч болно. Бидэнд яг л чам шиг хүн хэрэгтэй, Невилл Долгопупс!

- Там хөлдсөн үед л би танай талд орох байх даа! гээд Невилл,

- Дамблдорын арми! гэж хашгирахад цугласан олон хөөрөн шуугиж

Волдемортын шившлэг ч үйлчилж дийлэхгүй үймээн дэгдэв.

- Маш сайн байна гэж Волдеморт хэлэхэд Харри түүний торгомсог хоолойд хүчтэй аюул заналхийлэхийг олж сонслоо.

- Хэрвээ энэ чиний сонголт ийм бол Долгопупс бид эхний төлөвлөгөөндөө эргэж оръё. Чиний толгой унах болно.

Харри нүднийхээ завсраар Волдеморт саваагаа даллахыг харлаа. Дараагийн агшинд шилтгээний хагарсан цонхоор шувуутай төстэй нэвсгэр зүйл нисэн ирээд Волдемортын гаран дээр газардав. Тэр түүнийг шовгор оройноос нь барин сэгсрэхэд бүгдийн нүдэн дээр үнгэгдсэн Хуваарилагч бүрх малгай найгаж байв.

- Одооноос эхлээд Хогвартс сургуульд дахин хуваарилалт явагдахгүй.

Тэнхимүүд хаагдсан. Сүлд тэмдэг өнгө бүхэн миний хүндэт өвөг болох

Салазар Слизеринийх байх болно ойлгомжтой юу, Невилл Долгопупс?

Тэр саваагаа Невилл рүү чиглүүлэн хөшөөгөөд малгайг хүчээр нүдийг нь дарж өмсгөв. Шилтгээний өмнө зогссон хүмүүст хөдөлгөөн гарч эхлэхэд Үхэл залагигчид нэг хүн шиг саваагаа өргөн Хогвартсыг хамгаалагчдад хөдлөх боломж олгосонгүй.

- Невилл одоо та нарт миний урдаас эсэргүүцэн тэмцсэн тэнэгүүдэд юу тохиолдохыг үзүүлэх болно гээд Волдеморт саваагаа даллахад Хуваарилагч бүрх малгайд гал авалцан дүрсхийв.

Үүрийн гэгээг аймшигтай хашгиралт зүсэн Невилл байрандаа зогсон хөл гараа ч хөдөлгөж чадахгүй шатлаа. Харри үүнийг тэсэхгүй хөдлөх хэрэгтэй ...

Тэгтэл хэдэн зүйл нэгэн зэрэг болов.

Сургуулийн хилээс олон зуун хүмүүс үл үзэгдэх хана болон зогсож буй мэт чимээ шуугиан гараад дайны уриа цуурайтав. Тэр агшинд шилтгээний булангаас Грохх гарч ирээд «ХАГГЕР!» гэж орилов. Түүнд Волдемортын аварга биетүүд хүрхрэн хариулаад дайны заан шиг газар нүргэлүүлэн гүйлээ. Дараа нь туурайн цавчих болон хөвч нумрах чимээ гараад гэнэтхэн Үхэл залгигчид руу суман мөндөр буухад Волдемортын хүмүүс хашгиралдан эгнээгээ алдлаа. Харри хувцсан дороос үл үзэгдэх цуваа аваад нөмөрч хөл дээрээ үсрэн бостол ... Невилл ч гэсэн хөдлөв.

Тэр түргэн бөгөөд ажиглагдамгүй хөдөлгөөнөөр бие хөшөөх шившлэгээс мултраад галтай малгайг толгойноосоо авч дотроос нь ямар нэг гялалзсан мөнгөлөг бадмааараг бариултай зүйл гаргаж ирлээ ...

Мөнгөлөг ир исгэрэх чимээ олны үймээн, аварга биетүүдийн зодоон, хүн морьдын туурайн чимээнд сонсогдоогүй ч бүгдийн нүд гялалзсан илд рүү чиглэв. Невилл ганц цохилтоор аварга могойн толгойг таслахад агаарт өндөр хөөрөөд үүдний танхимийн гэрэлд уналаа. Волдемортын амнаас уур хилэнтэй хашгиралт гарсан ч могойн бие хөлд нь лүгхийн унасан тул хэн ч сонссонгүй.

Харри үл үзэгдэх цуван дор нуугдсан хэвээр Невилл, Волдеморт хоёрын дунд Бамбай шившлэг босгон хамгааллаа. Тэгтэл энэ бүх хашгиралт, шуугиан, зодоон, туурайн чимээг даран Хагридын дуу хадав.

- Харри! Харри! Харри хаана байна?

Үймээн самуун дэгдэв. Хүн морьдын сум Үхэл залгигчдын зүг тусахад сарнин зугтаж хаанаас ирсэн нь мэдэгдэхгүй нэмэлт хүч ирлээ. Харри том далавчтай амьтад Волдемортын аварга биетүүдийн толгой дээгүүр хөөрөхийг харлаа. Фестралууд болон гиппогриф Клювокрыл аварга биетүүдийн нүдийг сохлон маажихад, Грохх тэднийг нударгаараа балбав. Хогвартсыг хамгаалагчид болон Үхэл залгигчид адилхан шилтгээн рүү ухарлаа. Харри хараандаа өртсөн Үхэл залгигч бүр рүү шившлэг илгээхэд тэд цохилт хаанаас ирснийг ойлголгүй унаад олны хөлд гишгэгдэж байв.

Харри үл үзэгдэх цуван дор нуугдсан хэвээр Үүдний танхимд нэвтрэн орж Волдемортыг хайгаад Хар лорд Их танхимын нөгөө өнцөгт шидэт саваанаасаа баруун зүүнгүй шившлэг илгээн дагалдагч нартаа хашгиран тушаал өгч байхыг

харлаа. Харри ахин Волдемортын чиглүүлсэн хохирогчид болох Их танхим руу шурган орж буй Симус Финниган, Ханна Аббот нарын дунд Бамбай шид босгон хаав.

Довжоогоор улам их хүмүүс гүйлдэн орж ирэхэд Чарли Уизли, маргад ногоон өнгийн халатттай Гораций Слизнортыг гүйцэхийг харав. Тэд найз нөхөд болон Хогвартсыг хамгаалан үлдсэн сурагчдын төрөл төрөгсдөөс бүрдсэн армийг толгойлон ирсэн бололтой араас нь Хогсмидын мухлагын эзэд дагалджээ. Хүн морь Бейн, Ронан, Магориан нар үүдний танхимд туурайгаа чанга цавчилан орж ирэхэд Харрийн нурууны ард гал зуух руу хөтөлдөг хаалга нээгдэв.

Хогвартсын гэрийн үйлчлэгчид үүдний танхимд түрхрэн орж ирээд чанга хашгиран махны хутга заазуур эргэлдүүлэв. Тэднийг Регулус Блэкийн зүүлтийг энгэртээ зүүсэн Кикимер толгойлж байсан бөгөөд сөөнгө хоолой нь эндхийн чимээ шуугианд сонсогдохоор байлаа.

- Бүгд тулаанд! Тулаанд! Гэрийн үйлчлэгчдийг хамгаалагч миний эзний төлөө тулалд! Эрэлхэг Регулусын нэрийн өмнөөс Хар лордын эсрэг тэмц! Тулаанд!

Тэд жижигхэн нүүрэндээ хорсол хилэн тодруулан Үхэл залгигчдын шагай руу хутгаар чичиж хатгалаа. Хаашаа ч харсан Үхэл залгигчид эсрэг талынхандаа дийлэн ухарч, хаа сайгүй шившлэгэнд оногдон, хүн морьдын суманд өртөж, хөл рүү нь үйлчлэгч нар чичихэд зугтахыг оролдсон ч өөр бусад ирсэн хүмүүсийн давалгаанд залгигдав.

Гэсэн ч тулаан дууссангүй Харри тэмцлийн дундуур явсаар эцэст нь Их танхимд хүрлээ.

Волдеморт тулааны хамгийн гүнд байж уур хилэнд нь замд нь тааралдсан бүхэн өртөж байв. Харри тэмцэгчдийн дундуур үл үзэгдэх цувтай шууд ойртож чадсангүй. Их танхимд хөл дээрээ зогсож чадах бүхэн орж ирсэн учир улам зайгүй болжээ.

Тэр Жорж, Ли Жордан хоёр хэрхэн Якслиг унагаж, Долохов Флитвикийн шивлэгт өртөн, Хагрид өрөөн дундуур Уолден Макнейрийг чулуудахад эсрэг талын хана мөргөн газар ухаангүй унахыг нь харлаа. Бас Рон, Невилл хоёр Фенрир Сивыйг хөл дээрээс нь унагаж, Аберфорт Руквудыг Хөшөөх шившлэгээр онон, Артур Перси хоёр Тикнессийг дийлж, Люциус Нарцисса Малфой олны үймээн самуун дундуур хүүгээ дуудан хайж гүйхийг харлаа.

Волдеморт нэгэн зэрэг МакГонагалл, Слизнорт, Кингсли нартай тулалдаж байв. Тэд түүний хүйтэн үзэн ядалттай царайтай тулгараад шийдэмгий цохилт өгч чадахгүй байв.

Беллатриса Волдемортоос хэдхэн алхамын зайд тэмцлээ үргэлжлүүлнэ. Тэр эзэн шигээ ганцаараа гурвын эсрэг байсан бөгөөд Гермиона, Жинни, Полумна нар бүх хүчээ гаргасан ч дийлж чадсангүй. Харри үхлийн шившлэг Жиннигээс инчийн зайд зөрөн өнгөрөхийг хараад зүгээ өөрчлөн Волдемортын оронд Беллтариса руу чиглэв. Гэсэн ч түүнийг алхам хийж амжихаас урьтаж хажуугаас нь хүн түлхлээ.

- Мминий охинд бүү хүр, бусар амьтан минь!

Хатагтай Уизли гүйх зууpаа жанчаа хойшлуулан гараа чөлөөлөхөд Беллатриса онцом эргэн шинэ өрсөлдөгчөө хөхрөн угтлаа.

- Замаас холд! гэж хатагтай Уизли гурван охинд хашгираад саваагаа гарган тулаанд орлоо. Харри айдас хөөрөлд автан Молли Уизлийн гарт саваа шавхуурдан эргэхэд Беллатриса Лестрейнжийн царайнаас инээмсэглэл алга болж хорсолтой үрчийхийг харлаа. Хоёр саваанаас оч нисэлдэн шидтэнүүдийн хөл дорхи газар цуураад хоёул амьдралын төлөө биш үхлийн төлөө тулалдлаа.

- Үгүй! Холдоцгоо! Эндээс холд! Тэр минийх! гэж хатагтай Уизли туслахаар ухасхийсэн сурагчдад хашгирав.

Зуугаад үзэгчид хана налан зогсоод хоёр хэсэг тулаан болох Волдеморт гурван өрсөлдөгчийнхөө эсрэг болон, Белтлатриса Молллитой үзэлцэхийг ширтэхэд Харри үл үзэгдэх цуван дор Хар лорд руу дайрах болон хатагтай Уизлиг хамгаалах эсэхээ мэдэлгүй хөшлөө.

- Хэрвээ би чамайг алвал хүүхдүүдэд чинь юу тохиолдох бол? Ээж нь Фреддигийн араас явбал яах бол? гэж эзэн шигээ ухаангүй болсон Беллатриса Моллигийн илгээсэн шившлэгээс булталн бүжиглэх зууpаа даажигнав.

- Чи ... хэзээ ч ... манай ... хүүхдүүдэд ... хүрэхгүй! гэж хатагтай Уизли хашгирав.

Беллатриса үеэл Сириусээ хөшигний ар тал руу унаж байсан үеийнх шигээ хөгжилтэйгээр инээд алдахад ... Харри гэнэтхэн түүнээс урьд юу болсныг ойлголоо.

Моллигийн илгээсэн шившлэг Беллатрисагын сунгасан гаран доогуур цээж рүү нь зүрхэн тушаа газар онолоо.

Беллатрисагийн хорсолтой инээмсэглэл уруул дээрээс нь алга болоод нүд нь томров. Тэр агшин зуур юу болсныг ойлгоод дараа нь алгуурхан арагшаа унахад Волдеморт хашгирч үзэгчид шуугилдав.

Харри удаашруулсан кино зураг харж байгаа юм шиг МакГонагалл, Кингсли, Слизнорт гурав агаарт хатсан навч шиг хийсэхийг харлаа. Волдеморт хамгийн шилдэг туслагч нь унасан явдалд уурсан саваагаа өргөөд Молли Уизли руу чиглүүлэв.

- Протего! гэж Харри хашгирав.

Бамбай шид Их танхимын дунд дэлгэгдэн Волдеморт түүнийг илгээсэн хүнийг хайн харахад Харри эцэст нь үл үзэгдэх цуваа тайлав.

Гайхсан дуу алдалт, угтсан хашгиралт тал бүр сонсогдсоноо «Харри!», «Тэр амьд байна!» агшин зуур бөхөв. Цугласан олон Волдеморт, Харри хоёр урдаасаа харан зогсоод зэрэг тойрог хөдөлж эхлэхэд айсандаа нам гүм болов.

- Надад хэн ч туслах хэрэггүй. Тэгэх хэрэгтэй байгаа юм. Үүнийг би хийх хэрэгтэй байгаа юм гэж Харри хэлэхэд түүний хоолой нам гүм танхимд бүрээн дуу адил сонсогдлоо.

Волдеморт исгэрснээ улаан нүдээ томруулав.

- Поттер энэ чинь тоглоом уу. Түүний хэв маяг биш л байна даа. Хэн өнөөдөр чамайг бамбайгаар хамгаалсан бэ, Поттер?

- Хэн ч биш. Крестражууд байхгүй болсон. Зөвхөн чи бид хоёр үлдлээ. Бидний нэг нь нөгөөгөө амьд байхад амьдрах боломжгүй болохоор аль нэг нь үүрд явах ёстой ...

- Бидний нэг гэнээ? хэмээн Волдеморт шоолонгуй давтаад бүх бие нь чангаран улаан нүд нь дайралт хийх гэж байгаа могой шиг хөдөлгөөнгүй болов.

- Чи энэ юу болохыг ойлгож байна уу Дамблдорын санаандгүй амьд үлдсэн утсан хүүхэлдэй минь?

- Чи миний эх намайг аврахын төлөө үхсэнийг санаандгүй явдал гэж бодож байна уу? гэж Харри асуулаа. Тэд урьдын адил хоорондын зайгаа хадгалан тойрог хөдөлж байсан бөгөөд Харри одоо зөвхөн Волдемортын нүүрийг л харж байв.

- Чи намайг санамсаргүй тохиолдлоор оршуулгын газар тулалдахаар шийдсэн гэх нь үү? Санамсаргүй тохиолдлоор өөрийгөө хамгаалаагүй байж амьд үлдэн тулаанд эргэн ирсэн гэх нь үү?

- Санамсаргүй явдал! гэж Волдеморт хашгирсан ч цохилт илгээсэнгүй. Их танхимд байсан зуугаад хүмүүс бүгд амьсгаа даран хөшөөд зөвхөн энэ хоёр л амьсгалж байх шиг санагдана.

- Санаандгүй тохиолдлоор чиний ард нь нуугдан үлдсэн эрэгтэй эмэгтэй хэнийг ч байсан чамтай хамт ална!

- Өнөөдөр чи хэнийг ч алахгүй гэж Харри тэднийг бие биенээ ширтэн үргэлжлүүлэн эргэлдэхэд хэлээд,

- Чи ахин хэзээ ч хэнийг ч алахгүй. Ойлгов уу? Би чамайг энэ хүмүүсийг зовоохоо болихын тулд үхэхэд бэлэн байсан ... гэв.

- Гэвч үхсэнгүй!

- Би үүнд хангалтай бэлэн байсан. Би эх шигээ зүйл хийсэн. Тэд чамаас хамгаалагдсан. Чи тэднийг хэрхэн шившлэгээс чинь хөнгөн бултахыг хараагүй гэж үү? Чи тэднийг зовоож чадахгүй. Чи тэдэнд хүрч чадахгүй. Алдаанаасаа суралцах болоогүй юу, Реддл?

- Чи зүрхэлнэ ...

- Тиймээ зүрхэлж байна. Би чиний мэдэхгүй олон зүйлийг мэднэ, Том Реддл.

Би чиний чухал биш гэж тооцдог маш олон чухал зүйлсийг мэднэ. Хүсвэл чамайг ахин том алдаа хийхээс өмнө заримаас нь ярьж өгдөг юм бил үү?

Волдеморт юу ч хэлэлгүй тойрог эргэлдсэн хэвээр байсан ч Харри түүний цохилтоос нь яаж булталсан сүүлчийн нууцыг мэдэхийг хүсч буйг ойлгов ...

- Яасан ахиад л хайр уу? гэж Волдеморт могойн царайдаа шоолонгуй өнгө тодруулан хэлээд,

- Хайр Дамблдорын мөнхийн хэлдэг үг байсан. Тэр үүнийг үхлийг ялж чадна гэж баталдаг байсан. Гэсэн ч хайр түүнийг цамхагийн орой дээрээс хүүхэлдэй шиг нисэхэд саад болоогүй. Хайр надад чиний бохир цустай ээжийг жоом шиг няцлахад саад болоогүй, Поттер. Тэгээд ч энд чиний урдуур шившлэг угтан ухасхийх хайртай хүн байхгүй. Намайг чамд цохилт өгөн алахад юу саад болох юм бэ? гэв.

- Нэг л зүйл гээд Харри үргэлжүүлэн тойрог эргэлдэхдээ сүүлчийн нууцаа хэлсэнгүй.

- Хэрвээ хайр чамайг энэ удаад аврахгүй бол чи миний мэдэхгүй шид юмуу илүү хүчирхэг зэвсэг эзэмшсэн гэж бодож байгаа хэрэг үү?

- Хоёуланг нь гэж Харри хэлээд түүний могойн царайд цочирдсон айдас зурсхийснээ өмнөх шигээ болон хувирахыг харав.

Волдеморт хөхөрч эхлэхэд аймшигтай хашгиралт шиг сонсогдон чимээгүй танхимд цуурайтлаа.

- Чи миний мэдэхгүй шидийг мэднэ гэж бодоо юу? Лорд Волдемортын мэдэхгүй Дамблдорын зүүдэндээ үзэж ч байгаагүй шидийг үү?

- Мэдээж тэр зүүдэлж олон зүйлийг мэдэж байсан ч чам шиг зүйл хийгээгүй.

- Чи түүнийг сул дорой гэж хэлэхийг хүсээ юу! Түүнд биш надад харъяалагдсан зүйлийг авахад хэтэрхий сул дорой!

- Үгүй тэр чамаас ухаантай байсан. Хамгийн шилдэг шидтэн, хамаагүй дээр хүн байсан.

- Би Альбус Дамблдорыг үхлийг зохион байгуулсан!

- Энэ чамд л тэгж санагдаж байгаа юм. Гэхдээ чи алдаж байна.

- Дамблдор үхсэн! гэж Волдеморт Харрийн царайд тэсэлгүй өвдөлт харахаар найдан хэлээд,

- Тэр шилтгээний дэргэдэх гантиг бунханд бий. Би түүнийг харсан Поттер түүнд эргэж ирэх боломж байхгүй болсон! гэв.

- Тиймээ Дамблдор үхсэн гэж Харри тайван хэлээд,

- Гэхдээ чи түүнийг алаагүй. Тэр олон сарын өмнө үхлээ өөрөө сонгож чиний зарц гэж боддог хүнтэй нарийвчлан төлөвлөсөн гэв.

- Энэ чинь бас юу гээчийн хүүхдийн үлгэр вэ? гэж Волдеморт асуусан ч өмнөхийн адил цохилт илгээлгүй Харрийн нүүрнээс улаан нүдээ салгалгүй харлаа.

- Северус Снегг чамд зүтгэдэггүй байсан. Тэр миний эхийг ангуучилж эхэлсэн цагаас чинь хойш Дамблдорын талд орсон. Харин чи үүнийг хэзээ ч ажиглаагүй болохоор юу ч ойлгоогүй. Ингэхэд чи хэзээ нэгэн цагт Снегг Патронусаа дуудаж байхыг харж байсан уу?

Волдеморт хариулсангүй. Тэд бие биеэ тасчин хаях гэж байгаа чоно шиг дугуйран эргэлдлээ.

- Снеггийн Патронус согоо миний эхнийх шиг согоо байсан. Яагаад гэвэл тэр түүнийг хүүхэд байсаа эхлэн бүхий л амьдралдаа хайрлаж ирсэн. Чи тааварлаж болох байж. Тэр чамаас түүнийг өршөөхийг гуйгаагүй гэж үү? хэмээн Харри Волдемортын хамар сарталзахыг харан асуулаа.

- Тэр түүнийг хүссэн тэгээд л тэр гэж Волдеморт шоолонгуй хэлэв.

- Тэгээд түүнийг байхгүй болох үед миний талд орохыг зөвшөөрч өөр илүү цэвэр цусны илүү хүндэтгэлтэй эмэгтэйг ...

- Тэр чамд зөвшөөрөх шиг санагдсан. Гэвч чи түүнийг сүрдүүлж эхэлсэн цагаас хойш Дамблдорын тагнуул байж эсрэг талд чинь ажиллаж байсан! Дамблдорыг хэдийн үхэж байх үед Снегг дуусгасан юм!

- Ямар ялгаа байна! гэж Волдеморт үг бүрийг шунамхайран сонссон хойноо ухаангүй хөхрөн хэлээд,

- Снегг Дамблдорт юмуу надад зүтгэж байсан нь ямар ялгаа байна. Эсвэл тэд миний замд энэ өчүүхэн зүйлээр саад болохыг хүсээ юу! Би тэднийг Снеггийн агуу их хайр байсан эх шиг чинь шиг няц дарсан. Харин чи үүнийг ойлгохгүй байна! гэв.

- Дамблдор надад гандигарын сабааг өгөхгүйг оролдсон! Тэр түүний жинхэнэ эзэн Снегг болгохыг хүссэн! Гэвч би чамаас урьтсан, хүү минь ... Би сабаанд чамаас түрүүнд хүрч гартаа оруулсан. Би үнэнийг чамаас урьд ойлгосон. Гурван цагийн өмнө би Северус Снеггийг алсан болохоор одоо Гандигарын сабаа, Үхлийн сабаа, Хувь заяаны сабаа надад үнэнчээр зүтгэх болно! Дамблдорын төлөвлөгөө бүтсэнгүй, Харри Поттер!

- Тиймээ, бүтсэнгүй. Чиний зөв. Гэхдээ чамд намайг алахыг оролдохоос урьд хийх гэж зүйлийнхээ тухай бодохыг зөвлөх байна ... Гэмшихээсээ өмнө энэ тухай жаахан бодоод үз, Реддл ...

- Чи юуны тухай ярианд байна?

Энэ бүх хугацаанд Харрийн хэлсэн үг дундаас Волдемортыг энэ үг шиг цочирдуулсан зүйл байсангүй. Түүний хүүхэн хараа зураас болон нүдний эргэн тойрны арьс цайрлаа.

- Энэ чиний сүүлчийн боломж. Чамд үлдсэн бүх зүйл ... зоригтой бай ... гэмших гээд үз ...

- Чи зүрхэлнэ ...? хэмээн Волдеморт ахин хэлэв.

- Тиймээ би зүрхэлж байна. Учир нь Дамблдорын сүүлчийн төлөвлөгөө намайг цохиход биш байсан юм. Тэр чамайг цохиход байсан, Реддл.

Волдемортын гандигарын саваа барьсан гар чичирлээ. Харри Дракогын сабааг чанга атгаад одоо хэдхэн агшин үлдсэн гэдгийг ойлгож байв.

- Энэ саваа чамайг сонсохгүй байгаагийн учир нь чи буруу хүнээ алсан.

Северус Снегг хэзээ ч гандигарын сабааны жинхэнэ эзэн байгаагүй. Тэр хэзээ ч Дамблдорыг тэмцэлд дийлээгүй.

- Тэр алсан ...

- Чи миний юу ярьж байгааг ойлгож байна уу? Снегг Дамблдорыг дийлээгүй!

Дамблдорын үхэл тэдний хоорондтөлөвлөгдсөн зүйл байсан! Дамблдор гандигарын савааны жинхэнэ эзэн үхэхийг хүссэн! Хэрвээ түүний төлөвлөгөө биелсэн бол савааны хүч түүнтэй цуг бөхөн хэнд ч оногдохгүй байсан!

- Тэгсэн ч Поттер Дамблдор сабааг надад өөрөө өгсөн! гэж Волдеморт хөөрөн хэлээд,

- Би сабааг сүүлчийн эзнийх нь бунхнаас авсан! Эзнийх нь хүслийн эсрэг!

Иймээс савааны хүч надад харъяалагдана! гэв.

- Үгүй Реддл тэр чамд харъяалагдахгүй. Зөвхөн сабааг эзэмших нь хангалтгүй!

Чи түүнийг гартаа атгаж тушаал өгөх юм бол жинхэнээсээ зүтгэхгүй. Чи Олливандерын хэлснийг сонсоогүй гэж үү? Саваа эзнээ сонгодог ... Гандигарын саваа Дамбдлорыг үхэхээс өмнө түүнийг эзэмдсэнээ мэдээгүй шинэ хүний гарт очсон. Шинэ эзэн Дамблдорын сабааг түүний хүслийн эсрэг авахдаа юу хийснээ болон ертөнц дээр хамгийн аюултай саваа эзэмшиж байгаагаа ойлгоогүй ...

Волдемортын цээж түнхэлзэн амьсгаадахад Харри дотроос нь саваа урган нүүр өөд нь чиглүүлсэн адил зүйл мэдэрлээ.

- Гандигарын савааны жинхэнэ эзэн Драко Малфой байсан. Волдемортын нүдэнд илэрсэн айдас хоромхон зуур алга болов.

- Гэхдээ тийм байсан ч чухал гэж үү? Хэрвээ чиний зөв байсан ч бидний хоорондох зүйл өөрчлөгдөхгүй? Галт шувууны өдтэй саваа чамд байхгүй болсон. Бидний халз тулаан цэвэр чадварынх байх болно ... Би чамайг алаад дараа нь Драко Малфойтой өөрөө учраа олно ...

- Чи хоцорсон. Чи өөрийн боломжоо алдсан. Би чамаас урьтсан. Олон долоо хоногийн өмнө би Драког ялж түүний шидэт сабааг авсан гээд Харри саваагаа даллахдаа танхимд байсан хүн бүрийн нүд түүн рүү чиглэхийг мэдэрлээ.

- Тэгэхээр бүгдийн учир нэг л зүйлд байна. Чиний гарт байгаа гандигарын саваа сүүлчийн эзэн нь зэвсэггүй болгох шившлэгээр өөрийн болгосныг мэдэж байгаа. Хэрвээ тэр намайг ... савааны жинхэнэ эзэн гэж мэдэх юм бол.

Алтлаг улаан оч гэнэтхэн шидэт адарт гийн нарны нүд гялбам туяа ойролцоох цонхоор туслаа. Гэрэл тэдний нүдэнд гялсхийхэд Волдемортын царай толбо болон бүүдгэртэж Харри өндөр хашгиралт сонсоод Дракогын сабааг даллан хашгирлаа.

- Авада Кедавра!

- Экспеллиармус!

Үхэр буу буудах адил нүргэлэх чимээ гарахад тэдний тойргийн голд шившлэг мөргөлдсөн хэсэгт алтлаг дөл хуйлран эргэлдэв. Харри Волдемортын ногоон оч түүнийхтэй тулгараад Гандигарын саваа нарны гэрэлтэй шидэт адарт Нагайнагын толгой шиг эргэлдэн эзэн рүүгээ нисэхийг харав. Харри бэлтгэгдсэн баригч болохоор

түүнийг сул гараараа барих агшинд Волдеморт арагш гараа дэлгэн унаад нарийхан хүүхэн хараатай улаан нүд нь анилаа. Шалан дээр үхсэн Том Реддлээс үлдсэн зүйл болох сул дорой үрчгэр бие, зэвсэггүй болсон цагаан хоосон гар, могойн царай адил гөлийсөн нүүр үлдэв. Волдеморт өөрийнхөө эргэж ойсон шившлэгэнд өртөн үхэхэд Харри хоёр гартаа шидэт саваа барин зогсоод дайсныхаа бие рүү харлаа.

Хэсэг зуур нам гүм болов. Дараа нь танхимд хөөрөн шуугиж, хашгиран, дуу алдан, ёолох чимээ хадав. Нарны нүд гялбам туяа цонхоор гийгүүлэхэд бүгд Харрийн зүг ухасхийсэн ч Рон, Гермиона хоёр түрүүлж хүрэн тэвэрч чанга хоолой чихийг нь дүүргэв. Тэгтэл нь Жинни, Невилл, Полумна нар ирээд дараа нь Уизлийн бүх гэр бүл, Хагрид, Кингсли, МакГонагалл, Флитвик, Сетбль нар ирэхэд бүгд түүн рүү зэрэг хашгирч байсан учир Харри нэг ч үг ойлгож чадалгүй, хэний гар тэвэрч түлхэж татаж байгааг ч мэдэлгүй зуугаад хүмүүс шахцалдан бүх зүйл эцэстээ дууссанд амьд үлдсэн хүүд талархаар зүтгэлэв.

Нар Хогвартсын дээр хөөрөн мандахад Их танхимд амьдралын өнгө дүүрэв. Харри хөөрсөн, гашуудсан, баярласан гээд бүхий л зүйлд оролцох шаардлагатай байлаа. Бүгд түүний удирдагч аврагчаа гэж үзэн хэний ч толгойд аймшигтай ядарч унтахыг хүсч байгаа гэж орсонгүй. Тэр нас барсан хүмүсийн ар гэрийнхтэй ярилцан, гарыг нь атгаж нулимсыг нь тайвшируулан, хариу талархал хэлж, бүтэн бүлэг шинэ мэдээ болох орон даяар Империус шившлэгт өрстөн хүмүүс сэрж, Үхэл залгигчид зугтах юмуу баривчлагдан, гэмгүй хүмүүсийг Азкабанаас суллаж, Кингсли Бруствер энэ үеэс ид шидийн яамны сайдын үүрэг хүлээх болсон тухай сонслоо ...

Волдемортын биеийг Их танхимаас гаргаж Фред, Тонкс, Люпин, Колин Криви болон өөр бусад тавин амь үрэгдсэн хүнийхээс холдуулав. МакГонагалл тэнхимийн ширээнүүдийг буцаан тавиад багш нар, сурагчид, хий үзэгдэл, эцэг эхчүүд, хүн морьд, гэрийн үйлчлэгч нар холилдон суулаа. Эдгэрсэн Флоренц буланд хэвтээд, Грохохын хагарсан цонхоор цухуйх том нүүрэнд хүмүүс аманд нь хоол зөөн хийж байлаа. Эцэст нь зовж зүдэрч нимбэг шиг шахагдсан Харри Полумнагийн дэргэд суув.

- Хэрвээ би чиний оронд байсан бол одоо тайван чимээгүй суухыг хүсэх байсан даа гэж тэр хэлэв.

- Үүнийг чинь л мөрөөдөж байна гэж Харри бувтнав.

- Би тэднийг сатаарууллъя харин чи цуваа нөмрөөрэй гээд Полумна өөр үг хэлэхийн завдалгүй цонх руу заан,

- Хөөе, хараач үрчгэр эвэрт гэж хашгирлаа.

Ойролцоо суусан бүх хүмүүс эргэн харахад Харри эсрэгээрээ үл үзэгдэх цув нөмөрч суудлаасаа өндийв.

Тэр одоо л танхим дундуур тайван явж чадах болж. Жинни түүнээс хоёр ширээний цаана суугаад эхийнхээ мөрөн дээр толгойгоо тавьсан байв. Тэдэнд дараа ярих цаг, өдөр магадгүй бүтэн жилийн хугацаа хангалттай байгаа. Дараа нь тэр Невиллийг харлаа. Гриффиндорын илд тавганых нь дэргэд хэвтээд бүлэг хөөрсөн шүтэн

бишрэгчид хоол идэхийг нь нүд салгалгүй ширтэж байв. Бас холгүйхэн орших ширээн дундуур явахдаа гурван Малфой бие биеэ шахцалдан суугаад хэн ч тэдэнд өчүүхэн төдий ч анхаарал хандуулахгүй байгаад эргэлзсэн янзтай байхыг харав. Түүнчлэн эргэн тойрондоо эргэн нэгдсэн гэр бүлүүдийг хараад эцэст нь түүнд одоо хэрэгтэй байгаа хоёр хүнийг оллоо.

- Би байна. Хамт явах уу? гэж тэдэн рүү бөхийн хэлэв.

Рон, Гермиона хоёр байрнаасаа босоод түүний хамт Их танхимаас гарав. Гантиг шат эвдэрч хашлага нь алга болоод хаа сайгүй цусан толбо тогтжээ.

Хаа нэгтээ хонгилын гүнд Пивзийн өөрөө бодож олсон ялалтын дуулал сонсогдоно.

Жижигхэн Поттер ганцаараа түүнийг ялсан

Волди молди болоод явсан болохоор одоо хөгжилдөцгөөе.

- Хурц өрнөлтэй эмгэнэлт жүжиг байсан шиг санагдаж эхэлж байна шүү, тийм үү? гэж Рон хаалга онгойлгон Харри, Гермиона хоёрын хамт шургалахдаа хэлэв.

«Одоо л би жинхэнэ аз жаргалыг мэдэрч байна» гэж Харри бодов. Тэр эцэж ядарсандаа болоод алхам бүрд нь шарх шиг хатгуулах Фред, Люпин, Тонксыг алдсан мэдрэмжээ ч мартжээ. Тэр юунаас түрүүнд санаа амарч унтахыг хүсэв. Гэсэн ч өмнө нь Рон, Гермиона хоёрт бүгдийг тайлбарлах хэрэгтэй байлаа ... Тэд удаан хугацаанд түүнтэй хамт байсан болохоор үнэнийг сонсох эрхтэй билээ. Тэр тэдэнд гүн ухааны цүнхээлд юу харсан тухайгаа болон Хориотой ойд юу болсон тухай тодорхой ярьж өгөөд Рон, Гермиона хоёр гайхширлаа илэрхийлж амжаагүй байхад зорьсон газраа хүрэв.

Түүнийг сүүлд харснаас хойш захирлын өрөөг хамгаалан зогссон луу хажуу тийш хэлтийжээ.

Тэр нууц үгээ санаж чадах болов уу гэж Харри бодов.

- Бид орж болох уу? гэж тэр луунаас асуулаа.

- Орогтун гэж хөшөө бувтнав.

Тэд түүний дэргэдүүр өнгөрөөд чулуун эргүүлгэн шатаар гарч шатны дээд талын талбайд эргэлдэн хүрэхэд Харри үүдийг түлхлээ.

Тэр өрөөг түргэхэн ажиглахад гүн ухааны цүнхээл урьд нь охисон янзаар ширээн дээр байсан ч агшин зуур Үхэл залгигчид эргэж ирсэн болон, Волдеморт ахин төрсөн юм шиг чих дөжрөм хашгиралт нүргэлэв ...

Гэвч энэ алга ташилт байлаа. Хогварстын өмнөх захирлын хөргүүд ханан дээрээс ширтэн нөхөрсгөөр алга ташиж байв. Тэд малгай зарим нь хиймэл үсээрээ даллаж, бие биетэйгээ гар барилцаж байв. Дайлис Дервент ичгүүр сонжуургүй нулимс асгаруулан, Декстер Фортескью чихний бүрээгээ даллаж, харин Финеас Найжелус чанга хоолойгоор,

- Слизерин тэнхим гол дүрд тоглосныг ажиглаж байна уу! Бидний хувь нэмрийг бүү мартаарай! гэв.

Гэсэн ч Харри захирлын суудал дээр өлгөөстэй хамгийн том хөрөгт хэн зогсч байгааг харлаа. Хагас саран шилэн дороос нулимс мэлтэрч урт мөнгөлөг салал даган урсаж байв. Бахархал талархал царай дээр илрээд Харрийн сэтгэл санааг галт шувууны дуу шиг өргөлөө.

Эцэст нь Харри гараа өргөхөд хөргүүд хүндэтгэлтэйгээр чимээгүй болж инээмсэглэн нүдээ арчингаа юу хэлэхийг нь тэсч ядан хүлээв. Гэсэн ч тэр зөвхөн Дамблдорт хандан ярилаа. Эцэж ядран нүдний өмнө манан сүүмэлзэхийг үл харгалзан сүүлчийн хүчээ гарган зөвлөгөө асуулаа.

- Снитчэд нуугаастай байсна зүйлийг би Хориотой ойд унагачихсан. Байгаа газрыг нь санаж чадахгүй болохоор хайж чадахгүй нь. Та намайг зөвшөөрч байна уу?

- Зөвшөөрч байна, хонгор хүү минь гэж Дамблдор хэлэхэд үлдсэн хөргүүд тэднийг гайхширч сониучирхсан харцаар ажиглав.

- Энэ бол миний чамаас хүлээгээгүй цэцэн мэргэн эрэлхэг шийдвэр байлаа. Хэн нэгэн түүнийг чамайг тэнд унагасан гэж мэдэх үү?

- Хэн ч мэдэхгүй гэж Харри хариулахад Дамблдор сэтгэл ханамжтай толгой дохив.

- Гэхдээ би Игнотусын зүйлийг хадгалж үлдсэн. Дамблдор баясан гийлээ.

- Мэдээж Харри тэр чамайг үр удамдаа дамжуулах хүртэл чинь үүрд харъяалагдана.

- Энэ бас үлдлээ.

Харри гандигарын сабааг өргөв. Рон, Гермиона хоёр түүн рүү бишрэн харлаа. Харри эцэж ядарсан хэдий ч энэ харцыг ажиглаад таалагдсангүй.

- Надад энэ хэрэггүй.

- Юу? Чи чинь ухаан солиоров уу? гэж Рон чанга дуу алдав.

- Би түүний хүчирхэгийг мэдэж байгаа ч гэхдээ минийх илүү таалагддаг.

Тэгээд ч ...

Тэр хүзүүндээ зүүсэн хүүдийнээс галт шувууны өдтэй хугарсан саваагаа гаргаж ирлээ. Гермиона сабааг засаж болохооргүй хэтэрхий хүнд гэмтсэн гэж хэлсэн. Гэвч тэр нэг л зүйлийг мэдэж байв. Хэрвээ энэ тус болохгүй бол өөр юу ч тус болохгүй.

Тэр хугархай саваагаа захирлын ширээн дээр тавиад үзүүр лүү нь гандигарын саваагаар хүрэн,

- Репаро! гэв.

Сабааны үзүүр урган нэгдэж үзүүрээс нь улаан оч асгарахад Харри бодол нь бүтсэнийг мэдлээ. Тэр шивээ мод галт шувууны өдтэй саваага авахад саваа уулзсандаа баярлах мэт хуруу нь бүлээхэн оргив.

- Би гандигарын сабааг авсан газар нь орхилоо. Тэнд үлдсэн нь дээр. Хэрвээ би Игнотус шиг өөрийн үхлээрээ үлдвэл тэр хүчээ алдана биз дээ? Түүний өмнөх эзэн

хэзээ ч ялагдаагүй болохоор. Ингэж л түүний хүч төгсгөл болно гэж хязгааргүй хайрлан хүндэтгэсэн харцаар харж буй Дамблдорт хэлэв.

Дамблдор толгой дохиход тэд бие бие рүүгээ инээмсэглэв.

- Чи итгэлтэй байна уу? гэж Рон асуугаад гандигарын сабааг шохоорхон харахад хоолойд нь харамссан өнгө илрэв.

- Би Харригийн зөв гэж бодож байна хэмээн Гермиона аяархан хэллээ.

- Энэ саваа төвөг зовлон авчирдаг. Харин үнэнийг хэлэхэд төвөг миний амьдралд хангалтай гэж бодож байна гээд Харри хөргүүдээс эргэн Гриффиндорын цамхагт хүлээж байгаа адрын дорх дөрвөн хөлтэй ороо бодлоо. Магадгүй тийшээ Кикимер хачиртай талх аваачсан ч байх юм билүү.

ТӨГСГӨЛ: АРВАН ЕСӨН ЖИЛИЙН ДАРАА

Энэ жилийн намар гэнэтхэн айлчлан есөн сарын нэгний өглөө алтлаг алим шиг шаргалтаж байлаа. Жижигхэн гэр бүл чимээ шуугиантай замаар аврага том утаатай буудал руу чиглэхэд машины яндангийн утаа болон явган зорчигчийн амьсгал хүйтэн агаарт цантан аалзны шүлс мэт гялтагнаж байлаа. Эцэг эх нь орой дээр нь хоёр том тор тавьсан ачаатай тэргэнцэр түлхээд, торонд байгаа ууль уурсан гууглаж, шаргал үстэй охин ах нарынхаа араас уйлах шахам явахдаа эцгийнхээ гараас чанга зуурчээ.

- Хүлээгээрэй чи ч бас удахгүй явна гэж Харри түүнд хэлэв.

- Хоёр жил. Харин би одоо л явахыг хүсч байна! гэж Лили шуухитналаа.

Зорчигчид есөн бүхэл дөрөвний гурав дугаар тавцангийн саад руу явж байгаа гэр бүл болон уулийг сониучирхан харна. Харрид чимээ шуугиан дундаас Альбусын хоолой сонсогдон ... түүний хөвгүүд машинд эхэлсэн маргаанаа үргэлжлүүлж байлаа.

- Тэгэхгүй! Би Слизеринд орохгүй!

- Жеймс, боль! гэж Жинни хэлэв.

- Би зөвхөн түүнийг магадгүй л гэж хэлээ биз дээ хэмээн Жеймс бага дүү рүүгээ инээмсэглэн хэлээд,

- Тэгээд юу гэж? Тэр үнэхээр Слизеринд орж магад ... гэв.

Гэсэн ч эх нь түүнийг ширүүн харцаар ажиглахад Жеймс чимээгүй болов. Таван Поттер хаалтанд дөхөж очлоо. Жеймс бага дүү рүүгээ сэтгэл хангалуун харснаа эхээсээ тэргэнцэрийг аван урагш гүйлээ. Хормын дараа тэр алга болов.

- Та нар надад захиа бичих үү? гэж Альбус эцэг эхээсээ том ахынхаа байхгүйг ашиглан асуулаа.

- Өдөр бүр бичихийг хүсч байна уу? гэж Жинни хэлэв.

- Үгүй, өдөр бүр хэрэггүй гэж Альбус яаран хэлээд,

- Жеймс ихэнхи хүүхдүүд гэрээсээ захиа сард нэг удаа авдаг гэсэн гэв.

- Өнгөрсөн жил бид Жеймст долоо хоногт гурван удаа захиа бичсэн гэж Жинни хэлэхэд,

- Тэгээд ч чи түүний Хогвартсын тухай хэлсэн бүхэнд итгэх хэрэггүй. Чиний ах чинь тоглох дуртай гэж Харри нэмэрлэв.

Бүгд хамтдаа хоёр дахь тэргэнцээрээ түлхэн хурдаа авлаа. Хаалтны өмнө Альбус давхийсэн ч мөргөлдөх зүйл гарсангүй. Оронд нь гэр бүл есөн бүхэл дөрөвний гуравдугаар тавцан дээр гарч ирээд гал улаан өнгийн «Хогвартс Экпресс» галт тэрэгнээс өтгөн цагаан утаа олгойдож байлаа. Манан дунд тодорхойгүй дүрсүүд бүрэлзэн Жеймс хэдийн тэдний дунд алга болжээ.

- Тэд хаа байна? гэж Альбус түгшин асуугаад дэргэдүүрээ өнгөрөх бүүдгэр дүрсүүдийг харлаа.

- Бид тэднийг олно гэж Жинни тайвшируулав.

Гэвч өтгөн утаанд царай ялгах хэцүү байлаа. Эзэн нь үзэгдэхгүй ч хоолой чанга сонсогдож байв. Харрид шүүр зохицуулах талаар ярьж байгаа Персийн хоолой сонсогдох шиг санагдсан ч мананд заавал зогсож мэндлэх хэрэг гараагүйд баяртай байлаа.

- Ал, тэд энд байна гэж Жинни гэнэтхэн хэлэв.

Манан дундаас сүүлчийн вагоны өмнө зогссон бүлэг хүмүүс гарч ирэхэд Харри, Жинни, Лили, Альбус нар ойртож очсон хойноо л царайг нь тод харах боломжтой болов.

- Сайн уу! гэж Альбус санаа амарсан хоолойгоор хэллээ. Хогвартсын шинэ дүрэмт хувцсаа өмссөн Роза инээмсэглэн зогсоно.

- За яасан хэвийн зогссон уу? гэж Рон Харригаас асуугаад,

- Би тэгсэн. Гэсэн ч Гермиона намайг маглуудын жолооны шалгалтыг өгсөн гэдэгт итгэхгүй байгаа шүү. Тэр намайг шалгагчыг нь Конфундусаар самууруулсан гэж бодоод байгаа юм гэв.

- Худлаа. Би чамд хэзээ ч эргэлзэж байгаагүй гэж Гермиона хэлэв.

- Ер нь бол би үнэхээр түүнд Конфундус илгээсэн гэж Рон Харрийн хамт вагонд Альбусын чемодан уулийг оруулахдаа шивнэн хэлээд,

- Би зөвхөн хажуу талын толио харах хэрэгтэй гэдгийг мартчихсан юм гэв.

Тэднийг тавцан руу эргэж ирэхэд Лили, Розагын бага дүү Хьюго хоёр Хогвартс явах үедээ ямар тэнхимд элсэх талаар маргалдаж балгаа.

- Хэрвээ чи Гриффиндорт орохгүй бол бид чамайг өв залгамжлагчаасаа хасна.

Гэхдээ энэ дарамталсан хэрэг биш шүү гэж Рон хэлэв.

- Рон!

Лили, Хьюго хоёр инээлдэхэд Альбус, Роза хоёр бодлогоширсон байдалтай үлдэв.

- Тэр зүгээр л тоглож байгаа юм гэж Гермиона, Жинни хоёр чанга хэлсэн ч Рон сонссонгүй. Тэр Харри руу хараад ойролцоо зогссон гурван дүрс рүү дохилоо. Утаа энэ хоромд шингэрэхэд жижигхэн бүлэг сайн харагдав.

- Тэнд хэн зогсч байгааг хараач!

Энэ бол Драко Малфой эхнэр хүүхдийнхээ хамт хоолойгоо хүртэл товчилсон хар пальтотой зогсч байсан хэрэг байлаа. Дух нь халзарсны улмаас шовх эрүү нь улам урт болсон юм шиг санагдана. Хүү нь Альбус Харриг санагдуулдагийн адил эцэгтэйгээ маш адилхан аж. Драко Харри, Рон, Гермиона, Жинни нар түүн рүү харахыг хараад толгой дохин цааш эргэлээ.

- Аан энэ жижигхэн Скорпиус байх нь. Чи түүнийг шалгалт бүр дээр давах ёстой шүү, Роза. Бурханы авралаар чи ээжийнхээ ухааныг өвлөжээ! хэмээн Рон шивнэн хэлэв.

- Рон, чамаас гуйя гэж Гермиона уурлах тоглохын завсар хэлээд,

- Хүүхдүүд сургуульдаа яваагүй байхад чи хэдийн бие биенийх нь эсрэг түлхэж байх юм! гэв.

- Чиний зөв, хонгор минь гэж Рон хэлсэн ч удаан тэсч чадсангүй.

- Гэхдээ түүнтэй нөхөрлөх хэрэггүй шүү, Роза. Уизли өвөө нь хэрвээ чамайг цэвэр цусны хүнтэй гэрлэвэл уучлахгүй дээ! гэв.

- Сайн уу!

Энэ бол Жеймс эргэж ирсэн хэрэг байв. Тэр хэдийн чемодан, ууль, тэргэнцэрээсээ салаад шинэ мэдээ дуулгах гэж тэсч ядаж байв.

- Тэнд Тедди байна гээд Жеймс өтгөн утаа руу зааж,

- Би түүнийг сая л харлаа! Тэр юу хийж байсныг мэдэх үү? Виктуартай үнсэлдэж байсан! гээд томчуудын хариу үйлдэлд урам хугарсан янзтай,

- Манай Тедди! Тедди Люпин! Манай Виктуартай үнсэлдэж байсан! Үеэл эгчтэй минь! Би Теддигээс юу хийж байгааг нь асуусан ... гэв.

- Чи тэдэнд саад болсон юм уу? Өө, Жеймс чи Ронтой төстэй юм байна! гэж

Жинни хэлэв.

- Харин тэр түүнийг харахаар ирсэн гэж хэлсэн! Дараа нь намайг цаашаа яв гэж хэлсэн! Тэр түүнтэй үнсэлдэж байсан! гэж Жеймс хэн нэгэн ойлгоогүй үлдэхээс болгоомжилсон мэт нэмэрлэв.

- Хэрвээ тэд гэрлэвэл сайн хэрэг байна даа! Тэгвэл Тедди манай гэр бүлийн гишүүн болно! гэж Лили хөөрөн шивнэв.

- Тэр хэдийн бидэнтэй долоо хоногт дөрвөн удаа хооллодог шүү дээ. Гэхдээ бид яагаад түүнийг манайд амьдрахыг урьж болохгүй гэж? хэмээн Харри хэлэв.

- Тийм шүү! Би хувьдаа Алтай нэг өрөөнд амьдрахаас татгалзахгүй.

Минийхийг Теддид өгч болно гэж Жеймс урам зоригтой дэмжлээ.

- Үгүй. Чи Алтай намайг гэрээ нураахыг хүссэн цагт л нэг өрөөнд амьдраарай гээд Харри Фабиан Пруэттээс өвлөгдсөн хуучин цагаа харж,

- Арван нэг болох нь. Та нар вагондоо орсон нь дээр байх гэв.

- Бас Невиллийг бидний өмнөөс үнсэхээ бүү мартаарай гээд Жинни Жеймсийг тэвэрлээ.

- Ээжээ! Би профессорыг үнсэж чадахгүй!

- Гэхдээ чи Невиллтэй танил биз дээ ... Жеймс нүдээ эргэлдүүлэв.

- Тэр чинь гэртээ болохоос биш харин сургуульд бол профессор Долгопупс!

Намайг ургамал судлал дээр түүн рүү очоод хэлэхийг төсөөлж байна уу ... гээд эхийнхээ тэнэгийг гайхан толгой сэгсэрснээ Альбусыг даажигнан.

- Дараа уулзатлаа баяртай, Ал! Фестралуудаас хол байгаарай! гэв.

- Гэхдээ тэд чинь үл үзэгдэх биз дээ? Чи тэднийг харагдахгүй гэж хэлсэн!

Жеймс хариуд нь инээмсэглээд ээжийнхээ хацар дээр үнсэж, эцгээ тэврээд яаран галт тэрэг руу орлоо. Тэд түүнийг хонгилын цонхоор найзуудаа эрэн гүйхийг харав.

- Фестралуудаас айх хэрэггүй. Тэд их сайхан сэтгэлтэй айх зүйл юу ч байхгүй.

Тэгээд ч та нарыг сүйх тэргээр биш завиар зөөнө гэж Харри хэллээ. Жинни Альбусыг салах ёс гүйцэтгэн үнсээд,

- Зул сар хүртэл баяртай! гэв.

- Баяртай, Ал. Хагридынд баасан гаригт цай уухаар уригдсанаа бүү мартаарай.

Пивзтэй орооцолдох хэрэггүй. Юу ч сураагүй байж халз тулаан хийж болохгүй. Бас Жеймст чамайг чадах боломж бүү өгөөрэй гээд Харри хүүгээ тэвэрлээ.

- Хэрвээ намайг Слизеринд хуваарилвал яах бол?

Тэр эцэгтээ сонсогдохоор аяархан шивнэсэн ч Харри энэ асуултын ард байгаа гүнзгий айдсыг мэдэрлээ.

Тэр доошоо явган суухад Альбус арай өндөр байлаа. Харрийн гурван хүүхэд дундаас

Альбус л зөвхөн Лилигийн нүдийг өвлөжээ.

- Альбус Северус чамайг Хогвартсын хоёр захирлын нэрээр нэрлэсэн. Тэдний нэг нь Слизеринийх байсан ч миний мэдэх хамгийн зоригтой хүн байсан гэж Харри зөвхөн галт тэргэнд байгаа Роза руу гар даллаж байгаа Жиннид сонсогдох төдий аяархан хэлэв.

- Гэхдээ хэрвээ ...

- Слизерин тэнхим маш сайн сурагчдыг сонгон авдаг юм. Бидний хувьд энэ чухал биш, Ал. Гэхдээ чамд Гриффиндор, Слизерин хоёрын алинд орох нь чухал байгаа бол хуваарилагч бүрх малгай хүслийг чинь хүндэтгэж үзэх болно.

- Үнэн гэж үү?

- Минийхийг тэгсэн гэж Харри хэлэв.

Тэр хэзээ ч энэ тухай хүүхдүүдээ хэлж байгаагүй болохоор Альбусын гайхширсан царайг харлаа. Энэ агшинд гал улаан галт тэрэгний үүд хаагдахад сүүмэлзсэн эцэг эхчүүд урагш ухасхийн салах ёс гүйцэтгэн үнсэж, сүүлчийн захиа сануулгаа хэлээд, Альбус галт тэргэнд үсрэн ороход Жинни хаалга хаав. Ойролцоох цонхоор сурагчид цухуйна. Галт тэргэнд байгсдын олонхийн царай Харри руу ханджээ.

- Тэд юугаа хараад байгаа юм бол? гээд Альбус цонхоор Розагийн хамт толгойгоо цухуйлган хөршүүдээ харлаа.

- Санаа зовох хэрэггүй. Надаас болж байгаа юм. Би маш алдартай гэж Рон хэлэв.

Альбус, Роза, Хоьюго, Лили нар инээд алдав. Галт тэрэг хөдлөж эхлэхэд Харри зэрэгцэн яваад хүүгийнхээ туранхай хөөрсөн царайг харав. Харри араас нь гар даллан инээмсэглэсэн ч галт тэрэг алсад хүүхдийг нь авч явж байгаад сэтгэл зүрх нь гунигтай байлаа ...

- Түүний бүх зүйл хэвийн гэж Жинни хэлэв.

Харри түүн рүү хараад духан дээрх сорвиндоо хүрсэн гараа буулгав.

- Тэгэлгүй яахав.

Сорви арван есөн жил өвдсөнгүй. Бүх зүйл сайн байлаа.

ТӨГСӨВ